

ЖОРЖ ОРВЕЛЛ

1984



**Жорж Орвелл**

**Мянга Есөн Зуун Наян Дөрөв**

# НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

# I

Дөрөвдүгээр сарын нэгэн цэлмэг хүйтэн өдөр, цагийн зүү арван гурван цагийг зааж байлаа. Уинстон Смит хүйтэн салхинд цээжээ цохиулахгүй гэж толгойгоо бөхийлгөн явсаар Виктори хэмээх орон сууцны байшингийн шилэн хаалгаар хурдан алхан орсон боловч араасаа хуйларсан тоосыг хааж чадсангүй.

Байшингийн хонгилд чанасан байцаа, хуучирсан дэвсгэрэнцрийн эвгүй үнэр ханхалж байшингийн дотор гэхэд дэндүү томдмоор өнгөт зурагтай самбарыг хонгилын нөгөө үзүүрийн хананд хадсан харагдана. Дөчин тав эргэм настай, шигүү тас хар сахалтай, нэгэн эрийн ширүүн харцтай нэг метр гаруй өргөн том нүүрний зургийг энэхүү самбар дээр зуржээ. Цахилгаан шат азтай үед ч ховорхон ажилладаг тэгээд ч одоо Үзэн ядах долоо хоногт бэлтгэх ажлын хүрээнд цахилгааныг өдрийн гэгээтэй цагаар тасалсан болохоор цахилгаан шатаар явах гэж бодсоны ч

хэрэггүй болохоор Смит шатаар дээшээ алхав. Гучин есөн настай Смит баруун хөлийнхөө шагайн дээхэн талд хөлийн булчингийн шархтай тул долдугаар давхарт байдаг байр руугаа явах замдаа үе үе амарсаар аажуухан дээшилж байв. Давхар бүрийн шатны тавцан дээр цахилгаан шатны хаалганы өөдөөс харуулан нөгөөх нэгэн эрийн лут том нүүр бүхий самбар байрлуулжээ. Тэр эрийн нүдний харц нь таныг хаашаа ч явсан дагалдан гүйж байхаар зургийг зурсан аж. Зургийн дор ИХ АХ ЧАМАЙГ ХАРЖ БАЙНА гэсэн бичиг хаджээ.

Байрны дотор ган хайлуулалтын үйлдвэрлэлийн тоо хэмжээний талаарх тоо баримтын жагсаалтыг тоочсон сонсголонтой дуу хоолой баруун хананд өлгөөтэй харлуулсан толь мэт хавтгай дөрвөлжин металлаас гарч байна. Смит түүний дууг багасгасан боловч гарах дуу нь тод сонсдоно. Энэ хэрэгслийн (теледэлгэц хэмээх) дууг намсгаж болно гэхдээ түүнийг бүрэн хаах арга байдаггүй аж. Смит цонх руу дөхөж очлоо. Түүний өмссөн Намын дүрэмт хувцас болох хөх

баадай нь биеийнх нь жижиг, хэврэг, эцэнхий туранхайг нь илтгэн харуулна. Мань хүний үс нь цайвар, царай нь төрөлхийн өөдрөг сэтгэлтэйг нь илтгэх бөгөөд арьс нь муу саван, сахлын мохоо хутга хэрэглэдэг болон дөнгөж саяхан дууссан хүйтэн өвлийн жавраас болж барзайсан харагдана.

Гадаа нартай, тэнгэр нэг л хүйтэн цэнхэртээд байх бөгөөд газар сайгүй хадсан самбараас өөр өнгөтэй өөдтэй юм байхгүй юм шиг харагдана. Хар сахалтай нүүр хотын өндөрлөг бүр дээрээс харна. Гудамжинд салхи хуйлран тоос шороо, цаасны хогийг эргэлдүүлэн хийсгэнэ. Хаалттай гэгээвчний цаанаас ч гадаад ертөнц хүйтэн цэвдэг харагдана. Гудамжны нөгөө талын байшингийн хананд бас нэг том самбар байх бөгөөд түүний ИХ АХ ЧАМАЙГ ХАРЖ БАЙНА гэсэн бичиг нь Смитийн нүд рүү цоо ширтэнэ. Гудамжны доод хэсэгт бас нэг самбар байх бөгөөд түүний урагдсан үзүүр нь салхинд дэрвэлзэн АНГСОЦ гэсэн үгийг нэг хааж нэг харагдуулна. Хотын цаад захад нэгэн нисдэг

тэрэг байшингийн дээврүүдийн хажуугаар шумбан орж хүүрний ногоон ялаа шиг хүнгэнэснээ гэнэт дээш мушгиралдан хөөрч алга болно. Цагдаагийн эргүүл айлын цонхонд ойртон очиж дотор нь юу болж буйг хянаж буй аж. Энгийн эргүүл бол гэмгүй, харин Сэтгэхүйн Цагдаа бол аюултай.

Смитийн ард теледэлгэцийн хөтлөгч ган хайлуулалт болон Ес дөх Гурван жилийн Төлөвлөгөөний биелэлтийн талаар уншсаар байна. Теледэлгэц бол нэгэн зэрэг хүлээн авч дамжуулна. Смитийн шивнэх төдий хэлэх үгнээс чангахан дуугарахыг ч теледэлгэц хүлээн авахаар барахгүй металл дөрвөлжингийн харааны хүрээнд л байх юм бол түүнийг харж ч чадна, сонсч ч чадна. Хэн нэгэн хүн өөрийг нь хэдийд хэрхэн чагнаж байна, хэдэн удаа, ямар аргаар гэдгийг мэдэх арга байхгүй гэдэг нь ойлгомжтой хэрэг ээ. Сэтгэхүйн Цагдаа чухам хэнийг чагнаж байна гэдгийг мэдэх арга байхгүй. Цагдаагийнхан хүн бүрийг тасралтгүй чагнаж байна гэдгийг л ухаарах хэрэгтэй болно.

Юутай ч тэд дуртай цагтаа таны утсыг чагнана. Чамаас гарсан дуу чимээ болгоныг сонсож байгаа, харанхуй болоогүй байгаа цагт чамайг харж байгаа гэдэг зуршилд чи дасаж амьдрах хэрэгтэй, амьдарч ч байсан юм.

Смит эргээд теледэлгэц рүү харлаа. Смит хүний нуруу хүртэл өөрийг чинь илчилж болно гэдгийг мэдэх тул ингэх нь аюул багатай хэрэг байлаа. Километр гаруйн зайд өөрийнх нь ажлын газар болох Үнэний Яамны цагаан байшин хотын уйтгартай дүрс дотор сүрлэг харагдана. Смит энэ бол Далайн Гүрний хамгийн олон хүнтэй гурав дахь мужийн нийслэл, Онгоц нисэх нэгдүгээр зам-Лондон шүү дээ гэж ялимгүй зэвүүрхэн бодож байв. Хажуудаа овоолоостой гуалин модтой, хатуу цаас наасан цонхтой, зэвэрч муудсан төмөр дээвэртэй, арван есдүгээр зууны элэгдэж муудсан байшингууд, тал тал тийшээгээ нурж унасан хашаатай цэцэрлэгүүд энэ бүхэн дандаа байсан бил үү? Салхинд тоос шороо бужигнаж бөөн хогон дундаас уд модны бут цухуйсан



онгоцны бөмбөгний цоорхой, бөмбөгдөлтийн улмаас үүссэн том том зурвас газарт бий болсон тахианы хорго шиг модон оромжны хороолол байсан билүү? гэж Смит бага насныхаа дурсамжийг эргэн санахыг хичээлээ. Тэрээр юу ч санаж чадахгүй байлаа. Юу вэ энэ чинь гэдгийг ялган хэлэх аргагүй ард талд нь юу ч байхгүй нүд гялбам гэрэлтэй дүрсээс өөр бага насны дурсамж огт алга байна. Бага насныхаа дурсамжийг эргэн санах арга алга байна.

Үнэний Яам-Шинхэлийнхээр Үнэний яам нүдэнд харагдаж буй бүх юмнаас гайхалтай онцгой харагдана. Яамны байшин нь цагаан бетоноор барьсан 300 метр өндөр суварга хэлбэртэй лут том байшин бөгөөд давхар давхар нь дээшээгээ цойлон тэмүүлэх шиг харагдана. Смитийн зогсож буй газраас тэрхүү байшингийн нүүр тал дээр гоёмсгоор бичсэн Намын гурван уриа үг тодхон харагдана. Тэдгээр нь:

*ДАЙН БОЛ ЭНХ ТАЙВАН*

# *ЭРХ ЧӨЛӨӨ БОЛ БООЛЧЛОЛ*

## *ҮЛ МЭДЭХ НЬ ХҮЧ*

Үнэний Яам нь газрын дээр гурван мянган өрөөтэй, мөн газар доор ч төдий чинээ өрөөтэй гэж ярьдаг юм. Лондоны энд тэнд яг ийм хэлбэртэй, ийм хэмжээтэй гурван яамны байшин бас бий. Энэ дөрвөн байшин эргэн тойрныхоо барилга байгууламжийг өчүүхэн жижиг болгон харагдуулдаг болохоор Виктори орон сууцны байшингаас тэдгээрийг нэгэн зэрэг харах боломжтой. Засгийн газрын бүх аппаратын ажилладаг дөрвөн Яамны байр нь энэ дөрвөн байшин юм.

Үнэний Яам нь мэдээ, үзвэр үйлчилгээ, боловсрол, дүрслэх урлагийн асуудал хариуцна. Энх тайвны Яам нь дайны асуудал эрхэлнэ. Хайрын Яам нь хууль зүй, дэг журмын асуудал эрхэлнэ. Элбэг дэлбэгийн Яам нь эдийн засгийн асуудлыг хариуцана. Шинхэлээр тэдгээрийн нэр

нь Үнэням, Тайваням, Хайрям, Элбэгям болно.

Хайрын яамны байшинд нэг ч цонх байхгүй, албан ажлаар л яваа биш бол тэр байшинд орох арга байхгүй, орлоо гэхэд гаднах өргөстэй төмөр торон хамгаалалт, төмөр хаалга болон хананы пулемёттой бэхэлгээнүүдийг дамжин явж л орно. Тэр байшин руу явсан гудамжинд хүртэл дүрэмт хар хувцастай, янз бүрийн бороохой зүүсэн хамгаалалтын харуулуудыг байрлуулсан байна. Хайрын Яам бол хамгийн айдас төрүүлсэн газар бөгөөд Смит энэ яамны дотор нь орох нь байтугай түүнд нэг километр ч ойртож үзээгүй юм.

Смит огцом эргээд теледэлгэц рүү нүүрээ харуулахдаа ингэх нь зүйтэй гэж үздэг ёсоороо нилээд өөдрөг царай гаргалаа. Тэрээр өрөөнийхөө дундуур гараад гал тогооныхоо давчуу өрөөнд орохдоо яамнаасаа өдөр дунд гарч явахдаа гуанзанд үдийн хоолоо идэлгүй орхисон, гал тогоонд нь маргааш өглөөний

хоолондоо хадгалах ёстой хэрчим хатсан хар талхнаас өөр идэх юм байхгүй гэдгээ саналаа. Смит тавиур дээрээс Виктори жин гэсэн энгийн шошготой Хятадын тутраганы спиртийн эвгүй үнэртэй, өнгөгүй шингэн шил архийг гаргаад түүнээсээ цайны халбаганы хагасын хэрийг хийгээд амьсгаагаа авч зүрхээ чангалаад гашуун эм ууж байгаа юм шиг хөнтөрч орхив. Дараагийн хоромд түүний нүүр нь час улайгаад нүд нь цэлийгээд нулимсаар дүүрч байв. Энэ архи нь азотын хүчилтэй адил, тэгээд ч үүнийг уусан хүн дагз руугаа эрзээн бороохойгоор цохиулсан юм шиг болдог аж. Тэгээд л мань хүний ходоод шатах намжаад хорвоо дэлхий арай баяр баясгалантай болж эхлэхэд тэрээр ВИКТОРИ ЯНЖУУР гэсэн бичигтэй үрчийж хумхигдсан хайрцагнаас нэг ширхэг янжуур гарган зуугуураас нь болгоомжгүй барьтал тамхи нь шалан дээр асгарч орхив. Тэрээр дараагийн янжуурыг арай болгоомжтой гаргаад зочны өрөөндөө орж теледэлгэцийн зүүн гар талд буй жижигхэн ширээний ард суугаад үзэг, бэх, улаан артай зузаан хавтастай жижиг

тэмдэглэлийн дэвтрээ ширээний нүднээс гаргаж ирэв.

Зочны өрөөн дэх теледэлгэцийг яагаад ч юм эвгүй байрлуулсан аж. Бүх өрөөг багтаан харахын тулд теледэлгэцийг голдуу өрөөний буланд байрлуулдаг байтал энэ теледэлгэцийг цонхны эсрэг талын урт хананд байрлуулсан аж. Энэ хананы нэг талд нь одоо Смитийн сууж байгаа нэг их гүнзгий бус хонхорхой зай бий бөгөөд үүнийг анх байшин барихдаа номын тавиур хийх гэж хийсэн бололтой юм. Смит энэ зайд суугаад нуруу тэгш суух юм бол теледэлгэцийн хараанд өртөхгүй байж болдог аж. Түүнээс гарах чимээг сонсох нь мэдээж хэрэг боловч энэ байршилдаа байгаад байх юм бол түүнийг харах боломжгүй юм. Чухамхүү өрөөнийх нь энэхүү ер бусын зохион байгуулалт л мань хүнд одоо хийхээр зэхэж буй юмыг хийх санааг төрүүлсэн билээ.

Мөн дөнгөж сая ширээний нүднээс гаргаж ирсэн дэвтэр нь ч ийм юм хийх санааг

төрүүлсэн. Энэ нь наад зах нь сүүлийн дөчин жилд хэвлээгүй улиран өнгөрөх цаг хугацааны эрхээр бага зэрэг шарласан сайхан зузаан цаастай адьбиш гоё дэвтэр байлаа. Тэрээр энэ дэвтэр үүнээс урт настай байх гэж бодож байсан бөгөөд хотын ядуучуудын хорооллын (тэрээр одоо аль хороолол гэдгийг нэгэнт мартжээ) нэгэн жижигхэн навсайсан линсий эд юмсын мухлагийн цонхон дотор байхыг хараад түүнийг авах юмсан гэсэн хүсэлдээ аргагүйн эрхэнд татагдаж билээ. Намын гишүүд жирийн мухлагт ( “чөлөөт зах зээл дээр наймаа хийх” гэж нэрлэдэг) орох ёсгүй гэж үздэг боловч шаахайны оосор, сахлын хутга гэх мэтийн төрөл бүрийн эд юмсыг олж авах өөр ямар ч аргагүй болохоор энэ журмыг нэг их хатуу баримталдаггүй аж. Смит гудамжны өөд уруу хурдан гэгч нь хяламхийн хараад мухлагт шалавхан орж дэвтрийг хоёр доллар хагасаар худалдаж авахдаа дэвтрээ чухам юунд хэрэглэх гэж буйгаа ухаараагүй билээ. Смит дэвтрээ хавтсандаа гэм хийсэн хүн шиг хийж бариад гэртээ авчирсан юм.

Дэвтэрт хэдийвээр ямар ч бичиг байхгүй ч гэсэн ийм юм эзэмших нь хэрэгт оруулж болох осолтой байлаа.

Смитийн санасан зүйл бол өдрийн тэмдэглэл хөтлөх явдал байв. Энэ үйлдэл нь хууль бус зүйл биш (ямар ч хууль нэгэнт байхгүй болсон тул хууль бус юм гэж байхаа больсон) гэхдээ мэдэгдэх л юм бол энэ үйлдэл хийсний төлөө цаазаар авах ял оноох буюу хүнд хүчир хөдөлмөрийн лагерьт наад зах нь хорин таван жил цөлөгдөх ял хүлээх нь бараг гарцаагүй. Смит үзэгнийхээ үзүүрийг ишинд нь лав хийгээд амандаа үмхэж цэвэрлэв. Үзэг нь гарын үсэг зурахад ч цөөхөн хэрэглэсэн хуучин эд бөгөөд Смит энэхүү зузаан гоё цаасан дээр зүгээр нэг үзгээр бичсэнээс жинхэнэ сурагчийн үзгээр бичих нь зүйтэй гэж үзэж түүнийг сэмхэн олж авсан юм.

Тэрээр богино тэмдэглэл хийхээс цааш гардаггүй тул үнэн хэрэг дээрээ бичиж дадаагүй юм. Тэрээр голдуу бүх бичих юмаа үгбичигчид

дуудаж бичүүлдэг болохоор одоо тэрнийгээ энд хэрэглэх боломжгүй байв. Смит үзгээ бэхэнд дүрээд хоромхон зуур бодолхийлэхэд бие нь чичирч байлаа. Цаасан дээр бичиж эхлэх нь эр зоригийн хэрэг байв. Тэрээр муруйлган бичиж байлаа,

*1984 оны 4 дүгээр сарын 4*

Смит аргаа барж ар тийшээ наллаа. Тэрээр юуны өмнө энэ бол 1984 он гэдгийг баттай мэдэхгүй байна. Тэрээр гучин есөн настай гэдгээ нилээд сайн мэдэж байгаа болохоор энэ жил бол тэгш жил байх ёстой. Өөрийгөө 1944 юм уу 1945 онд төрсөн гэдгийг мэддэг, харин одоо нэг, хоёр жилийн дотор аль нэг өдрийг яг төдний өдөр гээд хэлчих ямар ч боломж байхгүй болжээ.

Би хэнд зориулж энэ тэмдэглэлийг бичиж байгаа билээ гэсэн санамсаргүй бодол толгойд нь орж ирлээ. Ирээдүйд үү, одоо төрөөгүй байгаа хүмүүст үү?. Тэрээр цаасан дээр тавьсан



он сар өдрийг нэг хэсэгтээ эргэцүүлж бодсоноо Шинхэлийн хоёрсэтгэх гэдэг үгийг гэнэт саналаа. Хийхээр шийдсэн зүйлийнхээ цар хүрээг анх удаагаа ухаарлаа. Чи ирээдүйтэй хэрхэн харилцаж чадах вэ? Энэ нь хэрэг дээрээ боломжгүй зүйл юм. Ирээдүй өнөөдрийнхтэй адил байна гэвэл тэр нь миний үгийг сонсох ч үгүй, аль эсвэл өнөөдрийнхээс өөр байх юм уу, тэгвэл миний зовлон бэрхшээл утгагүй юм.

Смит цаасаа гөлрөн ширтэж хэдэн мөч суулаа. Теледэлгэцээс одоо чих дөжрүүлсэн цэргийн хөгжим сонсдоно. Тэрээр өөрийгөө илэрхийлэх чадвараа алдсан юм шиг байгаад зогсохгүй юу хийх гэж анх бодсоноо ч бүрмөсөн мартчихсан юм шиг байлаа. Тэрээр өөрийгөө сүүлийн хэдэн хоногт ийм явдал гарахад бэлтгэсээр ирсэн мөртлөө эр зориг гаргахаас бас өөр юм шаардлагатай болно гэсэн санаа орж ирээгүй юм. Яг бичээд эхэлнэ гэдэг бол хялбархан зүйл биш. Дотроо өөртэйгөө олон жил тасралтгүй яриад байсан сэтгэл зовоосон зүйлээ л цаасан дээр буулгах нь л түүний хийх ёстой бүх ажил

юм. Энэхэн мөчид нөгөө өөртэйгөө ярьсан зүйл нь ч мартагдчихаж. Бас тэгээд нөгөө хөлийн булчингийн шарх нь тэсвэрлэх аргагүй загатнаж байна. Шархыг маажих л юм бол дороо сэдэрчихдэг эд. Цагийн зүү цохилсоор байна. Смит өмнөө байгаа хоосон цагаан цаас, шагайны дээхнэх хөлийн арьсны загатнаа, чихэнд чийртэй хөгжмийн дуу болон жинийн бага зэрэг хөлчүүрлээс өөр юу ч мэдрэхгүй байлаа.

Смит гэв гэнэт зүгээр л сандран юу хийж байгаагаа үл ухааран бичиж эхлэхэд бага хүүхдийнх шиг бичиг нь хуудсыг дүүргэж эхлээд том үсгүүд болон цэг таслал ч гарч байлаа.

*1984 оны 4 дүгээр сарын 4. Өчигдөр орой кино үзлээ. Бүх кино нь дайны тухай юм. Газрын Дундад Тэнгисийн хаа нэг газар дүрвэгсэд дүүрэн усан онгоцыг бөмбөгдөж байгаа тухай нэг сайхан кино байна. Нэгэн том тарган эр нисдэг тэргэнд хөөгдөн зугтаж байгаад*

буудуулахад нь үзэгчид ихэд хөөрөн хөгжиж байв. Эхлээд тэр эрийг далайн гахай шиг усан дотор тонгочиж байхыг нь, дараа нь нисдэг тэрэгний бууны овоо харааны нухээр тэгээд бур суулд нь биед нь олон сум ороод тэнгисийн ус ягаан улаан болж сумны шарханд нь ус нэвтчин гэв гэнэт живж буйг нь үзэгчид хараад тас тас инээлдлээ. Үүний дараа хүүхдүүд дүүрэн суусан аврах завь дээгүүр нь эргэлдэх нисдэг тэрэг гарна. Завины хошуун дээр еврей бололтой ахимагдуу насны нэгэн бүсгүй гурав орчим настай жаахан хүүг цээжиндээ тэврэн сууж байна. Жаахан хүү айж чарлан уйлж эхийнхээ биед шигдэн орох гэж байгаа мэт толгойгоо хоёр цээжнийх нь хооронд хавчуулчихсан байх бөгөөд эх нь айснаасаа царай нь зэвхий цагаан болчихсон хүүгээ хоёр гараараа тас тэврэн тайтгаруулахыг оролдоно. Эх нь бууны сутнаас хатгаалж чадна гэж бодсон бололтой хүүгээ аль байдгаараа гараараа хаацайлж байтал нисдэг тэрэг тэдний дээрээс 20 килограммын бөмбөг хаяхад их дэлбэрэлт болж завь бухлээрээ далайн усанд живнэ. Тэгтэл

нисдэг тэрэгний толгойд байрлуулсан аппаратаар авсан байж таарах хүүгийн гарны тасархай агаарт улам улам дээшлэн ойж буйг харуулсан гайхамшигтай зураг гарлаа. Үүнийг гармагц намын гишүүдийн суудлаас алга нижигнуулэн таших нь сонсогдтол киноны танхимтын үгээгүйчүүдийн хэсгээс нэгэн эмэгтэй та нар хүүхдийн нүдэн дээр ийм юм үзүүлэх ёсгүй, та нарт хүүхдийн нүдэн дээр ийм юм үзүүлэх эрх байхгүй гэж чанга хаширан бөөн шуугиан дэгдээв. Цагдаа ирж тэр эмэгтэйд чирж гаргав. Тэд үгээгүйчүүдийн жирийн гишүүн юу хэлж буйг огт ойшоодоггүй болохоор энэ эмэгтэйд юу ч болохгүй гэж би таамаглаж байна.

Смит шөрмөс нь татсан тул бичихээ түр азнав. Тэрээр энэ шал хэрэггүй юмыг яагаад бичих болсноо мэдэхгүй байв. Хачирхалтай нь тэрээр энэ юмаа бичиж байх үед огт өөр дурсамж санаанд нь орж ирээд түүнийгээ цаасан дээр бараг буулгаж бичихээ дөхөв.

Чухамхүү тэрхүү тохиолддоос болж тэрээр гэртээ гэнэт харьж өдрийн тэмдэглэл бичих болсон гэдгээ сая л нэг ухаарлаа.

Ийм бүдэг бадаг юмыг ямар нэг юм болсон гэж хэлж болдог л юм бол өнөө өглөө Яаман дээр энэ явдал болсон юм.

Арван нэгэн цагийн орчимд Смитийн ажилладаг Баримтжуулах газрын ажилтнууд Хоёр минутын үзэн Ядалтад оролцохоор бүхээгнээс сандлаа гарган танхимын төвийн том теледэлгэцийн өмнө тавьж байв. Смит голын эгнээний дундах сандал дээр суух гэж байтал өмнө нь дөнгөж зүс таних төдий бөгөөд огт үг солилцож үзээгүй хоёр хүн гэнэт ирж суулаа. Тэр хоёрын нэг нь Смиттэй байшингийн хонгилд дандаа дайралдцаг нэрий нь үл мэдэх залуухан бүсгүй аж. Смит түүний нэрийг мэддэггүй боловч Уран зохиолын газар ажилладаг гэдгийг нь мэдэх юм. Түүний гар нь тос болчихсон, түлхүүр барьчихсан явахыг нь зарим үед харсан болохоор роман бичигч машин

дээр ямар нэг механикийн ажил хийдэг байж болох талтай. Тэр бүсгүй хорин долоо орчим настай, өтгөн үс, сэвхтэй нүүртэй, нүүрэмгий байдалтай, түргэн шаламгай хөдөлгөөнтэй нэгэн ажгуу. Бүсгүй ажлынхаа халааз дээр Бэлгийн харилцаанд орохын эсрэг залуусын Холбооны бэлгэдэл болох час улаан бүс хэд ороон бүсэлсэн нь ташааны нь гоог нлтгэнэ. Смит анх дайралдангуут л тэр бүсгүйд дургүй хүрсэн бөгөөд яагаад ингэснээ ч мэдэж байв. Энэ нь тэр бүсгүй хоккей тоглох, хүйтэн усанд орох дуртай, юм болгоныг хийх гэж салбаганаж явдаг нь таалагддаггүй байсан юм. Смит бараг бүх эмэгтэй хүнд тэр тусмаа залуухан, аятайхан эмэгтэй бүрд дургүй. Эмэгтэйчүүд ялангуяа юуны өмнө залуу эмэгтэйчүүд бол Намыг хамгийн их бишрэн шүтэгчид, уриа лоозонд итгэгчид, сайн дураараа мөрдөн мөшгигчид, тэрс үзэлтнийг илрүүлэгчид юм. Харин энэ бүсгүй бусдаас хамаагүй илүү аюултай юм шиг түүнд санагддаг байв. Нэг удаа байшингийн хонгилд дайралдахад энэ бүсгүй нүднийхээ булангаар хялайн харахад нь Смитийн хар хөлс

цутгах шиг болж билээ. Смитэд энэ бүсгүй ер нь Сэтгэхүйн Цагдаагийн туршуул байж магадгүй гэсэн бодол ч төрж байсан. Гэхдээ энэ бол үнэн гэхэд үнэмшил багатай юм. Смит тэр бүсгүйд ойртох бүрд бие нь нэг л хачин эвгүйрхдэг бөгөөд тэр нь айдас, дайсагналын аль аль нь байлаа.

Нөгөөдөх нь Дотуур Намын гишүүн, Смит Намын чухам ямар албан тушаал болохыг нь бүдэг бадаг таамаглаж буй аль нэг чухал албан тушаалтан болох Обрайэн гэдэг хүн байлаа. Дотуур Намын дүрэмт хар хувцастай хүн орж ирэхэд сууж байсан хүмүүсийн дунд шивнэлдэн ярих чимээ гараад замхарлаа. Обрайэн нь том биетэй, хүзүү бүдүүн, царай барсгар, инээдтэй мөртлөө догшин нэгэн ажгуу. Мань эр биерхэг бадруун мөртлөө гадаад төрх байдал нь гарцаагүй ялдам аж.

Түүний нүднийхээ шилээ хамар дээрээ тогтоогоод дээгүүр нь хардаг зуршил нь хүнийг яагаад ч юм хачин жигтэй тайвшруулдаг бөгөөд

өөрийг нь гайхмаар соёлтой харагдуулдаг юм. Энэ нь арван наймдугаар зууны сурвалжит хүн хамрын тамхины хөөргөө зөрүүлж буйг санагдуулж болох юм. Смит энэ хэдэн жилд Обрайэнтэй арав гаруй удаа дайралдсан, тэхдээ түүнд сэтгэл нь ихэд татагдаж байсан юм. Түүний сэтгэлийг Обрайэны хотын хүний төрх байдал ба шагнал авсан тамирчны шинжтэй бадриун бие бялдар хоёрын авцалдаагүй байдал зөвхөн татсан юм биш харин ч сэтгэлдээ нуун хадгалж явдаг итгэл, магадгүй итгэл ч гээд байх юу байх вэ, зүгээр л Обрайэны улс төрийн итгэл үнэмшил нь тийм ч бат биш гэсэн найдвар илүү их татаж байлаа. Түүний царай нь ийм байж магадгүй гэсэн санааг үргэлж төрүүлнэ. Тэгээд ч царайнаас нь харагдах нийтээр дагаж буй улс төрийн итгэл үнэмшилд үнэнч бус байдал бус харин ч оюун ухаан нь сэтгэл татаж байсан. Ямар ч гэсэн тэр хүний гадаад төрх байдал нь теледэлгэцийн хараанаас яаж ийгээд нэг мулттраад нүүр тулан уулзаж чадах юм бол яриа дэлгэж болох хүн гэсэн санааг төрүүлж байлаа. Смит энэхүү бодол таамаглалаа шалгаж үзэх



гэсэн оролдлого хэзээ ч хийж байгаагүй, үнэндээ ингэх ямар ч арга байгаагүй юм. Энэхэн хоромд Обрайэн бугуйн цагаа харахад бараг арван нэгэн цаг болж байсан ба тэрээр Баримтжуулах газарт Хоёр минутын үзэн Ядалтыг дуустал байхаар шийдсэн бололтой. Обрайэн Смитийн сууж байгаа эгнээнд түүнээс хэдэн сууддын цаана суухад Смитийн хажуугийн бүхээгт ажилладаг намхан нуруутай цайвар үстэй хүүхэн тэдний дунд, нөгөөх залуухан бүсгүй арын эгнээнд суув.

Тэгтэл өрөөний нөгөө үзүүрт байгаа теледэлгэцнээс эд ангийнх нь тос дуусчихсан аюумшигт машин явж байгаа юм шиг дотор арзагануулсан хахиралдаан харчигнааны чих дүлийрэм дуу чимээ гармагц толгойтой үс өрвийж ар зоо руу хүйт оргиуллаа. Ингэж Үзэн Ядалт эхлэв.

Нөгөөх л Ардын дайсан-Эммануэл Голштейний нүүр дэлгэц дээр үе үе гялсхийнэ. Хүмүүс энд тэнд дуу алдаж исгэрч байна.

Цайвар үстэй жижигхэн хүүхэн айдас зэвүүцлээ барьж ядан хашгирч байна. Голдштейн бол олон жилийн өмнө (одоо хэн ч хэдэн жилийн өмнө билээ гэдгийг сайн санахгүй болжээ) Их Ахтай бараг нэг зиндаанд Намын удирдах зүтгэлтэн байгаад хувьсгалын эсрэг хорлон сүйтгэх үйл ажиллагаанд оролцсон учир цаазаар авахуулахаар яллагдсан боловч нууцаар зугтаж сураггүй алга болсон урвагч, тэрсүү үзэлтэн юм. Хоёр минут үзэн Ядалтын хөтөлбөрийг өдөр бүр өөр өөрөөр хийдэг боловч түүний гол дүр болох Голдштейнийг үзүүлэхгүй байна гэж огт байдаггүй. Тэр хүн бол хамгийн том урвагч, Намын эгнээг хамгийн түрүүнд бузарлагч, Намын эсрэг гарсан түүнээс хойших бүх гэмт хэрэг, урван тэрслэл, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, тэрсүү үзэл, үзэл суртлын гажиг үзэгдэл түүний сургаалаас болсон юм. Тэр этгээд яагаад ч юм амьд сэрүүн байж сүлбэлдээн хуйвалдаанаа зохион байгуулсаар байна.

Тэрээр гадаадын хөлсний эздийнхээ хамгаалалт дор далайн чанадад хаа нэг газар ч юм уу, аль эсвэл Далайн Гүрний дотоодод хаа нэг газар нуувчинд хоргодож байж магадгүй гэсэн ам дамжсан яриа үе үе гарч байдаг юм.

Смит, Голдштейний царайг сэтгэл тайван харж чаддаггүй болохоор цээж нь давчдаж байв. Энэ нь сэгсийсэн буржгар цагаан үс, жаахан оочин сахалтай еврей хүний турьхан царай байх бөгөөд ухаалаг гэмээр мөртлөө нүднийхээ шилийг нарийхан урт хамрынхаа үзүүрт зүүчихсэн нь цаанаа л нэг дургүй хүрмээр, тэгээд ч хонины толгойтой адилхан, хоолойн өнгө нь ч хонь майлахыг санагдуулна. Голдштейний Намын онолыг хортойгоор дайрч довтлон хэлж буй үг нь хүүхдэд ч хэтрүүлэг, гажуудуулалт гэдэг нь ив илт, тэр хэрнээ өөрөөс нь тэнэгдүү бусад хүний сэтгэлийг гижигдэн итгүүлж чадаж магадгүй байв. Голдштейн Их Ахыг үгээр доромжилж Намын манлайллыг буруушааж Еврази Улстай нэн даруй энх тайвны гэрээ байгуулахыг шаардаж үг хэлэх эрх,

хэвлэлийн эрх чөлөө, хуран цугларах эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахыг шаардаж хувьсгалын үйл хэргийг урван тэрслэлээ гэж хийрхэн орилж байна. Түүний амнаас зогсоо зайгүй гарах энэ бүх урт үг нь Намын илтгэгчдийн элэглэлэрхүү мөртлөө Шинхэлийн зарим үгийг ч хэрэглэсэн байв. Намын жирийн аль нэг гишүүн бодит амьдралдаа хэрэглэдгээс ч илүү олон Шинхэлийн үг тэнд гарч байна. Энэ үеэр Голдштейн ийм нуршаа дэмий үг хэлсэн гэдэгт хэн нэгэн эргэлзэж магадгүйг үгүйсгэхийн тулд теледэлгэц дээр түүний толгойн ар талд Евразийн армийн тоо томшгүй олон гөлийсөн царайтай, ширүүн харцтай эр цэргүүд жагсаал жагсаалаараа дахин дахин гарч ирж байлаа. Голдштейний майлах хоолойг цэргүүдийн хөлийн пад пад хийх нэг хэмийн чимээ дагалдана.

Үзэн Ядалт гучин секунд үргэлжлэв үү, үгүй юү өрөөнд байгаа хүмүүсийн тэн хагас эмх замбараагүй халаглан дуу алдаж эхэллээ.

Теледэлгэц дээрх ихэмсэг хонин нүүртэй хүн түүний араас маршлах Евразийн аюумшигт армийн хүчин чадлыг хараад тэсч байж чадах аргагүй юм. Түүгээр зогсохгүй Голдштейний нүүрийг харах, тэр бүү хэл түүний тухай бодоход л айдас, уур хилэн аяндаа төрдөг аж. Далайн Гүрэн аль нэгэнтэй нь дайтаж байвал нөгөөхтэй нь дайнгүй байдаг хоёр гүрэн болох Евразийн Гүрэн буюу Дорнодазийн Гүрний аль алинаас ч илүү Голдштейнийг жигшил зэвүүцдийн байнгын бай болгож байдаг юм. Харин хачирхалтай нь Голдштейнийг хүн бүр, өдөр бүр индэр дээрээс, теледэлгэцнээс, сонин хэвлэлээр, ном зохиолоор хэдэн мянган удаа үзэн ядаж, хараан зүхэж онолыг нь олны нүдэн дээр хэнд ч хэрэггүй шал дэмий юм гэж нотлон буруушааж, үгүйсгэж, тоглоом тохуу хийж ийм их хүч чармайлт гаргасаар байтал түүний нөлөө огт буурахгүй юм шиг байдаг явдал юм. Түүнийг урхинд оруулах арга мэх дандаа гарч байдаг. Сэтгэхүйн Цагдаагийнхан Голдштейний удирддагаар ажилладаг тагнуул, хорлон сүйтгэгчдийг илчлэхгүй нэг ч өдөр өнгөрдөггүй.

Тэр этгээд бол маш том нууц арми, Төрийн эргэлт хийх зорилготой хуйвалдагчдын далд сүлжээний удирдагч юм. Энэ бүхний нэр нь Ах дүүгийн барилдлага гэдэг хэмээн таамагладаг. Голдштейний өөрийнх нь бичсэн хаа сайгүй нууцаар тарааж байдаг тэрсүү үзлийн бүх номлолын цуглуулга нэгэн айдас төрүүлсэн ном бий гэж олноороо шивнэлдэн ярьдаг. Тэр ном нь гарчиггүй болохоор хүмүүс энэ тухай ярих болбол зүгээр л тэр ном гэдэг. Гэхдээ хэн нэгэн хүн ийм ном байдгийг хүмүүсийн сэм цуу яриагаар л олж мэднэ. Ярихгүй байж л болдог юм бол Намын жирийн гишүүн Ах дүүгийн барилддага, тэр ном хоёрын аль алины нь ч дурдах ёсгүй.

Үзэн Ядалтын хоёр дахь секундэд хүмүүс суудлаасаа босон харайж дэлгэцнээс гарах хилэнтэй майлах дууг дарах гэж орилолдон солиорцгоолоо. Цайвар үстэй жижигхэн хүүхний нүүр нь час улайгаад ам нь уснаас гаргасан загасны ам шиг үе үе ангалзаж байхад Обрайэний том нүүр хүртэл улайжээ. Обрайэн

сандад дээр цээжээ түрэн суух бөгөөд хүчирхэг өргөн цээж нь далайн давалгааг сөрөн зогсож буй мэт оволзож байлаа. Смитийн арын хар үстэй бүсгүй “Гахай!, Гахай! Гахай!” гэж орилоод Шинхэлийн зузаан толь номыг шүүрэн авч дэлгэц рүү чулуудахад тэр нь Голдштейний хамрыг цохиод газар уналаа.

Смит нэг мэдэхнээ өөрөө ч бас хар байдгаараа орилон хөлийнхөө өсгийгөөр санддын хөлийг тийрч байлаа. Хоёр минут Үзэн Ядалтын айдас төрүүлмээр юм нь хүн бүр түүнд гар биеэрээ заавал оролцох ёстойд бус харин түүнд оролцохгүй байх ямар ч арга үгүйд оршино. Гучин секунд болоход үүнд оролцохгүй мэт дүр үзүүлээд нэмэргүй. Хүний амь насыг нь бүрэлгэх, тарчлаан зовоох, нүүрийг лантуудан хэмх цохих айдас, залхаан цээрлүүлэлтийн зүрх зүсэм хар хөөрөл эдгээр хүмүүсийн биеэр тогшиг гүйж тэд өөрсдөө ч юу хийж байгаагаа мэдэлгүй галзуурч,орилж чарлаж нүүр амаа ярвагануулдаг. Тэхдээ хэн хүний тэрхүү их хийсвэр, эрээ цээргүй сэтгэл хөддөлийн

хийрхэл дэлбэрсэн чийдэн шиг нэг юмнаас нөгөөд дамждаг юм. Энэ хоромд Смитэд Голдштейнийг ерөөсөө үзэн ядах сэтгэл төрдөггүй, харин ч Их Ах, Нам, Сэтгэхүйн Цагдааг үзэн яддаг бөгөөд сэтгэл санаа нь дэлгэц дээр гарч байгаа ганцаардмал, шоовдорлогдсон тэрсүү үзэлтэн, үнэний цорын ганц хамгаалагч, худал хуурмагийн ертөнц дундах эрүүл саруул ухаан болсон тэр хүн рүү татагддаг билээ. Тэгсэн мөртлөө дараагийн хоромд Смит хажуудаа байгаа хүмүүстэй санал нийлж Голдштейний тухай ярьсан бүх юм түүнд чин үнэн юм шиг санагдана. Ийм үед Их Ахыг жигших Смитийн далд сэтгэл нь түүнийг бишрэх сэтгэлээр солигдоод Их Ах Азийн сүрэг дээрэмчдийг сөрөн зогсож буй хад хясаа, ялагдашгүй, аюумшиггүй хамгаалагч болон торойн гарч ирэхэд нөгөөх Голдштейн нь хэдийгээр ганцаардмал, өрөвдмөөр боловч түүний оршин тогтнож буйд төрсөн эргэлзээ нь соёл иргэншлийг ганцхан дуу хоолойгоороо нураан эвдлэх хар нүгэлт илбэчин шиг санагдуулна.



Зарим үед үзэн ядах сэтгэлээ өөрөө мэдэн нэг юмнаас нөгөө юманд шилжүүлж ч болдог юм. Смит хар дарсан зүүдэндээ толгойгоо дэрэн дээрээ ийш тийш нь савлаж байгаа юм шиг дэлгэц дээрх хүний нүүрийг жигшин зэвүүцэхээ больж ардаа суугаа хар үстэй бүсгүйг үзэн ядаж байлаа. Смитийн ой ухаанд нэг сайхан хурц тод хий үзэгдэл орж ирээд тэрээр бүсгүйг нүцгэлээд эрзээнэн бороохойгоор үхтэл нь ташуурдана, нүцгэнээр нь шонд хүлээд Гэгээн Себастиан шиг нум сумаар бүх биеий нь нэвт харвана, тэгээд төгсгөлд нь хүчиндэж хоолойг нь тас огтолно. Тэр бүсгүй залуухан, аятайхан мөртлөө дур тачаал татдаггүй тул Смит түүнийгжигшдэг. Смитэд бүсгүйн нарийхан бүсэлхийг тэврээд авмаар санагддаг боловч бэлгийн харилцаанд үл орох бэлгэ тэмдэг болох час улаан өнгөтэй ой гутам бүс бүсэлсэн тул түүнтэй хэзээ ч унтахгүй.

Голдштейний хоолой хонь майлах дуугаар солигдож нүүр нь хонины толгой болж хувирахад Үзэн Ядалтын хийрхэл дээд цэгтээ

хүрлээ. Тэгээд нөгөөх хонины толгойн дүрс үй түмээрээ аюумшигтай урагшлан давшиж буй Евразийн Гүрний цэргүүдийн дүрд уусаж бууны дуу тачигнан цэргүүд дэлгэцнээс үсрэн гарч ирэх шиг болоход урд эгнээнд суусан хүмүүс ар тийшээ гэдийв. Харин энэхэн хоромд дайсны дүр хар үстэй, хар сахалтай, эрч хүч, нэг л далд тайван дэлгэцээр дүүрэн Их Ахын асар том нүүрэнд уусан алга болоход хүн бүр санаа алдан тайвширав. Их Ах юу хэлж буйг хэн ч сонссонгүй. Түүний үг нь байлдаан тулалдааны галын дунд хашгиран хэлдэг урам зориг оруулсан гэхдээ юу хэлж буй нь тод бус боловч итгэл төрүүлсэн үг байв. Дараа нь Их Ахын нүүрний дүрс алга болж Намын уриа гурван лоозон том үсгээр гарч ирлээ.

*ДАЙН БОЛ ЭНХ ТАЙВАН*

*ЭРХ ЧӨЛӨӨ БОЛ БООЛЧЛОЛ*

*ҮЛ МЭДЭХ НЬ ХҮЧ*

Хүн бүрийн нүдний алиманд үлдсэн дүр тийм амархан алга болохгүй мэт Их Ахын нүүрний дүр дэлгэц дээр хэдэн секунд хадгалагдах шиг боллоо. Цайвар үстэй жаахан хүүхэн урдах санддынхаа түшлэг дээгүүр тонгойгоод хоёр гараа дэлгэц рүү сарвайн “Авралт тэнгэр” минь гэж байгаа бололтой хоолой нь чичрэн амандаа үглэснээ алгаараа нүүрээ хаагаад залбирч байх шиг болов.

Энэ агшинд тэнд байгаа бүх хүн “И-А... И-А” гэж үгээ зөөн дэлгэцнээс гарч буй нүцгэн хөлийн газар дэвсэх, бамбарын нэгэн хэмнэлт нүдэлтийг давтан маш алгуурхан “И” гэж давтан давтан үглэх нь гайхмаар зэрлэг аж.

Хүмүүс магадгүй гучин секунд үүнийгээ зогсолтгүй үглэх нь сэтгэлийн хөдөлгөөнөө тэвчих гэсэн оролдлого байв. Нам нь Их

Ахын мэргэн ухаан, цог жавхлангийн нэгэн ёсны сүлд дуулал нь мөн боловч энэ нь нэгэн хэмнэлтэй дууны чимээгээр ухаан санаагаа

зориуд мартах, өөрийгөө ховсдох үйлдэл бас мөн байлаа. Смит Хоёр минут үзэн Ядалтын хийрхэлд оролцохгүй байж чаддаггүй ч гэсэн “И- А” гэж хүмүүний бус дуу дуулахад айдас төрдөг бөгөөд одоо ч дотор нь эвгүй болж байлаа. Тэрээр мэдээжээр бусдын адил дуулж байсан, дуулахгүй байх арга ч байхгүй юм. Бодол санаагаа ил гаргахгүй байж царайгаа хувиргахгүйгээр бусад хүн бүрийн хийж байгаа юмыг давтан хийх нь зөнгөөрөө гардаг үйлдэл байв. Нүднийх нь харц хэдхэн агшинд магадгүй өөрийг нь илчилсэн байж болох ба чухамхүү энэхэн агшинд л маш чухал ач холбогдол бүхий юм болсон, үнэхээр болсоон.

Обрайэн босож зогсоод дадсанаараа нүднийхээ шилийг хамрынхаа үзүүрт зүүх гэж байх тэрхэн хоромд Смитийн харц түүний харцтай тулгарав. Тэдний харц хоромхон зуур тулгарах тэрхүү хоромд л Смит Обрайэн өөртэй нь адилхан юм бодож байна гэдгийг *Мэдсэн!* Тэдний оюун ухаан нь нээгдээд бодол нь нүдээрээ дамжин бие бие рүүгээ шилжиж байгаа юм шиг хоёр

биеэ яриангүй ойлголоо. Обрайэн “Би чамтай хамт шүү, Би чиний жигшил зэвүүцэл, үзэн ядалт, эгдүүцэл дургүйцдийг бүгдийг мэднэ. Би чиний үзэл боддыг сайн мэднэ. Тэхдээ чи санаа зовох хэрэггүй. Би чамтай санаа нэг байна!” гэж хэлж байх шиг байлаа. Гэтэл нөгөөх түр зуурын бодол нь гэнэт алга болоод Обрайэний нүүр бусдын нүүрнээс ялгагдахаа болив.

Ингээд л бүх юм дуусчихлаар Смит ийм юм болсон гэдгийг баттай мэдэхээ больчихсон байв. Ийм тохиолдлуудад үргэлжлэл гэж байдаггүй болохоор тэдгээр нь Смитэд өөрөөс нь бусад хүн бүр Намын дайснууд гэдэг итгэлийг, магадгүй найдварыг алдагдуулахгүй байлгадаг юм. Нууц байдалд асар их хуйвалдаан байна гэсэн цуу яриа эцсийн бөлөгт үнэн, байж магадгүй Ах дүүгийн барилдлага үнэхээр оршин тогнож байгаа! Зогсоо зайгүй баривчилгаа, хэргээ хүлээх болон ялын шийдвэр хэдийгээр гарсаар байгаа боловч Ах дүүгийн барилдлага гэдэг байгууллага бий гэдэг нь хоосон домог яриа гэж

баттай хэлэх боломжгүй юм. Смит заримдаа үүнд итгэнэ заримдаа үүнд үл итгэнэ.

Энэ талаар ямар нэг ач холбогдолтой байж болох, аль эсвэл ямар ч ач холбогдолгүй зэрвэсхэн дохио сураг, тухайлбал хүний ярианы дундаас санамсаргүй дуулсан үг, жорлонгийн ханан дээр сараачсан хэдэн үг, тэр ч байтугай нэг удаа үл таних хоёр хүн уулзахдаа гараа нэг л сэжигтэй хөдөлгөсөн нь бие биеэ таних дохио байж магадгүй юм шиг байснаас өөр баримт нотолгоо байхгүй. Энэ бүхэн бол зөвхөн таамаглал. Смит энэ бүхнийг санаанаасаа зохиосон байж таарах нь. Смитэд Обрайэнтай нэгэн агшинд тогтоосон холбоогоо цааш нь үргэлжлүүлэх бодол бараг төрсөнгүй. Үүнийгээ хэрхэн хийхээ мэдээд ингэлээ гэхэд тэр нь тун аюултай зүйл байх байсан тул Смит Обрайэн руу харалгүй бүхээг рүүтээ зүглэв. Тэр хоёр бие биеэ зэрвэсхэн харснаар энэ явдал дуусгавар боллоо. Гэлээ ч гэсэн хэн хүн ганцаардмал байдалд аж төрөхөөс өөр аргагүй нөхцөлд энэ бол мартагдашгүй үйл явдал байлаа.

Уусан жин нь ходоодыг нь халааж эхэлсэн тул Смит сандал дээрээ эгц суугаад эвшээлгэв. Тэрээр хуудас цаасандаа дахин анхаарлаа хандуулав. Тэрээр бодолдоо автан дэмий сууж байхдаа аяндаа л нэг юм бичсээр байсан аж. Харин түүний үсгийн хэлбэр нь өмнөх шиг муруй тахир, болхи байсангүй. Түүний үзэг толигор цаасан дээгүүр чөлөөтэй гүйж том үсгээр нямбай бичиж гарваа:

*ИХ АХ СӨНӨТҮГЭЙ*

*ИХ АХ СӨНӨТҮГЭЙ*

*ИХ АХ СӨНӨТҮГЭЙ*

*ИХ АХ СӨНӨТҮГЭЙ*

*ИХ АХ СӨНӨТҮГЭЙ*

гэж дахин дахин бичсээр тал хуудас дүүргэв.

Чухамхүү ийм үгүүдийг бичих нь өдрийн тэмдэглэл хөтөлж эхэлснээс ч илүү аюултай байсан тул энэ нь мунхаг хэрэг байлаа. Тэгээд ч Смит сандарч тэвдэхгүй байж чадсангүй. Тэрээр одоо бол нөгөөх бичигтэй хуудсаа тасдаж ураад бичихээ больмоор байлаа.

Ингэх нь ямар ч ашиггүй гэдгийг мэддэг болохоор тэрээр харин ингэсэнгүй.

Тэрээр ИХ АХ СӨНӨТҮГЭЙ гэж бичсэн ч, бичихээ больсон ч ямар ч ялгаа байхгүй. Тэрээр өдрийн тэмдэглэлээ хөтөлсөн ч, хөтлөөгүй ч ямар ч ялгаа байхгүй юм. Сэтгэхүйн Цагдаа ямар ч л байсан түүнийг баривчлах болно. Тэрээр энэ бүхнийг агуулсан гол гэмт хэргийг үйлдчихсэн, цаасан дээр юм бичээгүй байсан ч үйлдэх л байсан. Тэд үүнийг сэтгэхүйнгэм гэдэг юм. Сэтгэхүйнгэм гэдэг бол хэзээ ч нуун дарагдуулж болдоггүй юм. Чи үүнийгээ нэг хэсэгтээ, хэдэн жилээр ч нууж болно гэхдээ л эрт орой хэзээ нэгэн цагт чи баригдах л болно.



Баривчилгыг шөнөөр, заавал шөнөөр хийдэг. Унтаж байхад чинь гэнэт мөрнөөс чинь угз татаж сэрээгээд л нүдэн дээр чинь хурц гэрэл тусгаад л ширүүн харцтай бөөн хүн орны чинь дэргэд зогсож байдаг юм. Олонхи тохиолдолд ямар ч шүүх хурал болохгүй, баривчилсан тухай ямар ч мэдээ сонсогдохгүй ээ. Хүмүүс ихэнх тохиолдолд шөнөөр алга болно. Нэрийг чинь бүртгэлээс хасаад хаячихсан, чиний хийсэн юм бүхний ул мөрийг арилгачихсан, чамайг хэзээ нэг цагт байсан гэдгийг чинь үгүй болгоод чамайг мартагдуулчихсан байдаг. Чамайг устгачихсан, сөнөөчихсөн байдаг. Үүнийг хэлдэг жирийн үг нь *ууршуулчихсан* гэдэг юм.

Смит энэхэн агшинд хийрхэлд автагдаад муруйлган бичиж эхлэв ээ.

*Тэд нар намайг буудна л биз тэр ямар хамаатай юм, тэд нар миний дагз руу буудна биз ямар хамаатай юм. Их Ах сөнөтүгэй, тэд нар миний дагз руу буудна биз ямар хатаатай юм. Их Ах сөнөтүгэй,*

Смит жаахан ичингүйрэн сандал дээрээ эгц суугаад үзгээ хажуу тийшээ тавьтал хаалга цохих дуу сонсдоход тэрээр маш ихэд сандрав.

Хүрээд ирчихлээ гэж үү! Тэрээр хаалганы цаана байгаа хүн хаалга цохичихоод л яваад өгч магадгүй гэж хий дэмий найдан айсан хулгана шиг чив чимээгүй суутал хэн нэгэн хаалга цохисоор байна. Хаалгаа онгойлгохгүй удах нь хамгийн осолтой хэрэг юм. Смитийн зүрх нь бөмбөр дэлдэлт шиг луг луг цохилох боловч царай нь олон жилийн дадалдаа дулдуйдан хувирч өөрчлөгдсөнгүй бололтой. Тэрээр суудлаасаа босож хаалга руу хөлөө чирэн алхлаа.

## II

Смит хаалганыхаа түгжээг онгойлгох гэж байхдаа өдрийн тэмдэглэлийн дэвтрээ хамхилгүй ширээн дээр орхисноо харав. ИХ АХ СӨНӨТҮГЭЙ гэсэн хуудсан дээрх бичээс нь өрөөний үүднээс ч харагдахаар том харагдана. Ингэж дэвтрээ орхисон нь толгойд багтамгүй тэнэг хэрэг байлаа. Гэлээ ч гэсэн тэрээр сандарч тэвдэж байхдаа ч бэх нь хатаж амжаагүй байхад нь толигор цаасаа балиартуулах бодолгүй байсан гэдгээ сая ухаарлаа.

Тэрээр амьсгаагаа бариад хаалгаа онгойлгоод сэтгэл нь ихэд уужрав. Үүдэн дээр зэвхий царайтай, шингэн үстэй, үрчлээтэй нүүртэй ядрангуй хүүхэн зогсож байлаа.

“За нөхөр минь” гэж тэрээр гоншигноод “Би чамайг орж ирж байгааг дуулах шиг болсон юм. Чи очоод манай гал зуухны өрөөний угаагуурыг үзээд өгнө үү. Бөглөрчихөж ээ, тэгээд” гэв.

Энэ эмэгтэй бол нэг давхрынх нь хөрш Хатагтай Парсонс байлаа. (Нам “Хатагтай” гэдэг үг хэрэглэхийг зохимжгүй гэж үздэг, хүн бүрийг “нөхөр” гэж дуудах ёстой, харин зарим эмэгтэйн хувьд хэн нэгэн санамсаргүй ингэж дуудах явдал бий) Тэр эмэгтэйн нүүрний үрчлээсэнд тоос шингэсэн юм шиг сэтгэгдэл зарим хүнд төрдөг бөгөөд тэрээр гуч эргэм настай боловч их хөгшин харагддаг юм. Виктор орон сууцны байшин нь 1930-аад оны үед баригдсан ба нурж эвдэрч байгаа болохоор бараг өдөр тутам гардаг засварын ажил нь ядаргаатай аж. Хана дээврийн шавар нь дандаа унаж, хүйтрэх бүрт усны хоолойнууд нь хагарч, цас орохоор дээвэр нь гоожиж, эдийн засгийн хэмнэлт гаргах шалтгаанаар бүрмөсөн хаачихаагүй л бол дулааны паар нь хагас дутуу ажиллаж байдаг. Өөрийнхөө хүчээр хийж чадахаас бусад засварын ажлыг хаа нэг газар байдаг хорооны зөвшөөрлөөр хийдэг ба тэдгээр нь цонхны раамын засварыг хоёр жил хүртэл хүлээлгэж байж хийдэг юм.

"Том гэртээ байхгүйгээс л ийм юм болчихлоо" гэж Хатагтай Парсонс үглэнэ.

Парсонсынхны байр нь Смитийнхээс том, гэхдээ ямар нэг зэрлэг догшин араатан дөнгөж саяхан дайраад гарсан юм шиг бүх юм нь энд тэндээ хонхойчихсон, цөм цохичихсон, эвдэрч хэмхэрсэн балиар заваан харагдана.

Тоглоомын хэрэгслүүд болох хоккейн түлхүүр, боксын бээлий, хагархай бөмбөг, эргүүлчихсэн хөлстэй богино өмдийг шалан дээгүүр энд тэнд тарааж хаясан байна. Ширээн дээр заваан хоолны үлдэгдэл, хуудасны үзүүр нь нугларчихсан дасгалын дэвтрүүд байна. Ханан дээр Залуучуудын Холбоо ба Тагнуулчдын час улаан дарцаг, Их Ахын бүтэн зураг бүхий зурагт хуудас өлгөөстэй байна. Өрөөнд нөгөөх бүх л байшинд тарсан чанасан байцааны үнэр, тэхдээ анх удаа үнэртэхэд л андашгүй мөртлөө яагаад ийм үнэр гарч буйг нь хэлэхийн аргагүй хамар цоргиулсан биеийн хулмасны хурц үнэрээр хачирласан, одоо энд байхгүй хэн нэгэн хүний

үнэр ханхалж байлаа. Хажуугийн өрөөнд хэн нэгэн хүн теледэлгэцнээс гарч буй цэргийн хөгжмийн хэмнэлийг дагалдан үсний сам, ариун цэврийн цаасны тасархайгаар товшиж байна.

“Хүүхдүүд тоглож байна. Эд нар өнөөдөр гадаа гараагүй юм. Тэгээд л” гэж Хатагтай Парсонс нөгөө өрөө рүү эмээсхийн харж хэллээ.

Тэрээр үгээ тасалж ярьдаг зуршилтай болсон хүн. Гал зуухны угаагуур байцааныхаас ч бүр муухай үнэртэй балиар зэвтэй усаар дүүрчихсэн байх бөгөөд ус нь савнаасаа хальж асгарах гэж байна. Смит доошоо бөхийгөөд усны хоолойны углуургыг шалгаж байв. Тэрээр тонгойхдоо ханиалгадаг болохоор тонгойх, гараараа юм хийх дургүй юм. Хатагтай Парсонс аргаа барсан байдалтай түүний араас харж зогсоно.

“Том гэртээ байсан бол үүнийг дор нь хийчих нь. Тэр чинь ийм юм хийх дуртай, Томын гар нь их дүйтэй шүү” гэж тэрээр ярьж байлаа.

Парсонс бол Смиттэй Үнэний Яаманд хамт ажилладаг ажилтан. Мань эр бол бүдүүвтэр биетэй үнэхээрийн мулгуу, хэнд ч хэрэггүй бөөн идэвх зүтгэл гаргагч, Намын тогтвортой байдал Сэтгэхүйн Цагдаагаас ч илүү тэдний үг дуугүй, үнэнч үйл ажиллагаанаас нь хамаарч байдаг тийм хүмүүсийн нэг билээ. Тэрээр гучин таван настайдаа Залуучуудын Холбооноос аргагүйн эрхэнд хөөгдсөн,

Залуучуудын Холбоонд элсэхийн өмнө Тагнуулчдын эгнээнд нэг жил гаруй нас хэтрүүлэн үлдэж чадсан аж. Тэрээр Яаманд тагнуулын ажлын ямар ч хэрэгцээ байхгүй аль нэг захиргааны албан тушаалд ажилладаг, гэхдээ Спортын Хороо болон хөдөөний аялал, шуурхай жагсаал цуглаан, хэмнэлт гаргах кампанит ажил, бусад сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулдаг хороодын тэргүүлэгч гишүүн юм. Тэрээр сүүлийн таван жилийн туршид орой бүр Нэг нутгийнхний Төвд тасралтгүй ажилласан гэж гаансныхаа утааг сорох завсраа бардамнан ярина. Түүнийг

хаа ч явсан, тэр ч байтугай яваад өгсөн хойно нь ч эрч хүчтэй амьдралынх нь шалгуур болсон хамар нэвт үнэртсэн хулмас нь ханхална.

Смит усны хоолойн углуургын эргийг гараараа эргүүлэх гэж оролдоод "Түлхүүр байна уу?" гэж асуув.

"Түлхүүр ээ, Байхгүй байхаа даа, Магадгүй хүүдүүдэд" гэж Хатагтай Парсонс гэмгүй царайлан хэллээ.

Чанга дэвсэх хөлийн чимээ, самаар чанга тогших дуу гараад хүүхдүүд зочны өрөөнд харайж орж ирлээ. Хатагтай Парсонс түлхүүр авчирч өгөхөд Смит усны хоолойд бөглөрсөн хүний туг үсийг гаргаж усыг нь гоожуулаад хүйтэн усанд гараа аль болохоор сайн угааж нөгөө өрөөнд орлоо.

"Гараа өргө!" гэж жаал хүү урдаас нь зэрлэг дуугаар ориллоо.



Есөн настай царайлаг, ширүүн зантай бололтой хүү ширээний араас үсрэн гарч ирээд тоглоомон автомат гар буу гаргахад түүнээс хоёр нас дүү бололтой эмэгтэй модны тасархайгаар хийсэн буугаа гартаа барьжээ. Тэр хоёр хоёулаа цэнхэр богино өмд, саарал цамц өмсөж Тагнуулчдын дүрэмт улаан хүзүүний ороолт зүүсэн аж. Смит эвгүйрхэн гараа өргөхөд хүүгийн царай хорлонтой харагдаад энэ нь зүгээр нэг тоглоом шоглоом биш байв.

“Чи бол урвагч! Чи бол сэтгэхүйн гэмт этгээд! Чи Евразийн Гүрний туршуул! Би чамайг ууршуулна, Би чамайг давсны уурхайд цөлнө!” гэж хүү улангасан орилж байв.

Тэд хоёулаа “Урвагч!”, “Сэтгэхүйн гэмт этгээд!” гэж орилон Смитийг тойрон гүйлдэхэд жаахан охин дүү нь ахынхаа хөдөлгөөн бүрийг давтан хийж байлаа. Энэ нь удахгүй хүн иддэг махчин амьтан болж өсөх барын бамбарыг өдөж байгаа юм шиг жаахан айдас төрүүлж байв. Хүү Смитийг ширүүн догшин нүдээр хараад цохиод

авах ч юм уу, цохиод унагах гэж улайран дайрч өөрийгөө яриангүй том болсон гэж бодож байгаа нь илт байлаа. Смит гар дахь гар буу нь жинхэнэ буу биш нь яамай даа гэж бодож байлаа.

Хатагтай Парсонсын зүрхшээсэн харц нэг Смит дээр, нэг хүүхдүүд дээр тусаж байхад зочны өрөөний тод гэрэлд түүний нүүрний үрчлээнд үнэхээр тоос тогтсон байхыг Смит анзаарав.

“Эд нар хүн дүүжлэхийг харахаар гарч чадахгүй байгаадаа урамгүй байгаа юм. Үүнээс л болоод байгаа юм. Надад эд нарыг дагуулж явах зав байдаггүй. Томын ажил цагтаа тарахгүй. Тэгээд л шуугилдаад байна” гэж тэр эмэгтэй хэллээ.

“Бид яагаад хүн дүүжлэхийг үзэж болдоггүй юм бэ?” гэж жаал хүү бүдүүн дуугаар орилж байлаа.

“Бид хүн дүүжлэхийг хармаар байна!, Бид хүн дүүжлэхийг хармаар байна!” гэж нөгөөх жаал охин гүйсээр хашгирч байна.

Тэр орой дайны гэмт хэрэг үйлдсэн Евразийн Гүрний олзлогдогсдыг нийтийн цэцэрлэгт дүүжлэнэ гэдгийг Смит саналаа. Хүн дүүжлэх ажиллагаа сар тутам болдог, хүмүүс ч үзэх их дуртайгаас гадна хүүхдүүд үүнийг үзэх гэж их л хөөрдөг юм. Смит Хатагтай Парсонсоос салж гараад шатаар хэдхэн алхам доош буутал ар шил рүү нь улайсгасан төмрөөр хатгах шиг нэг юм хүчтэй хатгахад нь эргээд хартал Хатагтай Парсонс чавхаар харваж буй хүүгээ чирэн хаалгаар орж байгаа нь харагддаа.

Жаал хүү хаалга хаагдаж байх агшинд “Голдштейн!” гэж хашгирахад эхийнх нь зовуурьтай царайд аргаа барсан айдас барайж байгааг Смит гайхан харлаа.

Смит гэртээ орж ирээд теледэлгэцийн хажуугаар хурдан алхаж өнгөрөөд хүзүүгээ

нухсаар ширээнийхээ ард дахин суулаа. Теледэлгэцээс гарах хөгжим зогсчихсон, цэрэг эр чанга дуугаар Исланд ба Фарос арлын хооронд дөнгөж сая далайд тавьсан Хөвдөг Цайзны зэвсэглэлийг ихэд бахархан тоочиж байлаа.

Смит ийм хүүхдүүдтэй хөөрхий тэр эмэгтэйн амьдрал ч айдаснаас салахгүй дээ гэж бодож байлаа. Нэг хоёр жилийн дараа тэд эхийгээ тэрсүү үзэл гаргах нь уу гэж өдөр шөнөгүй харуулдах болно. Одоо бараг хүүхэд бүр айдас төрүүлдэг болжээ. Тагнуулчдын байгууллага шиг байгууллагын үйл ажиллагааны нөлөөгөөр хүүхдүүдийг ямар ч захиргаагүй жижиг зэрлэг амьтад болгож хувиргасан боловч тэдэнд Намын сахилга батыг эсэргүүцэх хандлагыг бий болгосонгүй. Харин ч тэд Нам, түүнтэй холбоотой бүх юмыг бишрэн шүтэж байдаг. Тэдний хувьд ялгуусан үйл ажиллагаа бол дуу дуулцгаах, жагсаал хийх, туг дарцаг мандуулах, аяллаар явах, модон буу үүрэн сургууль хийх, лоозон үг хашгирах, Их Ахыг шүтэн бишрэх

явдал юм. Тэдний эрч хүч гадагшаа тухайлбал, Төрийн дайсан, гадаадынхан, урвагчид, хорлон сүйтгэгчид, сэтгэхүйн гэмт хэрэгтнүүдийн эсрэг чиглэж байна. Гуч гарсан хүмүүс хүүхдүүдээсээ айж эмээх нь жирийн хэрэг болжээ. Бараг долоо хоног бүр нийтээрээ хэрэглэдэг үгээр “бяцхан баатар” аав ээжийнхээ тэрсүү яриаг сэм чагнаад Сэтгэхүйн Цагдаад мэдээлсэн тухай мэдээ *Таймс* сонинд гардаг тул ингэх нь ч аргагүй юм.

Смитийн шилэнд үлдсэн чавхны сумны хонхорхой өвдөхөө зогссон болохоор тэрээр үзгээ аваад өдрийн тэмдэглэлдээ юу бичдэг билээ гэж шийдэж ядаж байтал Обрайений тухай бодол толгойд нь дахин орж ирлээ

Хэдэн жилийн өмнө, хичнээн жилийн өмнө билээ? Долоон жилийн өмнө болсон байх ёстой, тэрээр тас харанхуй өрөөн дотор явж байна гэж зүүдэлсэн юм. Хажуу талд сууж байсан хэн нэгэн дэргэдүүр нь өнгөрөхөд “Чи бид хоёр гэрэл гэгээтэй хаа нэг газар уулзах болно” гэж тун аяархан, зүгээр л хэлсэн, энэ бол "тушаал бус

мэдэгдэл байсан. Смит сааталгүй явж өнгөрсөн билээ. Тэрхэн агшинд зүүдэн дунд энэ үг түүнд ямар нэг сэтгэгдэл төрүүлээгүй нь сонин юм. Харин сүүлд аажим аажмаар энэ үг чухал юм шиг санагддаг болсоон. Энэ бодол нь Обрайенийг анх харсан зүүд зүүдэлснээс өмнө үү, хойно уу, аль эсвэл Обрайений дуу хоолойг таньж мэдсэн цагаас уу гэдгээ санахгүй байна. Харанхуйд ярьсан хүн бол Обрайен яриангүй мөн байсан гэдгийг юутай ч мэддэг болсон юм.

Смит Обрайен бол дайсан, аль эсвэл нөхөр гэдгийн алинд нь ч баттай итгэж чадахгүй байна, өнөө өглөөний харц тулгарсан агшнаас хойш ч баттай итгэж чадахгүй байлаа. Энэ бүхэн ач холбогдолгүй ч юм шиг санагдана. Харилцан хүндэтгэл, түншлэлээс ч илүү тэр хоёрын хооронд ойлголцлын холбоо сүлжээ байна. “Чи бид хоёр гэрэл гэгээтэй хаа нэг газар уулзах болно” гэж тэрээр хэлсэн. Смит энэ нь чухам юу гэсэн үг вэ гэдгийг ойлгоогүй ч гэсэн ямар ч гэсэн энэ биелэгдэнэ гэдгийг мэдэж байлаа.

Теледэлгэцийн дуу түр нам болоод бүрээ бишгүүрийн цангинасан дуу хадаж нэвтрүүлэгч чухарсан хоолойгоор уншиж байна.

“Анхаараарай! Анхаарна уу! Малабарын фронтоос дөнгөж сая мэдээ ирлээ. Манай зэвсэгт хүчин ялгуусан ялалт байгууллаа. Бидний мэдээлж буй энэхүү ажилбар дайны төгсгөлийг тодорхой хугацаанд авчрах болно гэдгийг би бүрэн эрхийнхээ дагуу мэдэгдэж байна. Одоо мэдээг бүрнээр нь”

Смит муу юм дуулах нь дээ гэж бодож байлаа. Үнэхээр тийм шүү гэсэн шиг Евразийн Гүрний алагдсан, олзлогдсон цэргүүдийн асар их тоог үзүүлж ялгуусан ялалт байгуулсан тухай мэдээлсний дараа ирэх долоо хоногоос хүн бүрт ногдох шоколадны хэмжээг 30 граммаас 20 грамм болтол багасгах болсон тухай зарлав.

Смит дахин хэхрүүлээд уусан жин нь гарч эхэллээ. Теледэлгэц, магадгүй ялалтаа тэмдэглэх гэж, магадгүй хасагдсан шоколадыг

мартагдуулах гэж, “Далайн Гүрэн минь”, “Бид эх орныхоо төлөө” гэсэн дуу сүрлэгээр хангинаж эхэллээ. Энэ дууг дуулахад хүн бүр босож номхон зогсох ёстой боловч Смит одоогоор хэнд ч харагдахгүй сууж байна.

“Далайн Гүрэн минь”, “Бид эх орныхоо төлөө” дуу хөнгөн хөгжмөөр солигдоход Смит сууддаасаа босож теледэлгэцэд нүүрээ харуулалгүй явсаар цонхныхоо дэргэд очив. Тэнгэр цэлмэг, жихүүн, алсад хаа нэг газар бөмбөг унаж тэсрэлтээс чих дүлийрэм дуу гарч байна. Одоо Лондон хотод долоо хоногт гуч дөчин бөмбөг унадаг болсон.

Гудамжны адагт самбарын үзүүр урагдаж дэрвэлзээд АНГСОЦ гэсэн үг нэг харагдаад нэг алга болж банна. Ангсоцын арнун нандин зарчим бол Шинхэл, хоёрсэтгэх, өнгөрснөө өөрчлөх явдал юм. Смитэд далайн ёроол дахь ой модон дотор тэнэж явна, мангас болчихоод аюумшигтай муухай ертөнцөд хаягдчихсан юм шиг санагдаж байна. Тэрээр гав ганцаараа



байна, өнгөрсөн бүх юм арилчихсан, ирээдүйг төсөөлөх арга алга. Өөрийнх нь талд нэгэн амьд хүн байна гэдгийг тэрээр хэрхэн баттай мэдэж байгаа юм бэ? Намын ноёрхол *мөхөшгүй биш* гэдгийг мэдэх арга байна уу? Үүний хариулт мэтээр Үнэний Яамны байшингийн нүүрэн дээрх гурван лоозон дахиад санагддаа.

*ДАЙН БОЛ ЭНХ ТАЙВАН ЭРХ*

*ЧӨЛӨӨ БОЛ БООЛЧЛОЛ*

*ҮЛ МЭДЭХ НЬ ХҮЧ*

Нэг талд нь жижигхэн тод үсгээр эдгээр гурван лоозонг сийлбэрлэсэн, нөгөө талдаа Их Ахын толгойн дүрстэй хорин таван центийг Смит халааснаасаа гаргаж ирлээ. Их Ахын нүд зоосон дээрээс ч чамайг харж байна. Бүх юман дээр, зоосонд ч, номын хавтсанд ч, туг дарцаг дээр ч, янжуурын хайрцаг дээр ч энэ дүр бий. Чамайг унтаж байсан ч, сэрүүн байсан ч, ажлаа хийж байсан ч, хоолоо идэж байсан ч, гэртээ байсан

ч, гадаа явж байсан ч, орондоо хэвтэж байсан ч, усанд орж байсан ч түүний нүд чамайг үргэлж харж, дуу хоолой нь үргэлж дуулдана. Тэхлээр үүнээс зугтаж зайлах арга байхгүй ээ. Чамд гавал доторх хэдэн шоо дөрвөлжин сантиметрээс бусад өөрийн гэх юм байхгүй.

Нар жаргах тийшээ хандаад Үнэний Яамны байшингийн тоо томшгүй олон цонхон дээр гэрэл тусахаа больмогц тэдгээр нь харанхуй ой доторх ойн цоорхой шиг уйтгартай харагдаж байна. Яамны аврага том сувраган байшинг хараад Смитийн зүрх түгшиж байна. Энэ байшин хэтэрхий бат бэх, дэлбэлж дийлэхгүй, хэдэн мянган бөмбөг ч нурааж чадахгүй.

Тэрээр би хэнд зориулан энэ өдрийн тэмдэглэлийг хөтөлж байгаа билээ гэж дахин бодож байлаа. Ирээдүйд үү, өнгөрсөн үедээ зориулж байна уу, төсөөлж буй эрин зуунд уу. Өмнө нь үхэл бус харин хүйс тэмтрэл харагдана. Өдрийн тэмдэглэлийг шатааж өөрийг чинь ууршуулна. Тэмдэглэсэн юмыг нь устгаж хүний

ой тойноос арчиж арилгахын өмнө Сэтгэхүйн Цагдаа л түүнийг унших болно. Өөрийн чинь ул мөр, цаасны тасархай дээр нэр нь үл мэдэгдэх хүний бичсэн үг хүртэл үлдэж хоцрохгүй болохоор чи яаж ирээдүйд хандах вэ?

Теледэлгэцийн цаг арван дөрөв болох гэж байна. Смит арван дөрвөн цаг гэхэд ажил дээрээ байх ёстой тул арван минут болоод гэрээсээ гарах хэрэгтэй болно.

Гайхмаар нь цагийн зүүний цохилт Смитийг зоригжуулах шиг болов. Тэрээр хэн ч хэзээ ч дуулж байгаагүй үнэнийг хэлж буй ганцаархан сүнс юм. Тэрээр үнэнийг хэлж л байгаа цагт энэ дэлхийд юу ч тасалдахгүй. Энэ нь өөрийнхөө үгийг дуулгахдаа бус харин эрүүл саруул ухаантай байж л чи хүний өвийг хадгалж чадна. Смит ширээ рүүгээ очоод үзгээ дүрээд бичиж эхлэв.

*Ирээдүйд ч бай, өнгөрсөн үед ч бай, сэтгэхүй чөлөөтэй байх тэр цагт, хүн хүнээсээ өөр*

*байж, ганцаардахаа болих цагт-үнэн оршиж,  
байсан юмыг байхгүй болгодоггүй тэр цагт.*

*Нэг хэвийн эринээс, ганцаардлын эринээс, Их  
Ахын эринээс, хоёрсэтгэхүйн эринээс мэнд  
дэвшүүлье!*

Тэрээр би аль хэдийн үхдэл болчихсон гэж бодож байлаа. Өөрийнхөө бодлыг илэрхийлж эхэлснээс л шийдвэрлэх алхмаа хийчих шиг санагдана. Үйлдэл бүрийн үр дагавар үйлдэлдээ байна. Смит бичсэн нь.

*Сэтгэхүйнгэм үхэл авчрахгүй, сэтгэхүйнгэм бол  
үхэл мөн*

Одоо тэрээр өөрийгөө үхдэл гэж үзсэн болохоор аль болохоор амьд байх нь чухал юм. Түүний баруун гарын хоёр хуруунд нь бэх наапджээ. Энэ бол өөрийг нь хэрэгт хийж магадгүй зүйл яг мөн. Энэ яагаад үдийн завсарлагаанаар юм бичив, яагаад сурагч үзэг хэрэглэв, юу бичив гэж Яамны зарим хэнхэгтэн (магадгүй аль нэг

эмэгтэй хүн, Уран зохиолын газрын хар үстэй охин ч юм уу, нөгөөх цайвар үстэй эмэгтэй ч юм уу) сонирхоод холбогдох хүмүүст нь шивнэчихэж болох юм.

Смит угаалгын өрөөндөө ороод арьсанд хүрэхээрээ төмөр үрүүр мэт хатуу шороо шиг өнгөтэй, ёстой л ийм юм угаахад яг таарсан савангаар савандаж гарынхаа бэхийг сайн гэгч нь арилгав.

Тэрээр өдрийн тэмдэглэлээ татуурганд хийв. Тэмдэглэлээ нуух боломж огт байхгүй гэхдээ ийм тэмдэглэл байна гэдгийг ямар ч гэсэн хүнд мэдэгдэхгүй байх нь чухал байлаа. Тэмдэглэлийн хуудсанд үс хавчуулж тавибал хэтэрхий илт тул тэрээр хуруугаараа жаахан тоос чимхэж хавтсан дээр нь асгав, дэвтрийг хөдөлгөвөл тоос нь уначихна.

### Ш

Смит эхийгээ зүүдэлж байлаа. Эх нь өндөр гуалиг нуруутай, сайхан цайвар үстэй, үг цөөтэй хүн байсан. Ээжийгээ сураггүй алга болох үед би арав, арван нэгэн настай л байсан байж таарах нь гэж Смит бодов. Тэрээр аавыгаа бүрэгхэн санадаг бөгөөд аав нь нүдний шил зүүдэг, туранхай хар хүн байсан ба маш цэвэрхэн хар өнгийн хувцас (Смит түүний шаахай их нимгэн ултай байсныг сайн санадаг юм) өмсдөг байсан юм. Тавад онд эхэлсэн анхны хэлмэгдүүлэлт тэр хоёрыг залгичихсан байж таарах нь.

Энэхэн агшинд ээж нь охин дүүгий нь тэвэрчихсэн Смитээс тээр доор сууж байна. Смит охин дүү нь туранхай, том гярхай нүдтэй, үг цөөтэй, ядруу хүүхэд байсан гэдгээс өөр юу ч санадаггүй юм. Тэр хоёр Смит руу харж байна. Тэд нар газрын гүнд, худагны ёроолд ч юм уу, булшны нүхний ёроолд, юутай ч улам доошилсоор байгаа газрын гүний аль нэг газарт

байна. Тэд нар далайн гүн рүү живж буй усан онгоцны нэгэн танхимд улам харанхуйлах усны цаанаас дээшээ харна. Тэрхүү танхим нь одоохондоо агаартай болохоор Смит тэднийг, тэд Смитийг харсаар байхад тэр хоёр далайн гүн рүү доошоо живсээр л, живсээр л байх ба нэг л хоромд ус тэднийг харагдахгүй болгон аваад явчихна. Тэднийг үхэл рүүгээ живсээр байхад Смит гэгээтэй, агаартай газар гарч ирчихсэн байх ба тэрээр газар дээр байгаа *учраас л* тэд тэр доор байна. Тэдний сэтгэл зүрхэнд ч, нүүр царайнд ч зэмлэсэн өнгө аяс алга, Смитийг амьд үлдээхийн тулд тэд үхэх ёстой, энэ бол гарцаагүй тохиолдох зүйл гэсэн ухаарал л байна.

Смит зүүдэн дундаа чухам юу болсныг санахгүй ч гэсэн эхийнх нь болон охин дүүгийнх нь амь нас өөрийнх нь төлөө золиослогдсон гэдгийг мэдэж байлаа. Энэ нь зүүдэн дунд гарсан юм маань хүний өдрийн бодол болон үргэлжилж нойрноос сэрсэн үед санаа бодол, бодит зүйл, шинэ үнэ цэнэтэй юм мэт санагддаг тийм л зүүд

байлаа. Гуч шахам жилийн өмнөх ээжийнх нь үхэл одоо яаж ч ойлгох аргагүй тийм эмгэнэлтэй харамсалтай байсан юм гэж Смит гэнэт бодлоо. Смит энэ явдлын эмгэнэл нь бүр урьдын цагт, хүний дархан байдал, хайр сэтгэл, нөхөрлөл гэдэг юм байсан, гэр бүлийн гишүүд зөнгөөрөө бие биеэ хайрлаж хамгаалдаг байсан цаг үед хамаарах юм байна гэж ухаарч байлаа. Смитийг эхийгээ хайрлахыг мэддэггүй жаахан хүүхэд байхад ээж нь хүүгээ хайрласаар байгаад өөд болсон, үнэнч шударгын, өөрийнхөө хувиршгүй итгэл үнэмшлийн тусын тулд ээж нь яагаад ч юм амь насаа өгсөн гэдгийг тэрээр бодон сэтгэл нь шаналж байлаа. Одоо бол тийм юм болохгүй гэдгийг Смит мэдэж байна. Өнөөдөр айдас, үзэн ядалт, сэтгэлийн зовиур л байхаас бус сайхан сэтгэл, гүн гүнзгий харамсал гэдэг юм алга аа. Далайн тээр дор гүнд живсээр байгаа мөртлөө дээшээ харсаар байгаа ээж, охин дүүгийнхээ дүрлийсэн нүдэнд энэ бүхнийг харах шиг Смитэд санагдана.



Смит гэнэтхэн намалзсан зүлэг дээр зогсож байна, зуны оройн нарны туяа газрын ногоог алтлаг өнгөтэй болгожээ. Тэрээр зүүдэндээ олон удаа харсан энэ газар нутгийг бодит байдал дээр ер нь үзсэн үү, үгүй юү гэдгээ сайн хэлж чаддаггүй юм. Тэрээр

нойрноосоо сэрсэн цагтаа энэ газар нутгийг Үзэсгэлэнт нутаг гэж дууддаг. Энэ бол хулганы нүхэнд идэгдчихсэн, явган хүний мөр гарчихсан, энд тэнд сохор номины нүхний шороо овооролдсон урдын цагийн нутаг юм. Талбайн захад хайлаас модны мөчир зөөлөн салхинд гулзганан навч нь эмэгтэй хүний үс шиг намиран унана. Хажууханд үл харагдах цэнгэг устай жижиг горхи дөлгөөн урсаж унжгар уд модны ёроолын цөөрөмд улаан нүдэн хөвнө.

Хар үстэй залуухан бүсгүй наашаа гүйн ирж явна. Тэр бүсгүй гарынхаа ганцхан хөдөлгөөнөөр хувцсаа урж тасдаад ийш тийш нь хаяж байна. Тэр бүсгүйн бие цав цагаан

булбарай мөртлөө Смитийн дур тачаалыг гижигдсэнгүй, үнэн хэрэг дээрээ тэрээр бүсгүйг бараг харсангүй. Тэр бүсгүй хувцсаа урж тасдан хаяж байгаа хөдөлгөөнийг нь л тэрээр бахдан харж байлаа. Уяхан налархай хөдөлгөөн, цалгар назгай байдал нь бодлын бүхэл бүтэц, соёлыг хүйс тэмтэрч Их Ах, Нам болон Сэтгэхүйн Цагдааг гарынхаа ганцхан хөдөлгөөнөөр алга болгож болох юм шиг байна.

Энэ дохио сануулга ч аль дээр үеийн юм. Смит нойрноос сэрэхдээ “Шекспир” гэж шивнэн сэрлээ.

Теледэлгэцнээс чих дүлийрэм чанга шүгэл хангинаж гучин секунд орчим үргэлжиллээ. Өглөөний долоон цаг арван таван минут буюу албан хаагчдын босох цаг. Смит орноосоо суга үсэрч, Гадуур Намын гишүүнд жилд хувцасны 3000 талон өгдөг ба унтлагын хувцас 600 талоны үнэтэй болохоор тэрээр нүцгэн унтдаг юм, босоод сандал дээрээс майк, богино өмдөө авч өмсөв. Биеийн Дасгал гурван минутын

дараа эхлэх ёстой. Смит нойрноосоо сэрмэгц л хөхүүлэн ханиалгадгаараа ханиалгаж эхэлсэн тул дээшээ харж хэвтээд хэдэн удаа урт амьсгаа авч уушгиа цэвэрлэсний дараа л хэвийн амьсгалахад нь хөлний судасны шарх нь загатнаж байлаа.

"Гучаас дөчин настангууд!, Гучаас дөчин настангууд!, Байраа эзэлнэ үү!" гэж эмэгтэй хүний огцом дуу сонсдоно.

Смит босоод теледэлгэцийн өмнө номхон зогсоход цэрэг цамцтай, биеийн тамирын шаахайтай, залуувтар царайтай, туранхай, хэрзгэр, булчинлаг эмэгтэй теледэлгэц дээр гарч ирсэн байлаа.

"Гараа хумхиарай, дэлгээрэй!, Тоолоод хийгээрэй, Нэг, хоёр, гурав, Нэг, хоёр, гурав! Нөхөд өө, хийгээрэй, жаахан хөддөөд өгөөрэй! Нэг, хоёр, гурав!" ... гэж тэрээр хашгирна.

Смит хөхүүлэн ханиалгаж байхдаа ч зүүдэнд үзсэн зүйлээ мартаагүйгээр барахгүй нэг хэмнэлттэй дасгалын үед тэр нь дахин ой тойнд нь орж ирж байлаа. Смит гараа урагш хойш аянд нь хөдөлгөж байхдаа Биеийн Дасгал хийхдээ үзүүлэх ёстой таашаал авч буй царай гаргаж байсан боловч хүүхэд насныхаа бүдэг бадаг цаг үеийг эргэн санах гэж оролдож байв. Тавиад оны сүүлийн жилүүдээс өмнөх бүх юм мартагдан арилсан тул эргэн санахад амаргүй байлаа. Эргэн санах тод дурсамж байхгүй болохоор өөрийнх нь амьдралын дүр төрх хүртэл бүдгэрчээ. Тэрээр болсон байж болох томоохон үйл явдал, ямархуу нөхцөл байддыг нь эргэн санахгүй ч гэсэн болсон үйл явдлын нарийн ширийнийг санаж байсан ба юу ч үлдээгүй урт хугацааны хоосон цаг үе бас байлаа. Тэр үед бүх юм өөр байсан. Улс орны нэр ч, тэдгээрийн газрын зураг дээрх хэмжээ хязгаар ч өөр байсан. Жишээ нь, тэр үед Онгоц нисэх нэгдүгээр зам бий болох хүртэл Англи орон буюу Британи улс гэж нэртэй байсан

бөгөөд Лондон хотыг дандаа Лондон хот гэж нэрлэсээр ирсэнийг Смит сайн санаж байна.

Смит өөрийнх нь орон дайн дажингүй байсан цаг үеийг сайн санахгүй байна, харин анхны бөмбөгдөлт болоход хүн бүр ихэд сандарч байсныг санаж байгаа болохоор түүнийг хүүхэд байх цагт тайван цаг хугацаа удаан үргэлжилсэн гэдэг нь тодорхой юм. Колчестерт атомын бөмбөг унах үед энэ явдал болсон байж магадгүй юм. Смит бөмбөгдөлт хэрхэн болсныг санадаггүй юм. Тэрээр аав нь түүнийг гартаа чанга тэврэн газрын гүн рүү хаа нэг газар руу, эргэлдсэн шатаар уруудан гүйсээр амьсгаадаад хөл нь ядран зогсч амарч байсныг санаж байна. Эх нь удаан хөдөлгөөнтэйгээрээ тэднээс их л хол хоцрон араас нь явж байсан. Эх нь жаахан охин дүүгий нь тэврэн, тэр үед охин дүү нь төрсөн байсан бил үү гэдгийг Смит сайн санахгүй тул магадгүй тэр нь хэдэн бүтээлэг ч байсан байж болох юм. Тэд явсаар нэгэн олон хүн үймэлдэж шуугисан газар очсон нь Метроны буудал байсныг тэрээр ойлгосон юм.

Тэнд олон хүн чулуун шал дээр, зарим нь дээр дээр нь давхарлан тавьсан төмөр ор дээр шахцалдан сууж байв. Смит аав ээжийнхээ хамт шал дээр суухад хажууд нь настай эрэгтэй, эмэгтэй хоёр хүн төмөр ор дээр сууж байлаа. Настай эрэгтэй нь нилээд дажгүй хар костюмтай, цал буурал толгойдоо хар даавуун саравчин малгай өмссөн аж. Түүний нүүр нь час улаан, цэнхэр нүд нь дүүрэн нулимстай аж. Мань хүнээс жин ханхалж, хөлс нь дусалж буй арьсныхаа нүхээр амьсгагж нүднээс нь дуслах нулимс нь тэр чигээрээ жин архи юм шиг санагдуулна. Мань хүн хэдийгээр бага зэрэг согтуу боловч үнэхээрийн тэсвэрлэхэд бэрх уй гашуугаас болон шаналж байв. Ямар нэг аймшигтай юм, өршөөж, засаж залруулж болохгүй юм тохиолджээ гэж Смит хүүхэд зангаараа мэдэрч байлаа. Смитэд юу болсныг нь мэдэх юм шиг санагдана. Настай хүний хамгийн хайртай нэгэн нь, магадгүй жаахан зээ охин нь, алагдсан байх нь. Настай эр нэг л үгээ үе үе давтан ярина.

"Тэдэнд итгэх хэрэггүй байсан юм. Би дандаа л ярьдаг байсан шүү дээ, тийм үү? Тэдэнд итгэснээс л ийм юм боллоо. Муу новшнуудад итгэх хэрэггүй байсан юм"

Тэдгээр муу новшнууд нь хэн байсныг Смит огт санахгүй байв.

Тэр цагаас хойш дайн тасралтгүй үргэлжилсэн бөгөөд нарнын ярих юм бол нэг дайн бус дайн дажин гарч байлаа. Смитийг хүүхэд ахуй цагт Лондон хот дотор замбараагүй зэвсэгт мөргөлдөөн хэдэн сар үргэлжилсэн нь санаанд тов тодорхой байна. Тэр үеийн түүхийг, хэн нь хэнтэйгээ байлдаж байсныг санах арга огтхон ч байхгүй юм. Өнөөдрийнхөөс бусад хүчний харьцааны талаарх ямар ч бичиг баримт, ам яриа байхгүй. Жишээ нь, өнөөдөр гэхэд л 1984 онд (он маань 1984 он мөн бол) Далайн Гүрэн Евразийн Гүрэнтэй Дорнодазийн Гүрэнтэй холбоотон болон байлдсан юм. Хуучин цагт бол гурван их гүрний харилцаа өөр байх байсан гэж хэн ч олны өмнө ч, нүүр учран хоёулхнаа

уулзахдаа ч дурсаж ярьдаггүй болно. Далайн Гүрэн үнэн хэрэг дээрээ Евразийн Гүрэнтэй байлдаж Дорнодазийн Гүрэнтэй дөрөвхөн жил л холбоотон болоод байгааг Смит сайн мэдэж байлаа. Тэрээр үүнийг дотроо л мэддэг, түүний ой ухааныг бүрэн дүүрэн хяналтад авч чадаагүй учраас л тэр үүнийг олж мэдсэн юм. Албан ёсоор бол холбоотон ба дайсан хэзээ ч өөрчлөгдөөгүй. Далайн Гүрэн Евразийн Гүрэнтэй үргэлж байлдаж байсан. Тэхлээр Далайн Гүрэн Евразийн Гүрэнтэй дандаа байлдаж байсан байна. Өнөөдрийн дайсан бол хамгийн муу муухай бүхний илэрхийлэл мөн болохоор түүнтэй өнгөрсөн үед ч, ирээдүйд ч эвлэрнэ гэдэг бол утга учиргүй юм.

Хамгийн их айдас төрүүлж буй нь гэж Смит мөрөө урагш хойш нь хөдөлгөөд (нуруунд сайн гэж үздэг болохоор тэрээр одоо гараа ташаан дээрээ тавьчихсан бэлхүүсээрээ биеэ эргэлдүүлж байна) хамгийн их айдас төрүүлж буй нь энэ бүхэн үнэн байж болох юм гэж тэрээр хэдэн мянга дахь удаагаа дахин бодож байлаа.



Нам өнгөрсөн үе рүү гараа дүрээд аль нэг үйл явдлын талаар *ийм юм хэзээ ч гарч байгаагүй* гэвэл энэ нь тарчлаан байцаалт аль эсвэл үхэл мөхлөөс ч аюумшигтай юм. Далайн Гүрэн Евразийн Гүрэнтэй хэзээ ч холбоотон байгаагүй гэж Нам баталж байна. Смит дөрөвхөн жилийн өмнө Дачайн Гүрэн Евразийн Гүрэнтэй холбоотон байсныг мэднэ. Харин энэ мэдлэг хаана байна вэ? Зөвхөн түүний ухаан санаанд л бий, гэхдээ түүнийг ямартай ч удахгүй алга болгоно. Намын тулган хүлээлгэж буй худал хуурмаг юм бүр, бүх баримт бичигт байгаа хуурмаг домог бүрийг хүн болгон зөвшөөрөх юм бол энэ худал хуурмаг мэддэг түүхэнд үлдэж үнэн болж хувирна.

“Хэн өнгөрснийг гартаа авна, тэр ирээдүйг гартаа авна. Хэн өнөөдрийг гартаа авна, тэр өнгөрснийг гартаа авна” гэсэн Намын лоозон бий. Гэхдээ өнгөрсөн үеийн мөн чанар өөрчлөгдөж болох боловч түүнийг ерөөсөө өөрчилж байгаагүй юм. Өнөөдөр үнэн юм бол үүрд мөнх үнэн юм. Бүх юмыг ойлгож ядах юм

байхгүй. Өөрийнхөө оюун ухааныг тасралтгүй ялан дийлж байх хэрэгтэй. Үүнийг “бодит байддыг хяналтдаа авах” гэдэг бөгөөд Шинхэлээр “*хоёрсэтгэхүй*” гэдэг юм.

-Сул зогс! гэж багш эмэгтэй арай эелдгээр хэлэв.

Смит гараа буулган хэдэн удаа урт амьсгаа авахад санаа бодол нь *хоёрсэтгэхүйн* ээдрээтэй ертөнцөд эргэлдэж эхэллээ. Мэдэж байгаа мөртлөө мэдэхгүй байх, зохиомол худал юм ярьж өөрийнхийгөө үнэн болоход итгэх, нэг нь нөгөөгөө үгүйсгэж буй хоёр үзэл бодлыг хоёуланг нэг зэрэг баримталж хоёуланд нь итгэлтэй байх, логикийг логикийн эсрэг хэрэглэх, ёс суртахууныг зарлан тунхаглаад түүнээс татгалзах, ардчилал бол боломжгүй зүйл, нам бол ардчиллыг сахиулагч гэж үзэх, мартаж ёстой юмыг мартаж, хэрэг гарахад дахин санах, дахиад аажмаар түүнээ мартаж, хамгийн гол нь энэ үйл явцаа үйл явцад өөрт нь хэрэглэх, энд л хамгийн нарийн учир байгаа юм, ухаанаа зориудаар хөхиүлэн дэмжих, дараа нь дахиад л

өөрийгөө ховсдож байгаагаа ухаарахгүй болох гэх зэрэг болно. Тэр ч бүү хэл “*хоёрсэтгэхүй*” гэдэг үгийг *хоёрсэтгэхүй*гүйгээр ойлгох аргагүй юм.

“За одоо та нарын хэн чинь хөлийнхөө хурууны үзүүрт гараараа хүрч чадахыг чинь үзье! Нэг хоёр, нэг-хоёр!” гэж дасгалжуулагч эмэгтэй их л уриалгахан дууддаа.

Смит энэ дасгалыг хийхээр хөлийнхөө улнаас аваад бөгс хүртэл нь огцом өвдөж хөхүүлэн ханиалгадаг тул их дургүй аж. Бодлого болж байсан юм нь толгойноос нь гарчихлаа. Тэрээр өнгөрснийг зүгээр л нэг өөрчлөөд зогсоогүй үнэн хэрэг дээрээ устгачихсан байна гэж боддоо. Чиний өөрийн ой ухаанаас гадна тэмдэглэгдэн үлдсэн юм юу ч байхгүй болсон тул хамгийн тов тодорхой баримтыг хүртэл хэрхэн тогтоох вэ? Тэрээр Их Ахын тухай анх удаагаа хэдэн онд сонслоо гэдгээ санах гэж хичээв. Жараад оны үед сонссон байх ёстой доо, гэхдээ яг тийм гэх боломж алга болжээ. Намын

түүхэнд бол Их Ахыг Хувьсгалын анхны өдрөөс л түүний удирдагч, хамгаалагч гэж үздэг нь мэдээж хэрэг билээ. Түүний алдар гавьяаны эхлэлийг өндөр бортогон малгайтай хөрөнгөтнүүд гялалзсан сайхан автомашинаар буюу шилэн цонхтой бүхээгтэй сүйх тэргээр Лондоны гудамжаар давхилдаж байсан сайхан цаг үе болох гуч, дөчөөд онд хамааруулчихсан юм. Ийм домог хэр зэрэг үнэн болох, аль зэрэг зохиомол болохыг мэдэх арга байхгүй. Смит Нам чухам хэдэн онд анх байгуулагдсаныг санадаггүй юм. Тэрээр мөн 1960 оноос өмнө Ангсоц гэдэг үгийг сонсоогүй гэдгээ сайн мэдэж байгаа бөгөөд харин энэ үг нилээд эрт хэрэглэгдэж байсан, “Английн социализм” гэсэн Хуучхэлээс гаралтай үг байж болох юм. Юм бүр манан будан дотор алга болжээ. Үнэндээ зарим үед илт худал юмыг худлаа гэд хэлчихэж ч болох юм. Жишээ нь Намын түүхийн номуудад Нам нисэх онгоц зохиосон гэж нотолдог юм. Смит бүр бага балчир наснаасаа нисэх онгоц байсныг санаж байна. Харин чи юу ч баталж чадахгүй.

Ямар ч нотолгоо олдохгүй. Смит энэ насандаа нэг удаа л түүхийн баримтыг гуйвуулсныг

гарцаагүй нотолсон баримт бичгийг олж бнлээ. Тэрхэн агшинд, “Смит ээ, 6079 Уинстон Смит ээ! Өөрийг чинь хэлж байна! Чи сайн тонгойгооч ээ! Чи сайн хийж чадна! Чи хичээхгүй байна шүү. Арай доошоо тонгой! Нөхөр минь наадах чинь арай дээр байна. За одоо бүгдээрээ биеэ сулруулаад намайг дагаж хийгээрэй” гэж теледэлгэцнээс хэрүүлч эмэгтэйн дуу сонсдов.

Смитийн бүх биеэр хүйтэн хөлс нь цутгаж нүүр нь танигдахын аргагүй болжээ. Айдсаа хэзээ ч ил бүү гарга! Эгдүүцэл дургүйцдээ хэзээ ч бүү гарга! Нүдээ нэг цавчлахад л чи илчлэгдэнэ. Смитийг дэлгэц рүү харж байхад дасгалжуулагч бүсгүй гараа толгойноосоо дээш, уяхан туяхан гэх аргагүй боловч цэмцгэрхэн амархан өргөөд, дараа нь доош тонгойж хөлийнхөө хурууны үзүүрт гараа хүргэлээ.

“Нөхөд өө, харав уу Та нар ингээд хийгээрэй, Намайг сайн харж хий! Би гучин есөн настай, дөрвөн хүүхэдтэй. Харж бай” гээд тэрээр тонгойгоод “Миний өвдөг нугарахгүй байгааг харж байгаа биз. Та нар ч гэсэн хичээвэл үүнийг хийж чадна. Дөчин таван нас хүрээгүй хэн бүхэн хөлнийхөө хурууны үзүүрт хүрч чадна. Бидэнд фронт дээр байлдах аз завшаан олдохгүй ч гэсэн ядахнаа эрүүл чийрэг байх боломжтой. Хөвөгч Цамхагийн усан цэргүүдийг санацгаа! Дахиад нэг оролдоод үзье. Нөхөд минь дээр байна, хамаагүй дээр байна” гэж Смит хамаг хүчээ гарган энэ хэдэн жилд анх удаагаа хөлийнхөө үзүүрт хуруугаа хүргэхэд тэрээр урам хайрлан хэлж байна.

## IV

Смит хамгийн ойр байгаа теледэлгэц ч дуулахааргүй өөрийн эрхгүй маш аяархан санаа алдаад үгбичигчийг өөр рүүгээ татан микрофоновх нь тоосыг арчаад нүднийхээ шилийг зүүж ажилдаа орлоо. Тэрээр ширээнийх нь баруун гар талын хийн шахуургын хоолойноос гаргаж хаясан бичгийн хавчаараар хавчаастай хуулиастай дөрвөн цаасыг аваад заддав.

Түүний бүхээгний хананд гурван онгорхой нүх бий. Үгбичигчийн баруун гар талд хэвлэлийн материалын хийн шахуургын жижигхэн онгорхой, зүүн гар талд, арай томхон онгорхой бол сонины мэдээний, хажуугийн хананд гар хүрэх зайд төмөр утсан тортой томхон онгорхой нүх байна. Энэ бол хэрэггүй цаас хийх онгорхой юм. Ийм онгорхой нүх Яаманд мянгаараа, хэдэн мянгаараа зөвхөн өрөөн дотор байгаад зогсохгүй хонгилд ч алхам тутам бий. Яагаад ч юм үүнийг

ой ухааны нүх гэж нэрлэдэг юм. Хэн хүн хэрэггүй баримт бичгээ хаях гэвэл аль эсвэл шал дээр унасан цаасны тасархайг хаях гэвэл түүнийг аваад л ой ухааны нүх рүү хаячихдаг юм. Тэрнийг нь халуун агаарын урсгал хийсгэн байшингийн дотор хаа нэг газар байгаа шатаагч зууханд аваачна.

Смит дөрвөн цаасан дээрх бичгнийг уншлаа. Даалгавар тус бүр нь цахилгаан утасны хэллэгээр бичигдсэн ганц хоёр мөр байх бөгөөд хэрэг дээрээ Шинхэлээр бус тэхдээ Шинхэлийн үгнээс бүрдсэн яамны дотоодын хэрэгцээний даалгавар банв. Даалгавар нь дараахаас бүрдэж байв:

*таймз 17. 3. 84 и. а, ын хэлсэн үг африкийг буруу мэдээлснийг залруулах*

*таймз 19. 12. 84 дөрөвдүгээр улирлын төлөвлөгөөнд үсгийн алдаа өнөөдрийн дугаартай нийцүүлэх*



*таймз 14. 2. 84 Элбэгамны мэдэгдэл буруу шоколад тодруулах*

*таймз 3. 12. 84 хасаххасах и. а. ташаа тайлбарласан үлхүн дурдагдсан үдэх хэсэг хүртэл хуулж бичих*

Смит дөрөвдөх бичгийг хойш нь тавив. Энэ бол нарийн, хариуцдагатай ажил тул сүүлд нь хийх нь зүйтэй. Нөгөөх гурав нь жирийн хийдэг зүйл гэхдээ хоёрдох даалгаврын хувьд бол тоо баримтыг сайн шалгах хэрэг гарах байх.

Смит теледэлгэц дээр «хуучин тоо баримт» гэсэн товчлуурыг дарж, «Таймз»-ын хуучин дугааруудыг өгөхийг хүсэхэд хийн шахуурган хоолой хэдхэн минутад тэдгээрийг гаргаж хаялаа. Ямар нэг шалтгаанаар өөрчлөлт оруулах шаардлагатай, албан ёсны хэлээр бол засвар оруулах сонины өгүүлэлүүд даалгаварт байна. Жишээ нь 3 дугаар сарын 17-ны Таймзын мэдээгээр Их Ах өмнө нь хэлсэн үгэндээ Өмнөд Энэтхэгийн фронт дээр гал зогсож Евразийн

Гүрэн Хойт Африкт тун удахгүй довтолгоогоо эхэлнэ гэж урьдчилан хэлсэн аж. Үнэн хэрэг дээрээ Евроазичууд Өмнөд Энэтхэгт довтолгоо хийж Хойт Африкт ямар ч цэргийн ажиллагаа явуулаагүй байна. Их Ахын хэлсэн үгийн энэ хэсгийг тэрээр үйл явддыг урьдчилан зөв хэлсэн болгож дахин бичих хэрэгтэй байлаа. Мөн «Таймс»-ын 12 дугаар сарын 19-ны дугаарт ес дэх гурван жилийн төлөвлөгөөний 6-р улирал болох 1983 оны 4-р улирлын төрөл бүрийн өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийн өсөлтийн албан ёсны урьдчилсан мэдээг нийтэлжээ. Сонины өнөөдрийн дугаарт үйлдвэрлэлийн бодит өсөлтийн талаарх мэдээг хэвлэсэн бөгөөд тэр нь урьдчилсан мэдээ огт алдаатай байсныг харуулж байна. Смитэд урьдчилсан мэдээний тоо баримт өнөөдрийнхтэй таарсан байхаар засвар хийх хэрэгтэй болж байна. Гуравдахь даалгаварт ганц минутад л засчих амархан алдаа байв. Баялгийн Яам саяхан 2-р сард 1984 онд шоколад олголтыг бууруулахгүй гэсэн амлалт (албан ёсны хэллэгээр хариуцлагатай мэдэгдэл) өгсөн юм.

Үнэндээ, Смитийн өөрийнх нь сайн мэдэж байгаагаар энэ долоо хоногийн сүүлээр шоколадны нормыг 30 граммаас 20 грамм хүртэл буулгахаар завдаж байгаа билээ. Смитийн хувьд бол 4-р сард нормыг багасгаж болзошгүй гэж урьдчилан хэлж байсан гэдгээр өмнө өгсөн амлалтыг засварлах хэрэгтэй болжээ.

Смит эхний гурван даалгаврыг хийчихээд үгбичигчээс авч засварласан бичгээ соннны дугаартай нь хамт хавчаараар хавчаад хийн шахуурган онгорхойд хийв. Тэрээр мөн дадсанаараа хүлээж авсан хуудаснууд, өөрийн хийсэн тэмдэглэлээ базаад шатаахаар ой тойны нүх рүү хийв.

Смит хийн шахуурган хоолойны цаад үзүүрт байгаа үл үзэгдэх байшингийн гүнд юу болж байдгийг яг мэддэггүй, ерөнхийд нь тааварлаж байлаа. Сонины дугаарт хийсэн бүх засварыг цуглуулж дахин шалгаад дугаарыг шинээр хэвлэж, хуучныг нь устгаад түүний оронд

засварласан дугаарыг үддэг юм. Энэхүү тасралтгүй өөрчлөх үйл ажиллагаанд зөвхөн сонин хамрагдаад зогсохгүй улс төр, үзэл суртлын ач холбогдолтой бүх зохиол бүтээл, баримт бичиг, ном, сэтгүүл, товхимол, зурагт самбар, хуудас, кино, дуун бичлэг, шог зураг, фото зураг хамрагдана. Өдөр бүр, бараг минут тутамд өнгөрснийг өнөөд авчирна. Иймд Намын урьдчилан харсан бүхэн үнэн гэдгийг баримтаар нотолж болно. Өнөөдрийн хэрэгцээнд таарахгүй нэг ч мэдээ, нэг ч үзэл бодол тэмдэглэгдэн үлдэх ёсгүй. Бүхий л түүх бол шинээр бичихээр хуучин бичсэнийгээ арилгачихсан гар бичмэл, хичнээн л хэрэгтэй бол төчнөөн бичиж болох хоосон зай.

Баримтжуулах газрын хамгийн том тасагт, Смитийн ажиллаж буй газраас хамаагүй том юм, устгавал зохих, засварлавал зохих сонин, ном болон бусад хэвлэлийн бүх хувийг олж цуглуулах цорын ганц үүрэг хүлээсэн хүмүүс ажилладаг юм. Их Ахын алдаатай зөгнөл, улс төрийн шинэ хуйвалдаанаас болж «*Таймс*»-ын

дугаарыг дахин, хэдэн арван удаа дахин хэвлэсэн бөгөөд үдэгдсэн хувьд нь өмнөх он сарыг нь хэвээр хадгалж үүнийг үгүйсгэсэн нэг ч хувь үлддэггүй юм. Номыг ч дахин дахин бичдэг ба дахин бичсэн гэдгийг нь дурдалгүй хэвлэдэг болно. Смитийн хүлээж аваад тэр дор нь устгаж буй баримт бичгийн даалгаварт ч баримт бичгийг хуурамчаар үйлдэх хэрэгтэй болох талаар ганц ч үг байдаггүй юм. Нарийн тодорхой болгохын тулд арилгах шаарддагатай алдаа, буруу ишлэл, нэмэлт тайлбар, буруу бичсэн үгийн тухай л энд үгүүлнэ.

Смит энэ бол ер нь хуурамч баримт зохиож буй бус зүгээр л дэмий юмыг өөр нэг дэмий юмаар сольж буй хэрэг гэж Элбэг дэлбэгийн яамны тоог засаж байхдаа бодож байлаа. Ихэнх тохиолдолд сэдэв нь бодит байдалд огт хамаагүй, илэн далангүй худал юм ч хүртэл байна. Тоо бүртгэл бол ер нь анх зохиогдох үедээ ч, засагдсан үедээ ч уран зөгнөл юм. Ихэнх тохиолдолд тоо бүртгэлийг толгойноосоо зохиох шаардлага гарна. Жишээ нь Элбэгийн

яам 4-р улиралд 145 сая хос гутал үйлдвэрлэнэ гэсэн төлөвлөгөө гаргажээ. Харин хэрэг дээрээ 62 сая хос гутал үйлдвэрлэсэн гэж мэдээлж байна. Смит төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байддаар харагдуулахын тулд төлөвлөгөөт зорилтыг 57 сая гутап гэж засварлана. Юутай ч 62 сая гэдэг нь 57 буюу 145 сая гэдгээс үнэн байдагд бас л ойр тоо биш юм. Ер нь хичнээн гутал үйлдвэрлэсэн гэдгийг хэн ч мэддэггүй ба мэдэхийг ч хүсдэггүй юм. Нэг л юм тодорхой юм, улирал тутамд цаасан дээр асар их олон гутал үйлдвэрлэдэг боловч Далайн Гүрний хүн амын тэн хагас нь хөл нүцгэн явдаг. Баримтжуулсан аливаа бодит байдал үүнтэй агаар нэг.

Смит хонгилын нөгөө талд байгаа шилэн бүхээгийг харж байна. Шилэн бүхээг дотор жижигхэн, хичээнгүй төрхтэй, бор эрүүтэй, Тиллотсон гэдэг хүн өвдгөн дээрээ эвхсэн сонин тавьчихсан, үгбичигч дээр ажиллаж байна. Тэрээр ярьсан хэлсэн бүхэн нь зөвхөн тэр хоёрын хооронд, үгбичигч тэр хоёрын хооронд,

үлдээсэй гэж хүсч байгаа юм шиг байлаа. Тэрээр толгойгоо өндийлгөж Смит рүү харахад нүдний шил нь зэвүүрхсэн юм шиг гялалзлаа.

Смит Тиллотсоныг таньдаггүй, түүний юу хийдгийг мэддэггүй аж. Баримтжуулах газрын ажилтнууд ажлынхаа талаар дуугүй байдаг. Цаас шарчигнаж, үгбичигчийн дуу дүнгэнэсэн хоёр талаараа шилэн бүхээг бүхий цонхгүй урт хонгилд хэдэн арван хүн ажилладаг бөгөөд тэдэнтэй бүх жилийн туршид дайралддаг, тэднийг Хоёр минут үзэн Ядалтын үеэр гараа өргөн хашгирч байхыг нь харсан боловч Смит тэдний нэрийг нь ч мэддэггүй юм. Тэрээр хажуугийн бүхээгт суугаа цайвар үстэй бүсгүй хэзээ ч оршиж байгаагүй гэж үзэх ёстой ууршуулагдсан хүмүүсийн нэрийг хэвлэлээс олж илрүүлэн арилгах ажлыг өдөр алгасалгүй хийж байдгийг мэднэ. Хоёр жил орчмын өмнө түүний нөхрийг ууршуулсан болохоор энэ ажил түүнд яг таарна гэж ч хэлж болох талтай. Смитээс хэдэн бүхээгний цаанах бүхээгт намхан нуруутай, номхон дөлгөөн, чадвар

сулхан, мөрөөдөмтгий, гайхмаар их үстэй чихтэй, хэмнэл, хэмжээнд их авьяастайгаараа хүний гайхал төрүүлдэг Амфлфорт гэдэг хүн өөрчилсөн хувилбар, төгсгөлийн сэдэв гэж нэрлэгддэг, үзэл сурталд үл нийцсэн, ямар нэг шалтгаанаар яруу найргийн цоморлигоос хасаж болдоггүй шүлэг дахин зохиох ажлыг хийж байна. Энэхүү хэдэн зуун ажилтантай хонгил нь Баримтжуулах газрын нарийн бүтцийн зөвхөн нэг эд эс нь юм. Толгойд багтамгүй олон төрлийн ажил гүйцэтгэдэг ажилтнууд дээд, доод давхруудад ажилладаг. Асар том хэвлэлийн үйлдвэр энд байдаг бөгөөд түүнд хянагчид, хэвлэлийн ажилтнууд ажилладаг ба фото зураг хуурамчаар хийдэг сайн тоног төхөөрөмжтэй студи ч бий. Хүний дуу хоолойг яг адилхан дуурайн гаргаж чаддаг жүжигчдийн бүхэл бүтэн бүлэг, найруулагчид, инженерүүд бүхий телевизийн хөтөлбөрийн баг хүртэл бий. Засварлавал зохих ном, сэтгүүлийн нэрийн жагсаалтыг гаргаж байдаг лавлагааны бүхэл бүтэн ажилтнуудын баг мөн ажилладаг болно. Засвар оруулсан баримт бичгийн маш их



цуглуулга, устгасан баримт бичгийн нууц цуглуулга ч бас бий. Өнгөрсөн үеийн зарим хэсгийг хадгалах, заримыг хуурамчаар үйлдэх, гурав дахь хэсгийг бүрмөсөн устгах талаарх улс төрийн шугамыг тодорхойлдог хаа байдаг нь үл мэдэгдэх нууц удирдан жолоодогч тархи хаа нэг газар байдаг юм.

Баримтжуулалтын газар нь эцсийн бөлөгт Үнэний Яамны өнгөрсөн үеийг шинэчлэн зохиох цорын ганц газраар зогсохгүй мөн Далайн Гүрний бүх хүн амыг сонин, кино, сурах бичиг, телевизийн нэвтрүүлэг, жүжиг, роман, бүхий л төрлийн мэдээлэл, цэнгүүн, хөшөө дурсгалаас аваад лоозон, уянгын шүлгээс аваад биологийн шинжилгээний зохиол, сургуулийн сурах бичгээс аваад Шинхэлийн толиор хүртэл хангадаг юм. Яам нь Намын бүхий л хэрэгцээг хангаад зогсохгүй, эдгээрээс чанарын хувьд арай доогуур үгээгүйчүүдийн хэрэгцээнд зориулсан өмнөхтэй төстэй бүтээгдэхүүнийг ч үйлдвэрлэдэг юм. Үгээгүйчүүдийн утга зохиол, хөгжим, жүжиг болон тэдний чөлөөт цагт

зориулсан бүтээгдэхүүнийг гаргах иж бүрэн тогтолцоо ч байдаг юм. Спорт, эрүүгийн гэмт хэргийн мэдээ, зурхайнаас өөр ямар ч мэдээлэлгүй хэрэгцээ багатай сонин, шуугиантай явдлын таван центийн тууж, эрээ цээргүй хурьцдын зурагтай кино, механик аргаар зохиодог уянгын дуу, шүлэг зохиогч гэдэг нэртэй үг холигч дээр зохиодог, энэ бүхнийг энд үйлдвэрлэдэг аж. Тусгай салбар газар Шинхэлээр бэлгийн харьцаа нэртэй хурьцал үйлдэх хамгийн эрээ цээргүй зургийг үйлдвэрлэдэг бөгөөд эдгээр зургийг зөвхөн намын гишүүдэд битүүмжилсэн дугтуйд хийж тараадаг ба тэдгээрийг хэвлэлийн ажилчдаас өөр хүн үзэхийг хориглосон байдаг.

Смитийг ажлаа хийж байхад хийн шахуурган хоолой гурван даалгавар гаргаж өгсөн нь амархан даалгаврууд байсан болохоор Смит тэдгээрийг Хоёр минут үзэн Ядалт эхлэхээс наана хийгээд дуусгачихав. Смит Үзэн Ядалт дуусмагц бүхээгтээ эргэж ирээд Шинхэлийн толио аваад үгбичигчээ өөртөө ойртуулан

нүднийхээ шилийг арчаад өнөөдрийн үдээс өмнө хийх ажилдаа шуурхайлан орлоо.

Смитийн энэ насандаа хамгийн дуртай юм нь түүний ажил юм. Ихэнх ажил нь нэг хэвийн залхуутай боловч заримдаа хэцүү тоо бодохтой адил төвөгтэй, ээдрээтэй ажил- Ангсоцын зарчмын тухай мэддэг болон Нам чухам юуг хүсч байгааг таамаглахаас өөр баримтлах юмгүйгээр хийхэд хүрдэг баримт бичиг хуурамчаар үйлдэх нарийн адармаатай ажил дайралддаг. Смитэд заримдаа зөвхөн Шинхэлээр бичсэн *Таймс сонины* тэргүүн өгүүллийг залруулах үүрэг ногддог юм. Смит нөгөө хойш нь тавьсан даалгавартай хуулиастай цаасаа дэлгэн үзлээ. Тэр нь.

*таймс. 3. 12. 84. и. а. -ын давхархасахсайд даалгавар гарсан үлхүн гэдгийг дээд үдээс хүртэл дахин бичих*

Үүнийг Хуучхэлэхээр (жирийн англи хэлээр) буулгавал.

*Таймс сонины 3. 12. 84-ны дугаарт гарсан Их Ахын өдрийн даалгаврын тухай сурвалжлага нь огт байхгүй хүнийг иш татсан тун хангалтгүй юм. Дахин бичээд сурвалжлагыг үдэхээсээ өмнө нооргоо дээд удирдлагад танилцуул*

Смит хэрэг тарьсан өгүүллийг сайн уншлаа. Их Ахын өдрийн даалгавар нь Хөвөгч Цайзын усан цэргүүдийг янжуур тамхи болон бусад тансаг бараагаар хангадаг ХЦУЦХ гэдэг байгууллагын ажлыг магтан сайшаасан зүйл байсан шиг санагдана. Доторх Намын гишүүн Нөхөр Уизааз гэгчийг онцгойлон үнэлж Апдар гавьяаны Хоёрдугаар зэргийн одонгоор шагнасан билээ. Уизааз болон түүний хамтран зүтгэгчдийг аль хэдийнээ адалдаг болсон гэж ойлгож болох юм байна. Харин энэ тухай хэвлэлээр болон телевизээр мэдээлээгүй юм.

Улс төрийн гэмт хэргийг шүүхээр шийтгэх буюу олон нийтийн өмнө буруутгах явдал нь хэвийн бус зүйл тул үүнд гайхах хэрэг байхгүй. Урвагчид ба сэтгэхүйн гэмт хэрэгтнийг олны

өмнө шүүж тэд нар нь эцсийн бөлөгт хэргээ хүлээгээд цаазлагддаг олон мянган хүнийг хамарсан их хэлмэгдүүлэлт хэмээх жүжиг хэдэн жилд нэг удаа л болдог юм. Ер нь бол Намын дургүйцдийг хүргэсэн хүмүүс зүгээр л сураг чимээгүй алга болж тэдний талаар ажиг сураг гардаггүй юм. Тэд чухам юу болсныг мэдэх ямар ч арга байдаггүй. Зарим тохиолдолд тэд үхээгүй ч байж болно. Смитийн мэдэж байгаагаар эцэг эхийгээ оролцуулалгүй тоолоход магадгүй гуч орчим танил хүн нь хэзээ нэгэн цагт сураггүй алга болсоон.

Смит хамраа хавчаараар маажгаад өрсөлдөгч рүүгээ харахад бүхээг дотроо Нөхөр Тиллотсон үгбичигч рүүгээ тонгойн хаацайлчихсан ажиллаж байна. Тэрээр толгойгоо өндийлгөж Смит рүү харахад нүдний шил нь хорсолтойгоор гялалзлаа. Смит Нөхөр Тиллотсон өөртэй нь яг адилхан даалгавар биелүүлж байгаа юм биш байгаадаа гэж сонирхож байв. Энэ ч ер нь магадгүй зүйл шүү. Ийм нарийн ширийн даалгаврыг нэг хүнд өгнө гэж огт байхгүй,

нөгөө талаар ямар нэг хороонд үүнийг даалгах нь хуурамч бичиг баримт зохиох үйл ажиллагаа явагдаж байна гэдгийг илт хүлээн зөвшөөрнө гэсэн үг. Их Ах чухам юу хэлсэн бэ гэдэг хувилбар дээр арав гаруй хүн ажиллаж буй нь лавтай. Одоо Доторх Намын хэдэн гоц ухаантан хувилбарыг сонгож авч дахин хянаад шаардлагатай баримтуудтай тулгах төвөгтэй ажлыг өрнүүлээд эцэст нь сонгож авсан худал хуурмаг зүйлээ нэгэнт баримтжуулснаар энэ нь үнэн болно.

Смит Уизаазыг яагаад аддагдах болсныг мэдэхгүй, магадгүй авилга, аль эсвэл ажлын чадвар сул байснаас ч болсон байж мэднэ. Уизааз болон түүний ойр дотны хүмүүс тэрс үзлийн хандлагад сэжиглэгдсэн ч байж болно. Үнэнд хамгийн ойр байж болох нь магадгүй, зүгээр л засгийн газарт шаардлагатай арга хэрэгсэл болох цэвэрлэгээ, ууршуулалтаас болсон байж болно. Энэ даалгаврын гол гогцоо нь "үлхүн" гэсэнд л байгаа бөгөөд энэ нь Уизааз аль хэдийнээ үхсэн гэдгийг зааж байна. Хүмүүс

баривчлагдахад энэ нь ийм юм болсон гэж лавтай хэлэхэд бас хэцүү юм. Заримдаа шоронгоос хүмүүсийг суллаад нэг хоёр жил байлгаад дараа нь цаазлах явдал ч бий. Аль хэдийнээ талийгаач болчихсон гэж бодож байсан хүн аль нэг олон нийтийн өмнө болдог игүүх хуралдаан дээр сүнс шиг гарч ирээд энэ удаа бүрмөсөн сураггүй алга болохынхоо өмнө хэдэн зуун хүний гэмт үйлддийг илчилсэн гэрчийн мэдүүлэг өгдөг явдал бий. Ямар ч гэсэн Уизааз бол аль хэдийнээ *үлхүн* болжээ. Тэрээр байхгүй, тэрээр хэзээ ч байгаагүй. Смит Их Ахын хэлсэн үгийг өөрчлөх нь хангалттай бус гэж бодлоо. Уг эх сурвалжийн сэдэвтэй огтхон ч холбогдолгүй ямар нэг зүйлийн талаар ярих нь арай дээр юм.

Тэрээр нөгөө хэлсэн үгийг урвагчид, сэтгэхүйн гэмт хэрэгтнүүдийг харааж зүхсэн үг болгож болох боловч ингэх нь хэтэрхий гэнэн хэрэг болно. Фронт дээрх том ялалт, Ес дэх Гурван жилийн Төлөвлөгөөний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн давуулан биелүүлэлт гэх нь

баримтжуулалтыг хүндрүүлэх болно. Саяхан баатарлагаар байлдаж яваад амь үрэгдсэн Нөхөр Огилви гэгчийн бэлэн дүр Смитийн ой ухаанд гэнэт орж ирлээ. Их Ах заримдаа Өдрийн даалгавраа бусдад үлгэр дууриал болууштай Намын жирийн нэг даруухан гишүүний амь нас, үхлийг дурсан хүндэтгэхэд зориулдаг. Тэрээр өнөөдөр Нөхөр Огилвийг хүндэтгэн тэмдэглэх хэрэгтэй. Нөхөр Огилви гэдэг хүн огт байгаагүй нь бодитой зүйл боловч түүний тухай хэвлэгдсэн хэдэн мөр, хуурамч фото зураг түүнийг байсан болгож чадна.

Смит хэдэн агшин бодолд автсанаа үгбичигчийг ам руугаа ойртуулаад Их Ахын танил янз маягаар үгээ уншиж гарав. Энэ нь асуулт тавиад түүндээ хурдан хариулт өгөх мэхтэй тэгсэн мөртлөө мэдэмхийрсэн янз маяг юм. («Нөхдөө, үүнээс бид ямар сургамж авах ёстой вэ? Сургамж нь Ангсоцын үндсэн зарчим ч болдог гэвэл...») гэдэг тул дуурайхад ч төвөггүй билээ.



Нөхөр Огилви гурван настай байхдаа бөмбөр, автомат буу, нисдэг тэрэгнээс өөр тоглоомоор тоглох дургүй болсон юм. Түүнийг зургаан настайд нь онцгойлон үзэж Тагнуулчдын эгнээнд авсан, естэйдээ цэргийн саиааны захирагч болсон. Арван нэгэн настайдаа өвөөгийнхөө яриаг сэм сонсоод гэмт хэргийн санаатай болохыг нь мэдээд Сэтгэхүйн Цагдаад мэдээлсэн байна. Арван долоотойдоо тэрээр Бэлгийн харилцаанд орохын эсрэг залуусын Холбооны удирдагч болсон. Арван естэйдээ гранат бүтээсэн ба түүнийг нь Энх тайвны Яам анх туршихад Евразийн Гүрний гучин нэгэн цэргийн олзлогдогсдыг дэлбэлж устгасан болно. Тэрээр хорин гурван насандаа Энэтхэгийн далай дээгүүр тусгай мэдээ хүргэн нисч явахад нь дайсны дайрагч онгоцнууд түүн рүү довтлоход пулемётоо биедээ зүүгээд нисдэг тэрэгнээсээ бүх юмаа авч үсрээд далайн ёроолд живж дайнд амь үрэгдсэн, Их Ах ингэж амь насаа алдах нь бахархалтай хэрэг гэж хэлсэн. Их Ах Нөхөр Огилвийн бүхий л амьдрал ариун нандин, зорилго эрмэлзэл төгөлдөр байсан юм

гэж цохон тэмдэглэсэн. Нөхөр Огилви тамхи татдаггүй, архи амсдаггүй байсан ба тэрээр чөлөөтэй цагаа зөвхөн гимнастикийн зааланд өдөр бүр нэг цаг дасгал хийж өнгөрөөдөг байлаа. Тэрээр хэзээ ч гэрлэхгүй гэж ам өгсөн бөгөөд өдөржин шөнөжин үүргээ биелүүлэхэд гэр бүлтэй байх, гэр бүлээ асрах нь харшилна гэж үздэг байв. Түүний ярианы сэдэв нь зөвхөн Ангсоцын зарчим, амьдралын гол утга учир нь Евразийн Гүрний дайсныг дарах, тагнуул туршуул, хорлон сүйтгэгчид, сэтгэхүйн гэмт хэрэг болон зүсэн бүрийн урвагчдыг мөшгин хөөж устгах явдал байсан юм.

Смит Нөхөр Огилвийг Ялгуусан гавьяаны одонгоор шагнах уу гэж тээнэгэлзэж байлаа. Энэ нь давхар давхар шалгалтад хүргэх тул тэрээр эцсийн бөлөгт шагнах хэрэггүй гэж үзлээ.

Смит дахиад л өрсөлдөгчийнхээ бүхээг рүү харахад Тиллотсон өөртэй нь яг адилхан юм хийж байгаа мэт санагдаж байв. Хэнийх нь

хийсэн юмыг эцсийн бүлэгт батлах вэ гэдгийг мэдэх арга байхгүй ч гэсэн өөрийнхийг нь батална гэдэгт Смит тун итгэлтэй байв. Нэг цагийн өмнө төсөөлөх ч аргагүй байсан Нөхөр Огилви одоо нэгэнт бодит зүйл болжээ. Өнөө үед огт байгаагүй Нөхөр Огилви өнгөрсөн үед орших болсон бөгөөд хуурамч баримт үйлдсэн нь нэгэнт мартагдах үед тэрээр Их Карл, Юлиус Цезарь нар шиг жинхэнээрээ маргашгүйгээр орших болно.

Өдрийн хоолны дараалал газрын гүн доорх намхан таазтай гуанзанд аажмаар урагшилна. Гуанз дүүрэн хүнтэй, чих дөжрөм шуугиантай аж. Гал зуухнаас гарах халуун хоолны хамар цоргисон үнэрээс энд тэндгүй ханхлах «Виктори» жиний үнэр хүчтэй аж.

“Яг эрж явсан хүн маань энэ байна” гэх дуу Смитийн ард гарав.

Эргээд хартал Шинжилгээ судалгааны газар ажилладаг түүний найз Сайм байна. Магадгүй “найз” гэдэг үг оноогүй ч байж мэднэ. Өнөө үед чамд найз гэж байхгүй, чамд нөхөр л бий, гэхдээ зарим нөхөдтэй бусад нөхөдтэй нийлэхээс арай аятайхан байдаг билээ. Сайм хэл бичиг судлаач, Шинхэлийн мэргэжилтэн бөгөөд Шинхэлийн Толь бичгийн Арван нэгдүгээр Хэвлэлийг бэлтгэж буй асар олон эрдэмтдийн багийн гишүүн юм. Тэрээр Смитээс жижигхэн биетэй,

хар үстэй, ярьж буй хүнээ нэвт ажиглаж буй мэт уйтгартай мөртлөө инээдэмтэй бүлтийсэн нүдтэй хүн аж.

“Би чамаас сахлын хутга байхгүй биз гэж асуух гэсэн юм” гэв.

“Танц ч байхгүй. Би зөндөө эрсэн. Одоо тийм хутга байхгүй болжээ” гэж Смит гэм хийчихсэн юм шиг яаран хариулав.

Хүн бүр л сахлын хутга гуйх болжээ. Смитэд үнэндээ хэрэглээгүй хоёр сахлын хутга бий нь бий гэхдээ тэрээр тэдгээрийг нөөцөлж байгаа юм. Хэдэн сарын турш сахлын хутга олдохоо байсан юм. Намын мухлагууд хэрэглээний аль нэг эд бараагаар үе үе тасардаг. Заримдаа товч, утас, гутлын үдээсээр тасардаг бол одоо сахлын хутганы ээлж иржээ. Тэдгээрийг сэмхэн, аз таарвал “чөлөөт” зах дээрээс олж авч болно.

“Би ч сар гаруй нэг хутгаар сахлаа хусч байна” гэж тэрээр худдаа хэлэв.

Тэр хоёр урагшилсаар байгаа дараалал түр зогсмогц хураалгаастай тос даасан хоол зөөх төмөр тавиурнаас авахад Смит эргэн түүн рүү харав.

“Өчигдөр олзлогдогсдыг дүүжилж байгааг харав уу?” гэж Сайм асуув.

“Ажилтай байсаан. Кинонд гарахад нь үзэж болно биз” гэж Смит хайхрангуй хариулав.

“Кинонд ч огт өөр л дөө” гэж Сайм хэлээд Смитийг дооглонгуй харж байв. «Чн яагаад олзлогдогсдыг цаазапж байгааг очиж үзээгүйгий чинь би сайн мэдэж байна. Би чамайг нэвт харж байна. Чамайг мэднэ ээ» гэж түүний харц хэлж байх шиг байлаа.

Сэхээтэн Сайм бол намын чиг шугамыг тууштай баримтлагч юм. Тэрээр нисдэг тэргээр дайсны тосгодыг довтолсон, сэтгэхүйн гэмт хэрэгтнүүд хэрхэн хэргээ хүлээсэн болон тэдний хэргийг таслан шүүсэн шүүхийн

хуралдаан болон Хайрын Яамны доод хонгилд хүмүүсийг цаазалсан тухай их муухай шүлсээ асгаруулж ярьдаг. Ярианых нь сэдвийг заримдаа боломж гармагц өөрийнх нь сайн мэддэг, сонирхолтой ч ярьдаг сэдэв болох Шинхэлийн асуудалд шилжүүлэхэд хүрдэг. Смит түүний нэвт харах харцнаас нүдээ буруулан хажуу тийшээ харав.

“Цаазлалт их сайхан болсон. Миний бодоход тэдний хөлий нь боодог нь дэмий юм. Би тэдний тэлчилж байгааг харах дуртай. Гэхдээ хамгийн гоё нь төгсгөл нь, тэдний бие нь хөхөрчихсөн, хэл нь унжиж байхыг... Хөв хөх хэл гэж хэлмээр юм уу даа. Энэ надад үнэхээр таалагдцаг юм” гэж Сайм мөрөөдөнгүй ярив.

Смит Сайм хоёр хоол зөөх тавиураа шургуулмагц дээр нь нормын хоол-ягаан саарал өнгөтэй төмөр тавагтай шөл, зүсэм талх, жижиг дөрвөлжин бяслаг, «Виктори» гэдэг аяга хар кофе, нэг ширхэг шахмал сахар орлуулагч тавьжээ.

"Тэнд теледэлгэцийн дор сул ширээ байна. Би жин аваад очье" гэж Сайм хэллээ.

Жинийг нь бариулгүй шавар аяганд хийж өгөв. Тэр хоёр олон хүний дундуур чихцэлдсээр явж төмөр ширээн дээр хоолоо тавилаа.

Ширээний нэг буланд ой гутам үнэртэй, хэн нэгний бөөлжис бололтой шөлний үлдэгдэл байна. Смит жинээ авч хоромхон бодолхийснээ зүрхээ чангалан тос амтагдсан архиа нэг мөсөн залгичихаад нүдэнд нь нулимс гүйлгэнэн өлссөнөө гэнэт мэдрэв. Тэрээр халбагаараа шөлөө хутган идэж эхлэв. Шөлөн дотор нь улаавтар өнгөтэй дөрвөлжин юм байх нь махан бүтээгдэхүүн бололтой юм. Мань хоёр тавагтай шөлөө дуустал үг дуугарсангүй. Тэр хоёрын арын ширээнд Смитийн зүүн гар талд хэн нэгэн зогсоо зайгүй галуу ганганаж буй мэт ярих нь олны яриан дотроос чанга дуулдана.

"Толины ажил хэр зэрэг явж байна?" гэж Смит шуугианаас болж дуугаа чангатган асуув.



“Удаан байна. Хавсралт нэр дээр ажиллаж байна. Гайхалтай сонин юм” гэж Сайм хариулав.

Сайм Шинхэлийг хөндөхөөр урам нь ороод төмөр тавгаа хажуу тийш нь болгон нэг гартаа зүсэм талхаа, нөгөө гартаа бяслагаа аваад чанга хашгирахгүйн тулд Смитэд ойртож суулаа.

“Арван нэгдүгээр хэвлэл, бас төгсгөлийн хэвлэл юм. Бид хэлийг төгсгөлийн төлөвт нь оруулж байна, хэн ч өөрөөр ярихгүй болох төлвийг бий болгоно. Үүнийг хийж дуусгамагц чам шиг хүмүүс хэлийг бүр эхнээс нь дахин сурах хэрэг гарна. Бидний гол ажлыг шинэ үг зохиох явдал гэж чи лав бодож байгаа байх аа. Огтхон ч тийм биш ээ! Бид үг устгаж байна: өдөр бүр хэдэн арваар нь, хэдэн зуугаар нь шүү. Бид хэлийг араг ясанд нь хүртэл тайрч байгаа. 2050 он гэхэд арван нэгдүгээр хэвлэлд орсон нэг ч үг хуучрахгүй”

Тэрээр талхаа ховдоглон ам руугаа чихэж идээд мэдэмхийрэн ярьсаар байх бөгөөд туранхай бор нүүр нь гэрэлтээд, нүднийх нь дооглонгуй харц мөрөөдөмтгий харцаар солигдов.

“Үг устгана гэдэг гайхамшигтай сайхан хэрэг. Хогны гол үндэс нь үйл үг, хавсрал нэрэнд байгаа нь мэдээж хэрэг ээ, гэхдээ зуу зуун илүү нэр үг бас байна. Зөвхөн ижил үгээр зогсохгүй, эсрэг утгатай үг ч бий. Эцсийн бөлөгт зүгээр л бусад үгний эсрэг утгатай үг байгааг зөвтгөх хэрэг байна уу? Үг өөрөө эсрэг үгээ агуулж байна. Жишээ нь “сайн” гэдэг үг байна. “Сайн” гэсэн үг байхад “муу” гэсэн үг байхын хэрэг нь юу байна вэ? “бишсайн” гэхэд л болно, энэ нь илүү дээр, энэ бол яг эсрэг утга нь, харин нөгөөх үг нь тийм биш юм. “Сайн” гэдэг үгийн утгыг арай чанга гаргахад “онц сайн”, “Их сайхан” гэх мэт хэрэгцээгүй бүдэг олон үгээр яах юм бэ? “

“Чи хэрвээ улам хүчтэй хэлье гэж бодож байгаа бол “нэмэхсайн”, аль эсвэл “давхарнэмэхсайн”

гэх нь утгыг нь гаргана. “Бид эдгээр төлөвийг аль хэдийнээ хэрэглээд эхэлчихсэн, гэхдээ Шинхэлийн төгсгөлийн төлөвт өөр юм орохгүй. Эцсийн бөлөгт сайн чанар, муу чанар гэдгийг зөвхөн зургаан үгээр л гаргана, үнэн хэрэг дээрээ ганц үгээр л илэрхийлнэ. Чи үүний гайхамшгийг ухаарч байна уу, Смит ээ? Их Ах анх энэ санааг гаргасан гэдэг нь мэдээж хэрэг ээ” гэж тэрээр жаахан бодож хэллээ.

Их Ахын нэрийг дуулаад Смит хүч гарган баярласан дүр гаргахад Сайм түүний дотроо дургүй байгааг дорхноо мэдээд яриагаа үргэлжлүүлэв.

“Чи Шинхэлийг зохих ёсоор үнэлж чадахгүй байна. Чи энэ хэлээр бичиж байхдаа ч Хуучхэлээр сэтгэж байна. *Таймс* сонинд хааяа гардаг чиний бичсэн юмыг би уншсан. Дажгүй л юм байна лээ, гэхдээ л орчуулга байна лээ. Чи сэтгэлдээ Хуучхэл, тэр хэлний бүдэг утга, хэрэггүй төлөвийг таашаадаг юм байна. Шинхэл бол үгсийн сан нь жилээс жилд цөөрч

байдаг энэ дэлхийн цорын ганц хэл гэдгийг чи мэдэх үү?”

Смит үүнийг үнэхээр мэддэггүй болохоор хэлснийг нь ойшоон инээмсэглэсэн боловч үг хэлж зүрхэлсэнгүй. Сайм хар талхнаас эмтлэн ам руугаа хийгээд зажилснаа үргэлжлүүлэн ярьж гарлаа.

-“Шинхэлийн зорилт бол сэтгэхүйн цар хүрээг нарийсгах явдал гэдгийг чи ойлгохгүй байна уу? Эцсийн бөлөгт бид сэтгэхүйнгэмийг хэрэг дээрээ үгүй хийнэ, түүнийг илэрхийлэх үг байхгүй болно. Хэрэгцээтэй гэж үзсэн үзэл баримтлал бүрийг утгыг нь нарийн гаргасан, бүрэг утгыг нь арилгаж үгүй болгосон зөвхөн нэг үгээр илэрхийлнэ. Арван Нэгдүгээр хэвлэлд бид үүнд бүр ойрхон яваа. Энэ үйл явц чи бид хоёроос хойш ч үргэлжилнэ. Жилээс жилд улам улам цөөхөн үгтэй болно, сэтгэлгээний цар хүрээ улам багасна. Одоо ч гэсэн сэтгэхүйнгэмийг зөвтгөх шалтгаан байхгүй нь тодорхой юм. Энэ нь зүгээр л сахилга баттай

байх, бодит байддыг жолоодох асуудал юм. Апсдаа энэ ч хэрэггүй болно. Хэл төгс төгөлдөр болмогц Хувьсгал дуусгавар болно. Шинхэл бол Ангсоц, Ангсоц бол Шинхэл юм” гэж тэрээр далдуур сэтгэл хангалуун хэлэв. “Хамгийн сүүлд гэхэд л 2050 онд чи бид хоёрын энэ яриаг тэр үед байх нэг ч хүмүүн ойлгож чадахгүй гэдгийг чи ер нь ухаарсан уу?”

“Бусад нь” гэж Смит эргэлзэнгүй хэлээд дуугүй болов.

Түүний аман дээр “Үгээгүйчүүдээс бусад нь” гэсэн үг гарч ирсэн ч тэрээр энэ үг намын бодлогод нийцэх эсэхийг баттай мэдэхгүй тул биеэ барилаа. Гэтэл Сайм хэлэх гэснийг нь аль хэдийнээ тааварлажээ.

“Үгээгүйчүүд бол хүн биш ээ. 2050 он гэхэд, түүнээс ч өмнө Хуучхэлний талаарх бүх бодит мэддэгийг үгүй болгоно. Өнгөрсөн үеийн бүхий л утга зохиолыг устгана. Чаусер, Шекспир, Милтон, Байрон тэдний зохиол зөвхөн

Шинхэлийн хувилбараар байх болно. Тэдний зохиолыг зүгээр л нэг өөр юмаар солиод зогсохгүй, тэдгээрийг үнэн хэрэг дээрээ байсантай нь огт өөр юмаар солино. Намын утга зохиол хүртэл өөрчлөгднө. Лоозон хүртэл өөрчлөгдөнө. Эрх чөлөөний үзэл баримтлалыг устгачихсан үед “эрх чөлөө бол боолчлол” мэт лоозонгоор юу хийх юм бэ? Сэтгэлгээний бүхий л орчин өөрчлөгдөнө. Хэрэг дээрээ бидний одоо ойлгож байгаа

шиг тийм сэтгэлгээ байхгүй болно. Үзэл бодолдоо үнэнч байх нь сэтгэхгүй гэсэн үг, бодох шаарддага байхгүй болно. Үзлээ тууштай баримтлах нь ухамсаргүй байдал мөн”

Сайм бол дэндүү ухаантай, тэрээр юмыг маш сайн ойлгодог, тун тодорхой ярьдаг тул ойрмогцоо түүнийг ууршуулна даа гэж Смит нтгэлтэй бодож байв. Нам ийм хүмүүст дургүй. Нэг л өдөр тэрээр сураггүй алга болно. Энэ нь түүний нүүр дээр бичээстэй байна.

Смит талх, бяслагаа дуустал идээд аягатай кофегоо уунгуут хажуу тийшээ харж суулаа. Түүний зүүн гар талын ширээний ард хахираа хоолойтой эр зогсоо зайгүй ярьсаар байна. Залуухан бүсгүй, нарийн бичгийн дарга бололтой, тэр эрийн яриаг анхааралтай сонсож хэлсэн үг болгоныг нь зөвшөөрч буй бололтой. Тэр эмэгтэйн үе үе "Таны тун зөв. Би тантай санал нэг байна" гэх дуу Смитэд сонсогдоно. Тэр эмэгтэйг ярьж байхад ч нөгөөх эр ярьсаар л байна. Смит тэр эртэй Яаманд дайралддаг тул зүс таних ба Уран зохиолын газар ямарваа нэг чухал алба хашдагийг нь мэдэх юм. Мань хүн гуч эргэм настай, бүдүүн хүзүүтэй, том амтай аж. Тэрээр толгойгоо жаахан дээш болгоход нь нүдний шил нь гялтганаад нүд нь харагдахгүй байхыг Смит харлаа. Түүний амнаас зогсоо зайгүй гарах үгний нэг нь ч ойлгогдохгүй байгаа нь дотор арзагануулна. Смит нэг удаа л хэлж буй үгнийх нь дундаас «голдштейнчүүдийг бүрэн төгс устгах нь» гэсэн үг чанга дарсан дардас шиг тов тод дуулдав. Бусад нь бөөн шуугиан, шувуу гуаглаж буй юм шиг байв. Хэлж байгаа

үгий нь ойлгох аргагүй ч гэсэн юу ярьж буйг нь ерөнхийдөө тааварлаж ядах юмгүй аж. Тэрээр Голдштейнийг хараан зүхэж, сэтгэхүйнгэмтнүүд болон хорлон сүйтгэгчдийн эсрэг улам хатуу арга хэмжээ авахыг шаардаж Евразийн Гүрний цэргийн эрхтэнүүдийн зэрлэг ажиллагаанд дургүйцдээ илэрхийлж, Их Ах болон Малабарын фронтын баатруудыг шагшин магтаж байсан ч, ямар ч ач холбогдолгүй байв. Юутай ч түүний үг бүр жинхэнэ Ангсоц үзэл бодолдоо үнэнч үг байв. Смитэд түүний нүдгүй нүүр, түргэн хөдлөх эрүүгий нь харж байхдаа тэрээр жинхэнэ хүн биш харин ямар нэг мануухай юм даа гэсэн хачин бодол төрж байв. Тэр хүний оюун санаа нь бус хоолой нь ярьж байна. Түүний амнаас гарч буй дуу чимээ нь үгнээс бүрдэж буй боловч энэ бол үнэн хэрэгтээ яриа биш аж. Энэ бол нугас гуаглах лугаа адил аяндаа гарсан дуу чимээ аж.

Сайм нэг хэсэгтээ чимээгүй болоод халбаганыхаа ишээр шөлний асгадас дээгүүр хээ зурж сууна. Хажуугийн ширээнээс нөгөөх



эрийн гуаглах дуу тасралтгүй гарч шуугиан чимээ дотроос үг нь тод дуулдана.

“Шинхэлд нэг үг байдаг юм. Чи тэр үгийг мэдэх үгүйг би мэдэхгүй. *Нугасхэл*, нугас шиг гуаглах гэсэн үг. Энэ бол эсрэг тэсрэг хоёр утгатай сонин үгний нэг юм. Энэ үгийг өрсөлдөгчдөө хэрэглэх юм бол дорөмжлол болно, санаа нийлж буй хүнд хэрэглэх юм бол энэ нь магтаал сайшаал болно” гэж Сайм ярьж байна.

Саймыг ууршуулах нь гарцаагүй хэрэг ээ гэж Смит дахиад л бодно. Тэрээр Сайм өөрийг нь үздэггүй, жаахан ойшоодоггүй бөгөөд шалтаг л гарах юм бол сэтгэхүйн гэмтхэрэгтэн гэж буруушааж бүрнээ чадах хүн гэдгийг мэдэх боловч түүний талаар гунигтай бодол төрж байв. Түүнд ямар нэг юм дутагдаж байна. Болгоомжлол, юмнаас хол байх зан, өөрийгөө аврах тэнэг үг. Үзэл бодолдоо үнэнч бус гэх аргагүй. Тэрээр Ангсоцын зарчимд итгэдэг, Их Ахыг шүтэн биширдэг, ялалт бүрийг бахархан хүлээж авдаг, тэрсүү үзэлтнийг чин сэтгэлээсээ

бус харин улайран үзэн яддаг, Намын жирийн гишүүнд олддоггүй хамгийн сүүлийн үеийн мэдээлэлтэй байдаг юм. Гэсэн мөртлөө яльгүй муу нэр түүнээс салдаггүй. Тэрээр хүний ярих ёсгүй юмыг ярьж явдаг, маш олон ном уншсан, зураач, хөгжимчдийн салдаггүй «Туулайн бөөр мод» кафед ордог юм. Энэ кафед орохыг хориглосон хууль ч, аман хориг ч байхгүй мөртлөө кафег муу ёрын газар гэж үздэг юм. Намын өндөр настай, адлагдсан удирдагчид албан тушаалаасаа бүрмөсөн авахуулахынхаа өмнө энд цугладаг байсан юм. Хэдэн жил, хэдэн арван жилийн өмнө Голдштейн өөрөө биеэрээ энд заримдаа ордог байсан гэсэн яриа гардаг. Саймын хувь заяаг тааварлаж чадах юм байхгүй. Сайм хэрвээ Смитийн далд боддыг жаахан ч гэсэн тааварлах л юм бол Сэтгэхүйн Цагдаад түүнийг тэр дор нь илчилнэ гэдэг нь гарцаагүй. Энэ тухайд гэвэл өөр хэн ч байсан ингэх л болно, гэхдээ Сайм бусдаас илүү идэвх гаргана. Үзэл бодолдоо үнэнч байна гэдэг ухамсарлахгүй байхыг хэлнэ.

Сайм толгойгоо өндийлгээд “Парсонс ирлээ” гэж хэллээ.

Түүний хоолойны өнгө нь “Нөгөө тэнэг чинь” гэх шиг санагдуулна. Виктори хэмээх орон сууцны байшинд Смиттэй хамт оршин суугч Парсонс нь мэлхий царайтай, намхан нуруутай, бөөрөнхий биетэй хүн. Тэрээр гучин насандаа гүзээ нь сунаж хүзүү нь бүдүүрсэн боловч алхаа гишгээ нь хүүхэд шиг хөнгөн. Түүний гадна төрх нь ч хүүхэд шиг мөртлөө том хүн шиг харагдана. Тэрээр дүрэмт баадай өмссөн боловч хөх цэнхэр богино өмдтэй, саарал цамцтай, улаан зангиатай тагнуулчийн дүр төрхийг аргагүй санагдуулна. Түүнийг харахад хонхойчихсон өвдөг, памбагар бугуйндаа ханцуйгаа шамаячихсан дүр төрх харагдана. Парсонс үнэхээр боломж л олдвол богино өмд өмсдөг, биеийн хүчин чадал шаардах хөдөө гадаа аялалд явах зэрэг тохиолдолд ингэнэ. Тэрээр нөгөө хоёртой “Сайн уу, Сайн уу!” гэж мэнддээд хулмасаа үнэртүүлсээр ширээний ард суулаа. Нүүрнээс нь хөлс асгарна. Парсонсын

хөлс асгарах нь гайхалтай. Клубт теннисний цохиур нойтон байх л юм бол тэрээр ширээний теннист хожигджээ гэдгийг мэдэж ядах юм байхгүй ээ. Сайм олон үг жагсаан бичсэн урт цаас гаргаад гартаа үзэг бариад уншиж гарав.

“Харж байна уу, үдийн хоолныхоо үеэр ч ажиллаж байна. Сонирхолтой байх нь, тийм үү? Хөгшөөн, чи юу олчихвоо? Миний толгой ч хүрэхгүй биз дээ? Смит би яагаад чамтай хөөцөлдөөд байгааг мэдэж байна уу? Чи захиалга хийхээ мартсан байна лээ”

“Юуны захиалга билээ?” Смит аяндаа халаасаа суйлан хэллээ. Маш олон захиалга явагддаг тул аль нь вэ гэдгийг хэлэхэд ч амаргүй бөгөөд захиалгад цалингийн дөрөвний нэг нь явдаг юм.

“Үзэн ядах долоо хоногт захиалгыг оршин суугаа газраар нь хийж байгаа. Би байрныхныхаа мөнгийг цуглуулж байна. Аль чадахаараа зүтгэж байна, муугаа харуулахгүй юм шүү. Манай «Виктори» байшин бусдаас

олон дарцаг мандуулж чадахгүй бол үүнд миний буруу байхгүй гэдгийг шууд хэлчихье. Чи хоёр доллар өгнө” гэж амласан шүү.

“Хөгшин минь, ингэхэд манай сахилгагүй баньд чамайг өчигдөр чавхаар харавсан гэж дуулсан. Би түүнийг сайн загнасан. Би түүнд дахиад ингэх юм бол чавхыг чинь хурааж авна гэж хэлсэн шүү” гэж тэрээр хэлэв.

“Хүн цаазлахыг үзээгүйдээ жаахан ууртай байсан байхаа” гэж Смит хэлэв.

"Тийм дээ ... би юу хэлэх гэж байна вэ гэвэл зөв хүмүүжилтэй нь харагдаж байгаа биз? Дүрсгүй золигнууд, аль аль нь, гэхдээ их эрмэлзэлтэй! Боддог юм нь тагнуулч болох, мөн дайнд явах. Өнгөрсөн бүтэн сайн өдөр охин маань яасан гэж бодож байна? Тэд нар Беркампстед рүү аяллаар явсан юм. Тэгсэн чинь миний охин өөр хоёр хүүхдийг дагуулж бусдаасаа салаад орой болтол нэг хүнийг дагаж мөрдсөн байна лээ. Хоёр

цагийн турш ой дундуур тэр хүнийг мөшгиж яваад, Амершемд харуулд барьж өгсөн байна”

“Яаж байгаа нь тэр вэ? “ гэж Смит яаран асуув.

Парсонс их л бахдалтай үргэлжлүүлсэн нь.

“Охин минь шүхрээр ч юм уу өөр ямар нэг юмаар буусан дайсны тагнуул байна гэдгийг нь мэджээ. Чухам юу болсон гэж бодож байна. Тэр хүнийг яагаад сэжиглэв ээ? Тэр хүний шаахай нь нэг л хачин байж, ийм шаахай өмссөн хүнийг ерөөсөө үзээгүй юм байна. Гадаадын хүн байж таарах нь? Долоохон настай жаахан охин гэхэд их сэргэлэн байгаа биз, тийм үү? “

“Тэр хүнийг тэгээд яасан бол оо?”

“Үүнийг ёстой мэдэхгүй юм даа. Түүнийг... би нэг их гайхахгүй” гээд Парсонс хуруугаа буудаж буй юм шиг гаргаад пү пүс гэв.

“Сайн байна” гэж Сайм уншиж буй цааснаасаа толгойгоо өндийлгөлгүй хайхрамжгүйхэн хэллээ.

“Бид сонор сэрэмжтэй байхгүй бол болохгүй шүү” гэж Смит хүлцэнгүй дуугарав.

“Дайн болж байна шүү дээ л гэж хэлэх гэсэн юм” гэж Парсонс хэлэв.

Парсонсын үгийг батлах мэт теледэлгэцнээс бөмбөр нүдэх чимээ гарлаа. Энэ удаа фронт дээр гарсан ялалтын тухай бус Элбэгийн Яамны мэдээ нэвтрүүлж байна.

“Нөхөд өө!” гэж эрч хүчтэй залуу хүний дуу гарч, “Нөхөд өө, Анхаараарай! Та бүхэнд шинэ мэдээ дуулгая. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх фронт дээр ялалт байгууллаа! Өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дүн өнгөрсөн онтой харьцуулахад амьжиргааны түвшин хориос илүү хувиар өссөнийг харуулж байна. Өнөө өглөө Далайн Гүрэн даяар ухаалаг

жолоодлогоороо шинэ, аз жаргалтай амьдрал хайрласан Их Ахад баярласан талархсанаа илэрхийлж ажилчид үйлдвэр, албан газраасаа гарч туг дарцгаа барин сайн дурын жагсаал цуглаан хийж байна. Одоо тоо баримтыг бүрнээр нь үзүүлье. Хүнсний бүтээгдэхүүн.

“Бидний шинэ, аз жаргалтай амьдрал” гэсэн хэллэг хэд дахин давтагдсан бөгөөд Элбэгийн Яам энэ үгийг сүүлийн үед хэрэглэх ханддагатай болсон билээ. Парсонс бөмбөрийн дуунд анхаарал нь татагдаж алмайрчихсан уйтгартай царайлан сууж байна. Тэрээр тоо баримтыг цээжиндээ тогтоох чадваргүй боловч түүнд баярлах ёстой гэдгээ мэдэж байсан бөгөөд халааснаасаа тамхины бохины эвгүй үнэртэй, толгойд нь тамхи хагас дүүргэсэн том гаанс гаргаж ирлээ. Долоо хоногт нэг зуун грамм тамхины нормтой болохоор хүмүүс гаансаа тамхиар дүүргэдэггүй болно. Смит «Виктори» хэмээх янжуур татдаг ба түүнийхээ тамхийг нь унагачихгүй байхыг хичээнэ. Тамхины шинэ талон маргаашнаас хүчин төгөлдөр болох гэж



буй бөгөөд Смитэд дөрвөн ширхэг янжуур үлдсэн. Тэрээр хажуугаас гарах чимээ шуугианыг дарж теледэлгэцээс гарч буй үгийг сонсох гэж хичээж байна. Шоколадны долоо хоногийн нормыг хорин грамм хүртэл нэмснийх нь төлөө Их Ахад талархал илэрхийлж жагсаап болсон шиг байна. Дөнгөж өчигдөр нормыг хорин грамм хүртэл *багасгасан тухай* зарласан шүү дээ гэж Смит бодож сууна. Ганц хоног өнгөрөхөд л үүнд хууртагдсан гэж үү? Хууртагджээ. Парсонс тэнэг амьтан болохоороо хууртагдсан. Хажуугийн ширээний ард суугаа нүд нь үл харагдагч өнгөрсөн долоо хоногт норм гучин грамм байсан гэж хэлсэн хэнийг ч байг илчилж ууршуулах хүсэл шуналдаа улайрсан тэр хүртэл итгэжээ. Тэхлээр Смит л ганцаараа эрүүл саруул ухаантай байна уу? “

Теледэлгэцнээс үлгэр домгийн тоо баримт дуулдсаар байх бөгөөд өнгөрсөн жилтэй харьцуулах юм бол их хоол хүнс, олон хувцас, олон байшин барилга, олон тавилга, олон хоолны тогоо, их түлш, олон усан онгоц, олон

нисдэг тэрэг зэргийг үйпдвэрлэсэн болон олон хүүхэд төрсөн, өвчин, гэмт хэрэг, галзуурал солиорлоос бусад бүх юм өссөн аж. Жилээс жилд, мөчөөс мөчид хүн бүр, юм бүр маш түргэн өссөөр байна. Смит халбагаараа ширээн дээрх шөлний бор саарал үлдэгдэл дундуур урт хээ гарган түрүүний Саймынх шиг зурж суулаа. Тэрээр өөрийнхөө ахуй байдал, амьдралынхаа нөхцөлийг зэвүүцэн бодож байлаа. Амьдрал дандаа ийм байсан уу? Хоолны амт дандаа ийм байсан уу? Тэрээр дээшээ өндийн гал тогоо руу харлаа. Намхан тааз, хүн шөргөөсөөр байгаад хир болсон муухай ханатай пиг дүүрэн хүнтэй танхим, бие биетэй нь зайгүй ойрхон тавьсан болохоор ард нь суугаа хүмүүс тохойгоороо чихцэлддэг, гөлийчихсэн төмөр ширээ сандал, гулзайчихсан халбага, цоорчихсон хоол зөөх тавиур, эмтэрхий цагаан аяга, юм болгоны тос даасан гадаргуу, тоос шороо чихчихсэн онгорхой цоорхой, аядаатай жин, муу кофены исгэлэн үнэр, огидос хүрмээр шөл, хиртэй уранхай хувцас харагддаа. Хүний нас ахиж бүх юм таалагдахаа больдог нь мэдээжийн хэрэг

боловч ая тавгүй, заваан балиар, юм болгоны хомсдолтой ахуй, удаан үргэлжилдэг өвөл, хөл үрсэн оймс, дандаа эвдэрдэг цахилгаан шат, хүв хүйтэн ус, тамхи нь гоожсон янжуур, ой гутам амттай хоол зэргээс дотор эвгүй болдог нь амьдрал *хэвийн бус* гэдгийн шинж тэмдэг биш үү? Энэ бүхнийг тэсвэрлэх аргагүй юм шиг санагдаж байгаа бол, амьдрал өөр байсан шүү гэж заяагдмал ой ухаан чинь шивнээд байгаа юм биш үү?

Тэрээр эргэн тойрноо дахиад л нэг харлаа. Бараг л хүн бүр муухай, дүрэмт цэнхэр баадай өмсөөгүй байлаа ч муухай харагдах л байлаа. Өрөөний нөгөө үзүүрт нэгэн жижигхэн биетэй, цох хорхойтой хачин адилхан эр кофе ууж суух бөгөөд жижигхэн нүд нь ийш тийшээ гүйлгэнэнэ. Смит эргэн тойрноо сайн харах юм бол Намаар хүмүүжсэн өв тэгш хүн байна, тэр ч байтугай тэд олонх нь байна гэдэгт итгэхэд яасан амархан юм бэ гэж бодож байв. Өндөр нуруутай, булчинлаг залуу эрс, цайвар үстэй, том хөхтэй, амарлингуй, эрч хүчтэй, наранд

борлосон бүсгүйчүүд. Түүний боддоор бол үнэн хэрэг дээрээ Онгоц нисэх нэгдүгээр замын хүн амын олонх нь жижигхэн, баргар, муухай царайтай аж. Цох хорхой шиг ийм амьтад Яамдад шүгэлсэн нь сонин. Жижигхэн нүдтэй, богинохон хөлтэй эрт таргалчихсан, гөлийсөн царайтай, нааш цааш үргэлж гүйлдсэн эрчүүд. Намын удирддагын дор ийм л маягийн хүмүүс байх ёстой юм шиг санагдана.

Элбэгийн Яамны мэдээ дуусч цоглог хөгжмөөр солигдов. Парсонс энэ олон тоо баримтад бага зэрэг сэтгэл нь хөдлөөд гаансаа сорохоо болив.

“Элбэгийн Яам энэ жил үнэхээр сайн ажилласан шүү. Смит, хөгшин минь ингэхэд чамд надад өгчих илүү сахлын хутга байхгүй биз?” гэж тэрээр юм мэддэг царай гарган хэллээ.

"Танц ч байхгүй шүү. Ганц сахлын хутгаараа сар гаруй хусаж байгаа “ гэж Смит хариулав.

“Аргагүй. Юу ч гэсэн асуугаад үзье л гэж бодсон юм”.

“Харамсалтай байна” гэж Смит хэлэв.

Яамны мэдээллийн үеэр түр тасалдсан хажуугийн ширээний ард суугаа хүний гуагласан дуу дахиад л түрүүчийнх шигээ чанга гарч эхэллээ. Смит яагаад ч юм Хатагтай Парсонс, түүний шингэн сэгсгэр үс, тоос даасан үрчлээсийг нь бодож байв. Хатагтай

Парсонс ч, Смит ч, Обрайен ч ууршуулагдана. Харин нүд нь үл харагдах нугас шиг гуагладаг эр ер нь ууршуулагдахгүй. Яамны асар том байшингийн хонгилоор гүйлдэх цох хорхой шиг амьтдыг хэзээ ч ууршуулахгүй. Уран зохиолын газрын залуу эмэгтэйг ууршуулахгүй. Тэрээр хэнийг хороох, хэн нь үлдэхийг зөнгөөрөө мэдэх юм шиг байх ба харин чухам яагаад зарим нь амьд үлдэнэ гэдгийг мэдэхгүй байна.

Түүний бодлыг хажуугийн хүний огцом харц гэнэт тасалдуулав. Хажуугийн ширээнээс нөгөөх хар үстэй залуухан бүсгүй түүн рүү нүднийхээ булангаар ихэд сонирхон харж байна. Тэр хоёрын харц тулгарахад бүсгүй нүүрээ буруулав.

Смитэд айдас төрж нуруу руу нь хүйт оргив. Тэрээр тэрхэн дороо тайвширсан ч дотор нь нэг л эвгүй байна. Тэр бүсгүй яагаад намайг хараад байна вэ? Өөрийг нь ирэхэд тэр бүсгүй ширээний ард сууж байсан уу, аль эсвэл дараа нь ирсэн үү гэдгийг тэрээр харамсалтай нь санахгүй байлаа. Харин өчигдөр Хоёр минут үзэн Ядалтын үеэр тэр бүсгүй яагаад ч юм түүний ар талд суусан. Тэр бүсгүй түүний аль зэрэг чанга хашгирахыг нь сонсох гэж суусан нь лавтай.

Тэрээр урьдын адил бодолд автав. Тэрээр Сэтгэхүйн Цагдаагийн орон тооны ажилтан л лав биш байх, харин сайн дураараа тагнадаг бол хамгийн аюултай нь байж таарна. Бүсгүй

өөрийг нь хэр зэрэг удаан харж байгааг, магадгүй таван минут ч юм уу, тэрээр мэдэхгүй байна, тэгээд бас энэ хугацаанд царайгаа би хянаж байсан бил үү мэдэхгүй байна. Нийтийн байранд буюу теледэлгэцийн хараанд боддогширсноо харуу.пах юм бол энүүн шиг их аюултай юм байхгүй. Жаахан хөдөлгөөн л чамайг илчилнэ. Нүүр татваганах, царай барайх, амандаа үглэх, энэ бүхнийг хэвийн бус байдал, ямар нэг юм нуух гэсэн оролдлого гэж үздэг юм. Ер нь жирийн бусаар царай хувирах (жишээ нь, ялалтын тухай зарлаж байхад үл итгэсэн царай гаргах гэх мэт) нь шийтгэл хүлээх гэмт хэрэг мөн. Шинхэлээр үүнийг *нүүргэм* гэдэг юм.

Одоо тэр бүсгүй буруу харан сууж байна. Тэрээр Смитийг ер нь мөрдөөгүй ч байж болно, хоёр өдөр дараалаад ойрхон суусан нь тохиолддынх ч байж болно. Смитийн янжуур нь унтарсан тул түүнийгээ ширээний буланд тавиад ажил тараад татъя гэж бодож байлаа. Хажуугийн ширээний ард суугаа бүсгүй мэдээлэгч ч байж бүрнээ болно, тамхи нь дэмий

үрэгдэх ёсгүйн учир нь ойрын хэд хоногт Смит Хайрын Яамны хонгилд орчихсон байж ч бүрнээ болно. Сайм уншиж байсан цаасаа халаасандаа хийж Парсонс дахиад л ярьж байна.

“Манай сахилгагүй хүүхдүүд зах дээр хүний банзал шатаасныг би та нарт ярьсан бил үү?” гэж тэрээр амандаа гаансаа зуусан хэвээр инээнэ. “Их Ахын зурагтай зурагт хуудсанд хиам боолоо гэж тэгсэн юм. Араас нь сэмхэн ойртож очоод хайрцаг чүдэнзээр шатаасан байгаа юм. Их ч сүрхий шатсан байж таарна. Сахилгагүй байгаа биз? Их идэвхтэй, урам зоригтой хүүхдүүд! Тагнуулч болох гээд байж сууж чадахгүй байгаа юм, миний үеийнхээс хамаагүй дээр шүү. Саяхан тэдэнд юу авч өгсөн гэж санаж байна? Цоожны нүхээр чагнах чагнуур! Охин минь өчигдөр түүнийг гэртээ авч ирээд том өрөөнийхөө хаалганд шалгаж үзсэн юм, чихээрээ сонссоноос хоёр дахин чанга дуулдаж байна гэсэн! Энэ бол зүгээр л тоглоом л доо. Тэхдээ л тэдэнд зөв санаа суулгаж байгаа юм, тийм биз дээ?”



Теледэлгэцээс ажилдаа орцгоо гэсэн шүгэл тас хийлээ. Тэд цахилгаан шатанд хүн бөөгнөрөхөөс өмнө амжих гэж босон харайхад Смитийн тамхи нь гоожчихсон байв.

## VI

Смит өдрийн тэмдэглэлээ хөтөлж байна.

*Энэ явдал гурван жилийн өмнө төмөр замын буудлын хажууханд мухар гудамжинд удшийн харанхуйгаар болсон юм. Тэр эмэгтэй гудамжны бүдэгхэн гэрэлтэй дэнлүүний дор зогсож байв. Нилдээ оо энгэсэг болсон залуу нүүр. Баг өмсчихсөн юм шиг хувхай цагаан нүүр, час улаан уруул надад таалагдлаа. Намын гишүүн хүүхнүүд ерөөсөө нүүрээ буддаггүй юм. Гудамжинд нэг ч хүн, тэр ч байтугай теледэлгэц ч алга байв. Тэр эмэгтэй «Хоёр доллар» гэв. Би тэгээд....*

Тэрээр нүдээ аниад зовхио хуруугаараа дарж нүдэнд харагдаад байгаа дүр зургийг санахгүй байх гэж чармайж байна. Хамаг байдгаараа харааж хашгирмаар, толгойгоороо хана мөргөмөөр, ширээгээ онхолдуулмаар, цонхоор бэхээ хага шидмээр, сэтгэл тарчлааж байгаа

дурсамжийг галзуурал солиорол, чимээ шуугиан, шаналгаагаар ч юм уу ямар нэгэн юмаар дарж мартмаар байна. Тэрээр цааш нь бичиж чадахгүй болов.

Тэрээр миний заналт дайсан бол төв мэдрэлийн систем гэж боддоо. Дотор бухимдал маань гэв гэнэт гадаад шинж тэмдгээр илэрч болох нь. Хэдэн хоногийн өмнө гудамжинд дайралдсан хүнийг Смит саналаа, намын гингүүн, гучин тав, дөч эргэм настай, туранхай, нилээд өндөр, гартаа цүнх барьчихсан бусдаас онц ялгарах юмгүй жирийн л хүн. Тэд хэдхэн алхмын зайтай бие биедээ ойртож иртэл тэр хүний зүүн хацар нь гэнэт татваганав. Зэрэгцээд ирэхэд хацар нь дахиад л татваганав. Зуршил болсон бололтой зургийн аппаратын товчлууур тог тог гэж байгаа юм шиг татваганав. Смит тэхэд нь боддоо. Хөөрхий амьтан ч өнгөрч дээ. Хүн өөрөө үүнийгээ мэдэхгүй бол аймшигтай. Хамгийн аймшигтай нь зүүд дундаа ярих юм. Хүн үүнийг гаргахгүй байж ерөөсөө чадахгүй юм шиг Смитэд санагдана.

Тэрээр санаа алдаад цааш нь бичиж гарлаа.

*Би тэр эмэгтэйг дагаад орцоор дамжин хашаанд орж хонгилын гал зуухны өрөөнд оров. Хананы хажууд ор тавьсан байх бөгөөд ширээний дээр доош нь харуулсан дэнлүү асаалттай байна. Тэр эмэгтэй...*

Тэрээр их л цухалдан нулиммаар байв. Хонгил доторх гал зууханд байсан эмэгтэйг санахаар өөрийнхөө авгай Кэтринийг эргэн саналаа. Смит авгайтай байсан, нэгэн цаг үед, одоо ч авгайтай байж мэднэ. Авгайгаа амьд гэдгийг тэрээр мэддэг юм. Смит дахиад л гал зуухны бүгчим, хиртэй цагаан даавуу, бясаа, хямд сүрчигний холилдсон үнэр, шившгийн муухай, Намын эмэгтэй гишүүн сүрчиг хэрэглэдэггүй болохоор тэдний үнэрээс огт өөр хорхой хүрмээр үнэр дахиад л үнэртэх шиг боллоо. Үгээгүйчүүл л сүрчиг хэрэглэдэг юм. Смитэд сүрчигний үнэр бол бэлгийн харилцаанд орохтой салшгүй холбоотой юм.

Түүний хувьд энэ нь хоёр жилд үйлдсэн анхны нүгэл байв. Янхантай явалдахыг хориглодог нь мэдээжийн хэрэг боловч энэ нь үе үе зориг гарган зөрчдөг зуршил байв. Аюултай, гэхдээ амь насанд аюултай бус юм. Янхантай явалдаж байгаад баригдах юм бол хүндрүүлэх л шалтаг байхгүй бол таван жил хүрэхтэй үгүйтэй хугацаагаар цөлөгдөнө. Энэ нь тийм ч их ноцтой хэрэг биш, бэлгийн харилцаанд орж байх үед л баригдаагүй бол шүү дээ. Ядуу дүүргүүдэд биеэ үнэлэх гэсэн хүүхнүүд бужигнаж байдаг. Хэн нэгэн эмэгтэйг шил жинээр л худалдаж авч болно. Үгээгүйчүүд жин уух ёсгүй гэж үздэг юм. Нам цаагуураа биеэ үнэлэхийг харин ч дэмждэг дарагдашгүй зуршлаа эддэх боломж олгохын тулд дэмждэг юм. Садар самуун явдал сэмхэн, гутруу хийгдэж түүнд дарлагдсан, адлагдсан бүсгүйчүүд оролцож байгаа цагт ач холбогдол багатай юм. Намын гишүүд хоорондын садар самуун явдал бол тэсвэрлэшгүй гэмт хэрэг мөн. Том цэвэрлэгээний үеэр яллагдагсад ийм хэрэг

үйлдсэнээ заавал хүлээдэг боловч амьдралд ийм юм байдаг гэж бодоход ч бэрх юм.

Нам өөрийнх нь хяналтаас гадуур гарчихаж магадгүй гэж үздэг учраас эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоорондоо үнэнч харилцаатай байхыг гаргуулахгүй байх зорилготой юм. Намын жинхэнэ, зарлаагүй зорилт бол бэлгийн харилцааг ямар нэг таашаалгүй болгох явдал мөн. Гол дайсан бол хайр сэтгэл бус харин гэр бүлийн дотор болон түүний гаднах бэлгийн харилцаа юм. Намын гишүүд хоорондын гэрлэлтийг тусгай хороо баталдаг, ямар зарчмаар гэдгийг хэзээ ч ил зарлаагүй, тэхдээ гэр бүл болох эр, эм хоёр бие биеийхээ нүдэнд дулаахан харагдаж байна гэж үзэх л юм бол тэднийг гэр бүл болохыг зөвшөөрдөггүй юм. Гэр бүлийн цорын ганц хүлээн зөвшөөрсөн зорилго бол Намд үйлчлэх хүүхэд гаргах явдал мөн. Бэлгийн харилцаанд өрөх нь ердөө л гэдэс цэвэрлэх шиг жаахан эвгүй засал гэж үздэг юм. Үүнийгээ хэзээ ч шууд ил зарлаагүй мөртлөө намын гишүүн бүрт хүүхэд ахуй цагаас нь

ойлгуулсан байдаг. Эр эм хүйсийг аль алиныг нь эр эмийн ёсыг бүрмөсөн цээрлэхийг уриалдаг Бэлгийн харилцаанд орохын эсрэг залуусын Холбоо мэт байгууллагууд хүртэл бий. Бүх хүүхдийг зохиомол хээлтүүлгээр (Шинхэлээр зохьхээлт гэдэг) бий болгож улсын байгууллагад өсгөж хүмүүжүүлэх ёстой. Смит энэ шаарддагыг заавал биелүүлэхийг шаарддаггүй гэдгийг мэдэх ба энэ нь Намын үзэл сурталд ерөнхийдөө нийцдэгийг ч мэддэг юм. Нам бэлгийн харилцаанд орох дуршлыг дарах эрмэлзэлтэй, гэхдээ үүнийг бүрмөсөн дарж чадахгүй юм бол гуйвуулж бузартуулахыг эрмэлздэг юм. Смит яах гэж ингэж буйн учрыг мэддэггүй. гэхдээ үүнийг гайхаад байх юм байхгүй. Эмэгтэйчүүдийн хувьд бол Намын хүчин чармайлт их амжилт олсон байна.

Смит дахиад л Кэтринийг бодож байлаа. Тэд салснаас хойш ес, арав, бараг арван нэгэн жил өнгөрсөн байх аа. Тэрээр түүнийгээ яахлаараа ийм цөөхөн боддог юм бэ. Тэрээр эхнэртэй байсан гэдгээ хэдэн долоо хоногоор ч

мартчихсан байдаг. Нам гэрлэлт салалтыг дэмждэггүй, гэхдээ хүүхэдгүй гэр бүл салалтыг чухамдаа өөгшүүлдэг юм.

Кэтрин шаргал үстэй, цэв цэгцхэн өндөр нуруутай, уяхан хөдөлгөөнтэй бүсгүй байсан. Тэр бүсгүйн монхор хамар, зоримог нүүр нь сурвалжит хүнийх гэмээр харагддаг боловч түүний цаана ийм юм огт байхгүй, ийм ч байх ёсгүй гэдгийг Смит ойлгосон юм. Смит хамтын амьдралынхаа бүр эхэнд л түүнтэй бусад хүнээс илүү ойр дотно байсан болохоор мэдсэн юм. Түүн лүгээ адил тэнэг, бүдүүлэг, оюун ухааны хомсдолтой хүнтэй ер нь дайралдаж байгаагүй гэдгээ ухаарсан юм. Кэтриний толгойд Намын лоозонгоос өөр юу ч байдаггүй бөгөөд Намаас тунхагласан л бол ямар ч утга учиргүй дэмий балай юуг ч тэрээр үг дуугүй дагадаг байлаа. Смит дотроо түүнийг “Хүний дуу хураагуур” гэж нэрлэдэг байв. Өвөрт орох гэгч юм байгаагүйсэн бол Смит түүнтэй тэсээд амьдраад байх байсан билээ.



Кэтриний биед хүрмэгц л тэрээр давхийн цочиж хөшчихнө. Түүнийг тэврэнэ гэдэг бол модон мануухай тэврэхтэй л нэг адил. Тэрээр нөхрөө тэвэрч байхад хамаг хүчээрээ түүнийг түлхээд байгаа юм шиг санагдуулдаг нь нэг л хачин жигтэй. Бүсгүйн хөшчихсөн булчин шөрмөс нь ийм сэтгэгдэл төрүүлнэ. Тэрээр нүдээ аньчихсан эсэргүүцэх ч үгүй, ая тал-ч засахгүй өөрийгөө л өгч хэвтэнэ. Энэ нь их ичмээр эцсийн бөлөгт их эвгүй байдагсан. Тэд өвөртөө орохгүй гэж тохиролцсон бол тэрээр үүнийг юутай ч тэсээд байх байсан юм. Гайхалтай нь Кэтрин үүнийг зөвшөөрдөггүй байсан ба бид болж л өгвөл хүүхэдтэй болох ёстой гэдэг байлаа. Тэр хоёр элдэв саад тохиолдохгүй л бол энэ ажлаа тогтмол долоо хоногт нэг удаа хийдэг байсан. Кэтрин тэр ч байтугай мартчихгүйн тулд орой ийм юм хийнэ шүү гэж өглөөгүүр сануулдаг байсан юм. Тэрээр үүнийгээ хоёр янзаар хэлдэг байлаа. Нэг нь «хүүхэд бодох», нөгөөх нь «намын өмнө хүлээсэн бидний үүрэг» (тэрээр яг ингэж хэлдэг байсан юм) гэдэг байлаа. Тун удалгүй нөгөө өдөр дөхөхөөр түүний дургүй

хүрдэг болсон юм. Аз болоход тэд хүүхэдтэй болоогүй билээ. Кэтрин ч оролдохоо болиод тэр хоёр удалгүй салсан юм.

Смит дахиад чимээгүйхэн санаа алдаад үзгээ аваад үргэлжлүүлэн бичлээ.

*Нөгөөх эмэгтэй орон дээрээ тэрийж унаад юу ч хэлэлгүй банзлаа маш бүдүүлгээр эрээ цээргүй дээш нь татлаа. Би...*

Тэрээр бүдэгхэн дэнлүүний гэрэлд өөрийгөө дахин харж жоом, хямд сүрчигний үнэр дахин үнэрлэж Кэтриний Намын ховсдолд хөшчихсэн цав цагаан биеийг жигшиж зэвүүцэн харлаа. Тэрээр яагаад дандаа ийм байх ёстой юм бэ? Хэдэн жилд тохиолддог ийм балиар заваан юмны оронд тэрээр яагаад өөрийн гэсэн хүүхэнтэй байж болдоггүй юм бэ? Харин жинхэнэ янаг амрагийн явдал гэдэг юм бол санахын ч хэрэггүй зүйл юм. Намын гишүүн эмэгтэйчүүд бүгд адил юм. Ариун онгон байна гэдэг бол тэдний хувьд Намдаа үнэнч байна

гэсэн үг. Тэдэнд сургуульд сурч байх үеэс нь Тагнуулчид, Залуусын Холбооноос зохион байгуулдаг спорт тоглолт, хүйтэн усанд орох, лекц сонсох, дуу дуулах, лоозон хашгирах, цэргийн хөгжим сонсох зэрэг долоон шидийн юмаар төрөлх сэтгэл санааг нь төлөвшүүлдэг юм. Тэрээр үүнээс гадуур юм гэж байх ёстой гэж ухаардаг ч зүрх сэтгэл нь үүнд нэг л итгэдэггүй юм. Нам зорьсондоо хүрсэн болохоор тэд бүгд халдашгүй юм. Тэрээр энэ ханыг цоо цохиод хэн нэгний хайр сэтгэлийг татах юмсан гэж хамгийн их хүсдэг байлаа. Бэлгийн харилцаанд сэтгэлээсээ орох нь бослого гэсэн үг юм. Хүсэл дуршил сэтгэхүйнгэм мөн. Кэтриний сэтгэлийг зөөлрүүлж чадсансан бол тэрээр хэдийвээр түүний гэргий ч гэсэн энэ нь завхай явдалд уруу татсан хэрэг байх байсан.

Тэрээр тэмдэглэлээ дуусгах учиртай тул үргэлжлүүлэн бичлээ.

*Би дэнлүүний гэрлийг нэмээд хартал...*

Хав харанхуйд керосин дэнлүүний гэрэл их юм шиг байх бөгөөд би сая л тэр эмэгтэйг сайн харлаа. Тэрээр дур тачаалдаа автан урагш алхсанаа айдастаа автагдан зог туслаа. Тэрээр ирснээрээ ямар их эрсдэл хийж байгаагаа ухамсарлаж байлаа. Түүнийг эндээс гарч явахад нь эргүүл бариад авчих ч юм бил үү, тэд одоо түүнийг хүлээж байж ч болох юм. Тэрээр хийх гэсэн юмаа хийлгүй гараад явлаа ч гэсэн!

Болсон явдлыг бичих хэрэгтэй, нүглээ наминчлах хэрэгтэй. Харин тэрээр дэнлүүний гэрэлд хөгшин эмэгтэйг харлаа. Тэрээр хацраа их өтгөн будсан болохоор хатуу цаасан баг шиг бөгөөд одоо задраад уначих юм шиг харагдана. Үсэнд нь буурал суучихсан, хамгийн эвгүй нь амаа нээсэн чинь нэг ч шүд байхгүй онгорхой хар нүх байна.

Тэрээр яаран муруйлган бичлээ.

*Би түүнийг гэрэлд харсан чинь тэр бээр бүр хөгшин тавь гаруй настай юм байна. Би зогссонгүй хүссэнээ гүйцээв.*

Смит зовхио алгаараа дарлаа. Бүх юмаа биччихлээ, тэгээд юу ч өөрчлөгдсөнгүй. Эмчилгээ нэмэр болсонгүй. Аль байдгаараа хараалын үг хашгирмаар хүсэл улам хүчтэй боллоо.

## VII

*Найдвар байдаг бол тэр нь үгээгүйчүүдэд л байна гэж Смит бичлээ.*

Найдвар гэж байдаг л юм бол тэр нь Далайн Гүрний хүн амын 85 хувь болох багширсан үй олон үгээгүйчүүдэд л байна. Энд л Намыг устгаж чадах хүч үүснэ. Намыг дотроос нь унагаж болохгүй. Намын дайснууд, түүнд дайсан гэж байдаг л юм бол, хоорондоо нэгдэх нь байтугай бие биеэ ч мэддэггүй юм. Домогт Ах дүүгийн Барилдлага байдаг бол, байдгийг үгүйсгэх арга байхгүй, тэр байгууллагын гишүүд хоёр, гурваас олноороо цугларна гэж бодохын ч хэрэг байхгүй. Тэдний тэмцэл гэдэг нь нүдний харц, хоолойны дууны өнгө. Хамгийн хүчтэй нь л гэхэд шивнээ үг байдаг. Үгээгүйчүүд өөрийнхөө хүчийг ухааран ойлгодогсон бол тэдэнд хуйвалдаан байгуулах ч хэрэг байхгүй. Тэд эмээлээ авч хаяж буй догшин морь шиг булгихад л хангалттай юм. Тэд хүсэх л юм бол маргааш гэхэд л Намыг бут

ниргэнэ. Тэд хэзээ нэгэн цагт үүнийг ойлгох л болно. Гэхдээ!...

Тэрээр нэг өдөр хөл хөдөлгөөнтэй гудамжаар явж байтал мухар гудамжнаас олон эмэгтэйчүүдийн орилох, бахирах, уйлах дуу гарч байлаа. Сүмийн хонхны дуу шиг хүчтэй уур хилэн, цөхрөлийн «Хөөе, хөөе ээ!» гэсэн дуу тасралтгүй хүнгэнэлээ. Смитийн зүрх хүчтэй цохиллоо. Эхэлчихжээ! Бослого гарчээ! гэж тэрээр бодов. Ашгүй дээ, тэд бослого гаргажээ! Тэрээр ойртож очоод харлаа. хоёр, гурван зуун эмэгтэйчүүд захын мухлагийн үүдний өмнө бөөгнөрөлдөөд царай нь живж байгаа усан онгоцны зорчигчдынх лугаа адил эмгэнэлтэй харагдана. Смитийг харж байтал нөгөөх

цөхрөлөө барсан хүмүүс нь хоёр гурваараа хуваагдаад маргалдаж эхлэв. Нэг мухлагт нь сав суулга худалдаж байсан бололтой юм. Тэр нь муухай хийцтэй, хэврэг төмөр сав шүү, гал тогооны сав суулга олж авахад ер нь амаргүй

байдаг. Тэгээд одоо нөгөөх сав суулга нь дуусчихлаа.

Азтай худалдан авагчид нь сав суулгаа тэврээд олны дундуур чихцэлдэн явж байхад хоосон хоцорсон хүмүүс нь мухлагийн үүд шавж мухлагийн худалдагчийг танил талдаа юм зарлаа, хагасыг нь цааш нь хийчихлээ гэж зэмлэнэ. Хоёр бүдүүн эмэгтэй, нэгнийх нь үс гээг задгай, хоолны төмөр сав хоёр тийш нь татаж булаацалдан бөөн шуугиан дахин дэгдпээ. Булаацапдсаар байтал савны бариул ч хугарчихлаа. Смит энэ бүхнийг зэвүүцэн харж байв. Энэ хоёр, гурван зуун хүний хашгирах дуунд ямар их аюумшигтай хүч байна вэ! Эд нар яахлаараа ер нь ямарваа чухал юмны төлөө ингэж хашгирдаггүй юм бэ!

Тэрээр бичиж байна.

*Тэд нар ухамсартай болоогүй цагт хэзээ ч босохгүй, босохгүй бол ухамсартай болохгүй.*



Намын сурах бичгээс шууд авчихсан юм шиг хэллэг боллоо гэж Смит бодов. Нам үгээгүйчүүдийг гинжнээс нь чөлөөлсөн гэж нотолдог. Тэднийг хөрөнгөтнүүд хувьсгалаас өмнө хоол унд өгөхгүй, зодож тарчлааж, эмэгтэйчүүдийг уурхайд ажиллуулж (дашрамд хэлэхэд тэд нар одоо ч уурхайд ажиллаж байгаа) хүүхдүүдийг зургаан настайгаас нь үйлдвэрт худалдаж аймшигтай дарлаж мөлжиж байсан. Үүний зэрэгцээ Нам хоёрсэтгэх зарчмынхаа дагуу үгээгүйчүүд нь заяаны дорд язгуурын хүмүүс мөн бөгөөд тэднийг цөөн хэдэн хялбархан дүрэм журмаар мал лугаа адил эрхшээлдээ байлгах ёстой гэж сургадаг. Үнэн хэрэг дээрээ үгээгүйчүүдийн талаарх мэдлэг хомс юм. Тэдний талаар их юм мэдэх ч хэрэг байхгүй. Тэд ажиллаад л, үржиж өсөөд л байвал тэдний юу хийх нь ач холбогдол байхгүй. Аргентиний нам дор газар бэлчиж яваа мал лугаа адил үгээгүйчүүдийг дур зоргоор нь тавьчихсан болохоор тэд өөрсдөд нь байгалаас заяасан мэт амьдралын хэвшилдээ эргэж очоод өвөг дээдсийнхээ замаар явж байна. Тэд нар

балиар заваан орчинд төрж өсөөд арван хоёр настайгаасаа ажил хийж, асархан хугацаанд бие бялдар нь хөгжиж, бэлгийн харилцаанд ороод, хорин насандаа гэрлэж гучин насандаа аль хэдийний ахимаг настай болж жаран насандаа гол төлөв үхдэг аж. Биеийн хүнд хөдөлмөр, ар гэр, хүүхдээ асрах, хөршүүд хоорондын ялихгүй хэрүүл, хөл бөмбөг, шар айраг, хамгийн гол нь мөрийтэй тоглоом энэ бүхэн бол тэдний оюун ухааныг эзэмдэж байдаг зүйл. Тэднийг хяналтдаа байлгах нь хэцүү биш ээ. Сэтгэхүйн Цагдаагийн хэдхэн туршуул тэдний дунд эргэлдэж цуу яриа тарааж аюултай байж болох цөөн хэдэн хувь хүнийг мөрдөн мөшгиж устгадаг. Харин Намын үзэл суртлаар тэдний тархийг угаах гэж чармайлт гаргадаггүй юм. Үгээгүйчүүд улс төрийн гүн мэдрэмжтэй байх нь хүсмээр зүйл биш ээ. Ажлын цаг уртасгах, хүнсний норм багасгах асуудал гарах үед тэд нараар эх оронч үзэл гаргуулах шаарддага гардаг юм. Тэд нарт дургүйцэл төрөх юм бол, ийм юм гарах явдал ч бас бий, тэр нь нийтлэг үзэл санаа байхгүй жижиг сажиг гомдол байдаг

тул ямар ч амжилт олдоггүй. Их гай зовлонг тэд олж хардаггүй юм. Олонх үгээгүйчүүдийн гэрт теледэлгэц ч байхгүй. Жирийн цагдаагийн байгууллага тэднийг анхаардаггүй юм. Лондонд маш их гэмт хэрэг гардаг бөгөөд улсын доторхи улс гэж болно. Хулгайч, дээрэмчид, янхнууд, хар тамхины наймаачид, зүсэн зүйлийн луйварчид бий. Харин тэд үгээгүйчүүдийн хүрээнд л эргэлдэж байдаг тул тэднийг хэн ч анхаардаггүй юм. Тэдэнд зан суртахууны хувьд өвөг дээдсийнхээ зуршлыг дагахыг зөвшөөрдөг юм. Бэлгийн харилцаанд орох нь нүгэл гэж үздэг Намын зарчим тэдэнд хамаагүй. Тэднийг садар самуун явлаа гэж шийтгэдэггүй, гэр бүл салалтыг нь зөвшөөрдөг. Үгээгүйчүүд өөрснөө сонирхох юм бол шажин шүтлэгийг ч зөвшөөрөх байсан. Үгээгүйчүүдийг хардаж сэжнглэдэггүй. «Үгээгүйчүүд ба амьтад чөлөөтэй» гэсэн Намын лоозон бий.

Смитийн хөлийн судасны шарх дахиад л тэсэхийн аргагүй загатнаж эхэлсэн тул тэрээр түүнийгээ маажиж суулаа. Хүссэн ч хүсээгүй

ч нөгөө л асууддаа өөртөө эргэж тавих болдог. Хувьсгалаас өмнө бидний амьдрал өөр байсан уу? Тэрээр Хатагтай Парсонсоос түр авсан дунд сургуулийн түүхийн сурах бичгийг гаргаад түүнээс хуулж бичиж гарлаа.

*Ялгуусан хувьсгалаас өмнөх үед Лондон бол бидний өнөөдрийн танил сайхан хот шиг байгаагүй юм. Энэ нь гэрэл гэгээгүй, бохир балиар, уйтгар төрүүлсэн, бараг бүх оршин суугчид нь өлмөн зэлтэн амьдралтай, мянга мянган орох оронгүй, хөл нүцгэн хүн гудамжаар нь хөлхөлдсөн хот байсан. Чиний үе тэнгийн хүүхдүүд харгис хэрцгий эздэд зарагдаж өдөрт арван хоёр цаг ажил хийдэг байжээ, жаахан удаан хөдлөх л юм бол тэднийг ташуурддаг, хатсан талхны булан, усаар тэжээдэг байсан юм. Ийм аймшигтай ядуурал хоосролын дунд баячуудын өндөр сайхан байшингууд байдаг, тэдний заримд нь гуч орчим зарц үйлчилдэг байв. Баячуудыг хөрөнгөтнүүд гэж нэрлэдэг байжээ. Эд нар бол бүдүүн тарган, зэрлэг царайтай хүмүүс байжээ. Тэд нар урт сүүлт*

*нэртэй, урт хар пиджактай, пийшингийн яндан шиг хэлбэртэй бортого малгай нэртэй, хар торгон бүрх малгай өмссөн байгааг харж байгаа биз дээ. Хөрөнгөтнүүд ийм дүрэмт хувцас өмсдөг байсан ба өөр хэн нэгэн ийм хувцас өмсөх эрхгүй байсан. Хөрөнгөтнүүд дэлхийн хамаг юм эзэмшдэг байсан ба бусад нь тэдний боол байлаа. Хөрөнгөтнүүдийн үгийг сонсоогүй хэнийг ч бай шоронд хийж өлсгөлөнгөөр хатааж алахын тулд ажлаас нь халдаг байв. Эгэл хүн хөрөнгөтөнтэй ярихдаа малгайгаа авч бөхийн тонголзож «Ноёнтон гуай» гэж дуудах ёстой байжээ. Хамгийн гол хөрөнгөтнийг хаан гэдэг байсан ба тэр нь...*

Смит энэ жагсаалтыг цээжээр мэддэг юм. Энэ жагсаалтад бээлий зүүсэн хамба ламтан, үслэг захтай нөмрөгтэй шүүгчид, дөнгө, гав, тээрэм эргүүлэх шийтгэл, бүдүүн ташуур, Хотын Лорд Мэрийн цайллага, Пап ламын хөлийн хурууг үнсэх зуршил зэрэг орно. Мөн *jus primae noctis* гэдэг юм бас бий. Харин хүүхдийн сурах бичигт энэ тухай дурдахгүй нь лав бололтой.

Хөрөнгөтөн бүр үйлдвэртээ ажилладаг эмэгтэйтэй хэнтэй нь ч унтах эрхийг хуульчилсан байжээ.

Эдгээр нь хэр зэрэг худал хуурамч зүйл гэдгийг та яаж мэдэх вэ? Дундаж амьдралтай хүн Хувьсгалын өмнөх үеийнхээс дээр аж төрдөг болсон гэдэг нь *үнэн* байж ч болох юм. Үүнийг хүлээж авахгүй байх цорын ганц нотолгоо нь өөрийн чинь мах цусанд шингэсэн ил хэлдэггүй эсэргүүцэл, амьдрал тэсч байхын аргагүй юм, хэзээ нэгэн цагт өөр *байсан байх* гэсэн төрөлх зөн юм. Өнөөгийн амьдралын хамгийн гол шинж тэмдэг бол энэ амьдралын ширүүн бүдүүн нь ч биш, баталгаагүй нь ч биш, харин зүгээр л хоосон хөндий, уйтгар гунигтай, гутармал чанар юм гэж Смитэд гэнэт бодогдлоо. Та өөрөө эргэн тойрноо нэг сайн харах юм бол амьдрал маань теледэлгэцээр цацаж буй худал хуурмаг зүйлтэй огт адилгүй, түүгээр ч зогсохгүй, Намын хүрэх гэж зорьж буй орь хүслэнгээс огт ондоо юм. Намын гишүүдийн ихэнхийн хувьд ч гэсэн ялгаагүй амьд явах

насны ихэнх нь улс төрийн гаднах орчинд өнгөрнө. Нэг хэвийн уйтгартай ажилд зогсоо зайгүй зүтгэх, Метронд урьтаж суудал авах гэж чихцэлдэх, оймсныхоо цоорхойг нөхөх, сахар орлуулагч олох гэж гуйланчлах, тамхины шилбэ цуглуулах гэсээр өнгөрнө. Намын туйлын зорилго нь асар их, сүр далайцтай, гайхам сайхан зорилт юм. Ган, бетоны үйлдвэрлэл, аврага том машин, хөнөөлт зэвсэг, адилхан сэтгэдэг, адилхан лоозон хашгирдаг, цуцалтгүй ажилладаг, тэмцдэг, адилхан баяр хөөр болдог, мөрдөж мөшгиж явдаг, нэг эгнээнд алхсан цэрэг эрс, бишрэн шгүтэгчид, нэг нүүр царайтай гурван зуун сая хүн юм. Цоорхой гуталтай өлөн зэлмэн хүмүүс хөлхөлдсөн сөнөж байгаа сүүмгэр баргар хотууд, байцаа, жорлон үнэртсэн арван есдүгээр зууны эвдэрхий байшингууд бол бодит байдал. Түүний нүдэнд Лондон хот сая хогийн савтай асар их эвдрэл сүйрлийн хот болон атираатай нүүртэй, шингэн үстэй, гал зуухны усны хоолойг засах гэж аргаа баран оролдож буй Хатагтай Парсонсын дүр харагддаа.

Тэрээр доошоо тонгойгоод хөлийнхөө судсыг маажив. Теледэлгэцээр өдөр шөнөгүй хүмүүс улам сайн хооллодог, сайн хувцасладаг, сайн байшинд суудаг, чөлөөт цагаа улам сайхан өнгөрөөдөг, урт насалдаг, бага ажилладаг боллоо. Тэдний бие бялдар нь улам том, улам эрүүл саруул, хүч чадалтай, аз жаргалтай, улам ухаантай, тавин жилийн өмнөхөөс илүү боловсролтой боллоо гэж тоо баримтаар чихэнд чинь хангинана. Нэг ч үгийг батлах боломжгүй, мөн үгүйсгэх ч аргагүй. Нам тухайлбал хувьсгалаас өмнө үгээгүйчүүдийн зөвхөн арван таван хувь нь бичиг үсэгт тайлагдсан бол өнөөдөр дөчин хувь нь бичиг үсэгт тайлагдсан гэж баталж байна. Нам өнөөдөр мянган хүүхдэд ногдох хүүхдийн эрсдэл дөнгөж нэг зуун тавь бөгөөд хувьсгалын өмнө энэ нь гурван зуу хүрч байлаа... гэхчлэн баталж байна. Энэ бол хоёр үл мэдэгдэхүүнтэй тэгшитгэл шиг юм. Түүхийн номонд байгаа үг бүр мэдээжийн юм гэж хүлээн авч болох үг бүр санаанаасаа цэвэр зохиосон үг байж бүрнээ болох юм. Миний мэдэхээс л *jus pretae noctis* гэсэн хууль, хөрөнгөтөн гэдэг



амьтан, бортого малгай гэж юм ерөөсөө байгаагүй байж ч болох юм.

Бүх юм манан буданд замхарч байна. Өнгөрсөн үеийг баллуурдчихсан, баллуурдсанаа мартчихсан, худал юм үнэн болж хувирсан. Тэрээр энэ насандаа нэг удаа л, хамгийн гол нь *үйл явдлын мөрөөр* үйл явдлыг гуйвуулж мушгисны гарцаагүй нотолгоог олж авсан юм. Тэрээр тэр баримтаа гартаа хэдхэн хором барьж байсан юм. Энэ явдал 1973 онд... Кэтринээс салсан үед болсон шиг санагдана. Долоо, найман жилийн өмнөх үйл явдлын талаар ярьж байна.

Жараад оны дунд үед хувьсгалын жинхэнэ удирдагчдыг толгой дараалан хядсан том цэвэрлэгээний үеэр энэ түүх эхэлсэн. 1970 он гэхэд хувьсгалын удирдагчдаас ганцхан Их Ах л үлдсэн бөгөөд бусад нь урвагч, хувьсгалын эсэргүү байсныг илчилсэн. Голдштейн зугтаж алга болоод хаа нэг газар нууц байдалд орж хэн нэгэн хүн зүгээр л сураагүй алга болж шуугиан

дэгдээсэн шүүх хурал дээр хнийсэн хэргээ хүлээсэн олонх хүнийг цаазаар авсан байв. Хувь заяа нь ийм эмнэнэлтэйгээр төгсгөл болсон хүмүүсийн дотор Жоунз, Аронсон, Резерфорд гурав байсан. Тэр гурвыг 1965 онд баривчилсан бөгөөд ийм юм болдгоороо болж тэд нар жил, жил гаруйн хугацаанд сураггүй алга болж амьд эсэхийг нь хэн ч мэдэхгүй байснаа гэнэт нөгөө гурав хийсэн хэрэг гэгчээ гэнэт хүлээсэн юм. Тэр гурав дайсны талын тагнуул байсан (тэр үед Евразын Гүрэн дайсан байв), улсын хөрөнгийг шамшигдуулсан, Намын үнэнч хэд хэдэн гишүүний амь насыг хороосон, Хувьсгал эхлэхээс бүр олон жилийн өмнөөс Их Ахын удирдлагын эсрэг хуйвалдаан зохион байгуулж байсан болон хэдэн зуун мянган хүний амь насыг хөнөөсөн хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулсан зэрэг гэмт хэрэг үйлдсэнээ хүлээжээ. Тэр гурвыг хэргээ хүлээснийх нь дараа цагаатгаж, намын гишүүнчлэлийг нь сэргээгээд чухал ач холбогдолтой мэт өндөр цалинтай албан тушаалд томилон ажиллуулжээ. Тэд *Таймс* сонинд урван тэрсэлсэн шалтгаанаа

тайлбарлаж нүглээ наминчилсан том өгүүлэл нийтлүүлж билээ.

Смит тэднийг чөлөөлөгдсөнийх нь дараа «Туулайн бөөр мод» кафед үнэхээр харсан билээ. Смит тэр гурвыг нүднийхээ булангаар ихэд гайхан харж байсан. Тэд нар Смитээс хамаагүй ах, өмнөх дэлхийн үлдэц, Намын баатарлаг үеэс үлдсэн том зүтгэлтнүүд байв. Тэр гурав далд тэмцэл, иргэний дайны сэтгэл татсан увьдастай байлаа. Смитэд хэдийгээр он жил, бодит үйл явдал мартагдсан ч гэсэн тэр гурвын нэрийг Их Ахаас хэдэн жилийн өмнө дуулсан юм шиг санагдана. Гэхдээ тэд бол нэг, хоёр жил дотор алга болох тавилантай хууль ёсны бус хүмүүс мөн. Сэтгэхүйн Цагдаагийн гарт ганц удаа ч гэсэн орсон хүнд аврал байдаггүй. Тийм хүмүүс бол оршуулгын газар хэдийд явуулахыг хүлээж буй хүүр юм.

Хажуугийн ширээнүүдийн ард нэг ч хүн алга. Ийм хүмүүстэй ойр байж харагдах нь боддогогүй хэрэг мөн. Тэд нар энэ кафены

онцгой ундаа болох лишийн амт оруулсан жин  
архийг дуугүй шимж сууна. Энэ гурваас  
Резерфорд Смитэд хамгийн их сэтгэгдэл  
төрүүлнэ. Резерфорд бол Хувьсгалаас өмнө  
болон Хувьсгалын үеэр хурц шог зургаараа олон  
нийтийн үзэл бодолд нөлөөлж чадсан алдартай  
шог зураач юм. Одоо ч гэсэн хэсэг хугацаа  
завсарласны дараагаар түүний зурсан шог зураг  
хааяа *Таймс* сонинд гардаг. Одоо түүний шог  
зураг урьдах хэв маягаа дуурайсан төдий, итгэл  
үл төрүүлсэн, гайхмаар үхмэл болсон байна.  
Хуучин сэдвээ хий хоосон давтана. ядуусын  
оромж, овоохой, нүцгэн хүүхдүүд, гудамжинд  
болж буй тулалдаан, бортого малгайтай  
хөрөнгөтнүүд, тэд гудамжны хамгаалалт дээр  
хүртэл бортого малгайнаасаа салдаггүй юм шиг,  
өнгөрсөн уедээ эргэж очих гэсэн үргэлжийн  
найдвар багатай оролдлого юм. Тэрээр эв  
хавгүй, том биетэй, ширэлдсэн цагаан үстэй,  
үрчлээ суусан хавдартай нүүртэй, зузаан  
уруултай нэгэн аж. Тэрээр хэзээ нэгэн цагт их  
хүч чадалтай хүн байсан байх ёстой. Харин  
одоо бол түүний аврага том бие нь энд тэндээ

хавдартай, булуу ургачихсан, арьс нь унжчихсан байна. Тэрээр нурж байгаа элсэн толгой шиг харагдана.

Хөл хөдөлгөөн багатай арван таван цаг болж байв. Смит яагаад ийм үед кафед ирснээ санахгүй байна. Энд бараг хүн алга, теледэлгэцнээс хөгжим сонсогдоно. Нөгөө гурав үг дуугаралгүй чимээгүй суусаар байна. Хоол зөөгч тэдний захиалгыг хүлээлгүйгээр хүн бүрт нэг нэг шилэн аяга жин авчирч тавилаа. Ширээн дээр өрөөстэй шатар байх боловч хэн нь ч тоглосонгүй. Тэгтэл хэдэн хоромд теледэлгэцэнд ямар нэг юм боллоо. Хөгжмийн эгшиг ч, хөгжмийн өнгө аяс ч өөрчлөгдлөө. Хөгжмийн дундуур огт өөр... тайлбарлахад хэцүү нэг юм орж ирлээ. Энэ нь нэг жигтэй, тасалдсан, чарлаа, дооглон элэглэсэн өнгө аястай дуу гарлаа. Смит үүнийг дотроо шар ая гэж нэрлэсэн юм. Тэгснээ теледэлгэцнээс дуу дуулах нь сонсогдоо.

*Гэгээн цагаан өдөр*

*Туулайн бөөрний навчис дор*

*Би чамайг, чи намайг худалдсан*

*Гэгээн цагаан өдөр*

*Туулайн бөөрний навчис дор*

*Чи бид хоёр хэвтэнэ*

Нөгөө гурав маань хөдөлсөн ч үгүй. Смит Резерфордын бэртсэн нүүр рүү ахиулаад хартал нүднээс нь нулимс тусалж байлаа. Смитийн дотор нь зарсхийн юунаас болж дотор нь зарсхийж буйг үл мэдэн дөнгөж одоо л Аронсон, Резерфордын аль алиных нь хамрыг цөм цохьчихсоныг олж харлаа.

Хэдхэн хоногийн дараа тэр гурвыг дахиад л баривчилсан юм. Шоронгоос дөнгөж суллагдмагц тэр гурав шинэ хуйвалдаанд оролцсон нь илэрсэн аж. Хоёрдахь шүүх хуралдааны үеэр тэд урьд өмнө үйлдсэн гэмт

хэрэг болон өөр олон гэмт хэрэг үйлдсэнээ улайсан аж. Тэднийг цаазаар авч хойч үеийнхэнд нь сургамж болгон Намын түүхэнд үүрд тэмдэглэж оруулсан юм. Энэ бүх үйл явдлаас таван жилийн дараа 1973 онд Смит хийн шахуурган хоолойгоор гаргаж хаясан ороолттой цаасыг задалж байгаад завсарт нь байсан сонины тасархайг олж билээ. Тэрээр ширээн дээрээ сонины тасархайг задалж үзэж байхдаа энэ нь ямар чухал зүйл болохыг дорхноо ухаарсан. Тэр нь ойролцоогоор арван жилийн өмнөд: *Таймс* сонины тасархай, сонины дээд хэсгийн тасархай байсан болохоор он сар өдөр нь харагдаж байсан бөгөөд Нью Йорк хотноо болсон Намын ямар нэг баяр ёслолд оролцогсдын зураг тэнд байна. Тэдгээр хүмүүсийн гол дунд Жоунз, Аронсон, Резерфорд гурав тод харагдаж байв. Тэднийг таньж ядах юмгүй байсны зэрэгцээ фото зургийн доод талд гарын үсэг нь ч байсан. Шүүхийн хоёр хуралдааны үеэр энэ гурав гурвуулаа тэр өдөр Евразийн Гүрний нутаг дэвсгэрт байсан гэсэн мэдүүлэг өгсөн юм.

Канадад байрладаг онгоцны бууддаас тэднийг Евразийн Гүрний цэргийн жанжин штабын ажилтнуудтай уулзуулахаар Сибирт хаа нэг газар аваачсан ба тэнд цэргийн маш чухал нууц мэдээллийг дайсны талд задалсан байна. Энэ явдал зуны дунд сард болсон тул Смитийн ой тойнд хадгалагдаж үлдсэн юм. Гэхдээ энэ хэргийг олон баримт бичигт бичиж үлдээсэн байх ёстой. Үүнээс цорын ганц дүгнэлт хийж болно. Гэмээ хүлээж улайсан гэдэг нь худдаа байх нь.

Энэхүү үйл явдал ерөөсөө шинэ нээлт биш ээ. Смит тэр үед ч гэсэн их цэвэрлэгээний үеэр устгагдсан хүмүүс үнэн хэрэг дээрээ гэмт этгээдүүд гэдэгт огтхон ч итгэхгүй байсан юм. Харин энэ бол маш тодорхой нотолгоо мөн. Энэ нь геологийн онолыг буддиантуулдаг газрын давхрагын буруу үед олдсон чулуужсан яс шиг үгүй болгочихсон өнгөрсөн үеийн нэгээхэн хэсэг мөн. Энэ баримтыг олон нийтэд хүргэж ач холбогдпыг нь тайлбарлан таниулж болдогсон бол зөвхөн энэ л Намыг бут ниргэх болно.



Смит шууд л ажилдаа оржээ. Тэрээр фото зургийг харангуут л ямар учир шалтгаантай болохыг нь ойлгоод дээр нь хуудас цаас тавьж далддав. Тэрээр зургийг заддахад аз таарч тэр нь теледэлгэц рүү уруугаа харсан байж таарсан юм.

Тэрээр тэмдэглэл хийдэг цаасаа өвдөг дээрээ тавьж сандлаа теледэлгэцээс аль болохоор холдууллаа. Хичээх юм бол юу ч болоогүй царай гаргаж, амьсгаагаа тогтуун авч ч болно. Харин теледэлгэц тун мэдрэмтгий эд тул юуг ч мэдэрч болох тул зүрхнийхээ цохилтыг яах ч арга үгүй юм. Тэрээр ихэд айж эмээн арван минут хэртэй хүлээж суухдаа ямар нэг тохиолддын зүйл, жишээлбэл нэвт салхи цаасыг нь хийсгээд сүйд хийчих вэ гэж ч айж байлаа. Тэгээд фото зургаа заддалгүй хэрэггүй цаасны хамт ой тойны нүх рүү хийчихлээ. Тэр зураг хэдэн минутын дотор үнс болон шатчих нь лав юм.

Энэ бол арав, арван нэгэн жилийн өмнө болсон явдал. Өнөөдөр бол тэрээр фото зургийг хадгалах байсан. Хачин жигтэй нь. фото зураг түүнд тусгагдсан баримт нь зөвхөн дурсамж боловч түүнийг гартаа барьж байсан гэдэг нь одоо хүртэл онцгой сэтгэгдэл төрүүлсээр байдаг юм. Нэгэнт байхгүй болчихсон жижигхэн нотолгоо хэзээ нэг цагт байсан гэдгээс шалтгаалан өнгөрсөн үеийг захирах Намын эрх мэдэл үнэхээр суларлаа гэж үү? гэж Смит өөрөөсөө асууж байна.

Өнөөдөр фото зургийг ямар нэг аргаар үнс дотроос гарган сэргээж болдог юм аа гэхэд тэр нь нотолгоо болохгүй ч байж мэдэх юм. Смитийг тэрхүү зургийг үзэх үед Далайн Гүрэн Евразийн Гүрэнтэй аль хэдийнээ дайтахаа зогсчихсон байсан ба нөгөө талийгаач гурав маань эх орноо Дорнодазийн Гүрэнд худалдах байсан юм. Тэр цагаас хойш үйл явдлын эргэлтүүд нэг, хоёр, гурван удаа хичнээн ч удаа гарлаа даа гэдгийг Смит санахгүй байна. Талийгаач нарын мэдүүлгийг дахин, дахин

зохиож байсан нь лав болохоор анхны бодит байдал, хугацаа ямар ч ач холбогдолгүй юм. Өнгөрсөн үе зүгээр л өөрчлөгдөөгүй, өнгөрсөн үе тасралтгүй өөрчлөгдөж байна. Энэхүү асар их луйвар *ямар зорилготой юм бэ* гэдгийг тэрээр ерөөсөө ойлгодоггүй нь айдас төрүүлдэг. Өнгөрсөн үеийг хуурамчаар үйлдсэнээс олж буй цаг зуурын ашиг бол тодорхой, харин туйлын зорилго нь оньсого юм. Тэрээр үзгээ аваад дахиад л бичлээ.

*Би ЯАЖ гэдгийг нь ойлгож байна. ЯАХ гэдгийг нь ойлгохгүй байна*

Тэрээр би өөрөө солиорчихсон юм биш байгаа гэж нэг бус удаа боддогоширч байсан шигээ боддогоширч сууна. Гав ганцаараа цөөнх болохоор л солиотой байж ч болох юм. Манай дэлхий нарыг тойрч эргэлдэнэ гэж бодох юм бол солнорол гэж үздэг цаг үе ч байсан, өнөөдөр өнгөрсөн үеийг өөрчилж болохгүй гэж бодох юм бол бас л солиорол юм. Тэрээр магадгүй *ганцаараа* үүнд итгэдэг байж болох юм, нэгэнт

л ганцаараа болохоор солиотой л байж таарна. Гэхдээ би солиотой хүн гэж бодоход санаа нь нэг их зовдоггүй юм. харин өөрөө ч буруутай байвал яана гэж бодоход айдас төрдөг юм.

Тэрээр сургуулийн хүүхдийн түүхийн номыг авч сурах бичгийн нүүрний хуудас дүүрэн Их Ахын зургийг харлаа. Зурагнаас ховстой харц түүний нүдэнд тусаж асар их хүчтэй юм дээрээс чинь дараад, гавлыг чинь нэвтрэн орж тархийг чинь цөм цохиж, итгэл үнэмшлээ алдтал чинь сүнсийг чинь зайлуулж, мэдрэх эрхтэндээ ч итгэл алдрах болгож байх шиг боллоо. Эцсийн бөлөгт Нам хоёр хоёрын тав гэж мэдэгдэхэд итгэхээс өөр арга байхгүй болно. Эрт орой хэзээ нэгэн цагт Нам ийм зарлиг гаргана. Намын байр суурьт ийм логик хэрэгтэй. Намын философи нь дадал туршлагадаа итгэх итгэлийг угүйсгээд зогсохгүй гаднах бодит байддыг ч үгүйсгэдэг юм. Тэрс үзлийн тэрс үзэл бол эрүүл ухаан. Чамайг өөр үзэл бодолтой байна гээд устгахад бус тэдний зөв байгаа болохоор чамайг устгана гэж бодоход л айдас төрж байгаа юм. Бид хоёр

хоёрын дөрөв гэдгийг үнэцдээ яаж мэдэж байгаа юм бэ? Аль эсюл татах хүч байна гэдгийг? Өнгөрсөн үе, гаднах ертөнц оюун ухаанд л оршиж байдаг, тэгээд оюун ухааныг жолоодож болдог юм бол, юу болж байна вэ?

Үгүй шүү! Тэрээр гэв гэнэт эр зоригийн хүч орох шиг боллоо. Обрайены дүр төрх оюун ухаанд нь яагаад орж ирсэн нь ойлгомжгүй байна. Тэрээр Обрайн өөрийнх нь талд байна гэдгийг улам сайн мэдэж байна. Тэрээр өдрийн тэмдэглэлээ Обрайенд зориулж, Обрайенд бичиж байна, Энэхүү эцэс төгсгөлгүй захидал шиг тэмдэглэлийг хэн ч хэзээ ч уншихгүй, гэхдээ энэ захиддыг нэгэн тодорхой хүнд зориулж бичсэн бөгөөд тийм ч агуулгатай юм.

Нам нүдээр үзсэн чихээр сонссон юмандаа бүү итгэ гэж сургаж байна. Намын төгс, хамгийн гол даалгавар нь энэ юм. Өөрийнх нь эсрэг ямар аутаа их хүч бөөгнөрч байна вэ, маргаан гарахад Намын жирийн нэг үзэл суртлын ажилтан үгүйсгэх нь байтугай ойлгоход ч бэрх бачтай

нотолгоо гаргаж, үзэл боддыг минь бут цохих бол гэж бодоход сүнс зайлмаар санагдана. Гэлээ ч гэсэн өөрийнх нь зөв! Тэдний буруу, өөрийнх нь зөв. Ил тодорхой, бодоод байх юмгүй үнэнийг хамгаалах ёстой. Мэдээжийн юм бол үнэн, үүнийгээ баримтал! Дэлхий бат бэх оршиж байна, түүний хууль хувиршгүй юм. Чулуу хатуу, ус нойтон, тулгуургүй юм дэлхийн төв рүү унана. Тэрээр үүнийгээ Обрайенд бичиж байна гэдэгтээ итгэчихсэн нэгэн чухал илт үнэнийг дэвшүүлж бичлээ.

*Эрх чөлөө бол хоёр хоёрын дөрөв гэж хэлж болохыг хэлнэ. Үүнийг зөвшөөрөх юм бол бусад бүх юм үүнээс үүснэ.*

Нэвтрэх замын хаа нэг доороос хуурч буй кофе, Ялалт кофены бус жинхэнэ кофены үнэр гудамжаар нэг гарч байна. Смит өөрөө мэдэлгүй зог тусаад хэдхэн хоромд бараг мартчихсан хүүхэд насандаа эргэж очлоо. Хаалга чанга савах чимээ гарч дуу чимээ таслаж байгаа юм шиг үнэрийг тасаллаа.

Смит гудамжаар хэдэн километр алхахад хөлийн судасны шарх лугшин өвдөж байв. Тэрээр сүүлийн хорь гаруй хоногт Олон нийтийн Төвд болдог үдэшлэгийг хоёрдахь удаагаа тасалжээ. Төвийн арга хэмжээнд оролцогсдыг бүртгэдэг нь лав тул энэ нь хуумгай явдал байв. Зарчмын хувьд Намын гишүүнд ерөөсөө чөлөөтэй цаг байдаггүй ба унтахаар хэвтэхээс өөрөөр ганцаараа байх үе байхгүй. Хүн ажиллах, хооллох, унтах зэргээс бусад үед олон нийтийн зохион байгуулаиттай ажилд оролцож байх ёстой гэж үздэг юм. Ганцаараа байх гэсэн аливаа хандлага, тэр ч байтугай салхинд ганцаараа гарах нь ч сэжиг төрүүлдэг. Шинхэлд хувиа бодож довоо шарлуулах, этгээд амьдралтай гэснийг илэрхийлэх өөрөөтьдрах гэсэн үг бий. Харин тэрээр өнөөдөр Яамнаасаа гарч явахдаа дөрөвдүгээр сарын зөөлөн бүлээн салхинд толгой нь эргэж байлаа. Тэрээр сүүлийн гурван жилд тэнгэр ийм гүн цэнхэр байхыг үзээгүй болохоор Олон нийтийн Төвийн сунжирсан шуугиантай үдэшлэг, уйтгартай ядаргаатай

тоглоом, лекц яриа, жин ууж жаахан биеэ халаачихсан хүмүүсийн шуугилдаан, энэ бүхэнд үнэн голоосоо дургүй хүрч байлаа. Тэрээр гэнэт сэтгэл нь хөдлөөд автобусны буудлаас буруу тийшээ эргэж Лондоны сүлжилдсэн гудамжаар эхлээд урагшаа дараа нь зүүн тийш, хойт тал руу эргэн алхаж үл мэдэх гудамжинд заримдаа төөрч харсан зүг рүүгээ алхаж байв.

“Найдвар байдаг л бол тэр нь үгээгүйчүүдэд л байна” гэж тэрээр өдрийн тэмдэглэлдээ бичсэн билээ. Ид шидтэй үнэн, илэрхий утга учиргүй зүйл болох эдгээр үгс үе үе санагдаж байлаа. Смит Гэгээн Панкрасын төмөр замын буудаг байсан газраас зүүн хойхон нь ядуучуудын үзэмжгүй оромжууд дунд явж байна. Тэрээр хонх ёнх болж үүгээр харх гүйлддэг болов уу гэсэн бодол төрүүлмээр хаалга нь явган зам руу шууд гарсан жижигхэн хоёр давхар байшинтай бул чулуулсан гудамжаар алхаж явлаа. Бул чулуулсан гудамжинд хаа хаагүй шавар шавхай дайралдана. Байшингийн орц, завсар зайгаар олон хүн хөлхөлдөх нь сонин, уруулаа их будсан



бие гүйцсэн охид, араас нь хөөцөлдсөн залуус, арван жилийн дараа охид ийм л болно доо гэж санагдуулсан булчинлаг хүүхнүүд, хөлөө чирсэн бөгтөр авгай нар, эхээ дуудахаар тал тал тийшээ задран гүйж буй шалбааганд тоглож буй хөл нүцгэн хүүхдүүд байна. Байшингийн цонхны ихэнхийн шилийг хага цохичихсон, модон самбараар хадаж бөглөсөн харагдана. Смитийг бараг анзаарахгүй мэт боловч хаа нэг хүн айж эмээсэн, сонирхсон харцаар үднэ. Байшингийн үүдний дэргэд хоёр бүдүүн эмэгтэй ярилцаж зогсох бөгөөд Смит дэргэдүүр нь өнгөрөхөд ярианых нь хагас хугас чихэнд сонсогдлоо.

- "Тийм ээ, энэ бүхэн их сайн байна гэж байна шүү дээ. Чи миний оронд байсан бол бас л тэгэх байсан шүү дээ. Хэлэхэд ч амархан л даа, чамд ийм юм тохиолдоогүй л байхгүй юу "

- "Тийм ээ, Тийм л байхгүй юу даа" гэж нөгөөх нь хэлэв.

Тэр хоёр гэнэт ярихаа болиод Смитийг хажуугаар нь өнгөрөхөд араас нь даган хүйтнээр харж байлаа. Хажуугаар үл мэдэх амьтан өнгөрч байгаа юм шиг хүйтэн гэхэд ч хаашаа юм бэ, болгоомжилсон харцаар Смитийг үдэж байлаа. Энэ хавиар Намын дүрэмт хөх баадай цөөхөн үзэгддэг юм. Эргүүлтэй мөргөлдөх юм бол саатуулагдна. «Нөхөөр, баримт бичгээ гарга. Та энд юу хийж яваа юм бэ? Та хэдийд ажлаасаа гарсан бэ? Та гэр рүүгээ дандаа энэ гудамжаар явдаг уу?» гэхчилэн байцаана. Өөр гудамжаар гэртээ харихыг хориглодоггүй. Гэхдээ ийм үйлдэл нь Сэтгэхүйн Цагдаагийн анхаарлыг яриангүй татна.

Гэв гэнэт бүх гудамж хөл хөдөлгөөнд орж энд тэндээс хүмүүс хашгиралдан байшин руугаа туулай зугтаж байгаа юм шиг хар хурдаараа гүйлдэн орж байв. Смитийн өмнөхөн нь нэгэн залуу бүсгүй үсрэн гарч ирээд шавхай дотор тоглож байсан жаахан охиноо шүүрэн авч тэврээд хормогчоороо нүүрийг нь ороогоод байшин руугаа гүйж оров. Энэхэн хоромд

гудамжны мухраас гармонь хөгжнм санагдуулмаар хар костюмтай нэгэн эр гарч ирэн Смитэд ойртоод тэнгэр рүү зааж сандран хашгирлаа.

“Уурын тэрэг! Дарга минь болгоомжтой бай! Толгой дээр чинь бууна! Хурдан хэвтээрэй!”

Үгээгүйчүүд яагаад ч юм бэ, пуужингийн бөмбөгийг “Уурын тэрэг” гэж нэрлэдэг юм. Смит доошоо харж газар унав. Ийм үед үгээгүйчүүд бараг алддаггүй юм. Пуужин дууны хурдаас ч хурдан нисдэг гэж үздэг ч гэсэн үгээгүйчүүд пуужин унахыг хэдхэн хормын өмнө зөнгөөрөө мэддэг юм. Смит гараараа толгойгоо халхлав. Гудамж доргиулсан их чимээ гарч нуруун дээр нь баахан шажигнасан юм асгарлаа. Смит өндийж босоод хажуугийн байшингийн цонхны шилний хагархай унасныг харлаа.

Тэрээр гудамжаар цааш алхахад гудамжны дээд талд 200 метрийн цаана хэд хэдэн байшинг

дэлбэлэлтээр газартай тэгшитгэсэн харагдав. Тэндээс бөөн хар утаа дэгдээд эвдэрхий байшингуудын дээгүүр тоос хуйлралдаж байна. Түүний өмнөхөн явган хүний зам дээр бөөн шавар шохой унасан байх бөгөөд дотроос нь час улаан юм цухуйж байна. Смит босоод хартал тэр нь хүний царвуу байх бөгөөд цустай хэсгээс бусад нь гибсэн хэв шиг цав цагаан аж.

Тэрээр нөгөөхийг хөлөөрөө гудамжны усны суваг руу өшиглөж хаяад хүмүүсээс нүүр буруулан баруун гар талынхаа хажуугийн гудамжийг урууддаа. Тэрээр дэлбэрэлт болсон газраас хоёр гурван минут холдон явж орсон гудамжинд хүмүүс юу ч болоогүй юм шиг бужигналдаж байна. Хорин цаг болох гэж байх ба үгээгүйчүүдийн архи, шар айрагны мухлагуудад (тэд нар үүнийг “пааб” гэдэг юм) хүн амьтан пиг дүүрэн байна. Мухлагийн савлуур хаалга нэг онгойж, нэг хаагдахад тамхи, шээс, гашуун шар айрагны үнэр ханхлана. Байшингийн буланд гурван эр шавалдан зогсож байна. Дундах эр нь дэлгээстэй сонин барьсан

байх ба нөгөө хоёр нь түүний мөрөн дээгүүр өнгийн харж байна. Смит холоос нүүрийг харж чадахгүй байгаа боловч тэдний байдал нь ямар нэгэн юмыг шуналтай үзэж байгааг илтгэнэ. Тэд ямар нэг чухал мэдээ уншиж байсан нь илт байв. Смитийг хэдхэн алхам ойртож очтол нөгөө гурав бие биеэсээ салж тэдний хоёр нь хоорондоо чанга хэрэлдэж хариугүй зодоон цохиондоо хүрэх дөхөв.

“Миний хэлж байгааг сонс гэж чамд хэлж байна шүү, тэнэг минь. Сүүлийн хоёр жилд долоогоор төгссөн тоогоор хэн ч хожоогүй юм шүү!”

“Би чамд хожсон гэж хэлж байна!”

“Үгүй, хожоогүй! Би сүүлийн хоёр жилийн хожлыг хуулж биччихсэн байгаа, гэрт бий. Би үүнийг мөнгөний нярав шиг бичиж авдаг юм. Би чамд долоогоор төгссөн тоо хэзээ ч”

“Үгүй ээ! Долоогийн тоогоор хожсон шүү! Би энэ муу тоог бараг цээжээр хэлж чадна. Дөрөв

буюу долоогоор дуусч байсан. Хоёрдугаар сард, хоёрдугаар сарын сүүлийн хагаст”

“Хоёрдугаар сард гэнээ, хөгшин нохой чинь! Надад бүх тоо цагаан дээр хараар бичээстэй байгаа. Би чамд долоогоор төгссөн ямарч тоо..”

“За, та хоёр болиоч ээ!” гэж гуравдахь нь хэллээ.

Тэд нар сугалааны тухай ярьж байсан бөгөөд Смит нилээд холдоод эргэн харахад маргалдсан хэвээр л байв. Долоо хоног бүр их шагнал олгодог сугалаа бол үгээгүйчүүд их ач холбогдол өгдөг олон нийтийн цорын ганц үйл явдал юм. Сугалаа нь хэдэн сая үгээгүйчүүдийн хувьд амьд явах цорын ганц биш юмаа гэхэд амьд явах гол утга учир нь болдог байна. Сугалаа нь тэдний баяр бахдал, солиорол, тайвшрал, оюун санааны урамшил нь юм. Сугалаанд уншиж бичиж чадахгүй хүн ч хүртэл маш нарийн тооцоо, онц гойд ой ухаан гаргадаг байна. Сугалааны билетийн худалдаа, тоог таах, азтай хожигчийг мэргэлэх омгийн бүхэл бүтэн

тогтолцоо байдаг байна. Смитэд Сугалаа гаргах ажил хамаагүй боловч тэрээр сугалааны шагналын ихэнх нь хурдаа гэдгийг мэддэг (Намын гишүүн бүр үүнийг мэддэг) юм. Энэ асуудлыг Элбэгийн Яам хариуцдаг. Сугалааны хожлын өчүүхэн хэсгийг том шагнал хожсон гэх огт байхгүй хүнд олгодог юм. Далайн Гүрний дэвсгэр нутгуудын хооронд харилцаа холбоо хэрэг дээрээ байхгүй нөхцөлд ингэж зохион байгуулахад төвөггүй аж.

Найдвар байдаг л бол тэр нь үгээгүйчүүдэд л байна. Энэ санаагаа баримтлах хэрэгтэй. Үүнийг үгээр хэлэхээр зөв юм шиг. Гудамжаар хажуугаар өнгөрч буй хүмүүсийг харахад энэ нь бишрэл болдог юм. Тэрээр доошоо уруудсан гудамжаар алхахад энэ нь нэг л таньдаг газар юм шиг санагдах ба холгүй гол гудамж бий. Өмнө нь хаа нэг газраас хүмүүс шуугилдах чимээ гарна. Гудамж огцом муруйж лангууны худалдаачидтай нарийн гудамжтай нийлэхэд доошоо буусан шат дайралдлаа. Смит гэнэт хаа ирснээ саналаа. Нарийн гудамж гол замд нийлэх

ба хэдхэн алхмын цаана нөгөөх өдрийн тэмдэглэлийн дэвтрээ худалдаж авсан лэнсий мухлаг бий. Мөн холгүй байгаа бичиг хэрэгслийн мухлагаас нөгөөх үзэг, бэхээ худалдаж авсан юм.

Тэрээр шатны орой дээр түр зогслоо. Нарийн гудамжны нөгөө талд цантай юм шиг мөртлөө үнэн хэрэг дээрээ тоос шороонд хав дарагдсан цонхтой жижиг заваан пааб байдаг юм. Бөгтөр нуруутай, өрвийсөн живэр сахалтай, тэнхээлэг, их настай өвгөн шар айрагны паабны хаалгыг татаад дотогшоо орж явчихав. Нас сүүдэр лав наяд гарсан энэ өвгөн хувьсгал гарах үед нас бие гүйцсэн эр байсан байх гэсэн бодол Смитэд төрж байв. Энэ өвгөн, түүний үеийн хэдхэн хүн устаж алга болсон хөрөнгөтний ертөнцөөс үлдсэн сүүлчийн хэлхээ холбоо юм. Хувьсгалаас өмнө үзэл бодол нь төлөвшсөн цөөн хэдхэн хүн Намд бий. Хуучин үеийнхний ихэнхийг тавь, жаран онд болсон их хэлмэгдүүлэлтээр хүйс тэмтэрчихсэн ба амьд үлдсэн цөөхөн хэдэн хүнийг сүнсий нь зайлтал айлган сүрдүүлж үзэл



боддоос нь бүрмөсөн татгалзуулсан юм. Энэ зууны эхэн үеийн нөхцөл байдаын талаар үнэн зөв юм хэлж чадах амьд сэрүүн хүн байдаг л бол тэр нь үгээгүй хүн байж таарна. Смит хүүхдийн түүхийн номноос өдрийн тэмдэглэлдээ хуулж бичсэн зүйлээ санахад өөрт нь нэгэн хачин бодол төрлөө. Би энэ паабанд ороод өвгөнтэй танилцан яриа дэлгээд «Та хүүхэд ахуй цагаа ярина уу? Амьдрал ямар байсан бэ? Одоогийнхоос дээр үү, доор уу?» гэж асууна гэж боддоо.

Тэрээр энэ бодаосоо халшраад буцчихаасаа өмнө очье байз гэж бодоод шатаар доош гүйж буугаад гудамж хурдхан огтолж алхлаа. Мэдээж энэ бол тэнэглэл. Үгээгүйчүүдийн шар айрагны газар орох, тэдэнтэй яриа дэлгэхийг хориглоогүй нь мэдээж хэрэг. Гэхдээ ийм жигтэй үйлдэл анзаарагдахгүй үлдэнэ гэж байхгүй. Эргүүл орж ирэх юм бол бие эвгүйрхээд сууж байна гэж хэлж болно л доо, гэхдээ үүнд бараг итгэхгүй биз дээ. Тэрээр хаалга чанга түлхэн ороход шар айрагны гашуун

үнэр ханхлаад тэнд байгаа хүмүүсийн яриа намдааа. Хүн бүрийн харц түүний хөх баадай дээр тусч байгааг тэрээр мэдэрч байлаа. Дартс шидэж байсан хүмүүс ч түр зогсов. Нөгөөх хэрэг болгож ирсэн өвгөн нь биерхүү, шовгор хамартай, бүдүүн шуутай баарны үйлчлэгч залуу эртэй ямар нэг юм маргалдаж байгаа нь харагдав. Хажууханд нь шилэн аягатай шар айргаа гартаа барьсан хэдэн хүн тэднийг ажиглан зогсоно.

“Чамайг хүн болохоор чинь асууж байна, тийм үү. Чи тэхэд надад архины мухлагт чинь пинтын аяга огт байхгүй гээд байх юм, тийм үү?” гэж өвгөн цээжээ түрэн асуув.

“Энэ нэг пинт гээд байгаа юм нь, юун хогийн юмыг хэлээд байна вэ?” гэж баарын үйлчлэгч гараараа лангуун дээр тулж зогсоод дургүйндээ илэрхийлэв.

“Дуулж байна уу? Баарын үйлчлэгч мөртлөө пинт гэж юуг мэддэггүй гэнэ ээ! Пинт бол хагас

кварт, дөрвөн кварт нэг галлон болдог юм. Чамд цагаан толгой зааж өгөх үү?”

“Энэ насандаа л дуулаагүй юм байна. Литр, хагас литрийн аяга байна, мэдэв үү? Хэмжүүр нь тавиур дээр байна” гэж баарын үйлчлэгч хариу барив.

“Пинтээр л уумаар байна. Пинтээр хийгээд өгөхөд юу нь хэцүү байна вэ? Миний үед чиний тэр литр чинь байгаагүй юм” гэж өвгөн ундууцав.

“Таныг залуу байхад бид бүгд модны мөчир дээр байсан шүү дээ” гэж баарын үйлчлэгч хүмүүс рүү эргэн харснаа хариулав.

Хүмүүс чанга инээлдээд Смитийг орж ирэхэд бий болсон эвгүйрхэл арилах шиг болов. Өвгөний нүүр нь час улайж тэрээр огцом эргээд Смиттэй мөргөлдөхөд тэрээр тохойноос нь аяархан барьж авав.

“Би таныг дайлах уу?” гэж Смит асуув.

“Буянтай хүү байна” гэж тэрээр хэлээд цээжээ дахин түрэхдээ Смитийн хөх баадайг анзаарсангүй. “Пинт шүү! Пинт пиво” гэж тэрээр баарны үйлчлэгч рүү хашгирав. Баарны үйлчлэгч лангууны доорхи саванд хоёр хагас лирийн аяга зайлаад өтгөн хар пиво хийж өглөө. Ийм газруудад пивоноос өөр юу ч байдаггүй бөгөөд жин зарах ёсгүй боловч түүнийг олж ядах юм байдаггүй аж. Хүмүүс дартсаа үргэлжлүүлэн тоглож, лангууны дэргэдэх хүмүүс сугалааны тухай ярьж байлаа. Смитийг түр мартацгаав. Цонхны доор нарсан ширээ байна, тэнд өвгөнтэй хоёулахнаа өөр хүн дуулчихаж магадгүй гэж айх юмгүй ярилцаж болно. Энэ үйлдэл бол их аюултай үйлдэл, юутай ч энд теледэлгэц алга байна, Смит орж ирэхдээ үүнийг баттай харсан юм.

“Надад пинтээ хийгээд өгөхгүй дээ. Хагас литр багадана, амны цангаа гаргахгүй. Литр болохоор ихдэнэ. Морь олон харах болно.

Тэгээд ч бас үнэтэй гэдэг нь ээ” гэж өвгөн үглэнэ.

“Залуугаасаа өнөөг хүртэл та ч олон юм үзээ биз дээ?” гэж Смит яриагаа болгоомжтой эхлэв.

Өвгөн ч тэр олон юмыг энд пивоны газраас олох гэсэн юм шиг зэвхий цэнхэр нүдээрээ дартсын бай руу, лангуу руу, хаалга руу, эрчүүдийн жорлон руу ээлжлэн харлаа.

“Сайн пивотой байсан. Хямд ч байжээ! Намайг залуу байхад зөөлөн пиво, бид пиов гэдэг байсан юм, пинт нь дөрвөн пенс байлаа. Дайны өмнө шүү дээ мэдээжийн хэрэг” гэж өвгөн үг дуугарлаа.

“Аль дайн бэ?” гэж Смит асуув.

“Дандаа л дайн болж байна” гэж өвгөн яагаад ч юм бэ хэлснээ цээжээ түрэн аягатай пивоо өргөөд “Таны өлмий бат орших болтугай!” гэв.

Өвгөний төвөнх нь гүдэлзээд пиво дорхноо хоолойгоор нь орчихов. Смит лангуунаас дахиад хоёр аяга пиво авчрахад өвгөний бүтэн литрийн мухар сүсэг нь апга болчихсон юм шиг байлаа.

"Та бол надаас их настай хүн. Намайг төрөөгүй байхад та лав нас бие гүйцсэн эр хүн байсан байх. Хувьсгалаас өмнө амьдрал ямар байсныг та санаж байна уу. Миний үеийн хүмүүс тэр цаг үеийн талаар үнэндээ юу ч мэддэггүй юм. Энэ тухай номноос л унших юм, тэр нь үнэн ч юм уу, үгүй юү бүү мэд. Танаас л дуулмаар байна. Хувьсгалаас өмнө амьдрал өнөөгийнхөөс огт ондоо байсан гэж түүхийн номонд бичсэн байх юм. Аюумшигт дарлал, мөлжлөг, шудрага бус ёс, ядуурал, гуйланчлал, бидэнд төсөөлөхөд ч бэрх юм байжээ. Манай Лондон хотод гэхэд л маш олон хүн насан туршдаа цадталаа хоол идэж байсангүй. Тэдний тэн хагас нь хөл нүцгэн байжээ. Өдөрт арван хоёр цаг ажилладаг, хүүхдүүд есөн настайдаа сургуулиас гардаг, нэг өрөөнд арваараа унтдаг байжээ. Харин цөөнх

болох хөрөнгөтнүүд гэгч хэдхэн мянган хүн бүх эрх мэдэл, баялгийг эзэмшиж байжээ. Тэд эзэмшиж болох л бүх юмыг эзэмшиж байсан байна. Тэд сайхан байшинд сууж гучин зарц ажиллуулж шампань дарс ууж автомашин, сүйх тэргээр давхилдаж бортого малгай..”

Өвгөн гэв гэнэт сэргээд,

“Бортого малгай! Та яаж үүнийг санав аа? Би яагаад ч юм бэ өчигдөрхөн үүнийг санаж байсан юм. Хичнээн ч жил бортого малгай харсангүй вэ. Бүр үзэгдэхээ больсон эд. Би үеэл эгчийнхээ оршуулганд л сүүлчийн удаа бортого малгай өмссөн юм. Хэзээ билээ, би оны нь хэлж чадахгүй нь, гэхдээ лав л тавь гаруй жилийн өмнө байж таарна. Ийм тохиолдолд хөлсөөр авдаг байсан нь мэдээж шүү дээ” гэж тэрээр ярилаа.

“Бортого малгайдаа гол нь биш ээ. Хамгийн гол нь хөрөнгөтнүүд, тэдний хүчээр амьдарч байсан цөөн хэдэн лам, хуульчид болон бусад нь

дэлхийн эзэд байсан. Энэ хорвоод байгаа бүх юм тэдний гарт байсан. Та нар шиг жирийн ажилчид тэдний боол байсан. Тэд та нарыг яасан ч дурын хэрэг байсан. Та нарыг мал шиг усан онгоцонд ачаад Канад руу явуулж ч болдог байсан. Хүсэх л юм бол та нарын охидтой унтчихна. Та нарыг бүдүүн ташуураар ташуурд гэсэн зарлиг буулгачихна. Та нар тэдэнтэй дайралдахдаа бүрх малгайгаа авдаг байсан. Хөрөнгөтөн бүрт олон зарц байдаг, тэд нь..”

“Зарц гэнэ ээ! Энэ үгийг би хичнээн жил дуулсангүй вэ, тийм ээ? Үнэнээ хэлэхэд залуу нас санагдаж байна. Санаж байна... хэдийд ч билээ дээ.. ,би илтгэгчдийн үг сонсох гэж бүтэн сайн өдөр Гайд Паркад очдог байлаа.

Тэнд очдоггүй хүн гэж байхгүй. Авралын Армийнхан, католик шашинтнууд, жүүдүүд, энэтхэгчүүд... Тэнд нэг эр байх...нэрий нь одоо мартжээ, маш сайхан үг хэлдэг хүн дээ! Тэднийг ч мөн болгож өгнө дөө! Зарц нар гэнэ. Хөрөнгөтнүүдийн гар хөл! Цус сорогчид! арай



хэтрүүлж байгаа биз? Гар хөл бологсод, гар хөл бологсод гэж яг хэлж байсан. Энэ бүхэн лейбористуудыг хэлж буй хэрэг, чи ойлгож байгаа биз дээ?” гэж өвгөн дахин сэргээд хэллээ.

Смит яриа авцалдахгүй байгааг ойлгов.

"Та одоо урьдынхаасаа илүү эрх чөлөөтэй байна гэж бодож байна уу гэдгийг би мэдэх гэсэн юм аа. Танд одоо ипүү хүнлэг хандаж байна уу? Урьд баян хүн, эрх мэдэлтэй хүн.." гэж Смит хэлэв.

“Лордуудын танхим” гэж өвгөн санагалзан хэллээ.

“За тэгвэл Лордын танхимын тухай ярья л даа. Тэд баяндаа юу, ядуудаа юу, таныг яагаад дорд үздэг байсан юм бэ? Та тэд нарыг “Сэр” гэж дууддаг, тэдэнтэй дайралдахдаа малгайгаа авдаг байсан чинь үнэн шүү дээ”

Өвгөн гүн бодолд автах шиг болоод хариулахынхаа өмнө шар айргаа хэд залгилав.

"Тэр ч үнэн л дээ. Бидний малгайгаа өргөх нь тэдэнд таалагддаг байсан. Хүндэтгэл л дээ. Би чамтай санал нийлэхгүй байна, гэхдээ би голдуу л тэгдэг байсан. Тэгэх ёстой байсан гэж чи хэлэх байх л даа"

"Заншил болчихсон зүйл байсан. Би түүхийн номноос уншсанаа л иш татаж байна. Тэд нар, тэдний зарц нар та нарыг гудамжны муу усны суваг руу түлхээд хаячих нь бас жирийн юм байсан уу?"

"Нэг тийм хүн намайг түлхчихсэн явдал бий шүү. Би үүнийг өчигдөр болсон юм шиг санаж байна. Завины уралдааны үдэш байсан юм. Завины уралдааны үдэш тэд нар их үймж шуугидаг юм. Шафсберри-авенюд нэг залууг би дайрчихдаг юм байна. Харахад дажгүй эр, гоёлын костюмтай, бортого малгайтай, хар пальтотой юм. Тэрээр явган замаар гуйвж дайвж

яваад надтай мөргөлдчихсэн юм. «Чи замаа харж явах нь яадаг юм бэ?» гэж байна. «Чи энэ замыг худалдаад авчихсан юм уу?» гэлээ. «Олон юм яриад байвал чинь наад муу толгойг чинь тастна шүү» гэж байна. «Чи согтуу байна. Одоохон чамайг цагдаад өгчих нь шүү» гэлээ. Тэгтэл нөгөөх чинь цээжнээс минь барьж аваад намайг шидчихсэн чинь би арай л автобус доор ойчсонгүй, хачин байгаа биз? Би тэхэд залуу ч байлаа, эргүүлээд цохичихож болох байлаа, гэтэл...

Өвгөний дурсамж гэдэг нь үл ялих юмны цуглуулга гэмээр байсан тул Смит аргаа барлаа. Өвгөнийг өдөржингөө шалгаасан ч олигтой юм дуулахгүй нь. Намын түүх тэхлээр ямар нэг талаар үнэн ч байж болох талтай юм, магадгүй энэ түүх бүр үнэн ч байж болох юм. Смит одоо сүүлчийнхээ оролддогыг хийв.

"Та лав намайг ойлгоогүй байх аа. Миний хэлэх гээд байгаа юм бол энэ л дээ. Та их урт нас насалсан хүн юм, Та насныхаа тэн хагасыг

Хувьсгалын өмнө өнгөрөөжээ. Жншээ нь 1925 онд та эрийн цээнд хүрсэн байжээ. 1925 онд амьдрал өнөөгийнхөөс дээр байсан уу, доор байсан уу, та санаж байна уу, яриач. Танд тэр үед амьдарсан нь дээр үү, өнөө үед амьдарсан нь дээр үү?”

Өвгөн дартсын бай руу боддогодоо автан хараад шар айргаа аажуухан ууж дуусгаад санаа тайвширсан бололтой гүн ухааны хүлцэнгүй байдлаар хариу ярив.

“Чиний юу хүсч байгааг би мэдэж байна аа. Дахиад залуу болмоор байна гэж хэлүүлэх гээ юу? Залуу насанд эрүүл мэнд, хүч чадал гээд бүх юм чамд байна. Өдий хүртэл насалсан над шиг хүний бие үргэлж зовиуртай шүү дээ. Миний хөл зарим үед тэсч байхын аргагүй өвдөнө, шээс хүрэх гэж жигтэйхэн. Шөнө зургаа, долоон удаа гүйхэд хүрнэ. Гэхдээ хөгширөхөд бас баярламаар юм бий. Урьдын санаа зовох юм байхгүй. Хүүхнүүдтэй зууралдах хэрэг байхгүй болно, энэ бол том

зүйл шүү. Би гучин жил хүүхэн хүнд ойртоогүй гэвэл чи итгэх үү? Гол нь дургүй дээ шүү дээ”.

Смит цонхны тавцанг наллаа. Яриаг үргэлжлүүлэх ямарч утга алга. Смит дахиад шар айраг авахаар завдаж байтал өвгөн босоод хажуугийн хананы цаана байгаа өмхий үнэртэй өрөө рүү орлоо. Илүү уусан хагас литр шар айраг үйлчилж эхэлжээ. Смит хоосорсон шилэн аяга руу гөлөрч сууж байгаад яагаад гудамжинд гарснаа санахгүй байв. Тэрээр хорин жилийн дараа их утга агуулгатай мөртлөө энгийн «Хувьсгалаас өмнө амьдрал дээр байсан уу?» гэсэн асуултад өгөх хариу бүрмөсөн байхгүй болох юм байна гэж бодож явлаа. Энэ асуултад одоо ч хэрэг дээрээ хариулт байхгүй. Хуучин ертөнцийн ганц нэг гэрч хоёр эринийг харьцуулан дүгнэх чадваргүй юм. Хамт ажилласадтайгаа хэрүүл хийсэн, унадаг дугуйны насос эрж явсан, аль эрт өөд болсон эгчийн нүүр ямар байсан, далан жилийн өмнөх нэгэн өглөө тоос шороо хуйлран дэгдсэн гэх зэрэг маш олон аар саар юмыг тэд санаж чаддаг

мөртлөө харин үнэн бодит байдал тэдний дурсамжийн гадна үлджээ. Дурсан санах чадвар алдагдаад бичгээр үлдсэн баримтыг хуурамчаар үйлдээд байхлаар хүмүүсийн амьдралыг сайжруулсан гэдэг Намын номлолыг хүлээн зөвшөөрөхөөс өөр арга байхгүй. Үүнийг нягталж шалгах үндсэн баримт мэдээ огт байхгүй ба хэзээ ч бий болохгүй юм.

Смитийн бодол тасалдаж гэнэт зог тусан дээгүүр харлаа. Тэрээр хэд хэдэн мухлаг завсарт нь шахан барьсан сууцны жижиг байшингууд бүхий нарийхан гудамжинд зогсож байлаа. Түүний дээр хэзээ нэгэн цагт алтадсан бололтой өнгөгүй болсон гурван металл бөмбөлөг байна. Тэрээр энэ гудмыг таних шиг боллоо. Тэгэлгүй яахав! Тэрээр өдрийн тэмдэглэлээ худалдаж авсан лэнсий барааны мухлаг өмнө нь байна.

Ном худалдаж авах нь хуумгай үйлдэл байсан бөгөөд тэрээр энд хэзээ ч дахиж ирэхгүй гэж өөртөө ам өгсөн билээ. Айдас бүх биеийг нь эзэмдлээ. Харин бодолдоо жаахан автагдтал

өөрөө ч мэдэлгүй энд хүрээд ирчихсэн байна. Ийм л амь насандаа аюултай тачааддаа дарах байх гэж найдсандаа өдрийн тэмдэглэлээ хөтөлсөн юм. Хорин нэгэн цаг болж байхад мухлаг хараахан хаагдаагүй байгааг тэрээр мөн анзаарлаа. Тэрээр явган зам дээр холхиж байснаас дотогшоо орох юм бол хүний анхаарач татах нь бага юм гэж бодоод мухлагийн хаалгаар орж явчихав. Тэрээр байцаагдах юм бол сахлын хутга авах гэсэн юм гэж хэлнэ.

Мухлагийн эзэн утаатай мөртлөө нэг л аятайхан үнэртэй өлгөөстэй керосин дэнлүү дөнгөж сая асаажээ. Тэрээр жар эргэм настай, тэнхээ муутай, бөгтөр, ялдам царайтай эр байх бөгөөд нүдний зузаан шилний цаанаас дөлгөөхөн нүд нь том юм шиг харагдна. Түүний үс нь цал буурал харин хөмсөг нь өтгөн бөгөөд хар аж. Нүдний шил, ялдам зөөлөн хөдөлгөөн болон хар өнгийн тансар хилэн пиджак нь түүнд сэхээтэн төрх, тэрээр зохиолч, аль эсвэл хөгжимчин байсан болов уу гэсэн бодол төрүүлнэ. Тэрээр сөөчихсөн мэт намуухан дуугаар үгээ хэлэхдээ

ихэнх үгээгүйчүүдийг бодвол арай гайгүй хазгай хэлж байв.

“Би таныг явган замаар явж байхад чинь таньсан шүү. Охидын бэлгийн альбом худалдаж авсан ноён бол та шүү. Ёстой гоё цаас байсан, үнэхээр гоё цаас шүү. Цагаан шаравтар цаас гэдэг юм. Тийм цаасыг үйлдвэрлэхээ болиод, миний бодоход... тавиад жил болж байгаа байх аа. Танд ямар нэг юм хэрэгтэй юу? Зүгээр л юм харж явна уу?” гэж тэрээр нүднийхээ шилний дээгүүр харж хэлэв.

“Энүүгээр явж байсан юм. Ороод гарья гэж л боддоо. Юу ч хэрэггүй” гэж Смит эргэлзэн хариулав.

“Сайн л биз. Таны санаанд таарах юм бараг байхгүй байх аа” гэж тэрээр атгаа дээш нь харуулан хүлцэл өчиж буй мэт хэллээ. “Та харж байгаа биз дээ, хоосон мухлаг л гэсэн үг. Танд л гэж хэлэхэд хуучин эдийн наймаа бараг зогссон доо. Эрэлт бараг алга, худалдах ч юмгүй болж



дээ. Тавилга, шаазан аяга сав, шилэн эддэл бага багаар эвдэрч хэмхэрч дууслаа. Металл эддэлийн ихэнхийг ган хайлуулах үйлдвэрт тушаачихлаа. Би лааны гуулин суурь үзсэнгүй хичнээн ч удав даа”.

Үнэндээ давчуу мухлагт үнэ цэнэгүй элдэв юм пиг дүүрэн аж. Гишгэх ч зай энд алга. Хананы дагуу уран зургийн жааз овоолоостой байна. Үзвэрийн цонхонд хоол зөөх тавиур дүүрэн эрэг шураг, мухар цүүц, хугархай тонгорог, сахлын хутга, аль хэдийнээ явахаа байсан хагархай шилтэй бугуйн цаг болон элдэвийн эрээвэр хураавар юм байна. Өрөөний булангийн жижиг ширээн дээр хэдэн лэнсий эд юм.сонирхол татаж магадгүй хэдэн юм, маажинтай хөөрөг, гартааман энгэрийн зүйлт зэрэг байна. Смитийг ширээ рүү дөхөж очиход нэгэн бөөрөнхий, булцгар дэнлүүний гэрэлд бүдэгхэн гялтганасан юм нүдэнд нь тусахад тэрээр гартаа авч үзэв.

Тэр нь нэг тал нь хавтгай, нөгөө тал нь хагас бөмбөрцөг шиг гүдгэр шил байв. Шилний голд

гүдгэр талаас нь харахад ягаан улаан өнгөтэй сарнай юм уу, дапайн яргуйжин цэцэг лугаа төстэй хээ байна.

“Энэ юу юм бэ?” гэж Смит гайхан асуулаа.

“Шүр шүү. Энэтхэгийн далайгаас авчирсан байж таарна. Шүрийг шилэнд суулгадаг байсан юм. Үүнийг зуу гаруй жштйн өмнө хийсэн байх аа. Зуун жилээс ч өмнө байж магадгүй” гэж өвгөн хариулав.

“Их гоё эд юм аа” гэж Смит хэлэв.

“Их гоё эд шүү” гэж мухлагийн эзэн үнэлэнгүй хариулав. “Одоо ч ийм юм ховордсон доо” гэж тэрээр хоолойгоо засан хэлэв. Та үүнийг худалдаж авмаар байвч дөрвөн долларын үнэтэй. Би иймэрхүү юм найман фунт стерлинг хүрч байсныг санаж байна, би энэ нь одооны мөнгөөр хэд болохыг хэлж мэдэхгүй нь ээ, гэхдээ л энэ чинь их мөнгө байсан шүү. Харин

одоо жинхэнэ хуучны юмыг хэн үнэлэхэв дээ, ховорхон юмыг ч ялгаагүй, тийм ээ?”

Смит дөрвөн доллар тэр дор нь төлөөд нөгөөх шилээ халаасандаа хийв. Энэ бөөрөнхий шил гоё сайхандаа бус харин өнөөгийнхөөс огт өөр эрин үеийн амьсгал төрүүлж байсан нь Смитийн хорхойг хүргэжээ. Тэрээр борооны усны дусал шиг ийм гөлгөр шилийг ер нь үзээгүй аж. Гаднаас нь харахад хэрэгцээгүй энэ шилийг хэзээ нэгтэй цаас даруулагч болгон хэрэглэж байсан бололтой. Одоо ямар ч хэрэггүй болсон нь улам ч хорхой хүргэнэ. Бөөрөнхий шил халаас дарж байгаа ч гэсэн нэг их товойхгүй байлаа. Энэ бол Намын гишүүний нэрийг ч гутааж мэдэх хачин юм байлаа. Бүх л хуучин юм тэх тусмаа гоёмсог юм болгон сэжиг төрүүлдэг. Мухлагийн эзэн дөрвөн доллараа аваад мэдэгдэхүйц урамтай болоход нь, гурав тэр бүү хэл хоёр доллар хүртэл үнэ хаялцаж болох байсныг Смит сая л ухаарлаа.

“Дээр бас нэг өрөө бий. Та үзэж болно шүү. Нэг их юм байхгүй. Цөөн хэдэн юм байгаа. Харин дээшээ гарахад гэрэл л хэрэгтэй” гэж өвгөн хэлэв.

Тэрээр дахин нэг дэнлүү асаагаад элэгдэж гөлийсөн шатаар бөхийн нарийхан шатаар дээш явж Смитийг өрөөнд дагуулж орууллаа. Өрөөний цонх гудамж руу бус арын чулуулсан хашаа, пийшингийн өндөр яндан яралзсан тал руу харжээ. Смит өрөөний тавилгыг хүн суух юм шиг зассаныг анзаараад авав. Шалан дээр нь нарийхан хивс, хананд нь ганц хоёр уран зураг, задгай зуухны өмнө хуучин зөөлөн сандал байна. Задгай зуухны дээрх тавиур дээр арван хоёр цагийн зүүтэй шилэн цаг явж байна. Цонхны дор өрөөний ихэнх зайг эзэлсэн дэвсгэртэй томоос том ор байна.

“Авгайг амьд байхад бид энд суудаг байсан юм. Би тавилгаа ганц нэгээр нь зарж л байна. Энэ уг нь улаан модон гоё ор байгаа юм. Бясаагий нь арилгачих юм бол бүр ч гоё болно. Харин

танд дэндуу том юм шиг харагдаж болох юм” гэж өвгөн уучлал гуйж байгаа юм шиг ярилаа.

Тэрээр өрөөгөө бүхэлд нь гэрэлд харуулах гэж дэнлүүгээ дээш нь өргөхөд дэнлүүний бүдгэвтэр гэрэлд өрөө нь нэг л аятайхан харагдаж байлаа. Долоо хоногт хэдхэн доллараар өрөөг хөлсөлж авахад ядах юм байхгүй юм байна гэсэн бодол Смитэд гэнэт төрлөө. Ийм хачин жигтэй бодол нь цээжинд төрсөн шигээ дорхноо алга боллоо. Мах цусанд нь шингэсэн ямар нэг дурсамж, ямар нэг санагалзлыг энэ өрөө сэргээлээ. Өрөөндөө задгай зуухны хажууд хөлөө торон дээр нь тавьчихсан сууж байхад гал дээрх данхтай ус буцлах, цагийн зүү чаг чаг цохихоос чамд саад болох дуу гарахгүй, хэн ч чамайг мөрдөж мөшгихгүй, чи гав ганцаараа амар тайван байдгийг тэрээр сайн мэдэх юм шиг санагдаж байлаа.

“Энд теледэлгэц байхгүй юм аа” гэж тэрээр дуу алдав.

"Тэр үү? Надад ерөөсөө байдаггүй юм. Үнэтэй эд шүү дээ. За тэгээд ч надад хэрэггүй эд дээ. Тэр буланд дажгүй эвхдэг ширээ байгаа. Харин хэрэглэх болбол дэгээг нь солих хэрэгтэй болно доо" гэж өвгөн хариулав.

Өрөөний бас нэг буланд Смитийн анхаарлыг аль хэдийний татсан номын тавиур байна. Дээр нь хэнд ч хэрэггүй хэдэн ном байна. Номыг хайж олоод шатааж устгах ажил хаа хаагүй явагддагийн нэгэн адил үгээгүйчүүдийн дүүрэгт ч энэ ажил явагдсан. Далайн гүрэн даяар 1960 оноос өмнө хэвлэгдсэн аль нэг номын ганц хувь ч бараг олдохоо байсан юм. Өвгөн гартаа дэнлүүгээ барьчихсан, зандан жаазтай зурагны өмнө зогсож байна. Зураг орны эсрэг талд өлгөөстэй аж.

"Ингэхэд танд хуучны сийлбэр зураг хэрэггүй биз?" гэж өвгөн ая дантай асуув.

Смит ойртож очоод харлаа. Ган дээр хийсэн сийлбэр аж. Дөрвөлжин цонхтой, урд талдаа

жижигхэн цамхаг бүхий зууван байшингийн сийлбэр байна. Байшингийн гадуур хайс байх ба цаад захад нь ямар нэг баримал байсан бололтой юм. Смит сайн ажиглалал энэ байшин нэг л танил санагдавч баримлыг нь санахгүй байв.

“Жааз нь хананд хадаастай юм. Би аваад өгч болно шүү” гэж өвгөн хэллээ.

“Би энэ байшинг мэднэ. Нураачихсан шүү дээ. Гудамжны дунд Шүүхийн ордны ар талд байгаа” гэж Смит үг дуугарав.

"Тийм ээ. Шүүхийн ордны цаана байгаа. Бөмбөгдчихсөн... Олон жилийн өмнө дөө. Энэ чинь сүм байсан юм. Сент-Клемент, даниуд Гэгээн Клемент гэдэг юм” гэж тэрээр дэмий юм ярьчихсанаа мэдсэн юм шиг инээмсэглээд «Гэгээн Клементийн хонх амтат зүрж, нимбэг гэж дуудна» гэж тэрээр нэмж хэлэв.

“Наадах чинь юу билээ?” гэж Смит асуув.

“Гэгээн Клементийн хонх амтат зүрж, нимбэг гэж дуудна”. Намайг жаахан хүүхэд байхад ийм дуу байсан юм. Би цаадахыг нь мартсан байна, харин яаж төгсдөгийг нь санаж байна. “Унтахад чинь асаах лаа энэ байна. Толгойг чинь тас цавчих мэс энэ байна”. Бүжиглэж тоглодог байсан юм. Хүүхдүүд гар гараасаа барин өргөөд чамд дөхөж очоод гар доогуураа чамайг гарахад “Толгойг чинь тас цавчих мэс байна” гээд гараа буулгаж чамайг барьж авна. Сүмүүдийн нэр л байдаг байсан. Лондоны бүх сүмийн нэр, гол сүмүүдийн нэр байдагсан”.

Смит сүмүүд аль зуунд байлаа гэж бүдэгхэн бодож байлаа. Лондоны аль нэг байшингийн насыг тогтооход ер нь хэцүү. Аливаа том, сүрлэг бөгөөд өнгө төрх нь гайгүй л байшин байвал Хувьсгалаас хойш барьсан гэж нотолдог ба яриангүй хуучин байшин л байх юм бол эрт урьдын нэгэн үл мэдэх цаг үеийн буюу Лундад Зуун хэмээх цаг үеийнх гэдэг юм. Капитализмын эрин үед үнэ цэнэтэй юу ч бий болгоогүй гэж үздэг. Түүхийг номноос сурч



болохгүйтэй адил уран барилгаас ч сурах боломжгүй юм. Баримал, сийлж бичсэн дурсгалын бичлэг, хөшөө дурсгал, гудамжны нэр, өмнөх цаг үеийг санагдуулж болох юм болгоныг зориуд арилгаж устгачихсан билээ.

“Би үүнийг сүм байсан гэдгийг мэдэхгүй юм” гэж тэрээр хэллээ.

“Ер нь бол ийм байшин их үлдсэн л дээ. Гэхдээ одоо эдгээрийг өөр зорилгоор ашиглаж байгаа л даа. За саналаа! Энэ шүлэг ямар байна!”

*“Тэгээн Клетенийн хонх амтат зүрж, нимбэг өг гэж дуудна*

*Гэгээн Мартины хонх фартинг өг гэж дуудна!”*

За бас цаадахыг нь мартжээ. Фартинг гэдэг нь цент шиг задгай зэс мөнгө байсан юм.

“Тэгээн Мартины сүм хаана байна вэ?” гэж Смит асуув.

“Гэгээн Мартин уу? Одоо байгаа. Ялалтын талбай дээр уран зургийн үзэсгэлэнгийн дэргэд байгаа. Үүдэндээ асартай, баганатай, өргөн шаттай байшин шүү дээ”.

“«Тал дахь Гэгээн Мартин» нэртэй байлаа. Гэхдээ энэ хавьд тал газар байсныг би санахгүй байна” гэж өвгөн хэлэв.

Смит сийлбэрлэсэн зургийг авсангүй. Энэ нь бөөрөнхий шилнээс ч илүү тохиромжгүй эдээс гадна жаазыг нь авахгүй бол гэр рүүгээ авч явах боломжгүй аж. Тэрээр хэдэн мөч саатаад өвгөнтэй үг дэлгэж байхдаа өвгөний нэр нь мухлагийн үүдний хаяг дээр байгаа Уикс биш харин Чаррингтон гэдгийг мэдэж авлаа. Ноён Чаррингтон жаран гурван настай, бэлэвсэрсэн эр бөгөөд энэ мухлагт гучин жил сууж байгаа аж. Мухлагийнхаа хаягийг энэ хугацаанд солих гэж бодсоор ирсэн боловч нэг л завдал болоогүй гэнэ. Смит өвгөнтэй яриа дэлгэж байхад чихэнд нь нөгөөх шүлгийн үг хангинаж байлаа. «Гэгээн

Клементийн хонх амтат зүрж, нимбэг өг гэж дуудна, Гэгээн

Мартины хонх фартинг өг гэж дуудна». Эдгээр мөрийг өөртөө хэлэхэд устаж алга болоод хаа нэг газар үл харагдах, мартагдсан Лондоны хонхнууд дуугарч байгаа юм шиг санагдах нь нэг л сонин. Сүмийн сүүдэгнэсэн гонхонуудаас хонхны дуу бие биеэ дагалдан цуурайтах шиг Смитэд санагдана. Харин тэрээр сүмийн хаан хонхны дууг энэ насандаа ерөөсөө дуулж байгаагүй юм байна гэж бодно.

Смит Чаррингтонд баяртай гэж хэлээд гадагшаа гарахдаа гудамжийг сэрэмжлэн харж байгаагаа өвгөнд харуулахгүй гэж бодоод ганцаараа гарч явлаа. Тэрээр жаахан хүлээгээд, нэг сар орчим ч юм уу болоод мухлагт дахин ирнэ гэж аль хэдийнээ шийджээ. Энэ бол Олон нийтийн Төвийн арга хэмжээг тасалснаас илүү осолтой биш юм. Мухлагийн эзэнд найдаж болох уу, үгүй юү гэдгээ мэдэхгүй байж ном худалдаж

авсныхаа дараа мухлагт дахин ирсэн нь их гэнэн явдал байлаа. Гэсэн мөртлөө...!

Тийм ээ энд ирэх хэрэгтэй байна гэж тэрээр дотроо бодно. Тэрээр даниудын Гэгээн Клемент гэдэг сийлбэрлэсэн зургийг худалдаж аваад жаазнаас нь гаргаж гэртээ аваачина. Ноён Чаррингтоноор шүлгийг нь бүрэн хэлүүлэх болно. Дахиад л дээд өрөөг хөлслөх тухай солиотой бодол төрж байлаа. Тэрээр сэтгэл нь хөөрсөндөө болгоомжтой байхаа тэр дороо мартаад гудамж руу сэрэмжлэн харсан болоод гарч явлаа. Тэр ч байтугай өөрийнхөө дураар амандаа аялж явлаа.

*Гэгээн Клетенцийн хонх амтат зүрж, нимбэг өг гэж дуулна*

*Гэгээн Мартины хонх фартинг өг гэж дуудна!*

Тэрээр хэдхэн алхмын цаана өөдөөсөө ирж яваа хөх баадайтай хүнийг хармагц ар зоо руу нь хүйт оргиод гэдэс нь өвдөх шиг боллоо. Уран

зохиолын газарт ажилладаг хар үстэй залуу бүсгүй мөн байна. Үдшийн бүрүйд ч гэсэн тэрээр түүнийг сайн танилаа. Бүсгүй өөдөөс нь эгцдэн харснаа юу ч мэдээгүй юм шиг хажуугаар нь өнгөрөөд явчихлаа.

Тэрээр хөлгүй юм шиг хэдхэн хором хөдөлж ч чадсангүй. Тэгээд баруун гар тийшээ эргэж буруу явж байгаага ч мэдэлгүй аажимхан сажиллаа. Одоо ямар ч гэсэн бүх юм тодорхой боллоо. Эргэлзэх хэрэг үгүй, бүсгүй түүнийг араас нь мөрдөж явна. Бүсгүй түүнийг мөрдөн мөшгиж байна. Намын гишүүдийн оршин суудаг газраас хэдэн километрийн зайтай хүн цөөхөн явдаг гудамжаар зүгээр явж байна гэхэд итгэх арга үнэхээр байхгүй. Ийм олон юм нэгэн зэрэг болж байна. Бүсгүй Сэтгэхүйн Цагдаагийн туршуул уу, аль эсвэл өөрийнхөө дураар тагнаж явна уу гэдэг нь хамаагүй хэрэг. Бүсгүй намайг мөрдөж явна гэдэг нь хангалттай хэрэг. Шар айргийн паабанд орж байхыг ч харсан байж магадгүй.

Смитэд урагшаа явахад улам бэрх болж халаасан дахь бөөрөнхий шил нь гуя руу нь цохиод байхаар гаргаад хаячихдаг ч юм уу гэж бодож явлаа. Гэдэс базлах нь ихдээд бие засах газар олохгүй бол яадаг юм билээ гэж тэрээр бодож байв. Ийм дүүрэгт нийтийн бие засах газар байхгүй. Тэгсгээд гэдэс нь базлахаа зогсоод жаахан хөндүүрхэн болов.

Смит мухар гудамжинд орсноо мэдээд хэдэн хором яадаг юм билээ гэж бодсоноо эргэж явлаа. Тэрээр эргээд явахдаа нөгөө бүсгүйтэй хэдхэн хормын өмнө дайралдсан болохоор гүйгээд очих юм бол гүйцэх юм байна гэсэн бодол төрнө. Түүнтэй хөл хөдөлгөөн багатай газар уулзаад толгойгий нь чулуугаар хага цохино. Хүнд болохоор бөөрөнхий шил ч хэрэг болно. Гэхдээ энэ бодлоо орхилоо. хүний биед халдана гэж бодохын ч хэрэг байхгүй. Гүйгээд явах ч чадал алга, цохиод авах ч чадал алга. Тэгээд ч тэр бүсгүй залуухан, хүч тамиртай, эсэргүүцэл үзүүлэх болно. Олон нийтийн Төвд очоод хаах хүртэл нь тэнд байж өөрийнхөө үйлдлийг

цагаатгая гэж ч бодлоо. Харин энэ нь боломжгүй зүйл юм. Маш их залхуу хүрч байна. Ганцхан юм л бодогдоно, гэртээ хариад юу ч хийлгүй суух юмсан.

Тэрээр гэртээ хорин гурван цагт л дөнгөж хүрч ирлээ. 23. 30-д цахилгааныг тасалдаг юм. Тэгээд гал тогооныхоо өрөөнд орж нэг хундага «Виктори» хэмээх жин хөнтөрчихлөө. Тэрээр тэгээд хананы онгорхойд байгаа ширээний ард суугаад өдрийн тэмдэглэлээ гаргаж ирсэн ч түүнийгээ нээлгүй жаахан суув. Теледэлгэцнээс нэгэн эмэгтэй чанга дуугаар эх оронч дуу дуулна. Смит теледэлгэцийн дууг сонсохгүй байхыг хичээж өдрийн тэмдэглэлийнхээ хатуу хавтас руу харж сууна.

Тэд харанхуй шөнөөр ирж баривчилдаг. Баривчлахаас өмнө өөрийгөө егүүтгэх нь хамгийн зөв шийдэл юм. Ихэнх хүн ингэсэн байж таарна. Ихэнх хүн сураггүй алга болсон нь үнэн хэрэгтээ амиа егүүтгэсэн явдач байсан юм. Галт зэвсэг ч, сайн хор ч олдохгүй энэ оронд

өөрийгөө егүүтгэхэд аюумшиггүй чин зориг гаргах хэрэгтэй болно. Тэрээр биологийн зовиур, айдас хэрэг болохгүй, онцгой хүч чармайлт гаргах тэрхэн мөчид хүний бие махбодь итгэл алдаж хөшиж царцана даа гэж гайхан бодлоо. Тэрээр шууд л хөдөлсөн бол хар үстэй бүсгүйг үгүй хийж болох байсан, гэхдээ энэ нь тун аюултай зүйл байсан болохоор чадаагүй юм. Хүн туйлдаа хүрэх мөчид гаднах дайсантай бус өөрийнхөө биетэй тэмцдэг юм байна гэсэн бодол түүнд төрнө. Одоо ч гэсэн жин уучихаад байхад гэдэс нь базлаад цэгцтэй бодох зав өгөхгүй байна. Бүхий л эмгэнэлт явдал, баатарлаг үйл хэрэг байгуулах үед ч ийм л байдаг юм байна гэж тэрээр ухаарч байна. Байлдааны талбарт ч, тамлан тарчлаах шоронд ч, живж байгаа усан онгоцонд ч бие махбодь чинь хавдаж хөөхөөр тэмцэж явсан үйл хэрэг дандаа мартагддаг ба айдас төрснөөс болон тэсч чадахгүй өвдсөнөөсөө болж хашгирч ориллоо ч гэсэн бие чинь өлсөх, хөрч даарах, нойр алдах, ходоод, шүд өвдөхтэй зогсолтгүй тэмцдэг юм.



Смит ямар нэг юм бичих хэрэгтэй байсан тул өдрийн тэмдэглэлийнхээ дэвтрийг нээв. Теледэлгэц дээрх эмэгтэй дахиад л чанга дуулж эхлэхэд дуу нь шилний хурц хагархай тархинд шигдэх шиг бөлж байна. Смит өдрийнхөө тэмдэглэлийг зориулж буй, зориулан бичиж буй Обрайены тухай бодохыг оролдсон боловч Сэтгэхүйн Цагдаад намайг баригдахад түүнийг яах бол гэсэн бодол салахгүй байв. Шууд л алчих юм бол ч боллоо л доо. Аиуулна гэдэг бол мэдээж хэрэг ээ. Харин үхэхийн өмнө (энэ тухай хэн ч ярьдаггүй боловч хүн бүр үүнийг мэддэг юм) тогтсон журмын дагуу хэргээ хүлээх гэж нэг юм бий. Өршөөл үзүүлэхийг гуйн цөхрөлөө баран шал дээгүүр мөлхөх, хугарсан үе мөч шажигнах, цус хурсан туг үс унах энэ бүхнийг туулах болно. Төгсгөл нь бүгд адилхан байдаг болохоор энэ бүхнийг туулах хэрэг юу байна вэ? Чиний амь наснаас яагаад хэдэн хоног, хэдэн арван хоног хасаж болдоггүй юм бэ? Хэн ч хэрэг илрүүлэлтээс зайлж чадаагүй, чи өөрийгөө цаазаар авах бичигт гарын үсэг зурсан тэрхэн хоромд л хүн бүр хэргээ хүлээсэн. Юу ч

өөрчилж болохгүй л юм бол чи ирээдүйд ирэх энэ тарчлалыг яах гэж хүлээж байгаа юм бэ?

Смит дахиад л Обрайены дүр төрхийг санах гэж оролдоход түүний дүр төрх нүдэнд нь орж ирлээ. «Та бид хоёр гэрэл гэгээтэй газар уулзах болно» гэж Обраиен хэлсээн. Смит түүний үгийг ойлгосон, ойлгосон шиг санагдаж байна. Гэрэл гэгээтэй газар, ирээдүйн тухай төсөөлөл мөн, чи энэ насандаа түүнийг үзэхгүй, харин ид шидээр төсөөлөн хуваалцаж болно. Теледэлгэцээс гарах дуу Смитийн чихэнд сонсогдоод боддоо үргэлжлүүлж чадахгүй байлаа. Смит янжуураа зуутал тамхи хэлэн дээр нь асгарч наалдаад гашуун нунтаг нь нулимахад төвөгтэй байв. Смитийн оюун ухаанд Обрайены дүр төрхийн оронд Их Ахын дүр төрх орж ирлээ. Тэрээр хэдхэн хоногийн өмнөх шигээ нөгөөх зоосоо гаргаж ирээд үзлээ. Хүйтэн, тайван эцгийн царайгаар өөр рүү нь ширтэж байна. харин хар сахалны цаана ямаршуу инээмсэглэл нуугдана вэ? Оршуулгын хонхны сэтгэлд цэвдэг дуу шиг үгс сонсогдоно.

*ДАЙН БОЛ ЭНХ ТАЙВАН*

*ЭРХ ЧӨЛӨӨ БОЛ БООЛЧЛОЛ*

*ҮЛ МЭДЭХ НЬ ХҮЧ*

# ХОЁРДУГААР ХЭСЭГ

# I

Смит бүхээгнээсээ гарч бие засах газар руу алхахад үд болж байв.

Гэрэлтүүлсэн урт хонгилоор нэгэн хүн ганцаараа өөдөөс нь ирж явсан нь нөгөөх хар үстэй залуухан бүсгүй аж. Тэр бүсгүйтэй лэнсий барааны мухлагийн гадаа үдэш дайралдсанаас хойш дөрвөн хоног өнгөрчээ. Смит түүнд ойртож очихдоо баруун гар нь боолттой байхыг харлаа. Боодол нь хөх баадай шигээ өнгөтэй байсан болохоор холоос ажигласангүй. Бүсгүй романы зохиомжийг «хольж найруулдаг» том шагайврыг эргүүлж байгаад гараа гэмтээсэн байж магадгүй юм. Уран зохиолын газарт ийм осол гарах нь жирийн үзэгдэл.

Тэр хоёрыг дөрвөн метр орчим газар бие биедээ дөхөж явахад бүсгүй бүдэрч нүүрээрээ газар харуулдаж унав. Тэрээр шархтай гараа дарж унасан бололтой, чанга ёолох нь дуулдав. Смит

зог тусан зогсоход бүсгүй өвдөг дээрээ өндийгөөд нүүр нь цайчихсан, уруул нь улам улайгаад Смит рүү өвдсөндөө бус айсан нүдээр гайхан харж байлаа.

Смитийн сэтгэл нэг л хачин байлаа. Түүний өмнө өөрийг нь алахыг оролдсон дайсан байна, түүний өмнө магадгүй яс нь гэмтсэн, өвчиндөө шаналсан хүмүүн байна. Смит зөнгөөрөө түүнд туслахаар урагш ухасхийв. Тэр бүсгүйг боолттой гараа дарж унах хоромд Смитийн өөрийнх нь бие өвдөх шиг болсон юм.

"Та зүгээр биз?" гэж тэрээр асуув.

"Зүгээр, зүгээр. Гар минь, одоохон зүгээр болно"

Бүсгүйн зүрх хүчтэй цохилж байх шиг байх бөгөөд царай нь хувхай цайчихжээ.

"Та бэртчихээгүй биз?"

“Үгүй, дажгүй ээ. Жаахан өвдөж байна, тэхдээ зүгээр ээ”.

Бүсгүй гараа өгөхөд нь Смит татаж босгоход түүний царай нь дээрдээд бие нь сайжрав бололтой.

“Зүгээр ээ. Би бугуйгаа жаахан хөндчих шиг боллоо. Баярлалаа, нөхөр минь”

Бүсгүй ингэж хэлээд явж байсан зүг рүүгээ үнэхээр юу ч болоогүй юм шиг хурдан хурдан алхав. Энэ бүх явдал хэдхэн хором дотор болоод өнгөрлөө. Сэтгэлийнхээ хөдөлгөөнийг нүүрэндээ гаргахгүй байх нь угийн зуршил болчихсон ба энэ явдал болох үед харин тэр хоёр теледэлгэцийн яг өмнө нь байсан аж. Гэлээ ч гэсэн бүсгүйг гараас нь татан босгож байх тэрхэн агшинд Смитийн гарын апганд нэг юм хавчуулахад нь төрсөн цочирдол гайхлаа гаргахгүй байхад их бэрх байсан. Бүсгүй энэ үйлддийг санаатайгаар хийсэн гэдэгт эргэлзэх юм ачга. Тэр юм өчүүхэн жижиг хавтгай юм

байлаа. Тэрээр бие засах газрын хаалгаар орохдоо нөгөөх юмаа халаасандаа хийгээд хурууныхаа үзүүрээр тэмтэрч үзэхэд тэр нь дөрвөлжилж нугалсан цаас байлаа. Ямар нэг юм цаасан дээр бичсэн байх ёстой. Тэрээр жорлонгийн нэг бүхээгт ороод бичгийг уншмаар байв. Гэхдээ ингэх нь тун тэнэг хэрэг гэдгийг тэрээр мэднэ. Теледэлгэц байхгүй гэж итгэлтэй хэлж чадах газар байхгүй.

Смит бүхээгтээ эргэж очоод нөгөөх тасархай цаасаа ширээн дээрх цаасан дунд сэмхэн хийгээд нүдний шилээ зүүж үгбичигчийг өөр рүүгээ ойртууллаа. "Тавхан минут", "Хамгийн багадаа л таван минут!" гэж тэрээр өөртөө хэлж байлаа. Зүрх нь айдас хүргэмээр чанга цохилж байна. Аз болоход хийх ажил нь жирийн л нэг ажил, анхаарап нэг их төвлөрөөд байх ажил биш зөвхөн урт тоо баримтын жагсаалтад засвар хийх ажил байв.

Цаасан дээр юу ч бичсэн байлаа гэсэн ямар нэг улс төрийн агуулгатай байж таарна. Түүний



мэдэж байгаагаар хоёр л хувилбар байна. Нэг нь түүний эмээж байсанчилан бүсгүй Сэтгэхүйн Цагдаагийн агент болох нь бараг лав биз ээ. Сэтгэхүйн Цагдаа ямар учраас ийм маягаар зурвас дамжуулах болсныг Смит мэдэхгүй, гэхдээ ингэх учир шалтгаан байсан нь магад. Цаасан дээрх бичиг нь заналхийлэл, өдөөн хатгалт, амиа егүүтгэх тушаал, ямар нэг урхи байж магадгүй. Харин огт өөр юм ч байж болох бөгөөд тэрээр энэ бодлоо аль болохоор дарах гэж оролдож байлаа. Энэ нь зурвасыг Сэтгэхүйн Цагдаа ерөөсөө ирүүлээгүй, харин ямар нэг нууц байгууллага ирүүлсэн байж мэдэх юм гэсэн бодол байв. Магадгүй Ах дүүгийн Баршцлага эцсийн бөлөгт оршиж байж мэдэх юм! Бүсгүй ч түүний гишүүн байж ч болох юм! Цаасны тасархайг гартаа авмагц л ийм бодол толгойд нь орж ирсэн бөгөөд энэ бол утга учиргүй санаа бодол гэдэгт эргэлзэх юмгүй. Хэдхэн хором өнгөрсний хойно л үүний огт өөр тайлбар бодогдлоо. Одоо болтол зурвас бол үхлийг хэлж байгаа юм гэж оюун санаа нь давтсаар байгаа ч гэсэн тэрээр үүнд итгэхгүй

байсан ба учир шалтгаангүй нэгэн найдвар төрж зүрх нь хүчтэй цохилж үгбичигчид нөгөөх тоонуудаа шивнэн бичүүлэхдээ хоолойгоо чичрүүлэхгүй байхад хэцүү байлаа.

Тэрээр цаасныхаа ажлыг дуусгаад хийн даралттай хоолой руу хаяв. Найман минут өнгөрлөө. Тэр нүдний шилээ засаж санаа алдаад нөгөөх цаасны тасархайгаа дээр нь тавиад дараагийн цаасны ажлаа өөр рүүгээ ойртууллаа. Нөгөөх цаасаа дэлгээд үзтэл дээр нь том галбир муухан үсгээр бичсэн бичээс байлаа:

*Би чамд хайртай*

Тэрээр хэдэн хором мэл гайхаж цэл хөхрөөд нөгөөх хэрэгт уруу татсан зурвасыг ой тойны нух рүү хаяхаа завдсангүй. Зурвасыг хэт сонирхох нь аюултай гэдгийг мэдэж байгаа ч гэсэн үнэхээр тэдгээр үг бичээстэй байна гэдгийг нэг сайн харахын тулд дахин уншихгүй байж чадсангүй.

Үдээс өмнийн туршид түүнд ажил хийхэд их бэрх байлаа. Залхуутай ажилдаа анхаарлаа төвлөрүүлэхээс илүү теледэлгэцээс сэтгэлийн хөдөлгөөнөө нуух нь хэцүү байлаа. Түүний цээжинд гал шатаж байгаа юм шиг байхаас гадна халуу оргисон, хүн пиг дүүрэн, чих дөжрөм чимээ шуугиантай гуанзанд үдийн хоол идэх нь нэг ёсны там цайсан хэрэг байв. Тэрээр ганцаараа байя гэж бодож байтал нөгөөх усан тэнэг Парсонс хажууд нь ирж наалдаад хулмас хөлсөөрөө төмөр тавагтай шөлний үнэрийг дараад Үзэн ядах долоо Хоногийн бэлтгэл ажлын талаар эх төгсгөлгүй яриагаа дэлгэж байлаа. Парсонс баярт зориулан охиныхоо Тагнуулчдын цэргүүдийн хатуу цаасаар хийсэн Их Ахын хоёр метр өргөн толгойн зургийг гайхуулан ярьж байв. Смит шуугиан чимээн дундаас Парсонсын юу хэлж буйг тод дуулахгүй дахин дахин асууж нөгөөх тэнэг яриаг нь давтаж яриулах болж байсан нь харамсалтай байв. Тэрээр танхимын нөгөө үзүүрт хар үстэй бүсгүй өөр хоёр хүүхний хамт байхыг харсан

боловч бүсгүй өөрийг нь хараагүй юм шиг байхлаар нь тэр рүү дахин харсангүй.

Үдээс хойших хугацаа гайгүй өнгөрөв. Үдийн завсарлагын дараа нарийн төвөгтэй даалгавар хүлээж авсан бөгөөд түүнд хэдэн цагаа зориулж өөр юм бодох зав гарсангүй. Аддагдах болсон Дотуур Намын нэгэн том зүтгэлтний нэр хүндийг гутаахын тулд хоёр жилийн өмнөх үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн гаргалтын тайланг хуурмагаар үйлдэх хэрэг гарав. Смит ийм даалгаврыг сайн хийдэг бөгөөд хоёр цагийн туршид хар үстэй бүсгүйг мартаж чадав. Дараа нь тэр бүсгүйн царай нүдэнд нь харагдаад гав ганцаараа байх хүсэл ихэд төрж байлаа. Тэрээр ганцаараа л байхгүй юм бол энэ болсон явддыг тунгаан бодох боломжгүй юм. Тэр өнөөдөр Олон нийтийн Төвд очих ёстой байсан. Тэрээр гуанзанд амтгүй оройн хоол идээд Олон нийтийн Төвд яаран очиж «бүлгийн мэтгэлцээн» хэмээх шал хэрэггүй ёслолын арга хэмжээнд оролцож хоёр удаа ширээний теннис тоглоод хэдэн удаа жин ууж «Шатар, Ангсоц

дахь түүний хандлага» гэсэн хагас цагийн лекцэнд суув. Сэтгэл нь уйтгартай байсан мөртлөө урьдынхтайгаа адил төвөөс явах хүсэл төрөхгүй байв. «Би чамд хайртай» гэдэг үгнээс болж амь насаа уртасгах хүсэл төрөөд жаахан ч гэсэн аюултай юм хийх нь тэнэг хэрэг шиг санагдана. Тэрээр хорин гурван цагт гэртээ эргэж ирээд орондоо ороход, чимээ гаргахгүй л юм бол теледэлгэцээс ч айх хэрэг байхгүй, бодох чадвар нь сэргэлээ.

Практикийн асуудлыг шийдэх хэрэгтэй боллоо, түүнтэй холбоо барьж уулзах газраа тохирох хэрэгтэй байна. Тэр бүсгүй өөрт нь урхи тавьж байна гэсэн бодлоосоо саллаа. Тэрээр тийм юм байхгүй гэдгийг ойлгосон, тэр бүсгүй зурвасаа өгч байхдаа үнэхээр сэтгэл нь хөдөлж байсан, айхаа мэдэхгүй байсан, энэ бол ойлгомжтой. Бүсгүйн сэтгэлийн тэмүүллийг хүлээж авахгүй байя гэсэн бодол надад огтхон ч байхгүй. Тэрээр тавхан хоногийн өмнө түүний толгойг бул чулуугаар хага цохье гэж бодож байсан, гэхдээ энэ бол өнгөрсөн юм. Урьд нь бүсгүйн залуухан

шалдан халуун биеийг зүүдэндээ харсан шигээ харж байна. Тэрээр бүсгүйг бусдын адил тэнэг, толгойд нь худап хуурмаг, жигшүүртэй юм дүүрчихсэн, бие нь тэр чигээрээ мөс гэж төсөөлж байсан. Түүнийг алдчихаж магадгүй, залуухан цагаан бие нь түүнээс зугтаад алга болж магадгүй гэсэн айдас түүнд төрж байлаа. Бүсгүйтэй хурдхан уулзахгүй л юм бол түүний санаа нь хувирчихвий гэж тэрээр хамгийн их айж байлаа. Хэрэг дээрээ түүнтэй уулзана гэдэг үнэхээр хэцүү юм. Энэ нь шатар тоглож байхдаа шалуулчихаад дараагийнхаа нүүдлийг эрж байгаатай адил юм. Хаашаа л явна теледэлгэцтэй мөргөлдөнө. Зурвасыг аваад уншмагц л бүсгүйтэй холбоо барих долоон шидийн арга толгойд нь төрж байсан, харин одоо тэрээр бодох цаг гармагц ширээн дээр багаж хэрэгслээ нэг нэгээр нь тавьж байгаа юм шиг нөгөөх аргаа нэгбүрчлэн цэгнэж байна.

Өнөө өглөөнийх шиг уулзалт давтагдах ёсгүй нь мэдээж юм. Бүсгүй Баримтжуулалтын газар ажил хийдэг байсан бол түүнтэй дайралдах нь

харьцангуй хялбар байх бөгөөд Смит Уран зохиолын газар хаа байдгийг бараг мэддэггүй ба тэнд очих шалтаг олоход хэцүү юм. Бүсгүй хаана оршин суудгийг нь мэддэг, хэдийд ажил нь тардгийг мэддэгсэн бол түүнийг гэр рүүгээ явах замд нь уулзаж болохсон билээ. Түүний араас явахын тулд Яамны гадна эргэлдэх хэрэг гарах бөгөөд энэ нь бас л анзаарагдах болно. Түүнд шуудангаар захидал илгээх тухай бодохын ч хэрэг байхгүй. Бүх захидлыг илгээж байхдаа задалж уншдаг нь жирийн хэрэг юм. Үнэн хэрэг дээрээ цөөн хэдэн хүн л захидал бичдэг. Заримдаа хэл сураг дуулгах шаардлага гарахад олон тооны хэвлэсэн хэллэгтэй ил захиддын хуудас дээр өөртөө тохирсон хэллэгийг дугуйлаад л явуулчихна. Тэгээд ч бүсгүйн хаяг байтугай нэрийг нь мэдэхгүй. Тэрээр бодож бодож хамгийн аюул багатай газар бол гуанз юм байна гэж боддоо. Тэрээр өрөөний дунд, теледэлгэцээс холхон шиг олон хүн шуугилдсан ширээнд бүсгүйн хажууд суугаад, ганц хоёр мөч нөхцөл байдал

тохиромжтой байх юм бол түүнтэй хэд гурван үг сольж амжихсан билээ.

Энэ явдлаас хойш хэдэн арван хоног Смитийн амьдрал хар дарсан зүүд шиг байлаа. Дараагийн өдөр Смитийг үдийн завсарлага дууссаны хонх дуугарсны дараа гарч явахад нь бүсгүй гуанзанд орж явлаа. Тэр оройн ээлжинд шилжсэн бололтой юм. Тэр хоёр бие бие рүүгээ харшггүй зөрж өнгөрөв. Дараагийн өдөр нь бүсгүй гуанзанд цагтаа ирсэн боловч бусад бүсгүйчүүдтэй хамт байхаар зогсохгүй теледэлгэцийн яг нүүрэн дээр сууж байв. Тэгээд дараагийн айдас төрүүлсэн гурван өдөр бүсгүй ерөөсөө ирсэнгүй. Түүний оюун ухаан, бие махбодь нь сэтгэлийн тэсвэрлэшгүй дарамтанд нэвтэрхий автагдсан юм шиг болоод хөдөлгөөн бүр, дуу чимээ бүр, хэлсэн дуулсан үг бүр нь зовлон шаналал болж хувирчээ. Унтаж байхад нь ч бүсгүйн дүр өөрөөс нь салахгүй байлаа. Тэрээр энэ өдрүүдэд өдрийн тэмдэглэлдээ гар хүрсэнгүй. Тэрээр ажил хийж байхдаа арван минут ч гэсэн өөрийгөө мартдаг нь түүнд



сэтгэлийн тайвширал авчирч байв. Бүсгүйд юу тохиолдсоныг мэдэх арга түүнд огт байсангүй. Ажиг сураг гаргах арга огтхон ч алга байна. Бүсгүйг ууршуулчихсан, бүсгүйн амийг егүүтгэчихсэн, бүсгүйг Далайн Гүрний газрын тагтанд цөлчихсөн ч байж магадгүй юм. бүсгүй зүгээр л санаа буцаж түүнтэй уулзахаас зайлсхийж байж магадгүй гэсэн таамаглал нь хамгийн ортой, хамгийн эвгүй нь юм.

Дөрөв хоногийн дараа бүсгүй дахин харагддаа. Тэрээр гарынхаа бооддыг авчихсан, бугуйгаа л боосон байна. Смитийн сэтгэл ихэд тайвшраад бүсгүй рүү хэдэн хором харахгүй байж чадсангүй. Дараагийн өдөр тэрээр бүсгүйтэй бараг яриа дэлгэхээ дөхөв. Смитийг гуанзанд ороход бүсгүй хананаас холхон ширээний ард ганцаараа сууж байлаа. Гуанз дөнгөж саяхан нээгдсэн тул хүн цөөхөн аж. Хоолны дараалал урагшилсаар Смит хоол тавьж өгдөг лангуунд ойртож явтал дараалал хэдэн мөч зогсчихлоо. Сахар орлуулагч өгсөнгүй гэж хэн нэгэн гомдол гаргаж байна. Гэлээ ч гэсэн Смит хоолоо аваад

харахад бүсгүй ганцаараа суусаар л байлаа. Смит чөлөөтэй суудал эрж байгаа мэт дээгүүр харан түүнийг чиглэн явлаа. Бүсгүй ердөө л хоёр, гуравхан алхмын цаана байх бөгөөд нэг, хоёр хормын дараа л гэхэд зорилгодоо хүрэх ажгуу. Ард нь хэн нэгэн «Смит!» гэж дуудахад нь дуулаагүй болон урагш алхтал араас нь «Смит!» гэж улам чанга дууддаа. Салахгүй нь л дээ. Смит эргээд хартал муухан таньдаг, цайвар үстэй, тэнэгдүү царайтай Уилшер хэмээх залуу инээмсэглэн ширээнийхээ сул суудалд урьж байлаа. Татгалзах арга алга. Нэгэнт л өөрийг чинь таньчихсан хойно ганцаараа хоол идэж суугаа эмэгтэйтэй хамт суух аргагүй юм. Суух л юм бол анхаарал татна. Смит ялдам инээмсэглэн суухад тэнэг царай баяр баясгалантай байлаа. Смитэд зээтүүгээр нуруун дундуур нь цохиод авах шиг боллоо. Хэдхэн хормын дараа бүсгүйн дэргэд ч хүмүүс сууж харагддаа.

Бүсгүй өөр рүү нь явж байгааг лав харсан байх ёстой, магадгүй ойлгосон ч байх аа. Дараагийн өдөр Смит арай эрт ирэхийг хичээв. Энэ нь ч

талаар болсонгүй. Бүсгүй өчигдрийнхөө суудлын хавьцаа ганцаараа сууж байна. Дараалалд Смитийн өмнө нь нэгэн хавтгай нүүртэй, сэжигтэй жижигхэн нүдтэй, жаахан биетэй, хурдан хөдөлгөөнтэй цох хорхой шиг эр байлаа. Смит хоолоо аваад эргэтэл нөгөөх жижигхэн эр бүсгүйн ширээ рүү чиглэн явж харагдав. Смитийн горьдоого дахиад л хөсөрдөө. Жаахан цаана нь сул суудал байсан хэдий ч жижигхэн эр өөрийнхөө тухыг бодож хамгийн сул ширээнд суух гэж байгаа нь илт байлаа. Смит зүрх шимшрэн араас нь дагалаа. Хоёулахнаа л уулзахгүй бол юу ч бүтэхгүй ээ. Гэтэл нэг их пичигнээн гарч жижигхэн эр дөрвөн мөчөөрөө газар тулчихсан, хоолны тавиур нь холоо гэгч нь гулсаад шалан дээгүүр шөл, кофе ураж байна. Тэрээр хөл дээрээ өндийж босоод Смит рүү өөрийг нь дэгээдчихсэн юм шиг муухай харж байна. Энэ хамаагүй хэрэг. Смит хэдхэн хормын дараа зүрх нь хүчтэй цохилсоор бүсгүйн дэргэд очиж суулаа.

Смит түүн рүү харалгүй хоолны тавиураа чөлөөлөөд шууд л идэж гарлаа. Хүн ирж суугаагүй байхад ярьж эхлэх нь чухал байсан ч гэсэн Смит айдасдаа ихэд автагджээ. Анх уулзсанаас хойш нэг долоо хоног өнгөрчээ. Санаа нь хувирсан байж болно, лав хувирсан байх! Энэ бүхнээс юу ч бүтэхгүй, амьдралд ийм юм байдаггүй юм. Смит гартаа хоолны тавиураа барьж сул суудал эрж нүдээ эргэлдүүлсэн чихэндээ үстэй яруу найрагч Амплфортыг хараагүй бол яриагаа эхлэж зүрхлэхгүй байсан юм. Мартамхай Амплфорт Смитэд өөрийнхөөрөө элгэмсэг ханддаг бөгөөд түүнийг харах л юм бол дэргэд нь ирээд суух байсан. Ердөө л мөч хурэхгүй хугацаа үлджээ. Тэр хоёр хоёулаа шоштой шингэн шөлөрхүү юм ууж байна. Смит намхан дуугаар ярьж эхлэлээ. Тэд нүүр рүүгээ харсан ч үгүй. тэгээд халбагаараа хоолоо хутган ам руугаа хийх завсарт нэгэн дуугаар хэрэгтэй хэдэн үгээ сольж амжлаа.

“Чиний ажил хэдийд тардаг вэ?”

“Арван найм хагаст”

“Хаана уулзах вэ?”

“Ялалтын талбайд, хөшөөний дэргэд”

“Тэнд чинь теледэлгэц дүүрэн бий”

“Бөөн хүний дунд бол зүгээр”

“Дохио өгөх үү?”

“Үгүй дээ. Намайг хүмүүсийн дунд ортол бүү ойртоорой. Над РУУ бүү хараарай. Зүгээр л дэргэд байгаарай”

“Хэдэн цагт?”

“Арван есөд”

“За ойлголоо”

Амплфорт Смитийг харсангүй өөр ширээнд суужээ. Бүсгүй хоолоо түргэн идээд гарч явахад Смит тамхи татсаар үлдэв. Тэд дахиад юу ч яриагүй бөгөөд эсрэг ширээний ард суугаа хоёр хүний хувьд тэр хоёр бие бие рүүгээ эгцэлж харалгүй өнгөрч чадав.

Смит цагаасаа өмнө ирээд орой дээр нь Евразийн Гүрэнтэй онгоц нисэх нэгдүгээр замын төлөөх агаарын тулалдаанд (хэдэн жилийн өмнө энэ нь Дорнодазийн Гүрэн байсан) ялалт байгуулсан өмнө зүг рүү ширтэн харж буй Их Ахын хөшөө бүхий ховилтой асар том баганыг эргэлдэн холхив. Гудамжны нөгөө талд Оливер Кромвелийн хөшөө гэж үздэг байсан морьтой хүний хөшөө байна. Болзсон цаг хэдэн мөч өнгөрсөн ч нөгөөх бүсгүй бас л алга байна. Смит дахиад л айдаст автагдав. Ирэхгүй нь, санаа буцжээ! Тэрээр талбайн хойт үзүүрт хүрч очоод Гэгээн Мартины сүмийг хараад жаахан баярлав, нөгөөх «Надад фартинг өг» гэж хонх нь дууддаг сүм мөн байна. Смит тэгээд нөгөөх бүсгүйг харлаа. Тэрээр баганыг

ороосон сурталчилгааны хуудсыг уншиж байгаа юм уу, уншиж байгаа дүр үзүүлж байгаа мэт зогсоно. Олон хүн тэнд цуглараагүй байхад дөхөж очих нь осолтой. Баганын эргэн тойронд теледэлгэц байрлуулжээ. Зүүн талаас гэнэт хүмүүс гарч ирээд хүнд машины дуу хүнгэнэх сонсогддоо. Талбай дээрх бүх хүн тэр зүг рүү хошуурлаа. Бүсгүй баганын ёроол дахь арслангуудыг тойроод гүйж байна. Смит түүний араас гүйж явахдаа хүмүүсийн хашгирах дуунаас Евразийн цэргийн олзлогдогсдыг тууж явааг ойлголоо.

Талбайн урд хэсэгт пиг дүүрэн хүн байна. Смит уг нь иймэрхүү бөөгнөрсөн хүмүүсийн захад гарахыг хичээдэг боловч энэ удаа хамгийн гүн рүү шахцалдан, түлхэлцэн, түрэн явж байв. Бүсгүй Смитэд тун ойрхон гараараа татаад авмаар иртэл тэдний өмнүүр маш бүдүүн үгээгүй нэгэн, мөн тийм бүдүүн эмэгтэй орлоо. Смит тэдний дундуур мөрөөрөө түлхэн хамаг байдаг хүчээрээ урагшлав. Смитэд хоёр талаас нь энэ хоёр булчинлаг бие хавиргы нь хугалчих

юм шиг санагдсан ч гэсэн тэрээр хөлсөө асгаруулан зүтгэж байлаа. Тэрээр бүсгүйн дэргэд очиж тэр хоёр мөр зэрэгцэн зогсоод урагшаа харж байв. Гудамжаар ачааны машины урт цуваа сунжрах бөгөөд тэдгээрийн тэвшний дөрвөн өнцөгт автомат буу барьсан цэрэг зогсжээ. Цэргүүдийн дунд навсархай ногоон дүрэмт хувцастай шар арьстан жижигхэн хүмүүс өвдөг дээрээ суусан харагдана. Тэвшний цаана гунигтай, юуг ч эс анзаарсан тэдний монгол царай харагдана. Ачааны машин донслоход төмөр харчигнах чимээ гарах бөгөөд энэ нь олзлогдогсод төмөр гавтайг илтгэнэ. Олзлогдогсодтой ачааны машинууд нэг нэгээрээ өнгөрч байна. Смит тэднийг хэрхэн авч явдгийг дуулсан болохоос биш нүдээрээ хараагүй аж. Бүсгүйн мөр, гар нь Смитийн гар, мөрөнд хүрээд хацар нь их ойрхон байсан тул бүсгүйн биеийн хапууныг мэдэрч байв. Бүсгүй санаачилгыг шууд л гартаа авч уруулаа дөнгөж хөдөлгөн намхан дуугаар үгээ шивнэн ярихад хүмүүсийн яриа, ачааны машины дүнгэнээнд бараг дуулдахгүй аж.



“Намайг сонсож байна уу?”

“За”

“Бүтэн сайнд гарч чадах уу?”

“Чадна”

“Сайн сонсож бай. Чи сайн тогтоогоорой. Паддингтоны галт тэрэгний буудал дээр очоод..”

Бүсгүй Смитийн замыг цэргийн хүн нарийн тодорхойлж буй юм шиг зааж өгсөн нь гайхмаар байв. Хагас цаг галт тэргээр явна. Буудлаас зүүн тийшээ эргэнэ, замаар хоёр километр явна, задгай хаалга дайралдана, тал дундуур зөрөг замаар явна, модон дундуур өвс ургасан зөрөг замаар явна, бутан дундуур зөрөг зам бий, унасан мод бий. Түүний толгойд нь газрын зураг тэр чигээрээ байх шиг юм.

“Бүгдий нь тогтоов уу?” гэж тэрээр шивнэн асуулаа.

"Тэглээ"

“Зүүн тийшээ эргэнэ, дараа нь баруун тийшээ, дахиад зүүн тийшээ эргэнэ. Задгай хаалга бий”

"Тийм. Хэдэн цагт вэ?"

“Арван таван цагийн орчимд. Чи жаахан хүлээх болж магадгүй шүү, би нөгөө талаас нь очно. Бүгдийг нь сайн тогтоов уу?”

"Тэгсээн"

“За тэгвэл одоо хурдхан яв”

Цугларсан хүмүүс тараагүй болохоор ингэж хэлэх ч шаардлага байсангүй. Машины цуваа үргэлжилсээр хүмүүс ханахгүй тэднийг харсаар л байв. Анхандаа намын гишүүд хашгиралдаж шүгэлдэж байснаа дараа нь чимээгүй болцгоов.

Сэтгэл хөдлөлийн хийрхэл нь зүгээр л нэг сониуч зан байв. Гадаадынхан, Евразийнхан байна уу, Дорнодазийнхан байна уу, зэрлэг амьтад л шүү дээ. Тэднийг цэргийн олзлогдогсод болохоор нь л хараад өнгөрсөн болохоос биш ерөөсөө тэднийг чи үзээгүй. Тэдний хувь заяаг ч мэдэхгүй, цэргийн гэмт хэрэгтэн гэж дүүжилснийг нь л мэднэ, бусад нь сураг чимээгүй алга болно, хүнд хөдөлмөрийн лагерьт цөлчихдөг бололтой юм. Дугуй монгол царайтангууд сахалтай, бохир, зовж шаналсан европ царайтангуудаар солигддоо. Зарим нэгнийх нь ширтэнгүй харц Смит дээр тусаад алга болж байлаа. Жагсаал дуусч байхад Смит эрүүндээ цав цагаан сахалтай настайвтар хүнийг харлаа, тэрээр гавлуулаад сурчихсан юм шиг гараа урдаа зөрүүлж барин зогсоно. Смит бүсгүйгээс холдон явах цаг аль хэдийнээ болжээ. Сүүлийн мөчид хүмүүс тэр хоёрыг шахаж түлхсээр байхад тэрээр Смитийн гарыг олж бариад атгав.

Энэ нь хоромхон зуур болсон ч гэсэн Смитэд тэд гар гараасаа барилцаад л байгаа юм шиг санагдаж байсан. Смит түүний гарыг сайн санаж байна. Тэрээр түүний урт хуруу, хумс, хар ажлаас эвэртсэн алга, зөөлхөн бугуйг тэмтэрч байна. Тэрээр гарыг нь тэмтэрч мэдэрсэн болохоор одоо түүнийг хараад л мэднэ. Бүсгүйн нүд ямар өнгөтэй вэ гэдгийг хараагүй юм шиг Смитэд санагдана. Хар үстэй хүүхний нүд голдуу цэнхэр байдаг ч гэсэн түүний нүд хар байсан байж таарна. Түүний нүд рүү эгцдэн харах нь тэнэг хэрэг байсан. Бөөн хүний дунд шахагдан гар гараасаа барин зогсож буй тэр хоёр чанх урагшаагаа харж байхад бүсгүйн нүд биш харин олзны настайвтар эрийн харц дух руугаа унжсан бөөн үсний цаанаас Смит дээр тусаж байлаа.

## II

Смит модны алаг цоохор сүүдэртэй, хааяа алтан шар нар туссан цоорхойтой замаар явж байна. Түүний зүүхэн талд модны дорхи газар хонхон цэцэг дуниартана. Зөөлөн салхи хацар үлээнэ. Тавдугаар сарын хоёрны өдөр байсан. Ойн гүний хаа нэг газраас тагтаа гүдэгнэнэ.

Тэрээр цагаасаа жаахан эрт ирчихжээ. Замд ямар нэг бэрхшээл гарсангүй. Бүсгүй туршлагатай нь мэдээж байсан болохоор тэрээр ердийнх шигээ нэг их айсангүй. Тэрээр бүсгүй аюул багатай газар сонгож авсан гэдэгт эргэлзсэнгүй. Ер нь бол Лондоны гадна аюул багатай гэж найдахад бэрх юм. Мэдээж хэрэг теледэлгэц энд байхгүй. Тэхдээ л хааяагүй микрофон нуучихсан байж болно. Дуу хоолойг чинь бичиж аваад хэнийх вэ гэдгийг чинь тогтоочихно, ганцаараа яваа хүн болгон бас тэгээд анхаарал татна. Зуун километрийн доторхи зайнд явахад паспортонд тэмдэглүүлэх шаардлага байхгүй, гэхдээ л зарим

үед галт тэрэгний буудлын ойролцоо эргүүл дайралдаж Намын гишүүдийн баримт бичгийг шалгаж байцаах нь бий. Тэрээр эргүүлтэй дайрагдаагүй ч гэсэн галт тэрэгний буудал руу явж байхдаа араас дагуул байна уу гэж нэг бус удаа эргэж харж байсан юм. Тэнгэр сайхан байсан тул баяр хөөр болсон үгээгүйчүүд гапт тэргэнд дүүрэн байлаа. Түүнтэй хамт галт тэрэгний вагон дотор модон суудал дээр бүхэл бүтэн гэр бүл шүдгүй чавганц, нэг сартай нялх хүүхэд, хөдөө тосгон дахь “төрөл төрөгсөддөө” очих гэж явж байсан ба тэд хар захын жаахан цэцгийн тос олж авахаар явж байна гэж Смитэд ярьсан аж.

Зөрөг зам өргөн болоод бүсгүйн тайлбарлаж ярьсан бутан дундуур гарсан үхрийн мөр рүү орлоо. Смитэд цаг байхгүй ч гэсэн лав арван таван цаг болж байх ёстой. Шигүү ургасан хонхон цэцгийг гишгихгүй байх аргагүй байв. Тэрээр цаг нөхцөөх гэж, бас тэгээд бүсгүйтэй уулзахдаа баглаа цэцэг бэлгэнд өгье гэж бодоод цэцэг түүлээ. Тэрээр бүхэл бүтэн тэвэр цэцэг

түүчихээд анхилуун үнэрийг нь үнэртэж эхэлтэл ард нь хүний хөлийн чимээ гармагц зүрх нь пап гээд явчихлаа. Хэн нэгний хөл дор хатсан гишүү шажигналаа. Тэрээр ийм үед хамгийн зөв арга нь энэ гэж бодоод цэцгээ түүсээр л байлаа. Ард нь магадгүй нөгөө бүсгүй байж болно, магадгүй араас нь хэн нэгэн дагаж байж болно. Тэрээр нэг хонхон цэцэг авлаа, дахиад нэгийг авлаа. Мөрөн дээрээс нь зөөлхөн татлаа.

Эргээд харахад нь нөгөөх бүсгүй зогсож байна. Бүсгүй бүү дуугар гэж толгойгоо дохиод бутан дундуур ой руу орсон зөргөөр түргэн түргэн алхлаа. Тэрээр лав урьд нь энд ирж байсан бололтой, бүсгүй шавхайг тойрон алхана. Смит баглаа цэцгээ барин араас нь алхаж явлаа. Анхандаа түүний сэтгэл амарсан ч гэсэн бүсгүйн туяхан залуухан бие, час улаан ороолтоор ороосон ташааг хараад энэ бүсгүй намайг тоох болов уу гэсэн бодол төрж байв. Одоо бүсгүй эргэж хараад л өөрөөс нь зайлж одох юм шиг түүнд санагдана. Зүрх нь зөөлөн үлээх салхи, ногоорон харагдах навчист улам

үхнэ. Тэрээр галт тэрэгний бууддаас явж байхдаа л өөрийгөө бузар заваан, хатингар туранхай, Лондон хотын тоос шороонд дарагдсан хир буртаг биенийх нь нүх сүвээр дүүрсэн амьтан гэж бодож байжээ. Тэрээр энэ бүсгүй намайг өдрийн гэгээнд, задгай газар ер нь хараагүй дээ гэж бодно. Тэдний өмнө бүсгүйн хэлж байсан унасан мод харагдлаа. Бүсгүй модыг тойрч гараад өндөр ургасан бутыг гараараа ярлаа. Смит араас нь даган ороход эргэн тойрон буттай ойн жижигхэн цоорхой байна. Бүсгүй одоо л эргэж харлаа.

“Хүрээд ирчихлээ” гэж тэрээр хэллээ.

Смит хэдхэн алхмын цаана зогсох бөгөөд түүнд ойртож зүрхлэхгүй байв.

“Би замдаа юм яримааргүй байлаа. Микрофон байвал яана. Бараг үгүй биз дээ, гэхдээ л юмыг яаж мэдэх вэ. Цаад өөдгүй юмнууд чинь дуу хоолойг танивал яана. Энд айх юм байхгүй”.



Смитэд түүнд ойртох зүрх хүрэхгүй л байна.

“Энд айх юм байхгүй юү?”

“Айх юм байхгүй. Модыг харж байна уу? Яшил мод байсныг нь огтолчихсон юм билээ. Энд хүний бугуйнаас нарийхан сургааг ургачихсан юм. Микрофон зоочих бүдүүн мод энд байхгүй. Тэгээд ч би энд өмнө нь ирж байсан юм”.

Тэр хоёр зүгээр л ярьж байлаа. Смит бүсгүйд юутай ч гэсэн ойртож очлоо. Бүсгүй Смитийн өмнө зогсоод энэ яагаад хөддөхгүй байна гэсэн шиг жоготойхон инээмсэглэн зогсоно. Смитийн гар дахь хонхон цэцэгнүүд аяндаа асгаран унахад тэрээр бүсгүйг гараас нь барилаа.

“Би энэхэн хормыг хүртэл чиний нүд ямар өнгөтэйг мэдэхгүй байсан гэвэл үнэмших үү?, Хар нүд, хар сормуустай харавтар нүд. Чи одоо намайг сайтар хараад авчихлаа. Дургүй чинь хүрэхгүй байна уу?”

“Огтхон ч үгүй”

“Би гучин есөн настай. Авгайтай, түүнээс хагацаж чаддаггүй. Миний судас бүдүүрсэн. Таван хиймэл шүдтэй”

“Энэ бүхэн ямар хамаатай юм бэ?”

Хэн нь эхэлснийг анхандаа мэдсэнгүй, нэг л мэдэхэд тэврэлдэн зогсож байна. Анхандаа тэрээр юу ч мэдэрсэнгүй, зүгээр л бодож зогслоо. Ийм амархан уу гэж бодлоо. Бүсгүйн залуу халуун бие өөр рүү нь наалдаж өтгөн хар үсэнд нь нүүр нь шүргэж байна. Тийм ээ, Үнэхээр шүү!, Бүсгүй толгойгоо дээш өргөхөд тэрээр зөөлхөн улаан уруул дээр нь үнслээ. Бүсгүй Смитийг хүзүүгээр нь тэврээд хонгор минь, хайрт минь, амраг минь хэмээн Смитийн гарын аяыг

даган хэвтэж хүссэнээр нь болов. Харамсалтай нь тэрээр бүсгүйн биед нь хүрснээс өөр таашаал авсангүй. Түүнд өөрт нь баяр бахдал төрж

байсан ч одоо болтол энэ болж буй юманд итгэж чадахгүй байлаа. Тэрээр энэ бүхэнд баярлаж байсан ч хүсэл тачаал төрөхгүй байна. Бүх юм хэтэрхий түргэн боллоо. Бүсгүйн залуу нас, гоо үзэсгэлэнгээс эмээж байна. Тэрээр эмэгтэй хүнтэй хавьтахгүй байгаад дасчихжээ. Бүсгүй өндийж суугаад үсэндээ наалдсан хонхон цэцгийг авснаа Смит рүү наалдан бүсэлхийгээр нь дахин тэвэрлээ.

“Зүгээр, хонгор минь. Яарах юм байхгүй. Бидэнд цаг байна. Сайхан нуугдах газар байгаа биз? Би аяллын үеэр бусдаас хоцорч яваад олсон юм. Ойр хавьд хүн явбал зуун метрийн цаанаас дуулдана”

“Чиний нэр чинь хэн бэ?” гэж Смит асуув.

“Жулия. Би чиний нэрийг мэднэ. Уинстон Смит”

“Чи яаж мэддэг юм бэ?”

“Би лав тагнуулчийн хуьд чамаас илүү авьяастай байх аа. Чи зурвас авахаас өмнө намайг юу гэж боддог байсан бэ?”

Тэрээр худал хэлэхийг хүссэнгүй. Хайр сэтгэлийн нэгэн урьдчилгаа болгож хамаг муу юмаа эхэлж хэлье гэж бодов.

“Хоёр нүдэндээ үзэхгүй байсан. Хүчиндэж орхиод алчихмаар байсан. Хэдэн хоногийн өмнө толгойг чинь бул чулуугаар хага цохьё гэж үнэхээр бодож байлаа. Илэн далангүй хэлэхэд чамайг Сэтгэхүйн Цагдаатай холбоотой гэж бодож байсан шүү”.

Бүсгүй өөрийнх нь зүсээ сайн хувиргасных нь нотолгоо гэж Смитийн үгийг хүлээн авч баярлан инээлээ.

“Сэтгэхүйн Цагдаатай холбоотой гэж үү? Үгүй байлгүй дээ, чи үнэхээр тэгж бодсон гэж үү?”.

“Яг тэгж бодоогүй ч байж магадгүй. Гэхдээ л чамайг хараад... Чи залуухан, эрүүл чийрэг, цэвэр цэмцгэр, ойлгож байна уу... гэж би бодсон..”.

“Чи намайг намын үлгэр жишээ гишүүн, үйл хэрэг, бодол санаа нь ариун тунгалаг гэж бодсон уу? Туг далбаа мандуулах, жагсаал цуглаан хийх, лоозон гаргах, спорт тоглоом хийх, аялал зохиох нь хэрэггүй дэмий юм. Намайг ялихгүй шалтгаар өөрийг чинь сэтгэхүйнгэмтэн гэж буруутгана гэж бодоо юу?”

"Тийм ээ, иймэрхүү л юм бодсон. Олонхи залуу бүсгүйчүүд ийм шүү дээ, өөрөө мэднэ дээ”.

“Энэ заваан юмнаас л бүх юм болж байгаа юм” гэж тэрээр хэлээд Бэлгийн харилцаанд орохын эсрэг залуусын Холбооны час улаан ороолтоо авч бут руу шидэв.

Тэрээр нэг юм санасан мэт бэлхүүсээ тэмтрээд халааснаасаа хугархай шоколад гаргаад хагасыг

нь Смитэд өглөө. Смит гартаа бариагүй байхдаа л үнэрээр нь энэ бол ер бусын шоколад байна гэдгийг мэдлээ. Тэр нь гялтганасан хүрэн өнгөтэй бөгөөд мөнгөн

цаасанд боолттой аж. Ер нь шоколад бол бүдэг хүрэн өнгөтэй, үйрэмхий, хэлэхэд бэрх, шатаж буй хогны утааны үнэртэй байдаг юм. Тэрээр хэзээ ч билээ иймэрхүү шоколад амсаж үзсэн юм. Үнэр нь ямар нэг юм санагдуулах нь юу билээ? Смит юу билээ гэдгийг санаж чадахгүй байна, гэхдээ л тэр нь санаа зовоож байлаа.

“Чи үүнийг хаанаас олов оо?”.

“Хар зах дээрээс. Гаднаас нь харахад би яг тийм хүн л дээ. Сайн тамирчин. Тагнуулчдын багийн ахлагч байсан. Бэлгийн харилцаанд орохын эсрэг залуусын Холбооны олон нийтийн ажлыг долоо хоногт гурван удаа хийдэг юм. Лондон хот даяар тэдний заваан хуудсыг нааж явдаг хүн. Жагсаалд дандаа лоозон барьж явдаг. Юунаас ч хойш суудаггүй, үргэлж баяр баясгалантай

царай гаргадаг. Миний зарчим бол үргэлж бөөгнөрсөн хүмүүстэй хамт орилж явах юм. Ингэж л өөрийгөө хамгаална”.

Шоколадны хэлтэрхий хэл дээр нь хайлчихлаа. Сэтгэ-лийнх нь гүнд ямар нэг дурсамж, хурц мэдэрмээр дурсамж сэрэгдлээ, харин тэр нь нүднийхээ булангаар харж болох хэв төрх олсонгүй. Смит тодруулж чадаагүй нөгөөх дурсамж нь ямар нэг үйлдэлтэй холбоотой бөгөөд болдогсон бол түүнийг дуртайяа мартагсан гэж бодоод дахин түүнээ бодсонгүй.

“Чи их залуу юм. Надаас арав, арван таван насаар дүү байна. Чамд над шиг хүний юу нь таалагдсан юм бол оо?”

“Нүүр чинь нэг юм хэлээд байх шиг. Би азаа үзье гэж бодсон юм. Би чамайг анх харахдаа л тэдний эсрэг хүн байна гэж ойлгосон юм”

Тэд гэдэг нь түүний илт жигшин шоолж буй Нам, тэх тусмаа Дотуур Нам болж таарч байна,

хэдийвээр энд тэр хоёр аюулгүй байж болох юм бол тийм л аюулгүй байгаа ч гэсэн Смитэд ингэж ярихад нь их эвгүй байлаа. Тэрээр бүсгүйн эрээ цээргүй яриаг гайхаж байв. Намын гишүүд хараал зүхэл тавих ёсгүй, Смит бараг уурладаггүй, ямар ч гэсэн үг хэлээрээ түүнийгээ илэрхийлдэггүй, харин Жулия Намыг, ялангуяа Дотуур Намыг жорлонгийн хананы бичгийн үг хэрэглэхгүйгээр ярьж чадахгүй аж. Үүнд нь тэрээр дургүйцсэнгүй. Энэ нь түүний Нам, Намын үзэл санааг эсэргүүцэж буйн илэрхийлэл бөгөөд шинэхэн өвс үнэрлэсэн морь тургих шиг эрүүл саруул, зүй ёсны хэрэг юм. Тэр хоёр босоод зэрэгцэж явж болох газар бие биетэйгээ тэврэлдэн явлаа. Тэрээр ороолтоо тайлчихлаар бүсгүйн ташаа нь хичнээн уяхан болсныг анзаарлаа. Шивнэн ярилцана. Жулия ойн цоорхойгоос гарахаараа чимээгүй явах нь зүйтэй гэж ярина. Тэд ойн захад гарлаа. Жулия Смитийг зогсоолоо.

"Задгай газар бүү гар. Хүн харж байж мэднэ. Ой дотор байхад бол айх юм байхгүй".



Тэр хоёр шид модны дор зогсоход саглагар мөчирний цаанаас нарны гэрэл нэвт гарч хацар нүүрийг халаана. Смит нэг л таньдаг юм шиг хачин мэдрэмж төрөн өмнөө байгаа нугыг харж зогслоо. Тарчиг өвстэй хуучин бэлчээр байх бөгөөд дундуур нь зөрөг зам гарч энд тэнд сондуул харагдана. Нугын нөгөө захад арчил бургас энд тэндгүй ургасан харагдах ба зөөлөн салхинд навчис нь бүсгүй хүний үс шиг намилзана. Энүүхэнд жараахай усан дотор нь шазалзсан горхи байх ёстой.

“Энэ хавьд горхи бий юу?” гэж тэрээр асуулаа.

"Тийм ээ, байгаа шүү. Энэ хажуугийн нугын захад байгаа. Том загастай. Унжгар уд модны ёроол дахь усанд сүүлээ хөдөлгөн хөвж байхыг нь харж болно”

“Үзэсгэлэнт сайхан нутаг юм аа... бараг л” гэж тэрээр шивнэн хэллээ.

“Үзэсгэлэнт сайхан нутаг аа?”

“Зүгээр л хэлсэн юм. Надад заримдаа зүүдэнд ийм нутаг харагддаг юм”

“Хараач!” гэж Жулия шивнэн хэллээ.

Тэр хоёроос хэдхэн алхмын цаана цагаан хөөндэй тэдний нүүрний урдуур нисч модны мөчир дээр суув. Хөөндэй нарны гэрэлд нисэж тэр хоёр сүүдэрт зогсож байсан болохоор шувуу тэр хоёрыг харсангүй бололтой. Хөөндэй далавчаа дэлгэснээ аажимхан хумиад наранд мөргөж буй юм шиг толгойгоо дохиод жиргэлээ. Үд хэвийж буй энэхэн үед түүний дуу цочирдмоор чанга сонсогдоно. Смит Жулия сэтгэл нь уяран хоёр бие биедээ наалдан зогсож байв. Шувууны жиргээ ур чадвараа гайхуулах гэсэн юм шиг тасралтгүй тэхдээ өөр өөр өнгөөр үргэлжилнэ. Цагаан хөөндэй дуулахаа нэг хоёр хором зогсосхийгээд далавчаа нэг дэлгэж, нэг хумиад цоохор цээжээ төмбийтэл түрээд дахиад л жиргэн дуулна. Смит хөөндэйг хүндэтгэлтэйгээр ширтэн харж байна. Шувуу хэнд зориулж, юунд ингэж жиргэн дуулна вэ?

Ойр хавьд нь өрсөлдөх дайсан, өр зүрхний андын аль нь ч алга. Хөөндэй чи яахлаараа ойн эзгүй цоорхой дотор уяхан сайхан дуугаа хоосон цацна вэ? Смит гэнэт бодлоо, энд тэгээд далд микрофон байвал яах вэ? Тэрээр Жулияттай шивнэн ярьж байгаа болохоор тэдний хоолойг ялгаж чадахгүй, харин хөөндэйн дууг сонсож лав чадна. Шугамны нөгөө үзүүрт цох хорхой шиг жижигхэн эр суучихсан үүнийг чих тавин сонсож байж магадгүй юм. Энэ уяхан ялдам дуунд түүний бодоогошрол аажмаар замхран алга боллоо. Хөөндэйн дуу түүний биед чийг мэт навчис дундуур тусах нарны гэрэлтэй холилдон шингэж байна. Тэрээр бодолд автахаа больж зөвхөн сэтгэлээрээ мэдэрч байна. Гарынх нь үзүүрт бүсгүйн уян зөөлхөн, халуун бүлээн бэлхүүс мэдрэгдмэгц тэрээр түүнийг эргүүлэн өөр рүүгээ харуулахад хоёр бие нүүр нүүрээрээ нийлээд бүсгүйн бүлээн бие түүнд шингэчих шиг боллоо. Түүний гар хүрэх болгонд л уян зөөлхөн бие дайралдана. Тэр хоёр уруул дээрээ озон үнсэлцдээ. Анх шунан үнсэлцсэнээс энэ нь огт өөр байна. Тэр хоёр салж зогсоод амьсгаагаа

авав. Цагаан хөөндэйг ямар нэгэн юм айлгачихсан бололтой далавчаа шарчигнуулаад нисч оддоо. Смит бүсгүйн чихэнд шивнэн хэллээ.

“За одоо”.

“Энд болохгүй. Ойн цоорхойд очье. Тэнд айх юм байхгүй” гэж бүсгүй шивнэн хэллээ.

Тэр хоёр хуурай гишүү шажигнуулан явж ургаж буй модны дор буй ойн цоорхойдоо яаран очлоо. Жулия түүн рүү эргэн харахад уруул дээр нь инээмсэглэл тодорч байна. Бүсгүй Смит рүү хэдхэн хором харснаа цахилгаан товчоо тайлж эхэллээ. Тийм ээ! Зүүдэн дундаа байгаа юм шиг байна. Тэрээр түүний төсөөлж байснаар хувцсаа хуу татаж тайлаад бүхэл бүтэн соёл иргэншлийг үгүй хийж байгаа юм шиг гайхалтай сайхан хөдөлгөөнөөр хувцсаа шидэж орхилоо. Бүсгүйн нүцгэн бие нарны гэрэлд цагааран харагдана. Смит нэг хэсэгтээ түүний биеийг харсангүй, харин түүний харц яльгүй, тэхдээ эрэмгий

инээмсэглэл бүхий сэвхтэй нүүр дээр тусаж байлаа. Тэрээр өвдөглөн суугаад бүсгүйн гарыг барилаа.

“Чи урд нь ингэж байсан л биз дээ?”

"Тэгэлгүй яахав. Хэдэн зуун удаа... за за, хэдэн арван удаа”

“ Намын гишүүдтэй юу?”

"Тэгэлгүй яахав. Дандаа Намын гишүүдтэй”

“Дотуур намын гишүүдтэй мөн адил уу?”

“Үгүй шүү, энэ новшийн юмнуудтай үгүй шүү. Жаахан нүүр өгвөл тэд буцахгүй л дээ. Тэд ярьж байгаа шигээ ариун амьтад биш шүү дээ”

Смитийн зүрх хүчтэй цохилж байна. Бүсгүй олон удаа ийм юм хийжээ. Ийм юмыг хэдэн зуун удаа, хэдэн мянган удаа хийсэн ч болоосой. Завхралын талаар яриа гарах бүрт л Смитэд

галзуу горьдлого төрдөг юм. Нам дотроосоо ялзарч байгаа бөгөөд Намын эрч хүч, амь биеийг үл хайрлах тэмцдийг нь шүтэх нь хоосон зүйл байж болох юм. Тэрээр бүх хүнд уяман, тэмбүүг ямар баяр хөөртэй тараах байсан болоо! Өмхрүүлэх, сулруулах, нэр сүрий нь гутаахын тулд юу ч хийхэд бэлэн байна! Тэрээр бүсгүйг доош нь татахад хоёулаа өвдөглөн суулаа.

“Хөөе чи хичнээн олон хүнтэй явбал би чамд төчнөөн хайртай. Чи ойлгож байна уу?”

“Би сайн ойлгож байна”.

“Би цэвэр ариун байдал, нинжин сэтгэлийг үзэж чаддаггүй юм. Энэ дэлхий дээр ачтан тустан ерөөсөө байдаггүй бол сайнсан гэж би боддог. Хүн бүрийг ясанд нь тултал ялзруулахсан гэж би боддог”.

“За тэгвэл хонгор минь би чамд таарах юм байна. Би чинь бүрмөсөн ялзарсан хүн шүү дээ”.

“Чи ийм юм хийхдээ дуртай юу? Надтай биш, ер нь гэж л асууж байна?”.

“Би их дуртай”.

Смитийн хамгийн их сонсохыг хүсч байсан юм нь энэ билээ. Нэгэн хүний хайр сэтгэл биш юм. Харин адгуусны зөн, жирийн л нэг ялгаварлалгүй хүсэл тачаал. Намыг зад татаж эвддэх хүч бол энэ мөн. Тэрээр бүсгүйг дээрээс нь хонхон цэцгийн дунд дарлаа. Энэ удаа бүх юм амархан бүтэв. Тэр хоёр тэгээд амьсгаагаа дарж хоёр тийшээ салж хэвтэв. Нар хүчтэй ээж тэд унтмаар байх аж. Смит баадайгаа авч бүсгүйг хучлаа. Хоёулаа хагас цаг унтчихжээ.

Смит түрүүлж сэрээд гарынхаа алган дээр толгойгоо тавин унтаж буй бүсгүйн сэвхтэй нүүрийг харна. Нүднийх нь гадуур яльгүй үрчлээ үүсчихсэн, богинөхон хар үс нь их өтгөн зөөлхөн аж. Тэрээр одоо хүртэл түүний овог, суудаг газрынх нь хаягийг мэдэхгүй юм байна шүү гэж бодож байлаа.

Тэрээр гэмгүй унтаж буй залуу бүсгүйн биеийг харахад өрөвдөх, өмөөрөх сэтгэл төрж байлаа. Цагаан хөөндэй жиргэж байхад аяндаа бий болсон сэтгэлийн уярал дахин эргэж ирсэнгүй. Тэрээр баадайгаа сөхөөд бүсгүйн цав цагаан биеийг харж байлаа. Тэрээр урьд бол эр хүн залуу бүсгүйн нүцгэн биеийг хараад л тачаал нь хөдөлж бүх юм үүгээр дуусдаг байлаа гэж бодлоо. Харин одоо бол ариун хайр сэтгэл ч байхгүй, цэвэр хүсэл тачаал ч байхгүй. Сэтгэл хөдлөл ариун тунгалаг биш бөгөөд бүх юманд айдас, жигшил хутгалджээ. Тэр хоёрын тэврэлцэл бол тэмцэл, ялалтын оргил нь байсан юм. Энэ бол Намд өгсөн цохилт байлаа. Энэ бол улс төрийн үйл ажиллагаа байлаа.



### Ш

“Бид энд дахиад ирж болно. Нуугдах газрыг ер нь хоёр удаа л ашиглаж болно. Тэхдээ нэг хоёр сардаа хэрэглэхгүй байх нь зөв” гэж Жулия хэллээ.

Тэрээр сэрэнгүүтээ хувцсаа түргэн өмсөж улаан ороолтоо бүслээд хэрхэн буцаж явах төлөвлөгөөг гавшгайлан мэдлэгтэй тайлбарлаж эхлэв. Түүний үгийг авах нь зүйн хэрэг байлаа. Тэрээр Смитийг бодох юм бол аар саар зүйлийг сайн мэддэг, тэгээд ч маш олон удаа аялалд явсан болохоор Лондон хот хавийн газрыг арван хуруу шигээ мэддэг аж. Тэрээр буцах замыг нь хэлж өгөхдөө огт өөр замаар явахыг зөвлөөд галт тэрэгний өөр буудалд очихыг зааж өглөө. Тэрээр нийтлэг зарчмыг зааж буй мэт «Ирсэн замаараа хэзээ ч бүү буцаж явж бай» гэв. Тэрээр өөрөө түрүүлээд явах ба Смит хагас цагийн дараа л хөддөх ёстой аж.

Жулия дөрөв хоногийн дараа ажил тараад уулзах газрыг товлож өглөө. Тэр газар нь ядуучуудын дүүрэгт юм байна. Тэр нь хөл хөдөлгөөн ихтэй, чимээ шуугиантай зах аж. Тэрээр мухлагуудаар гутлын оосор, утас эрж яваа болж холхино. Ямар ч аюул байхгүй гэж үзэх юм бол Смитийг ойртож очиход нь найтаалгана, ийм дохио өгөөгүй л бол Смит түүнийг огт хараагүй юм шиг өнгөрөөд явах ёстой аж. Боломж олдвол бөөн хүний дунд уулзаад хэдэн мөч ярилцаж дараа уулзах газраа тохиролцож болох юм.

“За миний явах цаг болчихлоо. Арван ес хагаст буцаж очих ёстой. Бэлгийн харилцаанд орохын эсрэг залуусын Холбоонд хоёр цаг ажиллах ёстой. Ухуулах хуудас, бас бус юм тараах ёстой. Энэ юу болж байна вэ? Үсэнд өвс наалдчихсан байна уу? За сайн арилгаарай? За тэгвэл баяртай, хайрт минь, баяртай” гэж тэрээр Смит хэлж өгсөн юмыг нь тогтоосны дараа хэлэв.

Тэрээр Смитийг тэвэрч аван шуналтай үнсчихээд тэрхэн дороо модон дундуур орж чимээгүй алга болов. Смит түүний нэр, хаягийг ч мэдэж чадалгүй үлдлээ. Энэ бол ач холбогдолгүй юм. Тэр хоёр нэг байранд уулзана, захидлаар харилцана гэж бодохын ч хэрэг байхгүй юм.

Тэр хоёр ойн цоорхойд дахин уулзаж чадсангүй. Тэд тавдугаар сард нэг л удаа уулзаж амжив. Жулия огт өөр газар, гучин жилийн өмнө атомын бөмбөг хаяхад дэлбэрч устсан сүмийн хонхонд уулзахаар болзоо тогтоосон юм. Энэ нь найдвартай нуувч газар байсан бөгөөд харин түүнд хүрэх зам нь их осолтой байв. Тэд бусад цагт гудамжинд үргэлж шинэ газар уулздаг болсон ба хагас цаг л уулзаж байв. Юутай ч гэсэн гудамжинд ярилцаж болж байсан. Тэд явган замаар бие бие рүүгээ харалгүй, мөр зэрэгцэлгүй алхаж гэрлэн дохио анивчих мэт үе үе тасалдсан хачин яриа дэлгэдэг байв. Ойр хавьд теледэлгэц байх юм уу, дүрэмт хувцастай Намын гишүүн өмнөөс нь ирж явах юм бол тэд

яриагаа дунд нь тасалдаг байв. Салж явахаар тохиролцсон газраа хүрмэгц Смит түрүүлж алхаад тасалсан яриагаа тэд дараагийн уулзалтын үеэр үргэлжлүүлдэг байв. Жулия ингэж яриад сурчихсан бололтой бөгөөд үүнийгээ сунгасан яриа гэж нэрлэдэг байв. Мөн уруулаа хөдөлгөхгүй ярих гайхмаар чадвар эзэмшсэн байлаа. Тэд нэг сарын турш орой болгон уулзаж байхдаа ганцхан удаа үнсэлцэж амжсан юм. Тэр хоёр нарийхан гудамжаар дуугүй алхаж явтал (Жулия том гудамжнаас гарч явахдаа юм ярьдаггүй юм) гэв гэнэт чих дүлийрэм чанга дуу гарч, зам доргиод бөөн хар тоос шороо дэгдэж Смитийн нүүр нь шалбарчихсан, айж эмээчихсэн газар ойчсон хэвтэж байлаа. Пуужин тун ойрхон унасан бололтой юм. Смит Жулиягийн шохой шиг хувхай цайчихсан царайг хажуудаа ойрхон харлаа. Уруул нь хүртэл цайчихсан байна. Алуулчихжээ! Тэрээр бүсгүйг тэвэрч авснаа амьд хүний халуун нүүрийг үнсэж байгаагаа мэдэрлээ, харин аманд нь нарийн тоос амтагдаж

байна. Тэр хоёрын нүүр нь нилдээ цементийн тоосонд дарагджээ.

Тэд заримдаа болзсон газраа ирээд бие бие рүүгээ харал-гүй салах тохиолдол ч гардаг байлаа. Гудамжны булангаас эргүүл гараад ирнэ, толгой дээгүүр нисдэг тэрэг эргэлдэнэ. Тэр хоёрт тохиолдох аюулаас гадна уулзах цаг гаргахад ч амаргүй байлаа. Смит долоо хоногт жаран цаг ажиллаж Жулия үүнээс ч олон цаг ажилладаг болохоор тэр хоёрын амралтын өдөр нь таарахгүй байхаас гадна ажлын их багаас хамаарч олдцог байв. Жулия лекцэнд суух, жагсаал цуглаанд оролцох, Бэлгийн харилцаанд орохын эсрэг залуусын Холбооны ном тараах, Үзэн ядах долоо хоногийн лоозон бэлтгэх, янз бүрийн сайн дурын хураамж цуглуулах гэх мэтийн ажилд гайхмаар их цаг зарцуулж байлаа. Ийм далдлан халхавчлал ашгаа өгнө гэж тэрээр ярина. Жижиг сажиг дүрэм журмыг нь сахих юм бол том дүрмийг нь зөрчиж болно. Тэрээр идэвхтэй Намын гишүүдийн ажлын бус цагаар сайн дураараа хийж буй зэр зэвсэг хийх ажилд

нэрээ бичүүлж оролцож нэг оройгоо өнгөрөөж байхыг Смитэд ятгаж чадсан юм.

Тэд хонхонд уулзахдаа өмнө тасарсан яриагаа нөхөж чаддаа. Халуу шатсан өдөр хонхны жижигхэн дөрвөлжин өрөө бүгчим халуун бөгөөд тагтааны өтөгний тэсэхүйеэ бэрх үнэр ханхална. Тэд гишүү дүүрсэн тоостой шал дээр суугаад ярилцана, нэг нь үе үе босож жижигхэн цонхоор хүн ирж буй эсэхийг харуулдана.

Жулия хорин зургаан настай, гучин залуу эмэгтэйтэй хамт нийтийн байранд суудаг (Хүүхнүүдийн өмхий үнэр бүх юманд ханхална! Хүүхнүүдийг харахаар ой гутах юм! гэж тэрээр дашрамд үглэнэ) бөгөөд Смитийн таамаглаж байсанчлан Уран зохиолын газар роман зохиодог машин дээр ажилладаг аж. Тэрээр хүчтэй, нарийн ажиллагаатай цахилгаан мотор ажиллуулдаг ба энэ ажилдаа дуртай. Хэдийгээр «авьяасгүй» боловч гараар ажиллах дуртай, техник сайн мэддэг юм. Роман зохиох бүх үйл явц, төлөвлөгөөний хорооноос өгч буй ерөнхий

чиглэлээс аваад хяналтын бүлгийн хийсэн засварыг хүртэлх бүх үйп явцыг тэрээр тайлбарлан ярьж чадна. Тэрээр эцсийн бүтээгдэхүүнээ сонирхдоггүй, «Би унших дургүй» гэж ярьсан. Түүний хувьд ном бол жимсний жигнэмэг, гутлын оосор лугаа адил өргөн хэрэглээний бараа юм.

60-аад оны дунд хүртэл юу болж байсныг тэрээр санадаггүй бөгөөд хувьсгалын өмнө юу болж байсныг санагдуулдаг түүний мэдэх ганц хүн байсан нь есөн настай байхад нь сураггүй алга болсон түүний өвөө юм. Сургуульд сурч байхдаа хоккейн багийн ахлагч байсан ба хоёр жил дараалан гимнастикийн аврага болж байжээ. Тагнуулчдын бүлгийн ахлагч байснаас гадна Бэлгийн харилцаанд орохын эсрэг залуусын Холбоонд элсэхээс өмнө Хүүхдийн Холбооны хэсгийн ахлагч байсан аж. Хаана л байна тэргүүлж байжээ. Түүнийг тэр ч байтугай уран зохиолын газрын үгээгүйчүүдэд зориулан хямдхан порно сэтгүүл гаргадаг порно тасгийн ажилд (нэр хүнд сайны шинж тэмдэг) нэрийг

нь дэвшүүлжээ. Ажилтнууд нь энэ тасгийг Өтөг бууцны хашаа гэж нэрлэдэг хэмээн Жулия ярьжээ. Жулия тэнд нэг жил ажиллахдаа «Зүтгүүйдсэн түүх», «Охидын сургуульд өнгөрөөсөн нэгэн шөнө» гэх мэт номуудыг хэвлэн гаргах ажилд оролцсон бөгөөд энэ номыг дугтуйд хийж наагаад илгээдэг, үгээгүйчүүдийн залуус хориотой ном худалдаж авч байна гэж итгээд тэдгээрийг сэмхэн худалдаж авдаг юм.

“Энэ ямар ном байдаг юм бэ?” гэж Смит асуулаа.

“Шал хэрэггүй заваан юм бий. Уйтгартай ч гэж жигтэйхэн. Зургаахан сэдэв байдаг, тэдгээрийг хялбархан зохиодог юм. Би бол холигч машин дээр л ажилласан. Ном хянах бүлэгт ерөөсөө ажиллаж байгаагүй ээ. Хонгор минь, би чинь уран зохиол ойлгохдоо тааруухан шүү дээ”.

Смит порно тасгийн ерөнхий эрхлэгчээс бусад нь залуу эмэгтэйчүүд байдгийг дуулаад гайхал төржээ. Эр хүний бэлгийн харилцаанд орох



хүслийг тогтоон барих нь эмэгтэй хүнийхийг тогтоон барихаас хэцүү гэсэн онол байдаг болохоор ийм балиар юм хийхэд эрчүүд илүү ялзрал завхралд автагдана гэж үздэг аж.

"Тэд нөхөрт гарсан эмэгтэй хүнийг ч ажилд авах дургүй. Охид бол цэвэр нандин гэж үздэг юм. Харин чиний өмнө огт өөр хүн байна шүү" гэж Жулия ярилаа.

Жулия арван зургаан настайдаа нууц амрагтай болсон бөгөөд тэр нь сүүлдээ баривчлагдахаас айхдаа өөрийгөө егүүтгэсэн жаран настай намын гишүүн хүн байсан аж. «Амиа хорлосон нь ч зөв байсан. Эрүү шүүлтээр миний нэрийг хэлүүлэх л байсан» гэж Жулия ярив. Тэрээр үүнээс хойш олон хүнтэй явсан. Түүний бодож байгаагаар амьд явна гэдэг бол амархан эд аж. Чи хэрэв баяр хөөртэй амьдарья гэж бодож байвал яах ёстой вэ. «тэд» өөрөөр хэлвэл Нам чамд саад хийхийг оролдоно, тэхлээр чи дүрмийг нь аль болохоор зөрчөөд бай. «Тэд» чиний баяр цэнгэлийг булааж авахыг оролдож

байхад чи тэдэнд баригдахгүй байхыг хичээх нь жам ёсны хэрэг мөн гэж тэрээр боддог юм шиг байна. Тэрээр Намыг үзэн яддаг, үүнийгээ хамгийн бүдүүлэг үтээр илэрхийлж байгаа мөртөө Намыг бүхэлд нь шүүмжлэхгүй байна. Жулия өөрийнх нь хувийн амьдралыг л хөндөхгүй бол Намын үзэл баримтлалыг сонирхдоггүй юм. Жулия өдөр тутмын ярианд орчихсоноос бусад Шинхэлийн үгийг хэрэглэдэггүй болохыг анзаарчээ. Тэрээр Ах дүүгийн барилдлага байгууллагын талаар сонсоо ч үгүй, тийм байгууллага байдаг гэдэгт итгэдэгчгүй. Нэгэнт л эцэстээ ялагдпаар дуусахаас л хойш аливаа зохион байгуулалттай бослого хөдөлгөөн нь тэнэглэл гэж Жулия боддог. Тоглоомын дүрмийг зөрчөөд амьд үлдэж чаддаг хүн бол ухаантай хүн мөн. Залуусын дунд, хувьсгатын дараахи орчинд өсөж буй болсон хүмүүсийн дунд, намыг тэнгэр огторгуй шиг мөнхийн халдашгүй юм гэж үздэг, түүний ноёрхолд эсэргүүцэл үзүүлдэггүй зүгээр л түүнээс туулай, нохой шиг зугтаж зайлахыг

хичээдэг хүмүүс олон бий болов уу гэж Смит санаашран өөрөөсөө асууж байлаа.

Тэд гэрлэх тухай ярьсангүй. Энэ бол дэндүү бүтэшгүй зүйл тул ярихын ч хэрэг байхгүй. Смит Кэтринээс бүрмөсөн салж чадлаа ч гэсэн ямар ч Хорёо зөвшөөрөл өгөхгүй. Энэ тухай мөрөөдөөд ч нэмэргүй.

“Чиний авгай ямар шуу хүн байсан юм бэ?” гэж Жулия асуув.

“Тэр үү? Шинхэлд *сайнсэтгэлт* гэж үг бий дээ. Утга нь төрөлхийн тууштай, муу юм боддоггүй гэсэн үг”

“Үгий нь мэдэхгүй юм байна. Ийм араншинтай хүнийг бол мэднээ. Харин ч сайн мэднэ шүү”

Смит өөрийнхөө гэр бүлийн амьдралын талаар ярьж байлаа. Жулия тэрнийх нь гол юмыг хэлүүлэлтгүй мэдэж байгаа нь гайхмаар байлаа. Жулия биед нь хүрэхэд Кэтриний бие хэрхэн

хөшиж байсан, тэвэрч байхад нь бүх хүчээрээ түлхээд байх шиг байсныг өөрийнхөө нүдээр харсан юм шиг, өөрөө биеэрээ мэдэрсэн юм шиг нэг нэггүй тайлбарлан ярьж байлаа. Смитэд Жулиятай энэ тухай ярихад хялбар байсан бөгөөд Кэтриний тухай зовиурт дурсамж аль хэдийнээ жигшил зэвүүцэл болж хувирчээ.

“Би ч тэвчвэл тэвчих л байсандаа. Гэхдээ тэвчих аргагүй байлаа. Түүнийг болиулах ямар ч арга байгаагүй юм. Тэрээр үүнийгээ юу гэдэг билээ дээ... Тааж хэлэх аргагүй байсан юм” гэж Смит Кэтриний долоо хоног бүрийн тогтсон нэг өдөр болгон хийдэг цэвдэг хүйтэн үйлддийг Жулияд ярьж өглөө.

“Манай Намын үүрэг даалгавар” гэж Жулия тэр дор нь хариулав.

“Чи яаж мэддэг юм бэ?”

“Хонгор минь би ч гэсэн сургуульд сурдаг байсан шүү. Арван зургаан нас хүрмэгц л

бэлгийн харилцааны тухай сард нэг удаа яриа хийдэг байсан. Хүүхдийн холбоонд ч ялгаагүй. Олон жилийн турш тархийг чинь утаана. Ихэнх тохиолдолд үр дүнгээ өгдөг гэж хэлмээр байна. Мэдээж хэрэг хэлэхэд хэцүү л дээ, хүмүүс хоёр нүүртэй амьтад болохоор..”

Тэрээр энэ асуудлыг дуртайяа ярьж байна. Жулия бүх юмыг өөрийнхөө бэлгийн дуршилтай холбон авч үздэг юм. Энэ сэдвийг хөндөж эхлэхэд л түүний үнэлэлт их гярхай байдаг. Тэрээр Смитийг бодвол Намын номлож буй бэлгийн цэвэр ариун байддын утга учрыг ойлгожээ. Бэлгийн дуршил нь Намд үл захирагдах өөрийн ертөнцийг бий болгодог тул түүнийг үгүй хийх ёстой гэдэгт хамаг учир байгаа юм. Бэлгийн шунал нь солиорол үүсгэдэг бөгөөд үүнийг дайны хийрхэл ба жолоодогчийг шүтэх хийрхэл болгож хувиргах нь улам чухал юм. Жулия ингэж тайлбарлалаа.

“Чи хүнтэй унтахдаа эрч хүчээ зарцуулж байна, дараа нь чи баяр баясгалантай болоод юу ч эс

тооно. Тэд чамайг ийм баяр баясгалантай байхыг тэсвэрлэж чадахгүй. Тэд чиний биед үргэлж эрч хүч буцалж байхыг хүсч байна. Энэ бүх жагсаал цуглаан, лоозон хашгирах, туг далбаа мандуулах энэ бүхэн бол бэлгийн дуршил унтарсных юм. Чи хэрвээ өөрөө аз жаргалтай юм бол Их Ах, гурван жилийн төлөвлөгөө, Үзэн ядах хоёр минут болон бусад жигшүүрт дэмий юманд сэтгэлээ хөдөлгөж байхын хэрэг юу байна вэ?”

Смит энэ бүхэн үнэн дээ гэж бодож байлаа. Бэлгийн цээрлэл ба улс төрийн тууштай баримтлал хоёрын хооронд шууд нягт холбоо байна. Ямар нэг хүчирхэг зөнг хав дарж шатахуун болгож хэрэглэхгүйгээр үзэн ядалт, айдас, мухар сүсэглэлийг хэрхэн өөрт хэрэгтэй хэмжээнд хүртэл дэвэргэж чадах юм бэ? Бэлгийн дуршил Намд аюултай, Нам түүнийг өөртөө үйлчилдэг болгосон юм. Эх эцгийн зөн бэлгийн хувьд мөн ийм бач хэрэглэсэн болно. Гэр бүлийг үгүй хийж болохгүй, урьдын байсан үр хүүхэддээ хайртай байх ёсыг хадгалж үлдсэн.

Хүүхдүүдийг эцэг эхийнх нь эсрэг байнга хандуулдаг, эцэг эхээ араас нь тагнах, буруу үйлдэл бүрий нь талаар мэдээлэхэд сургадаг юм. Үнэн хэрэг дээрээ гэр бүл нь Сэтгэхүйн Цагдаагийн үргэлжлэл нь болжээ. Хүн бүрт ойр дотных нь хүнийг мэдээлэгч болгожээ.

Смит дахиад л Кэтринийг бодож байна. Кэтрин тийм тэнэг биш байгаад Смитийн тэрсүү үзэлтэй гэдгийг мэдсэнсэн бол Сэтгэхүйн Цагдаад гарцаагүй мэдээлэх байсан. Шатсан халуун нар, бүгчим агаар, духнаас нь дуслах хөлс авгайнх нь талаар санууллаа. Тэрээр арван нэгэн жилийн өмнө өөрт нь юу тохиолдсон тухай, үнэндээ бол юу тохиолдоогүй тухай Жулияд ярьж байлаа.

Энэ явдал гэрлэснээс хойш гурав юм уу, дөрвөн сарын дараа болсон юм. Кентийн хавьд аялалд явж байгаад тэр хоёр бусдаасаа хоцорчихож билээ. Хоёр гурван минут сандарч гүйж байгаад замаа алдаад шохойн чулуу гаргаж байсан хонхорт тулж очсон юм. Урд нь хорь, гучин метр

гүнзгий нүх байлаа, ёроолд нь том бул чулуунууд харагдана. Зам асуух хүн байсангүй, Кэтрин төөрчихлөө гээд их сандарч байна. Хөгжиж шуугисан аялагчдаасаа жаахан хоцорчихно гэдэг нь түүний хувьд зөрчил байлаа. Кэтрин нөгөөдүүлээ хайхаар буцаж гүйх гэж завдаж байтал Смит чулуун хадны ирмэг дээр тэрэм цэцэг сагсайж ургасныг харлаа. Нэг үндэснээс ургасан хоёр цэцгийн нэг нь час улаан, нөгөө нь хүрэн өнгөтэй аж. Смит ер нь ийм цэцэг үзээгүй болохоор Кэтринийг дуудлаа.

“Кэтрин, хараач ээ! Ямар гоё цэцэг вэ. Тэр бутны ёроолд байна. Харж байна уу, хоёр өнгөтэй юм?”

Кэтрин нилээд хол явчихсан байснаа уцаарлан буцаж ирээд Смитийн заасан цэцгийг үзэхээр нүхний аман дээр гарлаа. Смит түүний ард нь гараад бүсэлхийнээс нь барьж зогслоо. Смитэд биднээс өөр хэн ч энд алга гэсэн бодол төрлөө. Нэг ч хүн алга, цэцэгний навч ч хөдлөхгүй байна, шувуу ч жиргэхгүй байна. Ийм газар



нууц микрофон байхвий гэж айх хэрэггүй, байлаа ч гэсэн чимээнээс өөр юу мэдрэх юм бэ? Үд дөнгөж хэвийсэн хав халуун, нойр хүргэсэн үе байлаа. Нар дээрээс шарж хацар даган хөлс гоожиж байлаа. Түүний толгойд ингэчихвэл яадаг юм бэ гэсэн бодол...

“Түлхчихгүй яасан юм бэ хонгор минь. Би л байсан бол түлхчих байсан юм”

"Тийм ээ, хонгор минь чи бол түлхчих байсан. Би одоогийнх шигээ байсан бол түлхчих байсан. Магадгүй... Гэхдээ сайн мэдэхгүй байна”

"Түлхээгүйдээ харамсаж байна уу?"

"Тийм ээ, Ер нь бол харамсаж байна”

Тэр хоёр тоостой шалан дээр зэрэгцэн сууж байна. Тэрээр бүсгүйг өөр рүүгээ татвал тэрээр толгойгоо Смитийн цээжин дээр тавихад түүний үс тагтааны өтөгнөөс хүчтэй үнэртэж байна. Бүсгүй ч их залуу, тэгээд амьдралаас ямар нэг

юм хүсэж байгаа, муухай санагдсан хүнээ өндөр дээрээс түлхсэнээр юу ч шийдэхгүй гэж Смит бодож байлаа.

“Үнэндээ ингэх нь юу ч өөрчлөхгүй л дээ”

"Тэгвэл түлхчихсэнгүй гэж юунд харамссан юм бэ?"

“Үйлдэл бол зүгээр байснаас дээр гэж боддогтоо л харамсаж байна. Бид энэ тоглоомондоо хожиж чадахгүй. Зарим нэг бүтэлгүйдэл нь бусад бүтэлгүүддээсээ дээр юм, ийм л байна” Жулия дургүйцэн толгойгоо сэгсрэв. Смитийг иймэрхүү юм ярихад тэрээр санал нийлдэггүй, хувь хүн дандаа ялагддаг тухай байгалийн хуулийг зөвшөөрдөггүй юм. Тэрээр эрт орой хэзээ нэгэн цагт Сэтгэхүйн Цагдаа өөрийг нь барьж аваад ална гэдгийг сэтгэлийнхээ гүнд мэдэж байсан ч гэсэн өөрийн далд ертөнцөд дураараа амьдарч болно гэж итгэдэг байлаа. Ингэж амьдрахад аз хийморь, заль мэх, эр зориг л хэрэгтэй юм. Тэрээр мөн

аз жаргал гэдэг юм байхгүй, ялалт бол алсын ирээдүйд л ирэх бөгөөд тэр үед миний бие аль хэдийнээ алга болчихсон байна, чи Намд дайн зарласан тэр цаг үеэс өөрийгөө үхдэл гэж бодсон нь дээр гэдгийг ойлгодоггүй юм.

“Бид бол хүүр юм” гэж Смит хэллээ.

“Арай ч хүүр болоогүй ээ” гэж Жулия түүний үгийг засаж хэллээ.

“Бие мах бодиороо биш л дээ. Хагас жилийн ч юм уу, жилийн дараа... таван жилийн дараа гэж бодъё л доо. Би үхэхээс айдаг. Чи залуу болохоор надаас илүү айдаг байж таарна. Бид мэдээж үхлийн цагийг аль болохоор хойшлуулахыг хичээнэ. Тэхдээ ямар ч ялгаа байхгүй. Хүн хүнээрээ байгаа цагт амьд явах, үхэх хоёр бол адилхан юм”

-“Пөөх яасан дэмий юм ярьдаг юм бэ. Чи хэнтэй унтмаар байна вэ, надтай юу аль эсвэл араг

ястай юу? Чи амьд байгаадаа баярлахгүй байна уу? Чамд энэ бүх юмыг мэдрэхэд аятайхан бус

байна уу. би байна, энэ миний гар, миний хөл, би явж байна, би амьсгалж байна, би амьд байна! Энэ чамд таалагдахгүй байна уу?” Жулия эргээд цээжээрээ түүнд наалдлаа. Тэрээр бүсгүйн том, хатуу хөх баадай нэвт шүргэж байгааг мэдэрч түүний бүх биед бүсгүйн залуу нас, эрч хүч гүйж байх шиг байлаа.

-“Энэ бүхэн надад таалагдаж байна”.

-“За тэгвэл үхлийн тухай ярихаа болиорой. Одоо чи сонсож бай, дараагийнхаа уулзалтын талаар тохиролцье. Нөгөөх ой дахь газар луугаа очиж болох юм. Тэнд очилгүй нилээд уддаа. Чи харин өөр замаар явах хэрэгтэй. Би бүх юмыг бодчихсон. Галт тэргэнд суугаад... За жаахан хүлээж бай, би чамд зураад өгье”

Тэрээр гишүү авч хэзээний ажил хэрэгч байдлаар шалны шороон дээр зураг зурж гарлаа.



## IV

Смит ноён Чаррингтоны мухлагийн дээд талын нооронхой өрөөг харж зогсоно. Цонхны дор шалдан тэнгэлэгтэй том орыг уранхай бүтээлгээр хучиж засчээ. Задгай зуухан дээр арван хоёр тоотой хуучны цаг цохилж байна. Өрөөний булан дахь эвхдэг ширээн дээр түүний авчирсан бөөрөнхий шил гялалзана.

Задгай зуух дотор ноён Чаррингтоны өгсөн хуучин керосин халаагуур, хувин, хоёр аяга байна. Смит керосин халаагуурыг асааж дээр нь хувинтай ус тавилаа. Тэрээр бүтэн дугтуйтай «Виктори» хэмээх кофе, чихэр орлуулагч авчиржээ. Цаг 19. 20 болж байна, Жулия 19. 30-д ирэх ёстой.

Тэнэг хэрэг, тэнэг хэрэг! гэж түүний зүрх сэтгэл нь давтаж байна, өөрийгөө баллах цамаан зан, тэнэг хэрэг! Намын гишүүний үйлдэж болох бүх гэмт хэргээс ийм хэргийг нуухад хамгийн хэцүү

нь юм. Үнэндээ энэ санаа эвхдэг ширээн дээрх бөөрөнхий шил дотор хүсэл мөрөөдөл болон харагдсан билээ. Түүний төсөөлж байснаар ноён Чаррингтон өрөөгөө ямар нэг төвөг удалгүй хөлслүүлсэн болно. Тэрээр хэдэн доллар сул олохдоо баяртай байх шиг байсан. Смит энэ өрөөг нууц амрагтайгаа уулзахад ашиглах юм гэдгийг тэр мэдээд гайхсан ч үгүй, дургүйцсэн ч үгүй. Ноён Чаррингтон нүд буруулан хараад эелдгээр аар саар юм ярьж байхдаа үл харагдагч болж хувирах шиг байлаа. Хүн амар амгалан байх нь их чухал шүү гэж тэрээр ярьж байв. Хүнд үе үе ганцаараа амар амгалан баймаар санагддаг юм. Хүн тийм газар олоход нь тэрнийг нь мэддэг хүн эелдэг зангаа бодсон ч гэсэн хүнд ярихгүй байх ёстой. Тэрээр ажиг сураггүй алга болж буй юм шиг сэтгэгдэл төрүүлснээ, байшинд хоёр хаалга бий, арын хаалгаар нь хашаагаар дамжаад гудамжинд гарч болдог юм гэж ярьжээ.

Хэн нэгэн цонхны дор дуу дуулж байхаар нь Смит мосул даавуун хөшигний ард зогсоод

чагнаа. Зургадугаар сарын үд дунд болж буй тул нарны гэрэл хурц туссан хашаан дотор нэгэн Нормандын багана шиг том биетэй, наранд шарласан булчинлаг бугуйтай, хормогчоо урдуураа бөөчихсон хижээл эмэгтэй өлгөөстэй дөрвөлжин цагаан даавуу, түмпэн хоёрын хооронд алхана. Өлгөөстэй даавуу нь нялх хүүхдийн шээсний цагаан даавуу болохыг Смит мэдлээ. Тэр эмэгтэй амандаа зуусан хавчуураа дээсэнд хавчуулмагцаа хүчирхэг бүдүүн хоолойгоор дуулж байлаа.

*Сэтгэл зүрхэнд хоногшсон мөрөөдөл минь*

*Хаврын анхны өдөр шиг алга болжээ*

*Зүүдэнд минь харагдсан харц, чихэнд дуулдсан уг чинь*

*Сэтгэл зүрхийг минь сугалчихлаа!*

Энэ дуу Лондон хот даяар сүүлийн өдрүүдэд таран түгсэн юм. Хөгжмийн газрын тусгай тасаг



дууны үгийг үгээгүйчүүдэд зориулан маш олноор нь үйлдвэрлэсэн. Үгийг нь хүний оролцоогүй «шүлэг зохиогч» гэдэг аппаратаар зохиосон юм. Тэр эмэгтэй дууг их аятайхан дуулах тул чихэнд сонсголонтой аж. Смит эмэгтэйн дуулах, чулуулсан замаар явах түүний гутлын чимээ, гудамжнаас гарах хүүхэд хашгирах чимээ, холоос сонсдох гудамжны хөдөлгөөний нүргээнийг сонсож зогсоход өрөөнд гайхмаар нам гүм байна. энд теледэлгэц байхгүй аж.

Тэнэг хэрэг, тэнэг хэрэг! гэж тэрээр дахиад л боддоо. Хэдэн арван хоног энд уулзаж байх, тэгээд баригдахгүй байна гэдэг бол боломжтой хэрэг үү? Өөрийн гэсэн холгүй байртай байх юмсан гэсэн тэр хоёрын хорхой дэндүү их хүрч байв. Хонхонд уулзсанаас хойш тэр хоёр дахиад уулзаж огт чадаагүй билээ. Үзэн ядах долоо хоногийн ажлын үеэр ажлын цагийг уртасгасан юм. Энэ ажил эхлэхэд сар гаруйн хугацаа үлдэж байсан боловч түүнд бэлтгэх нарийн төвөгтэй ажил хүн бүрт нэмэгдэл ачаалал өгч байлаа.

Эцсийн бүлэгт Жулия Смит хоёр нэгэн өдрийн үдээс хойш цаг зав гаргаж чаддаа. Ойн цоорхойд очьё гэж тохирцгоожээ. Тэд бөөн хүний дундуур бие бие рүүгээ явж байхдаа Смит дадал болсноороо Жулия руу харалгүй өнгөрөхдөө царай нь цайчихсаныг зэрэвсхэн хараад л мэдсэн юм.

“Бүх юм бүтэхгүй нь. Би маргааш болох уулзалтын тухай ярьж байна” гэж Жулия ярилцаж болмоор болмогц шивнэн хэллээ.

“Юу гэнээ?”

“Маргааш. Үдээс хойш чадахгүй нь”

“Яав?”

“Жирийн шалтгаан. Энэ удаа эрт эхэлчихлээ”

Тэрээр анхандаа их уурласан ч танилцсанаас хойш сарын дараа Жулияд огт өөрөөр тэмүүлэх болжээ. Эхэндээ жинхэнэ хүсэл тачаал бага

байсан юм. Тэдний анхны бэлгийн хавьтал бол хүсэл зоригийн үйлдэл байлаа. Харин хоёрдахийн дараа өөр хэрэг болсон. Бүсгүйн үсний үнэр, уруулын амт, биед нь хүрэхэд төрсөн мэдрэмж энэ бүхэн түүний дотор нэвтэрч, эргэн тойронд нь тарах шиг болсон. Тэр бүсгүй түүний бие сэтгэлийн хэрэгцээ болсон ба түүнийг хүсээд зогсохгүй, түүнийг эзэмших эрхтэй юм шиг түүнд санагддаг болсон юм.

Бүсгүй ирж чадахгүй нь гэж хэлмэгц л намайг хуурч байна гэсэн бодол түүнд төрсөн. Яг энэхэн мөчид бөөн хүний шахцалдаан тэр хоёрыг ойртуулж гараа барихад хүргэсэн. Бүсгүй түүний хурууны үзүүрийг чанга атгахад энэ нь уур хилэнг бус хайр сэтгэлийг хүсэж байх шиг байсан. Эмэгтэй хүнтэй хамт амьдарч байхад санаа сэтгэлээр ийм унах юм гарах нь зүйн хэрэг бөгөөд давтагдах нь ч зайлшгүй гэж тэрээр бодов. Тэгээд түүнд урьд нь огт байгаагүй энхрийлэх сэтгэл төрлөө. Бид хоёр

нөхөр эхнэр байсан ч болоосой, арван жил хамт амьдарсан ч болоосой гэж тэрээр боддоо.

Бүсгүйтэй хамт гудамжаар айх бэргэх юмгүй, нуугдаж хоргодох юмгүй аар саар юм ярьсан шиг, гэртээ элдэв шалдав юм худалдаж авсан шиг ачхах юмсан гэж тэрээр боддоо. Уулзаж учрах бүртээ өвөр түрийдээ заавал орох албагүй хоёулхнаа байх газартай ч болоосой гэж хамгийн их хүсч байлаа. Үнэндээ чухамхүү тэрхэн хоромд бус маргааш өдөр нь ноён Чаррингтоны өрөөг хөлсөлж суух санаа түүнд төрсөн юм. Тэрээр энэ санаагаа Жулияд хэлэхэд цаадах нь харин тэр дороо зөвшөөрсөн билээ. Энэ бол тэнэглэл гэдгээ хоёулаа мэдэж байсан. Энэ нь тэр хоёр хоёулаа санаатайгаар булшиндаа ойртон ирж байгаа юм шиг үйлдэл байв. Тэр орны ирмэг дээр суугаад Хайрын Яамны яс цоожны өрөөний тухай бодож байлаа. Зайлшгүй тохиолдох энэ аймшиг ухаан санаанд орж гарч байдаг нь сонин юм. Тэрээр чамайгаа ирээдүйд хүлэЭж байгаа нь зуугийн араас ерэн ес заавал дагадаг шиг үхэл ч чамайг дагаж

байна. Үүнийг зайлуулах арга байхгүй, харин түүний ирэх хугацааг холдуулж болох байх аа, харин чи үүний оронд түүнийг санаатайгаар, сайн дураараа ойртуулж байна.

Шатан дээгүүр хэн нэгний хурдан явах чимээ гараад Жулия өрөөнд гүйн орж ирлээ. Тэрээр багаж хэрэгслээ хийдэг хүрэн брезентен цүнхээ барьжээ. Яаман дээр ийм цүнх барьж явахыг нь Смит нэг бус удаа харсан билээ. Тэрээр түүнийг тэвэрч авах гэтэл Жулия гартаа байгаа цүнхийг тавих гэсэн бололтой хажуу тийшээ зайлсхийв.

“Хүлээж бай. Би чамд юу авчирснаа үзүүлье. Чи нөгөөх заваан «Виктори» гэдэг кофегоо авчирсан биз дээ? Тэгж л таарна. Тэрний хэрэг байхгүй, байсан газар нь буцаагаад аваад яваарай. Бидэнд хэрэггүй. Харж байна уу?”

Тэрээр өвдөглөж суугаад цүнхээ уудалж дээрээс нь эрэг шурагны түлхүүр, эрэгдэгч гаргаж асгалаа. Тэдгээрийн доор нь цаасан уутанд боодолтой юм байна. Смит анхны боодлыг

тэмтрэхэд түүний дотор нэг л хачин, гэхдээ мэддэг ч юм шиг, элс шиг хүнд зүйл байна.

“Энэ элсэн чихэр үү?” гэж тэрээр асуулаа.

“Жинхэнэ элсэн чихэр. Чихэр орлуулагч биш, элсэн чихэр. Бас нэг талх байна, жинхэнэ цагаан талх, бидний иддэг балиар юм биш ... лааз чанасан жимс байна. Лааз сүү бас байна ... харж байна уу? Миний гол бахдал энэ байна!.. гүйн тул уутанд хийсэн юм..”

Тэрээр юунд уутанд хийснээ тайлбарлах хэрэг алга. Түүний хүчтэй сэтгэлд бүлээн үнэр өрөөгөөр дүүрлээ, энэ үнэрийг хаа нэг мэдрэх явдал одоо ч үе үе тохиолддогч гэсэн бага насны дурсамжийг санагдуулна. Энэ үнэр гадаа явж байхад хаалга онгойход үнэртээд өнгөрнө, гудамжинд олон хүний дунд гэнэт тараад тэр дороо сарниж алга болно.

“Кофе байна. Жинхэнэ кофе байна” гэж тэрээр амандаа үглэлээ.

“Дотуур Намынхны кофе. Бүтэн килограмм кофе”

“Чи энэ бүхнийг яаж олов оо?”

“Дотуур намынхны хүнсний зүйл. Энэ гахайнуудад бүх юм бий. Мэдээж хэрэг зарц, хоол зөөгч нар нь хулгайлж л байгаа шүү дээ... Хараач, бас боодол цай байна”

Смит түүний хажууд сөхөрч суугаад цайны боодлыг задаллаа. “Жинхэнэ цай байна. Үхрийн нүдний навч биш байна” “Сүүлийн үед цай гарч байгаа. Энэтхэгийг эзэлсэн ч бил үү, иймэрхүү юм болсон гэсэн шүү” гэж тэрээр итгэлгүйхэн хэллээ. “Хүүш ээ, хонгор минь. Хэдэн минут цаашаа хараад сууж байгаарай, за юу? Орны нөгөө талд сууж бай. Цонхонд бүү ойртоорой. Намайг хэлтэл эргэж харж болохгүй шүү”

Смит мосул даавуун хөшигний цаанаас харж сууна. Хүрэн улаан гартай эмэгтэй өлгөөтэй олс, тэвш хоёрынхоо хооронд нааш цааш явсаар

л байна. Тэрээр амандаа зуусан хоёр хавчаараа хавчаад сэтгэл нь хөддөн дуулж байна.

*Бүхнийг цаг хугацаа эдгээнэ гэж хэлж л байг*

*Бүх зовлон зүдүүр мартагдана гэж хэлж л байг*

*Он жилүүдийн инээмсэглэл, нулимс*

*Зүрх сэтгэлийг минь харин догдлуулсаар л байна!*

Тэр эмэгтэй энэ солиотой дууг цээжээр мэддэг бололтой. Түүний хоолой зуны зөөлөн агаарт аз жаргалтай өнгөрсөн цагийг санагдуулан уянгапан эгшиглэнэ. Тэрээр зуны энэ үдэш хэзээ ч дуусахгүй, цагаан даавуу нь барагдахгүй байвал сэтгэл хангалуун байх юм шиг бөгөөд юу ч хамаагүй дуулаад л цагаан даавуугаа мянган жил ч өлгөсөөр байхад бэлэн юм шиг байна. Смит Намын гишүүн хүн гав ганцаараа өөрөө өөртөө дуулж байхыг ерөөсөө үзээгүй нь яасан хачин юм бэ гэж гайхан бодож байлаа.



Ингэх юм бол хүн өөртэйгөө ярьж байгаа юм шиг дураараа сэтгэж байна, хачин зан гаргаж байна гэж үзэх байсан. Хүмүүс өлсгөлөнгийн ирмэг дээр байхдаа л дуулах юмтай байдаг байж ч болох юм.

“За одоо эргэж харж болно” гэж Жулия дуугарлаа.

Смит эргэж хараад түүнийг таньсангүй, түүнийг нүцгэн байх юм гэж бодсон чинь тэгсэнгүй. Бүсгүйд гарсан өөрчлөлт нүцгэн байснаас ч илүү гайхал төрүүллээ. Тэрээр нүүрээ буджээ.

Тэрээр үгээгүйчүүдийн аль нэг мухлагт сэмхэн ороод баахан оо энгэсэг худалдаж авсан байж таарах нь ээ. Уруулдаа час улаан будаг түрхчихсэн, хацартаа энгэсэг түрхчихсэн, хамартаа оо тавьчихсан, тэр ч байтугай нүдээ будчихсан нь улам цоглог харагдуулна. Смит Намын гишүүн эмэгтэй хүн нүүрээ будсан байхыг үзээ ч үгүй, тэгнэ гэж бодож ч байгаагүй юм. Жулия гайхмаар хөөрхөн болчихсон бөгөөд

нүүрнийхээ энд тэнд жаахан оо энгэсэг тавьчихсан нь улам гоо үзэсгэлэнтэй, хамгийн гол нь улам хүүхнэрхүү болжээ. Богино үс, эрэгтэй хүүхдийн баадай нь улам ч илүү сэтгэгдэл төрүүлнэ. Смит Жулияг тэврэхэд түүнээс нийлэг нил цэцгийн үнэр ханхаллаа. Смит доод хонгилын бүдэгхэн гэрэлтэй гал тогооны өрөө, нөгөөх эмэгтэйн хадан агуй шиг амыг саналаа. Жулиягаас мөн тийм л сүрчиг үнэртэж байна, гэхдээ энэ ямар хамаатай юм бэ.

“Сүрчиг байна!” гэж тэрээр хэлэв.

"Тийм ээ, хонгор минь, сүрчиг шүү. Чи намайг одоо яах гэж байгааг мэдэж байна уу? Би хаа нэг газраас жинхэнэ дашинз олоод энэ заваан өмдний оронд өмсөнө. Торгон оймс, өндөр өсгийтэй шаахай өмсөнө. Энэ өрөөнд би эмэгтэй хүн болно, нөхөр биш!"

Тэр хоёр хувцсаа тайлаад улаан модон том орон дээр гарлаа. Смит анх удаагаа түүний өмнө хувцсаа тайлав. Тэрээр өнөөг хүртэл туранхай

цагаан бие, хөлийнхөө хөх судас, шагайныхаа улаан толбоноос ичдэг байсан юм. Орон дээр цагаан даавуу байхгүй, дэвсгэр нь сэмэрчихсэн зөөлөн бөгөөд ор нь өргөн, намалзсан зөөлөн гудаастай нь тэр хоёрт аятайхан байлаа.

“Бясаа ч үй түм байх даа. За тэр ч ямар хамаа байсан юм, тийм ээ?” гэж Жулия ярилаа. Өнөө үед үгээгүйчүүдийн гэрээс өөр газарт хоёр хүний ор үзэгдэхээ больжээ. Смит хүүхэд ахуй цагтаа ийм ор дээр унтдаг байсан. Жулия ийм ор дээр унтаж байснаа ерөөсөө санахгүй байна.

Тэр хоёр нэг хэсэгтээ унтчихсан бөгөөд Смит сэрээд хартал цагийн зүү есийг зааж байна. Жулия гар дээр нь толгойгоо тавьчихсан унтаж байна. Түүний нүүрний будагны ихэнх нь Смитийн нүүр, дэрэнд наалдчихсан байх ба нүүрэнд нь үлдсэн жаахан будаг хацрын нь товгорын гоёыг илтгэнэ. Жаргаж буй нарны шар гэрэл орны хөл, задгай зууханд тусаж задгай зуухан дээр хувинтай ус буцалж байна. Хашаан дотор нөгөөх эмэгтэй дуулахаа больчихсон,

гудамжнаас хүүхдүүд хашгирах дуу сулхан дуулдана. Смит арилгачихсан өнгөрсөн цаг үед зуны сэрүүхэн орой эрэгтэй, эмэгтэй хоёр хүн шачдан нүцгэн ийм ор дээр хэвтээд хүссэн үедээ энгэр зөрүүлж, дуртай юмаа ярилцаж, гаднаас гарах амгалан чимээ шуугианыг сонсож, босох ямар ч шаарддагагүй хэвтэж байсан болов уу гэж сонирхон бодно. Ийм юм хэвийн юм шиг цаг хугацаа ер нь ч байсан уу? Жулиа сэрж нүдээ нухлаад тохой дээрээ өндийгээд задгай зуух руу харлаа.

“Усны хагас нь буцчаад ширгэчихсэн байна. Би босоод одоохон кофе хийе. Бидэнд цаг байна. Танай байрны гэрлийг хэдэн цагт тасалдаг вэ?”

“Хорин гурав гучид”

“Нийтийн байранд хорин гурван цагт тасалдаг юм. Түүнээс өмнө байрандаа орохгүй бол... Хүүе! Балиар амьтныг дээ, чамайг!” Тэрээр гэв гэнэт орон дээгүүр тэрийж үсрээд шалан дээрээс шаахайгаа шүүрч аваад Хоёр минут

Үзэн Ядалтын үеэр Голдштейн рүү толь бичгийн ном шидсэн шигээ эрэгтэй хүүхэд шиг гараа далайн өрөөний булан руу аль байдгаараа шидэж орхив.

“Юу болоод байна вэ?”.

“Харх байна. Хананцарын цаанаас толгой нь цухуйж байхгүй юу. Тэнд үүртэй юм. Муу новшийг хөөчихчөө шүү”

“Харх гэнээ! Энэ өрөөнд байдаг байх нь ээ?”

“Тийм ээ, зөндөө байгаа. Зарим газар бужигнаж байдаг юм. Харх хүүхэд рүү довтолдгийг чи мэдэх үү? Довтлоно оо. Зарим газар эх нь нялх хүүхдээ орхиж болдоггүй юм. Хамгийн муухай нь, энэ муу хогнууд чинь..”

“Боль доо!”

“Хөөрхий амьтан! Царай чинь бүр цайчихжээ. Яасан бэ? Хархнаас айдаг юм уу?”

“Харх... Энэ хорвоод үүнээс өөр аймшигтай юм байхгүй” Жулия түүнийг өөрийнхөө биеэр тайтгаруулах гэсэн юм шиг гараараа тэвэрч аваад хөлөө өвдөг дээр нь тавьжээ. Тэрээр насан туршид нь өөрийг нь зовоосон нөгөөх танил айдастаа хэдэн хором автсан юм шиг байлаа. Тэрээр хав харанхуй хананы өмнө зогсож байлаа, хананы цаана тэсвэрлэшгүй харахад нүд хальтирмаар аюумшигтай юм байна. Зүүдэн дундаа харанхуй хананы цаана юу байгааг сайн мэддэг болохоор өөрийгөө хуурч байна гэсэн сэтгэгдэл төрдөг байлаа. Тархин дотроосоо нэг хэсгийг нь гаргаад хаяж байгаа юм шиг асар их хүч гарган тэр юмыг ил гаргаж ч чадахсан билээ. Тэхдээ нөгөө юм нь юу болохыг мэдэж чадалгүй сэрчихдэг юм. Харин Жулиягийн дуусгаагүй яриа тэрхүү аймшигтай юманд хамаатай юм.

“Уучлаарай, зүгээр, зүгээр. Харх харах дургүй, өөр юм байхгүй”

“Бүү санаа зов доо, хонгор мннь. Энэ новшнуудыг ийш нь оруулахгүй дээ. Явахдаа нүхийг нь бөглөчихнө. Дараа шохой авчраад сайн бөглөчихнө”

Бажигдал сандрал харанхуйлсан мөчүүд мартагдаж эхэллээ. Смит бага зэрэг ичингүйрэн орны толгойд суулаа. Жулия орноос босч хөх баадайгаа өмсөөд кофе чаналаа. Хайруулаас дэндүү хүчтэй, хамар цоргисон үнэр гарч буйг гаднаас хэн нэгэн мэдээд юу вэ гэж сонирхож болох тул тэр хоёр цонхоо хаажээ. Кофе уухад хамгийн хорхой хүргэм нь түүний амтанд биш, харин олон жил чихэр орлуулагч хэрэглэсээр байгаад мартчихсан, хэлэнд амтагдах чихрийн гоё амт байлаа. Жулия нэг гараа халаасандаа хийчихсэн, нөгөө гартаа жимсний чанамалтай бутерброд барьчихсан өрөөн дотуур нааш цаашаа алхан номын тавиур дээрх номнуудыг нэг харж, эвхдэг ширээг хэрхэн засах тухай ярьж, хэр зэрэг тав тухтайг нь үзэх гэж зөөлөн сандалд сууж босоод арван хоёр цагийн хуваарьтай цагийн нүүр рүү хөгжилтэй бөгөөд

хүлцэнгүй харж байлаа. Тэрээр бөөрөнхий шилийг гэрэлд ойрхон харах гэж ор руу авчирлаа. Смит бөөрөнхий шилийг гартаа аваад доторхи борооны дусал шиг гүнийг нь дахин нэг бахдан харлаа.

“Энэ юунд хэрэгтэй юм бэ?” гэж Жулия сонирхов.

“Юунд ч хэрэггүй байх аа... юунд ч хэрэглээгүй юм билээ. Тийм болохоороо надад таалагдаж байгаа юм. Хувирган өөрчлөхөө мартчихсан түүхийн жижигхэн тасархай л юм даа. Хэрэв уншиж чадцагсан бол энэ нь зуун жилийн өмнөх үеийн ажиг сураг мөн” “Хананд өлгөөтэй тэр зураг. Үнэхээр өнгөрсөн зууных уу?” гэж Жулия толгойгоороо дохин хэллээ.

“Тэрнээс эртнийх ээ. Хоёр зуун жилийн өмнөх үеийнх байх аа. Хэлэхэд хэцүү л дээ. Одоо ямар ч юмны насыг тогтоох аргагүй болж дээ”

Жулия зурганд ойртож очоод зогслоо.



“Эндээс нөгөө балмад амьтны нүүр цухуйж байдаг юм. Энэ юун байшин бэ? Би үүнийг хаа нэг газар үзсэн юм байна”

“Энэ бол сүмийн байшин, юутай ч сүм байсан юм. Даничуудын Гэгээн Клементийн сүм гэдэг нэртэй байсан юм. Гэгээн Клементийн сүм амтат зүрж, нимбэг гэж дуудна” гэж тэрээр ноён Чаррингтоны заасан шүлгийн эхийг санаж хэллээ.

Жулия түүний гайхлыг төрүүлэн.

Фартинг надад өг! гэж Гэгээн Мартинг дуудна  
Өрөө төл! гэж Олд-Бейли уурлан дуудна.

Цааш нь юу билээ санахгүй байна. Харин яаж төгсдөгийг нь санаж байна. «За одоо хэдэн лаа асаая, чи орондоо орж болно. За одоо хурц илдээ авья, толгойг чинь тас цавчья»

Энэ нь нууц үг, түүний хариулт шиг байлаа. «Олд-Бейли»-ийн дараагаар өөр бас юм байх

ёстой. Ноён Чаррингтонтой аятайхан харилцах юм бол түүний ой ухаанаас дахиад юм гаргаж болно.

“Хэн чамд үүнийг зааж өгсөн юм бэ?” гэж тэрээр асуулаа. “Өвөө маань зааж өгсөн юм. Намайг жаахан охин байхад тэр надад хэлж өгсөн юм. Намайг найман настай байхад түүнийг ууршуулчихсан юм, ямар ч л гэсэн тэрээр сураггүй алга болсон юм. Ямар нимбэг байлаа даа. Нимбэгийг би үзсэн. Шаравтар өнгөтэй, хурц үнэртэй жимс бий” гэж Жулия гэнэт ярилаа.

“Би нимбэгийг санаж байна. Тавиад онд зөндөө байсан юм. Их исгэлэн, үнэртэхэд л шүлс гоожно” гэж Смит хэлэв.

“Зурагны ард лав бясаа байгаа байх. Яаж ийгээд түүнийг аваад сайн цэвэрлэнэ дээ. Бид явах нь зүйтэй байх аа. Би бас нүүрнийхээ будгийг сайн угаах хэрэгтэй байна. Яасан харамсалтай юм бэ!

Дараа нь чиний нүүр дээрх уруулын будгийг арилгая”

Смит хэдэн мөч хэвтлээ. Өрөөнд харанхуй орж байхад тэрээр гэрэл рүү хараад бөөрөнхий шилээ ажиглаж байв. Тэрээр шүрийг бус шилний доторхыг сонирхон харж байлаа. Шил нь гүн гүнзгий, тэгсэн мөртлөө агаар шиг тунгалаг аж. Шилний гадаргуу нь бүхэл бүтэн дэлхийг агаар мандалтай нь хамт хумисан нуман хаалга шиг байх юм. Смитэд шилний дотор орж болох юм шиг, аль хэдийнээ дотор нь орчихсон байна, тэр өөрөө, улаан модон ор, цаг, сийлбэр зураг, бөөрөнхий шил, гэж санагдана. Бөөрөнхий шил бол түүний суугаа өрөө, шүр бол тунгалаг шилний голд мөнхжүүлсэн Жулиягийн болон өөрийнх нь амь нас юм.

Сайм алга болжээ. Тэрээр өглөө ажилдаа ирсэнгүй, зарим болгоомжгүй хүмүүс түүнийг алга байна гэж ярьж байлаа. Маргааш нь хэн ч түүнийг дурссангүй. Смит гурав дахь өдөр нь Баримтжуулалтын газрын үүдний өрөөгөөр орж зарлалын самбар үзэхэд Саймын ордог Шатрын хорооны гишүүдийн хэвлэмэл нэрсийн жагсаалт өлгөөтэй байлаа. Нэрсийн жагсаалт яг л урьдынхтайгаа адилхан, харин нэг нэрээр дутуу аж. Бүх юм ойлгомжтой боллоо. Сайм оршихоо больжээ, тэрээр хэзээ нэгэн цагт оршиж байгаагүй.

Жигтэйхэн халуун өдрүүд байлаа. Яамны дотор, цонхгүй бүхээг дотор салхилуулагч хэвийн температурыг барьж байгаа ч гэсэн гудамжны явган зам хөл халуу оргиулж метро дотор тэсэхийн аргагүй өмхий үнэртэж байлаа. Үзэн ядах долоо хоногийн бэлтгэл ажил ид эрчээ авч яамны ажилтнууд илүү цагаар ажиллаж байлаа.

Жагсаал, хурал цуглаан, цэргийн парад, лекц, үзэсгэлэн, лаван дүрсний үзэсгэлэн, телевизийн тусгай хөтөлбөр, энэ бүхнийг зохион байгуулах хэрэгтэй байсан, индэр давцанг барих, хөшөө угсрах, лоозон уриаг эцэслэн хянаж гаргах, шинээр дуу зохиох, дэл сул хов живийг тарааж түгээх, фото зургийг хуурамчаар үйлдэх хэрэгтэй байлаа. Жулиягийн ажилладаг Утга зохиолын газрын тасагт романуудын дотроос зэрлэг явддын талаархи хэсгийг сугалан авч товхимол болгон тарааж байлаа. Смитэд ердийн ажлаас нь гадна «*Таймс*»-ын үдээстэй хувиуд дээр илтгэлд иш татахад зориулан мэдээг шинээр үйлдэх, засвар хийж суух хэрэг гарч байлаа. Шөнө оройгоор үгээгүйчүүдийн бөөн бөөн хүмүүс гудамжаар шуугилдаж байхад Лондон хот жигтэйхэн хийрхэлд автаж байлаа. Пуужингийн бөмбөг урьдынхаасаа улам олноороо унаж хаа нэг газар асар том дэлбэрэлт гарахад хэн ч түүнийг тайлбарлаж чадахгүй байхын хамт элдэв толгойд оромгүй цуу яриа тарж байлаа.

Үзэн ядах долоо хоногийн дууны ая болох шинэ ая (Үзэн ядах дуу гэсэн нэртэй)-ыг аль эрт зохиочихсон ба теледэлгэцээс түүнийг зогсоо зайгүй нэвтрүүлж байна. Догшин хэрцгий хуцсан хэмнэлтэй энэ ая хөгжимтэй огт адилгүй зөвхөн бөмбөр дэлдэлтийг л санагдуулж байлаа. Энэ аяыг хөлийн товшилттой хамт хэдэн мянган хоолойгоор хашгирахад сүнс зайлмаар болно. Үгээгүйчүүдэд энэ дуу таалагдаж шөнийн гудамжинд «Мөрөөдөл аль хэдийнээ алга болжээ» гэсэн дууг шахан гаргажээ. Парсонсын хүүхдүүд энэ дууг өдөр шөнөгүй аман хуураар залхтал орилдог болсон юм. Одоо Смитийн оройн цагт зав зай их бага болжээ. Парсонсын цуглуулсан сайн дурынхан Үзэн ядах долоо хоногт бэлтгэж зурагт хуудас гарган уриа лоозон зохиож, байшингийн дээвэр дээр туг далбаа хатгаж, лоозон зүүх олсыг амь насандаа аюултай байхыг үл тоон гудамж дээгүүр өлгөж байлаа. Парсонс зөвхөн «Виктори» хэмээх байшинд гэхэд л дөрвөн зуун тууш метр уриа лоозон өлгөнө гэж гайхуулан ярина. Тэрээр сурсан зангаараа хүүхэд шиг хөөрч байлаа.

Бүгчим халуун агаар, биеийн хөдөлмөр хийж буйн ачаар тэрээр оройдоо богино өмд, задгай цамц өмсөх бүрэн эрхтэй болжээ. Тэрээр хаал бол хаа явж, татаад л, түлхээд л, хөрөөдөөд л, хадаад л, шинээр бүтээгээд л, нөхөрсөгөөр урмын үг хайрлаад л байхын хамт бие махбодийнхоо нугалаа үрчлээ бүрээс исгэлэн хөлсөө дуслуулсаар байна.

Гэв гэнэт цоо шинэ зурагт хуудас Лондон хот даяар гарлаа. Зурагт хуудас дээр гурав, дөрвөн метр өндөр Евразийн Гүрний аврага том биетэй, цэвдэг хүйтэн монгол царайтай, том гуталтай цэрэг эр автомат бууныхаа бөгсийг ташаандаа тулаад барьчихсан урагшаа давшиж явна. Чамайг хаана ч байсан автомат бууны томруулж өсгөсөн ам чам руу чиглэж байна. Энэ зургийг байшингийн хана болгонд, зай гарсан газар болгонд наасан байх бөгөөд тоо нь Их Ахын зургаас ч олон байна. Үгээгүйчүүд уг нь дайныг сонирхдоггүй боловч тэдний үе үе хөдөлдөг эх оронч үзлийн хийрхлийг хөдөлгөжээ. Дайчин үзэл санааг нь дэмжиж байгаа мэт пуужингууд

урьд өмнөхөөс олон хүний амь насыг хөнөөх боллоо. Степни дахь олон хүн дүүрсэн кино театрт пуужин тусаж хэдэн зуун хүнийг булшлав. Тэдний оршуулганд энэ дүүргийн бүх хүн оролцож оршуулгын цуваа хэдэн цаг-үргэлжлээд төгсгөлд нь эсэргүүцтшин цуглаан болж хувирав. Бас нэг пуужин хүүхдийн тоглоомын талбайд унаж хэдэн арван хүүхдийг зад дэлбэлэв. Энд дахиад л сүрт жагсаал болж Голдштейний чихмэлийг шатааж Евразийн цэрэг эрийн зурагтай хэдэн зуун хуудсыг хуу татаж авч шатаалаа, үймээний үеэр хэд хэдэн дэлгүүрийг дээрэмджээ, тагнуулууд пуужинг радио долгионоор чиглүүлж байна гэсэн цуу үг тархлаа, гадаадын хүний гаралтай гэж сэжиглэгдсэн настай эр эм хоёрын суудаг байшинг шатаахад нөгөө хоёр нь утаанд бүтэж үхжээ.

Чаррингтоны мухлагийн дээд өрөөнд Смит, Жулия хоёр бүтээлгийг нь аваагүй орон дээр бүгчим халуунд нүцгэн хэвтэж байна. Харх дахиад гарч ирсэнгүй ч гэсэн халуунд бясаа



тэсвэрлэхийн аргагүй их цугларчээ. Тэд үүнд огтхон ч санаа зовсонгүй. Өрөө нь бохир байна уу, цэвэрхэн байна уу тэр хоёртоо л диваажин юм. Тэр хоёр өрөөнд оронгуутаа хар захаас худалдаж авсан чинжүүгээ бүх юман дээр цацаад хувцсаа хуу татаж тайлаад хөлсөө асгаруулан хурьцал үйлдээд унтаж орхисноо сэрээд харахад бясаа бөөгнөрчихсөн өөдөөс нь дайрахад бэлэн болчихсон байдаг аж.

Тэд нар зургадугаар сард тав, зургаа, долоон удаа уулзсан юм. Смит ч өдөржингөө жин уухаа ч больжээ. Тэрээр таргалж, шагайных нь дээхэн бор толбо үлдээгээд судасных нь шарх эдгэрч, үүрээр ханиалгадгаа зогссон аж. Амьдралынх нь явц тэсвэрлэж болшгүй зүйл байхаа больж теледэлгэц рүү муухай харах, аль байдгаараа хараал зүхэл хашгирах хүсэлгүй болжээ. Тэд нар бараг өөрийн гэр шигээ найдвартай нуугдах газартай болсон болохоор энд хааяа ганц хоёр цагаар ирэх нь зоштон гачигдал биш юм шиг байлаа. Тэдэнд мухлагийн эзний энэ өрөө байгаа нь чухал ач холбогдолтой юм. Ийм өрөө

байна, тэр нь халдашгүй байна гэдэг бол түүний дотор байгаа гэсэнтэй адилхан юм. Энэ өрөө бол нэгэн ертөнц, устаж алга болсон амьтад хөлхөж байдаг өнгөрсөн үеийн нэгэн цоорхой нүх юм. Смит ноён Чаррингтон бол бас нэг устаж алга болсон амьтан юм гэж бодож байлаа. Тэрээр голдуу шатаар дээшээ өгсөж явахдаа ноён Чаррингтонтой ярих гэж зогсдог байв. Өвгөн гадагшаа бараг гардаггүй буюу ерөөсөө гардаггүй бөгөөд түүнд худалдан авагч бараг байхгүй юм шиг байлаа. Түүний энэ даруухан амь зуулга нь давчуухан мухлаг, элдэв шалдав эд юмсын дунд гайхмаар эртний маш том хоолойтой пянз тоглуулагч бүхий хоолоо өөрөө хийж идцэг жижигхэн гал тогооны өрөө хоёрын хооронд өнгөрдөг аж. Өвгөн яриа дэлгэх боломж гарах бүрд л баяртай байдаг юм. Урт хамартай, бөгтөр нуруутай, нүдний зузаан шилтэй, хилэн хүрэмтэй худалдаачин гэхээсээ илүү цуглуулагч шиг харагдах тэрбээр хэрэггүй лэнсий эд барааныхаа дунд холхино. Тэрээр урамгүйхэн аль нэг шал хэрэггүй юмыг гартаа барьж, шилний шаазан бөглөө, будагтай

хагархай хөөрөг, хэзээ ч юм олон жилийн өмнө нас барсан нялх хүүхдийн туг үстэй гуулин гууг Смитэд худалдах гэлгүй зүгээр л сонирхохыг санал болгодог юм. Түүнтэй ярина гэдэг бол элэгдэж хуучирсан хөгжмийн хайрцгийн дуу сонсохтой агаар нэг юм. Тэрээр хүүхэд ахуй цагийнхаа мартчихсан хэдэн шүлгийн мөрийг эргэн дурсана. Хорин дөрвөн хар хөөндэйн дуу, нэг нь хугархай эвэртэй үхрийн тухай, бас нэг дуу Робин Гудын үхлийн тухай дуу байлаа. Тэрээр “Чамд сонин байх болов уу гэж бодсон юм” гэж инээмсэглээд дууны үг гаргаж ирэх боловч хэдхэн мөрөөс цааш санадаггүй байлаа.

Жулия тэр хоёр энэ бүхэн удаан үргэлжлэхгүй гэдгийг үргэлж ойлгож, санаж байсан. Тэр хоёрт нүүрлэж буй үхэл нь хэвтэж буй ор шиг нь бодитой юм шиг санагдах үед тэд тамд унасан хүн сүүлчийнхээ амьсгалыг тогтоосон цагийн зүү заахын өмнөхөн авч байгаа юм шиг бие биеэ цөхрөлөө баран тачаадаж тас тэвэрдэг байв. Тэр хоёр энэ өрөөнд л байгаа цагт ямар ч гай зовлон тохиолдохгүй гэж бодно. Энд ирэхэд хэцүү бас

осолтой ч гэсэн өрөө нь тэдний хоргодох газар нь байлаа. Смит нэгэн удаа бөөрөнхий шилний гол руу харж байхдаа түүний гүн доторхи ертөнцөд нэвтрэх юм бол цаг хугацааг тогтоон барьж болох юм даа гэж бодож байлаа. Тэдэнд үе үе аврагдана гэсэн мөрөөдөл төрж байлаа. Тэдний аз хийморь нь харьчихгүй хорвоогийн жамаар үхэх хүртэл энэ амраг сэтгэлийн харилцаа зогсохгүй. Нэг бол Смит Жулия хоёр элдэв арга чарга хэрэглэж байгаад гэр бүл болно, эсвэл хоёулаа хамтдаа амиа хорлох болно. Тэд нэг бол сураггүй алга болж, дүр төрхөө танигдахгүй болтол нь өөрчилж үгээгүйчүүдийн аялга сурч үйлдвэрийн хар ажилчин болоод зайдуу гудамжинд оршин сууж энэ насаа баригдалгүй барна. Энэ бүхэн бол огт утга учиргүй зүйл гэдгийг тэр хоёр хоёулаа мэдэж байлаа. Бодит амьдралд зугтаж алга болох ямар ч боломж байхгүй. Хэрэгжүүлж болох цорын ганц арга нь өөрсдийгөө егүүтгэх явдал байсан ч гэсэн тэдэнд үүнийг хэрэгжүүлэх санаа байсангүй. Ирээдүйгүй өнөөдрийг өдрөөс өдөрт, сараас сард үргэлжлүүлээд дэн дун аж

төрөхийг агаар л байгаа цагт уушиг дахин амьсгаа авдаг лугаа адил төрөлх зөн нь тэр хоёрт даалгадаг юм.

Тэд заримдаа Намын эсрэг ширүүн бослого гаргах тухай ярьдаг боловч юунаас эхлэхээ мэддэггүй байв. Нөгөөх домогт Ах дүүгийн барилддага хэмээх байгууллага байдаг бол түүнтэй хэрхэн холбоо тогтоох вэ? Смит Обрайентай хачин ойр дотно болсон, болсон ч юм шиг санагддаг тухай, Обрайентэй уулзаад өөрийгөө Намын дайсан гэж зарлаад түүнээс тусламж дэмжлэг гуйх хүсэл төрдөг тухайгаа Жулияд ярьжээ. Жулия энэ санааг огт дэмий юм гэж үзээгүй нь гайхмаар байсан. Жулия хүмүүсийг царайгаар нь дүгнэдэг бөгөөд Смит Обрайентэй нэг удаа л харц тулгараад түүнд итгэсэн нь зүйн хэрэг юм шиг түүнд санагджээ. Тэрээр хүн бүр, бараг хүн бүр Намыг дотроо үзэн яддаг, аюултай л биш бол тогтоосон дүрмийг зөрчдөг нь аргагүй гэж үздэг юм. Тэрээр харин зохион байгуулалттай өргөн эсэргүүцдийн хүчин байдаг, байж болно гэдэгт

итгэхийг хүсдэггүй юм. Голдштейн, түүний нууц байгууллагын тухай яриа бол Нам өөрийнхөө ашиг тусын тулд зохиосон хий хоосон зүйл юм. Харин чи үүнд итгэж байгаа юм шиг байх юм. Намын хурал, аяндаа үүссэн жагсаал цуглааны үеэр урд өмнө нэрий нь дуулж байгаагүй, хийсэн хэрэг гэдэгт нь өчүүхэн ч итгэх аргагүй хүмүүсийг цаазаар ав гэж хоолойгоо сөөтөл хичнээн их хашгирч байлаа. Олон нийтийн өмнө шүүхийн хуралдаан болоход тэд нар Залуусын Холбооны бүлэгт нэгдэж шүүхийн байшинг бүслэн зогсоод өглөөнөөс орой болтол «Урвагчдыг цаазаар ав!» гэж хашгирцгаадаг юм. Хоёр минут үзэн Ядалтын үеэр Голдштейнийг хамгийн ихээр харааж зүхдэг мөртлөө тэрээр хэн болох тухай болон түүний онол нь юунаас бүрддэг тухай бүрэг бараг л ойлголттой байдаг юм. Жулия хувьсгалаас хойш өсч хүмүүжсэн бөгөөд тавь, жараад оны үзэл суртлын тэмцлийг залуугаасаа болоод санахгүй байна. Жулия бие даасан улс төрийн хөдөлгөөн гэдгийг төсөөлж чаддаггүй юм. Нам бол ямар ч гэсэн ялагдашгүй юм. Нам

үргэлж оршин тогтнон, үргэлж энэ хэвээрээ байна. Чи бээр Намд даидуур үл дагаж эсэргүүцэл үзүүлж болно, аль эсвэл хэн нэгнийг алах, ямарваа юмыг дэлбэлэх зэргээр ганц нэг хүч хэрэглэх үйлдэл хийж болно.

Жулия бол зарим талаар Смитээс хамаагүй хэрсүү, Намын сурталд бага автсан аж. Смит нэг удаа Евразийн Гүрэнтэй хийж буй дайны тапаар үг дуугарсан чинь Жулия хэнэгчгүй ямар ч дайн болоогүй гэж бодож байна гэсэн нь түүнийг хирдхийлгэн цочоож билээ. Засгийн газар «хүмүүсийг айдас хүйдэст барьж байхын» тулд л Лондон хот дээр унаж буй пуужинг нисгэж байж ч болох юм. Смитэд ийм бодол ерөөсөө төрөөгүй билээ. Тэрээр нэг удаа Жулияд атаархах сэтгэл төрж билээ. Надад Хоёр минут үзэн Ядалтын үеэр хамгийн хэцүү нь инээд алдчихгүй байх явдал юм гэж Жулия ярьсан юм. Жулия өөрийнх нь амьдралыг шууд хөндөх үед л Намын үзэл сурталд эргэлздэг юм. Тэрээр үнэн худал хоёрын хоорондын ялгаа ерөөсөө ач холбогдолгүй юм шиг байна гэж үздэг учраас

албан ёсны суртал ухуулгыг ихэнх тохиолдолд хүлээн авахад бэлэн байдаг юм. Жулия жишээ нь сургуульд заалгаснаараа Нам нисэх онгоц зохион бүтээсэн гэдэгт итгэдэг юм. (Смитийг сургуульд байх үед буюу тавиад оны сүүлчээр Нам нисдэг тэрэг зохион бүтээсэн гэж нотолдог байсан, хэдэн жилийн дараа Жулияг сургуульд сурч байх үед Нам нисэх онгоцыг зохион бүтээсэн гэж нотолдог болсон, дараагийн үеийнхэнд уурын хөдөлгүүрийг зохион бүтээсэн гэж нотлох болно) Тэрээр нисэх онгоц түүнийг төрөхөөс өмнө, Хувьсгалаас олон жилийн өмнө байсан юм гэж ярихад Жулия огтхон ч тоосонгүй өнгөрчээ. Ер нь тэгээд нисэх онгоцыг хэн зохион бүтээсэн нь ямар хамаатай юм бэ? Далайн Гүрэн дөрвөн жилийн өмнө Дорнодазийн Гүрэнтэй дайтаж, Евразийн Гүрэнтэй найрамдалтай байсан гэдгийг Жулия санахгүй байна гэдгийг ярианы дашрамд Смит олж мэдээд нилээд цочирдон гайхаж билээ. Жулия энэ бүх дайн бол бач мэх гэж үздэг юм. Харин тэрээр дайсны нэр нь өөрчлөгдсөнийг ч мэдээгүй бололтой. “Би манайхан Евразийн



Гүрэнтэй байнга дайтаж байгаа юм л гэж бодсон юм” гэж тэрээр хайхрамжгүй хэллээ. Нисэх онгоцыг түүний төрөхөөс олон жилийн өмнө зохион бүтээсэн бол дайсан өөрчлөгдсөн нь түүнийг насанд хүрсэн хойно дөрөвхөн жилийн өмнө болсон хэрэг билээ. Смит түүнтэй энэ талаар бараг арван таван минут маргалдсан юм. Тэрээр эцсийн бөлөгт хэзээ нэгэн цагт Евразийн Гүрэн биш Дорнодазийн Гүрэн дайсан байсан гэдгийг түүнд бүрэгхэн санагдуулахад хүргэж билээ. Гэсэн хэдий ч тэрээр энэ мэдээг ач холбогдолгүй гэж үзсээр байсан юм. “Ямар хамаатай юм бэ? Нэг цус асгаруулсан дайны дараа дахиад л нэг дайн гарна. Тэгээд ч дайны тухай мэдээ шал худдаа гэдгийг толгойтой бүр нь мэдэж байгаа шүү дээ” гэж тэрээр уцаарлангуй хэллээ.

Смит заримдаа түүнд Баримтжуулалтын газар, тэнд баримтыг бүдүүлгээр засварлаж буй тухай ярьдаг байлаа. Тэрээр үүнд огтхон ч балмагдсангүй. Худал хуурмаг юмыг үнэн болгож байгаа нь их аюул авчирна гэсэн бодол

түүнд огт төрсөнгүй. Тэрээр түүнд Жоунз, Аронсон, Резерфорд нарын тухай болон гарт нь үнэн баримтын гарцаагүй гэрч болох сонины тасархай орсон тухай ярьсан юм. Жулияд энэ бүхэн ямар нэг сэтгэгдэл төрүүлсэнгүй. Тэрээр үүгээр ч зогсохгүй ярьсан юмны агуулгыг ч ойлгосонгүй.

"Тэд нар чиний найзууд байсан юм уу?" гэж тэрээр асуулаа.

"Үгүй, би тэднийг таньдаггүй байсан юм. Тэд нар Дотуур Намын гишүүд байсан юм. Тэд нар тэгээд ч надаас хамаагүй ахмад хүмүүс байсан. Тэд хуучин үеийн, хувьсгалын өмнөх үеийн хүмүүс байсан. Би тэдний царайг ч бараг мэдэхгүй"

"Тэгээд юунд нь сэтгэл чинь зовоод байгаа юм бэ? Хэн нэгнийг алах явдал дандаа л гарч байдаг, тийм биз дээ?"

Смит түүнд ойлгуулахыг оролдлоо.

“Энэ бол онцгой тохиолдол юм. Хэн нэгнийг алж устгасанд хэргийн учир начир байгаа юм биш ээ. Өчигдрийн өдрөөс авахуулаад өнгөрснийг үнэн хэрэг дээрээ үгүй хийчихээд байна, ойлгож байна уу? Өнгөрсөн үе зөвхөн энэ бөөрөнхий шил шиг биетэй юманд хадгалагдаж үлдсэн болохоос түүнд хамаатай үгэнд үлдсэнгүй. Бид хувьсгалын тухай, хувьсгалын өмнөх үеийн амьдралын тухай тодорхой юу ч мэдэхгүй байна. Бүх баримт бичгийг нэг нэггүй устгачихсан буюу зсаварлачихсан, бүх номонд засвар өөрчлөлт оруулчихсан, уран зургийг шинээр зурчихсан, хөшөө дурсгал, гудамж, барилга байшинд шинэ нэр өгчихсөн, бүх он цагийг өөрчилчихсөн байна шүү дээ. Энэ үйл явцыг нэг ч цаг, нэг ч хоног зогсоохгүй үргэлжлүүлж байна. Түүх зогсчихсон байна. Намын зөв дандаа байдаг дуусдаггүй өнөөдрөөс өөр юу ч алга байна. Би өнгөрснийг хуурамчаар үйлдэж байна гэдгийг тэддэг боловч үүнийгээ юугаар ч нотолж чадахгүй нь тодорхой. Би өөрөө хуурамчаар үйлдэж байхдаа ч чадахгүй. Үүнийгээ үйлдмэгц

л гэрчлэх баримт нь алга болж байна. Цорын ганц гэрчлэх нотолгоо нь миний толгойд байна, гэтэл өөр хэн нэгний толгойд ийм ой дурсамж хадгалагдаж үлдсэн гэдгийг хэн баттай хэлж чадах юм бэ? *Үйл явдал болж өнгөрснөөс* хойш хэдэн жилийн дараа л зөвхөн тэрхэн хоромд энэ насанд минь ганц удаа л жинхэнэ үнэн баримт надад байсан юм”

"Тэгээд ямар хэрэг гарав аа?"

“Ямар ч хэрэг болоогүй. Би хэдхэн хормын дараа устгачихсан юм. Өнөөдөр ийм юм болсон бол би хадгалах байсан”

“Би бол хадгалахгүй шүү! Би үнэхээр хэрэгтэй юмны төлөө бол азаа үзэхэд бэлэн байна, харин хуучин сонины тасархайн төлөө бол үгүй шүү. Чи түүнийг хадгаллаа гэж бодье тэгээд чи түүгээр яах юм бэ?”

“Онцгой юм биш байх л даа. Энэ чинь харин баримт нотолгоо байсан юм. Би зүрх гаргаад хэн

нэгэнд үзүүлсэн бол тэр хүнд эргэлзэл төрүүлэх л байсан юм. Бид энэ насандаа ямар нэг юм өөрчилж чадна гэж би бодохгүй байна. Энд тэнд эсэргүүцлийн голомт үүсч аажмаар өргөжин хойч үеийнхэнд уншуулах хэдэн баримт бичиг үлдээж бидний үйл хэргийг үргэлжлүүлэх болно гэж төсөөлж байна”

“Хонгор минь, би хойч үеийг сонирхохгүй байна. Би өөрсдийгөө л сонирхож байна”

“Чи бол зөвхөн бүсэлхийнээсээ л доогуур бослого гаргагч юм”

Жулия үүнийг маш мэргэн үг хэллээ гэж үзээд баярлан Смитийг хүзүүгээр нь тэвэрч авлаа.

Жулия Намын үзэл баримтлалын ээдрээтэй арга мэхийг өчүүхэн ч сонирхдоггүй аж. Смит Ангсоцын зарчмууд, хоёрсэтгэх, өнгөрсөн үеийн хувирамтгай чанар, бодит байдлын үгүйсгэл зэргийн талаар санаа боддоо илэрхийлж Шинхэлийн үг хэрэглэхээр тэр

дороо Жулия уйтгарлан ундууцаж, ийм юмыг ерөөсөө анзаарч байгаагүй юм байна гэж ярьдаг байлаа. Энэ бүхэн шал хэрэггүй юм гэдэг нь тодорхой тул юунд нь санаа зовсон юм бэ? Тэрээр хэдийд «уухай» хашгирах, хэдийд тухирахаа мэднэ, үүнээс өөр юм хэрэггүй. Хэрвээ Смит энэ сэдвээрээ яриад л байх юм бол Жулия санаа огт зоволгүй унтчихдаг байлаа. Тэрээр хэдийд ч, ямар ч байдалд дорхноо унтчихдаг зуршилтай хүмүүсийн нэг юм. Смит түүнтэй ярьж байхдаа намын үзэл суртлын талаар өчүүхэн ч мэдлэггүй мөртлөө намын үзэл суртлыг тууштай баримтлагчийн дүр эсгэх нь юутай амархан юм бэ гэдгийг ухаарч байв. Үүнийг ухаарах чадваргүй хүмүүст Намын ертөнцийг үзэх үзлийг ойлгуулах нь харин ч хялбар юм. Тийм хүмүүс хуурамчаар үйлдэхийн хамаг бузар муухайг ойлгодоггүй болохоор бодит байдлыг бүдүүлгээр гуйвуулан мушгиж буйтай санал нийлдэг бөгөөд нийгэмд болж буй үйл явдлыг бага сонирхдог болохоор эргэн тойрондоо болж буй үйл явдлыг анзаардаггүй болно. Тэд үл ойлгосноороо эрүүл ухаантай

үлддэг юм. Тэд дайралдсан бүхнээ залгичихдаг, залгисан бүхэн нь шувуу эрдэнэ шишийн үрийг зажлалгүй ходоод руугаа оруулчихдаг шиг тэдэнд гай хор болдоггүй, уршиг тарьдаггүй юм.

## VI

Энэ явдал одоо л нэг боллоо. Хүлээж байсан ажиг сураг гарлаа. Тэрээр насан туршдаа ийм явдал болохыг хүлээж байсан шиг байна.

Тэрээр Яамны урт хонгилоор алхаж яваад Жулия хальтирч унаж гарт нь зурвас бичиг атгуулсан яг тэр газар ойртоход ард нь өөрөөс нь том биетэй хэн нэгэн байгааг мэдэв. Ард нь яваа тэр хүн яриагаа эхлэхийн тэмдэг болгож аяархан ханиалгахад нь Смит эргээд хартал өмнө нь Обрайен зогсож байна.

Тэд нар одоо л нүүр нүүрээрээ уулзаж байгаа бөгөөд тэрээр зугтаад гүймээр болж зүрх нь хүчтэй цохилж Обрайентай үг дуугарч чадахгүй болох байлаа. Харин Обрайен Смитийн бугуйнаас хөтлөөд хоёулаа зэрэгцэн урагшаа алхлаа. Обрайен Дотуур Намын ихэнх гишүүдийнхээс ялгаатай их эелдэг дуугаар ярьж эхлэв.



“Би тантай хэдэн үг солих боломж хайж байсан юм. Саяхан би «Таймс» сонинд таны Шинхэлээр бичсэн өгүүллийг уншсан. Таныг Шинхэлийг шинжлэх ухааны үүднээс сонирхдог юм байна гэж ойлгосон шүү” гэж тэрээр яриа өдөв.

Смит бага ч гэсэн биеэ барьж байв.

“Шинжлэх ухааны гээд байх юм бараг үгүй дээ. Би бол зөвхөн сонирхогч л шүү дээ. Би бол мэргэжлийн хүн биш. Хэлийг боловсруулах бодитой ажилд би ерөөсөө оролцоогүй юм” гэж тэрээр хариулав.

“Их сайн бичсэн байна билээ. Энэ бол зөвхөн миний үзэл бодол биш ээ. Би саяхан жинхэнэ мэргэжлийн хүнтэй, танилтайгаа энэ тухай ярьж байсан юм. Харин би түүний нэрийг мартжээ”

Смитийн зүрх дахиад хүчтэй цохиллоо. Эргэлзэх юм байхгүй, Саймыг хэлж байна. Харин Сайм зүгээр л нэг үхсэн хүн биш түүнийг

арилгачихсан болохоор тэрээр улхун. Саймын нэрийг холуур дурдсан ч гэсэн их аюултай юм. Обрайены үгийг дохио, нууц үг гэж ойлгох нь зүйтэй юм. Обрайн түүнийг байхад энэ сэтгэхүйнгэм үйлдэж түүнийг хуйвалдаандаа орууллаа. Тэд хонгилоор цааш явж байтал Обрайн гэнэт зогсов. Тэрээр дадсанаараа нүднийхээ шилийг хамар дээрээ засаж тогтоолоо. Энэ нь нэг л тайвшруулсан нөхөрсөг дохио байлаа. Тэрээр тэгээд.

“Би үнэндээ ийм л юм хэлэх гэсэн юм. Таны өгүүлэлд хуучирсан гэж тооцогдож буй хоёр үг байна лээ. Энэ үгүүд тун саяхан л хуучирсан юм. Та Шинхэлийн толь бичгийн аравдахь хэвлэлийг үзсэн үү?”

-“Үгүй пгүү. Манай Баримтжуулалтын газар есдэх хэвлэлийг одоохондоо ашиглаж байгаа”.

-“Миний мэдэж байгаагаар аравдахь хэвлэлийг хэдэн сарын дараа л гаргах юм. Харин

туршилтын хувийг тараачихсан юм. Надад бий. Танд бол сонирхолтой байх байх аа”

-“Их сонин байх болно” гэж Смит юу хэлэх гээд байгааг нь ойлгон хариулав.

-“Зарим шинэ үг нь маш сайн оносон байна лээ. Үйл үгийн тоог цөөрүүлсэн... үүнийг би танд таалагдана гэж бодож байна. За байз яадаг юм билээ. Толийг танд хүнээр хүргүүлэх үү? Би ийм юманд их мартамхай хүн шүү. Та завтай цагтаа манайхаар ороод гарч болох юм шүү? Хүлээж байгаарай, би танд хаягаа өгье”

Тэд яг теледэлгэцийн өмнө зогсож байна. Обрайен халаасаа хайхрамжгүй тэмтэрснээ арьсан хавтастай тэмдэглэлийн дэвтэр, алтадсан үзэг гаргалаа. Тэрээр нөгөө талд нь ажиглаж буй хүн уншиж болохоор тодоор хаягаа бичээд хуудас цаасаа тасдаад Смитэд өгөв.

“Би оройдоо ихэвчлэн гэртээ байдаг юм. Би байхгүй бол зарц толийг өгчихнө” гэж тэрээр хэлэв.

Тэрээр хуудас бичгээ Смитэд өгөөд явлаа. Харин энэ удаа бичгийг нуух шаарддага байхгүй аж. Гэлээ ч гэсэн Смит хаягийг цээжилж аваад хэдэн цагийн дараа хуудас цаасаа бусад цаасны хамт ой тойны нүх рүү хаяв.

Тэд хэдхэн хором ярилцсан бөгөөд энэхүү уулзалтыг нэг юмаар л тайлбарлаж болох юм. Обрайен Смитэд хаягаа өгөх гэж л үүнийг зохион байгуулсан байна. Өөр арга ч байхгүй. хүний хаягийг өөрөөс нь шууд асууж байж л мэдэж болно. Хаягны лавлах ном гэж байдаггүй. «Надтай та уулзмаар байвал намайг та тэнд олж болно шүү» гэж үнэн хэрэг дээрээ Обрайен хэлсэн юм. Толь бичиг дотор бичиг нуучихсан байж болох юм. Юутай ч гэсэн нэг юм тодорхой байна. Смитийн мөрөөддөг хуйвалдаан ямар ч гэсэн байгаа юм байна, Смит түүнд их ойртлоо.

Эрт орой хэзээ нэг цагт Обрайены дуудлагыг хүлээн авч тэрээр очиж уулзана. Маргааш очих уу, аль эсвэл уулзалтаа хойшлуулах уу гэдгээ тэрээр мэдэхгүй байна. Одоогийн энэ болж буй юм бол хэдэн жилийн өмнө эхэлсэн үйл явцын үргэлжлэл нь юм. Эхний алхам нь санаандгүй төрсөн бодол, хоёрдахь нь өдрийн тэмдэглэл. Тэрээр бодлоо үг болгосон, одоо үгээ үйл хэрэг болгож байна.

Сүүлчийн алхам нь Хайрын Яаманд тохиолдох явдал юм. Тэрээр үүнтэй эвлэрчихсэн. Төгсгөл эхлэлээ агуулна. Харин энэ нь айдас төрүүлнэ. тэрээр тодорхой хэлэхэд үхлийн үнэр авсан юм шиг, амьд байх нь багассан юм шиг байна. Обрайентэй ярилцаж байхад, урилгын утга начырыг сайн ухаарахад түүний бие дагжин чичирч байсан юм. Түүнд булшны нүхний чийгтэй нойтон газар руу орж байгаа юм шиг байна, тэрээр булш холгүй байна, өөрийг нь хүлээж байна гэдгийг ер нь мэддэг байсан, гэлээ ч ингэлээ гээд түүнд санаа амрах юм алга байна.



## VII

Смит нүдэндээ нулимстай сэрэхэд Жулия нойрмоглоон түүнд нуруугаараа наалдаад “Юу болов оо?” гэсэн шүү юм шивнэж байна.

“Би зүүдэндээ..” гэж тэрээр ярьж эхэлснээ зогсчихов. Түүнд зүүдээ үгээр илэрхийлэхэд тун ярвигтай аж. Зүүдэлсэн зүүд байна, сэрсний дараахи хэдхэн хоромд ой ухаанд нь орж ирсэн зүүдэнд хамаарах дурсамж байна.

Тэрээр нүдээ аниад зүүдэндээ үзсэн бүхэндээ автагдан хэвтэж байлаа. Борооны дараахи зуны үдшийн үзэсгэлэнт байгал шиг бүхий л амьдралыг нь зурайн харагдуулсан гэрэл гэгээтэй том зүүд байлаа. Энэ бүхэн бөөрөнхий шил дотор болж буй бөгөөд шилний гадаргуу нь огторгуй, түүний доорхи дэлхий дээр хязгааргүй алсыг харж болох тунгалаг гэрэл тусчээ. Мөн түүнчлэн зүүдний шалтгаан, түүний агуулга нь гэвэл кино мэдээний сэтгүүлд гарсан гучин жилийн дараа

еврей эх нялх үрээ бууны сумнаас хаацайлах гэж оролдож байтал нисдэг тэрэг тэр хоёрыг зад бөмбөгдөхөд давтагдсан эхийнх нь гарын хөдөлгөөн байлаа.

“Би энэ хормыг хүртэл эхийгээ алчихсан гэж бодож байсныг минь чи мэдэх үү?” гэж Смит ярилаа.

-“Яах гэж алсан юм бэ?” гэж Жулия асуулаа.

-“Үгүй, би түүнийг алаагүй. Амь насыг нь хороогоогүй”

Тэрээр зүүд дундаа эхийгээ сүүлчийн удаа харснаа санасан бөгөөд сэрсний дараахи хэдхэн хоромд тэр өдөр болсон аар саар үйл явдлыг эргэн саналаа. Тэрээр олон жилийн туршид энэ дурсамжаа санахгүй байхыг хичээж байсан байж магадгүй юм. Энэ дурсамж чухам ямар үед хамаарахыг сайн санахгүй байгаа ч гэсэн тэрээр арав гаруй настай, бараг арван хоёр настай байсан байх нь ээ.



Эцэг нь бүр өмнө өөрийнх нь санаж байгаагаас хамаагүй өмнө алга болсон юм.

Тэр үеийн хурцадмал, замбараагүй байдал санаанд тодхон үлджээ. Агаараас довтлох үед үе үе үүсдэг үймээн сандралаас болж метронд олон цагаар хоргодож суух, хаа хаагүй дайралдах байшингийн бөөн нуранги, гудамжны булан бурт наасан үл ойлгогдох уриалга, адилхан цамцтай дээрэмчин залуус, талхны дэлгүүрийн үүдэн дэх урт дараалал, алсад сонсогдох пулемёт галлах чимээ, хамгийн гол нь үргэлж өлмөн зэлмэн явах. Тэрээр өдрийн ихэнхийг бусад хүүхдийн хамт байцааны гол, төмсний хальс хайж хогийн сав, угаадасны нүх ухдаг, заримдаа үнсний хог дотроос шатсан талхны хэлтэрхий олж үнсийг нь их нямбай цэвэрлэдэг байсан, малын тэжээл зөөдөг машины зам тосон хүлээж замын хонхорхойд машин донслоход унасан наран цэцгийн шахдас олдог байсан зэргээ санаж байлаа.

Эцэг нь ор сураггүй алга болоход эх нь гайхаж хачирхсанчгүй, уйлж гашуудсанчгүй, харин тэрээр их өөрчлөгдөж билээ. Эхээс нь сүр сүлд нь зайлчих шиг болсон. Эх нь зайлшгүй тохиолдох нэг юмыг хүлээгээд байгаа нь Смитэд хүртэл мэдрэгдэж байлаа. Тэрээр гэртээ нөгөө л хийдэг ажлаа, хоол хийх, юм угаах, юм оёх, ор засах, хог шүүрдэх, тоос шороо арчих, маш алгуурхан нэг ч илүү хөдөлгөөн гаргалгүй хиймэл хүн шиг хийдэг болсон аж. Түүний том гоолиг бие нь хөдөлгөөнгүй болчихсон байлаа. Тэрээр өвдөмтгий, жаахан гурав, дөрөвхөн настай номхон туранхайгаасаа сармагчин шиг царайтай охин дүүг нь тэврээд олон цагаар орны ирмэг дээр сууна. Заримдаа Смитийг биендээ наалдуулан чанга тэврээд юу ч дуугардаггүй байлаа. Смит хэдийвээр бага балчир, хар амиа боддог ч гэсэн энэ нь удахгүй зайлшгүй тохиолдох эхийн огт ярьдаггүй нэг юмтай хамаатай болохыг мэдэж байсан юм.

Тэр ихэнх зайг нь хаваастай цагаан бүтээлэгтэй ор эзэлсэн харанхуй бүгчим өрөөнд суудаг

байснаа санаж байна. Өрөөнд нь халдаг ширмэн тавагтай зуух, хоол хүнсний тавиур байсан ба гадна нь шатны тавцан дээр хэд хэдэн гэр бүл хэрэглэдэг улаан хүрэн өнгөтэй угаагуур байсан юм. Эх нь хувин савандаа зай гаргах гэж том биеэрээ халдаг ширмэн тавган дээр бөхийчихсэн байхыг тэрээр харж байсан. Тэрээр үргэлж тохиолддог өлмөн зэлмэн байдал хоол идэх үед гардаг уур хилэнтэй бузар булай хэрүүлийг их сайн санадаг юм. Эх нь яагаад хоол нэмэхгүй байна гэж гоншигнон үглэж хэрүүл шуугиан дэгдээдэг (хоолой нь эрт эвдэрч үе үе бүдүүн хоолойгоор хашгирах болсон аж) байсан ба өөрийгөө өрөвдүүлэх гэж оролддог, илүү хоол авах гэж гоншигнодог байлаа. Эх нь тэр дор нь түүнд хоол нэмж өгдөг байсан. Тэрээр үүнийг ингэх ёстой гэж хүлээж авдаг байлаа. Тэрээр «эр хүн» болохоор бусдаас илүү авах ёстой гэж үздэг байсан бөгөөд эх нь хичнээн өгсөн ч дахиад л нэхдэг байсан. Эх нь түүнийг хар амиа битгий бодож бай гэж дандаа гуйж, охин дүү нь өвчтэй тул хоол сайн идэх ёстойг бүү март гэж ятгадаг ч ямар ч нэмэр

болдоггүй байлаа. Эх нь хоол аягалахаа зогсмогц л тэрээр уурлан орилж эхээсээ хоолны халбага, хайруулыг нь булаацалдаж дүүгийнхээ тавагтай хоолыг булаадаг байсан юм.

Түүнээс өөрөөс нь болж тэд өлсөж байгааг мэддэг боловч биеэ барьж чаддаггүй байсан, тэр ч байтугай өөрийгөө зөвтгөдөг байсан. Тэрээр гэдсээ өлссөнөөр өөрийгөө зөвтгөдөг байв. Хоол идэх хүртэл эхийгээ буруу харах бүрд л тавиур дээрх хоолноос нь авдаг байв.

Нэг удаа хэдэн арав хоногт, бүр хэдэн сарын туршид анх удаагаа тэдэнд шоколадны талон өгсөн юм. Тэрээр энэ алт шиг үнэтэй хавтгай шоколадыг сайн санаж байна. Гурван хүнд нэг лан (тэр үед лангаар хэмждэг байсан юм) шоколад ногдсон юм. Шоколадыг гурав хуваах хэрэгтэй байсан нь мэдээж хэрэг билээ. Смит гэв гэнэт өөрийнхөө хашгирах бүдүүн хоолойг хөнддөнгөөс сонсох шиг боллоо. тэрээр бүгдийг өг гэж нэхэж байлаа. Эх нь бүү ховдоглоод бай гэж хэллээ. Залхуу хүрмээр эцэс төгсгөлгүй

хэрүүл маргаан, үг хаялцал, орилолдоон чарлалдаан, уйлаан майлаан, нулимс асгаруулалт, ятгалцал, наймаалцал боллоо. Сармагчны хүүхэд шиг жаахан охин дүү нь эхээсээ хоёр гараараа зүүгдчихсэн уйтгартай том нүдээрээ мөрөн дээгүүр нь харж байлаа. Эх нь аргаа барахдаа шоколадны ихэнхийг хугалж аваад Смитэд, үлдсэн хэсгийг нь дүүд нь өглөө. Охин өөрийнхөө хувийг аваад юу өгснийг сайн ойлголгүй эргэлзэнгүй түүнийг харж байлаа. Смит түүнийг харж байснаа үсэрч очоод шоколадыг нь шүүрч аваад хар эрчээрээ гүйж одов.

“Смит, Смит ээ! Нааш ир! Дүүдээ шоколадыг нь өг!” гэж араас нь хашгирна.

Смит зогссон боловч эргэж очсонгүй. Эх нь сэтгэл түгшин түүнээс нүд салгалгүй харж байв. Тэрээр одоо ч гэсэн удахгүй зайлшгүй тохиолдох тэр юмыг л бодож байсан... Смит юун тухай гэдгийг мэдэхгүй байлаа. Охин дүү нь өөрийг нь гомдоосныг ойлгон аяархан уйлна.

Эх нь түүнийг нэг гараараа цээжиндээ тэвэрч байлаа. Тэрээр үүнийг хараад дүү нь амьсгаагаа хурааж байна гэдгийг тааварлалаа. Тэгээд эргээд хайлж буй шоколадаа атгасаар шатаар гүйлээ.

Үүнээс хойш эхийгээ дахиад хэзээ ч хараагүй юм. Тэрээр шоколадаа ам руугаа хийхэд ичмээр болж гэдэс нь өлсөж гэртээ буцахаас өөр аргагүй болтол гудамжаар тэнэж билээ. Тэр үед ийм юм тохиолдох нь жирийн үзэгдэл байлаа. Өрөөнд нь эх, дүү хоёроос өөр юм алга болсонгүй, эх нь хувцсаа, тэр ч байтугай пальтогоо ч авсангүй. Тэр одоо хүртэл эхийгээ нас барсан гэдгийг сайн мэддэггүй юм. Түүнийг цөллөгийн лагерьт явуулчихсан байж ч болох юм. Дүүг нь бол Смитийн нэгэн адил тэнэмэл хүүхдийн колонид (ийм «хүмүүжүүлэх төвүүд») өгчихсөн, эсвэл эхийнхээ хамт лагерьт очсон, аль эсвэл түүнийг хаа нэг газар ганцааранг нь хаячихсан ч байж болох юм.

Зүүд нь санагдсаар ялангуяа эх нь хүүхдээ хамгаалан тэвэрч буй хэсэг нь хамгийн чухал

юм шиг санагдаж байна. Хоёр сарын өмнөх зүүд нь бас санагддаа. Энэ зүүдэнд эх нь цагаан бүтээлэгтэй төмөр орон дээр дүүгий нь өвөр дээрээ аван живж буй хөлөг онгоцонд байх бөгөөд хөлөг онгоц далайн гүн рүү улам доошилсоор байна, харлан гүнзгийрэх усны гүнээс Смит рүү харж байна.

Жулияд эх нь хэрхэн сураггүй алга болсон тухай ярихад тэрээр нүд нь аниастай эргэж тухлан хэвтэв.

“Чи ч тэр үед өөдгүй гахай байжээ. Хүүхдүүд бүгд гахай шүү” гэж амандаа үглэв.

"Тиймээ. Гэхдээ гол нь,,"

Жулиягийн амьсгалах нь дахиад л унтаж эхэлж буй хэрэг. Смитэд эхийнхээ тухай яриад баймаар байлаа. Түүний санаж байгаагаар эх нь ер бусын эмэгтэй байгаагүй, тэр ч байтугай сэргэлэн хүн байгаагүй шиг санагдана, гэхдээ л түүний баримталдаг зарчим нь зөвхөн өөрийнх нь

байсан болохоор үнэнч шударга, өгөөмөр сэтгэлтэй байсан гэж хэлж болно. Тэрээр чин сэтгэлтэй бөгөөд түүнд гаднаас нь нөлөөлөх арга байхгүй байсан. Үйл ажиллагаа үр дүнд хүрэхгүй бол утга учиргүй юм гэдгийг тэрээр ойлгохгүй байсан юм. Чи хэн нэгэнд хайр сэтгэлтэй л бол чи түүнд хайртай, үүнээс өөр юм өгч чадахгүй ч гэсэн чи түүнд хайр сэтгэлээ өгнө. Тэрээр шоколад алга болчихлоор нялх үрээ цээжиндээ тэвэрсэн юм. Өөр яах ч арга байхгүй, юу ч өөрчлөгдөхгүй, шоколад шинээр үйлдвэрлэхгүй, нялх үрийнх нь, өөрийнх нь үхлийг зайлуулж чадахгүй юм. Тэр эмэгтэй нялх үрээ гараараа хаацайлан тэвэрч завин дээр суугаа нь хуудас цаасаар хаацайлж байгаа юм шиг бууны суманд ямар ч нэмэр болохгүй. Нам бол аймшигтай юм хийсэн. санаа сэтгэл, хүсэл эрмэлзэл бол ямар ч ач холбогдолгүй юм гэж чамд итгүүлсэн, тэхдээ биет зүйлийг эзэмших бүх чадварыг чинь булааж авсан юм. Чи нэгэнт л Намын атганд орсон бол чи юу бодно, юуг бодохгүй байна, чи юу хийсэн, юу хиймээргүй байна энэ бүхэн ямар ч хамаагүй юм. Юу ч



боллоо гэсэн чи алга болж чиний тухай, чиний үйл ажиллагааны тухай хэн ч хэзээ ч дуулж сонсохгүй. Чамайг түүхийн хуудаснаас бүрмөсөн арчиж цэвэрлэнэ. Харин хоёр үеийн өмнөх үеийнхэнд энэ бол тийм ч ач холбогдолтой зүйл биш байхсан. Тэд түүхийг өөрчлөх оролдлого хийгээгүй. Тэд нар бие биедээ үнэнч шударга байсан бөгөөд үүндээ ч эргэлздэггүй байсан юм. Хувь хүн хоорондын харилцаа чухал байсан бөгөөд зүгээр л жирийн үйлдэл, тэврэлдэх, нулимс асгаруулах, өөд болж буй хүнд хэлсэн үг энэ бүхэн үнэ цэнтэй байсан юм. Тэрээр үгээгүйчүүд л ийм хэв маягтаа үлдэж дээ гэж гэнэт бодов. Тэд Намд, улс оронд, үзэл сурталд үнэнч бус өөр өөрсөддөө л үнэнч юм. Тэрээр энэ насандаа анх удаа тэднийг жигшсэнгүй, тэднийг нэгэн цагт сэхэн сэргэж энэ дэлхийг шинэчлэх царцанги хүчин гэж үзсэнгүй. Үгээгүйчүүд хүнлэг хэвээрээ байна. Тэдний дотоод сэтгэл нь хөрсөнгүй. Тэд Смитийн зориудаар суралцахад хүрсэн жирийн санаа сэтгэлийг хадгалж үлджээ. Тэрээр энэ тухай бодож байхдаа, энэнд огт хамаагүй ч юм

шиг хэдэн долоо хоногийн өмнө явган зам дээр ойчсон хүний гарын тасархайг аваад байцааны гол шиг гудамжны усны суваг руу хаяснаа саналаа.

“Үгээгүйчүүд - хүн. Бид - хүн биш” гэж тэрээр дуулдахаар хэлэв.

“Яагаад тэр вэ?” гэж Жулия сэрээд асууж байна.

“Оройтоогүй дээрээ эндээс гарч яваад дахиад уулзахгүй байх нь бидэнд хамгийн өлзийтэй гэсэн бодол чамд ер нь төрөхгүй байна УУ?”

"Тиймээ, хонгор минь, ийм бодол нэг бус удаа төрж байсан шүү. Тэглээ ч гэсэн би чамтай уулзсаар л байх болно"

“Бид азтай байна. Гэхдээ энэ удахгүй шүү. Чи залуу байна. Чи бол жирийн, эвдрээгүй харагддаг. Над шиг хүнээс холхон байвал тавин жил ч амьд явах болно”

“Үгүй дээ. Би бүх юмыг бодож үзсэн. Чи юу л хийнэ, би ч адилхан хийнэ. Сэтгэлээр бүү уна. Би амьд явах азтай хүн шүү” “Бид хамтдаа хагас жил... нэг жил амьдарч болох байх. Гэхдээ хэн ч мэдэхгүй дээ. Хэзээ нэгэн цагт биднийг салгаж л таарна. Бид ганцаардахад ямар байхыг чи ухаарч байна уу? Биднийг баривчлаад авахад чи ч гэсэн, би ч гэсэн бие биедээ тусалж чадахгүй, юу ч хийж чадахгүй. Би гэмээ хүлээх юм бол чамайг буудаж ална, гэмээ хүлээхгүй ч, чамайг ч ялгаагүй мөн л буудаж ална. Би юу ч ярихгүй байсан, юу ч хийхгүй байсан, юунд ч ам алдахгүй байсан чиний үхлийг хэдхэн хором ч хойшлуулж чадахгүй. Бид огт хүчин мөхөс юм. Хэдийвээр энэ нь ямар ч ялгаагүй гэлээ ч гэсэн бид бие биедээ урван тэрслэхгүй байх нь л чухал юм”

“Гэмээ хүлээх тухайд бол бид тэр дороо л хүлээх болно. Хүн бүр хэргээ хүлээдэг юм. Өөр яах ч арга байхгүй. Эрүү шүүлт тулгана шүү дээ” гэж тэрээр хэллээ.

“Би гэмээ хүлээх тухай яриагүй ээ. Гэмээ хүлээх нь итгэл алдана гэсэн үг биш. Миний чамд хайртайг минь таслан зогсоож чадах юм бол жинхэнэ урвалт болно”

Тэрээр хэзээ ч сонсохоо зогсдоггүй чих болох теледэлгэцийг бодож байлаа. Тэд нар чамайг өдөр шөнөгүй мөрдөж мөшгөж болно, гэхдээ толгой чинь мөрөн дээрээ байгаа цагт чи тэднийг гол гаргаж болно. Тэд хичнээн ухаантай ч гэсэн өөр хэн нэгэн юу бодож байгааг мэдэх увидасыг эзэмшиж чадсангүй. Хайрын Яамны дотор юу болж байгааг хэн ч мэддэггүй гэхдээ юу болж байгааг нь таамагладаг аж. Эрүүдэн шүүлт, хар тамхиар хордуулах, мэдрэлийн хөддөлийг чинь хэмжих нарийн багаж хэрэгсэл, нойрноос чинь салгаж сульдуулах, ганцааранг чинь яс цоожинд байлгах, өдөр шөнөгүй байцаах. Болсон явдлыг нуух ямар ч арга байдаггүй түүнийг байцаалтаар илрүүлнэ, эсвэл эрүүдэн шүүгээд хэлүүлчихнэ. Зорилго нь амьд үлдэхдээ бус, хүнээрээ үлдэхдээ юм бол ямар хамаа байна вэ? Чиний сэтгэл санааг өөрчилж

болохгүй. ингэж ярих юм бол чи ч өөрөө түүнийг хүссэн ч өөрчилж чадахгүй. Тэд чиний юу хийсэн, юу ярьсныг маш тодорхой мэдэж чадна, харин өөрт чинь хүртэл далд дотоод сэтгэлийн чинь гүнд орж чадахгүй.

## VIII

Бүтлээ. Одоо л нэг бүтлээ!

Тэд нар жигдхэн гэрэлтүүлэгтэй урт өрөөнд зогсож байна. Теледэлгэцийн дууг намсгажээ, гүн хөх хивсэн дээгүүр явахад хамба хилэн дээгүүр алхах шиг санагдуулна. Өрөөний холын буланд Обрайен ширээний ард овоолоотой цаасан дунд сууж байна. Зарц нь Жулия, Смит хоёрыг өрөөнд дагуулж оруулахад тэрээр толгойгоо ч өндийлгөсөнгүй.

Смитийн зүрх нь хүчтэй цохилж ярьж чадах болов уу гэж өөртөө эргэлзэж байна. Бид чадлаа, одоо л чаддаа гэж л тэрээр бодно. Ер нь энд ирэх нь хуумгай явдал, хоёулаа ирэх нь тэнэг хэрэг байчаа, тэр хоёр өөр өөр замаар ирж Обрайены үүдний дэргэд уулзсан ч гэсэн. Гэхдээ л ийм байшинд орж ирэхэд их зүрх гаргах хэрэгтэй байсан юм. Хэн нэгэн маш ховор тохиолдолд Дотуур Намын гишүүний суудаг байрны дотор

талыг үздэг буюу тэдний оршин суудаг дүүрэгт ордог юм. Орон сууцны том байшингууд, тэдгээрийн тансаг сүрлэг дүр төрх, сайхан хоол, тамхины үнэр танар, дуу чимээгүй хурдан цахилгаан шат, цав цагаан хүрэмтэй ажилч хичээнгүй зарц нарын нааш цааш гүйлдэх, энэ бүхнээс эмээх сэтгэл төрнө. Смитэд энд ирэх сайхан шалтаг байсан ч гэсэн тэрээр алхам тутамдаа дүрэмт хар хувцастай харуул гэнэт гарч ирээд баримт бичгийг нь шалгаад хөөж гаргах вий гэсэн айдас төрж байлаа. Харин Обрайены зарц тэр хоёрыг ямар ч саадгүй оруулжээ. Зарц нь цагаан хүрэмтэй жижигхэн биетэй, хар үстэй, хүйтэн царайтай, лав хятад хүн бололтой аж. Тэрээр Жулия, Смит хоёрыг зөөлөн хивстэй, зузаан цаасалсан цэв цэвэрхэн ханатай хонгилоор дагуулан явсан бөгөөд энэ бүхэнд тэд мөн л эмээж байсан. Хүний бие шүргэснээс хар толбо суугаагүй ийм цэвэрхэн хана үзсэнээ Смит санахгүй байлаа.

Обраиен гартаа хуудас цаас барьчихсан их л хичээнгүй судалж байх шиг харагддаа. Тэрээр

буруулан суух тул нүүр нь бүхэлдээ харагдахгүй зөвхөн хамрынх нь үзүүр харагдах нь тэрээр догшин бөгөөд ухаалаг юм шиг байна. Тэрээр хэдэн хором үл хөдлөн сууснаа үгбичигчээ өөр рүүгээ ойртуулаад Яамны этгээд үг хэллэгээр уншиж гарлаа.

*“Нэгдүгээр зүйл таслал тавдахь таслал долоог батлах таслал зургадугаар зүйлийн талаархи саналд нэмэхнэмэх сэтгэхүйнгэмийн ирмэг дэх дэмий юм цэг суурь машин үйлдвэрлэлийн төлөвлөгөө давуулан биелүүлэлтийн нэмэх тоог хулээн автал оновчтой үргэлжлүүлэхгүй байх цэг даалгавар дуусав”*

Тэрээр суудлаасаа босоод зөөлөн хивс дээгүүр алхсаар Жулия, Смит хоёр руу чиглэн ирлээ. Жаахан албархаг байдал нь Шинхэлийн үгтэй хамт арилах шиг болсон ч гэсэн ажилд нь саад болсонд дургүй байгаа бололтой царай нь жаахан баргар харагдана. Смит айж эмээхийн хажуугаар мэгдэн сандарч байлаа. Түүнд



ерөөсөө тэнэг алдаа хийсэн байж болзошгүй юм гэсэн бодол төрж байна.

Обрайн улс төрийн хуйвалдаанд оролцогч гэсэн ямар үнэн баримт нотолгоо надад байна вэ? Нүдний хоромхон харц, учир нь сайн олдохгүй үг ярианаас өөр юу ч байхгүй, бусад нь далд хоосон зүүдэндээ тулгуурласан мөрөөдөл л байна. Тэрээр толь бичиг авах гэж ирсэн хэмээн өөрийгөө зөвтгөх ч арга алга, тийм юм бол Жулия яах гэж энд ирсэн билээ? Обрайн теледэлгэцийн хажуугаар өнгөрөхдөө гэнэт нэг юм санасан мэт ханан дээрх унтраалгыг дарахад тэр нь шажигнаснаа дуу нь тасрав.

Жулия аяархан дуу алдаж Смит ихэд сандарч байгаа хэдий ч биеэ барьж чадалгүй дуу алдан асуув.

"Та үүнийг унтрааж болох юм уу?"

"Тийм ээ. Бид үүнийг унтрааж болно. Бидэнд тийм эрх олгосон юм" гэж Обрайен хариуллаа.

Тэрээр Смит, Жулия хоёрын өөдөөс харан зогсох бөгөөд түүний лут том бие нь сүрлэг харагдаж царайных нь өнгийг таах арга алга байна. Тэрээр Смит рүү ширүүхэн харж түүний юу хэлэхийг хүлээж байна, харин юу ярих вэ? Одоо ч гэсэн энэ завгүй хүн өөрт нь яагаад төвөг удав гэж ундууцан гайхаж байгааг бүрнээ ойлгож болох юм. Хэн нь ч үг дуугарсангүй. Теледэлгэцийг унтраачихсан тул өрөөнд нам гүм байна. Цаг мөч маш удаан өнгөрч байна. Смит хүчлэн Обрайены нүд рүү харлаа. Гэрийн эзэн инээмсэглэх гэж байгаа юм шиг болоод ширүүн харц нь зөөлөрлөө. Тэрээр дадсан зангаараа нүднийхээ шилийг хамрынхаа үзүүр рүү доошлуулав.

“Би ярих уу, та юм хэлмээр байна уу?”

“Би ярья. Тэрнийг үнэхээр унтраачихсан уу?”

"Тиймээ, бүгдийг нь унтраачихсан. Бид л байна"

"Бид энд ирсний учир бол.."

Смит энд ирэх болсон шалтаг нь хичнээн тодорхойгүй болохыг анх удаагаа ухаарч түгдэрлээ. Тэрээр Обрайенээс ямар тусламж дэмжлэг хүлээж байгаагаа мэдэхгүй байсан ба яах гэж ирснээ тайлбарлахад хэцүү байлаа. Гэлээ ч түүнд хэлж байгаа үг нь итгэл үнэмшил багатай, сүр бадруулсан юм шиг бодогддоо.

"Бид хуйвалдаан байна, ямар нэг далд байгууллага Намын эсрэг тэмцэл явуулж байна, түүнд таныг оролцдог гэж боддог юм. Бид үүнд оролцмоор, түүний төлөө ажилламаар байна. Бид бол Намын дайсан. Бид Ангсоцын зарчимд итгэдэггүй. Бид Сэтгэхүйнгэмтэн юм. Бид мөн завхай зайдан хүмүүс. Бид энэ бүхнийг ярихдаа бүх эрх мэдлийг өөрт чинь даатгаж байна. Биднийг хийсэн хэргээ хүлээ гэх юм бол бид хүлээхэд бэлэн байна"

Тэрээр ард нь хаалга онгойлгох шиг болсон тул дуугүй болоод эргэж хартал үнэхээр шар царайтай зарц хаалга тогшилгүй орж ирлээ. Тэр хоол зөөх тавиуртай галуун хүзүүт лонх, шнлэн аяга барьж ирлээ.

“Мартин манай хүн. Мартин нааш нь аваад ир. Дугуй ширээ тавьчих. Сандал хүрч байна уу? Бид ингэхэд суугаад ярилцаж болох юм. Мартин чи ч гэсэн сандал ав. Ажил хэргийн асуудал ярих гэж байна. Чи зарц гэдгээ арван минут мартаж болно” гэж Обрайен тайван тайлбарлаж ярилаа.

Жижигхэн эр эрээгүй суухдаа доод хүнд хүндэтгэл үзүүлсэнд нь талархаж буй аж. Смит түүнийг нүднийхээ булангаар сэм харж суухдаа энэ хүн насан туршдаа чухал хүний дүр эегэсэн бөгөөд хэдхэн хоромд ч түүнийгээ алдчихвий гэж эмээж байна даа гэж бодно. Обрайен галуун хүзүүтэй лонхны хүзүүнээс нь бариад шилэн аягыг хар хүрэн өнгөтэй шингэнээр дүүргэлээ. Смит ханан дээр бил үү, хашаан дээр билүү асар

том лонхноос шилэн аяганд шингэн урсаж байгаа юм шиг цахилгаан гүйдэл гүйхийг харснаа бүдэг бадаг санапаа. Шингэний дээд тал нь бараг хар юм шиг харагдаж байснаа галуун хүзүүт лонхонд орсон хойноо бадмаараг шиг өнгөтэй шатаж байж билээ. Исгэлэн амтархаг үнэр ханхалж байна. Жулия шилэн аягыг гартаа бариад ихэд сонирхон үнэрлэлээ.

“Дарс гэдэг юм” гэж Обрайен жуумалзан хэллээ. “Та энэ тухай номноос уншсан байж таарна. Харамсалтай нь гадуур Намын гишүүдэд нэг их олдоод байдаггүй байх аа” гээд түүний царай төв болж хундага өргөлөө. “Хундага өргөхөөс эхлэх нь зүйтэй юм болов уу гэж бодож байна. Бид бүхний жолоодогч Эммануэл Голдштейний төлөө хундагаа өргөө”

Смит дарсны тухай уншсан, дарс уух юмсан гэж мөрөөддөг тул аягатай дарсыг дуртайяа гартаа авлаа. Бөөрөнхий шил, ноён Чаррингтоны хагас хугасыг нь мартчихсан шүлгийн мөрүүдийн нэгэн адил дарс бол сөнөж алга болсон сэтгэл

хөдөлгөсөн өнгөрсөн үед, Смитийн сэтгэл дотроо хуучин цаг үе гэж нэрлэдэг үед хамаарах зүйл юм. Тэрээр дарс бол чихэрлэг, үхрийн нүдний чанамал шиг чихэрлэг, тэр дороо толгойд гардаг байх ёстой гэж яагаад ч юм боддог байсан юм. Тэрээр дарсыг амтлахад тэр нь үнэндээ сэтгэлд нь таалагдсангүй. Тэрээр өдий олон жил жин уусан болохоор үнэнийг хэлэхэд одоо дарсны амтыг бараг мэдэрсэнгүй. “За тэхлээр Голдштейн гэдэг хүн байдаг байх нь ээ?”

"Тийм ээ, тэр хүн бий. Амьд сэрүүн байгаа. Би харин хаана байдгийг нь мэдэхгүй”

“Хуйвалдаан, нууц байгууллага? Үнэн хэрэг дээрээ байна уу? Сэтгэхүйн Цагдаагийн зохиосон юм уу?”

“Үгүй. Бодитой оршиж байгаа. Бид Ах дүүгийн барилдлага гэдэг юм. Энэ байгууллага байна, чи түүнд багтдаг гэдгээс өөр илүү юм мэдэж чадахгүй. Би энэ тухай дахиад ярина” гээд

тэрээр цагаа харлаа. “Дотуур Намын гишүүн хүртэл теледэлгэцээ хагас цагаас илүү хугацаагаар унтраах ёсгүй юм. Та хоёр хамтдаа ирэх хэрэггүй байсан. Тус тусдаа яваарай” хэмээн Жулия руу толгойгоо дохиод, "Та эхлээд гарч явна. Бидэнд хориод минут байна. Би юуны өмнө та нараас хэдэн асуулт асуух ёстойг ойлгож байгаа биз ээ. Ер нь тэхлээр та нар юу хийж чадах юм бэ?" гэв.

“Чадах бүхнээ л хийхэд бэлэн байна” гэж Смит хариулав. Обрайен цээжээрээ эргэж Смит рүү харж суулаа. Смит өмнөөс нь ярьж байна гэж ойлгосон бололтой Жулияд хандаж бараг үг хэдэхгүй байв. Тэрээр хоромхон зуур алгаараа нүдээ дараад хоолойныхоо өнгийг үл хувирган урдаас цээжилчихсэн хариултыг нь, тэртэй тэргүй мэдэж байгаа асуултыг лам хүн асууж буй мэт ярьж эхэллээ.

"Та амь насаа золиосолж чадах уу?"

“Чадна”

"Та хүний амь насыг хөнөөж чадах уу?"

"Чадна"

"Гэмгүй хэдэн зуун хүний амь насанд халтай хорлон сүйтгэх ажиллагаа явуулж чадах уу?"

"Чадна"

"Гадаадын гүрэнд эх орноо урван тэрслэх үү?"

"Тэгнэ"

"Та хүүхдийн оюун ухааныг хууран мэхлэх, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, нээнтэглэх, хар тамхи тараах, биеэ үнэлэхийг өөгшүүлэх, арьс өнгөний өвчин дэлгэрүүлэх, Намын хүчин чаддыг сулруулах, хүн амын дунд эмх замбараагүй байдал үүсгэхийн төлөө чадах бүхнээ хийхэд бэлэн байна уу?"

"Гийм"



“Манай эрх ашгийн тусын тулд нялх хүүхдийн нүүр рүү хүхрийн хүчил цацах хэрэг гарлаа гэхэд жишээ нь та нар ийм юм хийхэд бэлэн үү?”

"Тийм"

"Та нар нэр төрөө алдаж насныхаа үлдсэн хугацаанд хоол зөөгч, усан буудлын хар ажилчнаар ажиллахад бэлэн үү?"

"Тийм"

“Бид хэзээ нэгэн цагт та нарт тушаал өгвөл өөрсдийгөө егүүтгэхэд бэлэн үү?”

"Тийм"

"Та хоёр бие биеэсээ үүрд хагацаж бие биетэйгээ хэзээ ч уулзахгүй байхад бэлэн үү?"

“Үгүй!” гэж Жулия дуу алддаа. Смитэд хариу хэлэхийн өмнө их удах шиг болж үг хэлэх чадвараа алдсан юм шиг байлаа. Амнаас нь дуу

гарахгүй эхлээд нэг үг, дараа нь өөр үг цухалзаж байлаа. Тэрээр үгээ хэлэхдээ ямар үг хэлж байгаагаа ч мэдэхгүй байв. “Үгүй” гэж тэрээр одоо л дуугарлаа.

“Та үүнийг хэлсэн чинь сайн байна. Бид бүх юмыг нэг нэггүй мэдэх ёстой” гэж Обрайен хэлээд Жулия руу эргэн харж хоолойныхоо өнгийг засаад:

“Тэрээр амьд үлддээ ч гэсэн огт өөр хүн болно гэдгийг ойлгож байна уу? Бид түүнийг бүрмөсөн өөрчилж ч магадгүй юм. Нүүр, хөдөлгөөн, гар сарвууны хэлбэр, үснийх нь өнгө, тэрч байтугай дуу хоолойных нь өнгө ч өөрчлөгдөнө. Чамайг ч гэсэн огт өөр хүн болгоно. Манай мэс засалчид хүнийг танигдахааргүй өөр болгодог. Зарим үед ингэх шаарддага гардаг. Бид заримдаа үе мөчий нь ч салгадаг”

Смит тэсэлгүй Мартины монголжуу царай руу нүднийхээ булангаар харлаа. Түүний нүүрэнд

ямар ч шарх сорви анзаарагдсангүй. Жулиягийн царай цав цайж сэвх нь тодорч харагдсан ч тэрээр Обрайены өөдөөс эгцдэн харж байна. Жулия зөвшөөрч байгаа бололтой амандаа үглэлээ.

“За, бид тохиролцчих шив дээ”

Обрайн ширээн дээр байгаа мөнгөн хайрцагтай янжуурыг хайхрамжгүйхэн нөгөө хоёр руу ойртуулаад өөртөө нэг янжуур авч босоо байхад сайн боддог юм шиг нааш цааш аажим алхлаа. Янжуур нь сайн чанарын бөгөөд боодол нь сайн, чигжээс сайтай, торгомсог зөөлөн цаастай аж. Обрайн цагаа дахиад харлаа.

“Мартин чи буфетэндээ очсон нь дээр байх. Арван таван минут болоод би очно. Одоо чи энэ нөхдийн нүүрийг явахаас нь өмнө сайн хараад аваарай. Чамд эдэнтэй уулзах хэрэг гарна шүү. Надад бол бараг үгүй биз дээ”

Анх орж ирсэн үеийнх шиг зарцын хар нүдний харц тэдний нүүрэн дээгүүр гүйгээд өнгөрлөө. Тэр харцанд нөхөрсөг гэхээр юм огт алга. Тэрээр тэдний төрх байддыг тогтоож авсан боловч тэднийг үнэндээ сонирхсон ч үгүй, юутай ч тийм сонирхол ажиглагдсангүй. Мартин үг ч дуугарсангүй, баяртай ч гэж хэлсэнгүй хаалгаа чимээгүйхэн хаагаад гарч явлаа. Обрайен нэг гараа халаасандаа хийчихсэн нөгөө гартаа янжуураа барьчихаад өрөөний дотуур алхалж байна.

"Та нар харанхуйд тэмцэл явуулна гэдгээ ойлгож байгаа биз дээ. Үргэлж харанхуйд шүү. Яах гэж байгааг нь мэдэхгүйгээр даалгавар авч түүнийгээ биелүүлэх болно. Би сүүлд та нарт нэг ном явуулна, та нар тэр номноос манай нийгмийн жинхэнэ мөн чанар, түүнийг нураах стратегийг олж мэдэх болно. Номыг уншаад Ах дүүгийн барилддагын бүрэн эрхт гишүүн болно. Тэмцдийн ерөнхий зорилт, цаг үеийн яаралтай даалгавраас өөр юмыг та нар хэзээ ч мэдэхгүй. Би та нарт Ах дүүгийн барилдлага байгаа

гэдгийг хэлж чадах боловч түүний гишүүд нэг зуу юу, арван сая уу гэдгийг хэлж чадахгүй. Та нар өөрсдийнхөө холбоо сүлбээгээр энэ байгууллагад арваад хүнийг ч тогтоож чадахгүй. Та нартай гурав, дөрөвхөн хүн л холбоотой ажиллана, хэн нэг нь сураггүй алга болох юм бол оронд нь өөр хүн гарч ирнэ. Энэ маань анхны холбоо болохоор хадгалагдаж үлдэнэ. Та нар тушаал даалгавар авах юм бол энэ нь надаас гарсан гэж мэдэх хэрэгтэй. Та нар бидэнд хэрэг болох юм бол Мартинаар дамжуулан та нарыг олно. Та нарыг баривчлах юм бол та нар хэргээ хүлээнэ. Энэ бол зайлшгүй тохиолдоно. Та нарт өөрсдийн хэргээс өөр хүлээгээд байх юм байхгүй. Та нар цөөн хэдэн ач холбогдол багатай хүмүүсийг л барьж өгч чадна. Намайг ч барьж өгч бараг чадахгүй байх. Тэр үед чинь би үхсэн байна эсвэл өөр дүр төрхтэй өөр хүн болж хувирсан байна”

Тэрээр зузаан хивс дээгүүр алхсаар байна. Обрайен том биетэй ч гайхмаар хөнгөн алхана. Энэ уян налархай байдал нь гараа халаасандаа

хийж байгаа, янжуураа хурууныхаа завсар хавчуулж байгаагаар илэрнэ. Тэрээр хүчтэйгээс гадна итгэл төгс, жаахан сэргэлэн мэт сэтгэгдэл төрүүлнэ. Тэрээр буурь суурьтай харагдах бөгөөд хэт бишрэн шүтэгчдэд байдаг явцуу бодол түүнд огт үгүй байлаа. Тэрээр аллага, өөрийгөө егүүтгэх, заг хүйтэн, үе мөч тасдан салгах, нүүр өөрчлөх тухай ярихдаа хоолойд нь шоолох өнгө цухуйж байсан. «Энэ бол зайлшгүй зүйл, бид энэ бүхнийг ямар ч эргэлзээгүй хийнэ. Гэхдээ амьдрал дахиад үнэ цэнтэй болоход бидний хийх юм бол энэ биш ээ гэж тэрээр хэлж байх шиг байна.» Смитэд Обрайеныг гайхан бишрэх, түүнийг бараг шүтэх сэтгэл төрж байлаа. Голдштейний бүдэг бадаг дүр төрхийг тэрээр одоохондоо мартчихсан байна. Обрайены хүчирхэг цээж, болхи тэгсэн мөртлөө сэргэлэн хээгүй царайг харахад энэ эр ялагдана гэж итгэхэд бэрх байлаа. Түүнд аргалж болохгүй бач заль, давж гарахгүй бэрхшээл саад гэж байхгүй байна. Жулияд хүртэл сэтгэсдэл төрүүлчихсэн бололтой байх ба түүний янжуур нь унтарчихсан анхааралтай сонсож байна.

"Та нар лав Ах дүүгийн барилддагын тухай ажиг сураг сонссон байж таарна. Та нарт ч тэр байгууллагын талаар ойлголт төрсөн байна. Та нар хуйвалдагчдын өргөн далд байгууллага байгаа, тэд нар байшингийн доод хонгилд цуглардаг, ханан дээр бичээс үлдээдэг, гудамжинд нууц үг дохиогоор бие биеийгээ таньдаг гэж төсөөлж байгаа байх аа. Ийм юм ерөөсөө байхгүй. Ах дүүгийн барилддагын гишүүдэд бие биеийгээ таних боломж байхгүй, хүн бүр хэдхэн хүнийг л таньдаг юм. Голдштейн өөрөө Сэтгэхүйн Цагдаагийн гарт орох юм бол Ах дүүгийн барилдлагын гишүүдийн жагсаалтыг задруулж, энэ жагсаалтыг илрүүлэх мэдээллийг өгч чадахгүй. Ийм жагсаалт байхгүй. Ах дүүгийн барилдлага бол жирийн бидний ойлгодог шиг байгууллага биш учраас түүнийг устгах арга байхгүй. Энэ байгууллага үзэл суртлаар бэхлэгдсэн, үзэл суртлыг устгаж болдоггүй юм. Үзэл суртлаас өөр юм дээр тулгуурлах арга байхгүй. Ингэхгүй бол нөхөд ч байхгүй, дэмжлэг ч байхгүй болно. Эцсийн бөлөгт та нарыг баривчилж таарна, тусламж

хайх хэрэггүй. Бид ерөөсөө өөрийнхөндөө тусалдаггүй. Үг алдуулахгүй байх шаарддага байна гэж үзэх юм бол сайндаа л гянданд сахлын тонгорог дамжуулж амждаг юм. Та нар үр дүнгүй, итгэл найдваргүй амьдралд дасах хэрэгтэй. Та нар нэг хэсэгтээ үйл ажиллагаа явуулна, тэгээд баригдана, тэгээд хэргээ хүлээнэ, дараагаар нь үхнэ. Та нар үүнээс өөр дүн үзэхгүй. Бидний амьд байхад мэдэгдэхүйц өөрчлөлт гарна гэж бодохын ч хэрэг байхгүй. Бид нар үхдэлүүд. Бидний жинхэнэ амьдрал, ирээдүйд бий. Бид ирээдүйд атга чандруу, ясныхаа хэлтэрхийгээр л орно. Ирээдүй хэзээ ирэхийг хэн ч мэдэхгүй. Мянган жилийн дараа ч байж магадгүй юм. Одоо бол эрүүл саруул ухаанаа бага багаар тэлэхээс өөр юу ч хийж болохгүй. Бидэнд хамтарч үйл ажиллагаа явуулах арга байхгүй. Бид мэддэгээ хүнээс хүнд, нэг үеийнхнээс нөгөө үеийнхэнд л зөвхөн уламжилж болно. Сэтгэхүйн Цагдаа бидний эсрэг байгаа цагт өөр зам байхгүй”



Тэрээр дуугүй болоод гуравдахь удаагаа цагаа харлаа.

“Нөхөр минь, таны явах цаг болсон байна. За байзна, Дарс үлдсэн байна” гэж тэрээр Жулияд хэллээ.

Тэрээр аяганд архи дүүргээд өөрийнхийгөө өргөлөө.

“За энэ удаа юуны төлөө хундага өргөх вэ” гэж яльгүй егөөдөн хэлээд “Сэтгэхүйн Цагдааг гутаахын төлөө юу? Их Ахын үхлийн төлөө юу? Хүн төрөлхтний төлөө юу? Ирээдүйн төлөө юу?” “Өнгөрсөн үеийн төлөө” гэж Смит хэлэв.

“Өнгөрсөн үе илүү чухал юм” гэж Обрайен жинтэй дэмжлээ. Тэд нар аягатай дарсаа хөнтөрчихөөд Жулия суудлаасаа бослоо. Обрайен ханын шүүгээний татуурганаас цагаан өнгөтэй шахмал гаргаад Жулияд хэлэн дороо тавиарай гэж өгөв.

“Дарс үнэртүүлж болохгүй. Цахилгаан шатны жижүүрүүд их ажигламтгай шүү”

Тэрээр Жулиягийн араас хаалга хаагдмагц түүнийг ор тас мартчих шиг болоод хоёр гурав алхсанаа зогсов.

“Нарийн ширийн юмаа тохиролцох хэрэгтэй байна. Чамд ямар нэг нуугдах газар байгаа гэж таамаглаж байна, тийм биз дээ?” Смит ноён Чаррингтоны мухлагийн дээр өрөө бий гэдгээ хэлэв.

“Эхэн үед тэр чинь болно. Бид дараа нь чамайг өөр газар байрлуулна. Нуугдах газрыг үе үе сольж байх хэрэгтэй. Одоохондоо чамд нотыг аль болохоор хурдан хүргүүлэхийг хичээе” Смит Обрайен хүртэл энэ үгийг цохолттой хэлж байгааг анзаарлаа. “Голдштейний номыг хэлж байгааг ойлгож байгаа биз дээ. Аль болохоор хурдан хүргүүлье. Надад энэ ном хэд хоногийн дараа л олдох байх. Бэлэн хувь ховор гэдгийг мэдэж байгаа биз ээ. Сэтгэхүйн Цагдаа номыг

хайж байдаг, олонгуутаа бидний хэвлэж байгаа шиг хурдан устгачихдаг юм. Гэхдээ энэ бол ач холбогдол бага зүйл. Номыг устгаж чадахгүй. Номын хамгийн сүүлчийн хувийг устгалаа ч гэсэн бид түүнийг үг үсгээр нь сэргээж чадна. Та ажилдаа цүнхтэй явдаг уу?”

“Ер нь бол тэгдэг”

“Ямар цүнх вэ?”

“Хар өнгөтэй. Их хуучирсан. Хоёр цоожтой”

“Хар өнгөтэй. Хоёр цоожтой. Иххуучнн.. За ойлголоо. Ойрын хэд хоногт, яг өдрий нь хэлж мэдэхгүй байна. Өглөөгүүр хүлээж авдаг даалгавар дотор чинь буруу бичсэн үг дайралдана, түүнийг давтаж өгөхийг шаардаарай. Дараагийн өдөр нь ажилдаа цүнхгүй яваарай. Тэр өдөр гудамжинд нэг хүн гараас чинь татаад «Та цүнхээ унагачих шиг боллоо» гэж хэлнэ. Тэр хүн Голдштейний

номтой цүнхийг чамд өгнө. Чи яг хоёр долоо хоногийн дараа номыг эргүүлж өгөөрэй”

Тэд чив чимээгүй болцгоов.

“Явахад гурван минут үлдлээ. Бид дахиад уулзана... уулзах юм бол..”

Смит түүний нүд рүү харж байна.

“Гэрэл гэгээтэй нэг газарт” гэж тэрээр итгэл муутайхан хэллээ.

Обрайен огт гайхалгүй толгойгоо дохив.

“Гэрэл гэгээтэй нэг газарт” гэж тэрээр өөрт нь ойлгомжтой далд санааг ойлгосон юм шиг давтаж хэллээ. “Одоохондоо, явахын өмнө өөр хэлэх юм байна уу? Хүсэлт байна уу? Асуулт?”

Смит бодлогоширлоо. Түүнд өөр асуух юм алга, салж явахдаа улиг болсон гоё сайхан үг хэлэх ч сонирхол байсангүй. Смитийн ой тойнд Ах

дүүгийн барилддага байгууллагатай ч шууд хамаагүй, Обрайентай ч шууд хамаагүй нэгэн нийлмэл дүр зураг орж ирлээ. Энэхүү дүр зурганд эхийнх нь сүүлчийн өдрүүдээ өнгөрөөсөн бүдэг өрөө, бөөрөнхий шил, улаан модон жаазтай сийлбэр зураг бүхий ноён Чаррингтоны өрөө холилджээ. Смит санаандгүй.

"Та ийм нэг хуучин шүлэг сонссон уу? «Гэгээн Клементийн хонх амтат зүрж, нимбэг гэж дуудна» гэж эхэлдэг юм" гэлээ.

Обрайен энэ удаа ч толгой дохиод их л дуртайяа ихэмсгээр шүлгийн бадгийг дуустал уншлаа.

*"Гэгээн Клементийн хонх амтат зүрж, нимбэг гэж дуудна*

*Гэгээн Мартины хонх гурван фартинг өг гэж дуудна*

*Олд-Бейлийн хонх өрөө эргүүлж өгөх үү гэж дуудна*

*Шордичийн хонх мөнгөтэй болохоороо өгнөө гэж дуудна”*

"Та сүүлчийнх нь мөрийг мэдэж байна шүү!" гэж Смит хэллээ.

"Тийм ээ. Би сүүлчийн мөрийг мэднэ. За одоо харамсалтай нь таны явах цаг боллоо. За байзнаарай. Би танд энэ шахмалуудаас өгөөтөхье”

Смитийг босоход Обрайены бахим гар Смитийн алганы ясыг бяц атгах шиг боллоо. Смит хаалган дээрээс эргэж харахад Обраиен түүнийг аль хэдийнээ мартчихсан юм шиг харагдаж теледэлгэцийн унтраалгыг асаахаар завдаж буй аж. Түүний цаана нь ногоон бүрээстэй дэнлүү бүхий бичгийн ширээ, үгбичигч болон цаас овоолоотой төмөр сагс харагдлаа. Энэхэн мөч үүгээр дууслаа. Хэдхэн хормын дараа гэрийн

эзэн Намын хариуцдагатай ажлаа үргэлжлүүлнэ  
гэж Смит бодлоо.

## IX

Смит ядраад царцанги болжээ. Царцанги гэдэг бол яг оносон үг. Энэ үг түүний толгойд гэв гэнэт орж ирсэн юм. Бүх бие нь царцанги юм шиг сулаар зогсохгүй хагас тунгалаг болчихжээ. Тэрээр гараа дээш нь өргөх юм бол түүгээр гэрэл нэвтрэх юм шиг санагдана. Ажлын хэнээрхэл биенээс нь бүх цус, шингэний нь шавхаад зөвхөн мэдрэл, яс, арьс үлдээжээ. Бүх мэдрэмж нь туйлдаа хүртэл хурцаджээ. Баадай нь мөр үрж, явган зам хөлийнх нь улыг гижигдэж гараа зангидахад нь бүх үе мөч нь шажигнадаг болжээ.

Тэрээр долоо хоногт ер гаруй цаг ажиллажээ. Яамны ажилчид мөн л ингэж ажшшасан. Одоохондоо энэ бүх юм дуусаж маргааш хүртэл үнэндээ түүнд хийх ажил байхгүй, маргааш хүртэл ямар ч Намын ажил байхгүй аж. Тэрээр зургаан цагийг нууц байрандаа, дахиад есөн цагийг орондоо өнгөрөөж болох аж. Тэрээр зуны оройн жаргаж буй нар гарч байхад эргүүл байна



уу гэж эргэн тойрноо харсаар дотроо хэн ч түүнийг зогсоохгүй гэдэгт итгэн шавар шавхайтай гудамжаар ноён Чаррингтоны мухлаг руу алхаж явлаа. Хүнд цүнх нь алхам тутамд нь өвдгий нь цохиж бүх хөлий нь доргиож байна. Цүнхэн дотор нь нөгөөх ном бий, зургаа дахь өдрөө тэнд тэр нот байгаа бөгөөд түүнд номоо нээж үзэх нь байтугай гаргаж харах ч зав гараагүй юм.

Сүрт жагсаал, үг хэлэх, орилолдоон хашгиралдаан, нийтээр дуу дуулах, уриа лоозон хашгирах, зурагт хуудас гаргах, кино үзүүлэх, лаван сатга хийх, бөмбөрийн нижигнээн, бүрээ бишгүүрийн дуу, цэрэг эрийн маршаар алхах алхаа, танкны гинжний пичигнээн, байлдааны нисэх онгоц болон их бууны бууддагын чих дүлийрэм дуу зэргийн дараагаар Евразийн Гүрний цэргийн хоёр мянган олзлогдогсодыг энэ арга хэмжээний сүүлчийн арга хэмжээ болгож олон нийтийн өмнө дүүжлэх үеэр, Үзэн ядалт дээд цэгтээ хүрсэн бүх нийтийн хийрхэлийн үеэр олзлогдогсод бөөн хүмүүсийн

дунд орох юм бол тэднийг уе мөчөөр нь тасдаж хаях байсан чухамхуу тэр өдөр буюу Үзэн ядах долоо хоногийн зургаа дахь өдөр Далайн Гүрэн Евразийн Гүрэнтэй бус Дорнодазийн Гүрэнтэй дайтаж байна гэж зарлалаа. Дорнодазийн Гүрэнтэй дайтаж байна, Евразийн Гүрэн бол холбоотон мөн.

Ямар нэг өөрчлөлт гарсан гэх ямар ч юм ажиглагдсангүй. Дайсан бол Евразийн Гүрэн биш Дорнодазийн Гүрэн гэдэг нь гэв гэнэт хаа сайгүй илэрхий боллоо. Энэ мэдээ гарах үед Смит

Лондоны нэгэн төв талбайд жагсаалд оролцож явлаа. Үдэш болчихсон, гэрэлтүүлэгчийн хурц гэрэл хүмүүсийн цайвар цагаан нүүр, час улаан туг далбаан дээр тусаж байна. Талбайд хэдэн мянган хүн цугларчихсан тэдний дотор тагнуулчдын дүрэмт хувцастай мянга орчим сургуулийн сурагчид оролцож байв. Час улаан даавуугаар бүрсэн индэр дээр туранхай биетэй, хэт урт гартай, хэдхэн өрвийсөн үстэй хав

халзан толгойтой Дотуур Намын гишүүн эр үг хэлж байна. Жижигхэн эр үзэн ядалтдаа улайран нэг гараараа микрофоны ишийг муруйтал атгаж нөгөө ясархаг гараа толгой дээгүүрээ сүрдүүлэн зангаж байна. Мань хүн хахир хоолойгоор хязгааргүй их зэрлэг үйлдэл, хүйс тэмтрэх ажиллагаа, бүхэл бүтэн ард түмний нүүлгэн шилжүүлэлт, дээрэм тонуул, хүч хэрэглэх, дайны олзлогдогсдын тарчлаан тамлалт, энгийн хүн амыг бөмдөгдөж хөнөөсөн, санаанаасаа зохион явуулж буй суртал ухуулга, эрээ цээргүй түрэмгийлэл, гэрээ хэлэлцээрийг зөрчиж буй тухай дуу чангаруулагчаар аль байдгаараа орилно.

Түүний үгийг сонсоод эхлээд итгэхгүй байх, дараа нь солиорохгүй байх арга алга байна. Цугларсан хүмүүсийн уур хилэн хэдэн хором тутамд шатаж хэдэн мянган хүний зэрлэг араатан архирах шиг дуунд үг хэлэгчийн дуу дуулдахаа больж байлаа. Сургуулийн сурагчид хамгийн муухайгаар орилж байна. Илтгэгч үг хэлж эхлээд хориод минут болж байхад зарлага

индэр дээр яаран гарч ирэн илтгэгчийн гарт тал хуудас цаас бариуллаа. Илтгэгч үгээ хэлсээр л нөгөө цаасыг дэлгээд уншлаа. Түүний хоолойны өнгө ч, төрх байдал нь ч, ярьж байгаа юмных нь агуулга ч өөрчлөгдсөнгүй гэхдээ хүмүүсийн нэр гэнэт өөр болчихжээ. Цугларсан хүмүүс ямар ч үг дуугаралгүй Далайн Гүрэн Дорнодазийн Гүрэнтэй дайтаж байгааг ойлгон дэмжиж байна. Дараагийн агшинд маш их үймээн шуугиан дэгддээ. Талбайг чимэглэсэн туг далбаа, самбар буруу байна! Тэдгээрийн хагас дээр буруу хүний нүүр зурсан байна. Энэ бол хорлон сүйтгэх ажиллагаа мөн! Голдштейний тагнуул туршуулууд үйл ажиллагаа явуулж байжээ! Ханан дээр наасан зурагт хуудсыг хуулж туг далбааг урж тасдан хөл дороо гишгиж байхад бослого гарах нь уу гэмээр байлаа. Тагнуулчид байшингийн дээвэрт шаламгай авирч яндангуудын дунд дэржигнэн хийсч буй лоозонгийн даавууг тасдан авч байна. Харин хоёр гуравхан минутад бүх юм намжлаа. Илтгэгч цээжээ түрэн зогсоод нэг гараараа микрофоны ишийг барьчихсан нөгөө гараараа

зангаж үгээ таслалгүй хэлсээр байна. Нэг минут өнгөрөхөд л цугларсан олон хүн уурлаж хилэгнэн урьдын адил орилж хашгирч эхэллээ. Үзэн ядалт юу ч болоогүй юм шиг үргэлжилж байна. Харин бай нь өөр болжээ.

Илтгэгч огтхон ч мэдрэлгүй нэг чиг шугамаас нөгөө чиг шугамд хэлж байгаа өгүүлбэрийнхээ дунд, тэр ч байтугай үгийн дарааллыг алдалгүй шилжиж чадаж байсныг Смит эргэн санаад ихэд гайхаж байлаа. Одоо бол түүнд үүнийг бодох зав алга байна. Зурагт хуудсыг урж тасдан үймээн шуугиан дэгдэж байх тэрхүү агшинд нүүрээ үл харуулсан хэн нэгэн Смитийн мөрөн дээр аяархан цохиод “Уучлаарай, та цүнхээ унагачих шиг боллоо” гэхэд тэрээр цүнхийг авчээ. Цүнхний доторхийг үзэх боломж олдтол хэдэн хоног өнгөрнө гэдгийг тэрээр мэдэж байсан юм. Тэрээр бараг хорин гурван цаг болж байсан ч гэсэн жагсаал тармагц л Үнэний Яам руугаа явав. Яамны бүх ажилтнууд ч мөн яам руугаа явцгаалаа. Теледэлгэцээр тэднийг албан

ажлынхаа байранд ирэхийг дуудаж эхэлсэн ч гэсэн энэ нь илүү ажил байлаа.

Далайн Гүрэн Дорнодазийн Гүрэнтэй дайтаж байна. Далайн Гүрэн Дорнодазийн Гүрэнтэй үргэлж дайтаж байсан юм. Таван жилийн өмнөх улс төрийн номууд одоо огт хэрэггүй болжээ. Бүх төрлийн мэдээ, баримт, сонин, ном, товхимол, кино, дууны бичлэг, фото зургийг маш түргэн засварлаж өөрчлөх хэрэгтэй байна. Энэ талаар ямар нэг даалгавар өгөөгүй ч гэсэн Газрын дарга нар Евразийн Гүрэнтэй дайтсан тухай болон Дорнодазийн Гүрэнтэй холбоотон байсан тухай аливаа мэдээллийг долоо хоногийн дотор устгахаар шийдсэн нь тодорхой боллоо. Хийх ажил маш их, тэх тусмаа хийх аргы нь жинхэнэ нэрээр нь хэлж болохгүйд л бэрхшээл байлаа. Баримтжуулах газарт ажилтнууд нь хоёр гурван цаг унтаж амраад хоногт арван найман цагаар ажиллаж байв. Доод хонгилоос дэвсгэр гаргаж хонгилоор дэвсэж гуанзнаас бутерброд, «Виктори» кофе түрдэг тэргээр зөөж байлаа. Смит завсарлага болохоос

өмнө ширээгээ суллахыг хичээж байсан боловч нойрмог нүдлэн бүх бие нь янгинан өвдсөөр эргэж ирэхэд нь ширээ нь бөөн бөөрөнхий цаасанд дарагдчихсан үгбичигчийг нь дарчихсан зарим нь газар уначихсан байдаг, тэрээр юуны түрүүнд ажлын байраа суллахын тулд цаасаа эвтэйхэн овоолно. Ажил нь зөвхөн механик ажиллагаа шаардаад зогсдоггүй нь хамгийн хэцүү байв. Заримдаа хүний нэг нэрийг нөгөөгөөр солиход л хангалттай байдаг юм, дэлгэрэнгүй мэдээ бүр анхаарал, уран сэтгэмж шаардана. Дайны талбарыг дэлхийн нэг хэсгээс нөгөө хэсэгт аваачихын тулд газар зүйн багагүй мэддэг шаардагдана.

Түүний нүд нь гурав дахь өдрөөс эхлэн тэсч байхын аргагүй өвдөж хэдэн мөч тутамд нүднийхээ шилийг арчих хэрэг гарна. Энэ нь хүч чадал хүрэхгүй биеийн хөдөлмөрийг санагдуулна. Чи энэ ажлыг хийхгүй байж болох боловч хийж дуусгахаар махарч байгаа юм шиг санагдана. Тэрээр үгбичигчид хэлж бичүүлсэн үг бүр, цаасан дээр гаргасан мөр бүр нь зориуд

зохиосон худал хуурмаг юм байсанд сэтгэл огтхон ч зовоогүй бөгөөд энэ талаар бодох завч байсангүй. Тэрээр газрынхаа бусад ажилтны нэгэн адил баримтыг хуурамчаар өө сэвгүй үйлдэх юмсан гэж сэтгэл нь зовно. Зургаа дахь өдрийн өглөөгүүр ирэх даалгавар барагдаж эхэллээ. Хагас цагт нэг ч бөөрөнхий цаас гарч ирсэнгүй, дараа нь нэг даалгавар, дахиад юу ч ирсэнгүй. Энэ үеэр ажил багассаар байлаа. Газар даяар хүмүүс гүн, нууцхан гэмээр амьсгаа авлаа. Хэзээ ч дурьдаж болохгүй аугаа их гавьяа байгуулцгаав. Дэлхий дахинаа нэг ч хүн Евразийн Гүрэнтэй дайтаж байсан гэж баримтаар нотолж чадахгүй. 12. 00- д Яамны ажилтнууд маргааш өглөө хүртэл чөлөөтэй гэж гэнэт зарлав. Смит цүнхэн дэх номтойгоо (тэрээр ажлаа хийж байхдаа цүнхээ хөлнийхөө хооронд хавчаад хэвтэхдээ дороо хийдэг байсан) гэртээ ирээд сахлаа хусчихаад усанд орохдоо ус жаахан бүлээхэн байсан ч гэсэн арай л унтчихсангүй.



Тэрээр үе мөчөө тааламжтай гэгч нь шажигнуулсаар шатаар өгсөж ноён Чаррингтоны өрөөнд орлоо. Ядаргаа арилаагүй ч унтах дур нэг л хүрэхгүй байна. Цонх онгойлгоод керосин халаагуур асаагаад кофе чанах ус тавилаа. Жулия одоохон ирнэ, тэр болтол нотоо уншина. Тэгээд хир тоостой түшлэгтэй сандал дээр суугаад цүнхээ онгойлголоо.

Гараар хавтасласан хар хавтас дээр зохиогчийн нэр, номын гарчиг алга. Номын үсэг нь тэгш бус юм. Хуудсууд нь өнцгөөрөө урагдчихсан байх ба олон хүний гар дамжсан бололтой амархан салж унаж байна. Номын нүүр хуудас дээрх бичиг нь:

Эммануэль Голдштейн

ОЛИГАРХИЙН ХАМТЫН ЗАРЧМЫН ОНОЛ,  
ПРАКТИК

Смит уншиж эхлэв.

## Бүлэг 1

### ҮЛ МЭДЭХ НЬ ХҮЧ

Түүх тэмдэглэгдсэн хугацаанд, магадгүй Шинэ чулуун зэвсгийн эринээс энэ дэлхий дээр гурван зүйл хүн байсан. Дээдчүүл, Дундчуул, Доодчуул. Бүлэглэлүүдийг янз бүрээр хуваадаг, тэдэнд тоо томшгүй олон нэр өгдөг байсан, тэдний хоорондын ханддага зуунаас зуунд өөрчлөгдөж байсан юм. гэлээ ч нийгмийн суурь бүтэц ерөөсөө өөрчлөгдөөгүй юм. Энэ бүтэц нь асар том донсолгоо, эргэлт буцаптгүй юм шиг өөрчлөлтийн дараа ч хааш нь ч түлхсэн хуучин байрандаа эргээд очдог гороскоп шиг дахиад л бий болдог байна.

Энэ гурван бүлгийн зорилго нь огт эвлэршгүй...

Тэрээр хамгийн гол нь тайван тухтай суугаад уншиж байна гэдгээ дахин нэг сайн мэдрэхийн тулд уншихаа зогсов. Гав ганцаараа байна. теледэлгэц ч байхгүй, цоожны нүхээр чагнаж

буй хүн ч алга, номынхоо хуудсыг эргүүлэхдээ ийш тийшээ харах, хуудсаа алгаараа таглах шаарддага алга. Зуны зөөлөн салхи хацрыг нь үлээнэ. Хаа нэг газраас хүүхэд шуугилдах сонсдоно, өрөөн дотор ханын цагийн зүү хөддөх үл ялих чимээнээс өөр юу ч үл дуулдана. Тэрээр түшлэгтэй сандалдаа тухтай суугаад хөлөө задгай зуухны хаалтын төмөр торон дээр тавилаа. Ингэж суух нь аз жаргалтай, мөнхийн баяр юм. Хэн нэгэн заавал унших, эхнээс нь дуустал дахин дахин унших номондоо ханддагаар тэрээр дайралдсан хуудсаа эргүүлэхэд гуравдугаар бүлгийн эхний мөрүүд харагддаа. Тэрээр уншиж гарлаа.

### Бүлэг 3

## ДАЙН БОЛ ЭНХ ТАЙВАН

Дэлхийг гурван хэт их гүрэнд хуваасан нь урьдчилан харж болох үйл явдал байсан ба үүнийг ХХ зууны дунд үеэс урьдчилан харсан юм. Орос Европыг эзэлж Америкийн Нэгдсэн

Улс Британий эзэнт гүрнийг эзэлснээр хэрэг дээрээ хоёр хэт их гүрэн бий болсон. Гурав дахь нь болох Дорнодазийн Гүрэн нь хэдэн арван жил үргэлжилсэн эмх замбараагүй дайн дажны дараагаар бүхэл бүтэн улс болж бүрджээ. Хэт их гүрнүүдийн хоорондын хил хязгаар нь зарим газраар тогтоогдоогүй, зарим газар байлдааны байддаас шалтгаалан өөрчлөгдөж байдаг боловч жинхэнэ газар зүйн хил хязгаартай давхцана. Евразийн Гүрэн нь Португалиас Берингийн хоолой хүртлэх Европ Азийн эх газрын бүх умарт хэсгийг эзлэнэ. Далайн Гүрний нутаг дэвсгэрт хоёр Америк тив, түүний дотор Британи, Австралази болон Өмнөд Африк болон Атлантын далайн арлууд багтана. Энэ гурван их гүрний хамгийн бага нь бөгөөд баруун хил хязгаар нь бүрэн тогтоогдоогүй Дорнодазийн Гүрэн Хятад, түүнээс өмнө орших орнууд, Японы арлууд, Манжуур, Монгол, Төвдийн тогтворгүй хэсгийн ихэнхийг хамрана.

Гурван хэт их гүрэн бие биетэйгээ элдэв холбоо байгуулан хорин таван жил үргэлжилчихээд

байгаа дайныг хийж байна. Дайн нь ХХ дугаар зууны эхний хагасынх шиг онц аюултай, сүйрэл авчирсан тэмцэл байхаа нэгэнт больсон юм. Энэ байлдааны ажиллагаа нь бие биеэ устгах чадваргүй цэргийн бүлэглэлүүд хоорондын хязгаарлагдмал байлдаан бөгөөд тэдэнд дайн хийх эд баялгийн ашиг сонирхол, үзэл суртлын эрс ялгавар байхгүй. Харин дайн хийх арга барил, түүнд хандах хандлага нь цус бага асгаруулсан, харгис догшин биш болсон гэж бодох нь буруу юм. Харин энэ орнуудад дайны хэнээрхэл бүх нийтийг хамарч байнгын шинжтэй болсон бөгөөд эсрэг талын бус өөрийн талын хийсэн хүчирхийлэл, дээрэм тонуул, хүүхдийн амь нас хөнөөх, бүх хүн амыг боолчлолд оруулах, цэргийн олзлогдогсдыг халуун усанд чанах болон амьдаар нь газар булах хуртэл хэрцгийлэх зэргийг хэвийн зуйл, тэр ч байтугай гавьяат үйлс гэж үздэг байна. Дайнд сайн бэлтгэгдсэн мэргэжлийн цэргийнхэн голчлон оролцдог, хүн амын багахан хэсэг биечлэн оролцдог тул хүний хохирол харьцангуй бага байдаг болно. Тулалдаан алс

холын хил хязгаарт буюу далайн зам харилцааг хянаж байдаг Хөвөгч Цайзны эргэн тойронд болдог тул энгийн иргэд тулалдаан болж буй газрыг зөвхөн таамаглаж байдаг юм. Үе үе бий болдог өргөн хэрэглээний барааны байнгын хомсдол, хэдэн арван хүний амь насыг хөнөөсөн пуужингийн дэлбэрэлтээр л иргэншлийн төвүүдэд дайн болж байна гэж мэддэг. Дайны шинж чанар үнэн хэрэгтээ өөрчлөгджээ. Тодорхой хэлэх юм бол дайн хийх үндэс нь ач холбогддынхоо хувьд өөр болсон бөгөөд хорьдугаар зууны эхэн үеийн томоохон дайн гарахад ямар нэг хэмжээгээр нөлөөлсөн учир шаптгааныг өнөөдөр хүлээн зөвшөөрснөөс гадна зонхилох удирдамж болгосон байна.

Орчин үеийн дайны мөн чанарыг ойлгохын тулд хэдэн жил тутамд дахин бүлэглэх болдог ч гэсэн энэ нь дандаа л нэг дайн байдаг. Энэ дайн хэзээ ч эцсийн дайн биш гэдгийг юуны түрүүнд ухаарах хэрэгтэй юм. Хоёр гүрнийх нь арми нэгдлээ ч аль нэг гуравдахь гүрнээ эзэлж чаддаггүй юм. Тэдний хүч чадал дэндүү тэнцүү

бөгөөд батлан хамгаалалтын байгалийн чадавхи нь барагдашгүй. Евразийн Гүрнийг өргөн уудам газар нутаг нь, Далайн Гүрнийг Атлантын болон Номхон дөлгөөн далай нь, Дорнодазийн Гүрнийг түүний оршин суугчдынх нь хурдан өсөлт, хичээл зүтгэл нь хамгаалж байдаг юм. Үүнээс гадна эд баялгийн хувьд тэмцэлдээд байх юм нэгэнт байхгүй болсон байна. Өөрөө өөрийгөө хангадаг эдийн засгийн систем бий болсноор, өнгөрсөн дайнуудын гол шалтгаан болох зах зээлийн төлөөх тэмцэл, түүхий эдийн төлөөх өрсөлдөөн амин чухал ач холбогдлоо алдсан байна.

Хэт их гүрэн тус бүрийн нутаг дэвсгэр нь асар том тул хэрэгцээтэй түүхий эдээ өөрийнхөө нутаг дэвсгэрээс олж авдаг байна. Дайны эдийн засгийн зорилтын тухайд гэх юм бол энэ дайн нь ажиллах хүчний төлөөх дайн юм. Хэт их гүрнүүдийн хил хязгаарын дунд аль нэг гүрэн байнга эзэмшдэггүй Танжир, Браззавилл, Дарвин болон Хонконг гэсэн оройтой тэгш бус дөрвөлжин нутаг дэвсгэр бий бөгөөд энд

Дэлхийн хүн амын тавны нэг орчим нь оршин сууж байна. Гурван гүрэн хүн ам шигүү суурысан эдгээр нутаг дэвсгэр, мөн Арктикийн мөсөн хучлагыг эзэмших гэж байнга тэмцэл явуулж байдаг юм. Тэдгээрийн зарим хэсэг нь нэг гүрний мэдлээс нөгөө гүрний мэдэлд үргэлж шилжиж байдаг. Итгэл алдуулан гэнэт довтолж аль нэг хэсгийг булаан авах боломж нь түншээ байнга солих шаардлагыг бий болгодог байна.

Маргаантай бүх газар нутаг чухал эрдсийн баялагтай бөгөөд зарим нутагт каучук мэт хүйтэн уур амьсгалтай оронд харьцангуй өндөр үнэтэй, боловсруулалт хийж химийн аргаар үйлдвэрлэдэг ургамлын үнэ цэнтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Эдгээр нутаг дэвсгэрт хэмжээлшгүй их хямд ажиллах хүч байгаа нь их чухал юм. Экваторын Африк, аль эсвэл Ойрхи Дорнод ч юм уу, Индонезийн олтригийг булаан эзэлсэн аль нэгэн гүрэн хэдэн зуун сая үнэгүй гэж хэлж болох ажиллах хүчтэй болно. Их бага хэмжээгээр илэрхий боолчлолын байдалд байгаа эдгээр нутаг дэвсгэрийн хүн ам



нэг түрэмгийлэн эзэмшигчийн мэдлээс нөгөө түрэмгийлэн эзэмшигчийн мэдэлд тасралтгүй шилжиж байдаг ба тэднийг улам их зэр зэвсэг үйлдвэрлэх, улам их газар нутаг булаан авах, улам их ажиллах хүч олж авах гэж улайран нүүрс, газрын тос шиг зогсоо зайгүй зарцуулдаг юм. Байлдааны ажиллагаа гол төлөв маргаантай газар нутгийн зах хязгаар нутагт явагддаг болохыг тэмдэглэх нь зүйтэй. Евразийн Гүрний зах хязгаар Конго ба Газрын Дундад тэнгисийн хойт эргийн хооронд нааш цааш шилжиж байдаг, Энэтхэгийн далай, Номхон дөлгөөн далайн арлуудыг нэг мэдэхэд Далайн Гүрэн, нэг мэдэхэд Дорнодазийн Гүрэн эзэлчихсэн байдаг, Евразийн Гүрэн ба Дорнодазийн Гүрний Монголын нутгаар гарах хил нь тогтворгүй, Арктикт ихэнх нь хүн ам суурьшаагүй, суддагдаагүй асар уудам нутгийг Гурван Гүрэн булаацалдаж байдаг. Харин ойролцоогоор тэнцүү хүчний харьцаа байнга хадгалагдаж ирсэн бөгөөд хэт их гүрэн бүрийн голомт газар нь халдашгүй байдаг. Үүнээс гадна дэлхийн эдийн засагт гол нь халуун оронд мөлжиж буй

ажиллах хүч хэрэггүй юм. Тэнд үйлдвэрлэж буй бүх юм дайнд, шинээр хийх дайнд байр сууриа бэлтгэхэд зориулагддаг тул тэр нь дэлхийг юугаар ч баяжуулдаггүй болно. Эдгээр орон нь боолынхоо хөдөлмөрөөр зогсолтгүй үргэлжлэх дайны явцыг хурдасгадаг юм. Ийм юм байгаагүй байсан бол дэлхийн хамтын нийгэмлэгийн бүтэц түүнийг тэтгэж байдаг үйл явц үндсэндээ өөрчлөгдөхгүй байсан юм.

Орчин үеийн дайны гол зорилго (Дотуур Намын ухаантай удирдагчид *хоёрсэтгэхүйн* зарчмын дагуу энэ зорилгыг нэгэн зэрэг хүлээн зөвшөөрдөг ба хүлээн зөвшөөрдөггүй юм) бол нийт амьжиргааны түвшинг дээшлүүлэхгүйгээр хүний хөдөлмөрийн бүтээгдэхүүнийг зарцуулахад оршино. XIX зууны төгсгөлд аж үйлдвэржсэн нийгмийн өргөн хэрэглээний барааны илүүдлийг хэрхэх тухай асуудал далд өрнөж эхэлсэн билээ. Хэн ч цадталаа хоол идэхгүй байгаа өнөө үед ийм асуудал тавигдахгүй нь тодорхой. Сүйтгэлийн зохиомол үйл явц явагдаагүй тохиолдолд ч гэсэн ийм

асуудал үүсэхгүй байсан байж болох юм. Өнөөдрийн дэлхий нь 1914 оноос өмнө оршиж байсан дэлхийтэй, тэр ч байтугай тэр үеийн хүмүүсийн төсөөлж байсан гэгээн саруул ирээдүйтэй харьцуулах юм бол хоосон, өлмөн зэлмэн, замбараагаа алдсан дэлхий юм. ХХ зууны эхэн үед бичиг үсэгтэй бараг хүн бүрийн ухаан санаанд цаглашгүй баян чинээлэг, чөлөөт цагтай, дэг журамтай, үр ашигтай шил, цэв цэвэрхэн шил, ган болон цав цагаан бетонон хавтангаар бүтээсэн барилга байшин ирээдүйн нийгмийн тухай мөрөөдөл байсан. Шинжлэх ухаан, технологи гайхалтай хурдан хөгжиж энэ хөгжил цаашдаа ч ийнхүү үргэлжилнэ гэж төсөөлөх нь зүйн хэрэг байлаа. Нэг талаар дайн ба хувьсгалын гинжин цувралын бий болгосон ядуурал, нөгөө талаас хүртэн мэдрэх ба туршлагын сэтгэхүйн зуршилд тулгуурласан шинжлэх ухаан, техникийн дэвшлээс шалтгаалан энэ нь биелэгдээгүй болно. Дэлхий бүхэлдээ тавин жилийн өмнөхөөсөө ч улам буурай хөгжилтэй байна. Хоцрогдсон зарим бүс нутаг хөгжиж төрөл бүрийн шинэ багаж

хэрэгслийг, үнэндээ ямар нэг байдлаар дайн хийх, цагдаагийн мөрдпөг явуулахад шаарддагатай зохион бүтээсэн боловч туршилт судалгаа, зохион бүтээх ажил үндсэндээ зогсчихсон 50-иад оны атомын дайнаас үлдсэн эвдрэл сүйрлийг бүрэн арилгаж чадаагүй байна. Тэглээ ч гэсэн машин техникийн аюул арилаагүй байна. Машин техник бий болсон тэр мөчөөс эхлэн хар ажил хийх хэрэгцээ үгүй болж ингэснээр хүний тэгш бус байдал арилна гэж бүх сэтгэх чадвартай хүн үзэж байсан юм. Машин техникийг энэ зорилгод ухаалаг ашигласан бол өлсгөлөн, хүчрэгдэшгүй хүнд ажил, бохир заваан орчин, бичиг үсэг үл мэдэх явдал, өвчин эмгэгийг хэдэн үеийн дотор устгах байсан юм. Үнэндээ машин техникийг ямар ч зорилгогүйгээр аянд нь ашиглаж байх үед ч үйлдвэрлэсэн эд баялаг нь зарим үед түгээхгүй байх боломжгүй, арван есдүгээр зууны төгсгөл, хорьдугаар зууны эхэн үеийн тавь орчим жилд машин техник дундаж хүний амьжиргааны түвшинг ихээхэн дээшлүүлсэн билээ.

Эд баялгийн бүх талын өсөлт нь шатлан захирах ёст нийгэмд сүйрэл, үнэхээр сүйрэл авчирсан гэж хэлж болно. Авчирна гэдэг нь мөн тодорхой байсан юм. Хүн бүр цөөхөн цаг ажилладаг, хүрэлцэхүйц хоол ундтай, бие угаах өрөө, хөргөгч бүхий суух байшинтай, автомашин, тэр ч байтугай нисэх онгоцтой тийм орчинд тэгш бус байддын хамгийн илэрхий, хамгийн тодорхой хэлбэр устчихсан байх ёстой. Эд баялаг бүх нийтийнх болмогцоо ялгаатай байдал үүсгэхээ зогсоно.

Хувь хүний өмч гэдэг утгаар эд *баялгийг* тэгш хуваарилахад, *засгийн эрх мэдэл* нь онцгой эрх мэдэлтэй цөөнхийн давхаргад үлдэж буй нийгмийг төсөөлөн бодож болох юм. Харин үнэн хэрэгтээ тийм нийгэм урт хугацаанд тогтвортой байж чадахгүй. Чөлөөт цаг, аюулгүй байддаар бүх хүн нэгэн адил хангагдах юм бол ядууралд талхигдсан асар олон хүн бичиг үсэгт тайлагдаж бие даан бодож чаддаг болно, эдгээр хүмүүс эрт орой хэзээ нэгэн цагт онцгой эрх мэдэлт цөөнх ямар ч үүрэг гүйцэтгэхгүй гэдгийг

ойлгож тэднийг авч хаяна. Шатлан захирах ёст нийгэм нь эцсийн бөлөгт ядуурал ба харанхуй бүдүүлэг байдал дээр тогтдог юм. XX зууны эхэн үед зарим сэтгэгчийн бодож байсанчилан хөдөөгийн амьдралын хэвшлийг эргүүлж авах нь бодитой шийдэл биш юм. Ийм хандлага нь газар сайгүй бараг зөн болсон аж үйлдвэржүүлэлтийг хэрэгжүүлэх гэсэн эрмэлзэлд харшилж байна. Мөн түүнчлэн аж үйлдвэрийн буурай хөгжилтэй орон нь цэрэг зэвсгийн хувьд чадвар мөхөс бөгөөд арай илүү хөгжилтэй өрсөлдөгчдийнхөө эрхшээлд шууд буюу шууд бусаар ордог юм.

Үй олон хүнийг бараа үйлдвэрлэлтийн хязгаарлалтаар ядууралд барьж байх шийдэл ч хангалттай биш байлаа. Энэ нь капитализмын сүүлчийн үе шат болох 1920 ба 1940 оны хооронд их хэмжээгээр гарсан байна. Олонхи орны эдийн засагт зогсонги байдал бий болсон, газар тариалан эрхлэлт зогссон, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийхээ больсон, хүн амын томоохон бүлгүүдийг ажил хөдөлмөрөөр

хангахгүйгээр төрийн татаасаар амь зуулгыг нь чүү чай залгуулж байсан юм. Энэ нь ч гэсэн цэргийн хүчин чадлыг ихээхэн сулруулсан бөгөөд гачигдал дутагдал нь бодит шаарддагаар үүсээгүй болохоор аяндаа эсэргүүпдийг үүсгэж байлаа. Дэлхий дахины эд баялгийн үнэ цэнтэй зүйлсийн тоо хэмжээг ихэсгэхгүйгээр аж үйлдвэрийг бүрэн хүчин чаддаар нь ажиллуулах зорилт тавьж байсан юм. Барааг үйлдвэрлэх шаарддагатай, харин хуваарилах шаарддагагүй юм. Бодит байдалд ийм байдлыг хадгалж байх цорын ганц арга бол тасралтгүй дайтах явдал юм.

Дайны мөн чанар нь хүний амь насыг хөнөөгөөд зогсохгүй хүний хөдөлмөрийн үр шимийг устгахад оршино. Дайн бол үй олон хүний аж амьдралыг тохь тухтай болгох улмаар тэднийг алсдаа оюунлаг болгоход ашиглаж болох эд баялгийг зад дэлбэлж агаарт хийсгэх, далайн гүнд живүүлэх арга хэрэгсэл юм. Дайны талбарт зэр зэвсэг устгахгүй ч гэсэн түүнийг үйлдвэрлэх нь өргөн хэрэглээний бараа огт

үйлдвэрлэхгүйгээр хүний хөдөлмөрийг үрэн таран хийх арга хэрэгсэл мөн. Хөвөгч цайз барихад жишээ нь хэдэн зуун ачаа зөөгч хөлөг онгоц барихад хүрэлцэхүйц хөдөлмөр шаардагдсан юм. Эцсийн бөлөгт хөвөгч цайз нь эд баялгийн ямар ч үр ашиг өгөлгүй хуучирч элэгдэн төмрийн хаягдал болдог ба дараагийн хөвөгч цайзыг асар их хөдөлмөр зарцуулан барьж эхэлдэг юм. Онолын хувьд хүн амын хамгийн наад захын хэрэгцээг хангаад үлдсэн илүүддийг шавхахад цэргийн үйл ажиллагааг зориулахаар төлөвлөж байдаг. Бодит байдалд хүн амын хэрэгцээг дандаа дутуу үнэлдгээс амь зуулгын өдөр тутмын хэрэгцээт зүйлийн тэн хагас нь байнга дутагдаж байдаг. Харин үүнийг давуу чанар гэж үздэг байна. Нийтлэг хомсдол нь ялихгүй эрх ямбын ач холбогдлыг улам өсгөж бүлэг хоорондын ялгааг ихэсгэдэг тул эрх мэдэл бүхий давхаргыг хүртэл гачигдал дутагддын ирмэгт барьж байх зориудын бодлого явуулдаг юм. Хорьдугаар зууны эхэн үеийн жишгээр бол Дотуур Намын гишүүд хүртэл хөл бохирахгүй, даянч амьдралтай. Харин тэдэнд олгосон



жаахан эрх ямба, сайхан тавилгатай цэлгэр байр сууц, сайн даавуугаар хийсэн хувцас хунар, дээд зэргийн чанарын хоол хүнс, тамхи, архи ундаа, хоёр гурван зарц, албаны автомашин буюу нисдэг тэрэг зэрэг нь тэднийг Гадуур Намын гишүүдээс өдөр шөнө шиг ялгаатай болгодог бөгөөд Гадуур Намын гишүүд ч бидний «үгээгүйчүүд» гэж нэрлэж буй хамгийн ядуу үй олноос мөн эрс ялгаатай юм. Энэ бол баян ядуугийн хоорондын ялгаа нь хэнд адууны үмх мах байна гэдгээр тодорхойлогддог бүслэлтэд байгаа хотын нийгмийн байдал мөн. Мөн түүнчлэн дайныг, түүний аюулыг ухаарахаар бүх эрх мэдлийг цөөн хэдхэн эрх баригчдад олгох нь эсэн мэнд үлдэхийн зайлшгүй нөхцөл, зүй ёсны хэрэг мэт байдаг аж.

Дайн нь шаардлагатай эвдрэл сүйрэл авчирдаг тэхдээ түүнийгээ сэтгэлд нийцүүлэн хэрэгжүүлдгийг харж болно. Зарчмын хувьд сүм хийд, пирамид барьж босгох, томоос том нүх ухаад эргэж шороогоор дүүргэж бөглөх, асар олон тооны бараа үйлдвэрлээд дараа нь

тэдгээрийгээ шатааж үгүй хийхэд дэлхийн илүүдэл хөдөлмөрийг зарцуулах юм бол ихээхэн хялбар байх болно. Ингэснээрээ бид шатлан захирах ёст нийгмийн зөвхөн эдийн засгийн суурийг бий болгохоос бус сэтгэл санааны суурийг бий болгохгүй. Энд асууддын гол нь ажлаар барьж л байгаа цагт санаа сэтгэл нь ямар байх нь ач холбогдолгүй үй олон хүний ёс суртахуун бус Намын ёс суртахуун юм. Намын хамгийн жирийн гишүүн гэхэд л ажлаа мэддэг, хөдөлмөрч, явцуу заагт ухаалаг байх шаарддагатай, мөн тэрээр сэтгэл зүрхэнд нь айдас, үзэн ядалт, бялдуучлал, солиорлын хий хөөрөл давамгайлсан гэнэн харанхуй улайран бишрэгч байх ёстой аж. Өөрөөр хэлэх юм бол тэрээр дайны байдлын сэтгэлгээтэй байх шаардлагатай юм. Нэгэнт л бүрэн ялалт байгуулна гэж байхгүй болохоор дайн хэрэг дээрээ явагдаж байна уу, тэр нь амжилттай юу, амжилтгүй юу гэдэг нь ач холбогдол байхгүй. Нэг л юм хэрэгтэй, дайны байдалд л байх шаардлагатай. Намаас бүх гишүүддээ мэдээлэгч бол гэж тавьдаг шаардлага нь дайны нөхцөлд

хэрэгжүүлэхэд хялбар бөгөөд энэ нь одоо бүх нийтийн шинжтэй болж хүмүүс албан тушаал ахих тусмаа үүнд улам идэвхтэй оролцдог байна. Дайны хийрхэл, дайснаа үзэн ядах үзэл Дотуур Намд хүчтэй байдаг болно. Дотуур Намын гишүүн нь зохион байгуулагчийн хувьд байлдааны ажиллагааны тухай мэдээ бодит байдалд нийцэхгүй байна гэдгийг хааяа мэдэх шаардлагатай, мөн тэрээр дайн гэдэг нь хоосон зохиомол зүйл, ерөөсөө дайн болоогүй, аль эсвэл дайныг зарлан тунхаглаж буйгаас огт өөр зорилгоор хийж буйг мэдэж болно, харин ийм мэддэгийг *хоёрсэтгэх* арга барилаар саармагжуулдаг юм. Ингэлээ гээд жинхэнэ дайн болж байна, энэ дайн ялалтаар дуусч Далайн Гүрэн дэлхийн бөмбөрцгийн цорын ганц эзэн нь болно гэсэн Дотуур Намын ямар нэг гишүүний далд итгэл бишрэл алдагдахгүй.

Дотуур Намын бүх гишүүдийн хувьд бол ирээдүйн энэ ялалтад итгэх нь сүсэг бишрэл юм. Үүнийг газар нутгаа аажмаар өргөжүүлэх, хүчний давуу байддыг бий болгох, цоо шинэ

хүчирхэг зэвсэг бий болгохын аль нэгээр хангана. Шинэ зэвсэг бий болгохын төлөө хүчин чармайлт байнга гаргаж байдаг бөгөөд энэ нь зохион бүтээх авьяас болон онолын оюуны сэтгэлгээг ашигладаг цөөхөн салбарын нэг нь юм. Өнөөдөр Далайн Гүрэнд шинжлэх ухаан хуучин утгаараа байхгүй болсон. Шинхэлд «шинжлэх ухаан» гэсэн үг байхгүй. Өнгөрсөн үеийн шинжлэх ухааны хүртэн мэдрэх, туршлага дээр тулгуурласан сэтгэхүй нь Ангсоцын үндсэн зарчимд харшилдаг болно. Техникийн дэвшил, түүний ололтыг хүний эрх чөлөөг хумихад ямар нэг хэмжээгээр ашиглаж болох боломж гардаг юм. Хүний ур чадварын хувьд дэлхий зогсонги байдалд орчихсон, аль эсвэл хоцрогдсон байна. Газрыг морин анжисаар хагалж номыг машинаар зохиодог болсон. Харин чухал ач холбогдол бүхий асуудлууд, тухайлбал дайн, цагдаагийн мөрдлөг туршуулын асуудалд туршлагад тулгуурлах аргыг хэрэглэхийг дэмждэг, юутай ч үүнийг тэвчдэг юм. Бүх дэлхийг булаан эзлэх, биеэ даасан сэтгэлгээг мөхөөх нь Намын хоёр зорилт

юм. Намын шийдвэрлэх гэж буй хоёр том асуудал үүнээс үүдэлтэй юм.

Энэ нь нэгд хүн юу бодож байгааг өөрт нь мэдэгдэлгүйгээр хэрхэн мэдэж болох вэ, хоёрт урьдчилан анхааруулалгүйгээр хэдэн зуун сая хүнийг хэдхэн хоромд яаж хүйс тэмтрэх вэ гэсэн асуудал юм. Шинжлэх ухааны судалгаа шинжилгээний ажил зогсоогүй байгаа цагт энэ бол гол сэдэв нь юм. Өнөөгийн эрдэмтэн нь хүний нүүр, гар хөлийн хөдөлгөөн, хоолойны өнгөний шинж тэмдэг судалдаг, хүнийг үнэнийг нь хэлүүлэхийн тулд эрүүдэн шүүлт явуулах, цочирдуулах, айлгах үйлдэл хийх, эм тарианы үйлчилгээний туршилтын үр дүнг нарийн судалж байдаг сэтгэл зүйч ба шашны шүүгч хоёрын эрлийз, аль эсвэл өөрийнх нь салбарын хүний амь насыг бүрэлгэхэд хамаарах өөрийнхөө салбарын судалгаа хийж буй хими, физик, биологийн мэргэжилтэн юм. Энх тайвны Яамны асар том лабораториудад, Бразилийн ширэнгэ ой, Австралийн цөл, Антарктидийн зэлүүд аралд байрласан туршилтын нууц

талбайд эрдэм шинжилгээний багууд цуцалтгүй ажиллаж байдаг байна. Эдгээрийн зарим нь ирээдүйн дайны үе дэх материал-техникийн хангамжийн асуудлыг төлөвлөж байхад нөгөө нэг хэсэг нь улам их хурдан пуужин, улам их хүчтэй тэсрэх бодис, улам бат бэх хуяг боловсруулан үйлдвэрлэж, гуравдахь хэсэг нь бүхэл бүтэн тивийн ургамлын аймгийг устгах хэмжээний үхлийн хий, шингэн хор буюу биеийн дархлаанд дийлддэггүй шинэ төрлийн микроб гаргаж, дөрөвдөх хэсэг нь усан доогуур явагч завь далайн гүний усыг нэвт шумбаж чаддаг шиг газрын гүнд цоолон явагч тээврийн хөлөг онгоц, аль эсвэл онгоцны буудал болон усан онгоц дээр буудаггүй нисэх онгоц зохион бүтээх гэж чармайж, тавдахь хэсэг нь сансарт нарны туяаг томруулагч шилээр хурааж аваад Дэлхийн бөмбөрцгийн хапуун цөмд түүнийг тусгаж газар хөддүүлэх зэрэг уран зөгнөлийн санаа сэдлийг судалж байдаг юм.

Эдгээр төслүүдийн аль нь ч хэрэгжүүлэх шатандаа ороогүй ба гурван хэт их гүрний аль

нь ч чухал давуу байдал олж авч чадаагүй юм. Эдгээр гурван гүрэн нь аль хэдийнээ өнөөгийн эрдэмтдийн нээж олж чадахааргүй их хүчтэй зэвсэг болох атомын бөмбөгтэй болчихоод байгаа нь хамгийн хачирхалтай нь юм. Нам сурсан зангаараа өөрөө зохиосон гэж хэлдэг ч гэсэн атомын бөмбөг 40- өөд онд бий болсон ба түүнээс арван жилийн дараа бөмбөгийг олноор нь хэрэглэсэн билээ. Тэр үед аж үйлдвэрийн төвүүд, гол нь Орос, Баруун Европ, Хойт Америк дээр хэдэн зуун бөмбөг хаясан юм. Бүх улс орны эрх баригч бүлгүүд үүнээс нэг зүйлийг ойлгосон юм. Дахиад хэдэн бөмбөг хаях л юм бол зохион байгуулалттай нийгэм устана, тэгэхлээр эрх мэдэл нь хамт алга болно гэдгийг ухааран ойлгосон юм. Хэдийвээр апбан ёсоор ямар нэг хэлэлцээр байгуулаагүй ч гэсэн үүний дараа атомын бөмбөгийн бөмбөгдөлт зогссон билээ. Гурван гүрэн дайныг өөртөө" ашигтай дуусгах боломж эрт орой хэзээ нэгэн цагт гарах байх гэж найдахдаа зөвхөн атомын бөмбөг үйлдвэрлэх, нөөцлөхөө үргэлжлүүлж иржээ. Сүүлийн гуч дөчин жилд дайн хийх ур чадвар

ерөнхийдөө нэг байрандаа зогсчээ. Нисдэг тэргийг өргөн хэрэглэдэг болж хүний жолоодлогогүй нисдэг сум бөмбөгдөгч нисэх онгоцыг шахан зайлуулж живдэггүй хөвөгч цайзыг байлдааны хөлөг онгоцны оронд хэрэглэх болсон юм. Цэргийн техник бусад талаар өөрчлөгдсөнгүй. Усан доогуур явагч завь, пулемёт, тэр ч байтугай винтов буу, гранатыг хэрэглэсэн хэвээр байна. Хэвлэлд болон теледэлгэцээр цус асгаруулсан том байлдаан тулалдааны тухай зогсоо зайгүй мэдээлж байдаг ч гэсэн хэдэн долоо хоногийн дотор хэдэн зуун, тэрч байтугай сая сая хүн амь насаа алдсан өнгөрсөн үеийн аугаа их тулалдаанууд давтагдаагүй юм.

Гурван их гүрэн хүнд хохирол амсаж болох цэргийн довтолгоо ерөөсөө хийж байгаагүй юм. Холбоотон руугаа гэнэт довтолох гэж л цэргийн том ажиллагаа явуулах нь жирийн хэрэг болсон байна. Гурван гүрэн нэг л стратеги баримталдаг бөгөөд өөрсдөө ч тэгж нотолж байдаг юм. Гол санаа нь цэргийн ажиллагаа явуулах, хэлэлцээ



хийх, цаг алдаггүй хууран мэхлэх арга хэрэглэх зэргээр дайсны талыг цэргийн баазаар хүрээлж авах, итгэл төрүүлэхийн тулд найрамдлын гэрээ байгуулж түүнийгээ хэдэн жилдээ баримтлах явдал юм. Энэ хооронд нь стратегийн ач холбогдолтой цэгүүдэд атомын цэнэгтэй пуужин байрлуулчихаад эцсийн бөлөгт дайсагнагч талыг хариу цохилт өгч чадахгүй болтол нь гэнэтийн маш өргөн хэмжээний сүйрлийн цохилт өгдөг аж. Ингэсний дараа гуравдахь гүрэнтэй найрамдлын гэрээ байгуулж шинэ довтолгооны бэлтгэл хийж болно. Иймэрхүү бүдүүвч төлөвлөгөө бараг хэрэггүй бөгөөд хэрэгжүүлэх боломжгүй хоосон мөрөөдөл юм. Мөн түүнчилэн Экватор ба Хойт туйлын эргэн тойрны маргаантай газраас бусад газарт байлдааны ажиллагаа ерөөсөө болдоггүй бөгөөд дайсны нутаг дэвсгэрийг булаан эзлэх явдал хэзээ ч гарч байгаагүй болно. Хэт их гурнүүдийн хоорондын хил хязгаар тодорхойгүй байдгийг үүгээр тайлбарлаж болно. Евразийн Гүрэнд жишээ нь газар зүйн хувьд Европод хамаарагдаж буй Британий

арлуудыг булаан эзлэж ядах юмгүй байна, нөгөө талаар Далайн Гүрэн хилээ Рейн ч юм уу Висла мөрөн рүү ойртуулж болох байлаа. Ингэх нь тунхаглаагүй боловч бүх талын баримталж буй зарчим, соёлын бүрэн бүтэн байдлын зарчим алдагдах болно. Далайн Гүрэн өмнө нь Герман, Франц гэдэг нэртэй байсан нутаг дэвсгэрийг эзлэн авах юм бол бодит байдал дээр хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй оршин суугчдыг нь хүйс тэмтрэх асуудал гарах ба аль эсвэл Далайн гүрэнтэй хөгжлийн бараг нэг түвшинд байгаа зуун сая хүнийг уусгах шаарддага гарна. Гурван гүрэнд гурвууланд нь адилхан асуудал тулгарч байдаг юм. Хязгаарлагдмал хэмжээгээр цэргийн олзлогдогсод ба хар арьст зарц нартай зууралдахаас өөрөөр гадаадынхантай харилцахгүй байхаар эдгээр улс зохион байгуулагдсан байдаг юм. Тэд албан ёсны (яг энэ агшинд) холбоотондоо маш сэжигтэй хандцаг болно. Далайн Гүрний иргэн олзлогдогсодоос өөр Евразийн болон Дорнодазийн гүрний иргэнтэй уулздаггүй ба гадаад хэл сурахыг хориглосон аж. Хүнд

гадаадын хүнтэй харилцахыг зөвшөөрөх юм бол тэр нь өөртэй нь адилхан хүн бөгөөд түүний тухай яриа нь худал хуурмаг болохыг ухаарах болно. Ингэх юм бол өөрийнх нь аж төрж буй хаалттай ертөнц задарч иргэний ёс суртахууных нь тулгуур болох айдас, үзэн ядалт болон өөрийгөө зөвтгөх сэтгэл ууршиж алга болно. Гурван тал Перс, Египет, Ява, Цейлон нэгний эзэмшлээс нөгөөгийн эзэмшилд үе үе шилжиж байлаа ч гэсэн үндсэн зарчмыг пуужингаас өөр юу ч зөрчих ёсгүй гэдгийг мэдэж байдаг юм.

Ил ярьдаггүй, үг дуугаралгүй хүлээн зөвшөөрсөн, үйл ажиллагаа бүртээ баримталж байдаг нэгэн хүчин зүйл үүнд нуугдаж байдаг юм. Энэ гурван гүрний гурвуулангийнх нь амьдралын түвшин тун төстэй юм. Далайн Гүрэнд зонхилох үзэл баримтлал нь Ангсоц, Евразийн Гүрэнд бол Нео-болыдевик үзэл, Дорнодазийн Гүрэнд энэ нь «Үхлийг шүтэн бишрэх» гэж орчуулагддаг хятад үг бий, гэхдээ энэ үг нь «өөрийгөө үгүйсгэх» гэсэн утгыг илүү илэрхийлж байдаг болно. Далайн Гүрний иргэн

нөгөө хоёр гүрнийхээ үзэл баримтлалын талаар жаахан ч юм мэдэхийг хориглосон бөгөөд тэдгээр үзэл баримтлалыг ёс суртахуун, эрүүл саруул ухааны харанхуй бүдүүлэг доромжлол гэж тэрээр хараан зүхэж сурсан юм. Хэрэг дээрээ бол энэ гурван үзэл суртал хоорондоо бараг ялгаагүй бөгөөд эдгээрт тулгуурласан нийгмийн тогтолцоо нь ав адилхан аж. Хаа сайгүй төрийн босоо бүтэцтэй, бараг л тэнгэрлэг гэхээр жолоодогчийг шүтэн биширдэг, байнгын дайн дажны болон дайнд зориулсан эдийн засагтай болно. Үүнээс болж гурван их гүрэн хэн нэгнийгээ байлдан дагуулж чаддаггүй, ингэснээр ямар нэг ашиг олдоггүй юм. Харин ч гурван гүрэн дайсагналцах тусмаа бие биеэ овоолоостой өвс шиг тулж байх болно. Эдгээр гурван гүрний эрх баригч бүлгүүд гол төлөв юу хийж байгаагаа нэгэн зэрэг ухамсарлаж, ухамсарлахгүй байдаг. Тэд дэлхий дахиныг байлдан дагуулахад амь биеэ зориулдаг ч гэсэн дайн дажин ялалтаар төгсөхгүй байнга үргэлжлэх ёстой гэж ойлгодог юм. Улс гүрэн нь бусдад эзлэгдэх аюул нүүрлээгүй болохоор

Ангсоц болон түүнтэй өрсөлдөгч үзэл суртлын онцлог шинж чанар, бодит байдлыг үгүйсгэх боломж бий болдог. Энд дайн байнгын болсноор шинж төрхөө үндсээр нь өөрчилснийг урьдын адил хэлэх хэрэгтэй юм.

Өнгөрсөн үед дайн нь ихэнхдээ эрт орой хэзээ нэгэн цагт гарцаагүй ялалт юм уу ялагддаар дуусгавар болдог байсан. Үүний зэрэгцээ өнгөрсөн үед дайн нь нийгмийг бодит байдлаас нь салгахгүй байх гол хэрэгсэл байсан юм. Үе үеийн бүх эрх баригчид өөрийнхөө харьяат нарыг бодит байдлын талаархи хуурмаг ойлголтод итгүүлэхийг оролддог байлаа. Харин тэдэнд цэргийн хүчин чадлыг сулруулах хоосон санаа бий болгох арга байгаагүй. Ялагдал нь тусгаар тогтнолоо алдах ч юм уу өөр бусад муу үр дүнд хүргэх тул түүнээс аль болохоор зайлсхийх хэрэгтэй байв. Бодит байдлыг үгүйсгэх хэрэггүй. Гүн ухаан, шашин, ёс суртахуун, улс төрд хоёр дээр хоёрыг нэмэхэд тав гарч болох боловч их буу юм уу нисэх онгоц зохион бүтээж байхад хоёр хоёрын дөрөв байх

ёстой. Чадал муутай улс эрт орой хэзээ нэгэн цагт ялагдана, чадвар хоосон санаанд тулгуурлаж болдоггүй. Түүнээс гадна чадварлаг байхын тулд өнгөрсөн үеийн сургамжаас туршлага авах, үүний тулд өнгөрсөн үед юу болсныг ямар нэг хэмжээгээр мэдэх шаарддагатай юм. Сонин хэвлэл, түүхийн номонд ер нь буруу таамаглал, алагчилсан үзэл санаа гарах нь байсан ч гэсэн өнөөдрийнх шиг өргөн хуурамч мэдээлэл гарах боломж өмнө нь боломжгүй байсан юм. Дайн бол үргэлж эрүүл саруул ухааны баталгаа байсан бөгөөд эрх баригч ангийн хувьд бол гол баталгаа нь байсан бололтой. Эрх баригч анги дайнд ялж ч болох ялагдаж ч болох байсан үед хариуцдагагүй хандах эрх тэдэнд байхгүй байсан юм.

Дайн хэрэг дээрээ зогсолтгүй үргэлжилдэг болсноор тэр нь аюултай биш болсон. Дайн үргэлжилсээр байхад цэргийн шаарддага гэдэг юм байхгүй. Техникийн дэвшил гарахаа больж хамгийн лавтай баримтыг ч эс тоож үгүйсгэж болно. Цэргийн зорилгоор шинжлэх ухааны гэж

нэрлэж буй судалгаа шинжилгээний ажил хийгдсээр байгаа бөгөөд энэ нь үнэн хэрэг дээрээ мөрөөдлийн чанартай ба ямар ч үр дүнд хүрэхгүй байгаад хэн ч сэтгэл зовдоггүйг бид нэгэнт мэдэж байгаа. Чадвар тэх тусмаа цэргийн хүчин чадвар нэгэнт хэрэггүй болжээ. Далайн Гүрэнд Сэтгэхүйн Цагдаагаас өөр чадварлаг хүчин байхгүй. Гурван хэт гүрний аль нь ч ялагдашгүй болохоор гүрэн тус бүр нь биеэ даасан ертөнц бөгөөд тэнд оюун ухааныг яаж ч гуйвуулж завхруулж болдог аж. Бодит байдал өдөр тутмын амьжиргааны хэрэгцээт зүйлээр дамжин нөлөөлнө. Юм идэх, уух хэрэгцээ гарна, хувцас өмсөх, толгой хоргодох байрны хэрэгцээ гарна, хор залгихгүй байх, дээд давхрын цонхоор гадагш алхаж гарахгүй байх хэрэгтэй гэх мэт. Амьд явах ба үхэх, биеийн таашаал ба биеийн зовиурын хооронд ямар ч гэсэн ялгаа бий, тэгээд л гүйцээ. Гадаад ертөнцөөс тусгаарлагдсан Далайн Гүрний иргэн хүн оддын хязгааргүй уудам ертөнцөд байгаа мэт аль нь дээшээгээ аль нь доошоогоо гэдгийг мэдэх аргагүй болжээ. Ийм улс гүрний эрх баригчид

фараонууд, цезарынханд байгаагүй хэмжээлшгүй эрх мэдэлтэй байна. Эрх баригчид харьяатуудаа өөрсөддөө тавгүй тоогоор өлсгөлөнгөөр үхэж үрэгдэхийг гаргуулахгүй, цэргийн техникийг өрсөлдөгчдийнхөө түвшинд барьж байх ёстой, тэд энэхүү хязгаарлагдмал зорилтыг хангамагц л бодит байдлыг мушгин дур зоригоороо гуйвуулж чадна.

Өнгөрсөн дайннуудын жишгээр үнэлж дүгнэх юм бол дайн нь ердийн бач мэх мөн. Энэ нь эвэр нь бие биеэ шархдуулж чадахгүй тийм өнцгөөр ургасан хивэгч амьтад хоорондоо мөргөлдөж буйг санагдуулдаг юм. Дайн нь бодитой бус ч гэсэн утга учиргүй зүйл бас биш ээ. Дайн нь өргөн хэрэглээний барааны илүүддийг барагдуулж шатлан захирах ёст нийгмийн сэтгэлгээний онцгой нөхцөл байддыг хадгалахад хэрэгтэй. Одоо дайн нь цэвэр дотоодын асуудал гэдэг нь илт юм. Өнгөрсөн үед бүх улс гүрний эрх баригчид заримдаа нийтлэг эрх ашгаа ойлгон дайны сүйрлийг хязгаарлаж байсан мөртлөө бие биетэйгээ



дайтaж ялагч нь ялагдагчийгаа цөлмөн дээрэмдэж байсан юм. Өнөөдөр тэд бие биетэйгээ дайтахгүй байна. Эрх баригчид өөрсдийнхөө харьяатуудын эсрэг дайтаж байгаа бөгөөд ийм дайны зорилго нь газар нутаг булаан эзлэхэд бус, газар нутгаа алдахгүй байхад бус, харин нийгмийн зохион байгуулалтыг хөндүүлэхгүй байхад оршиж байна. «Дайн» гэдэг үг өөрөө төөрөгдөл төрүүлж байна. Үргэлж дайн хийсээр байгаад дайн бол дайн биш болсон гэж хэлэхэд үнэнээс нэг их гажихгүй байх гэж бид бодож байна. Шинэ чулуун зэвсгийн эринээс эхлэн ХХ зууны эхэн үе хүртэл хүн төрөлхтөнд дайны үзүүлсэн онцгой дарамт огт үгүй болж өөр ямар нэг юмаар солигджээ. Гурван гүрэн дайн хийхгүй, үүрд эв нэгтэй оршин тогтнохоор хэлэлцэн тохиролцож гүрэн тус бүр өөрийнхөө хил хязгаар дотор халдашгүй дархан байлаа ч гэсэн үр дүн нь мөн л адилхан байх байсан юм. Гүрэн тус бүр гадаадын эрүүлжүүлэх аюул заналаас үүрд хагацсан хаалттай ертөнц байх байлаа. Байнгын энх тайван нь байнгын дайнтай ав адил

байх байсан юм. Намын ихэнх гишүүдийн өнгөцхөн ойлгодог ДАЙН БОЛ ЭНХ ТАЙВАН гэсэн Намын лоозонгийн гүнзгий утга учир үүнд оршино.

Смит уншихаа зогсов. Хаа нэг газар пуужин унаж дэлбэрэх чимээ гарав. Теледэлгэц байхгүй өрөөнд гав ганцаараа хориотой ном уншиж байна гэсэн аз жаргалтай мөч өнгөрөөгүй байна. Амар амгалан, ганцаараа байгаагаа, түшлэгтэй сандлын зөөлөн суудлыг, цонхоор үлээн хацар илэх намуухан салхийг тэрээр мэдэрч байна. Ном нь сэтгэл татах увьдастай, үнэндээ гэхэд итгэл төрүүлж байна. Ном нь шинэ юм хэлээгүй ч гэсэн чухам энэ нь дур булааж байна. Элдэв санаагаа цэгцтэй болгож чадах юм бол тэрээр өөрөө ч хэлж чадах юм тэр номонд байна. Энэхүү ном нь түүний оюун ухаантай төстэй тэхдээ түүнээс хавьгүй хүчтэй, илүү цэгцтэй, айдас хүйдэст автагдаагүй, оюун ухааны бүтээгдэхүүн аж. Чиний аль хэдийний мэдэх юмыг чинь хэлж өгч буй ном бол хамгийн сайн ном байдаг юм. Смит Жулиягийн хөлийн чимээ

шатаан дээр гармагц номын нэгдүгээр бүлгийн хуудсыг эргүүлж түүнийг угтахаар бослоо. Жулия багажныхаа бараан цүнхийг шалан дээр хаяад Смитийг хүзүүгээр нь тэвэрч авлаа. Тэд арваад хоног уулзаагүй билээ.

“*Нөгөө ном* надад байна” гэж Смит Жулияг эргэхэд нь хэлэв.

“Өө, чи авчихаа юу? Сайн байна” гэж Жулия нэг их сонирхсон янзгүй хэлээд кофе чанахаар керосин халаагуурын дэргэд сөхрөн суулаа.

Тэр хоёр орондоо хагас цаг болсны дараа л номны тухай яриагаа дахин эхлэв. Энэ үдэш сэрүүвтэр болохоор тэд бүтээлгээр хучиж хэвтэнэ. Дороос нөгөө дуу дуулах танил дуу, чулуулсан зам дээгүүр явах хөлийн чимээ сонсогдоно. Смитийн анх харсан улаан бугуйтай бүдүүн авгай хашаанаасаа яваагүй юм шиг байна. Тэр авгай юм өлгөдөг олс, сагс хоёрын хооронд нааш цааш алхаад цагаан даавууны хавчаар амандаа хийхээр дуугаа татаж

дараа нь дахиад л чанга дуулсаар өнгөрөөдөггүй өдөр, цаг гэж байхгүй аж. Жулия хажуу тийшээ налж хэвтээд бараг унтчихжээ. Смит шалан дээрээс номоо аваад орны толгой дээр суулаа.

“Бид энэ номыг унших хэрэгтэй юм. Чи ч гэсэн. Ах дүүгийн барилддага байгууллагад орсон хүн бүр энэ номыг унших ёстой” гэж тэрээр хэлэв.

“Чи чанга унш. Ингэсэн нь дээр. Чи тэхдээ бүгдийг нь надад тайлбарлаж өгөөрэй” гэж Жулия нүд нь аниастайгаа хэллээ.

Цаг зургаа болжээ, арван найман цаг болж байна гэсэн үг. Тэдэнд гурав, дөрвөн цаг байна гэсэн үг. Смит номоо өвдөг дээрээ тавиад уншиж гарлаа.

## Бүлэг I

### ҮЛ МЭДЭХ НЬ ХҮЧ

*Түүх тэмдэглэгдсэн хугацаанд, магадгүй Шинэ чулуун зэвсгийн эринээс энэ дэлхий дээр гурван зүйл хүн байсан. Дээдчүүл, Дундчуул, Доодчуул. Бүлэглэлүүдийг янз бүрээр хуваадаг, тэдэнд тоо томшигүй олон нэр өгдөг байсан, тэдний хоорондын хандлага зуунаас зуунд өөрчлөгдөж байсан юм, гэлээ ч нийгмийн суурь бүтэц ерөөсөө өөрчлөгдөөгүй юм. Энэ бүтэц нь асар том донсолгоо, эргэлт буцалтгүй юм шиг өөрчлөлтийн дараа ч хааш нь ч түлхсэн хуучин байрандаа эргээд очдог гороскоп шиг дахиад л бий болдог байна.*

“Жулия, чи унтаж байна уу?”

“Үгүй, би сонсож байна, хонгор минь. Унш, унш. Гайхамшигтай юм”

Смит үргэлжлүүлэн уншсаар байна.

Энэ гурван бүлгийн зорилго огт нийцдэггүй болно. Дээдчүүлийн зорилго бол байгаа байрандаа л үлдэх явдал. Дундчуулын зорилго

бол дээдчүүлтэй байраа солих явдал юм. Зорилго бий болохоор Доодчуулын зорилго бол Доодчуулын хамгийн онцлог шинж төрх нь тэд хүнд хүчир хөдөлмөрт хэтэрхий дарагдсан болохоор өдөр тутмын амь зуулгаас цааш юу ч олж харах ухааралгүй байдаг, бүхий л ялгааг устгаж хүн бүр тэгш эрхтэй нийгэм байгуулах явдал юм. Түүхийн бүх хугацаанд ингэж ерөнхийдөө ижил тэмцэл үе үе гарч байсан юм. Дээдчүүл эрх мэдлийг удаан хугацаанд баттай барьж байгаа юм шиг байсан боловч тэд нар өөртөө итгэх итгэлээ алдах юм уу, үр ашигтай удирдах чадвараа алдах, эдгээрийн аль аль нь тохиолдох цаг үе эрт орой хэзээ нэгэн цагт ирдэг байна. Ийм үед эрх чөлөө, шударга ёсны төлөө тэмцэгчийн дүр үзүүлэн Доодчуулыг өөрийнхөө талд татан оруулсан Дундчуул Дээдчүүлийг суудлаас нь авч хаядаг юм. Дундчуул нь зорилгодоо хүрмэгц Доодчуулыг боолын хуучин байдалд нь түлхэж оруулаад өөрсдөө Дээдчүүл болдог байна. Энэ хооронд Дундчуул нөгөө хоёр бүлгийн аль нэгнээс нь ч юм уу аль эсвэл хоёулангаас нь тусгаарлахад тэмцэл дахин

шинээр эхэлдэг. Энэ гурван бүлгээс Доодчуул л түр зуур ч гэсэн зорилгодоо хүрч байсан удаа огт байхгүй байна. Түүхийг эд баялгийн дэвшил дагалдаагүй гэх юм бол хэтрүүлэг болох биз ээ. Уналтын өнөөгийн үе шатанд ч гэсэн эгэл хүн хэдэн зуун жилийнхээс эд баялгийн хувьд илүү сайн аж төрж байна. Эд баялгийн арвижилт ч, ёс зуршлын зөөлрөл ч, аливаа шинэчлэл ч, хувьсгал ч хүний эрх тэгш байддыг мухар сөөм ч ойртуулаагүй юм. Доодчуулын үзэл боддоор бол түүхэн бүх өөрчлөлт нь эздийг сольсноос цааш гараагүй юм.

Энэхүү үлгэр загвар давтагддаг болох нь XIX зууны эцэс гэхэд олонхи ажиглагчдад тодорхой болсон билээ. Чухамхүү тэр үед түүхэн үйл явц бол мөчлөг үйл явц бөгөөд хүний аж төрөх хөдөлшгүй хууль бол эрх тэгш бус байдал мөн гэж үздэг номлол бий болсон юм. Мэдээжийн хэрэг энэхүү номлолыг баримтлагчид урьд өмнө ч байсан. Харин одоо энэ номлолыг цоо шинээр тайлбарлах болсон юм. Дээдчүүлийн номлолоор шатлан захирах ёст байгуулал хэрэгтэй гэж урьд

өмнө үздэг байсан билээ. Хаад ноёд, эрхтэн дархтангууд, тэдний шүүсийг сорогч лам хувраг, хуульчид гэх мэтүүд энэ сургаалыг номлодог байсан ба санаандаа төсөөлсөн хойт насанд нь хохиролгүй болгоно гэсэн амлалтаар үүнийгээ зөөлрүүлдэг байлаа. Дундчуул эрх мэдлийн төлөө тэмцэл явуулж байх үедээ эрх чөлөө, шударга ёс, ах дүүгийн барилддага гэх мэт үг хэллэгийг хэрэглэдэг юм. Харин одоохондоо эрх мэдэл олж авч чадаагүй байгаа боловч түүнийг булааж авахыг мөрөөдөж буй хүмүүс хүний ах дүүгийн барилдлагын үзэл баримтлалыг дайрч довтолдог болсон байна. Хуучин цагт Дундчуул эрх тэгш байдал гэдэг уриан дор хувьсгал хийж дарангуйлагчийг түлхэн унагаад тэр дороо шинэ дарангуйлагчийг тавьдаг байлаа. Харин одоо Дундчуул дарангуйлагчаа хэрэг дээрээ урьдаас зарладаг болсон байна. XIX зууны эхэн үед үүссэн социализмын онол нь эрт дээр үеийн боолчуудын бослогоос эхэлсэн үзэл суртлын уламжлалын сүүлчийн гинж бөгөөд энэ онолд өнгөрсөн зуунуудын утопи үзэл суртал шингэсэн юм. Харин 1900 оноос хойш бий



болсон социализмын бүх хувилбар эрх тэгш байдал, ах дүүгийн барилдлагын үзлийг өөрийн зорилго гэж ил тунхаглахаас ямар нэг хэмжээгээр татгалздаг болсон билээ. Дундад зууны үед үүссэн шинэ хөдөлгөөнүүд болох Далайн Гүрний Ангсоц, Евразийн Гүрний необолюевизм, Дорнодазийн Гүрний үхлийг шүтэх гэж нэрлэгддэг үзэл зэрэг нь эрх чөлөөтэй бус, тэгш бус байдлыг өөрсдийн зорилгоо болгосон юм. Эдгээр шинэ хөдөлгөөн нь хуучин үзэл суртлаас үүсч, түүнийхээ нэрийг хадгалан үлдэж, аман дээрээ хуучин үзэл суртлыг баримтална гэдэг боловч эдгээр хөдөлгөөний зорилго нь тодорхой цаг мөчид түүхийн хөгжлийг саатуулан барьж зогсоох явдал юм. Дүүжмэг нэг саваад л тэндээ зогсох ёстой. Дундчуул Дээдчүүлийг түлхэн унагаж өөрсдөө Дээдчүүл болно, харин энэ удаа Дээдчүүл нухацтай боловсруулсан стратегийн дагуу өөрийн байр суурийг үүрд хадгална.

Эдгээр шинэ үзэл баримтлалын үүслийг XIX зуун хүртэл дөнгөж соёолж эхэлж байсан түүхэн

мэдлэгийн хуримтлалаар тайлбарлаж болно. Түүхийн хөгжил мөчлөгөөр явагддаг нь ойлгомжтой буюу ойлгомжтой юм шиг болсон бөгөөд энэ нь ойлгомжтой болохоор түүнд нөлөөлж болно. Бүр ХХ зууны эхэн гэхэд хүний эрх тэгш байдлыг хангах боломж бий болсон нь гүн гүнзгий ач холбогдолтой юм. Хүн хүний заяаны авьяас адил бус нь хэвээрээ үлдсэн ба ажил үүргийн хуваарилалт аль нэг хүнийг нөгөөхөөс нь илүү таатай байдалд оруулсан нь мэдээж хэрэг ойлгомжтой юм, гэхдээ ангийн ялгаа ба эд материалын ихээхэн тэгш бус байдлын шаарддага үгүй болжээ. Өнгөрсөн зуун жилүүдэд ангийн ялгаа зайлшгүй байгаад зогсохгүй шаарддагатай байсан билээ. Соёл иргэншлийг эрх тэгш бус байдлын үнэ цэнээр бий болгосон юм. Машин техникийн үйлдвэрлэлийн хөгжлийг дагаад байдал өөрчлөгдсөн юм. Хүмүүс урьдын адил ижил бус ажил гүйцэтгэх ёстой байсан боловч тэд нийгэм, эдийн засгийн өөр өөр түвшинд байх шаардлага алга болжээ. Хүний эрх тэгш байдал нь туйлын эрмэлзэл бус харин сэрэмжлэн зайлуулах ёстой

аюул занал гэж эрх мэдлийг булааж авахаар зэхэж буй шинэ бүлэглэлүүд үздэг юм. Нилээд харанхуй бүдүүлэг үед шударга, амар амгалан нийгэмд итгэхэд амархан байсан ч түүнийг цогцлон байгуулах боломж байхгүй байсан. Хүн бие биетэйгээ ах дүүгийн ёсоор хууль цаазгүй, хүнд хүчир хөдөлмөргүй энэ хорвоогийн диваажинд амьдрах юмсан гэж хэдэн мянган жилийн туршид мөрөөдөж ирсэн билээ. Түүхэн өөрчлөлтийн явцад ашиг хонжоо олж авсан бүлэглэлүүдэд ч энэ мөрөөдөл нөлөөлсөн юм. Англи, франц, америкийн хувьсгалыг залгамжлагчид хүний эрх, үг хэлэх эрх чөлөө, хуулийн өмнөх эрх тэгш байдал гэх мэт зэргийн тухай өөрсдийнхөө үг хэллэгт итгээд зогсохгүй зарим тапаар үйлддээ эдгээрт зохицуулдаг байсан юм. Харин ХХ зууны дөчөөд онд улс төрийн сэтгэлгээний үндсэн урсгалууд аль хэдийнээ авторитар болжээ. Энэ хорвоогийн диваажин бодитой бий болох тэрхэн мөчид л түүнд итгэхээ больсон юм. Ямар ч нэртэй байсан улс төрийн шинэ онол шатлан захирах ёс болон хатуу дэг журамд эргэж орохыг уриалж

байсан. Ойролцоогоор 1930-аад он гэхэд бий болсон үзэл боддын нийтлэг хатуу баримтлалын дагуу аль эрт мартагдсан (зарим нь зуу гаруй жилийн өмнө) зуршиллууд болох шүүхийн шийдвэргүйгээр шоронд хорих, цэргийн олзлогдогсдын боолын хөдөлмөр, олон нийтийн өмнө цаазаар авах, хэрэг хүлээлгэхийн тулд эрүү шүүлт явуулах, хүн барьцаалах, бүхэл бүтэн ард түмнийг шилжүүлэн нүүлгэх зэрэг нь сэргэсэн юм. Тэр ч байтугай өөрсдийгөө гэгээрсэн, дэвшилт үзэлтэй гэж үздэг хүмүүс хүртэл эдгээрийг тэвчин тэсвэрлэж зөвтгөдөг болсон юм.

Дайн дажин, иргэний дайн, хувьсгал болон хувьсгалын эсрэг хөдөлгөөнөөр дүүрэн арван жилийн дараа л дэлхийн өнцөг булан бүрд Ангсоц, түүнтэй өрсөлдөгч улс төрийн онол үүсч бүрэлдсэн болно. Энэ бүхний өмнө өнгөрсөн зууны эхэнд үүссэн ерөнхийд нь нэг намын гэж нэрлэдэг улс төрийн тогтолцоо үүсэж бий болсон бөгөөд зонхилж байсан эмх замбараагүй байдлаас үүсэж бий болох шинэ

дэлхийн дүр зураг аль эрт тов тодорхой байсан юм. Энэ дэлхийг ямар хүмүүс удирдах нь ч мөн тов тодорхой болсон. Төрийн албан хаагчид, эрдэмтэд, мэргэжилтнүүд, үйлдвэрчний байгууллагын зохион байгуулагчид, зар сурталчилгааны шинжээчид, социологичид, багш нар болон мэргэжлийн улс төрчид шинээр үүссэн язгууртны давхаргыг бүрэлдүүлсэн болно. Цалинжсан дундад анги болон ажилчин ангийн дээд давхаргаас гаралтай эдгээр хүмүүс нь монопольт аж үйлдвэр ба төвлөрсөн эрх мэдлийн үнэ цэнэгүй хүрээллийг бүрэлдүүлсэн юм. Тэдгээр хүмүүсийг өнгөрсөн зуунуудын ижил бүлгүүдийн хүмүүстэй харьцуулах юм бол тэд нар арай бага шуналтай, тансаглалд их дуртай биш боловч эрх мэдэл олж авахыг л хөөцөлддөг, хамгийн гол нь сөрөг хүчнээ дарах хатуу эрмэлзэлтэй ба түүнийгээ шургуу хийдэгт оршино. Энэхүү ялгаа нь шийдвэрлэх ач холбогдолтой байсан. Өнгөрсөн үеийн харгис дэглэмүүдийг одоо байгаа дэглэмүүдтэй харьцуулж үзэх юм бол тэдгээр нь шийдвэр төгс бус бөгөөд үр дүн муутай байжээ. Эрх баригч

бүлэглэлүүд нь үргэлж ямар нэг хэмжээгээр либераль үзэл бодолтой байсан ба газар сайгүй нөхцөл байдлыг сул тавьж зөвхөн илт үйл ажиллагааг л авч үздэг бөгөөд харьяат нар нь юу бодож буйг сонирхдоггүй байжээ. Өнөөдрийн жишгээр бол Дундад Зууны католик сүм хийд ч хүлээцтэй байсан юм. Үүний нэг шалтгаан нь өнгөрсөн үед ямар ч засгийн газарт иргэдээ байнга мөрдөж мөшгөж байх эрх мэдэл байгаагүйд оршино. Хэвлэлийг зохион бүтээснээр олон нийтийн санал боддыг жолоодоход улам хялбар болсон, радио, телевиз үүссэнээр энэ чиглэлд улам их ахиц гарсан. Телевизийн техник хөгжиж нэвтрүүлгийг нэг аппаратаар хүлээн авч дамжуулдаг болсноор хувийн амьдралын нууц үгүй болов. Иргэн бүрийг, юутай ч гэсэн ажиглалтад авах ёстой ач холбогдол бүхий иргэн бүрийг цагдаагийн ажиглалт хяналтад бүтэн хоногоор авч болох ба холбооны бусад хэрэгслийг хааж байгаад тэднийг албан ёсны суртал ухуулгаар бөмбөгдөж болох болжээ. Төрийн хүсэл зоригт бүхнийг бүрэн нийцүүлэх боломж гараад

зогсохгүй бүх асуудлаар үзэл бодол нэг байлгах боломж анх удаагаа бий болжээ.

Тавь, жараад оны хувьсгалт үеийн дараагаар нийгэм нь дахиад л Дээдчүүл, Дундчуул, Доодчуулд хуваагдлаа. Шинээр үүссэн Дээдчүүлийнхний урьдах бүх дээдчүүлийнхнээс ялгаатай нь тэд нар үйл ажиллагаагаа зөнгөөр биш өөрсдийн байр суурийг хамгаалахад шаардлагатай зүйлийг хийсэнд оршино. Олигархийн бат бэх суурь нь хамтын зарчим гэдгийг аль хэдийнээ ухаарсан юм. Эд баялаг, давуу эрхийг хамтдаа эзэмшиж байгаа цагт тэдгээрийг хамгийн амархан хамгаалж болно. Энэ зууны дундуур хэрэгжүүлсэн “хувийн эд хөрөнгийг халах” гэдэг нь үнэн хэрэг дээрээ урьд байснаас хамаагүй цөөн хүний гарт эд хөрөнгийг бөөгнөрүүлсэн хэрэг байлаа. Үүний хамгийн том ялгаа нь хөрөнгө эзэмшигч нь үй олон хувь хүн биш бүлэг хүн болсон явдал байлаа. Намын ямар нэг гишүүнд өөрийнх нь хувийн жаахан эд зүйлсээс өөр юу ч байх ёсгүй юм. Нам нь бүхнийг жолоодож өөрийнхөө

дураар бүтээгдэхүүнийг хуваарилан зарцуулдаг болохоор хамтдаа Далайн Гүрний бүх эд юмсыг эзэмшдэг юм. Хувьсгалын дараахи жилүүдэд хамтралжуулах лоозонгийн дор үйл явц явагдсан тул нам нь зонхилох байр суурийг олж авч чадсан болно.

Капиталистуудыг эд хөрөнгөнөөс нь салгах юм бол социализм ирнэ гэж үзэж байсан юм. Мэдээж хэрэг капиталистуудыг эд хөрөнгөгүй болгосон билээ. Тэднээс бүх юмыг тухайлбал үйлдвэр, уурхай, газар, барилга байшин, тээврийг хурааж авсан юм. Энэ бүхэн хувийн өмч байхаа больмогц нийгмийн өмч болсон гэсэн хэрэг юм. Хуучин социалист хөдөлгөөнөөс үүсч түүний хэллэгийг өвлөн авсан Ангсоц нь социшшт хөтөлбөрийн гол зорилтыг үнэн хэрэг дээрээ хэрэгжүүлсэн болно. Урьдчилан төлөвлөж хүрэхийг эрмэлзэж байсан үр дүндээ хүрсэн юм. Ингэж эдийн засгийн тэнцүү биш байддыг мөнхжүүлсэн юм.



Шатлан захирах ёст нийгмийг мөнхжүүлэх зорилт үүнээс ч гүн гүнзгий юм. Эрх баригч бүлэглэл эрх мэддээ алдах зөвхөн дөрвөн шалтгаан бий. Эдгээр нь гадаадын дайсанд ялагдах, маш чадваргүй удирдсанаас болж үй олон түмэн бослого гаргах, хүчтэй, сэтгэл дундуур дундчуулын бүлэглэл бий болоход саад хийгээгүй, аль эсвэл өөртөө итгэх итгэлээ алдаж удирдах сонирхолгүй болсон зэрэг шалтгаанууд болно. Эдгээр шалтгаанууд нь салангид бус юм. Энэ дөрвөн шалтгаан ямар нэг хэмжээгээр хоорондоо холбоотой болно. Эдгээр дөрвөн шалтгааныг гаргуулахгүй байж чадсан эрх баригч анги эрх мэддээ үүрд хадгалж чадна. Эцсийн бөлөгт эрх баригч ангийн сэтгэл зүйн байдал нь шийдвэрлэх хүчин зүйл юм.

Энэ зууны дунд үед анхны аюул бодит байдал дээр алга болсон юм. Үнэн хэрэг дээрээ дэлхийг хувааж авсан гурван их гүрэн ялагдашгүй бөгөөд хүн ам зүйн аажим өөрчлөлт л тэднийг сулруулж болох юм. Харин их эрх мэдэлтэй засгийн газрууд ийм өөрчлөлтийг хялбархан

сэрэмжлэн зайлуулж чадна. Хоёрдох аюул нь зөвхөн онолын чанартай юм. Үй олон хүн нь өөрсдөө хэзээ ч бослого гаргахгүй бөгөөд тэд дарлагдсан учраас хэзээ ч бослого гаргахгүй. Мөн түүнчлэн харьцуулж үзэх боломж олгохгүй бол тэд дарлал хавчлагад байгаагаа ухаарах ч үгүй. Өнгөрсөн үед давтагдсан эдийн засгийн хямралыг гаргах ямар ч шаардлага байгаагүй бөгөөд одоо бол ийм хямралыг гаргуулахгүй болоод байна. Иймэрхүү томоохон тасалдал доголдол гарч байгаа ба цаашид ч гарах бөгөөд харин дургүйцлээ ил тодоор гаргах ямарваа боломж бий болгодоггүй болохоор эдгээр нь улс төрийн ач холбогдолгүй юм. Машин техник хөгжсөний улмаас манай нийгэмд бий болсон хэтрүүлэн үйлдвэрлэлийн асуудлын хувьд гэвэл түүнийг зогсолтгүй үргэлжлэх дайнаар шийдвэрлэсэн болно. (Бүлэг 3-ыг үз) Жинхэнэ аюул нь эрх мэдэл олж авахыг эрмэлзэгч хөдөлмөр бүрэн эрхлээгүй чадварлаг хүмүүсийн шинэ бүлэглэл бүрэлдэн тогтсон явдал, либерализмын өсөлт болон өөрсдийнх нь эгнээнд бий болсон гутранги үзэл гэж манай

өнөөдрийн эрх баригчид үздэг юм. Өөрөөр хэлэх юм бол хүмүүжлийн асуудал байна. Энэ нь удирдан чиглүүлэгч бүлэг болон түүний дор байгаа илүү олон тооны гүйцэтгэгч бүлгийн ухамсарыг байнга хэлбэржүүлэх асуудал юм. Энэ нь үй олон хүний ухамсарт сөргөөр нөлөөлөхөдл хангалттай юм.

Дээр дурдсанаас хэн нэгэн нь үүнийг мэдэхгүй бол Далайн Гүрний ерөнхий зохион байгуулалтыг мэдэж ядах юм байхгүй болно. Пирамидын орой нь Их Ах юм. Их Ах алдаа гаргадаггүй ба хамгаас хүчтэй. Ололт амжилт, ялалт, шинжлэх ухааны нээлт, бүх танин мэдэхүй, цэцэн ухаан, алдар гавьяа бүхнийг түүний биечлэн оролцсон мэргэн удирддага, жолооддогоор олсон юм. Их Ахыг хэн ч хараагүй. Түүний нүүр зурагт хуудсанд, түүний дуу хоолой теледэлгэцэнд бий. Тэрээр хэзээ ч насан эцэс болохгүй гэж үзэх үндэслэл бидэнд бий, түүнийг хэзээ төрж мэндэлсэн талаар одоо ихээхэн тодорхой бус болсон. Их Ах бол Нам дэлхий дахинд өөрийгөө харуулах дүр төрх юм.

Түүний чиг үүрэг нь байгууллагад бус хувь хүнд илүү хялбар төвлөрүүлж болох хайр сэтгэл, айдас, шүтэн бишрэх болон сэтгэлийн хөдөлгөөнд нөлөөлөх явдал мөн. Их Ахын дор Дотуур Нам байна, Намын гишүүдийн тоо нь зургаан саяар хязгаарлагдана. Энэ нь Далайн Гүрний хүн амын хоёр хувиас ялихгүй бага болно. Дотуур Намын Дор Гадуур Нам байна. Дотуур Намыг улс гүрний тархи гэж үзэх юм бол Гадуур Намыг түүний гар гэж үзэж болно. Энэ бүхний дор бидний «үгээгүйчүүд» гэж нэрлэдэг үй олон хүн бий. Тэд хүн амын наян таван хувийг бүрдүүлж байгаа байх. Бидний дээр хийсэн ангиллаар үгээгүйчүүд нь Доодчуул бөгөөд нэг байлдан дагуулагчийн мэддээс нөгөөхийн мэдэлд дамжиж байдаг экваторын бүс нутгийн боолын хүн амыг нийгмийн байнгын бөгөөд шаардлагатай хэсэг гэж үзэж үл болно.

Зарчмын хувьд эдгээр гурван бүлгийн аль нэгэнд багтах нь өв уламжлалын чанартай бус юм. Дотуур Намын гишүүний хүүхэд төрмөгцөө

энэ Намд хамаарагдахгүй. Намын аль нэг салбарт түүнийг арван зургаан настайд нь шалгалт авч элсүүлнэ. Нам яс үндэс, газар зүйн шинж тэмдгээр шилж сонгох ёсгүй. Хамгийн дээд давхаргад еврей, негр, латин америк хүн болон цэвэр Энэтхэг хүн байж болно. Муж бүрийн захирагчийг орон нутгаас нь сонгож авна. Далайн Гүрний аль ч мужийн оршин суугч алс холын нийслэл хотоос удирдаж буй колонийн ард түмний хэсэг гэж өөрийгөө үзэхгүй. Далайн гүрэнд нийслэл хот гэж байхгүй. Улс гүрний нэр төдий тэргүүн хаа байдгийг хэн ч үл мэднэ. Англи хэл гол Ппёиа Стапса боловч албан ёсны хэл нь Шинхэл юм. Гэхдээ үүнийг төвлөрүүлээгүй болно. Эрх баригчид элгэн төрлөөрөө бус нийтлэг номлолыг баримталдгаараа эвлэлдэн нэгдэнэ. Манай нийгэм үетсэн, маш нарийн үетсэн гэдэг нь үнэн бөгөөд тэр нь өнгөцхөн харахад өв залгамжлалаар юм шиг харагдана. Янз бүрийн бүлгийн хоорондын шилжилт хөдөлгөөн нь капитализм, аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс хамаагүй бага байна. Намын хоёр

хэсгийн хооронд тодорхой солилцоо гарна. Тэхдээ энэ нь Дотуур Намын сул дорой гишүүдээс ангижрах эсвэл Гадуур Намын нэр төрд дуртай гишүүдэд албан тушаал дэвших боломж олгох шаардлага гарахад л явагдана. Үгээгүйчүүдэд Намд элсэх зам үнэн хэрэгтээ хаалттай. Тэдгээрээс хамгийн чадварлаг бөгөөд эсэргүүндийн голомт үүсгэж магадгүй хүнийг Сэтгэхүйн Цагдаа хараандаа аваад устгадаг юм. Харин үүнийг байнга хийх шаарддагагүй бөгөөд зарчмын асуудал ч биш юм. Нам бол энэ үгийн хуучин утгаар анги биш юм. Нам нь гишүүдийнхээ үр хүүхдэд эрх мэдлээ өвлүүлэхийг эрмэлздэггүй болно. Хамгийн чадварлаг хүмүүсийг дээд түвшинд цуглуулах боломж гарахгүй бол Нам нь үгээгүйчүүдийн дотроос удирдагчдын бүхэл бүтэн үеийнхнийг эргэлзэлгүй шилж авах болно. Нам нь үе дамжсан бус байгууллага байсан нь эгзэгтэй цаг үед сөрөг хүчнийг саармагжуулахад их тус болсон юм. «Ангийн эрх ямба» гэж нэрлэгддэг юмны эсрэг тэмцэж сурсан хуучин маягийн социалист үзэлтэн үе дамжсан бус юм болгон

байнгын бус гэж үздэг байсан юм. Социалист үзэлтэн нь олигархийн үе залгамжлал заавал биологийн гаралтай байх албагүй гэдгийг ойлгож байсан ба үе дамжсан язгууртан нь үргэлж удаан тогтдоггүй байхад католик сүм хийд шиг шилэн сонголтоор бий болдог байгууллага хэдэн зуун жил буюу хэдэн мянган жил оршин тогтнодгийг мөн ухаараагүй юм. Олигархийн захиргааны мөн чанар нь эцэг хүүгийн үе залгамжлал биш юм. Харин энэ нь үхэгсдээс амьд үлдэгсэддээ тулган хүлээлгэсэн ертөнцийг үзэх үзэл ба аж төрөх хэвшлийн шургуу чанар мөн. Эрх баригч бүлэг нь өөрийнхөө залгамжлагчийг томилж чадах чадвартай байх хүртлээ эрх баригч бүлэг байдаг болно. Нам нь үр удмаа мөнхжүүлэхэд санаа зовдоггүй, харин өөрийгөө мөнхжүүлэхэд санаа зовдог болно. Шатлан захирах ёст бүтэц үргэлж хэвээрээ байгаа цагт хэн эрх мэдэлтэй байх нь бага ач холбогдолтой юм.

Өнөөгийн цаг үеийн шинж болох шүтлэг бишрэл, зан заншил, дур сонирхол, мэдрэмж,

үзэл бодол нь Намын далд ид шидийг дээддэх, өнөөгийн нийгмийн жинхэнэ мөн чанарыг ил гаргахгүй байхад үнэн хэрэг дээрээ үйлчилж байдаг юм.

Хүмүүсийн бослого, тэр ч байтугай бослого гаргах гэсэн анхны алхам хийх боломж одоо байхгүй болсон. Үгээгүйчүүдээс айх юм байхгүй. Тэднийг зөнд нь орхисон болохоор тэд нар бослого гаргах зөнгүй, түүгээр зогсохгүй амьдрал өөр байж болох тухай огтхон ч ойлголтгүйгээр үеэс үед, зуунаас зуунд ажил хийж, өсөж үржиж, үхэж үрэгдэж байх болно. Техникийн дэвшил хөгжлөөс болж тэдэнд сайн боловсрол шаардагдах тохиолдолд л тэд аюултай болж болох юм. Харин цэргийн болон арилжааны өрсөлдөөн ач холбогдолгүй болсон тул ард түмний боловсролын түвшин бодит байдал дээр доошилсоор байна. Үй олон түмэн ямар үзэл бодолтой байна, ямар үзэл боддыг баримтлахгүй байна гэдэг нь ямар ч хамаагүй болсон аж. Тэдэнд оюун ухаан байхгүй болохоор оюуны эрх чөлөөг олгож болно.



Намын гишүүний хувьд бол харин ч хамгийн ач холбогдол багатай асууддаар ч гэсэн үзэл санаа зөрөхийг тэсвэрлэшгүй зүйл гэж үзнэ.

Намын гишүүн хүн төрөхөөс насан эцэслэх хүртлээ Сэтгэхүйн Цагдаагийн хараа хяналт дор аж төрдөг. Тэрээр гав ганцаараа байхдаа ч ганцаараа байна гэдэгтээ итгэх арга байдаггүй юм. Тэрээр хаана ч байсан, унтаж байсан ч, сэрүүн байсан ч, ажиллаж байсан ч, амарч байсан ч, усанд орж байсан ч, орон дотроо хэвтэж байсан ч түүнийг хянаж байж болох бөгөөд өөрийг нь хянаж байна гэдгийг тэрээр мэдэх арга байхгүй. Түүний хөдөлгөөн бүр анхаарагдах ёстой. Түүний найз нөхөд, амралт, авгай, хүүхэддээ хэрхэн ханддаг байдал, ганцаараа байхдаа царайных нь өнгө ямар байдаг, зүүд дундаа шивэгнэдэг үг, биеийнх нь хөдөлгөөний онцлог шинж, энэ бүхнийг нарийн судалж байдаг юм. Зөвхөн буруу үйлдлээр зогсохгүй хамгийн гэмгүй гаж зан авир гаргах, сэтгэлийн хямралын илрэл болж харагдах уур уцаар энэ бүхэн хараа хяналтын гадна үлдэх

ёсгүй. Түүнд чөлөөт сонголт хийх ямар ч боломж байхгүй. Нөгөө талаар түүний үйлдлийг хуулиар ч юм уу, нарийн хэмээр зохицуулсан юм байхгүй. Далайн гүрэнд хууль цааз байхгүй. Цаазаар авах ял хүлээх (илрэх юм бол) бодол санаа, үйлдлийг албан ёсоор хориглосон юм байхгүй, үргэлж гарч байдаг цэвэрлэгээ, баривчлага, шоронд хийх, эрүү шүүлт болон ууршуулалт нь гэмт этгээдийг шийтгэхэд бус харин ирээдүйд хэзээ нэгэн цагт гэмт этгээд болж болох этгээдийг устгах зорилготой болно. Намын гишүүн нь зөв үзэл бодолтой байгаад зогсохгүй зөв зөн билэгтэй байх ёстой болно. Түүнд байх ёстой үзэл бодол, итгэл үнэмшлийг яв цав тодорхойлоогүй юм. Ангсоцад угаасаа байгаа зөрчлийг илчлэхгүйгээр тэдгээрийг тодорхойлох арга байхгүй болно. Хүн хэрвээ төрөлхийн тууштай (Шинхэлээр *зөвсэтгэгч* гэдэг юм) бол тэрээр ямар ч нөхцөлд огтхон ч эргэлзэлгүйгээр ямар итгэл үнэмшил, ямар мэдрэмж зөв болохыг мэддэг юм. Юутай ч гэсэн Шинхэлийн хэлний *гэмээболих, харцагаан, хоёрсэтгэхүй* гэдэг үгэн дээр үндэслэгдсэн хар

багаасаа хийсэн оюун ухааны дасгал нь аль нэг асуудлыг гүн гүнзгий бодох зуршлаас ангижруулдаг болно.

Намын гишүүнд хувийн мэдрэмж байх ёсгүй ба түүний идэвх санаачилгад ямарваа завсарлага гарах ёсгүй аж. Тэрээр гадаадын дайсан, дотоодын урвагчдыг үзэн ядаж, ээлжит ялалтад баяр хөөр болж, Намын мэргэн ухаан, аугаа хүч чадлыг шүтэн биширч байнгын хийрхлээр амьдрах ёстой. Тарчиг, аз жаргалгүй амьдралаас бий болсон дургүйцлийг гаднах юм руу аажмаар чиглүүлж Хоёр минутын Үзэн Ядалт зэрэг арга хэрэгслээр гутранги юм уу, үймсэн боддыг саармагжуулан дөнгөж сэдэрч эхлэх үед нь хар багаасаа хүмүүжлээр олсон сэтгэлийн хатамжаараа дардаг юм. Хүүхэд хүртэл суралцах ёстой сэтгэлийн хатамжийн анхны алхмыг Шннхэлээр *гэмээболих* гэдэг болно. *гэмээболих* гэдэг нь аюултай бодол төрөхийн босгон дээр өөрийгөө зөнгөөрөө юм шиг зогсоох чадварыг хэлнэ. Үүнд адил юмыг харахгүй байх чадвар, логик алдааг анзаарахгүй

байх, Ангсоцод харш л бол хамгийн энгийн нотолгоог ч үл ухаарах, тэрсүү замд уруу татаж болох сэтгэлгээний хэлхээнд уйдаж, залхах зэрэг хамаарна. Товчдоо *гэмээболих* нь хамгаалалтын тэнэглэлийг хэлнэ. Харин зөвхөн тэнэглэх нь хангалттай биш юм. Харин ч бишрэн шүтэгч нь циркт хүн биеэ хэрхэн эзэмддэг шиг оюун ухаанаа эзэмдэх шаарддагатай юм. Эцсийн бүлэгт энэхүү байгуулал нь Их Ах бүхнээс хүчтэй, Нам алдаа хийдэггүй гэсэн итгэл үнэмшилд тулгуурлаж байна. Бодит байдалд Их Ах бүхнээс хүчтэй бус, Нам алдаа гаргадаггүй байх ёсгүй учир бодит байддыг үнэлж дүгнэхэд цуцалтгүй, агшин тутамдаа уян хатан хандах шаарддага гарна. Үүнд хэрэглэх гол үг нь *харцагаан* юм. Шинхэлийн бусад олон үгний нэгэн адил энэ үг хоёр эсрэг тэсрэг утгатай болно. Үүнийг өрсөлдөгчдөө хэрэглэх юм бол илт бодит байдлыг үл харгалзан хар бол цагаан гэж ичгүүр сонжуургүй зүтгэх зуршлыг хэлнэ. Намын гишүүний хувьд бол энэ нь Намынхаа сахилга батыг баримтлан Намдаа үнэнчээ харуулж хар

бол цагаан гэж хэлэхийг хэлнэ. Энэ нь зөвхөн хэлээд зогсохгүй. Хар бол цагаан гэдэгт итгэх, түүгээр ч зогсохгүй хар бол цагаан гэдгийг мэдэх, тэгээд чи өөрөө огт өөрөөр бодож байсан гэдгээ мартаж явдал мөн. Үүний тулд Шинхэлээр *хоёрсэтгэхүй* гэдэг үнэндээ бүх салбарыг хамарсан бодлын тогтолцооны тусламжтайгаар өнгөрсөн үеийг байнга өөрчилж байх шаардлага гарна.

Өнгөрсөн үеийг өөрчлөх хоёр учир шалтгаан бий. Түүний нэг нь болох хоёрдугаар зэргийн учир шалтгааныг урьдчилан сэргийлэх гэж хэлж болох юм. Намын гишүүн нь үгээгүйчүүдийн нэгэн адил харьцуулах юмгүй болохоор өнөөгийн нөхцөл байдлыг тэвчин тэсвэрлэж байдаг билээ. Тэрээр өвөг дээдсээсээ илүү сайн амьдарч байна, эд материалын хангамж байнга дээшилж байна гэдэгт итгэх ёстой учир гадаадын орнуудаас тасархай байдгийнхаа нэгэн адил өнгөрсөн үеэс тасарсан байх ёстой юм. Өнгөрсөн үед засвар оруулах харьцуулшгүй чухал ач холбогдол бүхий учир шалтгаан бол

Нам алддаггүй гэдгийг хамгаагж байх ёстойд оршино. Намын мэргэн удирддага ямагт зөв байсан гэдгийг батлахын тулд хэлсэн үг, тоо бүртгэл, бусад элдэв баримтыг өнөөдрийнх болгох ёстой. Үүгээр зогсохгүй үзэл баримтлал, улс төрийн чиг шугамд ямар ч өөрчлөлт оруулахыг хэзээ ч хүлээн зөвшөөрөх ёсгүй аж. Үзэл бодлоо буюу бодлогоо өөрчлөх нь сул дорой гэдгээ хүлээн зөвшөөрсөн хэрэг гэсэн үг. Жишээ нь өнөөдөр Евразийн Гүрэн (эсвэл Дорнодазийн гүрэн хэн байх нь хамаагүй хэрэг ээ) дайсан юм бол тэр нь дандаа дайсан гүрэн байсан гэсэн үг юм. Бодит байдал өөр байгаа бол баримтыг өөрчлөх шаардлагатай. Ингэж түүхийг байнга засварладаг юм. Энэхүү Үнэний Яамны хийж буй өнгөрсөн үеийг өөрчлөх өдөр тутмын ажил нь Хайрын Яамны дарангуйлал, тагнан туршнх ажлын нэгэн адил дэглэмийг тогтвортой байлгахад шаардлагатай.

Ангсоцын үндсэн зарчим бол өнгөрсөн үеийг өөрчлөн засварлах явдал мөн. Өнгөрсөн үйл явдлууд нь бодитой биш бөгөөд зөвхөн бичгээр

үлдсэн баримт бичиг болон хүний ой дурсамжинд л хадгалагдаж үлдсэн гэж үздэг юм. Өнгөрсөн үеийг тэмдэглэл ба дурсамжийг нийцүүлэн гаргадаг юм. Нам нь бүх баримт бичиг болон гишүүдийнхээ оюун ухааныг хянаж байдаг болохоор өнгөрсөн үеийг өөрийнхөө хүссэнээр болгодог юм. Өнгөрсөн үе нь хувирамтгай боловч түүнийг ямар ч мөчид өөрчлөөгүй гэсэн дүгнэлт үүнээс гарна. Өнгөрсөн үеийг өнөөдөр шаарддагатай дүр төрхөөр сэргээх юм бол энэ дүр төрх өнгөрсөн үе төн бөгөөд өөр өнгөрсөн үе гэж байж болохгүй гэсэн үг юм. Өнгөрсөн үйл явдлыг олонхи тохиолдолд нэг жидийн дотор танигдахгүй болтол нь өөрчилдөг болохоор ингэж хэлж буй нь зөв болно. Нам бол үнэмлэхүй үнэнийг үргэлж эзэмшдэг юм, үнэмлэхүй юм одоогийнхоос өөр байх боломжгүй нь мэдээж хэрэг билээ. Өнгөрснийг жолоодох нь юуны өмнө ой дурсамжийн дасгалаас хамаарна. Бүх баримт бичгийг өнөөдрийн шаарддагад нийцүүлэх нь цэвэр техник ажиллагаа юм. Үйл явдал шаардпагын

дагуу болж өнгөрсөн гэдгийг санах шаардлага бас чухал юм. Дурсамжийг өөрчилж баримт бичгийг хуурамчаар үйлдэх шаарддага гарах юм бол эдгээрийг хийснээ мартаж шаарддагатай юм. Апиваа оюуны хөдөлмөр хийдэг арга барилыг сурдагтай адил энэ илбийг ч сурч болно. Намын ихэнх гишүүд (сэргэлэн болон бишрэн шүтэгч бүгд) үүнийг сурцгаасан юм. Хуучхэлээр бол үүнийг «бодит байдлыг эзэмших» гэдэг юм. Шинхэлээр бол *хоёрсэтгэхүй* нь хэдийвээр өөр олон юмыг хамардаг боловч *хоёрсэтгэхүй* гэдэг юм.

*Хоёрсэтгэхүй* нь эсрэг тэсрэг итгэл үнэмшлийг нэгэн зэрэг баримтлах чадвар гэсэн үг мөн. Намын сэхээтэн өөрийнхөө дурсамжийг аль тал руу өөрчлөхөө мэднэ. Бодит байдлыг луйвардаж байна гэдгээ ухаарч байна гэсэн хэрэг мөн. Харин *хоёрсэтгэхүйн* тусламжтайгаар бодит байдал хөндөгдөөгүй гэж тэрээр өөрийгөө итгүүлнэ. Энэ үйл явцыг ухамсартай хийхгүй бол, түүнийг нямбай хийж чадахгүй юм бол, бас тэгээд энэ нь ухамсаргүй үйлдэл байх ёстой,



ингэхгүй бол хурдаа хэлсэн бас тэгээд гэм буруутай гэж санаа нь зовно. Нам санаатайгаар хууран мэхлэх арга хэрэглэж энэ зорилгодоо хүрэх чиг шугамыг тууштай баримталдаг бөгөөд үүнийг шударгаар хэрэгжүүлэх шаарддагатай тул Ангсоцын үзэл баримтлалын гол нь *хоёрсэтгэхүй* юм. Мэдээжийн худал хуурмаг юм ярьж байгаа мөртлөө түүндээ итгэх, тааламжгүй болсон аливаа бодит баримтыг мартаж, хэрэгцээ гармагц түүнийгээ эргүүлэн гаргаж ирэх, объектив бодит байдал оршиж буйг үгүйсгэх болон үгүйсгэсэн бодит байдлаа харгалзаж үзэх энэ бүхэн нь зайлшгүй хэрэгтэй юм. «*хоёрсэтгэхүй*» гэдэг үгийг хэрэглэж байхдаа л хоёр сэтгэх нь чухал юм. Хэн нэгэн энэ үгийг хэрэглэснээр бодит байдлыг гуйвуулж байна гэдгээ мэдэрдэг, дахин нэг *хоёрсэтгэхүйн* үйлдэл хийснээр энэ мэддэгээ бүрмөсөн мартана гэх мэтээр энэ нь хязгааргүй үргэлжлэх бөгөөд ингэхдээ худал хуурмаг юм бүхэн дандаа үнэний урд явна. Эцсийн бөлөгт Нам нь *хоёрсэтгэхүйн* арга чарга хэрэглэж түүхийн

явцыг зогсоож (магадгүй мянган жил ч чадах юм бил үү) чадсан юм.

Өнгөрсөн үеийн бүх олигархи нь зогсонги, сул дорой байдалд орсноосоо болж эрх мэдлээ алдсан. Тэд эрүүл ухаалаг дүгнэлт хийж чадахаа больж өөртөө хэт итгэснээсээ болж зайлуулагдсан. Аль эсвэл тэд либерал үзэлтэй бөгөөд хулчиймтгай болж хүч хэрэглэх шаардлагатай үед буулт хийснээсээ болж зайлуулагдсан. Тэд ухамсартайгаар буюу ухамсаргүйгээр зайлуулагдсан гэж хэлж болно. Энэхүү хоёр нөхцөл нэгэн зэрэг орших сэтгэхүйн тогтолцоог бий болгосон нь Намын гавьяа юм. Намын эрх мэдэл оюуны өөр ямар ч үндсэн дээр халдашгүй дархан байж чадахгүй байсан юм. Хэн нэгэн захирах, захирсаар байх бодолтой байгаа бол тэрээр бодит байддын мэдрэхүйг таслан зогсоож чаддаг байх ёстой. Өөрөө алдаа гаргадаггүй гэдэгт итгэх нь урьд өмнө гарч байсан алдаанаас сургамж авах чадвартай хослоход захирахын нууц оршино.

Оюуны аугаа их башир арга гэж ухаарч *хоёрсэтгэхүйг* үүсгэсэн хүмүүс л үүнийг маш нарийн ойлгодог гэдгийг хэлэх нь илүүц юм. Манай нийгэмд болж буй үйл явддын талаар хамгийн их мэдээлэлтэй хүмүүст хорвоог байгаагаар нь ойлгох чадвар хамгийн бага байдаг. Ихэнхдээ хэдий чинээ сайн ойлгоно, төдий чинээ төөрөгдөнө. Хэдий чинээ оюунлаг байна төдий чинээ ухаалаг бус байна. Хэн нэгний нийгэмд эзлэх байр суурь бэхжих тусам дайны хийрхэл улам дэгддэг нь үүний тод жишээ юм. Маргаантай нутаг дэвсгэрийн ард түмэн л дайны асуудалд хамгийн ухаалаг ханддаг юм. Дайн дажин нь эдгээр ард түмний хувьд тэдний бие махбодийг хөндөж буй далайн хар салхи шиг үргэлжийн гамшиг юм. Аль тал нь ялалт байгуулсан нь тэдэнд огт хамаагүй хэрэг. Тэд шинэ эрх баригчдын үед хийдэг ажлаа л хийнэ, шинэ эзэд тэдэнд урьдын эзэдтэй л адил хандана гэдгийг ухаардаг юм. Арай дээр нөхцөлд буй бидний «үгээгүйчүүд» гэж нэрлэж буй ажилчид л дайныг үе үе мэдэрдэг. Хэрэгцээ гарах үед тэдэнд айдас, үзэн ядалтын хийрхэл

төрүүлж болдог ба тэд нэгэнт л зөнд нь орхисон болохоор дайн болж байна гэдгийг удаан хугацаанд мартаж чаддаг болно. Намын гишүүд, тухайлбал Дотуур Намын гишүүдийн дунд л дайн хийх жинхэнэ идэвх гарч байдаг болно. Дэлхийг байлдан дагуулах боломжгүй гэдгийг мэдэж байгаа хүмүүс л дэлхийг байлдан дагуулна гэдэгт хатуу итгэдэг. Энэхүү эсрэг тэсрэгийн хачин холбоо, мэдлэгийг үл мэдэхтэй, эрээгүй явдлыг улайрсан бишрэлтэй нь Далайн Гүрний нийгмийн ялгарах онцлог мөн. Бодит шалтгаан байхгүй байхад ч албан ёсны үзэл сурталд багагүй зөрчил гардаг болно. Социализм анх үүсэхдээ баримталж байсан бүх зарчмыг нам ингэж буруушааж муулж байдаг ба социализмын нэрийн өмнөөс ингэж ажиллаж байдаг. Нам нь ажилчин ангийг өмнөх зуунуудад байгаагүйгээр үзэн яддаг, өөрийнхөө гишүүдэд хэзээ нэгэн цагт хар ажилчин хүний хэрэглэж дассан хувцсыг дүрэмт хувцас болгон өмсгөдөг юм. Нам нь гэр бүлийн бүрэн бүтэн байдлыг ямагт бусниулж байдаг ба удирдагчаа гэр бүлдээ үнэнч байхыг уриалсан уян сэтгэлээр

дууддаг болно. Биднийг захирч буй дөрвөн яамны нэр хүртэл бодит байдлаас огт өөр эрээ цээргүй байдаг. Энх тайвны яам дайны асуудал, Үнэний яам худал хуурмаг мэдэгдэл, Хайрын яам эрүү шүүлт, Элбэгийн яам өлсгөлөнгийн асуудал хариуцдаг. Ийм эсрэг тэсрэг байр суурь нь тохиолдлын зүйл биш бөгөөд зүгээр л засдаг зангаас болж байгаа юм биш ээ. Энэ нь тэд *хоёрсэтгэхүйг* санаатайгаар хэрэглэж буй хэрэг мөн. Зөрчлийг зохицуулж байж л эрх мэдлийг хязгааргүй удаан эдэлж болно. Эртний мөчлөгийг өөрөөр тасалдуулах арга байхгүй. Хүний эрх тэгш байдлыг ямагт боломжгүй болгоё гэвэл, бидний Дээдчүүл гэж нэрлэж буй бүлэглэл байр сууриа үүрд хадгалах гэж байгаа бол зонхилох сэтгэхүйг ухаалаг бусаар захирах ёстой.

Харин бидний одоо болтол авч үзээгүй нэг асуудал бий. Хүний эрх тэгш байдлыг *яагаад* боломжгүй болгох хэрэгтэй юм бэ? Үйл явцын хөгжлийн тогтолцоог зөв тодорхойлсон гэж үзэх юм бол тодорхой нэг цэгт түүхийн хөгжлийг

зогсоон барьж байхад чиглэсэн энэ аугаа их нягт нямбай төлөвлөсөн үйл ажиллагааны учир шалтгаан нь юунд байна вэ?

Бид энд гол далд аргыг нь олж байна. Бидний үүний өмнө олж мэдсэнээр Нам, юуны өмнө Дотуур Намын ид шид нь хоёрсэтгэхүй баримталдагт байна. Энэ бүхний цаана эхлээд эрх мэддийг булаан авахад хүргэсэн, дараа нь *хоёрсэтгэхүй*, Сэтгэхүйн Цагдааг үүсгэсэн болон байнгын дайн дажин, байгууллын бусад зайлшгүй хэрэгцээт зүйлсийн угийн учир шалтгаан болох судлагдаагүй инстинкт нуугдаж байна...

Смит шинэ дуу чимээ сонсох шиг нам гүм байддыг мэдэрлээ. Жулия нэг хэсэгтээ хөддөхгүй байх шиг түүнд санагдлаа. Жулия гараа дэрлээд үс нь нүүр рүү нь задран унжчихсан бүсэлхийгээ хүртэл шалдан хажуугаараа хэвтэнэ. Түүний цээж нь аажмаар үе үе турж харагдана.

“Жулия”

Хариу дуугарсангүй.

“Жулия, чи сэрүүн байна уу?”

Тэрээр унтаж байгаа тул харну дуугарсангүй. Смит номоо хааж шал дээр тавиад доошилж хэвтээд бүтээлгээрээ хоёр биеэ хучив.

Тэрээр гол далд учрыг мэдэж чадсангүй гэж бодож хэвтлээ. Тэрээр *яаж* гэдгийг нь ойлголоо, *ях* гэж гэдгийг нь ойлгосонгүй. Нэгдүгээр бүлэг нь гуравдугаар бүлгийн адил үнэндээ түүнд шинэ юм нээсэнгүй. Энэ бүлгээс мэдлэгээ цэгцтэй л болгосон юм. Харин энэ номыг уншиж дуусгаад өөрийгөө солиотой биш гэдгийг эцсийн эцэст ойлголоо. Чи цөөнх, тэр ч байтугай ганцаараа ч гэсэн чи солирсон хэрэг биш юм. Үнэн гэж байна, худал юм гэж байна гэхдээ чи ертөнцийн бүх юмыг сөрөн зогсож үнэнийг баримтлах юм бол солиотой хүн биш ээ. Жаргаж байгаа нарны шар туяа орны дэвсгэр

дээр туслаа. Смит нүдээ аниад хэвтэж байхдаа нүүр нь нарны туяанд, бие нь эмэгтэй хүний ялдам биед хүрч бүлээцээд амар амгалан нойрмог итгэл төрж байна. Юу ч тэдэнд заналхийлэхгүй, бүх юм сайхан байна. Тэрээр амандаа «эрүүл саруул ухаан бол тоо бүртгэлийн ойлголт биш» гэж үглээд нойрмоглолоо. Эдгээр үгэнд гүн гүнзгий мэргэн ухаан шингэсэн юм шиг санагдаж байлаа.

\* \* \*

Смит их л удаан унтсан юм шиг санаж сэрэхэд хуучны цагаар дөнгөж 20.30 болж байна. Тэрээр дахин зүүрмэглэхэд хашаан дотроос нөгөөх танил хоолойгоор дуулах дуулдлаа.

*“Сэтгэл зүрхэнд дотно мөрөөдөл минь*

*Хаврын эхний өдөр шиг арилжээ*

*Зүүд нойрыг минь түгшүүлсэн*



*Итгэл найдварыг би одоо ч мартаж чадахгүй нь!”*

Энэ тэнэгдүү дуу моодноос гараагүй бололтой, хот дотор хаа хаагүй дуулсаар байгаа аж. Энэ дуу «Үзэн ядахын дуу»-наас ч илүү тархжээ. Жулия дууны чимээнээр сэрээд тааламжтайяа суниагаад орноосоо бослоо.

“Юм идмээр байна. Кофе чанах уу? Керосин халаагуур унтарчихаж, ус нь хөрчихжээ. Керосин ч апга” гэж тэрээр хэллээ. “Өвгөнөөс асууж болох байх аа”

“Хачин юм. Ус нь дүүрэн байсан юмсан. Хүйтэрчихэв үү дээ. Хувцсаа өмсье”

Смит ч мөн босч хувцсаа өмслөө. Нөгөөх цуцдаггүй хоолой хангинасаар байна:

*“Цаг хугацаа бүхнийг мартагдуулна гэж л байг*

*Зовлон зүдүүрээ март л гэж байг*

*Олон жилийн инээмсэглэл, нулимс*

*Зүрх сэтгэлийг минь шаналгасаар байна!”*

Смит баадайныхаа тэлээг чангалаад цонхонд ойртож очиход нар байшингийн цаагуур далд ороод нарны туяа хашааны дотор тусахаа больжээ. Явган замын чулуулаг дөнгөж сая угаасан юм шиг нойтон байх бөгөөд тэнгэр хүртэл байшингийн яндангуудын дундуур цэмбийж хөхрөн харагдах нь угаачихсан юм шиг санагдуулна. Нөгөөх эмэгтэй нааш цааш цуцалтгүй алхсаар амаа нэг ангайж нэг хамхиж дуугаа дуулж, дуугүй болж хүүхдийн цагаан даавуугаа өлгөсөөр байна. Энэ эмэгтэй юм угааж амь зуулгаа залгуулдаг юм болов уу, аль эсвэл хорь гучин ач гуч нарынхаа даавууг угаадаг юм болов уу гэж Смит бодож байлаа. Жулия босож ирээд дэргэд нь зогслоо. Тэр хоёр хашааны доторхи биелэг бүдүүн авгайг сонирхон харж зогслоо. Нөгөөх эмэгтэй дадсанаараа бүдүүн гараа сунган олсонд хүрээд гүүнийх шиг бүдүүн бөгс нь тонтгоноход

Смитэд анх удаагаа энэ эмэгтэй их сайхан юм байна гэсэн бодол төрлөө. Тавин настай эмэгтэйн хүүхэд гаргахдаа тэлж сунасан, дараа нь ажилд дарагдан хатуурч хатсан сарнай шиг болсон хаа бие ийм сайхан байх юм гэсэн бодол Смитэд хэзээ ч төрж байгаагүй юм. Гэхдээ л сайхнаараа байна, эцсийн бөлөгт яагаад ийм байж болдоггүй юм бэ гэж тэрээр боддоо. Аржгар улаан арьстай бөөн боржин шиг хэлбэр галбиргүй хатуу ширүүн энэ хаа бие дэлбээлэх гэж байгаа зэрлэг сарнай шиг залуухан бүсгүйн хаа биетэй төстэй ажгуу. Яагаад жимс нь цэцэгнээсээ дор байх ёстой юм бэ?

“Энэ их сайхан эмэгтэй байна” гэж тэрээр амандаа дуугарав.

“Бүсэлхий нь лав нэг метр хүрнэ” гэж Жулия хэллээ.

“Түүний гоо сайхан нь үүнд л байгаа юм” гэж Смит хэллээ.

Смит түүнийг бүсэлхийгээр нь тэвэрч зогсоход тэр хоёрын өвдөг нийлж байлаа. Тэдний дундаас хэзээ ч хүүхэд төрөхгүй. Ийм хувь заяа тэдэнд байхгүй. Тэд үгээрээ, оюун ухаанаараа далд нууцаа дамжуулна. Хашаан доторхи эмэгтэйд оюун ухаан байхгүй, харин түүнд чадалтай гар, үржилтэй хэвлий бий. Энэ эмэгтэй хэдэн удаа хүүхэд төрүүлсэн бол оо гэж тэрээр бодлоо. Арван таван хүүхэд өлхөн гаргаж чадах байх. Түүний бие бялдар жил орчим хугацаанд зэрлэг сарнай лугаа адил гоо сайхан болоод удалгүй цэцгийн товчирхой шиг хатаж, хатуу ширүүн аржгар болж энэ насныхаа гуч гаруй жилийг тасралтгүй юм угаах, цэвэрлэх, нөхөх, хатгах, хоол хийх, шал угаах, шүүрдэх, гутал хувцас сэлбэх, эхлээд хүүхдүүдийнхээ, дараа нь ач гуч нарынхаа хувцас хунарыг угааж цэвэрлэж өнгөрөөсөн юм. Энэ бүхний эцэст одоо дуу дуулж байна. Тэр эмэгтэйг бишрэх сэтгэл байшингийн орой дээрх яндангийн цаагуур алсын алсад далд ортлоо харагдах цэв цэвэрхэн саарал тэнгэрийн өнгөн дээр улам ч хүчтэй хөдөлнө.

Тэнгэр хаана ч адилхан Евразийн гүрэн, Дорнодазийн Гүрэн дээр ч адил гэж бодоход хачин санагдаж байлаа. Тэнгэрийн доорхи ард түмэн бүгд хаана ч адилхан, манай ард түмэн шиг хэдэн зуун мянгаараа, хэдэн зуун саяараа байна. Тэд бие биеийхээ оршин тогтнож буйг мэдцэггүй бөгөөд тэднийг бие биеэ жигших, худал хуурмаг сурталчилгаа тусгаарлаж буй ч гэсэн тэд бараг адилхан юм. Тэд бодож сэтгэж сураагүй ч гэсэн дэлхийг нэг л өдөр эргүүлэх хүч чадлыг сэтгэл зүрх бие махбодьдоо хадгалж явна. Найдвар байдаг л юм бол тэр нь үгээгүйчүүдэд бий. Тэрээр номоо дуустал нь уншаагүй ч гэсэн Голдштейн ч ийм дүгнэлт хийнэ гэдгийг мэдэж байна. Уинстон Смитийн хүлээсэн цаг хугацаа ирэхэд түүний цогцдоон бүтээсэн дэлхий Намын дэлхий шиг хар элэгтэй байхгүй гэхийн баталгаа бий юу? Тийм ээ, шинэ ертөнц одоо л нэг эрүүл саруул ухааны дэлхий байх болно. Эрх тэгш байдал байгаа газарт эрүүл саруул ухаан байж болох юм. Эрт орой хэзээ нэгэн цагт энэ бүхэн буй болно. Хүч ухамсар болж хувирна. Үгээгүйчүүд бол

мөхөшгүй юм. Хашааны дотор байгаа эрэлхэг эмэгтэй бол үүний хамгийн тод нотолгоо мөн. Энэ бүхэн болоогүй байхад мянган жил хүлээлээ гэсэн ч Намын булааж авсан, тэхдээ дарж чадахгүй хүч чаддыг шувуу шиг амьдрах чадвараа бие биедээ дамжуулан бүхнийг сөрөн тэд оршин тогтнох болно.

“Анх бид уулзахад ойн цоорхойд хөөндэй донгодож байсныг чи санаж байна уу?” гэж тэрээр асуув.

“Тэр чинь бидэнд зориулж донгодоогүй. Тэр чинь өөрийнхөө зугааг гаргах гэж донгодсон юм. Тэр чинь зүгээр л донгодсон юм” гэж Жулия хэллээ.

Шувуу донгодно, үгээгүйчүүд дуулна, Нам дуулахгүй. Даян дэлхий даяар Лондонд ч, Нью Йоркт ч, Африкт ч, Бразильд ч, хилийн чанад дахь үл мэдэх хаалттай улс оронд ч, Оросын нүд алдам тал нутгийн тосгодод ч, Хятад, Японы зах дээр ч, хаа хаагүй хүнд хүчир ажилд дарагдаж,

хүүхэд төрүүлж биеэ барсан энэ чийрэг мөхөшгүй эмэгтэй зогсож байна, тэгээд энэ бүхнийг үл тоон дуугаа дуулж байна. Ийм хүмүүсийн хүчирхэг өврөөс хэзээ нэгэн цагт ухамсартай үндэстэн төрж болох юм. Чи бол үхдэл харин ирээдүй тэдний гарт байна. Харин тэд бие махбодио хадгалсан шиг оюун ухаанаа мөхөөлгүй хадгалж хоёр хоёрын дөрөв гэсэн далд сургаалыг цаашид уламжлуулах юм бол чи ч гэсэн тэр ирээдүйд багтаж чадна.

“Бид бол үхдэл” гэж Смит хэллээ.

“Бид бол үхдэл” гэж Жулия дуулгавартайяа дагаж хэллээ.

“Та нар бол үхдэл” гэж тэдний ард чанга дуу гарлаа.

Тэр хоёр бие биеэсээ холдов. Смитийн гол руу нь хүйт оргилоо. Тэрээр Жулиягийн нүд том болж царай нь хувхай цайхыг харж байлаа.

Түүний булчин нь яснаасаа мултарсан юм шиг товойж харагддаа.

"Та нар бол үхдэл" гэж нөгөөх хахнр дуу дахнад гарлаа.

"Зурагны араас гарч байна гэж" Жулия шивнэлээ.

"Тиймээ, зурагны араас ярьж байна. Бүү хөдөл. Тушаап хүлээж бай" гэж нөгөөх дуу гарлаа.

Нөгөөх чинь эхэллээ! Нөгөөх чинь одоо л эхэллээ! Тэр хоёр өчүүхэн ч хөдөлж чадахгүй бие биеэ харж зогсоно. Оройтоогүй дээр нь зугтаж амь насаа аврах, байшингаас зугтах тухай бодол тэдний толгойд төрсөнгүй. Хананаас гарч буй хахир дууг дагахгүй байхыг бодохын ч хэрэг байхгүй. Хөшиг татаж буй юм шиг тог гэх дуу гарч шил хагарах чимээ сонсдов. Сийлбэр зураг унаж, цаана нь теледэлгэц харагддаа.



"Тэд одоо биднийг харж байна" гэж Жулия хэллээ.

"Бид одоо та хоёрыг харж байна. Өрөөний дунд очиж зогс. Гараа дээш нь өргөөд бие биедээ хүрэлгүй буруу харж зогс" гэх дуулдав.

Смит Жулияд хүрээгүй боловч түүний бүх бие чичирч буйг мэдэрч байлаа. Тэрээр өөрөө шүдээ харчигнуулахгүй байсан ч өвдөг нь яах ч аргагүй чичирч байлаа. Байшин дотор ч, гадна нь ч түрийтэй гуталтай хүний хөлийн хүнд алхаа дуулдана. Байшин хүнээр дүүрсэн бололтой. Явган замаар ямар нэг хүнд юм чирч байна. Эмэгтэйн дуу дуулах нь сонсогдохоо больжээ. Чулуулсан явган зам дээгүүр угаалгын ванн чирэх шиг чимээ гарч баахан хашгирах шуугиан дэгдэснээ тэр нь хүн ёолох чимээ гарч дууслаа.

"Байшинг бүсэлжээ" гэж Смит хэллээ.

"Байшинг бүсэлсэн" гэж нөгөөх дуу гарлаа.

Жулия шүдээ тас зуух нь сонсогдоод “Бид салах ёс гүйцэтгэх нь зөв байх аа” гэж хэллээ.

“Салах ёс гүйцэтгэж болно” гэж нөгөөх хоолой дуугарлаа.

Смитэд танил юм шиг өөр нэг сэхээтэн хүний хоолой хажуугаас нь гэнэт орж ирээд.

“Бид нэгэнт л энэ асуудлыг хөндсөнөөс хойш «Би лаа асаагадахья, чи орондоо орж болно, хурц илд аваадахья, толгойг чинь тас огтольё»” гэлээ.

Смитийн ар талд орон дээр ямарваа нэг юм хангинан унаж цонх руу шат тавьсан тул үзүүр нь цонхны рааманд ёрдойж харагддаа. Хэн нэгэн хүн цонх руу авирч байна. Шатан дээр болон байшин дотор олон хүний хөлийн чимээ гарч байна. Дүрэмт хар хувцастай, уландаа төмөр хадсан гуталтай, гартаа бороохой барьсан чийрэг эрс өрөөгөөр дүүрлээ.

Смит чичрэхээ болиод нүдээ ч хөдөлгөхгүй зогсож байна. Тэдэнд зодох шалтаг гаргахгүйн тулд өчүүхэн ч хөддөхгүй байх, хөддөхгүй байх нь чухал байна! Нударган зодооны аварга бололтой урт эрүүтэй, амны оронд том нүхтэй нэгэн эр эрхий хурууныхаа үзүүрт бороохойгоо сагалдрагаар нь эргэлдүүлэн Смитийн өмнө зогсож байна. Тэр хоёрын харц тулгарлаа. Гараа толгой дээрээ өргөчихсөн нүүр, бие нь задгай гэж бодоход тэсэхүйеэ бэрх аж. Нөгөөх эр цагаан хэлээ цухуйлгаад уг нь уруул байх ёстой амаа долоогоод хажуугаар нь өнгөрөв. Дахиад л юм хагарах чимээ гарлаа. Хэн нэгэн бөөрөнхий шилийг авч ил зуух руу шидэж хага цохив.

Шүрний ягаан хагархайнууд бялуун дээр шигтгэсэн чихрэн сувд шиг шалаар нэг тарлаа. Смит энэ яасан жижигхэн, яасан жижигхэн юм байсан юм бэ гэж бодож байлаа. Смитийн ард ямар нэг зөөлхөн юм руу хүчтэй цохих чимээ гарч хэн нэгэн ёоллоо. Смитийг цагдаа шагай руу нь хүчтэй өшиглөхөд тэрээр арай л ойчсонгүй.

Цагдаа Жулиягийн хэвлийн хөндий рүү гараараа чанга цохиход тэрээр шалан дээр ойчоод дөрвөн хөллөн мөлхөж амьсгаагаа авч чадахгүй байлаа. Смит хэдийвээр эргэж харж зүрхлээгүй ч гэсэн Жулиягийн том ангайчихсан ам, хувхай цагаан болчихсон царай нь нүднийх нь буланд харагдаж байна. Тэрээр өөрөө айдас хүйдэст автагдсан ч гэсэн хөөрхий бүсгүйн зовлон шаналал, боомилогдож үхэхээс арай наагуур тэвэрлэшгүй их шаналлыг биеэрээ амсаж байлаа. Тэрээр ингэж тарчлахыг мэднэ. Огт намдахгүй аюумшигтай муухай, амь тэмцсэн тарчлаан, энэ бол шаналж зовж дууссан хэрэг биш бөгөөд хамгийн чухал нь ямар ч байсан нэг амьсгаагаа авах хэрэгтэй байна! Хоёр цагдаа бүсгүйг цээж хөлнөөс нь өргөөд шуудайтай юм авч яваа юм шиг өрөөнөөс авч оддоо. Смит түүний шарлаж, муруйсан уруугаа харсан нүүр, аниастай нүд, хацар дээрх улаан нөрөөгий нь зэрэвсхэн харлаа, тэрээр түүнийг сүүлчийн удаа харлаа.

Смит хөддөхгүй зогссоор байх бөгөөд одоохондоо түүнийг зодсонгүй. Түүнд элдвийн огт хэрэггүй бодол төрнө. Ноён Чаррингтоныг баривчлаа болов уу? Хашаан дотор байсан эмэггэйг яасан бол? Шээс их хурч байх чинь хачин юм даа. Хоёр гуравхан цагийн өмнө шээсэн юмсан. Задгай зуухны дээрх цагаар есөн цаг буюу 21 цаг болж байна. Гадаа гэгээтэй байна. Наймдугаар сард хорин нэгэн цагт бүрэнхий болдоггүй билүү? Жулия бид хоёр цагаа андуурсан юм уу, хагас өдөр унтчихсан юм уу, бидний 20. 30 гэж бодож байсан чинь өглөөний 8. 30 болж байсан юм болов уу? Тэрээр үүнийг цааш нь бодсонгүй, сонирхол ч алга байлаа.

Хонгилд хэн нэгэн хүн зөөлхөн алхсаар ирж буй чимээ гарлаа. Ноён Чаррингтоныг өрөөнд орж ирэхэд дүрэмт хар хувцастай хүмүүс чив чимээгүй боллоо. Ноён Чаррингтон ч өөрчлөгдчихжээ. Түүний харц бөөрөнхий шилний хагархай дээр тусав.

“Шилний хагархайг цуглуулж ав” гэж тэрээр огцом хэллээ.

Нэг цагдаа дуулгавартай нь аргагүй шилний хагархайг цуглуулж гарлаа. Гэрийн эзний Лондон хотын борчуудын ярианы аялга алга болжээ, Смит түүний дуу дөнгөж саяхан теледэлгэцнээс гарч байсныг ойлголоо. Ноён Чаррингтон нөгөөх л элэгдсэн хилэн хүрмээ өмсчихсөн байна, харин түүний бараг бууралтсан үс нь хар болчихсон, нүдний шил зүүгээгүй байна. Тэрээр Смит рүү хэн болохыг нь тогтоож байгаа юм шиг эгцлэн харснаа түүнийг анзаарахаа болив. Түүнийг таниж болох боловч тэрээр өөр хүн болчихсон байна. Түүний нуруу нь тэгшрээд бие хаа нь том болчихсон ч юм шиг харагдана. Түүний нүүр ялихгүй өөрчлөгдсөн мөртлөө тэрээр огт өөр хүн болжээ. Хар хөмсөг нь тийм ч өтгөн биш юм шиг болоод үрчлээ нь алга болж нүүр нь өөр болжээ, хамар нь хүртэл намхан болсон байна. Энэ царай бол гуч эргэм настай хүний цовоо, цэвдэг хүйтэн царай байна. Смит энэ насандаа

анх удаагаа Сэтгэхүйн Цагдаагийн ажилтантай ямар ч эргэлзээгүй нүүр тулан уулзаж байна даа гэж боддоо.

# ГУРАВДУГААР ХЭСЭГ



# I

Смит хаана байгаагаа мэдэхгүй байна. Түүнийг Хайрын Яаманд авчирсан байх ёстой, гэхдээ үүнийг баттай хэлэх арга алга аж.

Смит өндөр таазтай гялалзсан цагаан шаазан ханатай цонхгүй гяндангийн өрөөнд байна. Далдалсан дэнлүү өрөөг бүдэгхэн гэрэлтүүлэх бөгөөд намуухан хүнгэнэсэн дуу гарч буй нь салхижуулалтын хэрэгслийн дуу бололтой юм. Хаалганаас бусад өрөөний бүх хананы дагуу хүн суух өргөнтэй сандал ч юм уу тавиур ч юм уу байх бөгөөд түүний үзүүрт хаалганы эсрэг талд шалан дээр хувин тавьжээ. Хана бүрт бүгд дөрвөн теледэлгэц байна.

Смит өөрийг нь бүхээгтэй машинд чихэж оруулаад авч явснаас эхэлсэн гэдэс дотор чинэрэн өвдөх нь одоо ч хэвээрээ байна. Тэрээр их өлсөж байна. Ер бусын мэрсэн өлсгөлөн аж. Смит нэг хоног, хоног гаруй юу ч идээгүй. Тэрээр өөрийг

нь оройгоор уу, өглөөгүүр үү хэзээ баривчилсныг ойлгосонгүй, ойлгох ч үгүй биз. Баривчилснаас хойш түүнд огт хоол өгөөгүй юм.

Одоо тэр нарийхан сандал дээр гараа өвдгөн дээрээ тавиад чимээгүй сууж байна. Гэнэт л хөдлөх юм бол теледэлгэцнээс чам руу хашгирдаг тул тэрээр чимээгүй суугаад сурчихжээ. Үмх хоол ч гэсэн идмээр, юуны өмнө зүсэм талх идмээр байна. Тэгснээ баадайны халаасанд талхны үртэс үлдсэн байж магадгүй гэж бодлоо. Үе үе хөлийн уланд нь нэг юм тэмтрэгдээд байх шиг болохоор талхны хэлтэрхий уначихсан байж ч болох юм, хоол идэх гэсэн хорхойдоо автагдан айдас хүйдсээ мартан тэрээр халаасандаа гараа хийлээ.

“Смит! У. Смит. Жар далан ес! Өрөөнд гараа халаасандаа хийж болохгүй!” гэж теледэлгэцнээс чанга бархирлаа.

Тэрээр дахиад л гараа өвдөг дээрээ тавиад хөдлөхгүй суулаа. Түүнийг энд авчрахын өмнө шорон юм уу харуулын хэрэглэдэг түр саатуулах газрын аль нэг нь бололтой газарт аваачсан юм. Тэнд хэр зэрэг удсанаа мэдэхгүй байна. Нилээд хэдэн цаг болсон байх, гэрэл гэгээ байхгүй, цаг байхгүй байсан болохоор хэдэн цаг болсныг мэдэх аргагүй байлаа. Энэ нь чимээ шуугиан ихтэй, муухай үнэртэй газар байсан юм. Түүнийг одоогийнхтой адил гэхдээ их заваан бохир арав, арван таван хоригдолтой өрөөнд оруулсан юм. Тэдний ихэнх нь жирийн эрүүгийн гэмт этгээдүүд, цөөн хэдэн улс төрийн хоригдол байлаа. Смит тэдний дунд шахцалдан хана налаад айсан, дотуур өвдсөнөөс болж тэднийг бараг анзаарах завгүй сууж байсан юм. Гэхдээ тэрээр намын гишүүн хоригдол, бусад хоригдлын гайхмаар ялгааг ажиглаж амжсан. Намын гишүүн хоригдол үг ч дуугарахгүй, айж эмээсэн байхад эрүүгийн этгээдүүд юунаас ч айхгүй юм шиг байсан. Тэд хуяг нарыг хараан зүхэж, эд юмыг нь хураахад булаацалдан зодолдож, шалан дээр бузар булай үг бичиж,

хулгайгаар оруулж ирээд хувцасныхаа хаа нэг үл ойлгогдох газарт нуучихсан хоол хүнсээ идэж, дэг журам тогтоох гэсэн теледэлгэцийн өөдөөс хүртэл хашгирч байсан юм. Бас тэгээд зогсохгүй зарим нэг нь хуяг нартай нөхөрлөж тэднийг хочоор нь дуудаж хаалганы нүхээр тамхи гуйж авч байсан юм.

Харгалзагч нар эрүүгийнхэнд зөөлөн, тэр бүү хэл хүч хэрэглэх шаардлага гарах үед ч аядуу хандаж байлаа. Ихэнх хоригдлууд цөлөгдөх, хүнд хүчир хөдөлмөрийн лагерийн тухай хүмүүс их ярьцгааж байлаа. Чи хэрэв нүх сүвийг нь мэддэг холбоо сүлбээтэй бол лагерь ч «айх юмгүй» гэдгийг Смит ойлгосон юм. Тэнд авилгал, тал тохой татах, дарамтлан зандалчлахаар ч зогсохгүй бандидах, янхандах мөн түүнчлэн төмснөөс архи нэрэх хүртэл байна. Жирийн эрүүгийн гэмт этгээдүүд, ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэгтнүүд болон алуурчдад итгэдэг ба тэд нар нь нэгэн төрлийн давуу эрх эдлэгчид болсон байх юм. Хамгийн бузар ажил нь улс төрчдөд ногдоно.

Шоронгийн өрөөгөөр долоон шидийн хүмүүс зогсолтгүй цувна. Хар тамхины наймаачид, хулгайчид, дээрэмчид, хар захын худалдаачид, архаг архичид, янхнууд. Зарим архаг архичин агсрахаар бусад хоригдлууд хамтран түүнийг номхотгож байлаа. Дөрвөн харгалзагч жар эргэм настай, том мээмтэй аврага том биетэй эмгэнийг дөрвөн мөчнөөс нь чирж гулдарсаар оруулж ирлээ. Тэрээр бахь байдгаараа хашгирч, хөлөөрөө тийрэхэд түүний цав цагаан үс нь мушгиралдан сагсайж байлаа. Эмгэн харгалзагчдын хөл рүү өшиглөсөөр байгаад шаахайг нь мултлаад тэд нар эмгэнийг Смитийн өвөр дээр хаяхад арай л түүний хөлийг хугалчихсангүй. Эмгэн суумагцаа харгалзагчдын араас «Эхээ о...!» гэж бархирав. Эмгэн эвгүй сууж байгаагаа мэдмэгц Смитийн өвөр дээрээс бууж сандал дээр суув.

“Хүү минь уучлаарай. Би өөрөө чам дээр суугаагүй шүү. Муусайн новшууд л суулгачихлаа. Эмэгтэй хүнтэй яаж харьцаж

байгааг харав уу?” гээд цээжээ илснээ  
“Уучлаарай. Би ч өөрийгөө мэдэхээ байлаа” гэв.

Эмгэн бөхийгөөд шалан дээр бөөлжчихөв.

“Энэ нь дээр. Би биеэ битгий барь гэдэг юм.  
Шингээгүй юмыг гаргаж бай” гэж тэрээр нүдээ  
аниад хана налж суугаад хэлэв.

Эмгэн бага зэрэг сэргэн Смит рүү эргэж харахад  
сэтгэл нь таатай болов. Тэрээр Смитийг мөрөөр  
нь тэвэрч, бөөлжис үнэртүүлэн өөр рүүгээ  
татлаа.

“Чамайг хэн гэдэг вэ, хүү минь?”

“Смит”

“Смит гэнээ? Би ч бас Смит шүү дээ” гээд сэтгэл  
нь хөдлөн “Би чиний ээж байвал таарах юм”

Ээж ч байж болох л юм гэж Смит бодлоо. Нас сүүдрээрээ ч, биеэрээ ч байж болох л юм. Хорин жил лагерьт байхад хүн их өөрчлөгдөнө л дөө.

Өөр хэн ч түүнтэй яриа дэлгэсэнгүй. Эрүүгийнхэн намын гишүүдийг үл тоож буй нь гайхмаар аж. Тэд илт жигшин «улс төрчид» гэж дуудаж байлаа. Баривчлагдсан улс төрчид яриа дэлгэхээс айн эмээж ялангуяа өөр хоорондоо яриа дэлгэхээс ихээхэн эмээж байлаа. Нэг удаа намын гишүүн хоёр эмэгтэйг сандал дээр шахаж ойртуулж суулгахад л тэд нар бие биедээ хурдан хурдан шивнэн ярилцах нь, үл ойлгогдох «зуун нэгдүгээр өрөөний» тухай ярих нь шуугиан дунд сонсдож билээ.

Шоронгийн энэ өрөөнд тэрээр хоёр цаг, магадгүй гурван ч цаг сууж байгаа байх. Биен дотор нь чинэрэх өвчин нь нэг хэсэгтээ ихсээд нэг хэсэгтээ намсаж түүнийг дагаж бодол нь сэргэж дарагдаж байна. Тэрээр өвчнөө ихсэхээр зөвхөн энэ тухай бодон юм идэх юмсан гэж бодож, өвчнөө намдахаар сандран мэгдэнэ.

Тэрээр удахгүй өөртөө ирэх юмыг тов тодорхой харж зүрх нь хүчтэй цохилж амьсгал нь зогсож байна. Тэрээр бороохойгоор тохой руу нь цохих, төмөр тахтай гутлаар шагай руу нь өшиглөхөд ямар байдгийг мэдэрч байна. Өөрийгөө шалан дээгүүр мөлхөж хага цохиулсан шүдээ нулиман «болиоч ээ!» гэж орилохыг тэрээр харлаа. Жулиягийн тухай бараг бодсонгүй, түүн дээр бодол нь ч тогтсонгүй. Смит түүнд хайртай байсан, түүнийг яасан ч худалдахгүй, гэхдээ энэ нь тоо бодох хэн бүхний мэддэг арга шиг бодит зүйл юм. Тэрээр одоо хайр сэтгэлээ мэдэрч чадахгүй Жулия яаж байгаа бол гэж бодох тэнхээгүй байна. Тэрээр үе үе найдвар төрөн Обрайеныг бодож байна. Обрайен түүний баригдсаныг лав мэдэж байгаа. Ах дүүгийн барилддага өөрийн гишүүдээ ерөөсөө авардаггүй юм гэнэ лээ. Харин сахлын тонгорог гэж нэг юм бий, тэд чаддаг л юм бол сахлын хутга явуулж болно. Хуяг хэдхэн агшинд л өрөөнд ороод ирж чадна. Сахлын хутга арьсанд ширчигнэн ороод чимхэж буй хурууны арьсыг ясанд нь хүртэл зүснэ. Тэрээр энэ бүхнийг одоо



болж байгаа юм шиг мэдрэхэд шаналсан бие нь өвчин нь өчүүхэн төдий сэдрэхэд л чичирч атирч байна. Смит сахлын хутга авлаа ч гэсэн түүнийг хэрэглэж чадах эсэхээ сайн мэдэхгүй байна. Хүн гэдэг агшин тутам амьд явахыг эрмэлздэг нь жам ёсны хэрэг бөгөөд эцэст нь эрүү шүүлттэй тулгарна гэдгээ сайн мэдэж байвч хэдхэн хором ч гэсэн амьд явахыг хусдэг юм.

Тэрээр өрөөний хананы шаазан шахмалыг тоолох гэж оролдож үзлээ. Энэ нь амархан юм шиг мөртлөө тоолох гэхээр алдчихаад байв. Тэрээр өөрийг нь хэрхэн шоронд хийсэн болон одоо өдрийн хэдэн цаг болж буй тухай л ихэвчлэн бодож байлаа. Хэдхэн хормын өмнө гадаа үд болж байна гэж бодож байсан, одоо бол гадаа хав харанхуй болсон байна гэж бодож байна. Ийм газар ерөөсөө гэрэл унтраадаггүй юм гэдгийг тэрээр зөнгөөрөө мэдэж байна. Гэрэл гэгээтэй нэгэн газар, Обрайен энэ зүйрлэлийг ойлгож байсны учрыг одоо л ойлгож байна. Хайрын Яаманд цонх огт байхгүй. Түүний одоо байгаа өрөө байшингийн дунд ч,

гадна хананд ч байж болно. Газар доогуур арван давхар дор ч, газар дээр гучин давхарт ч байж болно. Тэрээр оюун ухаанаараа нэг газраас нөгөө газарт нүүж тэр өөрөө өндөрт байна уу, газар дор байна уу гэдгээ мэдэх гэж оролдоно.

Хаалганы цаана хөлийн жигд алхаа дуулддаа. Төмөр хаалга хяхнан онгойж лаван баг шиг зэвхий цагаан нүүртэй, энд тэндгүй гялбалзсан цэвэрхэн ширэн дүрэмт хувцастай офицер орж ирээд хуяг нарт хоригдлыг оруулах дохио өгөхөд яруу найрагч Амплфорт бүдэрсээр орж ирлээ.

Амплфорт гадагшаа гарах өөр нэг хаалга эрсэн юм шиг ийш тийшээ гуйвагнан алхсанаа өрөөн дундуур нааш цааш холхилоо. Тэрээр одоохондоо Смитийг анзаарсангүй. Түүний түгшүүр дүүрэн харц Смитийн дээгүүр ханан дээр тусч байна. Тэр хөл нүцгэн аж, хиртэй том хуруунууд нь оймсных нь цоорхойгоор цухуйж байна. Тэрээр олон хоног сахлаа хусаагүй аж. Сахалдаа шанаагаа хүртэл дарагдсан нүүр нь

далайн дээрэмчний төрхийг санагдуулах боловч түүний суларч доройтсон бие, цочирч сандарсан алхаатай нь авцалдахгүй байх аж.

Смит мэгдсэн байдлаасаа гарахыг оролдлоо. Одоо теледэлгэцнээс хашгирсан ч гэсэн Амплфорттой ярилцах ёстой. Магадгүй Амплфортоор сахлын хутга явуулсан ч байж болох юм.

“Амплфорт” гэж тэрээр дуугарав.

Теледэлгэцээс дуу гарсангүй. Амплфорт жаахан гайхширан зог тусч Смит руу эгцлэн харлаа.

“Смит шив дээ. Чи бас энд байгаа юм уу?”

“Таныг яагаад баривчилсан юм бэ?”

“Үнэнийг хэлэхэд” гээд Смитийн өөдөөс харж сандал дээр эв дүйгүйхэн суулаа. “Зөвхөн ганц л гэмт хэрэг байдаг шүү дээ”

"Та тэгээд гэмт хэрэг үйлдчихээ юу?"

"Тэгсэн байж таарах нь"

Тэрээр гараа духандаа хүргээд ямар нэг юм санах гэсэн мэт чамархайгаа хуруугаараа дарж:

“Ийм юм гардаг юм” гэж тэрээр итгэл муутайхан яриагаа эхэллээ. “Би нэг тохнолдлыг санаж байна, байж болох тохиолдол л доо. Би хайхрамжгүй хандсан нь гарцаагүй хэрэг. Бид Киплингийн шүлгийн түүврийг хэвлэлд бэлтгэж байсан юм. Би бадгийн төгсгөлд “Бурхан” гэдэг үгийг хэвээр нь үлдээчихсэн юм. Өөр яах ч арга байхгүй байсан юм” гээд тэрээр Смитийн өөдөөс харж бараг эгдүүцэнгүй хэллээ. “Мөрийг өөрчлөх боломж байхгүй байсан юм. «Ташуур» гэсэн үгтэй шүлгийн мөрийн сүүлийн үгийг холбох ёстой байсан юм. Манай хэлэнд «Ташуур» гэдэг үгтэй зөвхөн арван хоёр үгийг холбож болдгийг та мэднэ биз дээ? Хэд хоног толгойгоо гашилгасан даа. Өөр сүүл холболт байхгүй байсан”

Түүний царай нь хувираад гоморхсон сэтгэл нь арилж сэтгэл хангалуун юм шиг боллоо. Сахалдаа дарагдсан хиртэй нүүрэнд нь ямар нэг ашиггүй баримтархуу юм ухааж мэдсэн ёсорхуу хүний урам зориг тодров.

“Англи яруу найргийн бүхий л түүхэн хөгжилд англи хэлний сүүл холбох ядмагхан арга нөлөөлсөн гэдгийг та бодож үзсэн үү?” гэж тэрээр асуулаа.

Смит чухам энэ асуудлыг бодож байгаагүй юм байна. Тэгээд ч энэ асуудлыг сонирхолтой, их чухал гэж үзэж байгаагүй юм.

“Та одоо хэдэн цаг болж байгааг мэдэх үү?” гэж Смит асуулаа.

Амплфорт гайхсан бололтой “Би энэ тухай бодож байгаагүй юм байна. Тэд нар намайг хоёр хоногийн өмнө магадгүй гурав хоногийн өмнө баривчилсан байх аа” гэлээ. Энд цонх олж харахгүй нь мэдээж хэрэг юм гэсэн шиг тэрээр

эргэн тойрноо харлаа. “Энд өдөр шөнийн ялгаа байхгүй. Цагийг яаж мэдэх билээ?”

Тэр хоёр дахиад хэдэн хором элдэв юм ярьж байтал яагаад ч юм теледэлгэцнээс дуугаа тат гэж бархирлаа. Смит тэр дороо дуугүй болоод гараа өвдөг дээрээ тавьж суулаа. Биерхэг Амплфортод нарийхан сандал дээр суухад эвгүй байсан тул хоёр тийшээ хавчигнан өвдгөө ээлжлэн барьж байлаа. Теледэлгэц дахиад л хөддөхгүй суу гэж бархирлаа.

Цаг явсаар байна. Хэдэн хором, бүтэн цаг өнгөрлөө, мэдэх арга алга. Гадаа дахиад хөлийн чимээ гарлаа. Смитийн айдас хүрч байна. Удахгүй, тун удахгүй магадгүй хэдхэн хормын дараа ээлж ирэхлээр өөрийг нь өшиглөж дэвслэх болно.

Хаалга онгойж хүйтэн царайтай офицер орж ирээд Амплфорт руу хуруугаараа зааж

“Зуун нэгдүгээр өрөө рүү яв” гэв.

Амплфортын сэтгэл багахан түгшин юу болж буйг үл ойлгон хоёр харгалзагчийн хамт эв хавгүй алхан гарч явлаа.

Их л удах шиг боллоо. Смитийн бие нь өвдсөөр байна. Түүний бодол нэг нүхэнд дахин дахин өнхөрч ойчоод байгаа бөмбөг шиг эргэлдсээр байна. Тэрээр зургаан юмыг л бодож байна. Эдгээр нь бие нь өвдөх, зусэм талх, цус урсах ба орилон дуу алдах, Обрайен, Жулия, сахлын хутга болно. Дахиад л айдас төрж байна. Хүнд хөлийн алхаа дахиад л дуулдлаа. Хаалга онгойход хулмас хөлс ханхаллаа. Парсонс өрөөнд орж ирлээ. Тэрээр ногоон өнгийн богино өмд, биеийн тамирын цамц өмсчээ.

Смит гайхсандаа бүх юмаа мартчихлаа.

"Та энд байгаа юм аа?" гэж тэрээр хэллээ.

Парсонс Смитийг сонирхсон ч үгүй, гайхсан ч үгүй шаналсан харцаар харж байлаа. Тэрээр тайван байж чадахгүй байсан болохоор өрөөнд

цухалдангуй орж иржээ. Түүний хавдартай өвдөг нь чичирч байгаа нь мэдрэгдэж байлаа. Тэрээр нүдээ том нээгээд алсын алс дахь нэг юмнаас хараагаа салгаж чадахгүй байгаа юм шиг ширтэж байлаа.

"Таныг юунаас болж баривчилсан юм бэ?" гэж Смит асуулаа. "Сэтгэхүйнгэм!" гэж тэрээр уйлах шахаж гэмээ хүлээж үнэхээр энэ үг түүнд хамаатай юу гэж гайхан айдас нь хүрч хэллээ. Тэрээр Смитийн өөдөөс харж зогсоод тэсч ядан:

"Найз минь, тэд намайг арай буудчихгүй байх, тийм биз дээ? Үнэхээр хэрэг хийчихээгүй бол тэд намайг буудахгүй, хүний бодлыг бол яах ч арга байхгүй, тийм биз дээ? Тэд нар үгийг нь сонсоно, учрыг нь олно. Би үүнд хатуу итгэлтэй байна. Миний хэрхэн зүтгэж байсныг тэд мэдэж байгаа. Та ч намайг ямар хүн болохыг мэдэж байгаа шүү дээ. Би чинь ямар ч гэсэн муу хүн биш. Би чинь ухаантай биш ч зүтгэлтэй хүн шүү. Би Намынхаа төлөө бүх хүч чаддаа дайчилсан, тийм биз дээ? Надад таван жил л



өгөх байх, тийм үү? Арван жил ч өгвөл өгөг, тийм ээ? Над шиг хүн лагерьт ч хэрэг болох байх аа. Нэг удаа алдаа гаргалаа гэж тэд намайг буудахгүй биз дээ?”

“Та өөрөө буруутай юу?” гэж Смит асуулаа.

“Би мэдээж буруутай!” гэж Парсонс теледэлгэц рүү зусарч зангаараа хашгирлаа. “Нам гэмгүй хүнийг баривчлахгүй, тийм биз дээ?” Түүний мэлхий шиг царай нь тайвширч хуурмаг зан нь цухалзлаа. “Сэтгэхүйнгэм бол бузар булай зүйл шүү, найз минь” гэж тэрээр сургамжлан хэллээ. “Энэ бол хортой зүйл. Мэдээгүй байхад чинь л чамд халдана. Энэ яаж надад халдсаныг та мэдэх үү? Нойрон дунд шүү. Би үнэнээ хэлж байна. Би хаа хаагүй ажиллаж, өөрийнхөө хувь нэмрийг оруулж байлаа. Тэхдээ ийм бузар булай бодол толгойд төрнө гэж төсөөлж ч явсангүй. Би тэгээд зүүдэндээ ярьчихдаг болсон байна. Тэд нар зүүдэндээ миний юу ярихыг сонссон гэж бодож байна?”

Тэрээр хүнд өвчнөөсөө болж бузар муухай үг хэлж байгаа хүн шиг дуугаа намсгаад.

“Их Ах сөнөтүгэй! Тиймээ, би яг ингэж хэлсэн байна! Олон дахин ингэж хэлсэн шиг байгаа юм. Эндээ гэж хэлэхэд намайг баривчилсанд би баяртай байна. Намайг шүүхэд аваачихад би юу гэж хэлэхийг мэдэх үү? «Та бүхэнд баярлалаа. Намайг цаг алдалгүй аварсанд баярлалаа» гэж хэлнэ”

“Хэн таныг барьж өгсөн юм бэ?” гэж Смит асуулаа.

“Жаахан охин минь” гэж Парсонс гашуудангуй бардамнан хариуллаа. “Охин минь цоожны нүхээр чагнадаг байсан юм. Миний ярихыг сонсоод маргааш нь гэхэд эргүүлийн цагдаад мэдэгдчихсэн байгаа юм даа. Долоохон настай гэхэд сэргэлэн байгаа биз. Надад түүнд гомдох юм байхгүй. Би үнэндээ охиноороо бахдаж байна. Энэ чинь ямар ч гэсэн би түүнийг зөв хүмүүжүүлснийг л харуулж байгаа хэрэг юм”

Тэрээр хэдэн удаа суулт хийснээ шээсний хувин руу тэсч ядан харж байгаад өмдөө доош нь мултлав.

“Өршөөгөөрэй, хөгшин минь. Тэсэхгүй нь. Сэтгэл хөдлөхөөр ингэдэг юм”

Тэрээр шээсний хувингийн ам руу эрхтэнээ шургуулахад Смит алгаараа нүүрээ таглав.

“Смит!-жар-далан ес, Смит ээ! Нүүрээ гарга. Өрөөнд нүүрээ бүү хаа!” гэж теледэлгэцнээс бархирлаа.

Смит гараа буулгав. Парсонс хувинд шурчигнуулан ихээр шээж авлаа. Хувингийн таглааг дутуу тагласан тул шээсний муухай үнэр өрөөнд удаан үнэртлээ.

Парсонсыг аваад явсан ба бусад хоригдлууд ч үзэгдээд л алга болж байлаа. Смит нэгэн эмэгтэй «101 дүгээр өрөө» гэсэн үгийг дуулмагц биеэ хавчаад царай нь цайж байхыг харлаа. Смитийг

энд өглөөгүүр авчирсан бол одоо орой болж байх учиртай. Өдрөөр авчирсан бол одоо шөнө дунд болж байх учиртай. Өрөөнд эрэгтэй, эмэгтэй зургаан хоригдол улдэв. Бүгд чимээгүй сууцгаана. Смитийн өөдөөс харан нэгэн гэмгүй мэрэгч шиг эрүүгүй том шүдтэй эр сууж байна. Мань эрийн цулцгар цоохор хацар нь төмбийж байхыг харахад ямар нэг идэх юм аманд нь байна гэсэн сэтгэгдэл аргагүйн эрхэнд төрүүлнэ. Түүний айж эмээсэн гэгээвтэр саарал нүд нь хүн бүрийн нүүр дээр ээлжлэн тусч харц тулгарахад өөр тийшээ харж байлаа.

Хаалга онгойгоод шинэ хоригдлыг оруулж ирэхэд Смит түүнийг хараад бие нь зарсхийв. Тэрээр жирийн нэгэн инженер юм уу, техник аж. Түүний ядрангуй нүүр нь гайхмаар аж. Хохимой толгой л гэсэн үг. Нүүр нь тураад ам, нүд нь их том юм шиг харагдаад харц нь хэн нэгнийг юм уу, ямар нэгэн юмыг тэчъяадан үзэн ядаж, жигшсэнийг харуулна.

Шинэ хоригдол Смитийн хажууханд суулаа. Смит түүн рүү дахиад хараагүй ч гэсэн түүний хохимой толгой шиг нүүр нүдэнд нь харагдсаар байна. Смит одоо л ухаарлаа. Мань эр өлссөндөө амьсгаагаа хураах гэж буй аж. Өрөөнд байгаа бүх хоригдолд ийм бодол төрөх шиг боллоо. Хүмүүс сандал дээрээ жаахан хөдөлцгөөв. Эрүүгүй нөгөөх эр хохимой толгойн нүүртэй эр рүү нэг эгцдэн харж буруу юм хийчихсэн юм шиг нэг өөр тийшээ харснаа дахиад л түүн рүү харц нь аргагүй татагдаж байна. Тэрээр суудалдаа хавчигнаснаа босоод өрөөний нөгөө талд буй сандал РУУ ШУУД явж очоод баадайныхаа халааснаас талхны хир болсон зүсэм гаргаад хохимой толгойнх шиг нүүртэй хүнд өглөө.

Теледэлгэцнээс чих дүлийрэм чанга дуу гарахад хохимой толгойнх шиг нүүртэй хүний бүх бие дагжин чичирч байна. Хохимой толгойнх шиг нүүртэй эр гараа угз татаж ардаа хийгээд юу ч аваагүй гэдгээ хүн бүхэнд харууллаа.

“Бамстед! Хорин долоо арван гурав, Бамстед! Талхаа хая!” гэж теледэлгэцнээс бархирлаа.

Эрүүгүй эр тушаалыг дагаж талхаа газар хаяхад хацар нь татвалзаж байна. Өрөөний хаалганы хяхтнасан дуу гарч залуу офицер орж ирээд хажуу тийшээ болж зогсоход араас нь өргөн цээжтэй том гартай хуяг орж ирлээ. Тэрээр хоригдлын өөдөөс харж зогссоноо офицерыг дохио өгмөгц хамаг байдаг чадлаараа хоригдлын эрүү ам руу цохиход хоригдол цаас шиг хийсч эсрэг талын хананы наана хувингийн хажууханд ойчлоо. Тэр муужран унаж хамар амнаас нь хар нөжөн цус садарч, ухаан нь балайртан амандаа үглэж байгаа ч юм шиг, гиншиж байгаа ч юм шиг дуугарч байна. Тэгээд доошоо хараад дөрвөн хөллөн өндийхөд нь амнаас нь шүлс цустай хамт хиймэл шүдний хоёр эмтэрхий уналаа.

Хоригдлууд гараа өвдгөн дээрээ тавиад хөдлөхгүй сууцгаана. Эрүүгүй эр суудал руугаа мөлхөн авирахад нэг хацар нь хөхөрчихсөн, ам

нь онгойгоод улаан хүрэгтэн хавдчихсан байна. Баадай руу нь цус тусалсаар байна. Өөрийнх нь доромжлолыг бусад нь хэр зэрэг жигшиж буйг мэдэх гэсэн юм шиг тэрээр хүн бүрийг гүйлгэн харна.

Хаалга онгойход офицер эрүүгүй эр рүү дохиж:

“101 дүгээр өрөө” гэж тэрээр хэллээ. Смитийн хажууд хүмүүс уулга алдах нь сонсогддоо. Нөгөөх эр өвдөглөн суучихсан гараа алгаараа нийлүүлэн барьчихсан байна.

“Нөхөр офицер оо! Намайг та нар яавал ч яа! Та нар надад олон хоног хоол өгөхгүй өлсгөлөө. Би үхвэл ч үхье, энэ бүхнээ дуусгаачээ. Намайг буудаад өгөөч. Дүүжлээд өгөөч. Хорин таван жилийн ял оноогооч. Би өөр хэнийг барьж өгөх ёстой юм бэ? Та нар хэлээд л аль хэрэгтэй хүний чинь би нэрлээтэхье. Тэр нь хэн болох, түүнийг та нар яах нь надад падгүй хэрэг. Би гэр бүлтэй, гурван хүүхэдтэй. Том нь зургаан нас ч хүрээгүй байна. Тэднийг бүгдийг нь баривчлаад миний

нүдэн дээр хоолойг нь огтлооч. Би харж байя. Намайг зуун нэгдүгээр өрөөнд л бүү аваачаач ээ!”

Тэрээр өөрийнхөө оронд золиосолчих хүн эрсэн юм шиг бусад хоригдлыг тойруулан санд мэнд нэг харлаа. Түүний харц эрүүгүй эрийн хөх няц болсон нүүрэн дээр тогтоод туранхай гараа дээш өргөн түүнийг заалаа.

"Та нар намайг биш түүнийг авч явах ёстой! Түүний нүүрий нь бяц цохиход юу гэж хэлснийг нь та нар дуулсангүй. Би бүгдий нь давтаж хэлье, болох уу? Энэ эр Намын эсрэг хүн, би биш ээ" Хуягууд урагшаа алхаад түүнд ойртлоо. Тэрээр одоо чарлаж гарлаа. "Та нар түүний юу хэлснийг дуулсангүй! Теледэлгэц ажилласангүй. Та нарт хэрэгтэй хүн чинь өмнө чинь байна. Намайг биш түүнийг аваад яваач!"

Биерхүү хоёр хуяг түүнийг өргөх гэж бөхийхөд тэрээр шалан дээр тэрийж унаад сандлын төмөр хөлнөөс хоёр гараараа зуурч аваад орь дуу тавин



адгуус адил гиншиж байна. Хуягууд түүний биеийг нь тэвэрч өргөх гэсэн боловч тэрээр сандлын хөлнөөс гайхмаар хүчтэй зуурч байна. Хуягууд түүний гарыг салгах гэж хэдэн хором оролдлоо. Хоригдлууд өвдөг дээрээ гараа тавин хөдлөхгүй сууж нүдэн дээрээ болж буй юмыг харж сууна. Нөгөөх эр гиншихээ болилоо. Түүнд сандлын хөлнөөс зууралдах л хүч үлджээ. Тэгээд гэнэт ёолох дуу чанга гарлаа. Хуяг түүний гарыг хуга өшиглөлөө. Хоёр хуяг түүнийг өргөж хөл дээр нь зосоолоо.

“Зуун нэгдүгээр өрөөнд аваач” гэж офицер тушаалаа.

Хоригдлыг чирч гаргалаа. Тэрээр ямар ч эсэргүүцэл үзүүлсэнгүй, толгойгоо гудайлган бэртсэн гараа элгэндээ тэврээд хамаг хүч тамираа барчихсан хөлөө чирж явна.

Олон цаг өнгөрчээ. Хохимой толгойн нүүртэй эрийг шөнөөр авч явсан бол одоо өглөө болж байх учиртай, өглөө авч явсан бол одоо орой

болж байх учиртай. Смит одоо ганцаараа, хэдэн цаг ганцаараа байна. Тэрээр нарийхан сандал дээр сууснаас болж бөгс нь тэсвэрлэшгүй өвдөхөөр нь босож өрөөн дотуур явна. Харин теледэлгэцнээс түүн рүү бархирахгүй байна. Эрүүгүй эрийн хаясан зүсэм талх тэр газраа л байна. Анхандаа талхыг харахгүй байх хэцүү байсан ч эцсийн бөлөгт амны цангаа нь өлсөхөөс ч хүчтэй болов. Ам нь хатаад эвгүй амт амтагдана. Жигдхэн тусах гэрэл, дүнгэнэх дуунаас толгой нь манарч дотор нь муухай болж байлаа. Тэрээр үе мөч нь тэсвэрлэшгүй их өвдөхлөөр босоход толгой нь эргэж ойчиж магадгүй гэж айхдаа тэр дороо суусаар байлаа. Биеийн зовиурыг түр мартмагц айдас хүргэсэн бодол төрнө. Тэрээр зарим үед сахлын тонгорог, Обрайены тухай итгэл муухан бодно. Хэрвээ ер нь сахлын тонгорог дамжуулах л юм бол идэх юманд нууж ирүүлэх байх гэж найдна. Жулияг бүдэг бадагхан санаж байлаа.

Жулия ямар ч гэсэн зовж шаналж байж магадгүй, надаас ч илүү зовж шаналж байгаа

байх. Яг энэхэн хоромд өвдсөнөөсөө орилж чарлаж ч байж мэдэх юм.

Смит «Би хэрвээ илүү зовж шаналаад үүгээрээ Жулияг аварч чадах байсан бол үүнийг хийх болов уу? Тэгэлгүй яахав, тэгэх л байсан» гэж бодно. Тэрээр ийм шийдвэр гаргах ёстой гэж үзсэн учраас л энэ нь цэвэр оюун санааных байсан юм. Тэрээр үүнийг мэдэрч чадсангүй. Энд чи өвчин зовиур ирнэ гэсэн зөнгөөс өөр юм мэдэрдэггүй юм. Үүний зэрэгцээ чи биеэрээ шаналан зовоходоо зовлон шаналлаа ихсээсэй гэж бодно гэдэг бол боломжгүй хэрэг биз дээ? Харин энэ асуултад одоохондоо хариулт өгөх арга байхгүй.

Хөлийн чимээ ойртсоор хаалга онгойж Обрайен орж ирлээ.

Смит болгоомжтой байх ёстойгоо мартаад бослоо. Тэрээр энэ олон жилд анх удаагаа теледэлгэц бий гэдгийг мартчихжээ.

"Та чинь эдний талынх юм уу!" гэж тэрээр хашгирлаа.

"Би аль хэдийнээ эдний талд орсон" гэж Обрайен яльгүй харуусан жоготойхон хэллээ.

"Смит, чи үүнийг мэдэж байсан шүү дээ. Өөрийгөө бүү хуур. Чи үүнийг мэдэж байсан.. ерөөсөө мэдэж байсан"

Тийм ээ, тэрээр одоо л ойлголоо. Ерөөсөө мэдэж байсан юм. Харин одоо энэ тухай бодох зав алга. Одоо ганц юмыг л, харгалзагчийн гарт байгаа бороохойг л харж байна. Тэр бороохойгоор толгойн орой руу, чих рүү, мөрөн дээр, тохой руу гэх мэтээр хаана ч цохиж болно.

Тохой руу! Смит өвдсөнөөсөө мэдрэл алдан тохойгоо гараараа барьж өвдөг дээрээ уналаа. Нүдэнд нь бүх юм эрээлжиллээ. Ганц цохилт ийм их өвтгөнө гэдэг нь ухаарахад бэрх, ухаарахад бэрх юм! Нүд нь эрээлжлэхээ зогсоход дээш харвал хоёр хүн дээрээс нь харж

байна. Хуяг түүний өвдсөнөөсөө ярвалзан мурилзаж буйг хараад инээж байна. Юутай ч гэсэн нэг юм тодорхой боллоо. Өвчин шаналгааг ихсээсэй гэж яагаад ч, юу ч болсон хүсч болохгүй. Өвчин шаналгаанаас ганцхан л юм хүснэ, зогсоосой л гэж хүснэ. Бие махбодийн өвчин шаналлаас адгийн юм гэж байхгүй. Тэрээр өвчтэй тохойгоо барин шал дээр тэлчигнэж байхдаа өвчин шаналал ирэхэд эрэлхэг зоригтонгууд байхгүй, эрэлхэг зоригтонгууд байхгүй гэж өөртөө давтан давтан хэлж байлаа.

## II

Тэрээр далайн хөлгийн дүүжин ор шиг бөгөөд хөдөлбөл уначих гээд байдаг ер бусын өндөр орон дээр хэвтэж байна. Нүүр рүү нь ерийнхөөс арай хүчтэй гэрэл тусч байна. Обрайен хажууд нь зогсчихсон түүн рүү нүд цавчилгүй харж байна. Нөгөө талд нь цагаан халаадтай гартаа тариурын зүү барьсан хүн зогсч байна.

Смит нүдээ нээсэн боловч хаана байгаагаа сайн ойлгосонгүй. Энэ өрөөнд огт өөр ертөнцөөс хөвөн орж ирсэн, тээр доор байгаа далайн гүний ертөнцөөс ирсэн мэт сэтгэгдэл нь хэвээр байна. Тэрээр энд хэр удаж байгаагаа мэдэхгүй. Түүний хувьд баригдсанаас нь хөйш өдрийн гэрэл гэгээ, шөнийн харанхуй гэж байхгүй болсон. Үүний зэрэгцээ түүний дурсамж бодол тасалдаж байлаа. Зүүдэнд гардаг шиг ухаан санаа нь бүрмөсөн алга болоод дараа нь дахиад л хоосон завсарлагын дараа гарч ирнэ. Энэ завсарлага өдрөөр, хэдэн

долоо хоногоор, хэдхэн хормоор уу гэдгийг ойлгох боломж байхгүй байна.

Тохой руу нь анх хүчтэй цохисноос тарчлал эхэлсэн юм. Түүнд тохиолдсон энэ бүхэн бол бүх хоригдлуудад тулгардаг жирийн байцаалт, бэлтгэл байсныг сүүлдээ ойлгосон юм. Хүн бүр гэмт хэргийн урт жагсаалтад орсон хэргүүд, тагнуул туршуул хийсэн хэрэг, хорлон сүйтгэх ажиллагаа гэх мэт гэмт хэрэг үйлдсэнээ хүлээх ёстой болдог юм. Хэргээ хүлээх нь ёс төдий хэрэг бөгөөд эрүү шүүлтийг хийсэн шиг хийдэг юм. Түүнийг хэдэн удаа, хичнээн удаан зодож нүдсэнийг санахгүй байна. Дүрэмт хар хувцастай тав зургаан хүн түүнийг тарчлааж байлаа. Тэд заримдаа зангидсан гараараа, заримдаа бороохойгоор, заримдаа төмөр утсаар, заримдаа гуталтай хөлөөрөө өшиглөж зодно. Зарим үед тэрээр адгуус лугаа адил шалан дээгүүр ичгүүргүй мөлхөн тахилзаж мушгиралдаж аргаа баран цохилтоос зайлах гэж байгаад хавирга, гэдэс, шагай, цавь, төмсөг, нуруу руугаа улам хүчтэй цохиулна.

Энэ тарчлаан зогсоо зайгүй үргэлжлээд байхад хамгийн хатуу, аюумшигтай, уучилж үл болох юм нь тэрээр ухаан алдахгүй байгаад орших юм шиг түүнд санагдах үе ч байлаа. Эр зориг нь халихаар тэрээр зодож эхлэхээс нь бүр өмнө өршөөл гуйж, зангидсан гараа өргөхөд нь жинхэнэ үйлдсэн болон зохиомол бүх хэргээ хүлээх үе ч байсан. Тэрээр ямар ч хэрэг хүлээхгүй гэж дотроо зориглох үе ч байсан бөгөөд энэ үед өвдсөнөөсөө болж ёолох бүрд нь амнаас нь үгийг нь гаргуулж байлаа, тэрээр өөртэйгөө «Би бүгдий нь хүлээнэ, гэхдээ шууд хүлээхгүй. Тарчлаан тэсч байхын аргагүй болтол тэснэ. Дахиад гурав, дахиад хоёр цохихоор нь бүх хэрэгтэй юмыг нь хэлье» гэж өөртөө ая тал засна. Заримдаа зодуулж нүдүүлсний дараа арайхийж хөл дээрээ тогтоно, түүнийг шуудайтай элс шиг шал дээр хаячихна, хэдэн цаг сэхээ ортол нь байлгаад дахиад л зодохоор авч явна. Зарим үед энэ завсарлага арай удаан үргэлжилж энэ үеийг унтаад юм уу, ухаангүй өнгөрөөсөн болохоор муухан санана, хананаас сугалж гаргадаг хавтгай модон ортой,



төмөр угаагууртай өрөө болон халуун шөл, талх зарим үед өгдөг кофег санаж байна. Тэрээр уйтгартай царайтай үсчин сахлыг нь хусаж үсийг нь засаж байсныг, ажилсаг байртай жишим ч үгүй цагаан халаадтай хүмүүс ирээд судсыг нь барьж үзээд, мэдрэлийг нь шалгаад, нүднийх нь зовхийг нээж хараад, ширүүн гараараа яс нь хугарсан эсэхийг тэмтрээд гарын булчинд нь унтуулах тариа хийж байсныг санаж байна.

Зодох нь багасаад зодно гэж сүрдүүлэх нь ихэслээ. Хэрвээ муу хариулах юм бол тарчлааныг дор нь эхлүүлнэ. Одоо түүнийг дүрэмт хар хувцастай дүрсгүй бандь нар бус хурдан хөдөлгөөнтэй, нүдний шилээ гялалзуулсан жижигхэн биетэй намын гишүүн мөрдөгчид байцаадаг болсон аж. Тэд бие биеэ солин түүнийг байцаах бөгөөд тэр нь арван хоёр цаг ч үргэлжилнэ. Түүнд ийм удаан байцаах шиг санагдах бөгөөд чухам хэдэн цаг үргэлжилдгийг үл мэднэ. Эдгээр шинэ мөрдөгчид Смитийг үргэлж тарчлаахыг хичээж байсан, харин энэ нь

тэдний гол арга байгаагүй юм. Тэд нар түүний хацрыг нь алгадана, чихийг нь мушгина, нэг хөл дээр нь зогсооно, нулимсыг нь асгартал гэрэл өөд харуулж зогсооно, шээлгэхгүй удаан барина. Тэд нар энэ бүхнийг түүнийг доромжлох гэж, маргах, юм бодох чадварыг нь алдагдуулах гэж ингэж тарчлаана.

Тэдний жинхэнэ зэвсэг нь олон цагаар хайр найргүй байцаах явдал байлаа. Тэд түүний боддыг нь самгардуулна, хуурамч асуулт тавина, хэлсэн бүхнийг нь гуйвуулж мушгина, түүнийг ичсэндээ ч юм уу, сульдаж ядарснаасаа уйлтал нь худлаа ярьж байна, өөрөө өөртэйгөө зөрчилдөж байна гэж алхам бүрт гүжирдэнэ. Тэрээр нэг байцаалтын үеэр тав зургаан удаа уйлах ч хэрэг гарна. Тэд гол төлөв түүнийг жаахан түгдрэх бүрт харааж зүхэн хуяг нарт дахиад өгнө гэж сүрдүүлнэ. Тэд заримдаа өнгө аясаа өөрчлөөд түүнийг нөхөр гэж дуудан Ангсоц болон Их Ахын нэрийн өмнөөс одоо түүнд Намдаа үнэнч сэтгэл төрж, гаргасан хор хөнөөлөө засах хүсэл төрөхгүй байна уу гэж

харамсан асууна. Тэрээр олон цагийн байцаалтад бухимдсанаасаа болж ийм хүсэлт гаргахад нь тэсч чадалгүй уйлчихдаг байлаа. Эцсийн бөлөгт эдгээр яншаа яриа харгалзагчдын зангидсан гараар зодох, хөлөөр өшиглөхөөс ч илүү түүний эр зоригийг мохоолоо. Тэрээр шаардсан юм болгоныг нь хэлэх ам, хүлээн зөвшөөрч гарын үсэг зурах гар хоёр л болж хувирлаа. Түүний санааг зовоож байгаа цорын ганц юм нь тэдний юу шаардаж буйг мэдэж аваад дахиад доромжилж эхлэхээс нь өмнө хурдхан гэмээ хүлээх явдал юм. Тэрээр Намын нэр төртэй гишүүдийн амь насыг бүрэлгэсэн, өдөөн хатгасан товхимол тараасан, олон нийтийн хөрөнгийг идэж шамшигдуулсан, цэргийн нууцыг задруулсан, хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан зэрэг гэмт хэрэг үйлдсэнээ хүлээсэн юм. Бүүр 1968 онд Дорнодазийн хөлсний туршуул болсноо хүлээсэн аж. Мөн шүтлэгтэй, капитализмыг шүтэгч, тэгээд ч зогсохгүй завхай зайдан гэдгээ хүлээсэн юм. Тэрээр авгай нь одоо ч эсэн мэнд бөгөөд мөрдөгчид үүнийг лав мэдэж байгаа ч гэсэн

түүний амийг хороосон гэмт хэргээ хүлээн зөвшөөрсөн юм. Голдштейнтэй олон жил хувийн харилцаатай явж ирсэн, өөрийн бүх танил нь гишүүн болох нууц байгууллагын гишүүн гэдгээ ч хүлээжээ. Бүх хэргээ хүлээгээд бүх юманд хүнийг холбогдуулах шиг амархан юм байхгүй. Үүний зэрэгцээ энэ нь нэг талаар үнэн юм. Тэрээр Намын дайсан гэдэг нь үнэн бөгөөд Намын нүдээр харахад сэтгэхүй ба үйл ажиллагааны хооронд ялгаа байхгүй.

Өөр нэг дурсамж ч үлдсэн билээ. Хоорондоо холбоогүй хар юмаар хүрээлэгдсэн зураг байна.

Гэгээтэй ч юм уу, харанхуй ч юм уу бүү мэд хоёр нүднээс өөр юу ч үгүй нэг өрөөнд байна. Хажууд аажмаар нэг хэмээр нэг багаж дуугарч байна. Хоёр нүд улам том болоод тодорч байтал тэрээр гэнэт нисч нүд рүү ойртоход нүд түүнийг залгичихлаа.

Түүнийг түшлэгтэй сандалд хүлчихсэн байх ба түүний дээрээс нүд гялбам хурц гэрэл тусаж

хуваарьтай багаж хэрэгсэл эргэн тойронд нь ажиллаж байна. Цагаан халаадтай хүн хуваарийг ажиглаж байна. Гаднаас хүнд гуталтай хүний хөлийн чимээ гарч хаалга хяхтнан онгойгоод хоёр харгалзагч дагуулан лаван царайтай офицер орж ирээд:

“Зуун нэгдүгээр өрөөнд оруул” гэж хэллээ.

Цагаан халаадтай хүн эргэж харалгүй Смит рүү биш багажны хуваарь руу харж байлаа.

Тэрээр гайхамшигтай сайхан гэрэл гэгээтэй нэг километр өргөн хонгилоор тэнгэрт тултал хэргээ хүлээн орилон өнхөрч байна, бүх хэргээ, тэрч байтугай эрүү шүүлтийн үед ч нууж байсан хэргээ хүлээж байна, тэртэй тэргүй олны мэдэх бүхий л амьдралаа олон түмэнд ярьж байна. Түүнтэй хамт хуягууд, мөрдөгчид, цагаан халаадтай хүн, Обрайен, Жулия, Ноён Чаррингтон байх бөгөөд тэд мөн өнхөрөн чанга инээж байна. Ирээдүйд ирэх нэгэн аюумшигтай юмнаас зайлж чаддаа, тэр нь тохиолдсонгүй.

Бүх юм сайхан байна, бие нь өвдөхөө зогслоо, амьдралынхаа сүүлчийн нарийн ширийн юмыг ч дэлгэчихлээ, бүгдийг нь ойлгосон, өршөөсөн...

Тэрээр цочоод хавтгай модон орон дээрээ Обрайен өөрийнх нь дуу хоолойг дуулсан гэдэгт итгэн өндийлөө. Обрайен байцаалт дээр ерөөсөө байгаагүй боловч тэрээр харагдахгүй байна, ард зогсож байна гэж мэдэрч байлаа. Обрайен энэ бүхнийг удирдаж байгаа. Мань хүн харгалзагчдыг Смит руу явуулаад тэдэнд түүний амь насыг нь хороохыг зөвшөөрөхгүй байгаа. Обрайен хэдийд түүнийг тарчлаан орилуулах, хэдийд түүнд түр зуур амсхийх чөлөө олгох, хэдийд түүнийг унтуулах, гарт нь хар тамхи тарихыг шийдэж байгаа. Тэрээр асуулт тавиад хариултыг нь санал болгож байлаа. Тэр бол тарчлаан тамлагч, тэр бол өмгөөлөн хамгаалагч, тэр бол шажны шүүгч, тэр бол анд нөхөр мөн. Смитэд нэг удаа хар тамхины зүүд дунд уу, сэрүүн сэргэг байхад бил үү гэдгээ санахгүй байна, чихэнд нь «Санаа бүү

зов. Би чамайг нөмөр нөөлөгтөө авсан. Чамайг би долоон жил араас чинь мөрдсөн.

Эргэлт гаргах цаг боллоо. Би чамайг аварна, би чамайг төгс төгөлдөр болгоно.» гэж шивнэлээ. Тэрээр энэ дуу хоолой бол долоон жилийн өмнө зүүдэндээ сонссон «Бид гэрэл гэгээтэй газар уулзана» гэсэнтэй адил Обрайеных гэдэгт итгэлтэй байна.

Энэ нь байцаалтын төгсгөлд бил үү гэдгийг тэрээр санахгүй байна. Харанхуйлаад ирснээ өөрийнх нь хэвтэж буй өрөө ч юм уу, шоронгийн өрөө ч юм уу аажмаар харагдлаа. Түүний биеийг хэд хэдэн газар бэхлээд уячихсан, доошоо харж, хөдөлж чадахгүй хэвтэнэ. Дагзыг нь хүртэл даруулаад боочихсон байна. Обрайен түүн рүү эгндэн хараад зогсож байна, түүнд харамссан шинж алга. Обрайены хавагнасан нүд, хамар, уруул нь үрчлээтсэн нь доороос нь харахад муухай, ядарсан харагдана. Тэрээр Смитийн санаж байгаагаас хөгшин харагдана. Дөчин найм ч юм уу тавь хүрч байгаа байх гэмээр.

Түүний гар дор, дээрээ бариултай нүүрэн дээрээ тоотой дугуй хуваарь байна.

“Би чамд бид уулзах л бол энд уулзана гэж хэлсэн шүү дээ” гэж тэрээр Смитэд хэллээ.

"Тийм ээ" гэж Смит хариуллаа.

Обрайены гарын яльгүй хөдлөхийг үл тооцох юм бол гэв гэнэт Смитийн бүх бие янгинаж эхэллээ. Бие нь аймшигтай ихээр янгинаж байна. Тэрээр юу болж буйг мэдээгүй болохоор энэ нь аймшигтай шаналал байв, тэхдээ бие нь маш ихээр бэртэх шиг боллоо. Тэрээр бие нь үнэхээр бэртэж байна уу аль эсвэл цахилгаан гүйдлээс болж өвдөж байна уу гэдгээ мэдэхгүй байна. Харин биеийг нь тал тал тийш нь хүчтэй татаад хөл гарыг нь аажмаар зулгааж байна. Өвдсөнөөсөө духанд нь хөлс чийхарч байсан ч нурууны яс л хугарчихвий гэж хамгийн их айж байлаа. Смит шүдээ тас зууж аль болохоор дуу гаргахгүй байх гэж хичээн хамраараа амьсгалж байв



“Чи одоо үе мөчөө хугарахаас айж байна. Нуруугаа хугарахаас их айж байна. Нуруу чинь үеэрээ хугараад нугас нь гоожиж байгаа нь нүдэнд чинь харагдаж байгаа. Смит ээ, чи чухам үүнийг л бодож байгаа биз дээ?” гэж Обрайен түүн рүү харж хэллээ.

Смит хариу дуугарсангүй. Обрайен бариулыг буцааж эргүүлэхэд өвдөх нь анх эхэлсэн шигээ тэр дороо намдлаа.

“Зүү дөч дээр байсан юм. Зүүний хуваарь зуу хүртэл байгааг харж байгаа биз. Чамтай ярилцаж байхдаа би чамайг яаж ч, хэдийд ч өвтгөж чадна гэж хэлж байсныг санаж байна уу? Худдаа ярих, хариултаа булзааруулах, аль эсвэл оюун ухааныхаа жирийн чадавхиас доогуур загнах юм бол чи аяндаа орилох болно. Чи үүнийг ойлгож байна уу?” гэж Обрайен асуулаа.

“За” гэж Смит хэллээ.

Обраиен ширүүн загнахаа бага зэрэг намдаад боддогширч нүднийхээ шилийг засаад өрөөн дотуур алхлаа. Тэрээр шийтгэх гэхгүй харин итгүүлж үнэмшүүлэх болон тайлбарлаж өгөх гэж буй эмч шиг, магадгүй лам хүн шиг болжээ.

“Би чамтай зууралдаж хайран цагаа барж байна. Чамтай ингэж зууралдах ч хэрэг байна. Чи өөртөө юу болоод байгааг сайн мэдэж байгаа. Чи энэ тухай бодохгүй байхыг хичээж байсан, гэхдээ чи үүнийг олон жил мэдэж байгаа. Чи бол оюун ухааны гажигтай хүн. Чиний ой той муудсан байна. Чамд жинхэнэ болж өнгөрсөн үйл явдыг эргэн санах чадвар байхгүй, чи байгаагүй юмыг санаж байна гэж итгэдэг. Аз болоход үүнийг эдгээж болно. Чамд өөрийгөө эдгээх хүсэл байгаагүй, тэгээд ч эдгээгүй. Үүнд багахан хүсэл зориг гаргахад л хангалттай, тэхдээ чи ингээгүй. Одоо л гэхэд чи алдар гавьяа юм шиг энэ өвчнөөсөө зууралдаад байгааг би харж байна. Би одоо нэг жишээ татаадахья. Далайн Гүрэн яг одоо ямар гүрэнтэй дайтаж байна вэ?”

“Намайг баривчлагдаж байх үед Далайн гүрэн Дорнодазийн Гүрэнтэй дайтаж байсан”

“Дорнодазийн Гүрэнтэй. Зөв. Тэгээд Далайн Гүрэн дандаа Дорнодазийн Гүрэнтэй дайтаж байсан, тийм үү?”

Смит амьсгаагаа авч амаа ангайсан ч үг хэлсэнгүй. Түүний харц багажны зүүний хуваарь дээр туслаа.

“Смит ээ, үнэнийг хэлээд өгнө үү. Үнэн гэж байгаа юм аа. Өөрийнхөө санаж байгаа гэж бодсон юмаа л хэлээтэх, за юу?” “Би намайг баривчлагдахаас долоо хоногийн өмнө гэхэд л бид Дорнодазийн Гүрэнтэй дайтаагүй байсныг санаж байна. Манай орон түүнтэй холбоотон байсан. Евразийн Гүрэнтэй дайтаж байсан. Энэ дайн дөрвөн жил үргэлжилсэн. Үүнээс өмнө..” Обрайен гараа дохин түүний яриаг нь тасаллаа.

“Бас нэг жишээ татъя. Хэдэн жилийн өмнө чи маш их төөрөгдөлд орсон байсан. Хэзээ нэгэн

цагт Намын гишүүн байсан бөгөөд хамаг хэргээ хүлээснийхээ дараа урван тэрсэлж, хорлон сүйтгэх ажиллагаа явуулсны улмаас цаазаар авахуулсан Жоунз, Аронсон, Резерфорд гэдэг хүмүүсийг гэмт хэрэг үйлдээгүй гэж чи үзэж байсан. Тэдний хэргээ хүлээсэн гэдэг нь зохиомол зүйл болохыг эргэлзээгүй нотлох баримт бичгийг олж харлаа гэж чи итгэж байсан. Энэ баримт бичгийг гартаа барьж байна гэж чи үнэмшиж байсан. Энэ нь фото зураг байсан байх” гэж тэрээр хэллээ.

Смит, Обрайен гартаа сонины хайчилбар барьсныг хэдэн хором харлаа. Энэ нь фото зураг байсан бөгөөд ямар фото зураг гэдгийг тааж ядах юмгүй аж. Энэ нь Смитийн арван нэгэн жилийн өмнө тохиолдлоор олж үзээд тэр дор нь устгасан нөгөөх Жоунз, Аронсон, Резерфорд нарын Нью-Йорк хотноо намын баяр ёслолд оролцож буй зураг аж. Энэ зураг Смитийн нүдэнд харагдаад алга боллоо. Тэрээр зургийг харсан, эргэлзээгүй харсан! Смит аль байдгаараа өндийх гэж оролдсон боловч

өчүүхэн ч өндийж чадсангүй, хөдөлж ч чадсангүй. Энэхэн хоромд багажны хуваарийг ч мартчихсан байна. Тэрээр одоо зургийг гартаа ганц хором ч барьж сайн харах юмсан л гэж бодож байна.

“Ийм зураг бий!” гэж тэрээр хашгирлаа.

“Байхгүй” гэж Обрайен хэллээ.

Обрайен эргээд хананд байгаа ой тойны нүх рүү очоод хаалтыг нь дээшлүүллээ. Цаасны нүдэнд харагдах төдий жижигхэн тасархайнуудыг хүчтэй агаар үлээж улалзсан гал руу оруулж байна. Обрайен эргээд Смит рүү харлаа.

“Энэ бол үнс. Үнсэнд юу ч харагдахгүй. Тоос. Фото зураг байхгүй. Хэзээ ч байгаагүй юм” гэж тэрээр хэллээ.

“Тэр зураг байсан! Байгаа шүү! Тэр зураг ой тойнд байгаа. Би санаж байна. Та бол санахгүй”

“Би зургийг санахгүй байна” гэж Обрайен хэллээ.

Смитийн зүрх шимширлээ. Энэ чинь *хоёрсэтгэхүй* байна. Тэрээр яаж ч чадахгүй гэдгээ ойлголоо. Обрайен худлаа хэлж байна гэдэгт үнэмшсэн бол энэ нь ач холбогдолгүй зүйл юм. Обрайен фото зургийг үнэхээр мартчихсан байж болох юм. Үнэхээр ийм юм бол тэрээр фото зураг байсан гэдгийг санаж байгаагаа үгүйсгэснээ мартчихсан, мартсан гэдгээ ч мартчихсан байна. Энэ бол зүгээр л бач мэх гэдэгт хэн итгэх юм бэ? Оюун ухаанд ийм солиотой төөрөгдөл гарч байгаа юм уу?- Смит ингэж бодоод цөхөрч байлаа.

Обрайен түүн рүү бодлогошрон харах бөгөөд тэрээр үг дуулдаггүй, мөртлөө сайн сурлагатай сурагчаа зодчихсон багш шиг харагдана.

“Өнгөрснийг жолоодох тухай Намын үзэл баримтлал бий. Түүнийг давтан хэлнэ үү” гэж тэрээр хэллээ.

«Өнгөрснийг жолоодож буй хүн ирээдүйг жолоодоно. Өнөөдрийг жолоодож буй хүн өнгөрснийг жолоодоно.» гэж Смит дуулгавартайхан хэллээ.

«Өнөөдрийг жолоодож буй хүн өнгөрснийг жолоодоно» гэж Обрайен дэмжингүй хэлж түүн рүү хуруугаараа заагаад “Смит, чи өнгөрсөн үе бодитойгоор оршино гэж бодож байна уу? гэв.

Смит дахиад л цөхрөнгөө барж багажны хуваарь руу нүднийхээ булангаар харлаа. Тэрээр «тийм», «үгүй» гэж хариулахын аль нь өвдөлтөөс ангижруулахыг бүр мэдэхээ больсон аж. Түүгээр ч зогсохгүй аль хариулт нь зөв бэ гэдгийг өөрөө ч мэдэхээ больсон байна.

Обрайен жаахан инээмсэглэлээ.

“Чи муу метафизикч байна. Чи одоо хүртэл «орших» гэдэг нь чухам юуг хэлээд байна вэ гэдгийг бодсонгүй. Би үүнийг чамаас арай тодорхой асууя. Өнгөрсөн үе орон зайд

тодорхой оршиж байна уу? Өнгөрсөн үе бодитойгоор үргэлжилсээр байгаа тийм биет зүйлсийн дэлхий, тийм нэг газар байна уу?”

“Үгүй”

"Тэхлээр тэр чинь оршж байгаа юм бол хаана оршиж байна

вэ?”

“Баримт бичигт байна. Тэмдэглэгдсэн байгаа”

“Баримт бичигт. Өөр?”

“Оюун ухаанд. Хүний ой дурсамжинд”

“Ой дурсамжинд. Их сайн байна. Манай Нам бүх баримт бичгийг хянаж, ой дурсамжийг удирдаж байгаа. Ингэхлээр бид өнгөрсөн үеийг ч удирдаж байна гэсэн үг, тийм үү?”



"Та нар хүнийг дурсан санахыг яаж зогсоож чадах юм бэ? Энэ чинь хүсэл зоригоос гадуур зүйл шүү дээ. Энэ бол өөрөөс огт хамаарахгүй зүйл. Та нар ой дурсамжийг яаж удирдаж чадах юм бэ? Минийхийг та нар удирдаж байна гэж үү?" гэж Смит нөгөөх багажны хуваарийг дахин мартаад ориллоо.

Обрайены царай барайгаад багажны бариул дээр гараа тавилаа.

"Харин ч тийм биш шүү. Чи л харин ой дурсамжаа хянаж чадахгүй байна. Тэгээд л чи энд байна шүү дээ. Чи өөрийгөө номхотгож чадахгүй, өөрийн сахилга батгүйгээсээ энд байгаа юм. Чи эрүүл ухааны үнэ болсон хүлцэнгүй байдлыг тэвчиж чадахгүй байна. Чи солиотой амьтан, гав ганц цөөнх байх нь дээр гэж үзэж байна. Смит ээ, сахилгатай оюун ухаан л бодит байдлыг харж чаддаг юм. Чи бодит байдал бол объектив, биднээс үл шалтгаалж, биднээс гадна оршино гэж бодож байна. Чи бас бодит байдлын мөн чанар илэрхий гэж үзэж

байна. Чи өөрөө ямар нэг юм харж байна гэж өөрийгөө хуурахдаа хүн бүр мөн л тэр юмыг харж байна гэж итгэж байна. Харин Смит ээ би чамд нэг юм хэлье, бодитой юм бол гаднын юм биш ээ. Бодитой юм хүний оюун ухаанд л оршино, өөр хаа ч байхгүй. Алдаж болох, өөрчлөгдөж болох нь хувь хүний оюун ухаанд биш Намын хамтын ялагдашгүй оюун ухаанд байдаг юм. Нам үнэн гэж үзсэн болгон үнэн. Намын нүдээр л биш бол үнэнийг олж харах боломж байхгүй. Смит ээ, энэ үнэнийг чи шинээр сурахаас өөр арга байхгүй. Үүний тулд чамд өөрийгөө устгах, хүсэл зориг гаргах хэрэг гарна. Чи эрүүл ухаантай болохын наана өөрийгөө номхотгох хэрэгтэй” гэж тэрээр хэллээ.

Тэгээд Смит хэлснийг нь тогтоож авахыг хүлээж байгаа юм шиг чимээгүй болов.

“Чи өдрийн тэмдэглэлдээ «Эрх чөлөө бол хоёр хоёрын дөрөв гэж хэлэх эрх чөлөөг хэлнэ» гэж бичсэнээ санаж байна уу?” гээд:

"Тийм ээ"

Обрайн зүүн гараа өргөөд эрхий хуруугаа нууж дөрвөн хуруугаа харууллаа.

"Би чамд хэдэн хуруу үзүүлж байна вэ, Смит ээ"

"Дөрөв"

"Нам үүнийг дөрөв биш тав гэвэл хэдэн хуруу байна вэ?" "Дөрөв"

Смит үгээ хэлж дуусаагүй байхдаа чанга ёолов. Багажны зүү тавь дугаар хуваарь дээр хүрэхэд Смитийн бүх биеэр нь хөлс чийхарч тэрээр дуу алдан ёолон ориллоо. Смит шүдээ тас зуусан ч гэсэн ёолсоор Обриен түүн рүү харсаар дөрвөн хуруугаа харуулсаар байна. Тэрээр багажны бариулыг буцааж эргүүлэхэд Смитийн бие өвдөх нь жаахан намжлаа.

"Смит ээ, Хэдэн хуруу байна вэ?"

“Дөрөв”

Багажны зүү жар гэсэн хуваарьт хүрлээ.

“Смит ээ, Хэдэн хуруу байна вэ?”

“Дөрөв! Дөрөв! Өөрөөр юу гэж хэлэх юм бэ? Дөрөв!” Багажны зүү дахиад л дээшээ гүйсэн бололтой ч Смит түүнийг харсангүй. Түүний нүдэнд барайсан царай, дөрвөн хуруу л харагдана. Дөрвөн хуруу нүдэнд нь аварга том багана шиг харагдана. Багананууд дайвалзаж байх боловч дөрөв л харагдана.

“Смитээ, Хэдэн хуруу байна вэ?”

“Дөрөв! Болиоч ээ! Болиоч ээ! Яаж байгаа юм бэ? Дөрөв! Дөрөв байна!”

“Хэдэн хуруу байна вэ?”

"Тав! Тав! Тав!"

“Үгүй, Ингэх хэрэггүй. Чи худлаа ярьж байна. Чи дөрөв гэж бодсоор л байна. За хэдэн хуруу байна вэ?”

“Дөрөв! Тав! Дөрөв! Танд хэд хэрэгтэй юм бэ? Намайг тарчлаахаа болиоч!”

Нэг мэдэхнээ Смит суучихсан байх бөгөөд Обрайен мөрөөр нь тэвэрчихсэн байна. Тэрээр хэдэн хором ухаан алдсан бололтой юм. Биеийнх нь хүлээсийг тайлжээ. Смитийн бүх биеэр хүйт оргиж чичирч шүд нь тачигнаад хацрыг нь даган нулимс нь асгарч байна. Тэрээр нялх хүүхэд шиг Обрайен руу наалдлаа. Түүний том гар биеийг нь илэн тайвшруулж байна. Одоо түүнд Обрайен түүний хамгаалагч, өвдөлт нь өөр хаа нэг газраас ирсэн, энэ өвдөлт өөр юмнаас болсон, Обрайен үүнээс хамгаалах юм шиг бодогдож байна.

“Чи юм сурахдаа удаан сурагч байна” гэж Обрайен аяархан дуугарлаа.

“Би яах ёстой юм бэ? Би нүднийхээ өмнө байгаа юмыг яаж харахгүй байж чадах юм бэ? Хоёр хоёрын дөрөв болно” гэж Смит нулимсаа асгаруулан үглэлээ.

“Смит ээ, Заримдаа, Заримдаа тав. Заримдаа гурав. Заримдаа хэд л байна төд шүү дээ. Чи их хичээх хэрэгтэй. Эрүүл ухаан суух амаргүй”

Тэрээр Смитийг орон дээр хэвтүүлэхэд үе мөчнийх нь хүлээс чангарсан боловч өвчин нь намдаад бие нь суларч хүйт дааж байна. Обрайен энэ бүхнийг харж хөдлөхгүй зогсож байсан цагаан халаадтай хүн рүү толгойгоо дохилоо. Нөгөөх цагаан халаадтай хүн Смитийн дээрээс бөхийгөөд нүдий нь үзээд судсыг нь барьж цээжинд нь чихээ наалдуулан чагнаад биеийх нь энд тэнд хуруугаараа тогшоод Обрайен руу толгойгоо дохилоо. “Дахиад” гэж Обрайен хэллээ.

Смитийн бүх бие янгинан өвдлөө. Багажны зүү дал юм уу далан тав хүрсэн байх ёстой. Тэрээр

энэ удаа нүдээ тас анилаа. Тэрээр нөгөө хуруунуудаа харуулж байгаа тэдгээр нь дөрөв л байгаа гэдгийг мэдэж байлаа. Хамгийн гол нь булчин өвдөхөө зогсоход амьд үлдэх явдал байв. Тэрээр уйлж байна уу үгүй юү гэдгээ ч мэдэхээ больжээ. Өвчин намдахад тэрээр нүдээ нээж харвал Обрайен багажны зүүг багасгажээ.

“Смитээ, Хэдэн хуруу байна вэ?”

“Дөрөв. Дөрөв л гэж бодож байна. Би чаддагсан бол таван хуруу харна. Би таван хуруу харах гэж чармайж байна”

“Чамд аль нь дээр байна. чи тавыг харж байна гэж намайг итгүүлэх үү, аль эсвэл чи үнэхээр тавыг харах уу?”

“Үнэхээр тавыг хармаар байна”

“Дахиад” гэж Смит хэллээ.

Багажны зүү лав на я ер хүрсэн байх аа. Смит тэр дороо өвдөлт дахиж байгааг мэдсэнгүй. Зовхио анихад хуруунууд бүжиглэн гүйлдэж нэг олширч нэг цөөрч бие биеийхээ араар далд орж дахин ил гарч байна. Тэрээр яагаад ч юм бэ тэдгээрийг тоолох гэж оролддоо. Дөрөв тав хоёр далдын учир шалтгаанаар адилхан болохоор тоолж болохгүй гэдгийг л мэдэж байлаа. Өвчин дахиад л намдахад нүдээ нээвэл нөгөөх л юм нь харагдсаар байх аж. Ургаж буй мод шиг боссон тоо томшгүй олон хуруу нэг нийлж нэг салж байна. Тэрээр дахиад л нүдээ анилаа.

“Смит ээ, би хэдэн хуруу харуулж байна вэ?”

“Мэдэхгүй. Та багажаа дахиад залгах юм бол би үхнэ. Дөрөв, тав, зургаа... Би үнэндээ мэдэхгүй байна”

“Дээрддээ”

Смитийн гар руу зүүний үзүүр орлоо. Бүх биеэр нь тэр дороо тааламжтай сайхан, өвчин



намдаасан бүлээн гүйдэл гүйлээ. Өвчин бараг мартагдаж байна. Нүдээ нээгээд Обрайен руу талархан харлаа. Тэрээр түүний дүнсгэр, муухай мөртлөө ухаалаг царайг хараад дотор нь уужирлаа. Хэрвээ хөдөлж чаддагсан бол гараа сунгаад Обрайены гараас бариад авмаар байна. Обрайныг зөвхөн тарчлааныг зогсоосонд нь бус тэрээр түүнд хэзээ ч одоогийнх шиг ийм их хайртай байгаагүй юм. Урьдын итгэл эргэж ирлээ. Обрайен анд нөхөр үү, дайсан уу гэдэг нь хамаагүй хэрэг ээ. Обрайен бол хэл амаа ололцож болох хүн. Хүн хайр сэтгэлээс илүү ойлголцох нь чухал байх аа. Обрайен түүнийг эрүүдэн шүүсэн, галзууруулах дөхсөн, магадгүй удахгүй түүний амь насыг хөнөөх байх. Энэ нь ач холбогдолгүй юм. Тэр хоёрыг ямар нэг утгаар найз нөхөрлөлөөс илүү юм холбож байж ч магадгүй юм. Тэд бие биедээ дотно, тэд үг дуугарахгүй ч гэсэн уулзаад ярилцаж болох тийм нэг газар байна. Обрайен түүний дээрээс мөн адил юм бодсон юм шиг харж байна. Тэрээр намуухан тайван ярьж байна.

“Смит, чи хаана байгаагаа мэдэж байна уу?”

“Мэдэхгүй. Тааварлаж байна. Хайрын Яаманд”

“Чи энд хэр удсанаа мэдэж байна уу?”

“Мэдэхгүй. Хэдэн хоног, хэдэн долоо хоног, хэдэн сар... хэдэн сар л гэж бодож байна”

“Бид энд хүмүүсийг яах гэж барьж байдаг гэж чи бодож байна вэ?”

“Тэдэнд хэргийг нь хүлээлгэх гэж”

“Үгүй, ингэх гээгүй. Сайн боддоо”

“ Шийтгэх гэж”

“Тийм биш! Үгүй! Шийтгэх гээгүй, чамайг хэргийг чинь хүлээлгэх гээгүй юм. Чамайг юунд энд барьж байгааг би чамд тайлбарлаж өгөх үү? Чамайг эмчлэх гэж байна! Чамайг эрүүл ухаантай болгох гэж! Смит, энд ирсэн хүмүүс

эдгэрэхгүй гардаггүй юм гэдгийг чи ойлгооч. Бидэнд та нарын тэнэг гэмт хэрэг сонирхолтой биш ээ. Нам илэрхий уйл ажиллагаанд санаа зовдоггүй юм. Бидний санаа зовж буй юм бол сэтгэхүй. Бид дайснаа устгаад зогсдоггүй, бид тэднийг өөрчилдөг юм. Би юу хэлж байгааг чи ойлгож байна уу?”

Обрайн түүн рүү тонгойлоо. Смит доороос дээшээ харж байгаа болохоор түүний нүүр маш том бөгөөд ой гутмаар муухай харагдлаа. Түүний царай баяр хөөр, солиотой бахдалаар дүүрэн харагдана. Смитэд айдас төрлөө. Болдогсон бол орон дотроо доошоо шингэчих юмсан. Тэрээр Обрайн одоо зугаагаа гаргах гэж багажныхаа бариулыг эргүүлнэ гэж бодож байлаа. Обрайн харин тэгсэнгүй, эргээд өрөөн дотуур хоёр гурав алхсанаа тайван ярьж эхэллээ.

“Энд тарчлагсад байдаггүй гэдгийг чи юуны өмнө ойлгох хэрэгтэй. Чи хуучин цагт шажны мөрдлөгө хавчилга байсан тухай уншсан уу? Дундад зуунд шажны шүүх байсан. Энэ нь үр

дүнд хүрээгүй юм. Энэ нь тэрсүү үзэлтнийг үндсээр нь устгахыг зорьж байсан боловч харин тэднийг мөнхжүүлсэн юм. Түүдэг галд шатаасан тэрсүү үзэлтэн бүрийн оронд шинээр мянган тэрсүү үзэлтнүүд босож байсан. Яагаад вэ? Шажны шүүх нь дайснаа илээр устгаж байсан, гэмшээгүй хүмүүсийг устгаж байсан юм. Үнэн хэрэг дээрээ хүмүүс гэмшээгүй болохоор нь тэднийг устгаж байсан юм. Хүмүүс үзэл бодлоосоо татгалзахыг хүсээгүй тул амь насаа алдаж байлаа. Ингэхлээр хохрогчдод алдар цуу ногдож, шажны шуугчдэд шившиг гутамшиг ногдсон юм. Сүүлд хорьдугаар зуунд тоталитар хэмээх дэглэмүүд байсан”

Германы нацистууд, Оросын коммунистууд гэж байсан. Оросууд тэрсүү үзэлтнүүдийг шажны шүүхээс илүү харгисаар мөрдөж байлаа. Тэд өнгөрсөн үеийн алдаанаас сургамж авсан гэж бодож байлаа. Тэд юутай ч гэсэн тарчлагдагсдыг бий болгох хэрэггүй гэдгийг ойлгожээ. Хохирогсдыг нээлттэй шүүхийн хуралдаанд оруулахын өмнө тэдний нэр төрийг

санаатайгаар гутаахыг оролдож байлаа. Хоригдлуудыг хэлсэн бүх хэргийг хүлээн зөвшөөрдөг өрөвдөм, золгүй боол болтол нь эрүүдэн шүүж, ганцаарчилан хорьж тарчлаахад тэд нар нь өөрсдийнхөө нэр төрийг гутаан, бие биедээ гэм буруугаа чихэн гоншигнон уйлж өршөөл үзүүлэхийг гуйдаг байсан юм. Тэгээд хэдхэн жилийн дараа ийм явдал дахиад л тохиолдоно. Үхсэн хүн тарчлагч болж түүнийг доромжлон гутаасныг мартчихна. Тэхлээр энэ бүхэн яагаад давтагддаг юм бэ? Хамгийн гол нь тэдний хэргийг хүч хэрэглэн хүлээлгэсэн бөгөөд энэ нь хуурамч байснаас болсон байна. Бид бол ийм алдаа гаргахгүй. Хэргээ хүлээн энд хэлж байгаа үг бүр үнэн. Бид түүнийг нь үнэн болгодог. Хамгийн гол нь бид үхэгсдийг бидний эсрэг босохыг гаргуулдаггүй. Чи хойч үе өөрийг чинь зөвтгөнө гэж төсөөлдгөө боливол зогсоно. Смит ээ, хойч үе чамайг хэзээ ч дуулахгүй. Бид чамайг түүхийн эргэлтээс арчих болно. Бид чамайг хий болгоод агаар мандалд хийсгэчихнэ. Чамаас юу ч үлдэхгүй. Нэр чинь хүмүүсийн нэр дотор ч, оюун ухаанд ч үлдэхгүй. Чамайг

өнгөрснөөс ч, ирээдүйгээс ч хасчихна. Чи энэ хорвоо дээр аж төрж байгаагүй юм шиг л болно”

Тийм л юм бол хүч гаргаж намайг эрүүдэн шүүх хэрэг юу байна вэ? гэж Смит харамсан бодлоо. Обрайен Смит энэ үгийг чанга хэлэхэд нь дуулсан юм шиг яриагаа таслаад Смит рүү ирэхэд муухай том нүүр нь ойртож, нүд нь жартганав.

“Бид чамайг устгах гэж байгаа бөгөөд чиний хэлсэн үг, үйл хэрэг чинь ач холбогдолгүй юм бол чамайг юунд ингэж хүч гаргаж байцааж байна вэ? Чи үүнийг л бодож байна, тийм үү?” гэж тэрээр хэллээ.

“Тийм” гэж Смит хариуллаа.

“Смит ээ, чи бол нийтийн дэг журам дахь сэв. Чи бол арилгавал зохих толбо. Бид урьдын залхаан цээрлүүлэгчдээс юугаараа ялгаатай вэ гэдгийг чамд тайлбарлаагүй гэж үү? Бидэнд сөрөг дуулгавартай байх, жигшүүрт хүлцэл

хангалттай биш ээ. Чи эцэстээ бидэнд бууж өгөхдөө өөрийнхөө хүсэл зоригоор бууж өгөх ёстой. Бид эсэргүүцэл үзүүлж байгаа болохоор нь тэрсүү үзэлтнийг устгадаггүй юм. Тэрээр эсэргүүцэл үзүүлээд байхад нь бид түүнийг устгадаггүй юм. Бид түүнийг өөрчилдөг, бид түүний дотоод оюун ухааныг гартаа оруулдаг, бид түүнийг дахин бий болгодог. Бид түүний бүхий л хор хөнөөл, хоосон мөрөөдлийг нь шатааж арилгана. Тэрээр манай талд ёс төдий бус чин сэтгэлээсээ оюун ухаан, зүрх сэтгэлээрээ орно. Тэрээр бидний нэг болно, тэгсэн цагт л бид түүнийг хөнөөнө. Бид энэ дэлхийд хаа нэг газар далд ч бай, хүчгүй ч бай ташаа бодол оршихыг тэвчиж чадахгүй. Сүүлчийн амьсгаагаа хураах мөчид ч бодлоосоо хазайхыг бид гаргуулахгүй. Урьдын цагт тэрсүү үзэлтэн тэрсүү үзлээ зарлан тунхаглаж түүгээрээ бахдан түүдэг гал руу орж байлаа. Оросын цэвэрлэгээний хохирогч хүртэл буудуулах гэж хонгилоор явж байхдаа хүртэл толгойдоо бослого гаргах санаагаа хадгалж байсан юм. Харин бид бол хага цохихоосоо

өмнө тарихыг нь төгс төгөлдөр болгодог юм. Хуучны дарангуйлагчдын сургаал «Чи тэгэх ёсгүй» гэж эхэлдэг байсан юм. Тоталитаруудын сургаал «Чи тэгэх ёстой» юм. Манай сургаал бол «Чи бол» юм. Энд авчирсан хүний хэн нь ч бидний эсрэг зогсож чадахгүй. Бид бүгдийг нь цэвэрлэдэг юм. Чиний гэмгүй гэж үзэж байгаа арчаагүй урвагчид болох Жоунз, Аронсон, Резерфорд нарын хүртэл зоригийг эцсийн бөлөгт хугалж чадсан юм. Би тэдний байцаалтад оролцсон, Би тэдний яваандаа хүч тамираа алдаж, гаслаж, дөрвөн хөллөж, гиншин уйлж байхыг харсан. Эцсийн бөлөгт энэ бүхэн нь өвдөж шаналснаас бус харин ч гэмшсэнээсээ болсон юм. Бид тэдэнтэй ажиллаад дуусахад тэднээс арьс яс л үлдсэн. Тэдэнд үйлдсэн хэрэгтээ харамсах, Их Ахыг хайрлах сэтгэлээс өөр юу ч үлдээгүй. Тэд Их Ахыг хайрлаж байгааг харахад сэтгэл хөдөлж байсан. Тэд нар өөрсдийгөө хурдхан буудаад өгөөч гэж гуйж байсан. Тэд санаа бодол нь цэвэрхэн байгаа дээрээ үхэх юмсан гэж байсан шүү”



Түүний хоолойд мөрөөдлийн өнгө аяс дуулдлаа. Царай нь сэтгэлийн хөөрөл, солиотой хүний урам зоригоор дүүрэн харагдана. Тэрээр бааш гаргаагүй гэж Смит бодно. Мань эр засдаг зантай хүн биш, хэлсэн үгэндээ итгэлтэй хүн. Оюун ухаанаараа түүнээс дор гэж бодохоор Смитийн сэтгэл нь хамгийн их зовж байлаа. Смит түүний том мөртлөө гоолиг бие харааных нь үзүүрт нэг орж ирээд нэг алга болохыг харж байлаа. Обрайен бүх талаараа өөрөөс нь том байлаа. Обрайены аль хэдийний мэдчихсэн байдаг, дуулмагц дүгнэж цэгнээд бут ниргэдэггүй тийм шинэ санаа Смитэд төрж байгаагүй, төрөх ч боломжгүй юм. Обрайены оюун ухаан Смитийн оюун ухааныг агуулж байна. Ингэхэд Обрайен солиотой гэдэг нь үнэн байж болох уу? Смит өөрөө л солиотой байж таарах нь. Обрайен явахаа зогсоод Смитийн дээрээс тонгойж харлаа, дуу нь дахиад ширүүн болжээ.

“Смит ээ, чи бүрмөсөн бууж өгсөн үнээрээ өөрийгөө аварлаа гэж төсөөлж үзсэн үү.

Замаасаа хазайсан хэн ч аврагдахгүй. Бид чамд жам ёсоороо үхэх хүртлээ аж төрөх боломж олголоо ч чи биднээс хэзээ ч зугтаж чадахгүй. Чамд энд тохиолдож буй юм бол мөнх. Үүнийг эртнээс мэдэж ав. Бид чамайг босож чадахгүй болтол чинь бяц дарах болно. Чи мянган жил амьд явлаа ч эдгэрч чадахгүй тийм юм чамд тохиолдоно. Чамд дахиад хэзээ ч жирийн хүний мэдрэхүй эргэж ирэхгүй. Чиний доторхи бүх юм үхдэл болсон. Хайр сэтгэл, нөхөрлөл, амьдралын баяр хөөр, инээд наадам, сониуч зан, эр зориг, нэр хүнд энэ бүхэн чамд үүрд байхгүй болно. Чамайг хов хоосон болгоно. Чамайг хов хоосон болтол базаж шахчихаад түүнийг чинь бид өөрсдөөрөө дүүргэнэ”

Тэрээр дуугүй болоод цагаан халаадтай хүн рүү дохио өглөө. Смит ямар нэг хүнд аппарат толгойн дээд талд чирж авчрахыг анзаарсан аж. Обрайен орны хажууд суухад түүний нүүр Смитийн нүүрний харалдаа ирсэн байлаа.

“Гурван мянга” гэж тэрээр цагаан халаадтай хүнд Смитийн толгой дээгүүр өнгийж хэллээ.

Смитийн чамархайд хоёр нойтон бололтой жийргэвч наалдуулахад тэдгээр нь хавчиж байна. Дахиад л өвтгөх нь, өөрөөр өвтгөх нь. Обрайен түүний гараас бариад бараг энхрийлэн тайвшрууллаа.

“Одоо өвдөхгүй. Миний нүд рүү хараарай”

Энэхэн агшинд айхавтар тэсрэлт боллоо, аль эсвэл тэсрэлт шиг юм боллоо, гэхдээ дуу чимээ гарсан гэдгийг баттай хэлэх арга алга байна. Нүд сохром гэрэл гялалзсан нь л эргэлзээгүй. Смит бэртсэнгүй, харин түүнийг эргүүлчихжээ. Тэрээр энэ тэсрэлт шиг юм болоход орон дээрээ дээшээ хараад хэвтэж байсан ч гэсэн элгээрээ харж хэвтэтлээ цохиулчихсан юм шиг хачин бодол төрж байна. Аймшигтай өвдөлтгүй цохилт түүнийг хавтгайлжээ. Мөн толгой дотор нь ямар нэг болжээ. Тэрээр нүдэндээ хараа ормогц өөрөө хэн билээ гэдгээ санаж, хаа

байгаагаа мэдэж өөр рүүгээ эгцдэн харж буй нүүрийг танилаа, харин тархиных нь нэг хэсгийг тасдаад авчихсан юм шиг хаа нэгэн газар нэгэн том хов хоосон газар байна.

“Одоохон зүгээр болно. Миний нүд рүү хараарай. Далайн Гүрэн аль улстай дайтаж байна вэ?” гэж Обрайен асуулаа.

Смит бодсоор байна. Тэрээр «Далайн Гүрэн» гэж юуг хэлж байгаа болон өөрөө Далайн гүрний иргэн гэдгээ мэдэж байна. Евразийн Гүрэн болон Дорнодазийн Гүрэнийг санаж байна. Харин хэн нь хэнтэй дайтаж буйг мэдэхгүй байна. Тэрээр тийм дайн болсон гэдгийг ч мэдэхгүй байна.

“Санахгүй байна”

“Далайн Гүрэн Дорнодазийн Гүрэнтэй дайтаж байна. Чи одоо санаж байна уу?”

“Тийм ээ”

“Далайн Гүрэн Дорнодазийн Гүрэнтэй дандаа дайтаж байсан.

Чамайг төрсөн цагаас хөйш, Нам байгуулагдсан өдрөөс хойш, дайны түүхийн эхнээс аван дайн тасралтгүй үргэлжилж ирсэн юм, тэр л дайн чинь. Чи үүнийг санаж байна уу?”

"Гийм ээ”

“Урван тэрслээд цаазаар авахуулсан гурван хүний тухай чи домог зохиосон. Тэдний гэмгүйг нотолсон цаасны тасархайг харсан гэж чи зүтгэсэн. Тэр цаасны тасархай ерөөсөө байгаагүй юм. Энэ бол чиний санаанаасаа зохиосон зүйл, чи дараа нь үүндээ итгэсэн. Чи одоо үүнийгээ санаанаасаа зохиож буй агшинаа санаж байгаа. Санаж байгаа биз дээ?”

“Санаж байна”

“Би дөнгөж саяхан чамд хуруугаа харуулсан. Чи таван хуруу харж байсан. Чи үүнийг санаж байна уу?”

“Санаж байна”

Обрайн эрхий хуруугаа нуугаад зүүн гарынхаа хурууг харууллаа.

"Таван хуруу. Чи таван хуруу харж байгаа биз?"

"Тийм”

Тэрээр оюун ухаанаа төвлөрүүлж амжаагүй байхдаа тэдгээр хурууг алга урвуулах хооронд л харсан юм. Тэрээр таван хуруу харсан, энд гажуудал байхгүй. Тэгээд бүх юм хэвийн болж урьдын айдас, үзэн ядалт, самуурал нөмөрлөө. Харин хэдхэн хором, тэрээр энэ нь хэр зэрэг удаан үргэлжилснийг мэдээгүй бөгөөд магадгүй хэдхэн агшин ч болсон байх. Обрайены шинэ санал бүр хов хоосон зайг бөглөөд үнэмлэхүй үнэн болж, шаардлагатай л гэж үзэх юм бол хоёр

хоёрын гурав ч болж болох, тав ч болж болох нь тов тодорхой үе өнгөрлөө. Обрайен түүний гарыг тавихаас өмнө энэ байдал алга боллоо. Смит хэдийвээр энэ байдалдаа эргэж очиж чадахгүй байсан ч гэсэн тэрээр огт өөр хүн байхад нь амьдралд нь тохиолдсон дурсамжтай юм шигээ үүнийг санаж байлаа.

“Чи одоо энэ бол боломжтой гэдгийг ямар ч гэсэн ойлгож байгаа биз дээ?”

"Тийм ээ" гэж Смит хариуллаа.

Обрайен сэтгэл нь ханасан шинжтэй бослоо. Смит зүүн гар талд байгаа цагаан халаадтай хүн ампул гаргаж хагалаад доторхи шингэний нь тариурын зүүгээр соруулж байгааг харав. Обрайен урд өмнөх шигээ нүднийхээ шилийг хамар дээрээ буулгаад инээмсэглэн Смитэд хандан ярилаа.

“Миний тухай өдрийн тэмдэглэлдээ юу гэж бичсэнээ санаж байна уу, энэ хүн анд нөхөр үү,

дайсан уу гэдэг нь хамаагүй. Энэ хүн намайг ядахнаа ойлгож чадна, энэ хүнтэй яриа дэлгэж болно. Таны зөв байжээ. Би тантай яриа дэлгэхдээ дуртай. Чиний оюун ухаан надад сонирхолтой юм. Чиний санаа эрүүл бус болохоос биш оюун ухаан чинь минийхийг санагдуулдаг юм. Бид яриагаа дуусгахаас өмнө асуумаар юм байвал та хэдэн асуулт тавьж болно шүү”

“Ямарваа асуулт байж болох уу?”

“Ямар ч асуулт байж болно” Тэрээр Смит багажны хуваарь руу хяламхийж буйг харлаа “Унтраачихсан. Таны анхны асуулт юу вэ?”

“Та нар Жулияг яасан бэ?”

Обрайен дахиад л инээмсэглэлээ.

“Смит ээ, цаадах чинь чамаас урвасан. Тэр дороо, үг дуугүй. Бидний талд хэн нэгэн тийм амархан орж байхыг би ховор үзсэн юм байна.



Чи түүнтэй уулзах юм бол бараг танихгүй дээ. Тэр бүсгүйн үймээн дэгдээх хүсэл, хуурамч зан, этгээд ааш, бузар булай явдал, энэ бүгдийг түүнээс арилгачихсан. Энэ бол сурах бичигт оруулмаар төгс эргэлт болсон”

"Түүнийг эрүүдэн шүүсэн үү?"

Обраиен үүнд хариулсангүй.

“Дараагийн асуулт” гэж тэрээр хэллээ.

“Их Ах бий юу?”

“Байлгүй яахав. Нам ч байгаа. Их Ах бол Намын илэрхийлэл мөн”

“Миний байгаагийн нэгэн адилаар тэрээр байгаа юу?”

“Чи бол байхгүй” гэж Обрайен хэллээ.

Тэрээр дахиад л аргаа барж эхэллээ. Тэрээр өөрийгөө байгаа гэдгийг яаж нотлох вэ гэдгээ мэдэж байлаа. Гэхдээ энэ нь үгээр тоглосон ямар ч утгагүй зүйл юм. “Чи байхгүй” гэж хэлэх нь логик тэнэглэл биш гэж үү? Үүнийг яриад ямар хэрэг байна вэ? Обрайен түүн рүү няцаашгүй, утга учиргүй нотолгоогоор дайрна гэж бодохоор ухаан санаа нь муужирмаар байна.

“Миний бодоход би оршиж байгаа. Би үүнийг ухаарч байна. Би хүн болж төрсөн. Би үхнэ. Надад гар, хөл бий. Миний бие тодорхой орон зай эзэлдэг. Энэ орон зайг ямар ч хатуу бие надтай нэгэн зэрэг эзлэхгүй. Ингэж Их Ах ч байгаа биз дээ?”

“Энэ хамаагүй. Тэрээр байгаа”

“Хэзээ нэгэн цагт Их Ах үхэх болов уу?”

“Үгүй, яалаа гэж. Тэр яалаа гэж үхэх билээ? Дараагийн асуулт” “Ах дүүгийн барилдлага байгууллага бий юу?”

“Өө, Смит чи үүнийг хэзээ ч мэдэж чадахгүй. Бид чамтай ажиллаж дуусаад чамайг тавихаар шийдэх юм гэхэд, чи ерэн нас насаллаа гэхэд, чи энэ асуултад яаж хариулахаа мэдэхгүй, тийм, үгүй гэдгээ мэдэхгүй. Чи хичнээн насалсан ч гэсэн энэ оньсого тайлагдахгүй хэвээр үлдэнэ”

Смит дуугүй хэвтэх бөгөөд амьсгаагаа арай түргэн авч цээж нь оволзоно. Тэрээр анх өөрт нь орж ирсэн асуултаа одоо хүртэл асуусангүй. Тэрээр энэ асуултыг тавих ёстой гэтэл асуулт амнаас нь гарч өгөхгүй байна. Обрайены царай тоглоом тохуу хийж байгаа юм шиг харагдана. Нүдний шил нь хүртэл егөөтэй гялалзана. Тэрээр миний асуух гэж байгаа юмыг мэдэж байна гэж Смит гэнэт боддоо! Тэрээр гэнэт үг алдаад асуулаа.

“Зуун нэгдүгээр өрөөнд юу хийдэг юм бэ?”

Обрайены царай хувирсангүй, хүйтнээр хариулж байна.

“Смит ээ, Чи зуун нэгдүгээр өрөөнд юу хийдгийг мэдэж байгаа. Зуун нэгдүгээр өрөөнд юу хийдгийг хүн бүр мэднэ”

Тэрээр цагаан халаадтай хүнд хуруугаараа дохио өглөө. Яриа дуусаж байгаа нь илт боллоо. Смитийн гар руу зүүний үзүүр ормогц тэрээр тэр дорхноо гүн нойронд автагдлаа.

### Ш

Чиний санаа боддын тогтворжуулалт гурван үеэс бүрдэнэ: сурах, ухаарах, үнэмших. Чи одоо хоёрдох үедээ орох цаг болжээ гэж Обрайен хэллээ.

Смит урьдынх лугаа нэгэн адил орон дээрээ хэвтэж байлаа. Хүлээс нь нэг их чанга барихгүй байна. Хүлээс нь түүний биеийг ор руу нь барих боловч тэрээр одоо өвдгөөрөө хөлөө хөдөлгөдөг, толгойгоо зүүн баруун тийшээ эргүүлдэг, гараа тохойлдон хөдөлгөдөг болсон аж. Тэрээр багажны хуваариас урдынх шиг айж эмээхээ мөн больж хурдан сэтгэж чадах юм бол хуваарийн зүү дээшээ гүйхээс зайлж чаддаг болсон. Одоо Обрайен түүнийг тэнэг хариулт өгөхөд л бариулыг эргүүлдэг юм. Заримдаа тэдний яриа багажийг хэрэглэхгүй ч өнгөрдөг явдал гарах болсон. Тэрээр тэдний ярилндага хэдэн удаа болж өнгөрснийг санахгүй байна. Энэ бүхэн удаан үргэлжилж байна. Ганц долоо хоног биш

гэдэг нь мэдээж хэрэг. Ярилцлага хоорондын завсарлага заримдаа хэдэн хоногоор, заримдаа ганц хоёр цаг байна.

“Чи энд хэвтэж байхдаа үе үе боддог байсан, заримдаа надаас ч асуудаг байсан. Ямар учраас Хайрын Яам ийм их хөдөлмөр, цагаа надад зориулна вэ гэж. Чи ганцаараа үлдэхээрээ гол нь энэ асуултыг л боддог байсан. Чи өөрийнхөө амьдарч байгаа нийгмийн механикийг ойлгож байгаа боловч түүнийг хөдөлгөгч шалтгааныг ойлгохгүй байна. Чи өдрийнхөө тэмдэглэлд «Би яаж гэдгийг ойлгож байна, яах гэж гэдгийг ойлгохгүй байна» гэж бичиж байснаа санаж байна уу? Чи энэ «яах» гэдгээ бодож байхдаа өөрийнхөө эрүүл ухаантай эсэхэд эргэлзэж байсан. Чи нөгөөх нотыг, Голдштейний номыг, ямар ч гэсэн хагас хугасыг нь уншсан. Чи энэ номноос урд өмнө өөрийнхөө мэдэхгүй байсан юмыг олсон уу?”

"Та энэ номыг уншсан юм уу?"

“Би түүнийг чинь бичсэн юм. Үнэндээ гэвэл зохиоход нь оролцсон юм. Номыг ганц хүн бичдэггүй нь ойлгомжтой шүү дээ”

“Номонд өгуулж байгаа юм үнэн үү?”

“Тодорхойлсон хэсэг нь үнэн. Хөтөлбөр нь огт хэрэггүй зүйл. Мэдлэгийг далдуур хуримтлуулах, аажмаар гэгээрүүлэх, үгээгүйчүүдийн бослого гаргах эцсийн зорилго Намыг татан буулгах. Цаашаа юу гарахыг нь чилав тааварлаж байсан биз. Үгээгүйчүүд хэзээ ч бослого гаргахгүй, мянган жилд ч, сая жилд ч гаргахгүй. Тэд бослого гаргаж чадахгүй. Чамд үүний учир шалтгааныг тайлбарлах хэрэг байхгүй. Чи өөрөө мэдэж байгаа. Зэвсэгт бослого гаргахыг мөрөөдөн санагалзаж байгаа бол түүнийгээ орхи. Намыг унагах ямар ч боломж байхгүй. Намын эрх мэдэл мөнх. Энэ үндсэн дээр л сэтгэн бодоорой”

Обрайн ор руу ойртож ирлээ.

“Мөнх!” гэж тэрээр давтан хэллээ. “За одоо «яаж», «яах» гэсэн асуултыг авч үзье. Нам өөрийн эрх мэддээ яаж хамгаалж байдгийг чинх, бага ч гэсэн ойлгосон. За чинх одоо надад хэлээд аль, бид юунд эрх мэдэлтэй зууралдаад байгаа юм бэ. Үүний учир шалтгаан юунд байна вэ? Яриач” гэж тэрээр хэллээ.

Харин Смит хэдэн хором дуугарсангүй. Тэрээр ядарч байлаа. Обрайены нүдэнд бүдэгхэн солиорлын урам зоригийн гэрэл гялсхийлээ. Смит юу хэлэх гэж байгааг урьдаас мэдэж байна. Нам өөрийнхөө төлөө эрх мэдэл рүү тэмүүлээгүй, харин олонхын эрх ашгийн тусын тулд л түүн рүү тэмүүлж байна. Эрх мэдэл рүү тэмүүлээд байгаагийн учир нь гэвэл хумүүс олонхидоо сул дорой, аймхай амьтад бөгөөд тэд эрх чөлөөг тэвчиж чаддаггүй, үнэнийг харж чаддаггүй юм. Хүчтэй нь тэднийг захирч толгойг нь байнга эргүүлж байх шаардлагатай юм. Хүн төрөлхтөнд сонголт хийх шаардлага тулгарч байна. Эрх чөлөө буюу аз жаргал, тэхдээ олонхийн хувьд аз жаргал нь дээр юм.



Нам бол тэднийг мөнхийн асрамжлан хамгаалж буян үйлдэхийн төлөө бүхнээ зориулан нүгэл үйлдэж буй бүлэглэл. Нам бусдын аз жаргалын тусын тулд өөрийнхийгөө золиослож байдаг юм. Хамгийн гутамшигтай нь Обрайен үүнийг халэхдээ тэрээр үүндээ итгэнэ гэж Смит бодож байлаа. Энэ нь түүний царайнаас харагдаж байна. Обрайен бүх юмыг мэднэ. Тэрээр хүмүүс ямар ядуу дорой амьдарч байгааг, Нам тэднийг ийм байдалд ямар худал хуурмаг үг, зэрлэг бүдүүлэг аргаар барьж байдгийг Смитээс хамаагүй илүү мэдэж байгаа. Тэрээр бүх юмыг ойлгосон, үнэлж цэгнэсэн бөгөөд үзэл бодолдоо хэзээ ч эргэлзэж байгаагүй. Туйлын зорилго бүхнийг зөвтгөнө. Өөрөөс чинь хамаагүй илүү ухаантай, үгийг чинь анхааралтай сонсчихоод дараа нь өөрийнхөө солиорлыг хатуу баримталдаг энэ солиотой амьтныг яах вэ? гэж Смит бодож байна.

"Та нар бидний тусын тулд биднийг захирч байна. Хүмүүс өөрсдийгөө захирч чадахгүй гэж

та нар үзэж байна уу, ингэхлээр..” гэж тэрээр сулхан дуугарлаа.

Тэрээр цочин арай л хашгирсангүй. Обрайен багажны бариулыг гучин тав хүртэл эргүүлэхэд бүх бие нь янгиналаа.

"Тэнэг, Смент ээ, энэ чинь тэнэг явдал! Би чамайг арай дээр хариулах байх гэж бодсон юм” гэж тэрээр хэллээ.

Обрайен бариулыг буцааж эргүүлэв.

“За одоо би энэ асуултад хариулья. Ийм байна. Нам бол зөвхөн өөрийнхөө тусын тулд л эрх мэдэл рүү тэмүүлдэг юм. Бидэнд бусдын сайн сайхан сонирхолтой бус. Бидэнд эрх мэдэл л сонирхолтой. Эд баялаг ч, тансаг урт удаан амьдрал буюу аз жаргал ч бус, гагцхүү эрх мэдэл, цэвэр эрх мэдэл. Цэвэр эрх мэдэл гэдэг нь юу гэсэн үг вэ гэдгийг чи одоо ойлгоно. Бид юу хийж байгаагаа мэднэ, үүгээрээ бид өнгөрсөн үеийн бүх олигархиудаас өөр юм. Бусад бүх

хүн, тэр ч байтугай бидэнтэй төстэй хүмүүс ч хулчгар, хоёр нүүртэнгүүд байсан юм. Германы нацистууд ба Оросын коммунистуудын арга барил биднийхтэй тун төстэй байсан, харин тэдэнд өөрсдийнхөө зорилгын учир шалтгааныг ойлгох эр зориг дутсан юм. Тэд нар эрх мэдлийг богино хугацаанд хүсээгүй мөртлөө гартаа авсан бөгөөд хүн эрх чөлөөтэй, эрх тэгш байх диваажин энүүхэнд байна гэсэн дүр үзүүлж байсан, магадгүй үүндээ итгэсэн ч байсан байх. Бид бол тийм биш ээ. Бид эрх мэдлийг татгалзах гэж хэзээ ч гартаа авдаггүй юм гэдгийг мэднэ. Эрх мэдэл хэрэгсэл биш. Эрх мэдэл бол зорилго. Хувьсгалыг хамгаалах гэж дарангуйллыг тогтоодоггүй юм. Дарангуйллыг тогтоох гэж хувьсгал гаргадаг юм. Залхаан цээрлүүлэлтийн зорилго бол залхаан цээрлүүлэлт мөн. Эрүү шүүлтийн зорилго бол эрүү шүүлт мөн. Эрх мэдлийн зорилго бол эрх мэдэл мөн. Чи одоо намайг жаахан ойлгож байна уу?

Смит урьд өмнөхийнхөө нэгэн адил Обрайены ядарсан царайг хараад гайхал төрлөө. Энэ нь

ширүүн дүртэй, махлаг, харгис догшин харагдах бөгөөд хүч хүрэхгүйгээ мэдрэн уур хилэнгээ тэвчин барьж буй шинжтэй аж. Тэхдээ л ядарч доройтсон царай харагдлаа. Нүд нь бөлцийгөөд хацар нь унжсан аж. Обрайен ядарсан царайгаа зориуд харагдуулах гэж ойртуулж Смитийн дээрээс бөхийлөө.

“Чи миний царайг хөгшин, ядарсан байна гэж бодож байгаа. Чи намайг эрх мэдлийн тухай яриад байгаа мөртлөө биеэ хөгшрүүлэхгүй байх чадалгүй юм гэж бодож байгаа. Смитээ, хувь хүн бол зөвхөн эс гэдгийг чи ойлгохгүй байна гэж үү? Эсийн ядрал бол бие махбодийн хүч тэнхээ. Чи хумсаа авахдаа үхэх үү?”

Тэрээр нэг гараа халаасандаа хийгээд өрөөгөөр нааш цааш алхлаа.

“Бид бол эрх мэдлийн тахилчид. Бурхан бол эрх мэдэл. Харин одоохондоо чиний хувьд бол эрх мэдэл гэдэг нь зөвхөн үг төдий зүйл юм. Чамд «эрх мэдэл» гэж ямар учиртай юм бэ гэдгийг

тайлбарлаж өгөх цаг болжээ. Чи юуны өмнө эрх мэдэл бол хамтын ойлголт гэдгийг ухаарах ёстой. Хувь хүн хувь хүн байхаа больсон зөвхөн тэр цагт л тэрээр эрх мэдэлтэй байна. Чи Намын “Эрх чөлөө бол боолчлол” гэсэн лоозонг мэднэ. Үүнийг тонгоргож болох юм гэсэн бодол чамд төрсөн үү? Боолчлол бол эрх чөлөө. Ганцаараа эрх чөлөөтэй хүн дандаа ялагддаг. Нэгэнт л хүн бүр үхдэг, энэ нь түүний хамгийн том ялагдал мөн болохоор ийм л байх ёстой. Хүн бүрэн дүүрэн захирагдаж чадах юм бол, хүн өөрөөсөө татгалзаж чадах юм бол, тэрээр Намд шингээд өөрөө Нам болох юм бол аугаа их хүчтэн, үхэшгүй мөнх болж чадна. Хоёрт, эрх мэдэл гэдэг бол хүнээс эрх мэдэлтэй байх, биендээ эрх мэдэлтэй байх, хамгийн гол нь оюун ухаандаа эрх мэдэлтэй байх явдал гэдгийг ойлгох нь зүйтэй юм. Материд буюу чиний нэрлэдгээр гаднах бодит байдалд эрх мэдэлтэй байх нь ямар ч ач холбогдол байхгүй. Бид материйг бүрэн эзэмшсэн”

Нэгхэн агшинд Смит нөгөө багажны зүү эргэхийг мартчихсан байх бөгөөд хүч гарган өндийж суух гэсэн боловч биеэ л улам хөндүүрлүүлээ.

"Та нар материйг яаж захирах юм бэ? Та нар цаг агаарыг, татах хүчийг ч захирч чаддаггүй. Тэгээд цаана нь өвчин, өвчлөх, үхэх" гэж тэрээр дуу алддаа.

Обрайн гараараа дохиж үгий нь таслав.

"Бид оюун ухааныг захирч байгаа болохоор материйг захирч байгаа юм. Бодит байдал нь гавал дотор бий. Смитээ, чи үүнийг аажмаар ухаарна. Бидний чадахгүй юм гэж юу ч байхгүй. Үл харагдах, агаарт нисэх ид шид юу ч байсан ялгаагүй. Миний дур хүрэх юм бол би яг одоо шалан дээрээс дээшээгээ савангийн хөөс шиг нисэж чадна. Нам үүнд дургүй тул би ингэхгүй. Чи байгалийн хуулийн талаархи арван есдүгээр зууны ойлголтоосоо салах хэрэгтэй. Бид байгалийн хуулийг бий болгож байна"

"Та нар түүнийг яаж бий болгох юм бэ? Та нар энэ дэлхий дээр хүртэл эзэд нь биш шүү дээ. Евразийн Гүрэн, Дорнодазийн Гүрний тухайд юу хэлэх вэ? Та нар эдгээрийг байлдан дагуулаагүй байна"

"Энэ чухал биш. Бидэнд хэрэгцээ гарвал байлдан дагуулах болно. Байлдан дагуулаагүй гээд ямар ялгаа байна. Бид тэдгээрийн оршихыг үгүйсгэнэ. Далайн Гүрэн бол бүх дэлхий мөн"

"Гэхдээ дэлхий өөрөө зөвхөн жоохон тоос. Хүн бол дорой арчаагүй! Дэлхий үүсээд хичнээн жил болж байна вэ? Дэлхий дээр хэдэн сая жил хүн суурынаагүй байсан"

"Хоосон яриа. Дэлхий бидэнтэй чацуу настай, биднээс ах биш. Дэлхий яаж биднээс ах байх юм бэ? Хүний ухаан санаанаас гадуур юу ч оршдоггүй юм"

"Дэлхийн чулуулаг бүрхүүл үхмэл амьтад, хүн нээж олохоос хамаагүй олон жилийн өмнө"

байсан арслан заан, аврага том хэвлээр явагчийн ясаар дүүрэн байна”

“Смит ээ, чи тэр ясыг ер нь харсан юм уу? Мэдээж хэрэг, үгүй шүү дээ. Арван есдүгээр зууны биологичид үүний чинь цээжнээсээ зохиосон юм. Хүн бий болохоос өмнө юу ч байгаагүй юм. Хүн хэрвээ устаж алга болох юм бол юу ч үлдэхгүй. Хүнээс өөр юу ч байхгүй”

“Биднээс гадна бүхэл бүтэн ертөнц байна. Одод руу хар даа! Тэдний зарим нь биднээс хэдэн сая гэрлийн жилийн алсад байгаа. Тэдэнд хэзээ ч хүрч чадахгүй”

“Одод гэж юу юм бэ? Хэдэн километрийн цаана байгаа галын оч шүү дээ. Бид хүсэх юм бол тэдгээрт хүрч чадна, эсвэл унтраачихна. Дэлхий ертөнцийн төв Нар, одод биднийг тойрон эргэлддэг юм”



Смит дахиад л өндийж суухыг оролдоод юу ч хэлсэнгүй. Обрайен түүнд хариулт өгч буй мэт үргэлжлүүлэн ярьсаар байна.

"Тодорхой зорилгод энэ таарахгүй нь мэдээж хэрэг юм. Бид далайд хөвж явахдаа ч юм уу, нар хиртэлтийг урьдчилан хэлэхэд Дэлхий нарыг тойрч байгаа, одод сая сая километрээр алслагдсан гэж төсөөлөхөд бидэнд таатай л даа. Тэгээд яагаа вэ? Бид давхар одон орон суддалыг бий болгож хүчирэхгүй гэж үү? Бидний хэрэгцээнээс хамаараад одод хол ч байж болно, ойр ч байж болно. Манай тоочид үүнийг дийлэхгүй гэж бодож байна уу? Чи *хоёрсэтгэхүйн* тухай мартчихсан уу?"

Смит орон дээрээ суниаж чилээгээ гаргалаа. Тэрээр юу ч хэлсэн хариулт нь бороохойдож байгаа юм шиг тэр дороо ирнэ. Тэхдээ л тэрээр өөрийнхөө зөв гэдгийг мэдэж байлаа. Чиний оюун ухааны гадна юу ч оршихгүй гэдэг итгэл байдаг аж. Энэ нь худлаа гэдгийг харуулах ямар нэг арга байж таарна. Энэ бол төөрөгдөл гэдгийг

аль хэдийнээ нотолчихсон биш үү? Энэ чинь бас нэртэй юмдаг, харин тэрээр түүнийг одоо мартжээ. Обрайен түүн рүү өнгийж харж байх бөгөөд инээмсэглэж харагдана.

“Смитээ, би чамайг метафизикт сул юм байна гэж хэлж байна шүү. Чиний санах гэж оролдож байгаа үг чинь солипсизм. Тэхдээ чи буруу ойлгож байна. Чамд хэрэгтэй бол энэ чинь хамтын солипсизм юм. Тэгэхээр энэ чинь өөр юм, хэрэг дээрээ эсрэг юм нь. Бид сэдвээсээ хадуурчихлаа” гэж тэрээр хоолойныхоо өнгийг өөрчлөөд хэллээ. “Бидний өдөр шөнөгүй олж авахын төлөө тэмцэж байгаа жинхэнэ эрх мэдэл, эд юм эддэх эрх мэдэл бус хүмүүсийг захирах эрх мэдэл юм”гээд тэрээр авьяастай сурагчдаа асуулт тавьж байгаа юм шиг:.

“Смит ээ, хүн бусдыг захирах эрх мэдлээ хэрхэн бататгадаг вэ?”

"Түүнийг зовоож байж".

“Маш зөв. Түүнийг зовоож байж. Хүнийг зовоохгүй юм бол тэрээр өөрийнхөө бус чиний хүсэл зоригийг дагаж байна гэдэгт хэрхэн итгэлтэй байж болох юм бэ? Эрх мэдэл нь шаналгал, доромжлол үүсгэхэд оршино. Хүний оюуныг урж тасдаад өөрийнхөө дур хүсэлд тааруулан дахин эвлүүлэхэд энэ нь оршино. Бид ямар дэлхийг бүтээж байгаа нь одоо чамд ойлгогдож байна уу? Урьдын шинэчлэгчдийн зугаа цэнгэл хөөсөн үл гүйцэлдэх үзэлтний мөрөөдөж байснаас энэ нь огт өөр байх болно. Айдас хүйдэс, урвалт тэрслэл, зовлон зүдүүрийн хорвоо, хөл доороо нухчин гишгэж буй, хөл дор нь нухчин гишгүүлж буй дэлхий, өөрийгөө цэвэршүүлэхдээ улам өршөөлгүй болон хөгжиж буй дэлхий юм. Энэ дэлхийн дэвшил нь шаналалын дэвшил байх болно. Эрт урьдын соёл иргэншил нь хайр сэтгэл, шударга ёс дээр бий болсон гэж нотолдог байсан. Манайх бол үзэн ядапт дээр бий болно. Бидний энэ дэлхийд айдас хүйдэс, уур хилэгнэл, ялгуусан ялапт, өөрийгөө дорд үзэхээс өөр сэтгэлийн хөдөлгөөн байх ёсгүй. Бид эдгээрээс

бусад бүх юмыг устгана. Бид Хувьсгалын өмнөх үеэс хадгалагдаж ирсэн сэтгэхүйн зуршлыг эвдэж эхлээд байна. Бид эцэг эх хүүхэд хоорондын элгэн барилддага, эрэгтэй эмэгтэй хүн хоорондын холбоо, хүн хүний хоорондын нөхөрлөлийн барилддагыг тасалсан. Хэн ч эхнэртээ, хүүхэддээ, найз нөхөртөө итгэхээ аль хэдийнээ больсон. Тун удахгүй эхнэр, найз нөхөд гэж байхгүй болно. Бид өндгийг эм тахианаас салгаад авчихдаг шиг нярай хүүхдийг эхээс нь салгаж авна. Бэлгийн харилцаанд орох дуршилыг үгүй хийнэ. Хүүхэд төрүүлэх нь хүнсний талон шинэчлэхтэй адил жил бүрийн ёс төдий зүйл болно. Дур ханахыг үгүй хийнэ. Манай сэтгэцийн эмч нар одоо энэ талаар ажиллаж байгаа. Намдаа үнэнч шударга байхаас өөр юунд ч үнэнч шударга байхаа болино. Их Ахаа хайрлахаас өөр юуг ч хайрлахаа болино. Дайснаа ялсны ялгуусан ялалтын инээд хөөрлөөс өөр инээд хөөрөл байхгүй болно. Урлаг, утга зохиол, шинжлэх ухаан бүгд байхгүй болно. Бид бүхнээс хүчтэй болмогц шинжлэх ухаан хэрэггүй болно. Гоо сайхан, зэвүүн

муухай хоёр ялгаагүй болно. Сониуч зан ч гэж байхгүй, амьдралын жаргал цэнгэл эдэх гэж ч байхгүй болно. Бид янз бүрийн зугаа цэнгэлийг устгана. Смитээ, эрх мэдэл улам гүнзгийрч, улам хүчтэй, улам нарийсахаар эрх мэдэлдээ толгой эргэх явдал дандаа гарна. Арчаагүй дайснаа хөл дороо гишгэсний ялалтын баяр хөөрийн агшин байнга гарна. Чамд ирээдүйн дүр зураг хэрэгтэй байгаа бол хүний нүүр руу дэвссэн савхин гутлыг төсөөлөөд үз”

Тэрээр Смитийн юу хэлэхийг хүлээж байгаа мэт дуугүй боллоо. Смитэд дахиад л орон дотроо нуугдмаар болж зүрх нь зогсчих шиг боллоо. Тэрээр юу ч хэлж чадсангүй. Обрайен яриагаа үргэлжлүүлээ.

“Үүнийг дандаа санаж яваарай. Дороо дэвсэлчих нүүр дандаа олдоно. Дахин дахин ялан дийлж доромжилж байвал зохих тэрс үзэлтэн, нийгмийн дайсан үргэлж олдоно. Чиний бидний гарт ороод үзсэн бүх юм чинь цаашдаа ч үргэлжилнэ, улам дор болно. Тагнан

турших, урван тэрслэл, баривчилгаа, эруу шүүлт, цаазлал, сураггүй алга болох энэ бүхэн хэзээ ч зогсохгүй. Энэ бол айдас хүйдсийн ч, ялгуусан ялалтын баяр хөөрийн ч дэлхий юм. Нам хичнээн хүчтэй болно төчнөөн үл тэвчинэ, эсэргүүцэл сулрах тусам дарангуйлал ширүүснэ. Голдштейн ба түүний хамсаатнууд үүрд мөнх байна. Тэднийг өдөр бүр, минут тутам ялан дийлнэ, нэр хүндийг нь гутаана, доромжилно, нулимна. Харин тэд хэзээд үлдэнэ. Чи бид хоёрын хооронд долоон жил үргэлжилсэн энэ сэтгэл хөдөлгөм үйл явдал дахин дахин үеэс үед улам нарийн хэлбэрээр болно. Бидэнд өвдөж шаналаад орилж чарласан, зориг нь мохож өрөвдөлтэй болсон тэрсүү үзэлтэн байнга олдоно. Эцсийн бөлөгт тэрээр аврагдаад, чин сэтгэлээсээ гэмшээд өөрөө бидний хөлд зууралдана. Бид ийм дэлхийг байгуулна, Смитээ. Ялалтаас ялалтанд, ялгуусан ялалтаас ялгуусан ялалтад хүрсэн дэлхий эрх мэддийн цөсийг зогсоо зайгүй цалгиулсан, цалгиулсан, цалгиулсан дэлхий. Ямар дэлхий байх нь чамд ойлгогдож байгааг би

харж байна. Эцсийн бөлөгт чи зүгээр л ойлгоод зогсохгүй, түүнийг дуртайяа хүлээн зөвшөөрнө, түүнд баяр хүргэнэ, түүний нэг хэсэг болно”

Смит яриа дэлгэх төдий сэхээ авав.

"Та нар чадахгүй”

“Чи юу хэлэх гээд байна?”

“Та нар дүрслэн ярьсан шигээ тийм дэлхийг бий болгож чадахгүй. Энэ бол хоосон мөрөөдөл. Энэ бол боломжгүй зүйл” “Яагаад вэ?”

“Соёл иргэншлийг айдас, үзэн ядалт, харгислалаар бий болгох боломжгүй. Энэ бол хэзээ ч тогтож чадахгүй”

“Яагаад?”

“Энэнд амьдрах чадвар байхгүй. Задран унана. Энэ нь өөрөө суйрнэ”

“Дэмий яриа. Үзэн ядалт бол хайр сэтгэлээс илүү хүч барсан зүйл гэж чи бодож байна. Яагаад ийм байх ёстой юм бэ? Энэ хэрвээ тийм юм бол ямар ялгаа байсан юм бэ? Бид биеэ хурдан илээхээр шийдсэн гэж бодоод үзье л дээ. Гучин настайдаа хүн зөнөглөхөөр хүний амьдралын хэмийг хурдасгаад үзье л дээ. Ингэлээ гээд юу өөрчлөгдөх юм бэ? Хувь хүний үхэл бол үхэл биш гэдгийг чи ойлгож чадахгүй байна уу? Нам бол үхэшгүй юм”

Түүний дуу дахиад л Смитийг аргаа барсан байдалд орууллаа. Тэрээр тэгээд ч зөрөөд байх юм бол Обрайен багажны зүүг дээш нь эргүүлж магадгүй юм гэж эмээж байв. Гэлээ ч үг дуугарахгүй байж чадсангүй. Тэрээр аргаа баран ямар ч нотолгоогүйгээр Обрайены хэлсэн үгнээс үүссэн дуугүй айдсаас өөр дэмжлэггүйгээр довтолгоогоо эхлэв.

“Би мэдэхгүй юм. Тэхдээ надад падгүй хэрэг. Ямар ч гэсэн та нарын энэ бүтэхгүй. Та нар ямар нэг юманд ялагдана. Та нар амьдралд ялагдана”



“Смитээ, Бид бүх түвшинд амьдралыг захирч байна. Хүний мөн чанар гэж нэг юм бий, тэр нь бидний бүтээж байгаа юманд хилэгнэн бидний эсрэг бөснө гэж чи төсөөлж байна”. Харин бид хүний мөн чанарыг бүтээдэг юм. Хүн бол маш гэнэн юм. Чи аль эсвэл үгээгүйчүүд буюу боолууд босч биднийг авч хаяна гэсэн нөгөөх санаагаа давтаж байж ч магадгүй юм. Чи үүнийгээ оюун ухаанаасаа авч хая. Тэд бол адгуус шиг арчаагүй амьтад юм. Хүн төрөлхтөн Нам мөн. Бусад нь үүний гадна бөгөөд ямар ч ач холбогдол байхгүй юм”

“Энэ надад падгүй. Эцсийн бөлөгт тэд та нарыг бут цохино. Тэд эрт орой хэзээ нэгэн цагт та нарыг хэн болохыг ойлгоно, тэгээд та нарыг тасдаад хаяна”

“Энэ бүхэн болно гэсэн нотолгоо байна уу? Ийм юм болохын учир шалтгаан нь юунд байна вэ?”

“Үгүй. Би үүнд итгэдэг юм. Би та нар сүйрнэ гэдгийг л тэднэ. Хорвоо дэлхийд ямар нэг юм

бий. Юу гэдгийг би мэдэхгүй, ямар нэг сүнс сүлд, ямар нэг зарчим бий, энэ бүхнийг та нар давж гарч чадахгүй”

“Смит ээ, чи бурханд сүсэглэдэг үү?”

“Үгүй”

“Тэгээд биднийг ямар зарчмаар ялах юм бэ?”

“Мэдэхгүй байна. Хүний ухаан санаа”

“Чи өөрийгөө хүн гэж бодож байна уу?”

“Гийм ээ”

“Смитээ, чи хүн юм бол сүүлчийн хүн. Таны угсаа бол үхмэл. Бид бол өвлөгчид. Чи өөрийгөө гав ганцаараа гэдгийг ухаарч байна уу? Чи бол түүхийн гадна үлдсэн, чи бол оршоогүй”  
Түүний ааш нь өөрчлөгдөөд арай шируунээр хэллээ: “Чи өөрийгөө худалч, харгис, биднээс ёс суртахуунаараа давуу гэж үзэж байна уу?”

"Тийм ээ, Би өөрийгөө давуу гэж үзэж байна"

Обрайн юу ч хэлсэнгүй. Смитэд өөр хоёр хүний дуу гарлаа. Нэг нь өөрийнх нь дуу хоолой аж. Энэ нь түүний Ах дүүгийн барилддага байгууллагад элссэн орой бичсэн бичлэг аж. Смит өөрийнхөө худал хэлнэ, хулгай хийнэ, хуурч мэхлэнэ, аллага үйлдэнэ, хар тамхи татах, биеэ үнэлэхийг өөгшүүлнэ, арьс өнгөний өвчин тараана, хүүхдийн нүүр рүү хүхрийн хүчил цацна гэсэн амлалт өгч байгаагаа дууллаа. Обрайн цааш нь сонсох хэрэггүй гэсэн мэт гараа огцом зангалаа. Тэрээр дуу хураагчийг унтраахад дуу хоолой дуулдахаа болив. "Орноосоо бос" гэж тэрээр хэллээ.

Хүлээс аяндаа тайлагдаж Смит хөлөө шалан дээр буулгаж гишгээд дэнжигнэн зогслоо.

"Чи бол сүүлчийн хүн. Чи бол хүний ухаан санааг манагч мөн. Чи өөрийгөө эхээс төрснөөр нь харах ёстой. Хувцсаа тайл"

Смит баадайгаа бүсэлж байсан уяагаа тайллаа. Хувцасных нь цахилгаан товчийг хэдийнээ суга татаад авчихсан юм. Тэрээр баригдсанаасаа хойш бүх хувцсаа тайлснаа санахгүй байна. Баадайны дотор дотуур хувцас гэмээргүй хиртэй шаргалтсан даавуугаар биеэ ороожээ. Тэрээр энэ бүхнээ газарт унагаад өрөөний нөгөө хананд байгаа гурван хавтастай толь руу ойртон очмогц өөрийгөө хараад дуу алдлаа.

“За, за. Толины хавтас дунд зогс. Өөрийнхөө хажуу хавиргыг бас хар даа”

Тэрээр айсандаа зог туслаа. Толинд бөгтөр, саарал өнгөтэй, хэлхээ яс шиг юм гарч ирлээ. Смит өөрийгөө таньсандаа бус биеийнхээ галбирыг харснаасаа айж байлаа. Тэрээр толинд ойртож очлоо. Нүүр нь муруйчихсан болохоор урагшаа унжчихсан юм шиг байна. Хоригддын ядарсан царай, булдруу болсон дух, үсгүй халзан гавал, муруй хамар, задарч ярзайсан булчин, айж болгоомжилсон ширүүн харц харагдана. Хацар нь үрчлээтэж амыг нь цөм

цохичихсон юм шиг байна. Энэ нь түүний нүүр мөн нь мэдээж боловч гарсан өөрчлөлтөөс ч илүү хувирсан юм шиг байна. Царайных нь өнгө түүний санаа сэтгэлтэй нийцэхгүй байна. Тэрээр их халзарчээ. Түүнд эхлээд бас үс нь бууралтсан юм шиг санагдаж байсан ч гэсэн үнэндээ гавал нь хувхайрчээ. Түүний нүүр, гараас бусад хэсэг нь хир буртаг тогтсоноос саарал өнгөтэй болсон байна. Биеийнх нь энд тэнд хирний цаанаас зодуулсны шарх цухуйх бөгөөд хөлийн судасны шарх нь улайж задраад арьс нь хуурчээ. Тэрээр тураалаасаа ихэд зовж байлаа. Арьсанд өлгөөстэй хавирга, цээжний яс, хөлийнх нь булчин агшаад өвдөг нь гуянаасаа том болжээ. Тэрээр одоо яагаад Обрайен түүнийг өөрийгөө хажуу талаасаа хар гэж хэлснийг ойлголоо. Нуруу нь тахийчихсан нь гайхширал төрүүлж байна. Туранхай мөр нь урагшаа унжаад цээжийг нь хөндийрүүлж хүзүү нь толгойгоо даахгүй гулзайж байх шиг байна. Тэрээр эдгэрдэггүй хүнд өвчин туссан жаран настай хүн шиг л байна.

“Чамд заримдаа Дотуур Намын гишүүн миний царай хөгшин, ядарсан харагдаж байсан байх. Чи өөрийнхөө царайны талаар юу гэж бодож байна вэ?” гээд Смитийн мөрнөөс нь татаж өөр рүүгээ эргүүлж харууллаа.

“Өөрийнхөө ямар байгааг хараач ээ! Бие чинь яасан муухай хиртэй байгааг хараач. Хөл, гарын хурууны чинь завсар хичнээн их хир тогтож вэ, хараач ээ. Хөлнийхөө булчинд байгаа нойтон шархыг хараач. Өөрөөс чинь малын шивтэр үнэртэж байгааг мэдэх үү? Чи ч энэ үнэртээ дасчихсан байх л даа. Чи ямар их турснаа харж байна уу. Ойлгож байна уу? Чиний гарын булчин чинь хоёр хурууны үзүүрт багтах болчихжээ. Би чиний хүзүүг шар лууван хугалж байгаа юм шиг хугалж чадна. Чи бидний гарт орсноос хойш жин чинь хорин таван килограммаар хасагдсаныг мэдэх үү? Үс чинь хүртэл туг тугаараа унаж байна. Хараач!” гээд Смитийн толгойноос туг үс авлаа.

“Амаа ангайлга. Ес... арав, арван нэгэн шүд үлджээ. Бидний гарт орох үед хэдэн шүд байлаа. Үлдсэн хэдэн шүд чинь ганхаж байна. Харж байна уу!”

Тэрээр Смитийн аманд хоёр хуруугаа хийхэд буйл нь огцом өвддөө. Обрайен үүдэн шүдийг нь угаар нь булгалж аваад өрөөний мухар руу шидэж орхилоо.

“Чи амьдаараа өмхөрч байна, ялзарч байна. Чи юу юм бэ? Шуудайтай хир буртаг. Алив толь руу дахиад нэг эргээтэх. Чам руу хэн харж байгааг харж байна уу? Энэ бол сүүлчийн хүн юм. Чи хүн юм бол хүн төрөлхтөн ийм л юм. За одоо хувцсаа өмс”.

Смит хувцсаа хөшчихсөн гараараа аажуухан татаж өмсөнө. Өнөөдрийг хүртэл өөрийнхөө турсан, сүльдсаныг анзаараагүй юм шиг байна. Нэг юм аман дээр нь гарч ирээд байна, төсөөлж байснаасаа урт хугацаанд энд байсан байж таарна. Тэрээр хиртэй хувцсаа өмсөж байхдаа

гэв гэнэт хөнөөгдсөн биеэ харамслаа. Тэгээд өөрөө ч юу хийж байгаагаа мэдэлгүй орны хажууд байгаа жижиг сандал дээр унаад мэгшин уйллаа. Тэрээр бузар муухайгаа, эв хавгүйгээ, хурц тусах гэрэл дор хиртэй дотуур хувцас доторхи хэлхээтэй хэдэн ясаа хараад биеэ барьж чадахгүй байна. Обрайен бараг л эелдэгхэн Смитийн мөрөн дээр гараа тавилаа.

“Энэ байдал төгсгөлгүй үргэлжлэхгүй. Чи дуртай цагтаа үүнээс зугтаж болно. Бүх юм өөрөөс чинь шалтгаална”

"Та л ингэсэн юм. Та намайг ийм байдалд оруулсан” гэж Смит цурхиран уйлж хэллээ.

“Үгүй шүү. Смит чи өөрөө өөрийгөө ийм байдалд оруулсан. Чи Намын эсрэг зогсож энэ замаар орсон юм. Чиний үйл ажиллагаа энэ бүхнийг харуулсан юм. Чи өөртөө юу тохиолдохыг урьдаас мэдэж байсан”



Тэрээр жаахан чимээгүй болсноо дахин ярьж эхлэв.

“Смит ээ, Бид чамайг зодож нүдсээн. Бид чиний эр зоригийг чинь мохоосон. Бие чинь юу болсныг чи харлаа. Чиний оюун ухаан мөн ийм л байгаа. Чамд бахархах сэтгэл нэг их үлдээгүй гэж бодож байна. Чамайг өшиглөж, ташуурдаж, доромжилж байсан, чи зовж шаналахдаа орилж чарлаж, цус бөөлжистэйгээ хутгалдан шалан дээр мөлхөж байсан. Чи өршөөл үзүүлэхийг гуйн гиншиж байсан, чи хүн бүрээс, юм бүрээс урван тэрсэлсэн. Чамд үзээгүй доромжлол, гутамшиг гэж байна уу?”

Смит уйлахаа больсон ч гэсэн нүднээс нь нулимс асгарсаар байна. Тэрээр Обрайен руу эгадэн харж:

“Би Жулиягаас урваагүй” гэж хэллээ.

“Тийм ээ, тийм. Үнэхээр тийм. Чи Жулиягаас урваагүй” Смитийн зүрх сэтгэл дахиад л

Обрайеныг гүн хүндэтгэх сэтгэлээр бялхлаа. Энэ хүндэтгэлийг юу ч эвдэж чадахгүй. Тэрээр яасан ухаантай юм бэ, яасан ухаантай юм бэ! гэж бодож байлаа. Обраиен түүнийг ойлгохгүй байсан тийм тохиолдол ерөөсөө

гараагүй юм. Өөр хэн нэгэн байсан бол чи Жулиягаас урвасан гэж тэр дор нь хариулах байсан. Тэд нар эрүү шүүлтээр түүгээр хэлүүлээгүй юм юу байна вэ! Тэрээр бүсгүйн талаар юу эс хэллээ. Түүний зуршлын тухай, түүний ааш зангийн тухай, өнгөрсөн амьдралынх нь тухай, болзоот уулзалтынхаа тухай, өөрийнхөө түүнд ярьсан юмны тухай, бүсгүйн өөрт нь ярьсан юмны тухай, хар захаас авсан хүнсээрээ оройн зоог бэлтгэсэн тухай, янаг амрагийнхаа явдлын тухай, Намын эсрэг шивнээ ярианыхаа тухай, ер нь бүгдийг маш дэлгэрэнгүй ярьсан билээ. Харин энэ үгийг одоо ойлгож байгаа утгаар бол тэрээр Жулиягаас урваагүй юм. Тэрээр бүсгүйд хайр сэтгэлтэй хэвээрээ байна. Түүнд тэмүүлэх сэтгэл

урьдынхаараа үлдсэн. Обрайен энэ бүхнийг ямар ч тайлбаргүй ойлгожээ.

“Намайг удахгүй буудаж даазаар авах болов уу, хэлээд өгөөч?” гэж тэрээр асуулаа.

“Энэ их удаж магадгүй. Чинийх бол төвөгтэй тохиолдол. Итгэл бүү алдраарай. Хүн бүр эрт орой хэзээ нэг цагт эдгэдэг юм. Тэр үед бид чамайг буудаж хорооно”

## IV

Смитийн бие овоо тэнхэрлээ. Тэрээр таргалаад өдрөөс өдөрт бие нь сайжирч байна.

Шоронгийн өрөөнд урьдын адил хурц гэрэл тусч дүнгэнэх дуу гарсаар байгаа ч өрөө нь өмнөхөөсөө арай тохьтой болсон аж. Өрөөнд нь жижиг сандал, хавтгай модон ор дээр нь дэвсгэр, дэр тавьсан байна. Түүнийг усанд оруулж онгоцонд сууж биеэ угаахыг нь үе үе зөвшөөрдөг болсон юм. Шинэ дотуур цагаан хувцас, баадай тавьж өгөөд халуун ус хүртэл өгдөг болсон аж. Хөлийн судасны шархыг нь ямар нэг өвчин намдаах тос түрхэн боож үлдсэн хэдэн шүдийг нь авч хиймэл шүд хийж өгчээ.

Хэдэн долоо хоног, магадгүй хэдэн сар ч өнгөрчээ. Одоо тогтмол хооллодог болсон юм шиг болохоор цаг хугацааг ч барагцаалж болох бололтой. Тэрээр өдөрт гурван удаа хоол өгдөг болсон юм байна гэж бодлоо. Харин хоолыг

өдрөөр өгч байна уу, шөнөөр өгч байна уу гэж гайхширан бодно. Хоол нь гайхмаар сайн байх бөгөөд өдөрт нэг удаа махтай хоол өгдөг болжээ. Түүнд нэг удаа хайрцаг янжуур хүртэл өгчээ. Түүнд шүдэнз байгаагүй боловч хоол зөөдөг үг дуугардаггүй хуяг тамхийг нь асааж өгсөн. Анх тамхи татахад дотор муухайрч байсан ч гэсэн тэрээр тэвчиж өнгөрөөгөөд хоолны дараа хугас янжуур алгуурхан татаж байв.

Түүнд буланд нь харандаа уячихсан цагаан занар самбар өгснийг эхний үед ашигласангүй. Сэрүүн байхдаа ч бие нь хөшчихсөн байдаг байсан. Тэрээр хөөлны хооронд орон дээрээ хөдөлгөөнгүй хэвтээд унтчихдаг, эсвэл мөрөөдөлдөө автан хэвтдэг бөгөөд ийм үед нүдээ арай л гэж нээдэг байлаа. Одоо нүүрэн дээрээ хурц гэрэл тусч байхад унтаад бүр дасчихсан. Түүнд энэ нь ямар ч ялгаагүй бөгөөд харин зүүд нь хоорондоо их уялдаатай аж. Энэ үеийн бүх зүүд нь дандаа аз жаргалтай зүүд байв. Тэрээр аз жаргалтай оронд аугаа том, гайхамшигтай сайхан туурь дунд ээж, Жулия,

Обрайены хамт наранд биеэ ээж суугаад ямар нэг амар жимэр юмны талаар хүүрнэлдэж байна. Сэрүүн байхад нь ийм бодол төрөхөөрөө голдуу зүүдний тухай л байдагсан. Тэрээр өвчний шаналгаа байхгүй болсон чинь оюунаа дайчлах чадвараа алдчих шиг болжээ. Тэрээр уйтгарлахаа больж хүнтэй ярих ч дургүй, өөр юм хийх ч дургүй болсон. Гав ганцаараа байж өөрийг нь байцаах, зодож нүдэхээ больсон, цадталаа хоол идэж бие нь хиргүй болсонд сэтгэл хангалуун аж.

Тэр яваандаа бага унтдаг болсон авч орноосоо босох дургүй хэвээрээ байна. Тэрээр ганц юмыг л хүснэ. Амар тайван хэвтээд биеийнхээ хүч тамир сэргэж буйг мэдрэх явдал юм. Тэрээр булчингаа бүдүүрч арьсаа сэргэж буйг үнэн эсэхэд итгэж ядан биеэ гараараа тэмтрээд таргалж байгаагаа улам бүр мэдэрлээ. Ташаа нь ямар ч гэсэн өвдөгнөөс нь бүдүүн болсон байна. Ингээд дурамжхан ч гэсэн бага зэрэг дасгал хийдэг боллоо. Тэрээр өрөөндөө алхаагаа хэмжсэнээр гурван километр явж чаддаг болсон.

Нуруу нь ч жаахан тэгширсэн, арай хүнд дасгал хийх гэж оролдсон боловч хачирхалтай бөгөөд харамсалтай нь хүч хүрэхгүй байна. Тэрээр гүйж чадахгүй, сунгасан гар дээрээ жижиг сандал даахгүй, нэг хөл дээрээ зогсож чадахгүй унаж байна, явган суугаад арай гэж босоход өвдөг гуя нь тэсэхүйеэ их өвдөнө, уруугаа харж хэвтээд хоёр гараа тулан өндийх гэтэл цээжээ ч өндийлгөж чадсангүй. Харин хэдэн өдөр, хэдэн удаа хооллосны дараа ингэж чадаж гавьяа байгууллаа. Нэг хэсэг хугацаа өнгөрсний дараа гар дээрээ зургаан удаа өндийж чадсан юм. Тэрээр өөрийнхөө биеэр бахдах болж нүүр минь хүртэл хүний нүүр шиг болж байгаа байх гэж заримдаа итгэдэг боллоо. Нэг удаа санамсаргүй халзан толгойгоо илээд толинд харсан үрчлээ сууж эв хавгүй болсон нүүрээ санаж билээ.

Оюун ухаан нь ч бага зэрэг сэргэлээ. Тэрээр орондоо хана налж хэвтээд занаран самбараа өвөр дээрээ тавьж өөртөө боловсрол олгох ажлаа хийж байв.

Тэрээр үг дуугүй бууж өгсөн, тэрээр зориг сэтгэл шулуудсан. Тэр үнэндээ зориг сэтгэл шулуудахаасаа бүр өмнө үг дуугүй бууж өгөхөд бэлэн байсан юм. Хайрын Яаманд ирсэн тэрхэн агшинаас теледэлгэцнээс дуулдах хүйтэн үгийг сонсон, Жулиятай хамт аргаа баран зогсож байсан тэрхэн мөчүүдэд ч Намын сүр хүчний эсрэг гаргасан оролдлого нь хөнгөн хийсвэр явцгүй зүйл гэдгийг ухаарч байсан юм.

Смит одоо Сэтгэхүйн Цагдаа нар түүнийг долоон жилийн туршид томруулагч шилээр цох хорхойг харж байгаа юм шиг ажиглаж мөрдөж байсныг мэдэж байна. Сэтгэхүйн Цагдаагаас нэг ч үйлддээ, дуулдахаар хэлсэн нэг ч үгээ тэрээр нууж чадаагүйгээр зогсохгүй тайлагдаагүй нэг ч бодол санаа үлдсэнгүй. Өдрийн тэмдэглэлийн дэвтрийн хавтсан дээр үлдээж байсан ширхэг цагаан тоосыг хүртэл тэд сольчихдог байсан байна. Цагдаагийнхан түүнд дуу хоолойн бичлэг, фото зураг хүртэл гэрч болгож харуулсан юм. Тэдгээр зурагны зарим нь Жулия тэр хоёрын зураг байв. За тэгээд... байгааг



хүртэл харуулсан зураг. Намын эсрэг цаашид тэмцэл явуулж чадахгүй болсон. Намын л зөв. Ийм л байх ёстой, Мөнхийн, хамтын оюун ухаан юу гэж апдаа хийх билээ! Намын үзэл баримтлалыг ямар гаднах шалгуураар үнэлэх юм бэ? Эрүүл ухаан бол тоо бүртгэлийн ойлголт. Тэд нар шиг бодохын тулд зүгээр л суралцах хэрэгтэй юм. Харин тэхдээ...!

Хуруунд нь харандаа том, барьцгүй юм шиг байна. Тэрээр эхлээд цээжиндээ орсон юмыг л бичиж байлаа. Эхлээд том үсгээр муруйлган бичлээ:

*ЭРХ ЧӨЛӨӨ БОЛ БООЛЧЛОЛ*

Үүний дор залгуулаад.

$$2 \times 2 = 5$$

Энд нэг саатал гарлаа. Түүний оюун ухаан нь ямар нэг юмнаас нуугдах гэсэн юм шиг төвлөрөхөө болив. Тэрээр дараагийн санаа

бэлэн гэж мэдэж байсан мөртлөө түүнийгээ санадаггүй. Тэгээд нөгөө санаагаа санасан чинь тэр нь толгойд нь аяндаа ож ирсэнгүй, юу гэсэн үг байх ёстой вэ гэж зориуд бодсоны эцэст орж ирлээ. Цааш нь бичсэн нь,

### *БУРХАН БОЛ ЭРХ МЭДЭЛ*

Тэрээр бүгдийг хүлээж авсан. Өнгөрсөн өөрчлөгдсөн. Өнгөрснийг хэзээ ч өөрчлөөгүй. Далайн Гүрэн Дорнодазийн Гүрэнтэй дандаа дайтаж байсан юм. Жоунз, Аронсон, Резерфорд нарыг гэмт хэрэг үйлдсэний улмаас шийтгэсэн юм. Тэрээр тэдний буруутайг үгүйсгэсэн фото зургийг хэзээ нэгэн цагт үзээгүй. Тэр зураг ерөөсөө байгаагүй, тэр зургийг санаанаасаа зохиосон юм. Эсрэг тэсрэг юмыг санаж буй мэт санаж байсан, харин тэр нь хуурамч дурсамж, өөрийгөө хуурсан явдал байсан юм. Энэ бүхэн яасан амархан юм бэ? Буугаад л өгчих, бусад юм нь аяндаа бүтнэ. Энэ нь далайн урсгалыг сөрж хичнээн ч сэлсэн, хичнээн ч хүч гаргалаа ч гэсэн давалгаа чамайг буцаагаад л хөөчихлөөр

чи түүнийг сөрөхөө болиод урсг&п дагаад сэлэхээр зориг шулуудахтай адил юм. Чиний өөрийн чинь хандлагаас өөр юу ч өөрчлөгдсөнгүй, болох ёстой юм болдгоороо л болсон. Тэрээр яагаад тэрсүү үзэлтэй болсноо өөрөө ч ойлгохгүй байна. Бүх юм амархан байжээ! Харин...

Юу ч үнэн байж болно. Байгалийн хууль гэдэг юм бол дэмий зүйл. Татах хүчний хууль бол утгагүй зүйл. “Надад савангийн хөөс шиг шалнаас дээш хөөрмөөр байх юм бол би чадна гэж Обрайен хэлж байсан”. Смит энэ санааг үндэслэлтэй болголоо. «Тэрээр өөрийгөө хөөрч байна гэж бодож байна, би түүний хөөрч байгааг харж байна гэж нэгэн зэрэг бодох юм бол энэ нь тийм л байж таарна.» Гэв гэнэт живж буй далайн хөлөг онгоцны эвдэрхий усны гадаргуу дээр ил гарч ирж буй юм шиг нэгэн бодол толгойд нь гялсхийлээ “ Үнэндээ ийм юм болохгүй. Бид хоосон юм төсөөлжээ.

Энэ бол хоосон үзэгдэл" Тэрээр тэр дороо энэ бодлоо орхилоо. Алдаатай бодол гэдэг нь илт юм. Өөрөөс чинь гадна хаа нэг газар «бодит» үйл явдал болж байгаа «бодит» дэлхий оршиж байна гэсэн таамаглал бий. Ийм дэлхий яаж байж болох юм бэ? Бид оюун ухаандаа байгаа юмыг л мэднэ. Бүх бо.чж байгаа юм оюун ухаанд л болж байдаг юм. Бүх хүний оюун ухаанд болж буй юм үнэхээр болж байдаг.

Тэрээр алдааг төвөггүй оллоо, алдааг амархан зайлууллаа. Харин ч тэрээр ийм юм бодох ёсгүй гэдгээ ухаарлаа. Осолтой бодол гарах бүрд тархинд хар толбо үүсэх ёстой юм. Энэ үйл явц аяндаа, зөнгөөрөө явагдах ёстой. Үүнийг Шинхэлээр гэтээболих гэдэг юм.

Тэрээр гэмээ болих дасгал хийж эхэллээ. Тэр өөртөө дараахи асуултыг тавилаа. “ Нам дэлхий хавтгай гэж сургаж байна”, “Нам мөс бол уснаас хүнд гэж сургаж байна Эдгээрийн эсрэг тэсрэг үзэл бодлыг ойлгохгүй, үзээгүй гэж өөрийгөө дасгаж байлаа. Амаргүй байлаа. Тунгаан бодох

болон аргыг нь олох чадвар шаардлагатай аж. “Хоёр хоёр тав болно” гэх мэтийн мэдэгдлийн тооны утгыг ойлгоход түүний толгой хүрэхгүй байна. Энэ нь мөн оюун ухааны бэлтгэл дасгал, нэг агшинд логикийг нарийн хэрэглээд дараагийн агшинд логикийн маш бүдүүлэг ачдааг ердөө мэдэхгүй байх чадварыг шаардана. Мунхаг нь оюун ухаан лугаа адил зайлшгүй шаардлагатай бөгөөд үүнийг ухаарахад бас л хэцүү байлаа.

Хэзээ намайг буудаж алах бол гэсэн бодол түүний толгойноос энэ хугацаанд гарахгүй байлаа. Обрайен «Бүх юм өөрөөс чинь л хамаарна» гэж хэлсэн, Смит үүнийг ойртуулах ямар нэг ухамсартай үйлдэл байхгүй гэдгийг ойлгосон болно. Энэ нь хэдэн мөчийн дараа ч, хэдэн жилийн дараа ч болж болно. Тэд түүнийг шоронгийн ганцаарчилсан өрөөнд олон жил суулгаж болно, лагерьт цөлж ч болно, ийм явдал урьд гарч байсны нэгэн адил түр хугацаагаар суллан тавьж ч болно. Баривчилга, байцаалтын бүх үе шатыг дахин давтахыг үгүй гэх газаргүй

юм. Нэг юм тов тодорхой нь үхэл хүлээсэн цагт ирдэггүй юм. Уламжлал, чихээрээ сонсоогүй уламжлал, өөрөө чихээрээ хэзээ ч дуулаагүй мөртлөө тэрээр яагаад ч юм бэ мэддэг юм. Тэд нар хоригдлуудыг араас нь, мөн урьдчилж мэдэгдэлгүйгээр шоронгийн нэг өрөөнөөс нөгөө өрөө рүү авч явахдаа дагз руу нь бууддаг юм.

Нэгэн сайхан өдөр, гэхдээ «өдөр» гэдэг бол оноогүй үг юм. Нэг удаа хачин жигтэй гүн мөрөөдөлд автлаа. Тэрээр толгойдоо сум зоохыг хүлээн хонгилоор явж байна, хэдхэн мөчийн дараа буудуулна гэдгээ мэдэж байна. Бүх юмтай зохицсон, төвөггүй болгосон, эвлэрсэн. Эргэлзээ, маргаан, шаналал, айдас үгүй болсон. Тэрээр баяр хөөртэй, нартай өдөр сэв сэв хийн алхаж явна. Тэр Хайрын Яамны цагаан хонгилоор явахаа болиод нэг километр өргөн нар туссан замаар хар тамхинаас согтуурсан мэт алхаж явна. Тэрээр аз жаргалтай оронд туулайн мөр гарсан бутан дундуурхи зөрөг замаар алхаж явна. Намалзсан ширэг дээгүүр алхах бөгөөд нүүр нь нарны туяанд бүлээцнэ. Талбайн нөгөө

үзүүрт ургасан хайлаас модны навч зөөлөн салхинд сэрвэлзэнэ. Түүний цаад талд горхи урсаж удган модны доорхи ногоон цөөрөмд жараахай бужигнана.

Тэрээр айсандаа орилон сэрлээ. Нуруугаар нь хөлс чийхарч байна. Тэрээр өөрийнхөө орилохыг сонслоо.

Жулия! Жулия! Жулия, Хайрт минь! Жулия!

Түүнийг дэргэдээ, бие дотор нь байна гэж бодлоо. Бүсгүй биеийнх нь хэсэг болчихсон юм шиг байна, энэхэн агшинд бүсгүйг хамт эрх чөлөөтэй байсан үеэсээ хамаагүй их хайрлаж байна. Бүсгүй хаа нэг газар амьд мэнд байгаа, түүнд өөрийнх нь тус дэм хэрэгтэй гэдгийг мэдэж байлаа.

Дахиад хэвтээд тухтай бодохыг оролддоо. Юу болов оо? Энэхэн хоромд сэтгэлийн хямралд орсноороо өөрийнхөө энэ боолчлолын хугацааг хичнээн жилээр сунгав аа?

Одоохон хаалганы цаана хуягуудын алхах чимээ гарна. Тэд ийм үйлддийг зүгээр өнгөрөөхгүй. Тэд одоо хэрвээ урд нь ойлгоогүй бол Смитийг тохиролцсоноо няцлаа гэдгийг ойлгоно. Тэрээр Намд захирагдаж байгаа боловч түүнийг урьдын адил үзэн ядаж байна, урьд нь тэрсүү үзэл санаагаа чиг шугамыг баримталж буй дүр үзүүлэн нууж байсан. Одоо нэг алхам ухарлаа. Оюун ухаандаа буулт хийчихсэн, гэхдээ зүрх сэтгэлээ хөндөлгүй хэвээр хадгалах гэж байна. Тэр өөрийнхөө бурууг ойлгож байна, буруу юм руугаа зүтгэсээр байна. Тэд энэ бүхнийг мэднэ, Обрайен ч мэднэ. Нэг удаа тэнэглэн дуу алдаад өөрийгөө илчилчихлээ.

Бүх юмыг бүр эхнээс нь эхлэхээс дээ. Үүнд он жилүүд шаардагдана. Смит бие маань ямар болсон билээ гэдгээ тов тодорхой мэдэх гэж нүүрээ гарынхаа алгаар тэмтэрлээ. Хацарт нь гүн үрчлээ сууж хацрынх нь яс овойгоод хамар нь нармигар болжээ. Үүний дээр толинд өөрийгөө харснаас хойш тэд нар түүнд шинэ шүд хийж өгсөн аж. Нүүр царайгаа ямар байгааг



мэдэхгүй байж учир битүүлэг байхад амаргүй. Ямар ч гэсэн нүүр царайгаа яаж авч явах нь хангалттай биш юм. Хүн нууцаа гаргахгүй байя гэж байгаа бол түүнийгээ өөрөөсөө ч нуух хэрэгтэй юм гэдгийг одоо л ухаарлаа. Мэдээжийн хэрэг чи нуух юм байгаа гэдгээ мэдэж байх ёстой бөгөөд хэрэгцээ гараагүй цагт ухаан санаандаа аль нэг хэлбэрээр ерөөсөө түүнийгээ нэрлэж гаргах ёсгүй юм. Үүнээс хойш зөвхөн зөв бодоод зогсохгүй, зөв мэдэрч, зөв зүүд үзэх ёстой. Тэрээр үзэн ядалтаа бие доторхи өөртэй нь холбоогүй уулинхай шиг тас хадгалж байх ёстой юм.

Тэд нар өөрийг нь хэзээ нэгэн цагт буудаж хороохоор шийднэ. Энэ хэзээ тохиолдохыг мэдэх арга байхгүй, гэхдээ хэдхэн хормын өмнө тааж лав болох байх. Хонгилоор явж байхад араас буудна. Арван секунд л хангалттай. Энэ агшинд цээжин доторхи бүх санаа бодол нь хувирч өөрчлөгднө. Тэрээр үг ч дуугаралгүй, алхаагаа ч алдалгүй, царайгаа ч хувиргалгүйгээр гэв гэнэт багаа авч хаяна. Үзэн

ядах уур хилэн дэлбэрч гарна! Үзэн ядах уур хилэн дүрэлзэн шатах гал мэт цээж дүүрэн оволзоно. Яг тэр агшинд буун дуу тас хийнэ, хэтэрхий оройтож, хэтэрхий эрт гарна. Тэд нар түүний тархийг засч залруулахаасаа өмнө зад цохино. Шийтгэгдээгүй, гэмээ хүлээгээгүй тэрсүү бодол тэдний гарт орохооргүй алсын алсад үүрд мөнх үлдэнэ. Тэд өөрсдийн дээд зорилгодоо цоорхой нүх үүсгэнэ. Тэднийг үзэн ядсаар амь насаа алдах нь эрх чөлөө мөн.

Тэрээр нүдээ анилаа. Энэ нь оюун ухаанаа дэгтэй болгохоос илүү хэцүү юм. Энэ бол өөрийгөө дорд үзнэ, зэрэмдэглэнэ гэсэн үг мөн. Балиарын балиар юманд шунган орох болно гэсэн үг юм. Хамгийн ой гутмаар, айдас хүрмээр нь юу байлаа? Их Ахын тухай бодооо. Хар сахалтай, нүднийх нь харц чамаас хэзээ ч салдаггүй, чиний оюун ухаанд дураараа эргэлдэж байдаг аврага том нүүр (энэ зургийг зурагт самбар дээр дандаа хардаг бөгөөд тэр нь өргөөшөө метр юм шиг байдаг). Тэрээр үнэн хэрэг дээрээ Их Ахад хэрхэн ханддаг вэ?

Хонгилоос хүнд алхаа сонсогдлоо. Төмөр хаалга хяхтнан дуугарч онгойгоод Обрайен өрөөнд орж ирлээ. Араас нь лаван царайтай офицер, хар хувцастай хуягууд орж ирлээ.

“Бос. Наашаа ир” гэж Обрайен хэллээ.

Смит түүний өөдөөс харж зогслоо. Обрайен хүчтэй гараараа Смитийн мөрнөөс бариад нүүр өөд нь эгцлэн харлаа.

“Чи намайг хуурчихья гэж бодоо юу? Энэ бол тэнэг хэрэг. Номхон зогс. Над руу эгц хар” гэж хэллээ.

Тэрээр жаахан дуугүй байснаа арай аядуухан ярьж эхэллээ.

“Чи засарч байна. Оюун ухааны хувьд бол бараг гайгүй болсон байна. Сэтгэл санааны хувьд бол ямар ч өөрчлөлт гарсангүй. Смитээ, чи надад хэлээд аль. Харин худал хэлж болохгүй, чи

үүнийг надаас нууж чадахгүй гэдгээ мэдэж байгаа. Чи үнэндээ Их Ахад хэрхэн ханддаг вэ?”

“Би түүнийг үзэн ядна”

“Чи түүнийг үзэн яддаг юм байна. Сайн байна. Одоо чамд сүүлчийн алхмаа хийх цаг болжээ. Чи Их Ахыг хайрлах ёстой. Түүнийг дагах нь хангалттай биш юм. Чи түүнийг хайрлах ёстой”  
Обраиен Смитийн мөрнөөс гараа буулгаад түүнийг хуяг руу аяархан түлхээд:

“Зуун нэгдүгээр өрөөнд” гэх нь тэр.

Смит хоригдож буй хугацаандаа шоронд цонх байхгүй ч гэсэн шоронгийн аль хэсэгт нь байгааг мэдэж байсан буюу мэдэж байгаа гэж төсөөлж байсан. Агаарын даралтын ялгааг мэдэрч байлаа. Хуягууд өөрийг нь зодож нүдэж байсан гяндангийн өрөө бол газрын доор байсан юм. Обрайен өөрийг нь байцааж байсан өрөө бол дээр дээврийн ойролцоо байсан. Одоогийн байгаа өрөө бол газрын гүнд, магадгүй хамгийн доор байна.

Энэ өрөө нь түрүүчийн бараг бүх өрөөнүүдээс илүү зайтай аж. Тэрээр доторхийг нь сайн мэдэхгүй байна. Өмнө нь ногоон цэмбэн бүтээлэгтэй хоёр жижиг ширээ байгааг ажигласан юм. Нэг ширээ нь хоёр метр орчим цаана, нөгөөх нь бүр цаана хаалганы хажууд байна. Смитийг түшлэгтэй сандалд чанга хүлсэн тул тэрээр толгойгоо ч хөдөлгөх аргагүй аж. Түүний толгой зөөлөн дэр шиг юманд хүлээстэй

байх бөгөөд зөвхөн урагшаа харж сууна. Тэрээр өрөөнд ганцаараа байх бөгөөд хаалга онгойж Обрайен орж ирлээ.

“Чи нэг удаа зуун нэгдүгээр өрөөнд юу хийдэг юм бэ гэж асууж байсан. Чи үүнийг мэднэ дээ гэж би хариулсан. Бүх хүн үүнийг мэднэ. Зуун нэгдүгээр өрөөнд энэ дэлхий дээрх хамгийн муу юм болдог юм”

Хаалга онгойгоод хуяг тор ч юм уу, сагс ч юм уу нэг юм оруулж ирлээ. Тэрээр түүнийгээ холын буланд тавилаа. Юу вэ гээд харах гэтэл Обрайен урдуур ороод байна.

“Энэ дэлхий дээрх хамгийн муу юм гэдэг нь хүн бүрт өөр өөр юм. Амьдаар нь газар булах, түүдэг гал дээр шатаах, усанд живүүлэх, гадсан дээр суулгах ч байж болно. Заримдаа энэ нь өчүүхэн жаахан үхэл үл авчрах зүйл ч байж болно”

Тэрээр хажуу тийшээ болоход Смит ширээн дээр байгаа нөгөөх юмыг харлаа. Энэ нь дээрээ

бариултай гонжгор уртавтар тор аж. Торны нүүр талд нь туялзуур жадны тэмцээнчийн баг мэт юмыг хонхорхой талыг нь гадагш гарган бэхэлжээ. Тэрхүү тор гурав, дөрвөн метрийн цаана байсан ч торыг уртааш нь хоёр хэсэгт хуваасныг Смит харсан бөгөөд тэдгээрт ямар нэг амьтан хөдөлж байна. Харх тэнд байна.

“Чиний хувьд бол энэ дэлхийн хамгийн муу юм гэдэг нь харх юм” гэж Обрайен хэллээ.

Смит тэрхүү торыг хармагцаа л бие нь чичирч үл мэдэх айдаст автагджээ. Тэрээр одоо яагаад торонд баг байгаагийн учрыг ойлголоо.

"Та ингэх ёсгүй!, Та ингэх ёсгүй, ёсгүй! Яаж ингэж болдог юм бэ?" гэж тэрээр дуу алдан ориллоо.

“Чи зүүдэн дундаа цочирдон сандарч байснаа санаж байна уу? Урд чинь хав харанхуй хана байна, чихэнд урхираан сонсдоно. Тэнд хананы цаана аюумшигтай юм байна. Хананы цаана юу

нуугдаж байгааг чи сэтгэлийнхээ гүнд мэдэрч байсан, гэхдээ үүнийг өөртөө хэлэх зүрх хүрээгүй. Хананы цаана харх байсан юм.

“Обрайн! Ингэх шаардлага байхгүй гэдгийг та мэдэж байгаа. Та намайг яах гээд байна вэ?” гэж тэрээр дуу хоолойгоо эзэмдэх гэж чармайн хэллээ.

Обрайн шууд хариулсангүй. Тэрээр заримдаа ингэдэг зангаараа сургуулийн багшийнх шиг хоолойгоор ярилаа. Тэрээр бодиогошрон холыг хараад Смитийн ард байгаа сонсогчдод хандаж буй мэтээр ярьж гарлаа.

“Зарим үед өвдөж шаналах нь хангалтгүй юм. Хувь хүн амьсгаагаа хураах хүртэл өвчин шаналалыг тэсч өнгөрөөсөн тохиолдол ч бий. Гэтэл хүн бүрт тэсч тэвчиж чадахгүй юм, ухаан санаанд багтахгүй юм гэж бий. Эрэмгий зориг, хулчгар зан үүнд огт хамаагүй юм. Өндөр дээрээс унахдаа дээс шидэмснээс зуураад авна гэдэг бол хулчгар зан биш. Усны гүнээс хөвж



гарахдаа агаар амьсгалах нь хулчгар зан биш. Энэ нь дагахгүй байх аргагүй зөн мөн. Хархтай ч мөн л адил юм. Чи бол хархыг тэвчиж чадахгүй. Энэ бол чи өөрөө хичээлээ ч тэсвэрлэж чадахгүй айдас мөн. Чи хийх ёстой юмыг л хийх болно” гэж тэрээр ярилаа.

"Тэр нь юу юм бэ? Юу юм бэ? Би юу гэдгийг мэдэхгүй байж юу хийх болж байна вэ?"

Обрайн тороо аваад ойролцоох ширээний цэмбэн бүтээлэг дээр хичээнгүйхэн тавилаа. Смитийн толгойд цус харвах шиг боллоо. Түүнд гав ганцаараа сууж байх шиг санагддаа. Тэрээр нарны гэрэл хурц туссан өргөн уудам цөл газарт байх бөгөөд хязгааргүй алс холоос янз бүрийн дуу чимээ сонсогдож байна. Гэтэл хархтай тор өөрөөс нь хоёр метр орчим газарт байна. Харх асар том бөгөөд хоншоор нь бөөрөнхий, догшин ширүүн болоод үс нь саарал байснаа хүрэн улаан болсон аж.

“Харх бол мэрэгчин бас тэгээд махчин амьтан юм. Чи үүнийг мэднэ. Манай хотын ядуучуудын дүүрэгт юу болдгийг чи лав дуулсан байх ёстой. Зарим гудамжинд эхчүүд нялх нярай хүүхдээ харах хүнгүй таван минут ч орхидоггүй юм. Харх хүүхэд рүү заавал довтолдог юм. Маш түргэн яс болтол мэрдэг. Харх бас өвчтэй, сульдсан хүн рүү довтолдог. Харх сул дорой хүнийг гайхалтай олж хардаг юм” гэж тэрээр үл үзэгдэх сонсогчдод хандан ярьж байв.

Тор дотор час час гэсэн дуу гарч тэр нь Смитэд их л холоос гарах шиг санагдана. Хархнууд бие биеэ мэрж эхэллээ. Хархнууд бие биетэйгээ өрсөлдөн торхноос гарах гэж гүйлдэж байна. Смитэд бас гаднаас гарсан юм шиг ёолох дуу дуулдана.

Обрайн торыг өргөөд нэг түгжээ дарлаа. Тов хийх дуу гарахад Смит тэсгэл алдан түшлэгтэй сандлаасаа босохыг оролдлоо. Түүний бүх бие болон толгойг нь хүртэл хүлчихсэн бололтой

байна. Обрайен торыг нүүрэнд нь нэг метр орчим ойртууллаа.

“Би анхных нь дэгээг буулгалаа. Чи торны бүтцийг ойлгосон байх. Баг чиний нүүрийг бүтэн хаана. Намайг дахиад нэг дэгээг мултлахад торны цонх онгойно. Өлсгөлөн амьтад сум шиг үсэрч гарна. Харх үсэрч байхыг чи харсан уу? Харх нүүрэнд чинь үсэрч зуураад мэргэж эхэлнэ. Заримдаа хацар зулгааж хэл тас хаздаг юм”

Торыг ойртуулсаар байна, одоохон нүүрний өмнө авчирна. Смит толгой дээгүүрээ тасралтгүй гарах орилолдох хашгирах дууг сонсож байлаа. Тэрээр мэгдэж сандрахгүй байхыг чармайж байв. Бодох, бодоод байх, хагас хором ч үлдсэн бодоод байх, бодох нь сүүлчийн найдвар мөн. Гэв гэнэт хархны шивтэртэй үнэр хамрыг нь цоргиуллаа. Дотор нь муухайрч огиулахад арай л ухаан алдчихсангүй. Бүх юм харлалаа. Жишээ нь тэрээр өөрөө солиотой, орилж чарласан адгуус болж хувирчээ. Тэрээр

нэгэн санаа өвөртлөн харанхуйгаас мултарч чаддаа. Аврагдах ганцхан л зам бий. Хархны өмнө өөр хүнийг тавьж өгөх ёстой, өөр хүний бие тахбодийг тавьж өгөх хэрэгтэй юм.

Зууван багийг нүүрэнд ойртуулсан тул бусад юм харагдахаа болилоо. Торны цонхыг хэдхэн сөөм ойртууллаа. Хархнууд ч сул тавих нь гэдгийг мэдэрсэн аж. Нэгэн харх тэсч ядан дэвхэрч байна. Нөгөөх нь муу усны хоолойн өвгөн харх, хойт хоёр хөл дээрээ зогсоод торноос урд хоёр хөлөөрөө зуурчихсан хамраараа уртаар амьсгал авч байна. Смит түүний сахал, шар шүдийг нь харлаа. Тэрээр ихэд мэгдэн сандарч юу ч харахгүй, хүч тамиргүй болоод ухаан санаа нь балайртжээ.

“Энэ бол Хятадын Эзэнт Гүрэнд дэлгэрсэн цээрлүүлэлт байсан юм” гэж Обрайен хэллээ.

Багаар нүүрийг нь бараг хааж байна. Торны төмөр утас хацрыг нь шүргэлээ. Тэгтэл... үгүй, энэ бол аврал биш, зөвхөн горьдлого, жаахан

горьддог. Тэрээр гэв гэнэт нарт хорвоод цээрлүүлэлтийг чихэж болох ганцхан хүн бий, ганцхан бие махбодиор өөрийгөө хархнаас хамгаалж болно гэдгийг ухаарлаа. Тэрээр тэсч ядан дахин дахин ориллоо.

“Жулияг хархад өг! Жулияг хархад өг! Намайг битгий өг! Жулияг өг! Түүнийг та нар яах нь надад хамаагүй. Нүүрий нь самардуул, ясыг нь гартал мэрүүл! Намайг битгий өг! Жулияг! Намайг битгий өг!”

Тэрээр хархнуудаас холдон нуруугаараа ёроолгүй гүнзгий нүх рүү унасаар байна.

Түшлэгтэй сандалд хүлээстэй хэвээрээ байна, гэхдээ л шал цоолон, хана нэвтлэн, газар цөмлөн, тэнгэс далай, агаар мандал, сансар хорвоог нэвтлэн оддын дунд хархнаас зайлан зайлан зугтаж байна. Тэрээр гэрлийн он жилүүдийн зайд холджээ, гэхдээ л Обрайен дэргэд нь байсаар байна. Торны хүйтэн төмөр утас хацрыг нь шүргэсээр байна. Өөрийг нь

бүрхсэн тас харанхуй дунд төмөр дэгээ тор хийхийг дуулаад торны цонх онгойсонгүй, хаагддаа гэдгийг мэдлээ.

## VI

«Туулайн бөөр мод» кафе хүнгүй, хөл хөдөлгөөн цөөтэй, арван таван цаг болж байна. Теледэлгэцнээс цовоолог дуу хангинана. Нарны шар туяа тоостой ширээн дээр тусна.

Смит дассан булангийн ширээнийхээ ард хоосон аяга руугаа харж сууна. Нөгөө талын хананаас өөрийг нь ажиглаж буй маш том нүүр өөд үе үе харна. Түүний доод талд ИХ АХ ЧАМАЙГ ХАРЖ БАЙНА гэсэн бичээс байна. Үйлчлэгч өөрөө хүрч ирээд шилэн аяганд нь «Виктори» хэмээх жин архи дүүртэл хийгээд эргэдэг бөглөөтэй өөр нэг шилнээс хэдэн дусал дусаав. Энэ нь чихэр орлуулагчтай хольсон лиш цэцэгний ханд бөгөөд кафены өөрийнх нь бүтээгдэхүүн аж.

Смит теледэлгэцийг чих тавин сонсох бөгөөд саяхан хөгжим нэвтрүүлж байсан. Одоо Энх тайвны Яамны тусгай мэдээг хүлээн авна.

Африкийн фронтоос их түгшүүртэй мэдээ ирсээр байна. Тэрээр бүр өглөөгүүр энэ тухай сэтгэл зовон бодож байсан юм. Евразийн Гүрний цэрэг (Цалайн гүрэн Евразийн Гүрэнтэй дайтаж байна, Далайн Гүрэн үргэлж Евразийн Гүрэнтэй дайтаж байдаг юм) өмнө зүг рүү маш эрчтэй давшиж байна. Үдийн мэдээгээр газар нутгийн нэрийг тодорхой хэлээгүй ч гэсэн байлдааны ажиллагаа Конго мөрний эх нутаг хавиар болж байх бүрэн боломжтой юм. Браззавиль, Леопольдвилийн байдал муу байна. Энэ юу гэсэн үг вэ гэдгийг газрын зураггүй ч ойлгож ядах юм байхгүй. Энэ нь Төв Африкийг алдах аюул тулгарч байна гэсэн үг биш, Дайны бүх явцад анх удаагаа Далайн гүрэнд аюул тулгарлаа.

Тэрээр айдаст бус ямар нэг утгагүй сэтгэлийн шаналалд автагдаад тэр нь дорхноо намддаа. Тэрээр дайны тухай бодохоо болилоо. Саяхнаас нэг юман дээр хэдхэн хормоос илүү удаан тогтож бодож чадахаа больсон байна. Тэрээр шилэн аягатай архиа ёроолыг нь гартал



хөнтөрчихсөн чинь дотор нь зарсхийж огиуллаа. Энэ архи бөөлжис цутгамаар аж. Чихэр орлуулагчтай лиш цэцгийн гашуун ханд жин архины тослог үнэрийг дарж чадахгүй байна. Хамгийн гайтай нь гэвэл түүнд өдөр шөнөгүй үнэртэх жиний үнэр нь түүний оюун ухаанд... - тай салшгүй холбоотой юм.

Смит тэднийг дотроо ч нэрээр нь дууддаггүй бөгөөд санахыг ч хичээдэггүй юм. Тэрээр тэднийг сайн таньдаггүй бөгөөд нүднийх нь өмнө эргэлдэж нөгөөх эвгүй үнэрээ ханхлуулахаар нь тааж мэддэг байсан юм. Жин ходоодыг нь цоргиод тэрээр хүрэн улаан хэлээ гарган огиулав. Шоронгоос суллагдсан цагаас хойш жин нэмж хацар нь урьдынх шигээ улаан болжээ. Нүүр нь махлаг болж хамар, хацар нь улайж халзан толгой нь хүртэл хүрэн улаан болжээ. Үйлчлэгч өөрөө шатрын хөлөг, шатрын нүүдэлтэй хуудсыг нь эргүүлчихсэн Тайтз сонин авчирч түүний өмнө тавилаа. Үйлчлэгч Смитийн аяга хоосон байгааг үзмэгцээ шилтэй жин авчирч дүүргэлээ. Захиалах хэрэг байхгүй,

тэд түүний зуршилгыг мэддэг юм. Шатрын хөлөг дандаа бэлэн, булангийн ширээг дандаа түүнд хадгалдаг аж, Хэн ч түүнтэй ойр суухыг хүсдэггүй болохоор хүн дүүрсэн үед ч булангийн ширээг түүнд хадгалдаг аж. Тэрээр хичнээн аяга архи ууснаа ч тоолдоггүй юм. Тэд үе үе түүнд тооцооны хуудас гэж бохир цаас өгдөг бөгөөд түүнээс архины үнийг тогтсоноос доогуур авч байх шиг санагддаг юм. Тэрээр одоо их мөнгөтэй болжээ. Тэд түүнд орон тооны бус албан тушаал өгсөн бөгөөд урьдах ажлаас нь илүү цалин олгодог юм.

Теледэлгэцээс нэвтрүүлэгчийн дуу гарч хөгжим тоглохоо зогслоо. Смит толгойгоо дээш болгоод чих тавин сонсоход фронтын мэдээ дамжуулсангүй. Элбэгийн Яамны мэдээ дамжуулж байна. Өнгөрсөн улиралд гутлын үдээс үйлдвэрлэлийн аравдахь гурван жилийн төлөвлөгөөг ерэн есөн хувиар биелүүлсэн аж.

Смит шатрын нүүдлийн бодлогыг хараад бодуудыг өрлөө. Мориор хоёр нүүх амаргүй

төгсгөл аж. «Цагаанаар эхэлж нүүгээд хоёр нүүддийн дараа мад тавина». Тэрээр өндийн Их Ахын зураг руу харлаа. Цагаан нь дандаа мад тавих юм гэж тэрээр гайхан боддоо. Дандаа л ингэдэг юм, ингэж урьдаас зохион байгуулдаг. Бүхий л түүхийн явцад хараар нэг ч удаа хожиж байгаагүй. Сайн юм болгон муу муухай бүхнийг ямагт гарцаагүй ялж байхын балгэ дэмбэрэл юм уу? Амар амгалан сүр хүчтэй маш том нүүр өөр рүү нь харлаа. Цагаан нь ямагт мад тавина.

Теледэлгэц түр чимээгүй болоод арай баяр баясгалантай хоолойгоор зарлалаа. «Анхаараарай, арван таван цаг гучин минутад чухал мэдээ нэвтрүүлнэ! Онц чухал ач холбогдол бүхий мэдээ. Манай мэдээг хүлээн авна уу. Арван таван цаг гучин минутад!» гээд хөгжим үргэлжиллээ.

Түүний сэтгэл хөдөллөө. Энэ бол фронтын мэдээ, муу мэдээ ирэхийг зөнгөөрөө мэдэрч байна. Тэрээр бүх л өдөржингөө сэтгэл нь догдлон Африкт хүлээсэн том ялагдлын тухай

үе үе бодож байлаа. Евразийн Гүрний үй түмэн цэрэг урьд өмнө халдашгүй байсан хил рүү довтолж тус тивийн зах хязгаараар бөөн шоргоолж шиг тархаж байгааг дүрслэн боддоо. Хоёр захаар нь яагаад сөрөн довтолж болдоггүй юм бол? Түүний нүдэнд Баруун эргийн дүр зураг харагддаа. Тэрээр цагааны морь авч хөлөгний нөгөө буланд тавилаа. Энэ бол зөв байрлал. Хар талын дээрмийн цэрэг Өмнө зүг рүү зугтаж байхад өөр нэг далд хүч хүчээ авч дайсны ар талд хураад далай болон хуурай газар дээрх дайсны ар талыг таслан цохиж байгааг нүдэндээ харлаа. Тэрээр хүсэл зоригоороо энэ хүчийг уриалан дуудаж байна гэж бодлоо.

Цаг алдалгүй үйл ажиллагаа явуулах хэрэгтэй байна. Дайсны цэрэг Африкийг гартаа авч Африкийн Хошуун дахь нисэх онгоцны буудал, усан доогуур явагч онгоцны баазыг эзлэн авах юм бол Далайн гүрэн хоёр хуваагдана гэсэн үг. Ингэх юм бол ямар ч уршиг тарьж болно. Ялагдал, дэлхийн дахин хуваарилалт, Намд сүйрэл авчирч болно! Тэрээр гүн амьсгаа авлаа.

Олон янзын хачин жигтэй бодол, гэхдээ энэ нь тодорхой хэлэх юм бол олон янзын бодол ч биш юм. Олон бодол давхцаад, хоорондоо тэмцэлдээд аль нь хамгийн гол нь вэ гэдэг нь мэдэгдэхгүй байна.

Түүний сэтгэлийн уймраа намжаад цагаан морио байранд нь тавьсан ч санаа нь тогтож өгөхгүй байна. Санаа бодол нь өөр юм руу тэмүүлээд байна. Тэрээр юу ч бодолгүй ширээний тоосон дунд хуруугаараа бичиж эхэллээ.

$2 \times 2 =$

"Тэд нар чиний дотор орж чадахгүй" гэж Жулия хэлсэн билээ. Харин тэд түүний дотор орчихсон байна. «Чамд одоо энд тохиолдож байгаа энэ юм бол *үүрдийнх* шүү» гэж Обрайен хэлсэн. Зүйтэй үг. Засаж болдоггүй өөрийн үйлдэл гэж байдаг юм. Чиний цээжинд байгаа ямар нэг юмыг дуусгачихсан, арилгачихсан, шатаачихсан.

Тэрээр бүсгүйг харсан, тэрч байтугай түүнтэй ярилцсан. Ингэлээ гээд ямар ч аюул байгаагүй юм. Тэд нар одоо түүний юу хийж байгааг бараг сонирхохоо байсныг зөнгөөрөө мэдцэг болсон. Тэр хоёрын хэн нэг нь хүсэх юм бол дараагийн уулзалтыг ч зохион байгуулж болох байсан. Харин тэд санамсаргүй уулзсан юм. Энэ явдал гуравдугаар сарын нэгэн хүйтэн салхитай өдөр, газар хав хатуу, өвс ургаагүй хаа нэг газар ганц хоёр ногоо цухуйж салхинд хийссэн цэцэрлэгт болсон билээ. Смит гар нь бээрчихсэн, хүйтэн салхинд нулимс нь гоожчихсон хурдан алхаж яваад бүсгүйг арваад метрийн өмнө явж байхыг харсан юм. Бүсгүй тун их өөрчлөгдсөн харагдсан бөгөөд чухам юу нь өөрчлөгдсөнийг мэдэх арга байхгүй байсан.

Тэд бие биеэ танихгүй хүн шиг зөрөөд явсан, дараа нь нэг их дуртайяа бус түүнийг гүйцэж очсон юм. Энэ үйлдэл нь ямар ч аюулгүй, тэднийг хэн ч сонирхохгүй гэдгийг мэдэж байсан. Бүсгүй үг дуугарсангүй. Бүсгүй түүнээс салах гэсэн юм шиг зүлгэн дээгүүр эргэж хэд

алхсанаа Смитийг хажуудаа явааг хулцэх шиг болсон. Тэд удалгүй салхинаас ч, хөндлөнгийн хүний нүднээс ч халхавч болж чадахгүй хувхай бутдын дунд орсон юм. Зогсцогоолоо. Их хүйтэн байна. Салхи ховорхон ургасан гүргэмийн бутны навчийг сэрчигнүүлэн шуугина. Тэрээр бүсгүйг бэлхүүсээр нь тэвэрлээ.

Теледэлгэц хажууд нь алга, харин нуучихсан микрофон лав байсан байх. Мөн тэр хоёр харагдаж байсан байх. Энэ бол ач холбогдолгүй зүйл, ямар ч ач холбогдол байхгүй. Тэр хоёр айх юмгүй газар хэвтээд хүссэнээ хийж болох байлаа. Энэ тухай бодоход ар зоо руу нь хүйт оргих шиг боллоо. Бүсгүй тэврээд авахад хөдөлсөнгүй, түүний гарыг суллах гэж ч оролдсонгүй. Тэрээр одоо л бүсгүйд юу өөрчлөгдсөнийг ухаарлаа. Бүсгүйн царай цонхийчихсон, үсний цаана хагас дарагдан харагдах духнаас шилээ хүрсэн урт соривтой аж. Гэхдээ гол нь энэ биш. Харин хачирхалтай нь бүсэлхий нь хатуурч бүдүүрсэн байна. Тэр

нэг удаа пуужин дэлбэрсний дараа байшингийн нуранги дотроос хүүр гаргахад тусалж байхдаа хүний хүүр өргөхөд ямар эвгүй, хүний гэмээргүй хад чулуу шиг хүнд, хатуу байдгийг гайхсанаа саналаа. Бүсгүйн биеийг тэмтрэхэд үхдэл шиг байх бөгөөд арьс нь хүртэл бүр өөр болчихсон байна гэж тэрээр боддоо.

Тэрээр бүсгүйг үнсэх ч гэсэнгүй, тэр хоёр үг ч дуугарсангүй. Тэр хоёр цэцэрлэгийн хаалгаар гарч явах зуур бүсгүй анх удаагаа түүн рүү эгцпэн харсан юм. Энэ харцанд ихэд үзэн ядсан, огидос хурсэн шинж илт байлаа. Энэ жигшил зэвүүцэл нь өнгөрсөн явддаас болсон уу, аль эсвэл өөрийнх нь хавдартай нүүр, салхинд нулимсаар мэлтэгнэх нүднээс болов уу гэж гайхширч байлаа. Тэр хоёр төмөр сандал дээр бие биеэсээ зайдуухан суулаа. Тэрээр одоо бүсгүй үг дуугарах нь гэдгийг тааварлалаа. Бүсгүй хуучивтар шаахайтай хөлөө урагш нь болгоод дөнгөж цухуйж буй ногооны шилбийг санаатайгаар тас гишгэлээ.



“Би чамаас урвасан” гэж Смит шулуухан хэллээ.

“Би ч чамаас урвасан”.

Бүсгүй дахиад л түүн рүү хүйтнээр харлаа.

“Зарим үед тэд нар чамайг ямар нэг юмаар заналхийлдэг, чиний тэсч чадахгүй юмаар, чиний ухаан санаанд ч ормооргүй юмаар заналхийлдэг. Ингэхлээр нь чи “Намайг битгий ингэ, өөр хүнийг ингэ, өөр хэн нэгнийг, тэрнийг, тэрнийг ингэ гэж “ хэлнэ. Тэгээд чи энэ бол тэднийг зогсоох гэсэн башир мэх байсан юм, үнэндээ бол үүнийг ерөөсөө хүсээгүй юм гэж өөрийгөө хуурна. Худдаа. Энэ бүх юм болж байхад чи үүнийг л хүсч байсан. Чи өөрийгөө аврах өөр арга байхгүй гэж бодно, ийм аргаар өөрийгөө аврахад бэлэн байна. Чи өөр хүнийг ингээсэй гэж хусэж байна. Түүний зовж шаналах нь чамд огт падгүй хэрэг. Чи зөвхөн хар амиа л бодож байна”

“Чи зөвхөн хар амиа л бодно” гэж тэрээр цуурай шиг дагаж хэллээ.

“Энэ бүхний дараа тэр хүний талаархи чиний хандлага өөрчлөгдөнө”

"Тиймээ, өөрөөр хандана"

Өөр ярих юм тэр хоёрт олдсонгүй. Хүчтэй салхи нимгэн баадайг нь нэвт үлээсээр байна. Дуугүй суугаад байхад эвгүй байхын хамт хүйтэнд цаашид суухад амаргүй байна. Бүсгүй метронд хоцорчих нь гэж амандаа үглээд бослоо.

“Бид дахиад уулзах нь зүйтэй” гэж тэрээр хэллээ.

"Тийм ээ, бид дахиад уулзах нь зүйтэй" гэж бүсгүй хэллээ.

Смит бүсгүйн араас жаахан хоцорсхийн алхлаа. Тэд ахиж ярилцсангүй. Бүсгүй түүнээс зугтаж зайлах гэсэндээ ч бус зүгээр л түүнд

гүйцэгдэхгүй хурдан алхлаа. Бүсгүйг метро хүртэл гаргаж өгье гэж бодсон боловч тун удалгүй энэ хүйтэнд түүний араас дэмий л дагаж яваагаа ойлголоо. Тэрээр Жулиягаас холдох гэсэндээ бус «Туулайн бөөр мод» кафед очих гэсэндээ яарч байлаа. Кафед очих гэж одоогийнх шиг хэзээ ч ингэж яарч байгаагүй билээ. Тэрээр булангийн ширээний ард суугаад сониноо уншиж шатрын бодлогоо тайлан дуусдаггүй жинээ уухаа санаж байлаа.

Хамгийн гол нь кафед дулаан байгаа. Хэдэн хүн дундуураа орж ирэхэд нь бүсгүйн араас явалгүй хоцорлоо. Үнэндээ бүсгүйг гүйцье гэж нэг жаахан хүчилснээ аажмаар болиод буцаад явлаа. Тавь орчим метр явснаа эргэж харвал гудамжинд нэг их хүн байгаагүй ч бүсгүйг олж харсангүй. Яаран алхаж буй цөөн хэдэн хүний хэн нь ч тэр бүсгүй байж болох байлаа. Түүний хатуурчихсан, бүдүүрчихсэн бие одоо бүр араасаа танигдахаа байсан байж ч магадгүй юм.

«Ийм юм болоход чи үнэхээр ингэх л болно гэж тэрээр хэлсэн юм». Тэр ингэх л байсан. Үүнийг зүгээр л хэлсэн юм биш, ингэх л гэсэн юм. Тэрээр өөрийг нь бус түүнийг л ...-нд өгөхийг хүсч байсан юм.

Теледэлгэцнээс гарах хөгжмийн аянд ямар нэг юм өөрчлөгджээ. Тас тас хийсэн, дооглонгуй, шар өнгө аяс гарч байна. Гэтэл магадгүй ийм юм байгаагүй ч байж болно, хөгжмийн ая нь дурсамжийг санагдуулсан байж ч мэднэ. Дуу дуулах хоолой сонсогдлоо.

*“Туулайн бөөрний навчис дор*

*Би чамайг, чи намайг худалдсан”*

Нүд нь нулимсаар дүүрлээ. Хажуугаар нь явж байсан үйлчлэгч аяга нь хоосон байгааг хараад шилтэй жин авчирлаа.

Тэрээр аягатай архиа бариад үнэрлэлээ. Архи нь уух тутам улам муухай амтагдана. Харин архи

уух нь түүний зуршил болжээ. Энэ бол түүний амь нас, үхэл, сэхэл мөн. Орой бүр жин ууж ухаан мэдрэлээ алдуулж өглөө бүр түүгээр сэхдэг болжээ. Голдуу арван нэгэн цагаас хойш зовхи нь аниастай, ам нь хатчихсан, хугарсан юм шиг өвчтэй нуруутай өглөө сэрээд хажууд нь шил жин, цайны аяга байхгүй бол өндийж ч чадахгүй болсон юм. Тэрээр үдээс өмнө теледэлгэц сонсон шил жин дэргэдээ тавиад гөлрөн сууна. Тэр арван таван цагаас хойш хаагдтал нь «Туулайн бөөр мод» кафед сууна. Түүнийг хэн ч тоодоггүй бөгөөд сэрүүлэг ч дуугарахгүй, теледэлгэц ч түүнд анхааруулга өгөхгүй.

Хааяа буюу долоо хоногт хоёр удаа Хайрын Яамны шороо тоосонд дарагдсан хүн бараг байдаггүй албаны өрөөнд орж ажил хийнэ. Үүнийг ажил гэж үзэх юм бол шүү. Түүнийг олон тооны хорооноос тасарч үүссэн Шинхэлийн арван нэгдүгээр хэвлэлийн хоёрдугаар зэргийн асуудал хариуцсан дэд хорооны дэд хороонд хуваарилсан юм. Одоо

Урьдчилсан илтгэл гэдгийг бэлтгэж буй бөгөөд үүнд чухам юу бэлтгэх ёстойг сайн мэдэхгүй ба мэдэж ч чадаагүй юм. Таслалыг хаалтны өмнө тавих, хойно нь тавих тухай ямар нэг дүгнэлт гаргах юм шиг байсан. Дэд хороонд түүн лүгээ адил өөр дөрвөн хүн ажилладаг. Тэд бүгд цуглаад бие биедээ хийх юм алга гэж үнэнээ хэлээд тэр дороо тарах ч өдөр байна. Гэхдээ өөр юм хийх ч өдөр гардаг байлаа. Тэд ажилдаа ханцуй шамлан ороод сүр бадруулан тэмдэглэлээ хөтөлж хэзээ ч дуусдаггүй санамж бичгээ төслөөд юуны талаар маргаан явуулж буй тухай маргалдан маш ээдрээтэй асуудалд орооцолдож, асууддаа тодорхойлох гэж хоорондоо хэрүүл маргаан үүсгэж дараа нь түүнээсээ буцаж дарга нартаа хэлнэ гэж заналхийлдэг байлаа. Тэгээд нэг мэдэхэд амьдрал нь өнгөрчихсөн байх бөгөөд тэд ширээний ард суугаад гал нь унтарчихсан нүдээрээ бие бие рүүгээ харж үүрээр азарган тахиа донгодоход алга болдог хий үзэгдэл шиг алга болно.

Теледэлгэц дуугарахаа болив. Смит чихээ тавин чагналаа. Сүүлийн үеийн мэдээ дамжуулах нь уу? Дамжуулсангүй, хөгжим л үргэлжилж байна. Смитийн нүдэнд Африкийн газрын зураг харагдана. Тэрээр армийн хөдөлгөөнийг зураасан зургаар төсөөлөн бодож байна. Хар зураас доошоогоо өмнө зүг рүү түргэн давшиж байна. Цагаан зураас хөндлөнгөөс харын сүүлийг тас цохин Дорно зүг рүү давшиж байна.

Тэрээр өөрийнхөө боддыг батлах гэсэн шиг зураг дээрх амгалан нүүр рүү харлаа. Хоёрдахь зураас ер нь байна гэж бодож болох уу?

Түүний сонирхол дахиад л унтарч балга жин залгичихаад юутай ч гэсэн цагаан мориороо нүүлээ. Харин энэ нүүдэл буруу байна, учир нь... .

Дурсамж өөрөө толгойд орж ирлээ. Лааны гэрэл асаатай өрөөнд цагаан бүтээлэгтэй том ор байна, Смит өөрөө ес, арван настай жаахан хүү шалан дээр суучихсан шоо хаян хөөрөн инээж

байна. Эх нь хажууд нь суучихсан бас л инээж байна.

Энэ явдал лав түүнийг сураггүй алга болохоос сарын өмнө болсон байх. Гэр бүлийн дотор түр зуурын эвлэрэл бий болжээ, их өлсөхөө больж эхийгээ хайрлах хайр нэг хэсэгтээ сэргэсэн юм. Тэр өдрийг сайн санаж байна. Тэнгэр муухай, тасралтгүй бороо цутгаж цонхны шил даган ус гоожиж өрөөнд бүдэг бадаг болохоор юм унших ч арга алга байсан юм. Хоёр хүүхдэд харанхуй давчуу унтлагын өрөөнд маш уйтгартай байлаа. Смит орилж чарлаж, өрөөн дундуур гүйж, юм нааш цааш нь чирч, байсхийгээд л хоол нэхэж модоор доторлосон хана нүдэхлээр цаанаас нь хөрш айлынхан хана цохиж, дүү нь байсхийгээд л орилж байсан. Эх нь тэсч чадахаа болиод. «Томоотой бай, чамд тоглоом авч өгье. Гоё тоглоом шүү. Чамд таалагдана» гэж хэлээд бороон дундуур ойрхон байх хааяа онгойдог дэлгүүр рүү явсан юм. Эх нь «могой-шат» гэдэг тоглоомын цуглуулга авчирч билээ. Смит өнөө



хүртэл нойтон хатуу цаасны үнэрийг мартдаггүй юм.

Цутлуулгыг их муу хийсэн бөгөөд самбар нь эвдэрхий, модон шоогий нь муу зорсон тул уначихаад байсансан. Смит дүнсийн сууж тоглоомыг сонирхохгүй байсан юм. Гэтэл эх нь лаа асаагаад шалан дээр суугаад хамт тоглож билээ. Тэрээр тун удалгүй тоглоомонд автаад баяр хөөр болоод могой шатаар ялалт өөд мөлхөж явснаа буцаж нураад тоглоомоо бүр эхнээс нь дахиж байсан. Тэд найман удаа тоглож дөрөв дөрөв хожиж билээ. Жаахан дүү нь толгой талд нь суугаад тоглоомыг ойлгохгүй мөртлөө тэднийг инээхээр даган инээж байлаа. Тэд гурвуулаа орой болтол Смитийн бага насных шиг баяр жаргалтай байж билээ.

Смит энэ бодлоо толгойноосоо хөөж зайлууллаа. Энэ бол хуурамч дурсамж мөн. Үе үе ийм дурсамж санаагий нь зовоодог юм. Үүнийг нь мэдэж байхад айх юм байхгүй. Зарим юм болсон, зарим юм болоогүй. Тэрээр шатрын

хөлөг рүүгээ хараад цагаан морио авсан боловч түүнийгээ шатрын хөлөг дээр чанга алдчихаад зүүгээр хатгуулсан юм шиг цочлоо.

Бүрээ бишгүүрийн дуу нам жим байдлыг тасалдууллаа. Сүүлийн мэдээ! Ялгуусан ялалт! Мэдээний өмнө бүрээ үлээж байгаа бол ялалт байгууллаа гэсэн үг. Кафе дотор цахилгаан цахих шиг боллоо. Үйлчлэгчид хүртэл сэрдхийж чих тавилаа.

Бүрээ дуугарсны дараа томоохон шуугиан дэгдлээ. Шинэ мэдээ гудамжинд цахилгаан шиг хурдан тарлаа. Тэрээр өөрийнх нь бодож байсан шиг үйл явдал өрнөж буйг теледэлгэцнээс ямар ч гэсэн ойлголоо. Далдуур цуглуулж бөөгнөрүүлсэн далайн цэргийн маш их хүчээр дайсны ар талд хүчтэй цохилт өглөө, цагаан зураас хар зураасын сүүлийг тас огтоллоо. Энд тэндээс чихэнд хагас хугас сонсогдлоо. «Стратегийн лут их маневр... нарийн харилцан уялдаа.. Африкийг бүрэн эзэллээ.. хагас сая цэрэг олзоллоо... ойрын үед дайн дуусах нь...

ялалт.. хүн төрөлхтөний түүхэн дэх аугаа их  
ялалт... ялалт... ялалт... ялалт!»

Смитийн хөл ширээн дор татваганаж байна. Тэрээр боссонгүй, тэхдээ санаандаа гүйсээр, улам хурддан гүйсээр байх ба хашгирсаар хоолой нь сөөчихсөн байна. Тэр дахиад л Их Ахын зураг руу харлаа. Дэлхийн бөмбөрцөг дээр боссон аврага том хөшөө! Азийн дээрэмчдийн толгойгоо хага мөргөж буй хад! Хэдхэн мөчийн өмнө сэтгэлийнхээ гүнд эргэлзэж байсан, ямар мэдээ ирэхийг мэдэхгүй байсан гэж бодлоо. ялалт уу, сүйрэл үү. Евразийн Гүрний арми бүрмөсөн сөнөснөөс ч илүү чухал юм боллоо! Хайрын Яаманд ирсэн анхны өдрөөс хойш маш их юм өөрчлөгдсөн, харин энэхэн агшинд л эцсийн, зайлшгүй шаарддагатай эдгээгч өөрчлөлт гарлаа.

Теледэлгэц ширүүн байлдаан, олзлогдогсод, олзолсон зэр зэвсгийн тухай дэлгэрэнгүй мэдээлсээр байхад гудамж дахь шуугиан чимээ жаахан намддаа. Үйлчлэгчид ажилдаа

идэвхийлэн орж тэдний нэг нь шилтэй жин авчирлаа. Смит баяр хөөр болон сууж байхдаа аяга дүүрэн архи хийснийг ч мэдсэнгүй. Тэрээр одоо олон хүнтэй хамт гүйхгүй, хашгирч орилохгүй байна. Дахиад л Хайрын Яамны дотор байх бөгөөд бүх юмыг өршөөсөн, булгийн тунгалаг ус шиг цэвэр болсон аж. Тэрээр ялтны суудал дээр суугаад бүх гэмээ хүлээж бүх хүний талаар мэдүүлэг өгч байна, цагаан тоосгон ханатай хонгилоор алхаж өөрөөс нь нарны гэрэл цацарч байх шиг бөгөөд ард нь буутай хуяг явж байна. Удаан хүлээсэн сум тархи руу нь нэвтрэн орж байна.

Тэрээр дахиад л аврага том нүүр рүү ширтлээ. Түүний хар сахлын цаана ямар инээмсэглэл нуугдаж байгааг олж мэдэхэд дөчин жил өнгөрчээ. Аяа, хатуу ширүүн, дэмий эндүүрэл! Эхийн нинжин сэтгэлээс гэжүүд, гэжүүн зангаараа хагацсан оргодол! Жин үнэртсэн гашуун нулимс гоожиж хамрын үзүүрт нь тогтлоо. Харин бүх юм сайхан байна, бүх юм

сайхан боллоо, тэмцэл дууслаа. Тэр өөрийгөө  
яллаа. Одоо Их Ахад хайртай болсон.

# **XABCPAJIT**

## Шинхэлийн зарчмууд

Шинхэл нь Далайн Гүрний албан ёсны хэл бөгөөд энэ хэлийг Ангсоц буюу Английн социализмын үзэл суртлын хэрэгцээг хангах гэж зохиосон. 1984 онд хэн ч энэ хэлийг харилцааны цорын ганц хэрэглэгдэхүүний хувьд аман болон бичгийн хэрэгцээнд хэрэглэдэггүй байсан юм. *Таймс* сонины тэргүүнийг Шинхэлээр бичиж байв. Ингэх нь их ур чадвар шаарддаг тул түүнийг зөвхөн нарийн мэргэжилтнүүдэд даалгадаг байв. 2050 он гэхэд Хуучхэл (орчин цагийн бичгийн хэл гэсэн үг)-ийг бүрмөсөн шахан зайлуулна гэж тооцоолж байсан. Намын бүх гишүүн Шинхэлийн үг, дүрмийг өдөр тутмынхаа хэл ярианд улам өргөн хэрэглэх болсноор энэ хэл өнөөг хүртэл хэлбэрэлтгүй газар авсаар байна. Энэ хэлний 1984 онд хэрэглэж буй Шинхэлийн толийн ес, аравдахь хэвлэлд орсон хувилбар нь түр зуурын бөгөөд сүүл рүүгээ хасагдах илүү, хуучирсан үгс агуулдаг аж. Энд бид Толины арван нэгдүгээр

хэвлэлд орсон хамгийн сүүлийн төгс төгөлдөр хувилбарын тухай ярих болно.

Шинхэлийг зохиосон зорилго бол Ангсоцыг шүтэн бишрэгчдийн ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний зохистой зуршлыг илэрхийлэх арга хэрэгслийг зөвхөн бий болгоод зогсохгүй, түүнчилэн өөр бусад сэтгэхүйг гаргахгүй байхад оршино. Шинхэлийн хэл бүрмөсөн эргэлт буцалтгүй хэлбэршиж Хуучхэл мартагдахад тэрс сэтгэлгээ, Ангсоцийн зарчмаас гажсан сэтгэхүй нь нэгэнт л сэтгэхүй үгээр илэрхийлэгддэг болохоор шууд утгаараа учир утгагүй болно гэж үзсэн юм. Үгсийн санг зохиохдоо Намын гишүүний зохистой илэрхийлж болох утга агуулга бүрийг маш нарийн гаргаад бусад бүх утга агуулга болон тойруу арга замаар ийм агуулгад хүрч болох боломжийг хаасан болно. Үүнийг шинэ үг зохиох аргаар, тэхдээ гол нь таарахгүй үгийг хасах, тууштай бус утга агуулгаас үлдсэн үгийг арилгах, хоёрдугаар зэргийн бүх үгийг хасах аргаар зохиосон болно. Жишээ татъя. Шинхэлд



*эрх чөлөөтэй* гэсэн үг одоо ч бий. Харин энэ үгийг “Энэ нохой бөөснөөс чөлөөтэй” буюу “Талбай хогийн ургамлаас чөлөөтэй” гэсэн утгаар л хэрэглэж болно. Бодох сэтгэх эрх чөлөө, улс төрийн эрх чөлөө гэдэг нь үзэл баримтлалынхаа хувьд байхаа больсон тул тэдгээрийг илэрхийлэх шаардлага байхгүй болсон юм. Ингэхлээр энэ үгийг «улс төрийн эрх чөлөө», «оюуны хувьд эрх чөлөөтэй» гэсэн хуучин утгаар хэрэглэхээ больсон. Илэрхий тэрс утгатай үгийг арилгахын зэрэгцээ толины үгийг цөөлөх нь бас нэг чухал зорилт гэж үзсэн бөгөөд хэрэглэхгүй байж болох бүх үгийг мөн хассан юм. Шинхэл нь бодлын цар хүрээг тэлэх бус *хумихад* зориулагдсан тул үг сонголтыг хамгийн доод хэмжээнд хийсэн нь энэ зорилгод нийцнэ.

Шинхэлийг бидний өнөөгийн мэддэг Англи хэл дээр үндэслэн зохиосон юм, харин шинээр зохиосон үг ороогүй Шинхэлийн олонхи өгүүлбэр өнөөгийн англи хэлээр ярьдаг хүнд ойлгомжгүй юм шиг ч байж болно. Шинхэлийн үгсийн сан гурван ангиллаас бүрдэнэ. А үгсийн

сан, Б үгсийн сан (нийлмэл үг ч гэж нэрлэх нь буй) болон Г үгсийн сан болно. Эдгээрийг тус тусад нь авч үзэх нь хялбар юм, харин бүх ангиллын хувьд дүрэм нь адилхан тул дүрмийн онцдогийг А үгсийн санд нэгтгэж болох юм гэж үзсэн болно.

*А үгсийн сан* нь өдөр тутмын амьдрал ахуйд зайлшгүй хэрэглэх шаардлагатай үгсийг хамарна: идэх, уух, ажиллах, хувцаслах, шатаар өгсөх, буух, дугуй унах, цэцэг тарих, хоол хийх г. м. Эдгээр нь өнөөгийн бидний хэрэглэж буй бараг бүх үг, тухайлбал, цохих, гүйх, нохой, мод, чихэр, байшин, талбай гэх мэтээс бүрдэнэ. Нөгөө талаар өнөөдрийн Англи хэлний үгийн сангаас хамаагүй бага бөгөөд тэдгээрийн утгыг маш нарийн гаргасан болно. Агуулгын эргэлзээтэй, тодорхой бус шинжийг арилгасан юм. Энэ ангиллын Шинхэлийн үгс нь боломжийн хэмжээнд тов тодорхой ойлгогдох нэг л ойлголтын дуу авиа буюу дуу авиануудын илэрхийлэл болно. А үгсийн санг утга зохиолын зорилгод болон улс төр, гүн ухааны маргаанд

ашиглах ямар ч боломжгүй юм. Энэ нь тодорхой биет зүйлс ба биет юмны үйлдлийн талаархи энгийн санаатай сэтгэлгээг илэрхийлэхэд л зориулагдсан болно.

Шинхэлийн дүрэм хоёр ондогтой. Эхнийх нь үгийн аливаа бүрэлдэхүүн хэсэг бүрэн харилцан солигдож болох онцдог юм. Хэлний ямарваа үгийг (энэ зарчим хийсвэр утгатай *юм бол* буюу *тэгэхэд* гэх мэт үгэнд ч хамаарна) үйл үг, нэр үг, хавсрал нэр, үйл хавсралын алианаар ч хэрэглэж болдог юм. Үгийн язгуур нь л нэг бол үйл үг, нэр үгийн хооронд ерөөсөө ялгаа байхгүй бөгөөд энэ дүрмээр олон хуучирсан үгийг эвдсэн юм. Жишээ нь Шинхэлд *сэтгэхүй* гэсэн үг байхгүй, энэ үгийг үйл үг, нэр үгийн аль алиных нь үүрэг гүйцэтгэж чадах *сэтгэх* гэдэг үг орлодог юм. Үүнд үгийн гарал зүйн зарчмыг баримтлаагүй юм. Зарим тохиолдолд нэр үгийг хадгалж үлдээсэн, зарим тохиолдолд үйл үгийг авсан. Утга адил нэр үг ба үйл үг нь үгийн гарал зүйн хувьд холбоогүй бол аль нэгийг нь арилгасан болно. Жишээ нь *хутга* гэдэг үг агуулгыг нь

хангалттай илэрхийлж буй болохоор *огтлох* гэдэг үг байхгүй. Хавсрал нэрийг, тай гэсэн дагавар нэмж үүсгэдэг ба үйл хавсралыг, *лэн, лан* гэсэн дагавар дагуулж үүсгэнэ. Жишээ нь *хурдтай* гэх нь “хурдан” гэсэн үг, *хурдлан* гэх нь “хурдаараа” гэсэн утгатай юм.

Өнөөдрийн хэрэглэгдэж буй *сайн, хүчтэй, том, хар, зөөлөн* гэх мэтийн хавсрал нэрийг хадгалж үлдсэн боловч тэдгээрийн нийт тоог ихээхэн цөөлсөн болно. Нэр үг болон үйл үгэнд, *тай* дагавар нэмж хавсрап үгийн агуулгыг бүрэлдүүлж болох тул тэдгээр үгний хэрэгцээ бага юм. *Лаг* гэсэн төгсгөлтэй цөөхөн хэдэн үгнээс бусад өнөөгийн хэрэглэж буй үйл хавсралын үгнээс нэгийг нь ч авч үлдээгүй болно. Жишээ нь *сайн* хийх гэсэн үйл хавсралыг *сайнлаг* гэдэг үгээр орлуулсан.

Дээр хэлснээс гадна хэлний аль ч үгэнд, *гуй* гэсэн дагавар заггаж үгүйсгэсэн утгыг нь чангаруулж болох ба *нэмэх* гэсэн угтвар залгаж хүчийг нь нэмэх ба улам их хүч нэмье гэвэл

давхарнэмэх гэдэг утгвар залгаж болно. Ингэхлээр хүйтэнгүй гэдэг нь “дулаан” гэсэн утгатай байхад *нэмэххүйтэн* ба *нэмэхнэмэххүйтэн* гэдэг нь “их хүйтэн” “чөмөг хаг ташим хүйтэн” гэсэн утгатай юм. Өнөөдрийн англи хэлэнд байгаачлан аливаа үгийн утгыг, *үл, дараа, дээш, доош* гэх мэт дагавар залгаж өөрчилж болно. Ийм аргаар үгийн санг маш ихээр багасгаж болох нь харагдсан билээ. Жишээ нь сайн гэсэн үг байхад муу гэдэг үг хэрэггүй бөгөөд улсайн гэдэг үгээр утгыг сайн, харин ч илүү илэрхийлнэ. Хоёр үг эсрэг утга илэрхийлж байгаа нөхцөлд арь үгийг арилгах вэ гэдгийг шийдэхэд энэ бүхэн шаардлагатай байсан юм. Жишээ нь *харанхуй* гэдэг үгийг *улгэгээтэй* гэдгээр ч юм уу, *гэгээтэй* гэдгийг *үлхаранхуй* гэдгээр орлуулж болно.

Шинхэлийн дүрмийн хоёрдахь онцдог нь түүний тогтвортой хэв юм. Доор дурдсан цөөн хэдэн дүрмийн бус тохиолдлоос бусад нөхцөлд үгийн тийн ялгал нэг л дүрмээр хийгдэнэ. Үйл үгийн энгийн өнгөрсөн цагийн төгсгөл нь бүх

үйл үгэнд нэг адил буюу, *сан*, *-сэн*, *-в* гэж төгсөнө. *Хулгайлах* гэдэг үг өнгөрсөн цагт *хулгайлсан*, *бодох* гэсэн үг өнгөрсөн цагт *бодсон* болно гэх мэтээр бүх хэлэнд адил юм. *Сэллээ*, *авчирлаа*, *ярилаа*, *авчээ* гэх мэтийн төлвийг үгүй болгосон юм. Нэр үгийн олон тоонд, *ууд*, *-ууд*-үпт төгсгөлийг хэрэглэнэ. *Эр хүн*, *шар үхэр*, *амьдрал* гэдэг үгсийн олон тоо нь *эр хүнүүд*, *шар үхрүүд*, *амьдралууд* болно. Хавсрал нэрийн харьцуулсан зэргийг, *арай*, *-хамгийн* гэсэн үгийг нэмж үүсгэх бөгөөд *илүү*, *хамгийн сайн* гэдэг үгийг арилгасан юм.

Тийн ялгаллаар ялгалахаар үлдээсэн ангиллын үгс нь төлөөний үг, холбох төлөөний үг, тодотгох хавсрал нэр үг болон туслах үйл үг болно. Эдгээрийг хуучин хэвээр нь хэрэглэнэ, харин нөгөөх гэдэг үгийг хэрэглэх шаардлагагүй гэж үзсэн юм.

Мөн үйл үгийн ирээдүй цагийн *тэгнэ*, *ингэнэ* гэсэн хэвийг үгүй болгосон бөгөөд үүнийг, *нө-нэ* гэсэн хэвээр орлуулсан болно. Хурдан түргэн

ярианы хэрэгцээнээс үүссэн үг бүтээх ёсны тогтвортой бус хэвийн асуудал бас бий. Хэл хугалчих гээд байдаг буюу буруу сонсогдож болох үгийг *ipso facto* муу үг гэж үздэг, чихэнд чимэгтэй дуулдуулахын тулд үгэнд илүү үсэг нэмдэг буюу хуучирсан үгийн хэвийг хадгалдаг. Харин энэ нь Б ангиллын үгийн санд голлон хамаарна. Үгийн дуудлагад *яагаад* ийм их ач холбогдол өгч байгааг энэ эссеин сүүлчийн хэсэгт тайлбарласан болно.

*Б үгсийн сан.* Б үгсийн сан нь улс төрийн зорилгоор санаатай зохиосон үгсээс бүрдэнэ. Зөвхөн улс төрийн утга агуулгатай бус, хэрэглэж буй хүнд сэтгэхүйн тодорхой байр суурийг тулган хүлээлгэсэн үгс юм. Ангсоцийн үндсийг бүрэн эзэмшихгүйгээр эдгээр үгийг зөв хэрэглэх арга байхгүй. Зарим тохиолдолд эдгээр үгний утгыг Хуучхэлийн үгээр юм уу, А ангиллын үгсийн сангийн үгээр илэрхийлж болох юм, гэхдээ ингэхэд сунжирсан урт орчуулга шаардагдах ба гаргах гэж буй утга санаа алдагдаж болох талтай.

Бүх нийлмэл үг Б ангиллын үгсийн санд багтана. Эдгээр үг нь хэлэхэд хялбар болгох үүднээс нийлүүлсэн үгийн хоёр буюу гурван үеэс бүрдэнэ. Ингэж үүссэн үг нь нэр үг, үйл үг болох ба жирийн дүрмийн дагуу ялгалагдана. Нэг тодорхой жишээ авья. *Сайнбодох* гэсэн үг бол ойролцоогоор “тууштай” гэсэн утгатай бөгөөд үүнийг үйл үг гэж үзэх юм бол “тууштай байр суурь баримтлах” гэсэн утга гарна. Энэ үгийг дараахи байдлаар ялгалж болно. Үүнд, нэр үг-үйл үг нь *сайнбодох*, өнгөрсөн цагт ба өнгөрсөн цагийн нөхцөлт үйл үг нь *сайнбодсон*, одоо цагийн нөхцөлт үйл үг нь *сайнбодсоор*, хавсрал үйл нь *сайнбодон*, аман ярианы нэр үг нь *сайнбодогч* болно. Б үгсийн сангийн үгийг гарал зүйн үндсэн дээр зохиогоогүй болно. Шинээр бий болгосон үг нь үгсийн арь ч аймгийн үг байж болох ба тэдгээрийг гарал үүсэл нь л тодорхой байх юм бол дуудахад хялбар байхаар бодож ямар ч аргаар хамаагүй зохиосон байж болно. *Гэмсэтгэхүй* (Сэтгэхүйнгэм) гэхэд сэтгэхүй гэдэг нь үгийн төгсгөлд байхад *сэтгэхүйнцаг* (Сэтгэхүйн



Цагдаа) гэдэг үгэнд сэтгэхүй нь үгийн эхэнд байгаа бөгөөд цагдаа гэдэг үгийн хоёрдахь үе нь гээгдсэн байна. Аятай дуудагдахыг хангах нь төвөгтэй байсан тул тогтворжоогүй хэвт үг Б үгсийн санд А үгсийн сангаас өргөн дэлгэр болно. Жишээ нь *Яамүнэнтэй, Яамэнхтэй, Яамбаялагтай, Яамхайртай* гэх нь дуудахад болхи дуулдах тул *Яамүнэн, Яамэнх, Яамбаялаг, Яамхайр* гэдэг үгсийг үүсгэсэн болно. Зарчмын хувьд бол Б ангиллын бүх үг ялгалагдах бөгөөд бүгд яг адилхан ялгалагдана.

Энэ хэлийг бүрэн дүүрэн эзэмшээгүй хүнд Б ангиллын зарим үгний утга санаа бараг ойлгогдохгүй байдаг юм. Жишээ нь «*Таймс*» сонины тэргүүний жирийн өгүүлбэрийг аваад үзье. «*Хуучбодолтнууд Ангсоцод дотрооүлдуртай*». Энэ өгүүлбэрийг хамгийн хялбар аргаар Хуучхэлэнд буулгах юм бол. “Хувьсгалаас өмнө үзэл бодол нь тогтчихсон хүмүүс Английн социализмын зарчмыг чин сэтгэлээсээ бүрэн дүүрэн хүлээж авч чадахгүй”. Гэхдээ л энэ нь зохистой орчуулга биш юм. Хэн

нэгэн хүн дээр иш татсан Шинхэлээр бичсэн өгүүлбэрийн төгс агуулгыг ухаарахын тулд энэ нь Ангсоцынхоор юу гэсэн утга вэ гэдгийг тов тодорхой ойлгосон байх хэрэгтэй юм. Үүний зэрэгцээ Ангсоцыг маш сайн мэддэг хүн л өнөөдөр амархан ойлгоход хэцүү *дотооүлдуртай* гэсэн бүдэг бадаг үгийн утгыг үнэлж чадна, ялзарсан ёс суртахуун, доройтлын үзэл бодолтой хутгалдсан *хуучбодолт* гэсэн үг ч үүний адил юм. Эдгээр хэдхэн үгийн ач холбогдол нь бүхэл бүтэн ухагдахууныг хамрах тутам өргөжиж байсан, ухагдахууныг нь нэг үгэнд багтаачихсаны дараа тэдгээрийг арилгах, мартагдуулах нь хялбар болсон юм. Толийг зохиогчдод тулгарч байсан хамгийн том хүндрэл бол шинэ үг зохиох явдал байсан юм. Харин үгээ зохиосны дараа тэр үг нь юу гэсэн үг вэ гэдэгт итгэлтэй байх нь бас хэцүү байсан, шинэ үг бий болгосноор үгийг ямар цар хүрээнд арилгаж чадав гэдэгтээ итгэлтэй байх явдал байсан.

Бид урьд нь тэрсүү агуулгатай байсан зарим үг тухайлбал, «эрх чөлөөтэй» гэдэг үгийг тохиромжтойг нь бодож хадгалж үлдээсэн болно, гэхдээ тэдгээрийн тааламжгүй агуулгыг цэвэрлэсэн болно. «Нэр төр», «шударга ёс», «ёс суртахуун», «интернационалч үзэл», «ардчилал», «шашин», «шинжлэх ухаан» гэх мэт тоо томшгүй олон тооны үг байхгүй болсон. Цөөн хэдэн үгээр эдгээрийг хучиж ингэснээрээ тэдгээрийг арилгасан болно. Жишээ нь эрх чөлөө, тэгш эрх гэсэн бүх үгсийн ухагдахууныг «гэмсэтгэх» гэдэг үг агуулах болж бодит байдал, утга учрын үзэл бодлын үгсийн агуулгыг хуучсэтгэх гэдэг үг агуулах болсон юм. Их нарийвчлах юм бол осолтой байсан. Намын гишүүн нь ертөнцийг үзэх үзлээрээ бусад ард түмэн «хуурамч бурхан» шүтсээр байна гэдгийг мэддэг мөртлөө нарийн учир шалтгааныг нь олохыг хүсдэггүй эртний еврей хүнийг санагдуулах ёстой юм. Түүнд эдгээр бурхдын нэр нь Ваал, Осирис, Молох, Астарта гэх мэт гэдгийг мэдэх шаардлага байгаагүй, тэдний талаар хичнээн бага мэднэ, түүний зөв бишрэлд

төчнөөн ашигтай байсан юм. Тэрээр Иегов болон түүний сургаалийг мэддэг тул өөр нэртэй, өөр шинж тэмдэгтэй бурхад бол, хуурамч бурхад гэдгийг ч мэддэг байжээ. Ингэхлээр Намын гишүүн бүр биеэ зөв авч явах гэдэг нь чухам юуг хэлж буйг мэддэг бөгөөд үүнээс хэрхэн гажиж болохыг бүрэг бараг мэддэг юм. Тухай нь түүний бэлгийн харилцаанд орох зуршлыг *бэлгээм* (ёс суртахуунгүй бэлгийн харилцаа), *сайнбэлгэхарилцаа* (ариун онгон) гэсэн Шинхэлийн хоёрхон үгээр л бүрэн зохицуулагддаг юм. *Бэлгээм* нь бэлгийн муу зуршил бүрт хамаарна. Үүнд садар самуун явдал, завхайрал, ижил хүйстэнтэйгээ явалдах болон бусад гажиг зуршил, мөн түүнчлэн өөрийн дур хүслээр орсон хэвийн бэлгийн харилцаа ч хамаарна. Эдгээрийг тус бүрт нь нэрлэх шаардлага байхгүй бөгөөд зарчмын хувьд эдгээр нь бүгд гэмт хэрэг болох тул цаазаар авахуулах ялтай юм. Шинжлэх ухаан, техникийн үгээс бүрддэг Г ангиллын үгсийн санд бэлгийн харилцааны зарим гаж зуршлыг тодорхойлох нэр томъёо шаардагдаж болох

боловч жирийн иргэнд энэ нь хэрэггүй зүйл юм. Жирийн иргэн нь *сайнбэлгэхарилцаа* хэмээгч эр эм хоёр хамтран амьдарч эм хүндээ биед нь зовиур төрүүлэхгүй жирэмслүүлэх үйлддийг мэддэг билээ. Үүнээс бусад нь *бэлгэгэм* юм. Шинхэл нь гэмтэй сэтгэхүйг гэмтэй гэдгийг нь хүртэл тодорхойлохоос цааш гарах боломж олгоогүй юм, үүнээс цааш хэрэгтэй үг байсангүй.

Б үтсийн санд үзэл суртлын нэг ч саармаг үг байхгүй. Ихэнх үг нь цээрлэсэн нэр болно. «*Баярлагерь*» (Баяр хөөрийн лагерь нь хэрэг дээрээ хүнд хүчир хөдөлмөрийн лагерь), *Энхяам* (Энх тайвны яам нь үнэн хэрэг дээрээ Дайны Яам) гэх мэт үг нь өнгөн дээрх утганыхаа эсрэг тэсрэг утгыг гаргана. Гэтэл зарим үг Далайн Гүрний нийгмийн байгууллын мөн чанарыг илэн далангүй жигшилтэйгээр илэрхийлдэг юм. Үүний жишээ нь «*ардтэжээх*» гэсэн үг бөгөөд энэ нь Нам үй олон түмнийг элдэв муу юмаар зугаацуулж, хуурамч мэдээг тэдэнд тарааж буйг хэлнэ.

Хоёрдмол утгатай үг ч бий, эдгээр үг нь Намын хувьд хэрэглэхээр «сайн» өнгө аястай болдог, дайсны хувьд хэрэглэхээр «муу» өнгө аястай болдог аж. Үүнээс гадна зэрэвсхэн харахад товчлол юм шиг олон тооны үг бий бөгөөд эдгээрийн агуулга нь үзэл суртлын өнгө аясаас бус бүтцээс нь үүссэн болно.

Хүний ур чадвар хүрэх хэмжээгээр улс төрийн агуулгатай буюу улс төрийн агуулгатай байж болох бүх үгийг Б үгсийн санд хамруулсан юм. Бүх байгууллага, бүлэг, үзэл баримтлал, улс орон, хүрээлэн, нийтийн байшингийн нэрийг танил болсон хэлбэрт хураангуйлж оруулсан болно, энэ нь гарал үүслийг нь ойлгоход хялбар, хамгийн цөөхөн үетэй, хэлэхэд амархан үг байх юм. Уинстон Смитийн ажиллаж байсан Үнэний Яамны баримтжуулах газрыг баримтга, утга зохиолын газрыг утгазохга, Телехөтөлбөрийн газрыг телехөтга г. м. нэрлэнэ. Энэ бүхнийг зөвхөн цаг хэмнэх үүднээс хийгээгүй юм. Арван есдүгээр зууны бүр эхэн үед үг-гинж нь улс төрийн хэлний нэг онцдог шинж болсон юм.

Тоталитар дэглэмтэй орнууд, тоталитар байгууллагуудад ийм товчлолыг өргөн хэрэглэдэг ханддага ажиглагдсан юм. Ийм үгийн жишээ нь «нацист», «гестапо», «коминтерн», «ухуулахбригад» г. м. үг байна. Эхний үед эдгээр үгийг зөнгөөрөө хэрэглэдэг байсан бол Шинхэлд эдгээрийг ухамсартайгаар хэвшүүлж байгаа юм. Үгэнд буй сэтгэлгээг үгүйсгэж байгаа болохоор нэр үгийг ингэж хураангуйлснаар агуулгыг нь хумин өөрчилдөг болох нь тодорхой болсон юм. Коммунист Интернациональ гэдэг үг жишээ нь оюун ухаанд олон зүйлийн нийлмэл дүр төрхийг санагдуулна. Дэлхий дахин даяархи хүний ах дүүгийн барилддага, улаан туг, гудамжны хориглол, Карл Маркс, Парисын коммун. Харин «Коминтерн» гэдэг үг нь нарийн тодорхойлсон үзэл баримтлал ба хатуу сахилга баттай байгууллагыг л зөвхөн санагдуулж байна. Энэ нь тун төвөггүй таньж болох ширээ, сандал шиг хязгаарлагдмал зорилготой ямар нэг юмыг санагдуулна. *Коминтерн* гэдэг үгийг шууд л хэлж болох бөгөөд Коммунист Интернациональ

гэдэг хэллэгийг хэлэхэд хэдэн хором сунжирна. Ингэхлээр *Үнэняам* гэдэг үгний утга агуулга нь Үнэний Яам гэдэг үгийг бодвол цомхон, хянах боломжтой юм. Энэ нь бүх юмыг хумих гэсэн эрмэлзлээр барахгүй үгийг амархан хэлж болдог болгох гэсэн зэрэвсхэн харахад дэндүү их юм шиг санаа зовж буй байдлаар тайлбарлагдана.

Шинхэлд утга агуулгыг нарийн тодорхой болгохын хамт үгийг аялгуу сайхан болгох нь бусад хүчин зүйлээс илүү юм. Шаардлага гарах үед үсгийн дүрмийн тогтвортой хэвийг үл тоож байсан юм. Хураангуйлсан, утга агуулга нь тов тодорхой, хэлэхэд хялбар, сонсож байгаа хүний оюун ухаанд хамгийн бага төөрөгдөл учруулж болох үг улс төрийн зорилгод шаардлагатай гэдэг нь аргагүй юм. Б үгийн сангийн үгсийг бараг бүгдийг нь адилхан хураангуйлснаас тэдгээр нь улам чухал болсон байна. Эдгээрийн олонхи үгүүд-*сайнбодох, ардтэжээх, бэлгээгэм, баярлагерь, Ангсоц, доторбодол, сэтгэхүйнцаг* (Сэтгэхүйн Цагдаа), *хуучсэтгэх* болон бусад маш олон үг нь хоёр буюу гурван үетэй үгүүд



бөгөөд нэгдүгээр үе ба сүүлийн үед цохилтыг нь адилхан хуваасан болно. Эдгээр үгийг хэрэглэснээр тасалдангуй, нэг хэвийн байсан яриаг дуржигнуулан хэлэх боломжтой болгосон юм. Ийм шаардлага ч байсан юм. Яриаг тухайлбал үзэл суртлын сэдэвтэй яриаг аль болохоор оюун ухаанаас үл хамаарах болгох зорилт тавьсан юм. Өдөр тутмын амьдралд хүн ярихынхаа өмнө бодох, ямар ч гэсэн заримдаа ийм шаардлага гардаг. Шаардлага гардаг нь зүйн хэрэг юм. улс төрийн болон ёс суртахууны асуудлаар үг хэлэх намын гишүүн хүн пулеметоор буудаж байгаа юм шиг зөв үзэл бодлоо гаргах ёстой. Намын гишүүний бэлтгэл үүнд зориулагддаг бөгөөд алдаа гаргуулдаггүй хэрэгсэл болох Шинхэл, Ангсоцын үзэл санааны дагуу санаатайгаар зохиосон ширүүн аялгуу ба зориудаар эвгүй хэлэх үг энэ үйл явцыг улам лавшруулсан болно. Энэ үйл явцыг сонгох үг маш цөөхөн болсноор улам амархан болгосон. Бидний өөрийн хэлтэй харьцуулах юм бол Шинхэлийн үгийн баялаг өчүүхэн жаахан бөгөөд түүнийг цаашид улам цөөлөх арга

хэрэгслийг үргэлж бодож олдог юм. Сонгох үг цөөрөх тусам бодох цар хүрээ багасдаг тул үгийн тоог цөөлсөн алхам бүрийг амжилт гэж үзэж болно. Эцсийн бөлөгт авиа тод үг мэдрэхүйн төвийн оролцоогүйгээр төвөнхөд л бий болно гэж төсөөлж байсан юм. Шинхэлийн «галуу шиг гааглах» гэсэн утгатай «галуухэл» гэдэг үг энэ зорилгыг хангадаг юм. Б үгийн сангийн бусад үгийн нэгэн адил «галуухэл» хоёрдмол утгатай. Тууштай үзэл бодлыг гааглаж байгаа бол энэ нь магтан сайшааж буй хэрэг бөгөөд *Таймс* сонинд намын нэгэн илтгэгчийг *давхарнэмэхгалууяригч* гэж нэрлэсэн нь түүнийг ихэд хүндэтгэн үнэлсэн хэрэг байлаа

*Г үгсийн сан* нь зөвхөн шинжлэх ухаан, техникийн үгнээс бүрдэх ба туслах үгийн сан болно. Эдгээр үгийг өнөөгийн үгийн үндэс дээр зохиосон бөгөөд нэр томьёо нь ч төстэй юм. Харин бусад үгийн нэгэн адил тэдгээрийг зохиохдоо хянамгай хандаж тааламжгүй утгыг нь цэвэрлэсэн болно. Эдгээр үгийн дүрэм нь нөгөө хоёр үгийн сангийнхтай адил байна.

Эдгээрээс цөөхөн хэдэн үгийг өдөр тутмын яриа болон улс төрийн үг хэллэгт хэрэглэдэг юм. Шинжлэх ухааны ажилтан юм уу, инженер хүн хэрэгтэй үгээ өөрийнхөө салбарын үгний тусгай жагсаалтаас олж болох бөгөөд энэ жагсаалтад бусад жагсаалтад дайралддаг үгийг бас оруулсан болно. Бүх жагсаалтад нийтлэг үг маш цөөн бөгөөд ямар салбарт хамаарагдахыг нь үл харгалзан хүний оюун ухааны дадал, аль эсвэл бодох чадварын талаархи үгийн сан ерөөсөө байхгүй. «Шинжлэх ухаан» гэдэг үг ч байхгүй. «Ангсоц» гэдэг үг энэ үгэнд багтаж болох бүх утгыг гаргаж байгаа юм.

Дээр дурьдсанаас харахад Шинхэлээр тууштай бус үзэл боддыг илэрхийлэх боломж огт байхгүй гэдэг нь ойлгогдоно. Тэрсүү үг хэлэх нь мэдээж хэрэг боломжтой. Гэхдээ хамгийн нандин юмаа харааж зүхсэн харанхуй бүдүүлгээр л байж болно. Жишээ нь «*Их Ах бол улсайн*» гэж хэлж болно. Тууштай баримтлагчийн чихэнд мэдээжээр утгагүй дуулдах энэ мэдэгдэлд шаардлагатай үг нь

дутагдаж буй тул үүнийг ямар ч шалтгаанаар нотлох аргагүй юм. Ангсоцод харш санаа бодол нь бүдэг бадаг үгээр илэрхийлээгүй хэлбэрээр ухаан санаанд орж ирдэг ба төрөл бүрийн тэрсүү үзлийг тус тусад нь тодорхойлолгүй бөөнд нь маш ерөнхий томъёоллоор цохон зааж болдог. Үнэн хэрэг дээрээ хэн нэгэн зарим үгийг хууль бусаар Хуучхэл рүү орчуулж байж л Шинхэлийг тууштай бус зорилгод ашиглаж чадна. Жишээ нь Шинхэлд «*Бүх хүн эрх тэгш*» гэж хэлэхийг зөвшөөрсөн юм. Гэхдээ энэ нь Хуучхэлний Бүх хүн улаан үстэй гэсэн утгаар л болно. Энэ өгүүлбэрт дүрмийн алдаа байхгүй боловч илт худал юмыг баталж байна. Энэ нь юу вэ гэхлээр бүх хүн өндөр нам, биеийн жин, хүч чаддаараа тэнцүү гэсэн үг юм. Иргэний тэгш байддын тухай ойлголт нэгэнт одоо байхгүй болсон «тэгш» гэдэг үгийн хоёрдахь утга алга болсон. 1984 онд Хуучхэл харилцааны жирийн хэрэгсэл хэвээрээ байсан үед хүн Шинхэлийг хэрэглэхдээ үгийн анхдагч утгыг эргэн санаж болох аюул онолын хувьд байсан юм. Бодит байдал дээр *хоёрсэтгэхүйгээр* хүмүүжсэн

аливаа нэгэн хүнд үүнийг гаргахгүй байх нь хэцүү биш бөгөөд нэг, хоёр үеийн дараа ийм алдаа гаргах боломж бүрмөсөн алга болох ёстой юм. Төрсөн цагаасаа эхлэн Шинхэлээс өөр хэл мэдэхгүй хүнд «тэгш эрх» гэдэг үгэнд «улс төрийн эрх тэгш байдал» гэсэн хоёрдахь утга бий, шатар мэдэхгүй хүн «тэмээ», «морь» гэсэн үгийн талаар ойлголтгүй байдагтай адил эрх чөлөө нь хэзээ нэгэн цагт «оюун санааны эрх чөлөө» гэсэн утгатай гэдэг нь санаанд нь ордоггүйтэй адил юм. Олон гэмт хэрэг, алдаа нь нэргүй, төсөөлөлгүй болохоор тэрээр тэдгээрийг үйлдэж чадахгүй байсан. Цаг хугацаа өнгөрөх тусам Шинхэлийн онцдог шинж тэмдэг улам, улам тодорхой болно гэдгийг тааварлаж байсан юм, үг нь улам, улам цөөрнө, утга нь улам, улам нарийн болно, үгийг буруу хэрэглэх боломж улам, улам багасна.

Хуучхал бүрмөсөн сөнөхөөр өнгөрсөн үетэй холбоо бүрмөсөн тасарна. Түүхийг шинээр биччихсэн, харин хуучин утга зохиолын бүрэн хянагдаагүй хэсгүүд энд тэнд үлдчихсэн тул

хүмүүс Хуучхэлийг санаж байгаа цагт тэдгээрийг уншиж болно.

Техникийн үйл явц, ахуйн чанартай жирийн үйлдэл буюу хандлага нь тэртэй тэргүй тууштай зарчимтай л (Шинхэлээр сайнбодолтой гэдэг юм) биш бол аливаа сэдвийг Хуучхэлээс Шинхэл рүү орчуулах арга байхгүй. Бодит байдал дээр 1960 оноос өмнө бичигдсэн нэг ч номыг бүхэлд нь орчуулах боломжгүй гэсэн үг юм. Хувьсгалын өмнөх үеийн утга зохиолыг зөвхөн үзэл суртлын аргаар орчуулж болно. Энэ нь хэлийг нь орчуулахын хамт утга агуулгыг нь орчуулна гэсэн үг юм. Тусгаар тогтнолын Тунхаглалын алдарт хэсгийг жишээ болгон авч үзье.

«Бүх хүнийг адил тэгш бүтээсэн, бүтээгч нь тэдэнд амьд явах, эрх чөлөөтэй байх, аз жаргалыг эрмэлзэх зэрэг тов тодорхой салшгүй эрх заяасан нь илт үнэн гэж бид үздэг. Эдгээр эрхийг хангахын тулд харьяат нарынхаа зөвшөөрснөөр эрх мэдэл авсан засгийн

газруудыг хүмүүсийн дунд үүсгэн байгуулдаг юм. Засаглалын аливаа үйл ажиллагаа эдгээр зорилготой харшилдах тохиолдолд ард түмэн түүнийг өөрчлөх, халах эрхтэй...»

Энэ хэсгийн үгийн утгыг нь хадгалан Шинхэлд буулгах ямар ч боломж байхгүй. Ингэхдээ хамгийн их ойролцоо орчуулга нь энэ хэсгийг бүхэлд нь ганц үг гэмсэтгэхүйд шингээх явдал мөн. Бүрэн төгс орчуулга нь Жеферсоны үгийг үнэмлэхүй эрх мэдлийг магтан дуулсан болгон өөрчилсөн үзэл суртлын орчуулга байж болох юм.

Өнгөрсөн үеийн уран зохиолын ихээхэн хэсгийг ийм маягаар өөрчилсөн юм. Түүхэн зарим нэрт хүмүүсийн бүтээл зохиолыг Ангсоцын үзэл баримтладд нийцүүлээд тэдний талаархи дурсамжийг хадгалах нь нэр төрийн хэрэг гэж үзсэн болно. Шекспир, Свифт, Байрон, Диккенс болон бусад зарим зохиолчийн бүтээлийг орчуулах ажил хийгдэж байгаа юм. Энэ ажлыг дуусгавар болгосны дараа угийн эх зохиол

болон өнгөрсөн үеийн утга зохиолоос хадгалагдаж үлдсэн зохиолуудыг устгах юм. Эдгээрийг орчуулах ажил нь цаг хугацаа шаардсан, нарийн чимхлүүр ажил бөгөөд ХХI зууны эхний хорин жилээс цааш дуусна гэж үзэж байгаа болно. Мөн ажлын хэрэгцээний ихээхэн баримт бичиг бий, гарцаагүй хэрэгцээтэй дүрэм журам гэх мэтийг нэгэн адил өөрчлөх юм. Орчуулгын бэлтгэл ажлыг хийхэд цаг хугацаа гаргах үүднээс Шинхэлд бүрэн шилжих хугацааг 2050 он хүртэл хойшлуулсан болно.



Thank you for evaluating ePub to PDF Converter.

That is a trial version. Get full version in [http://www.epub-to-pdf.com/?pdf\\_out](http://www.epub-to-pdf.com/?pdf_out)